АНТООН МОСТАЭРТ
МОНГОЛ СУДЛАЛЫН ТӨВ

ЭРДМИЙН ХЭЛХЭЭ

Эрдэм шинжилгээний бичиг
Боть XV

Эрхэлсэн: Т. Батбямба

Улаанбаатар
2026

АНТООН МОСТАЭРТ
МОНГОЛ СУДЛАЛЫН ТӨВ

ЭРДМИЙН ХЭЛХЭЭ

Эрдэм шинжилгээний бичиг
Боть XV

Эрхэлсэн: Т. Батбямба

Сэтгүүлийн зөвлөл:

Г. Гэрэлмаа	ШУА, Хэл зохиолын хүрээлэнгийн Харьцуулсан хэл шинжлэлийн салбарын эрхлэгч, доктор (Ph.D), дэд профессор
Л. Ганбат	ШУА, Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн Монголын эзэнт гүрэн, дундад үеийн түүхийн салбарын эрхлэгч, доктор (Ph.D)
Г. Нарантунгалаг	МУИС, Утга зохиол, урлаг судлалын тэнхимийн багш доктор (Ph.D), дэд профессор
Б. Аззаяа	МУИС, Ази судлалын тэнхимийн багш доктор (Ph.D), дэд профессор

ISSN: 3162-0590

ANTOON MOSTAERT
CENTER FOR MONGOLIAN STUDIES

STRINGS OF KNOWLEDGE

Research Works
Volume XV

Edited by: T. Batbyamba

Ulaanbaatar
2026

ANTOON MOSTAERT
CENTER FOR MONGOLIAN STUDIES

STRINGS OF KNOWLEDGE

Research Works
Volume XV

Edited by: T. Batbyamba

Editorial Board:

Guruuchin GERELMAA, Doctor (Ph.D), Associate professor, Senior researcher, Head of Department of Comparative linguistics, Institute of Language and Literature of Mongolian Academy of Sciences

Lkhundev GANBAT, Doctor (Ph.D), Head of Department of Mongol Empire and Medieval History, Institute of History and Ethnology of Mongolian Academy of Sciences

Gansukh NARANTUNGALAG, Doctor (Ph.D), Associate Professor, Department of Literature and Art Studies, National University of Mongolia

Badam AZZAYA, Doctor (Ph.D), Associate Professor, Department of Asian Studies, National University of Mongolia

ISSN: 3162-0590

ТАЛАРХАЛ

Монгол дахь CICM байгууллагын харьяа Антоон Мостаэрт Монгол Судлалын Төв (АМТ)-өөс монгол судлалын чиглэлээр суралцдаг оюутан залуусын дунд “Оюутан судлаач” хөтөлбөрт үйл ажиллагааг 15 дахь жилдээ амжилттай зохион байгууллаа.

Энэ удаагийн хөтөлбөрт МУИС-ийн Шинжлэх ухааны сургууль (ШУС)-ийн Монгол хэл, хэл шинжлэлийн тэнхим, Утга зохиол, урлаг судлалын тэнхим, Археологи, антропологи, хүн ам зүйн тэнхим, МУБИС-ийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургууль (НХУС)-ийн Монгол хэлний тэнхим, Утга зохиолын тэнхим, Түүхийн тэнхимийн 18 оюутан хамрагдав.

Оюутан судлаачдын судалгааны ажлыг удирдагч багш нар удирдан чиглүүлж, Антоон Мостаэрт Монгол Судлалын Төвөөс төлөвлөгөөт лекц, үйл ажиллааг зохион байгуулж, судалгааны ерөнхий арга зүйгээр чиглүүлж, *“Эрдмийн хэлхээ”* (Strings of Knowledge) оюутны эрдэм шинжилгээний бүтээлийн арван тавдугаар ботийг ISSN: 3162-0590 дугаартайгаар хэвлэн гаргаж байна.

Тус хөтөлбөрийг амжилттай хэрэгжихэд:

- Санхүүгийн бүрэн дэмжлэг үзүүлсэн CICM байгууллага;
- Тус хөтөлбөрт хамрагдаж, судалгааны ажлын арга зүйд суралцаж, эрдэм шинжилгээний өгүүллээ хэвлүүлсэн МУИС-ийн ШУС-ийн НУС-ын Антропологи хөтөлбөрийн IV курсийн оюутан Б. МӨНХЖИН, Археологи хөтөлбөрийн II курсийн оюутан Ш. УНДРАХ-ЭРДЭНЭ, Б. ШҮРЭНЦЭЦЭГ, III курсийн оюутан Ё. АДЪЯАЛХАМ, IV курсийн оюутан Э. ӨСӨХБАЯР, МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын Багш, монгол хэл, уран зохиолын боловсрол хөтөлбөрийн III курсийн оюутан Н.БЯМБАЖАРГАЛ, Б. ЛХАГВАЧИМЭГ, Ч. ӨНӨРЗАЯА, IV курсийн оюутан Г. ГАНСУВД, Утга зохиол судлал хөтөлбөрийн III курсийн оюутан Б. ЗОЛБОО, IV курсийн оюутан Б. НОМИН, МУБИС-ийн НХУС-ийн Монгол хэл, уран зохиолын багшийн I курсийн оюутан Г.ЛХАГВАНАРАН, III курсийн оюутан Ү. СОЛОНГО, IV курсийн оюутан Э. БУДСҮРЭН, З. ХИШИГБАЯР, С. ЦЭЛМҮҮН, С. ЧУЛУУНЦЭЦЭГ, Түүх, нийгмийн ухааны багш хөтөлбөрийн IV курсийн оюутан Э. БААТАР;
- Оюутнуудын судалгааны ажлыг удирдсан МУИС-ийн Археологи,

антропологи, хүн ам зүйн тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D), дэд профессор Ч. Амартүвшин, профессор М. Эрдэнэ, ахлах багш С.Бямбадорж, Монгол хэл, хэл шинжлэлийн тэнхимийн багш, доктор (Ph.D), дэд профессор О. Дэмчигмаа, доктор (Ph.D), дэд профессор М.Жавхлан, МУИС-ийн Утга зохиол, урлаг судлалын тэнхимийн багш, докторант И. Даваадорж, МУБИС-ийн НХУС-ийн багш доктор (Ph.D) Р. Сарангэрэл, доктор (Ph.D), дэд профессор Г. Цэцэгдарь, доктор (Ph.D) П. Яньдий, ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн ЭША, доктор (Ph.D) Г. Батболд, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн ЭШДэА, докторант Х. Гэндэнпил, ШУА-ийн Түүх, Угсаатны зүйн хүрээлэнгийн ЭША, докторант Г. Цэнгүүн;

- Лекц уншсан Монгол Улсын Ардын Багш, шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор, МУБИС-ийн Монгол судлалын төвийн зөвлөх, профессор Ц. Өнөрбаян, ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн Эртний түүхийн салбарын эрхлэгч, доктор (Ph.D) Г. Алтансүх, Соёл судлалын ухааны доктор (Ph.D), дэд профессор, зураач доктор (Ph.D) Д.Тангад, СУИС-ийн Соёл урлаг судлалын хүрээлэнгийн ЭШТА, Түүхийн ухаан доктор (Ph.D), дэд профессор Б. Баатархүү, Унгар улсын Сегедийн их сургуулийн хэл шинжлэлийн докторант, МУИС-ийн зочин судлаач Sara Tiszai, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн захирал, доктор (Ph.D), дэд профессор О. Шинэбаяр;
- Оюутны эрдэм шинжилгээний хурлын шүүгчээр ажилласан ЮНЕСКО-ийн ивээл дор Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэнгийн Эрдэм шинжилгээ, хөтөлбөрийн зохицуулагч, докторант Г. Зулбаатар, МУИС-ийн Утга зохиол, урлаг судлалын тэнхимийн докторант М. Пагмадулам, ШУА-ийн Түүх, Угсаатны зүйн хүрээлэнгийн Эртний түүхийн салбарын ЭША, Монгол Улсын Эрдмийн их сургуулийн докторант Г. Цэнгүүн, ШУА-ийн Түүх, Угсаатны зүйн хүрээлэнгийн Ойрх үеийн түүхийн салбарын ЭША доктор (Ph.D) Г.Баттүшиг, СУИС-ийн Эрдэм шинжилгээ, ахисан түвшний хөтөлбөрийн албаны эрдэм шинжилгээ хариуцсан мэргэжилтэн, соёл судлалын докторант Ц.Улаанаа;
- Оюутны эрдэм шинжилгээний хуралд амжилттай оролцож, тэргүүн байр эзэлсэн МУБИС-ийн НХУС-ийн Монгол хэл, уран зохиолын багшийн IV курсийн оюутан З. Хишигбаяр, МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын Багш, монгол хэл, уран зохиол хөтөлбөрийн III курсийн оюутан

Б. Лхагвачимэг, МУИС-ийн Археологи, антропологи, хүн ам зүйн тэнхимийн Антропологи хөтөлбөрийн IV курсийн оюутан Б. Мөнхжин;

- Тус хөтөлбөрийг хариуцан ажилласан МУБИС-ийн НХУС-ийн багш, АМТ-ийн Гүйцэтгэх захирал, доктор (Ph.D), дэд профессор Г. Цэцэгдарь Багшийн сургуулийн багш, доктор (Ph.D) Т. Батбямба;
- “Эрдмийн хэлхээ” эрдэм шинжилгээний бичгийг хэвлэсэн “Арвай бархан” ХХК нарт талархаж, ажил үйлст тань их амжилтыг хүсье.

АНТООН МОСТАЭРТ
МОНГОЛ СУДЛАЛЫН ТӨВ

ГАРЧИГ

ТАЛАРХАЛ 5

Хэл шинжлэл

Гансүхийн ГАНСУВД

МУИС-ийн Багш, монгол хэл, уран зохиолын боловсрол хөтөлбөрийн IV курсийн оюутан

“МӨ-” язгуурт бүлэг үгийн тухайд 15

Ганбаатарын ЛХАГВАНАРАН

МУБИС-ийн Монгол хэл, уран зохиолын багшийн I курсийн оюутан

Монгол хэлний тэмдэг нэр бүтээх төсөөт дагаврын тухай 30

Чимиддоржийн ӨНӨРЗАЯА

МУИС-ийн Багш, монгол хэл, уран зохиолын боловсрол хөтөлбөрийн III курсийн оюутан

“Монгол и юй” толь бичгийн нэмэлт дэвтрүүд дэх цаг улирлын аймгийн үгийн санг харьцуулах нь 38

Үнэнбүрэнгийн СОЛОНГО

МУБИС-ийн Монгол хэл, уран зохиолын багшийн III курсийн оюутан

Монгол хэлний нармайн эгшиг авианы тархац ба хувьсал 49

Зоригтбаатарын ХИШИГБАЯР

МУБИС-ийн Монгол хэл, уран зохиолын багшийн IV курсийн оюутан

Монгол хэлэн дэх гадаад үгийн хөөмийн эгшгийн дуудлага ба авианы хувьсал (англи, орос хэлний хүрээнд) 67

Сүхбаатарын ЦЭЛМҮҮН

МУБИС-ийн Монгол хэл, уран зохиолын багшийн IV курсийн оюутан

Торгууд аман аялгууны [е], [е:] эгшиг авиаг туршилт авиа зүйн аргаар судлах нь 81

Сугарын ЧУЛУУНЦЭЦЭГ

МУБИС-ийн Монгол хэл, уран зохиолын багшийн IV курсийн оюутан

Тод үсэгт урт эгшгийг тэмдэглэсэн “Удаан” тэмдгийн хэл шинжлэлийн тайлбар 96

Утга зохиол, аман зохиол

Эрхэмзаяагийн БУДСҮРЭН

МУБИС-ийн Багш монгол хэл, уран зохиолын боловсрол хөтөлбөрийн IV курсийн оюутан

Ж. Олдрижийн “Гайхамшигт монгол морь” тууж дахь морины дүр 107

Нямдаваагийн БЯМБАЖАРГАЛ

МУИС-ийн Багш, монгол хэл, уран зохиолын боловсрол хөтөлбөрийн III курсийн оюутан

“Хаан сийр” баатарлаг туулийн хувилбаруудын соёлын хам сэдвийг харьцуулан шинжлэх нь 118

Батсүхийн ЗОЛБОО

МУИС-ийн Утга зохиол судлал хөтөлбөрийн III курсийн оюутан

Монгол үлгэрийн баатад ба шидэт туслагчийн холбоо хамаарлыг синтагматик анализын хүрээнд шинжлэх нь 135

Баяндалайн ЛХАГВАЧИМЭГ

МУИС-ийн Багш, монгол хэл, уран зохиолын боловсрол хөтөлбөрийн III курсийн оюутан

С. Чойсүрэнгийн туульсын баатруудын нэр, нэршлийн өвөрмөц чимэг үгийн судалгаа (“Галзуу хар хөхөл”, “Эзэн улаан бодон”, “Бужин даваа хаан” туулийн жишээн дээр) 172

Бямба-Эрдэнийн НОМИН

МУИС-ийн Утга зохиол судлал хөтөлбөрийн IV курсийн оюутан

Монгол аман зохиол дахь ургамлыг оньсоголох тогтмолыг шинжлэх нь 185

Түүх, Археологи, Антропологи

Ёндонжамцын АДЬЯАЛХАМ

МУИС-ийн Археологи хөтөлбөрийн III курсийн оюутан

Хүрлийн үеийн соёлууд дахь оршуулгын зүг чигийг бөө мөргөлтэй холбон тайлбарлах нь 203

Эрдэнэбатын БААТАР

МУБИС-ийн Түүх нийгмийн ухааны багш хөтөлбөрийн IV курсийн оюутан

Хор дагалдуулах зан үйлийг тодруулах нь 220

Болорчулууны МӨНХЖИН

МУИС-ийн Антропологи хөтөлбөрийн IV курсийн оюутан

Монгол эмэгтэйчүүдийн анхны сарын тэмдэг ирэх нас болон бие бялдрын хөгжлийн хандлага 231

Эрдэнэ-Очирын ӨСӨХБАЯР

МУИС-ийн Археологи хөтөлбөрийн IV курсийн оюутан

Монголын эртний нүүдэлчдийн ясан дээрх гэмтэл бэртлийн судалгаа (ахуйн гэмтлийн жишээгээр) 245

Шижирбатын УНДРАХ-ЭРДЭНЭ

МУИС-ийн Археологи хөтөлбөрийн II курсийн оюутан

Монголын нууц товчооны 275-р зүйлийг нягтлан үзэх нь 257

Батбаярын ШҮРЭНЦЭЦЭГ

МУИС-ийн Археологи хөтөлбөрийн II курсийн оюутан

Орчин үеийн монголчуудын ялгараа ба нутгархах үзэл 265

CONTENTS

APPRECIATION 5

Linguistics

GANSUVD Gansukh
A Study of the Group of Words Derived from the "Mö-" Root 15

LKAGVANARAN Ganbaatar
About Imaginary Suffixes Used to Create Names for Symbols in the Mongolian Language 30

UNURZAYA Chimiddorj
A Comparative Study of Seasonal Vocabulary in the Supplementary Volumes of the "Menggu Yiyu" Dictionary 38

SOLONGO Unenburen
The Distribution and Evolution of Velar Sounds in the Mongolian Language ...49

KHISHIGBAYAR Zorigtbaatar
Pronunciation and Phonetic Change of Guttural Vowels in Foreign Words in Mongolian (With Reference to English and Russian) 67

TSELMUUN Sukhbaatar
An Experimental Phonetic Analysis of Vowel [e] in the Torghut Dialect 81

CHULUUNTSETSEG Sugar
The Linguistic Explanation of 'Udān' Special Mark for Indicating Vowel Length in the Todo Üsüg 96

Literature and Folklore

BUDSUREN Erkhemzaya
The Role of the Horse in J. Aldridge's The Marvellous Mongolian 107

BYAMBAJARGAL Nyamdavaa
A Comparative Analysis of the Cultural Contexts in the Variants of the Epic Khaan Siir 118

ZOLBOO Batsukh
A Syntagmatic Analysis of the Relationship Between the Hero and the Donor in Mongolian Folktales 135

LKHAGVACHIMEG Bayandalai

A Study of the Distinctive Ornamental Epithets Used in the Names and Appellations of the Heroes in the Epics of Sükhiin Choisüren
(Based on the Epics “Galzuu Khar Khökhöl,” “Ezen Ulaan Bodon,” and “Bujin Davaa Khaan”) 172

NOMIN Byamba-Erdene

An Analysis of Plant Riddles in Mongolian Oral Literature 185

History, Archeology, Anthropology Studies

ADIYALKHAM Yondonjamts

Interpretation of Burial Orientations in Bronze Age Cultures in Relation to Shamanism 203

BAATAR Erdenebat

On the Issue of Including Quivers in Funerary Ritual Practices 220

MUNKHJIN Bolorchuluun

Secular Trends in Age At Menarche and Physical Development Among Mongolian Women 231

USUKHBAYAR Erdene-Ochir

Accidental Trauma in Human Skeletal Remains of Ancient Nomadic Populations from Mongolia 245

UNDRAKH-ERDENE Shijirbat

A Critical Examination of Paragraph 275 of The Secret History of the Mongols 257

SHURENTSETSEG Batbayar

Differentiation and Localism Among Contemporary Mongolians 265

ХЭЛ ШИНЖЛЭЛ

2026 Fasc.1

“МӨ-” ЯЗГУУРТ БҮЛЭГ ҮГИЙН ТУХАЙД

Гансүхийн ГАНСУВД
МУИС-ийн Багш, монгол хэл, уран зохиолын боловсрол хөтөлбөрийн IV курсийн оюутан

Удирдагч: О. Дэмчигмаа
МУИС-ийн Монгол хэл, хэл шинжлэлийн тэнхимийн багш, доктор (Ph.D), дэд профессор

Хураангуй: *Уг өгүүлэлд “мө-” язгуурт үгсийн цөм утга, бүтэц, гарлыг бусад хэлний болон нутгийн аялгууны бариmтад тулгуурлан шинжлэв. Өмнөх үеийн судлаачдын үзснээр “мө-” язгуурт үгийг “мөл-” хэлбэрээр тогтооож ирсэн нь -л- гийгүүлэгчийн сулран сугарах авианы хувьсалтай холбоотой болохыг тайлбарлаж, уг язгуурын анхдагч цөм утга нь “шингэн зүйлийн хөрөх, хөлдөх, царцах” болохыг ажиглав. Мөн “мө-” болон “хө-” язгуурыг нэг утга илтгэх язгуурын хувилбарууд гэсэн шинэ саналыг дэвшүүлж, тэдгээрээс үүссэн “хөхөө”,“хөхүй” үгийн ялгааг тодруулаа. Иймд энэхүү судалгаагаар язгуур бүтээврийн утгын нийтлэг, тогтвортой шинж болон монгол хэлний үг бүтээх зүй тогтлыг гүнзгийрүүлэн танихад ач холбогдолтой юм.*

Түлхүүр үг: *“мө-” язгуур, цөм утга, “хө-” язгуур, төрөл үг*

УДИРТГАЛ

Монгол хэлэнд үгийн бодит утгыг хадгалсан гол хэсэг болох язгуур морфем нь тухайн үгийн цөм утгыг хадгалсан байна. Энэ талаар Ш. Лувсанвандан “үгийн язгуур нь уул үгийн хамгийн ерөнхий утгыг хадгалсан хэсэг байдаг”[1] хэмээн тодорхойлжээ. Язгуурын талаар цааш үзэхэд язгуур нь үгийн үнэмлэхүй эхэнд байрлаж, төрөл буюу ижил язгуурт үүр, утгын олонлогийг үүсгэдэг бөгөөд язгуур нь эгшиг зохицох ёс, авиа сэлгэх хуулиар нөхцөлдөн авиа зүйн тодорхой хувилбартай байна. Иймд “мө-“ язгуурт үгсийг мөшгөн үзэхэд ижил язгууртай хэрнээ өөр утга илтгэх үгс цөөнгүй байна. Энэ нь ижил үг буюу Т. Пагва “омоним

[1] Лувсанвандан, Ш., *Монгол хэлний зүй*, УБ., 2010, х.45.

буюу ижил үгийг полисемия буюу үгийн олон утгатай хольж болохгүй, гэхдээ туйлын зааг тавих ч шаардлагагүй"[2] гэж тэмдэглэсэн бол, Ц. Өлзийхутаг "монгол хэлэнд дуудлага ижил боловч тус тус бие даасан утгатай олон үг байдаг нь даруй ижил нэр болно"[3] гэж онцлон тэмдэглэжээ. Субашидын 33 дугаар бадагт тохиолдох *"gangs chu"* хэмээх үгийг Сономгарагийн орчуулгад *"kömügeltü usun*" хэмээн тэмдэглэснийг тодруулахад "мөхөөл" хэмээх үгтэй холбогдож хөлдөх, царцах, зайртах гэсэн утга илтгэх нь цааш *"мө-"* язгуурт бүлэг үгтэй ижил утга зааж байгааг анзаарч *"мө-"* язгуурын утгыг тодчилохыг хичээлээ.

0.1. Сэдвийн судлагдсан байдал. Язгуур бүтээврийн утгын талаарх судалгааны бүтээлүүд арвин байдаг ч *"мө-"* язгуурыг дэлгэрэнгүй судалсан судалгаа дутмаг байна. Харин Д. Бадамдорж "Үгийн сангийн утга зүй" бүтээлдээ 188 омгийн язгуурыг холбогдох үгийн хамт бүртгэн жагсаан бичихдээ *"мө-"* язгуурт үгсийг [4] *"мө-"* язгуур нь буурмаг мөлгөр, цагаавтар хатуу гэсэн ерөнхий утгатай гэж үзжээ.

Д.Төмөртогоо "Монгол үгийн гарлын тайлбар толь"-д *мөл* [möl/möli]* нь мөлгөр гэсэн утгыг хадгалсан язгуур. Энэ язгуураас *möliger 'мөлгөр', mölsün 'мөс', möligüü 'мөлүү'* гэх мэт үг үүсжээ[5].

М.Базаррагчаа "Үгийн гарлыг мөшгөх нь" бүтээлдээ *"мө-ли-ий-кү, мө/л/-сү-н"* гэх үгс нь *"мөл-"* язгуураас эхтэй гэж үзсэн бөгөөд *"мөлийж, мөлтийсөн хатуу юмыг"* заана гэжээ.[6]

0.2. Судалгааны ажлын зорилго

Монгол хэлний үгийн санд хүйтэн, сэрүүн, зэврүүн, бүлээн, жиндүү, царцах, зайртах зэрэг шинж байдлыг илтгэх утга *"мө-"* язгуураас ажиглагдаж буй учир үүнийг нутгийн аялгуу, төрөл хэлнүүдээс шүүрдэн үзэж, бичгийн сурвалж, толь бичгүүдээс мөшгөн нийтлэгийг тодруулах.

0.3. Судалгааны ажлын зорилт

- Монгол хэлний нутгийн аялгуу, төрөл хэлнүүдээс "мө-" язгуурт бүлэг үгийг шүүн, утгыг тодруулж бичгийн дурсгал сурвалжууд, толь бичиг зэргээс язгуурын утгыг нягтална.
- "Мө-", "Хө-" үе сэлгэн "хө-" язгуураас үүссэн үгсийн утга хэрхэн өргөжин салаалж, утгын цөм нь "мө-" язгуурт үгстэй хэрхэн холбогдож буйг тодруулна.

[2] Пагва, Т., *Хэл шинжлэлийн удиртгал,* УБ., 2016, х.122.
[3] Цогбадрах, Ж., *Монгол хэлний ижил нэрийн толь*, УБ., 1981, х.25.
[4] Бадамдорж, Д., *Үгийн сангийн утга зүй*, УБ., 2001, х.160.
[5] Төмөртогоо, Д., *Монгол үгийн гарлын тайлбар толь*, УБ., 2018, х.165.
[6] Базаррагчаа, М., *Монгол үгийн гарлыг мөшгөх нь*, УБ., 1995, х.89.

0.4. Судалгааны ажлын арга, арга зүй

Энэхүү судалгаанд харьцуулах, түүвэрлэх, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх аргуудыг хэрэглэсэн болно.

0.5. Судалгааны ажлын ач холбогдол: *"Мө-"* язгуурт бүлэг үгийг судалснаар холбоо хамаарал бүхий үгсийг бүртгэж, тухайн язгуураас үүссэн үгийн утгыг тодруулан таниулах боломжтой. Монгол хэлэнд нэг язгууртай олон үг байх бөгөөд эх хэлний үгийн сангийн баялаг хэрэглээ хумигдаж буй өдгөө үед тэдгээрийг олон нийтэд таниулах ач холбогдолтой.

0.6. Судалгааны шинэлэг тал: Монгол хэлний *"мө-", "хө-"* язгуурыг тусдаа бус шингэн зүйлийн хөрөх, хөлдөх утгат нэг цөмтэй язгуурын хувилбарууд гэж үзсэн нь шинэ санал байна. Мөн эдгээрийн авиа зүйн хувирлыг, түүхэн эх сурвалж, нутгийн аялгуу, төрөл хэлний баримттай харьцуулан тайлбарлаж *"мө-", "хө-"* язгуурын талаар шинэ санал дэвшүүлэв.

ҮНДСЭН ХЭСЭГ

1. "МӨ-" ЯЗГУУРТ ҮГС

Ю. Мөнх-Амгалан, Каншин нар үгийн язгуур бүтээвэр нь дараах үндсэн шинжтэй байна гэж үзсэн. Үүнд:

- Үгийн үнэмлэхүй эхэнд байрлах тул хүчиллэх өргөлт авч улмаар араасаа залгагдах бүтээврийн цуваан дахь эгшгийг зохицуулах төв болно.
- Төрөл буюу ижил язгуурт үгийн үүр, утгын олонлогийг үүсгэнэ.
- Язгуур нь эгшиг зохицох ёс, авиа сэлгэх хуулиар нөхцөлдсөн авиазүйн тодорхой хувилбартай байна[7] гэх мэтээр язгуурын онцлогийг үзжээ.

Үгийн утганцар утгыг бүрдүүлж, олон утгат хэлбэрүүдийн дундах давхцах, нийтлэг шинжийг илтгэсэн гол утганцрыг цөм утга буюу ах утга гэж үздэг бөгөөд шинэ утгууд нь энэхүү дундын цөм утгыг түшиглэн хэлний хэрэглээнд нэмэгдэн үүсдэг байна.[8] Тиймийн тул эдгээр үндэслэлд үгийн язгуурын цөм утга нь тогтвортой, хувьсахгүй, шинэ үгс үүсэх үндсэн суурь болдгийг нотлох бөгөөд энэ зарчмаар "мө-" язгуур нь шингэн зүйлийн хөрөх, хөлдөх, царцах, зайртах зэрэг үзэгдлийг илтгэх цөм утгыг агуулсан нь мөс, мөндөр, мөлийх, мөлүү, мөхөөл, мөхөөлтмөл, мөхөөлдөс зэрэг олон салаа үгсийн утгын нэгдмэл чанараас тодорхой харагдана. Гэвч Д.Төмөртогоо, М.Базаррагчаа нар *"мө-"* язгуурт үгсийг *"мөл-"* язгууртай холбон үзсэнээр цөм утга нь тухайн зүйлийн гадаргууг илэрхийлэх утга буй хэмээж хөрөх, хөлдөх, царцах, зайртах утгатай

[7] Мөнх-Амгалан, Ю., Каншин, *Орчин цагийн монгол хэлний бүтээвэр судлал*, УБ., 2014, х.12-14.
[8] Самбуудорж, О., *Үг, үгийн гарал, хэлц судлал*, УБ., 2020, х.21.

үгсийг хамруулжээ. Энэ нь дундад үеийн монгол хэлний -сун/-сүн дагаврын өмнө оршиж байсан *“л“* гийгүүлэгчийн ул мөрийг харгалзсантай холбоотой юм. Монгол хэлэнд үүнтэй адил үгс цөөнгүй бий. Тухайлбал халх аялгуунд аргал, хоргол, гутал, гадас, гэдэс, мөс, хумс, цаас, гомдол зэрэг үгс эртний дунд үеийн монгол хэлнээ (qarγalsun), (qorγulsun), (γodulsun), (γadalsun), (gedelsün), (mölsün), (qimulsun), (caγalsun), (γomdulsun) зэргээр тэмдэглэгдэж байжээ.[9] Эдгээр үгсээс ажиглахад хэлний хэмнэх зарчим, авиа хоорондын нөлөөгөөр үг бүтэх явцад утга ялгах үүрэггүй болсон авианууд сулран сугарч монгол хэлний сонсголонт, сул, дуутай, хэлний урдуурх, хажуугийн шүргэх *“л”* гийгүүлэгч нь энэ маягаар сугаран хэмнэгджээ. Иймд *“мөл-”* гэж тогтоосон хэлбэр нь мөлгөр, мөлийх гэсэн утгатай бус дундад үеийн монгол хэлэнд байсан бүтцийн нэг онцлог юм. Харин *“мө-”* хэлбэр нь хөлдөх, хөрөх зэрэг шингэн зүйлийн төлөв өөрчлөлтийг илтгэх анхдагч, нийтлэг цөм утгыг хадгалсан язгуур мөн бөгөөд *“мөл-”* хэлбэрт буй *“л”* нь хувьслын дундах авианы оролцоо буюу зөвхөн түүхэн үеийн бүтцийн онцлог байсан нь түүхэн хэлний баримтуудаас ажиглагдлаа.

Цааш “мө-“ язгуурын утгыг улам лавшруулан тодруулахын тулд язгуурыг хэдэн шалгууруар магадалж болно гэж үзсэн зарим эрдэмтний саналыг харъя. Үүнд:

1. Олон монгол хэлний баримтаар шалгуур хийх;
2. Төрөл үгийн шинжээр шалгуур хийх; [10]

Эдгээр шалгуур нь үгийн язгуурын анхдагч, суурь утгыг олон өнцгөөс нотолж, монгол хэлний нутгийн аялгуу, төрөл хэлний жишээнд тулгуурлан язгуурын утгын тогтвортой байдлыг тогтоох боломжтой.

1.1. Олон монгол хэл, аялгууны баримтаар шалгуур хийх нь

Хүснэгт 1. Алтай язгуурын хэлнээ

Орчин цагийн монгол хэл	Манж-хамниган хэлнээ	Казак	Япон хэлнээ	Солонгос хэлнээ
мөс	Buk-	Müz/ buz-	kōri 氷	얼음 eol-eum
ус	Muk-	(-mur)-	Mizu/mid/u/- 水	물 mul

Солонгос хэлэнд мөн дараах байдлаар хэллэгддэг muktta/meuktta (усархаг, чийгтэй), meorgeota (шингэн), museori (хяруу) хэмээн хэлэгддэг нь шууд

[9] Самбуудорж, О., *Үг, үгийн гарал, хэлц судлал*, УБ., 2020, х.134.
[10] Бадамдорж, Д., *Монгол хэлний утга зүйн судалгаа,* МУИС-ийн профессорын эрдмийн өв цуврал: Эрдэм шинжилгээний өгүүллийн эмхэтгэл, Боть (I), УБ., 2023, х.176.

“мө-” язгуурын утгатай тохирохгүй ч шингэн чанарыг илтгэж буй нь төсөөтэй байдлыг илэрхийлнэ. Хэлний баримтуудаас “мөс” гэх үгний жишээнээс үзвэл эгшиг авианы сэлгэцээр төсөөтэй хэлэгдэх ба язгуурын утгатай бүрэн тохирохгүй ч шингэн чанарын утга илтгэсэн нь уугуул шинжийг илэрхийлж байна.

Хүснэгт 2. Төрөл хэлнээ

Орчин цагийн монгол хэл	Дуньсян	Дагуур	Баоань	Монгор
мөс	мэнсун/мянсун	мэісэ	мэшу/мэншу	молсе

Хүснэгт 3. Нутгийн аялгуунд

Монгол бичгийн хэл	Ордос аялгуу	Буриад аялгуу	Ойрад аялгуу
mös	mösü	mülhe(n), mühü(Bar.), mölisü(Kham.), mühең(Aga., Khori.)	mösen
möliger	mölöger	müliger	mölgăr
Möliikü	-	mülihe	Mölăkxĕ
möligüü		mülyün	mölgăr
mösürkeü	-	müliheig	-
mösüjikü		müliheteige	

Дархад аялгуунд *“mösgim”* гэх үг нь цасан дээрх мөрийг нэрлэх нэршил[11] хэмээн тэмдэглэжээ. Энэ нь язгуурын утгаа хадгалсан нэг хэлбэр гэж үзэж байна.


1.2. Төрөл үгийн шинжээр шалгуур хийх нь

Төрөл үгийн шалгуур нь нэг язгууraас үүссэн олон үгсийг авч үзэн, тэдгээрийн утга болон хэлбэрийн нийтлэг шинжийг харьцуулан цөм утгыг тодорхойлно.[12] Энэ аргаар язгуурын утгыг тодруулахад дараах схем дэх бүлэг үгсийг авч үзэв.

[11] Цолоо, Ж., *Ойрд аялгуу*, БНМАУ дахь монгол хэлний нутгийн аялгууны толь бичиг, Боть (II), УБ., 1988, х.158.

[12] Бадамдорж, Д., *Монгол хэлний утга зүйн судалгаа,* МУИС-ийн профессорын эрдмийн өв цуврал: Эрдэм шинжилгээний өгүүллийн эмхэтгэл, Боть (I), УБ., 2023, х.176.

Бүдүүвч 1. "Мө-" язгуурт үгс



1. Хүйтэн, жихүүн байдлыг илтгэх үгс:

Эдгээр үг гол төлөв гадаад орчны хүйтэн, салхигүй боловч жихүүн, хүйтэн байдлыг илтгэнэ.

- Мөлгөр: Жихүүн, зэврүүн байдал; жишээ: гадаа мөлгөр байх (гадаа зэврүүн хүйтэн байх).
- Мөлгөрдүү: 1. Мөлгөр байрын; 2. бүлээн, зэгээн: мөлгөрдүү цай (зөөгдүү цай).
- Мөлийлгөх: Халуун цай, хоол зэргийг бага зэрэг хүйтэн болгох.
- Мөлийх: Салхигүй тогтуун боловч жиндүүлэх, жихүүн байх; мөлийсөн хүйтэн өдөр, дотоод мөлийх (гэдэс дотор хүйт даах, даарах).
- Мөлүү(н), Мөлүүдүү, Мөлүүхэн: Бага зэргийн хүйтэн, мөлгөр, нэлээд хүйтэвтэр, жихүүн байдлыг илтгэх.

2. Мөсний тунадас шинж байдлыг илтгэх үгс:

Эдгээр үгс нь байгалийн үзэгдлийг тодорхойлж, мөсний шинж чанарыг зааж байна.

- Мөндөр: Бороо, мөсөн тунадас; мөндөр орох, мөндөр цохих, мөндөр шиг асгарах.
- Мөндөрлөх: Мөндөр мэт зай завсаргүй унах, нулимс мөндөрлөх.
- Мөндрөнцөр: Мөндрөөс жижигхэн, хатуу тунгалаг, бөөрөнхий мөсөн тунадас.

3. Шингэний царцаж, мөс болон тогтох үйлийг илтгэх үгс:

- Мөс(өн) I, Мөсжих, Мөслөх, Мөслүүлэх, Мөсөрхөг, Мөсөрхүү: Мөс ихтэй, хөлдсөн байдал, мөсөнд хадгалах, хөлдөх үйлдлийг илтгэнэ.
- Мөст, Мөстлөг, Мөстмөл, Мөстөл, Мөстөлт, Мөстөх: Гол, мод, бут зэрэг зүйлсийг мөсөн бүрхүүлд оруулах, хөлдөх үйл явц.
- Мөхөөл: Шингэн зүйлийн гадаргууг бүрхэн хөлдсөн нимгэн зайрмаг.
- Мөхөөлтөх: Ус зайрмагтан хөлдөх; Туул голын ус мөхөөлтөн хөлдөв.
- Мөхөөлдмөл, Мөхөөлдөс: Жимсний шүүс, сүү зэргийг хөлдөөсөн хүнсний бүтээгдэхүүн.

2. “МӨ-“ ЯЗГУУР СЭЛГЭЛТ БА УТГА

ТӨ. rims kyis btab pai sems can rnams
gangs chu ’ba’ zhig yid la byed
СГ. kölüsün ebedčin-e kürtegsen amitan
үаүča kü *kömügeltü usun*-i küseyü[13]

Субашидын 33 дугаар бадагт тохиолдож буй *“gangs chu”* гэх үгийг Сономгарагийн орчуулгад “*kömügeltü usun”* гэж орчуулжээ. Уг үгийн утгыг тодруулбал Сэцэнцогт буриад, ордос, ойрад зэрэг аман аялгуунд ингэж хэлдэг гээд “Алтан бичиг”-т “...хүйтэн газар аялан явахад хөмөөлт мөс хэмлэн явахад...” гэж гардаг. Хөлдөх, хөрөх гэх мэт үгс гарал язгуур нэгтэй гэжээ.[14] Мөн Буриад-монгол-орос толь-д: анхны цас, шинэхэн орсон хөвсгөр цасыг *hүmeneg* гэсэн буй.[15] А.Мостаэртын “Ордос толь”-д *kömügei* буюу “уулын зүүн хажуу”, Зүүнгар-т хөмүгэй гол гэх зэргээр хэлдэг тухай тэмдэглэжээ.[16] Солонгосын судлаач Шин Сан Хуань “мөсний ус” гэж орчуулсан байна.[17] Дөрвөд аялгуунд ус зайрмагтахыг “*усун көмэалтэх*”[18] хэмээн ярьдаг аж.

Bur.	Ord.	Dö.
hүmeneg	***kömügei***	***усун көмэалтэх***
(анхны цас)	(уулын зүүн хажуу/мөсний ус)	(зайрмагтах)


Тиймээс **“*kömügeltü usun*”** гэж маш хүйтэн буюу мөстэй усыг хэлдэг болох нь тодорхой байна. Халх аялгуунд ус зайрмагтан хөлдөхийг “мөхөөлтөх”, зайрмагийг “мөхөөлдөс” гэдэг бөгөөд “хөмөөлт” гэдэг бол үе тонгорсон

[13] Дэмчигмаа, О., *“Субашид”-ын орчуулгуудын үгийн сангийн онцлог,* УБ., 2013, х.27.
[14] Sečenčoγtu, *Mongγol üges-ün ijaγur-un toli*, köke qota., 1988, х.1172.
[15] Черемисов, *Бурят-монгольско-русский словарь*, Москва., 1951, х.609.
[16] Mostaert, A., (1942). Dictionnaire Ordos (Vol. 2). Catholic University. p.427.
[17] Дэмчигмаа, О., *“Субашид”-ын орчуулгуудын үгийн сангийн онцлог,* УБ., 2013, х.58.
[18] Цэндээ, Ю., *Дөрвөд аялгууны язгуурлаг үгс*, УБ., 2001, х.141.

хэлбэр бололтой. Монгол хэлэнд ийм үгс цөөнгүй тохиолддог “гурил ~ гулир”, “балгасун ~ багалсун”, “саблар ~ салбар”, “шүтэх (*sitükü*) ~ түших (*tüsikü*)” гэх мэт үгсийн жишээлэн дурдаж болох юм.

“Хө-” язгуур *“мө-”* язгууртай үе сэлгэхийн зэрэгцээ *“хө-”* язгуураас мөн адил төстэй утга бүхий үгс салаалсан бололтой. Үүнийг дараах схемээс ажиглая.

Бүдүүвч 2. “мө-”, “хө-” язгуурт үгс



“Хө-“ язгуурт үг нь дараах утгыг илэрхийлнэ.

1. Мал, амьтны өвөл гарсан төл:
   - Хөгий *(kögei):* Өвөл төрсөн хурга, ишиг, дахлай.
   - Хөхүй *(köküi):* Өвөл гарсан төл ; хөхүй хурга.

2. Хөлдөж хатсан, хатуурсан зүйлс

Эдгээр үгс нь шингэн эсвэл зөөлөн зүйлс хүйтэнд хатуурч, тогтсон байдлыг илтгэнэ.

- Хөлдмөл *(köldemel):* Нэгэнт хөлдсөн юм; хөлдөөсөн амтлаг идээ.
- Хөлдүү *(köldegüü):* 1. Хүйтэнд хөлдөж хатуу болсон юм; 2. Хүний хөндий, хүйтэн, цэвдэг зан.
- Хөр *(Kör):* Хатуурч тогтсон зүйл; хөр цас, хөр шороо, бууцны хөрзөн.
- Хөрзөн *(Körǰeng):* Малын баас, шээс хөлдөж дагтаршсанаас тогтсон хөр.

3. Хөлдөх, хөрөх үйлийг илтгэх үгс:
   - Хөлдөлт *(köldelte):* Хөлдөх үйлийн үр дүн, үйл явц.
   - Хөрлөх *(Körlekü):* Хөрөх, хатуу төлөвт орох үйл явц.

“Хө-“ язгуурт хөлдөх, дагтарших, хүйтэрч хатуу болох утга агуулагддаг нь хөр, хөлдмөл, хөлдүү, хөхүй зэрэг олон үгэнд илэрсэн бол *“мө-”* язгуур нь мөс, мөстөх, зайрмагтах, хөлдөх гэсэн яг ижил ерөнхий утгыг мөхөөл, мөхөөлтөх, мөхөөлдөс, мөстөх зэрэг үгээр илэрхийлжээ.

Хөмөөлт (kömügeltü) хэмээх үг нь XIII-XIV зууны үеийн дурсгалд тохиолдож байгаа нь дундад эртний монгол хэлэнд үе тонгорох үзэгдэл байсан болохыг харуулах бөгөөд улмаар *“мө-“, “хө-“* язгуур нь тусдаа гаралтай бус, харин язгуурын хувилбар болох нь тодорхой байна.

Мөн Монгол хэлний язгуур нь төрөл үгийн хамгийн ерөнхий утгыг хадгалсан байхаас гадна, эгшиг авианы сэлгэцээр нэг төрлийн утгалбарын оронтой байна.[19] Жишээлбэл, *“ца–”* язгуур авианы сэлгэцээр цайвар, цагаан гэх өнгө илтгэх утга илэрхийлж буй бөгөөд цас, цан, цагаан, цавь, цаваг зэрэг үгт багтах бол *“цэ–”* язгуурт цэгээ, цэгээн, цэлдэн, цээдэм гэх мэт цагаан, цайвар өнгө заасан ерөнхий утгыг илтгэнэ. Түүнтэй адил*“хө–”*, *“хү–”* язгуур нь эгшиг авианы хувилбар бүхий хэлбэр боловч хоёулаа хүйтэн, хөрөх, хөлдөх зэрэг үзэгдлийг хамарсан нэгэн утгыг зааж байна. Иймээс *“хө–”*, *“хү–”* язгуур нь авиазүйн хувилбарын ялгаатай хэлбэрүүд байж болох ч хүйтэн, хөлдөх, хатуурах, дагтарших гэсэн нэг утгыг илэрхийлж байна.

Түүнчлэн *“хө–”* язгуурт үсгийг шүүхэд “хөхөө” гэх үгийн гарал, утгын талаар С.Дулам “*хөхөө* гэдэг нь *хөхүй* буюу хүйтэн гэх утгатай”[20] хэмээн санал дэвшүүлжээ. Монгол аман уламжлалд “хөхөө” хэмээх үг нь ихэвчлэн өвлийн хамгийн хүйтэн, ширүүн үеийг зааж буй нь дараах хэлцэд илэрчээ.

Хөхөө өвлийн хүйтэнд *Хөхөө өвлийн хүйтэнд*
Хөр цасны хайрууд *Хөр цасны жаварт*

Монголчууд хөхөө өвөл, хөх сар гэж өвлийн хамгийн хүйтэн үеийг ийнхүү нэрлэдэг. Мөн өвөл төрсөн хүргыг “хөхүй хурга” гэдэг. Иймд хөхөө, хөхүй хоёр үг нь дуудлагын хувьд ойролцоо бөгөөд хэлэхүйн явцад ялгаа гарч нэг үг гэж үзжээ. Иймд өвлийн хүйтэнтэй шууд холбогдох утгын хувьд “хөхүй” нь илүү тохиромжтой бөгөөд энэ нь төл малын өвлийн хүйтэн улиралд төрсөн гэдгийг заасан чанарын нэр болж тогтжээ. Тиймийн тул өвлийн тухайд “хөхөө” хэмээн бичиж хөхөө шувуутай холбон тайлбарлах нь үндэс муутай төдийгүй “хөхөө сар” буюу зуны тэргүүн сар, “хөхөөн” дууны сар гэдэгтэй хольж хутгах нь эндүү ташаа хэмээн бодож байна.

---

[19] Бадамдорж, Д., *Монгол хэлний утга зүйн судалгаа,* МУИС-ийн профессорын эрдмийн өв цуврал: Эрдэм шинжилгээний өгүүллийн эмхэтгэл, Боть (II), УБ., 2023, х.146.

[20] Дулам, С., *“Хан хөхүй хайрхны тахилга, магталга”, Элжигэн Халхын түүх, шашин, өв соёл,* УБ., 2023, х.29.

Үүний баримт болгон монгол бичгээр хэрхэн бичдэгийг харвал “хөхөө” шувууг ***көküge,*** “хөхүй”-г ***көküi*** гэжээ. Иймд ойролцоо дуудлагатай энэ хоёр үг хэлэхүйн явцад холилдон эндүүрэл үүсгэх болсон байна.

ДҮГНЭЛТ

Энэ бүхнээс үзэхэд орчин цагийн монгол хэлний *“мө-”* язгуурт үгсийг нутгийн аялгуу, төрөл хэлнүүдээс шүүрдэн үзэж, бичгийн сурвалж, толь бичгүүдээс мөшгөн нийтлэгийг тодруулан үзэхэд хэд хэдэн нийтлэг зүйл ажиглагдаж байна. Үүнд:

1. ОЦМХ-ний мөс, мөлгөр, мөлүүн, мөхөөл, мөхөөлдөс гэх мэт үг нь хөрөх, царцах, зайртах гэсэн ерөнхий утгыг илтэж байна
2. Нутгийн аялгуу, төрөл хэлнүүдэд *“мө–”* язгуурын авиазүйн хувилбар өөр боловч утга нь тогтвортой хадгалагдсан байна.
3. Дундад үеийн монгол хэлний *–л–* гийгүүлэгчийн сулран сугарсан хэлбэр нь *“мө–”* язгуурт нөлөөлж, утгын үндсэн цөмд өөрчлөлт оруулалгүй хэлний хувилбар болон хадгалагдсан байна.
4. “*хө–”* болон *“мө–”* язгуур нь хүйтэн, хөлдөх, хөрөх, хатуурах зэрэг үзэгдлийг илтгэх нэг ерөнхий утгыг зааж байна. *“Хө–“, “хү–“* язгуур нь эгшиг авианы сэлгэцээр хувилбар үүсгэж хоорондоо ойролцоо утгыг илтгэж байна. Мөн *“хө–”* ба *“мө–”* язгуур нь тусдаа гаралтай бус, нэг утгын хүрээнд авиазүйн хувилбарын хэлбэрүүд гэж үзэх нь зохистой.

A STUDY OF THE GROUP OF WORDS DERIVED FROM THE “MÖ-” ROOT

This article examines the core meaning, structure, and origin of words derived from the root *mö-* based on evidence from other languages and Mongolian dialectal materials. Previous scholars have identified this root in the form *möl-*; however, this study explains that such a form is related to the phonological weakening and loss of the consonant *-l-*. The study further argues that the original core meaning of this root was “the cooling, freezing, or solidifying of liquid substances.” In addition, a new hypothesis is proposed that the roots *mö-* and *kö-* are variant forms expressing the same semantic notion, and the semantic distinction between the words *köküge* and *kökü̈i* derived from these roots is clarified. Therefore, this research contributes to a deeper understanding of the common and stable semantic features of root derivation and the principles of word formation in the Mongolian language.

Keywords: *“*mö-”*root, core meaning, cooling, “*kö-” *root, homonym, kömügeltü usun*

НОМ ЗҮЙ

Эх хэрэглэгдэхүүн

Базылхан. Б, (1995). *Монгол-Казак толь.* УБ., УХГ

Гантогтох. Г, (2010). *Буриад аялгууны толь.* УБ., Бемби сан.

МУШУА, (2008). *Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь: Таван боть.* УБ., Бемби сан.

Цэвэл. Я, (1988). *Монгол хэлний товч тайлбар толь.* УБ.

Тодоева. Б. Х, (1964). *Баоаньский язык*. Москва.

Тодоева. Б. Х, (1964). *Дунсяньский язык.* Москва.

Тодоева. Б. Х, (1964). *Монгорский язык.* Москва.

Тодоева. Б. Х, (1964). *Дагурский язык.* Москва.

Norjin, (1997) *Mongγol kelen-ü toli,* ÖMAKQ.

Sečenčoγtu, (1988). *Mongγol üges-ün ijaγur-un toli*. Köke qota.

Šaγja. (1994). *Mongγol ügen-ü tayilburi toli.* kökeqota: Mongγol ulus-un soyul-un sang qaγan-u bičigsen tabun ǰüil-ün üsüg-iyer qabsuruγsan manǰu ügen-ü toli bičig. (1771)

Судалгааны бүтээл

Бадамдорж, Д, (2015), *Үгийн сангийн утга зүй*, УБ., МУИС пресс.

Бадамдорж, Д, (2023), *МУИС-ийн профессорын эрдмийн өв цуврал: Эрдэм шинжилгээний өгүүллийн эмхэтгэл: Б. I, II: Монгол хэлний утга зүйн судалгаа,* УБ., МУИС-МХС.

Базаррагчаа, М, (1995), *Монгол үгийн гарлыг мөшгөх нь III, IV, V ботиуд,* УБ., Орчлон.

Дэмчигмаа, О, (2003), *“Субашид”-ын орчуулгуудын үгийн сангийн онцлог*, УБ..

Мөнх-Амгалан, Ю, Кан шин, (2014), *Орчин цагийн монгол хэлний бүтээвэр судлал,* УБ.,

Самбуудорж, О, (2020), *Үг, үгийн гарал, хэлц судлал,* УБ., Соёмбо принтинг.

Төмөртогоо, Д, (2018), *Монгол үгийн гарлын тайлбар толь*, УБ., Адмон принт.

Цолоо. Ж, (1988), *БНМАУ дахь монгол хэлний нутгийн аялгууны толь бичиг Б. 2: Ойрд аялгуу*, УБ., БНМАУ-ын ШУА.

Цэндээ, Ю, (2001), *Дөрвөд аялгууны язгуурлаг үгс,* УБ., Ном притинг.

Черемисов, *Бурят-монгольско-русский словарь*, Москва., 1951

Mostaert, A., (1942). Dictionnaire Ordos (Vol. 2). Catholic University.

ХАВСРАЛТ

“Мө-“ язгуурт үг	Үгийн эрдэм шинжилгээний галиг	Үгийн тайлбар
Мөлгөр III	möliger	Жихүүн, зэврүүн байдал: **гадаа мөлгөр байх** (гадаа зэврүүн хүйтэн байх).
Мөлгөрдүү	möligerdegüü	1. Мөлгөр байрын; 2.бүлээн, зэгээн: мөлгөрдүү цай (зөөгдүү цай)
Мөлийлгөх III	möliilgekü	Халуун цай, хоол зэргийг бага зэрэг хүйтэн болгох.
Мөлийх IV	möliikü	Салхигүй тогтуун боловч жиндүүлэх, жихүүн байх: **мөлийсөн хүйтэн өдөр** (салхигүй зэврүүн өдөр).
Мөлийх V	möliikü	Хүйтнээр нь идсэн хоол унд шингэлгүй ходоод хүйт оргиулах: дотор мөлийх (гэдэс дотор хүйт даах, даарах), мөс залгисан шиг мөлийж, мод залгисан шиг гозойх [зүйр цэцэн үг] (а. Урам зориг, эрч хүчгүй болох; б. Маш их айх гэсэн санаа).
Мөлүү(н)	möligüü	– 1.Бага зэргийн хүйтэн зэгээн: **мөлүүн цай** (хүйтэн зэлгээн цай), **мөлүү оргих** (жихүүцэх), 2. Мөлгөр: **мөлүү болох** (ир ирмэггүй болох)
Мөлүүдүү	möligüdegüü	– Мөлүү байдалтай: **мөлүүдүү хоол** (хүйтэндүү хоол), **мөлүүдүү хүрз** (ир муутай, мөлгөрдүү хүрз) – *Гадаа гартал өвгөн манаач гуалигхан шулуун иштэй, мөлүүдүү төмөр хүрз түшиж зогсоно.* Т.Дэчингунгаа. Өөдрөг зам.
Мөлүүхэн	möligüken	Нэлээд мөлүүн, хүйтэвтэр: **мөлүүхэн шөл** (нэлээд хүйтэн шөл).
Мөндөр	möndür	Зуны улиралд үүлэн доторх борооны усан дуслууд өндрийн хүйтэн агаарт огцом хөлдөж, янз бүрийн хэмжээ бүхий бөөрөнхий үрэл хэлбэртэй мөс болон буух тунадас: **мөндөр орох** (бөөрөнхий, мөсөн тунадас орох), мөндөр цохих (үр тариа мэт зүйл мөсөн тунадаст цохигдон газарт унах), бороо мөндөр [хоршоо](жижиг мөсөн тунадастай хур) – *Мөст уулын оройдоо мөндөр бороо шаагьж...* Монгол ардын дуу., **аянга мөндөр** [хоршоо] (тэнгэрт хуралдсан цахилгаан цэнэг болон агаарын мөсөн тунадас), ***мөндөр буулгах** (ямар нэгэн зүйлээр зай завсаргүй шидэх, чулуудах), **чулуун мөндөр буулгах** (чулуугаар зай завсаргүй шидэх), ***мөндөр шиг асгарах** (зай завсаргүй , их хэмжээгээр асгарах) – *Дайсны хүнд хөнгөн пулемёт, их бууны сум мөндөр шиг асгарч эхэлжээ.* Т.Рэнцэн. Шинэ даваа., **мөөг шиг ургадаггүй, мөндөр шиг унадаггүй** [зүйр цэцэн үг] (аливаа ажил хэрэг тухайн хүнээс өөрөөс нь шалтгаалах гэсэн санаа).

Мөндөрлөх	möndürlekü	1. Мөндөр орох – *Зүс бороо нь нэг татарч дахин орж заримдаа хүйтэрч мөндөрлөх боллоо.* Б.Бааст. Алтайн хөх дөнөн; 2.[шилжсэн] Мөндөр мэт том том дусал зай завсаргүй орох, унах, асгарах: **нулимс мөндөрлөх** (нулимс асгарах) – *Хөвч солонго дагинын алаг хар нүднээс нь аяндаа аяганы чинээн рашаан хар нулимс мөндөрлөвд...* Монгод ардын баатарлаг туульс.
Мөндрөнцөр	möndürünčir	Мөндрөөс жижигхэн, хатуу тунгалаг, бөөрөнхий мөсөн тунадас
Мөс(өн) I	mösü	Хөлдөж хатуу төлөвт орсон ус- *Ус хэдий шингэн ч мөс болон хөлдөнө.* Ц.Дамдинсүрэн.
Мөсжих	mösü	1. Мөсний шинжтэй болох; 2. Мөс ихтэй болох.
Мөслөх	mösülekü	Ямар нэг зүйлийг хөлдөөх зорилгоор мөсөн дотор хадгалах.
Мөсөрхөг	mösürkeg	Мөс ихтэй.
Мөсөрхүү	mösürkeü	1.Мөс ихтэй; 2.Мөстэй төстэй.
Мөст	mösütü	Мөс бүхий: **мөст уул** (мөнхийн мөс цасанд хучигдсан уул) - *Мөст уулын оройдоо мөндөр бороо шаагьж…* Монгол ардын уртын дуу.
Мөстлөг	mösütülge	1. Мөсөөр хучигдсан байдал: **мөстмөл уул** (мөсөөр хучигдсан уул)
Мөстмөл	mösütümel	1. Мөсөөр хучигдсан байдал: мөстмөл уул (мөсөөр хучигдсан уул); 2. Мөхөөлдөс.
Мөстөл	mösütül	1. Мөстэй болох нь, мөстэй болж хөлдөх нь; 2. Мөсөөр бүрхмэл байсан үе: **мөстлийн галав** (геологийн түүхэн хөгжлийн явцад дэлхийн бөмбөрцгийн зарим хэсгийг мөсөөр бүрхэж байсан цаг үе), **мөстлийн завсар** (дөрөвдөгч галавт болсон хоёр удаагийн мөстлийн хоорондох зааг хугацаа)
Мөстөлт	mösütülte	Мөстөх үйлийн үр дүнг заасан нэр: **мөстөлт болох** (мөстөх үйл явц болох).
Мөстөх	mösütükü	1. Мөс тогтох: **гол мөстөх** (гол хөлдөж мөс тогтох) - *Голын ус шөнийн сэрүүнд мөстөн морьдын хөлийн аяар цөмөрч байлаа.* Ч.Алагсай. Алтайн зам; 2. Мод, бут зэрэг зүйлийн гадаргуугаар тогтсон цан мөс болох; 3. Юманд мөс барилдан тогтох: **сахал мөстөх** (сахлын үсэнд мөс тогтох).
Мөсч	mösüči	Мөсч хулгана амьтан эрт цагийн заан арслан.
Мөхөөл II	mökügel	Шингэн зүйлийн гадаргууг бүрхэн хөлдсөн нимгэн зайрмаг.
Мөхөөлтөх	mökügeltükü	Мөхөөл тогтох, мөхөөл бий болох: ус мөхөөлтөх (ус зайрмагтан хөлдөх) - Туул голын ус захаасаа мөхөөлтөн хөлдөв. Н.Банзрагч. Зам.
Мөхөөлдмөл	mökügeldümel	Шингэн зүйлийн гадаргуу зайрмагтан, хөлдөх нь: мөхөөлдмөл сүү (зайрмагтсан сүү).

Мөхөөлдөс	mökügeldüsü	Жимсний шүүс, сүү зэргийг тусгай аргаар боловсруулж хөлдөөсөн хүнсний бүтээгдэхүүн - Шилэн савтай жимсгэнэ, шинэхэн хийсэн мөхөөлдөс… байв. Д.Содномдорж. Түм буман хүүхэд., аарцтай мөхөөлдөс (аарц, сүү зэргийг тусгай аргаар найруулан боловсруулж хөлдөөсөн сүүн бүтээгдэхүүн).

“Хө-“ язгуурт үг	**Эрдэм шинжилгээний галиг**	**Үгийн тайлбар**
Хөгий	kögei	Өвөл төрсөн хурга, ишиг, дахлай.
Хөлдмөл	köldemel	Нэгэнт хөлдсөн юм; хөлдөөсөн амтлаг идээ.
Хөлдөлт	köldelte	Хөлдөх үйлийн үр дүн
Хөлдүү	köldegüü	1.Хүйтэнд хөлдөж хатуу болсон юм. 2. Хүний хөндий, хүйтэн, цэвдэг зан
Хөр	Kör	Хатуурч тогтсон юм; хөр цас (хатуурч дагтаршсан цас) – *Морь нь дагтаршсан хөр цас цөм цөм гишгэлэн явна. Л.Дашням. Бурхантын цэцэг.,* хөр шороо (хатуурч дагтаршсан шороо), бууцны хөр (хатуурч тогтсон бууц, хөрзөн хөлдүүс)
Хөрзөн	Körǰeng	Малын баас шээс хөлдөж дагтаршсанаас тогтсон хөр - *Хөрзөнгийн халуун илчинд бие нозоорч аяганы амсар зуунгуут нойр хүрч эхэллээ. Д.Мягмар. Тээрэмчин.,* хөрзөн давс (хөрлөсөн давс), хөр хөрзөн [хоршоо] (дагтаршсан хөр), бууц хөрзөн [хоршоо] (малын өтөг баас, түүний дагтаршиж хатуу болсон нь).
Хөрлөх	Körlekü	Хөр болох, хөртөх
Хөхүй	köküi	Өвөл гарсан төл: хөхүй хурга (өвөл гарсан хурга)

“Хү-“ язгуурт үг	**Эрдэм шинжилгээний галиг**	**Үгийн тайлбар**
Хүйгэх	Küigükü	1. Салхи жавар жижиг нүх, завсраар шуугин үлээх: хаяагаар салхи хүйгэх (гэрийн хаяагаар хүйтэн үлээх)
Хүйдэс	Küidesü	Үхрийн хөлдүү баас: хөлдүүс: малын хүйдэс (малын хөлдүү баас) - Малын хөлдүү хүйдсээр, хашаа саравчны салхи жавар цохидог талыг дагуулж хаалт хийх хэрэгтэй. Ж.Самбуу. Мал маллагааны арга туршлага., хотны хүйдэс арилгах (малын хэвтшийн хөлдүү өтгийг зөөж цэвэрлэх)
Хүйт	Küite	Хүйтэн: хүйт авах (салхи авах, салхинд цохиулах), хүйт даах (а. Хүйтэнд тэсвэрлэх; б. Хүйтэн жиндүү болох) - Агшин зуур хүйт даагаад бие нь чичрэв. Д.Содномдорж. Түм буман хүүхэд., хүйт оргих (а. Бага зэрэг даарах буюу биед хүйтэн байдал мэдрэгдэх - Миний бүх л бие хөрж, дотор хүйт оргино. С.Лочин. Сэтгэлийн өнгө;

		б. Сэтгэл эвгүйцэх - Ар зоо хүйт оргин, хайнагийн шарын хурц үзүүртэй сэлмэн эвэр нүдэнд харагдаад өмнөх газар эрээлжлэн байв. С.Лочин нар. Галтай залуу нас), хүйт орох (а. Хүйтэн байдалтай болох, хүйтрэх; б. Хүйт эхлэх) - Намрын жихүүн хүйт орсон зэврүүн үдэш гүйж явахад хөл хөнгөн ч өнгө нь товууцсан газарт товхтой гутал нь морин туурай шиг тов тов хийн сэтгэлд түгшүүртэй. Б.Өлзийсүрэн. Замын хүзүү., хүйт татах (жавар эхлэх, хүйтэн оргих) - Голын ус сайн халж амжаагүй дотор руу хүйт татан сэнгэнэж байв. П.Лувсанцэрэн. Хөдөөгийн дуун., хүйт эхлэх (өвлийн туйл болж есөн есийн наян нэгэн хоногийг тоолж эхлэх) - Мөр дарга бид хоёр өвлийн ид хүйт эхэлсэн цагт Хүрээнээс хойш яаран мордож одлоо. Ж.Дамдин. Үймээний жил
Хүйтдэх	Küitedekü	Дэндүү хүйтэн болох- Цай хүйтдээд ууж болохгүй байна.
Хүйтрүүлэх	Küiteregülkü	Хүйтрэхийг түр хүлээзнэх - Манайх хүйтрүүлж байгаад өвөлжөөндөө бууна. Яриа.
Хүйтрэлт	Küiterelte	Хүйтрэх үйлийн үр дүнг заасан нэр
Хүйтрэх	Küiterekü	Цаг улирлын уур амьсгал хүйтэн болох - Тоодог сүрэглэн бөөгнөөд шөнөдөө хүйтэрдэг боллоо, энэ жил цас эрт унах юм байлгүй, гэрийн давхарга, өвлийн хувцсаа сууринаас авч ирэх юмсан гэж ээжийн үглэх олшров. Б.Догмид. Цэнхэрлэн харагдана.
Хүйтхэн	Küiteken	Нэлээд хүйтэн: хүйтхэн шөнө (нэлээд хүйтэн шөнө)
Хүйтших	Küitesikü	Хүйтний шинж орох: цаг хүйтших (цаг улирал хүйтрэх шинж орох, хүйтний улирал эхлэх шинж орох).
Хүйтэвтэр	Küitebtür	Бага зэрэг хүйтэн - Майхан дотор хүйтэвтэр байв. С.Лочин. Сэтгэлийн өнгө.
Хүйтэн I	Küiten	Уур амьсгалын дулааны хэмжээ тэгээс дотогш хэм бүхий буюу халуун гэдгийн эсрэг утга: хүйтэн бүс (өмнөд, умард туйлын цагариг доторх газар), хүйтэн бороо (тэгээс дотогш хэмд орох бороо) - Гэрийн дотор жихүүн оргиж, шөнөдөө хүйтэн бороо орж, сэрүү татах янзтай байлаа. С.Удвал. Их хувь заяа., хүйтэн буцах (дулаарах) - Хэдий цаг ирж байвч, хүйтэн буцах шинж яагаа ч үгүй ажээ. Л.Түдэв. Улаан долгион.
Хүйтэндүүхэн	Küitendegüken	Нэлээд хүйтэндүү
Хүйтэндэх	Küitendekü	Хэтэрхий хүйтэн болох, хүйтдэх
Хүүрэг III	Keüreg	Ааруул ээзгий, амуу будаа зэрэг идээний амархан хэмхэрдэг, хэврэг болсон байдал: хүүрэг амуу (дарагдаж муудсан будаа), хүүрэг чанар (муу чанар).

2026 Fasc.2

МОНГОЛ ХЭЛНИЙ ТЭМДЭГ НЭР БҮТЭЭХ ТӨСӨӨТ ДАГАВРЫН ТУХАЙ

Ганбаатарын ЛХАГВАНАРАН
МУБИС-ийн Монгол хэл, уран зохиолын багшийн I курсийн оюутан

Удирдагч: Х. Гэндэнпил
ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн ЭШДэА, докторант

Хураангуй: *Монгол хэлний тэмдэг нэр нь жинхэнэ нэр, үйл үгийн өмнө үндсээрээ тохиолдож, тэдгээрээр тэмдэглэгдэж байгаа хүн амьтан, юмс үзэгдлийн шинж чанар, өнгө зүс, төрх байдал, бэлгэ тэмдэг, үйл хөдлөлийн болц байдлыг нэрлэх үл хувилах үг юм. Энэхүү судалгааны ажилд монгол хэлний тэмдэг нэр бүтээх төсөөт дагавар, тэдгээрийн үүсэх зүй тогтол, утга, хэрэглээний ялгааг хэлний баримтад тулгуурлан тайлбарлав. Ингэхдээ тэмдэг нэр бүтээх төсөөт дагаврыг дан болон хэлц бүтээврийн түвшинд авч үзсэн болно.*

Түлхүүр үг*: Тэмдэг нэр, төсөөт үг, төсөөт дагавар, дан бүтээвэр, хэлц бүтээвэр, утга*

УДИРТГАЛ

Судалгааны ажлын зорилго: Монгол хэлний тэмдэг нэр бүтээх төсөөт бүтээврийн үүсэх зүй тогтол, бүтэц, утга, хэрэглээний ялгааг тодорхойлоход бидний судалгааны ажлын зорилго оршино.

Зорилт:

- Тэмдэг нэр бүтээх төсөөт дагаврыг хэлний баримтаас тодруулах;
- Тэмдэг нэр бүтээх төсөөт дагаврыг бүтцээр нь ангилах;
- Тэмдэг нэр бүтээх төсөөт дагаврын утга, хэрэглээний ялгааг хэлний баримтад тулгуурлан тодорхойлно.

Сэдвийн судлагдсан байдал: Хэл шинжлэлийн ном бүтээлд Ц. Өнөрбаян *-мхий, -мтгай*[4]*, -мгай*[4] зэрэг дагаврыг *-хай*[4] дагаврын хувилбар гэсэн бол[1] Б.Идэрбаяр *-рхуу*[2] *~ рхаг*[4]*, -мгай*[4]*~мтгай*[4]*,* -л *~ л-да*[2] *~ -да*[2]*, -гчин ~ гтэй ~ гтэн,*

[1] Өнөрбаян, Ц., *Орчин цагийн монгол хэлний үг зүй,* УБ., 2004, х.40.

-гч ~ аач[4]*, -т ~ тан*[4] *~ тай*[4] зэрэг дагаврыг төсөөт бүтээвэр[2] гэж үзсэн байдаг. Төсөөт бүтээвэр нь төсөөт үг бүтээх (модорхог ~ модорхуу, уулархаг ~ уулархуу г.м) бөгөөд үгийн сан, утга зүйн асуудалтай давхар холбогдох юм.

Сэдвийн үндэслэл: Монгол хэлний үг бүтэх тогтолцоонд төсөөт дагавар чухал байр суурь эзэлдэг боловч тэмдэг нэр бүтээх дагаврын хэрэглээ, утгын ялгааг нарийвчлан судалсан ажил харьцангуй бага байна. Иймд тэмдэг нэр бүтээх төсөөт дагаврын утга, бүтэц, хэлбэрийг тодорхойлох нь хэрэглээний ач холбогдолтой юм.

Судалгааны ажлын шинэлэг тал, ач холбогдол: Тэмдэг нэр бүтээх төсөөт дагаврыг дан болон хэлц бүтээврийн түвшинд авч үзэн, үүсэх зүй тогтол, утга, хэрэглээний ялгааг тодорхойлсон. Өөрөөр хэлбэл төсөөт бүтээвэр бүхий төсөөт үг нь утгын хувьд ялимгүй ялгаатай юм. Үүнийг бид тэмдэг нэр бүтээх төсөөт дагаврын хүрээнд авч үзэв. Тэмдэг нэр нь хүн амьтан, юмс үзэгдлийн шинж чанар, өнгө зүс, төрх байдал, бэлгэ тэмдэг, үйл хөдлөлийн болц байдлыг нэрлэдэг. Иймд юмс үзэгдлийн шинж чанар, өнгө зүс, төрх байдлыг төсөөт бүтээврээр ялгаж илэрхийлэх нь монгол хэлний нэгэн өвөрмөц хэв шинж юм. Учир нь бүтээвэр бол хэлний хамгийн бага, утгат нэгж тул *-рхуу*[2] *~ -рхаг*[4]*, -мгай*[4] *~ -мтгай*[4]*, -втар (btur) ~ -тар (tur, tar) ~ -вар (bur), -мсаг (msuγ) ~ -саг (suγ) ~ -суу (suu), -р (r) ~ -й (i)* зэрэг дагавар нь хэлэхийн хам орчинд өөр өөр утга илэрхийлнэ.

Судалгааны ажлын арга зүй, хэрэглэгдэхүүн: Энэхүү судалгаанд тэмдэг нэр бүтээх төсөөт дагаврын утга, хэрэглээний ялгааг тайлбарлахын тулд задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, тайлан тайлбарлах зэрэг аргыг хослуулан ашиглав. Тэмдэг нэр бүтээх *-рхуу*[2] *~ -рхаг*[4]*, -мгай*[4] *~ -мтгай*[4]*, -втар ~ -тар ~ -вар, -мсаг ~ -саг~ -суу, -р ~ -й* зэрэг төсөөт бүтээврээр тоймлож, монгол хэлний баримтад тулгуурлан тайлбарлахыг зорьсон болно.

СУДАЛГААНЫ ҮНДСЭН ХЭСЭГ

“Монгол хэлний төсөөт үгийг хэлбэр ба утгаараа нэгэн зэрэг хагас буюу бүрэн бус тохирох нэгж гэж тодорхойлж болно. Үүнийг хэлний төсөөт үг (параномия) гэнэ. Харин хэлбэрээрээ төстэй, утгаараа огт өөр үгсийг хэлэхийн төсөөт үг буюу төсөөрхүү үг (параномизация)”[3] гэж тодорхойлжээ.

“Төсөөт үг нь дагавраар, үгийн салаа утгаар, үгийн утга эсрэгцэн салаалах ёсоор, гарал нэгтэй үгсээр, тус тус үүснэ. Төсөөт үг нь ойролцоо ба салаа утга, эсрэг ба зүйчилсэн утгат үгсийн аль алинтай нь утга зүйн харьцааны хувьд

[2] Идэрбаяр, Б., *Монгол хэлний төсөөт үг,* УБ., 2005, х.15.
[3] Идэрбаяр, Б., *Монгол хэлний төсөөт үг,* УБ., 2005, х.9.

нарийн холбоотой юм. Түүнээс гадна төсөөт үгийг хэл, хэлэхийн гэж ялгаж болно" гэжээ. Иймд тэмдэг нэр нь төсөөт дагавраар үүснэ. Б. Идэрбаяр *-рхаг ~ -рхуу, -л ~ -лда ~ -д, -магаи ~ -матагаи, -гчин ~ -гтэн ~ -гтэи, -гч ~ -ээч, -т ~ -тэн ~ -тэи* зэрэг дагаврыг төсөөт бүтээвэр[4] гэж үзсэн байдаг.

Бид монгол хэлний төсөөт дагаврыг утга, бүтэц, хэлбэр талаас нь авч үзнэ. Монгол хэлний баримтад эдгээр төсөөт дагавраас гадна *-втар ~ -тар ~ -вар, -мсаг ~ -саг ~ -суу, -р ~ -й, -д ~ -с* зэрэг төсөөт дагавар байна.

Монгол хэлний тэмдэг нэр нь жинхэнэ нэр, үйл үгийн өмнө үндсээрээ тохиолдож, тэдгээрээр тэмдэглэгдэж байгаа хүн амьтан, юмс үзэгдлийн шинж чанар, өнгө зүс төрх байдал, бэлгэ тэмдэг, үйл хөдлөлийн болц байдлыг нэрлэх үл хувилах үг юм[5].

Нэрээс тэмдэг нэр бүтээх *-лаг, -н, -рхаг, -рхуу, -чуул, -втар* (нарлаг, тарган, уулархаг, уулархуу, настайчуул, боровтор) зэрэг дагавар нь зөвхөн идэвхтэй язгуураас үг бүтээдэг дагавар юм[6]. Монгол хэлний *-втар ~ -тар ~ -вар, -мсаг ~ -саг ~ -суу, -магаи ~ -матагаи* зэрэг төсөөт дагавар нь идэвхтэй язгуураас тэмдэг нэр бүтээх бол зарим тохиолдолд идэвхгүй язгуураас тэмдэг нэр бүтээх *-р ~ -й* гэсэн дагавар бий.

Дан бүтээвэр

Бид төсөөт дагавартай 120 үг түүвэрлэснээс дараах тэмдэг нэр бүтээх дагаврыг дан бүтээврийн түвшинд авч үзлээ. Үүнд:

- *-р (r) ~ й (i)*
- *-г (γ, g) ~ уу[2] (γu, gü)*
- *-втар (btur) ~ тар (tur, tar) ~ вар (bur)*

Монгол хэлний идэвхгүй язгуураас тэмдэг бүтээх *-р (r) ~ й (i)* гэсэн дагавар нь төсөөт дагавар юм. Тухайлбал, балар хэмээх үг нь "үл мэдэгдэх эрт урьдын цагийн шинж, аливаа юмны тодорхойгүй бүдэг" гэсэн утгатай бол балай гэх үг нь "бүдүүлэг, мунхаг, ухаан солиу" гэсэн утгатай. Иймд "*р (r)*" дагавар нь орон цагийн нэр үүсгэж байгаа бол "*й (i)*" дагавар нь тэмдэг нэр бүтээж байна. Энэ нь дүлэр (Mo. düler) ~ дүлий (Mo. dülei), элэр (Mo. eler) ~ элий (Mo. elei) гэсэн үгнээс тодорхой харагдаж байна.

- *-г (γ, g) ~ уу[2] (γu, gü)*


Д. Соронзон тус бүтээврийг гарлын хувьд тэмдэг нэр бүтээх *(-уу[2])* дагавар бол *"γ+u"* буюу *"g + üü"* гэсэн нийлмэл бүтэцтэй дагавар юм. *"γ/g"* нь тэмдэг нэр бүтээх үүрэгтэй. Жишээ нь: "зожи-г, тарчи-г" г.м. Мөн *"у (үү)"* ч тэмдэг

[4] Идэрбаяр, Б., *Монгол хэлний төсөөт үг,* УБ., 2005, х.15.
[5] Өнөрбаян, Ц., *Орчин цагийн монгол хэлний үг зүй,* УБ., 1994, х.160.
[6] Ганбаатар, Ж., *Монгол хэлний дагавар байр, үүрэг, хэрэглээ,* УБ., 2023, х.8.

нэр бүтээх үүрэгтэй юм. Тиймээс тус дагаврыг *"-ра[2], -рха[2]"* төгсгөлтэй зарим язгуур, үндсэнд залгахдаа дан гэдсээр бичдэг. Мөн заримдаа нэг язгуур, үндсэнд хоёр дагаврын аль алиныг залгах нь ч бий. Жишээ нь: Бэгэрэ-г ~ бэгэр-эү, усурха-у гэх мэт. Тиймээс үүнийг үг бүтээх дагаврын утга, үүрэг сулрах үзэгдэлтэй холбон ойлгох нь зүйтэй бөгөөд ямар нэг гийгүүлэгч хасаж бичсэн хэрэг биш[7] гэжээ.

Тус бүтээвэр нь илүү (Mo. ilegüü) ~ үлэг (Mo. ülüg), зүдэг (Mo. ǰüdeg) ~ зүдүү (Mo. ǰüdegüü), бааряг (Mo. baγaraγ) ~ бааруу (Mo. baγarau) гэх мэтээр хэлний баримтад тохиолдож байна. Энэхүү üle- язгуур нь үлдэх, үлэмж зэрэг үндэс үүсгэнэ. Илүү гэдэг үг ойрад аялгуунд "ülü" гэсэн хэлбэртэй.[8] Иймд "илүү, үлэг" хоёр нь язгуур нэгтэй, төсөөт дагавар бүхий үг юм. Орчин цагийн монгол хэлэнд 'үлэмж', 'аварга' гэсэн утгатай бөгөөд үлэг гүрвэл хэмээх үгээс харж болно. Зүдэг (Mo. ǰüdeg) нь "бохир, муухай, шившигтэй явдал, ёрын, хэцүү бэрх", зүдүү (Mo. ǰüdegüü) нь "эдэлж хэрэглэх, идэх уухаар дутмаг байдал" гэсэн утгатай юм. Бааряг (Mo. baγaraγ) нь "омтгой, хуумгай" гэсэн утгатай бол бааруу (Mo. baγarau) нь буцаж няцдаг, итгэлгүй, найдваргүй гэсэн үг юм. Иймд үлэг, зүдэг, бааряг гэх үгс нь тодорхой утгатай бөгөөд хэрэглээ давтамж багатай бол илүү, зүдүү, бааруу нь барагцаалсан, ерөнхий тойм утгатай, хэрэглээ давтамж өндөр байна.

Бүдүүвч 1. "-втар" дагаврын салаалсан байдал




1. Орчин цагийн монгол хэлэнд *-втар[4] (btur)* дагавар нь аливаа юмны шинж чанар, дүр байдлыг бууруулсан утгатай. Тухайлбал *-втар (btur) ~ -тар (tur) ~ -вар (bur)* гэсэн төсөөт дагавар байна.

2. Цагаавтар (Mo. čaγabtur) ~ цагаавар (Mo. čaγabur) ~ цайвар (mo. čayibur), хөхөвтөр (Mo. kökübtür) ~ хөхвөр (Mo. kökübür), ногоовтор (Mo. noγuγabtur) ~ ногоовор (Mo. noγuγabur) гэх мэт.

[7] Соронзон, Д., *Монгол бичиг (үгийн бүтэц, дүрэм, дасгал, тайлбар),* УБ., 2021, х.41.
[8] Цолоо, Ж., *БНМАУ дахь монгол хэлний нутгийн аялгууны толь бичиг,* УБ., 1998, х.885.

Тус -втар[4] дагаврыг В. Котвич metü “мэт” хэмээх жишин адилтгах үгээс гаралтай[9] гэсэн байдаг. Сурвалжийн баримтаас үзэхэд жишин адилтгах утгатай bitür “битүр” гэсэн үг байжээ. 1794 оны монгол үгийг манж үсгээр галиглан бичсэн дурсгал[10]-д *“...yamar ǰüyiler surbači basa ene **bitür** buiǰa nemeǰi čidaqu geǰiü ene čöm čini ese dassan qariya...”* хэмээн тохиолдож байна.



Зураг 1. XVIII зууны үеийн монгол үгийг манж үсгээр галиглан бичсэн дурсгал

“Гэнэт” гэсэн утгатай “бакжа” хэмээх үгээс бэлтгэн холбохын -магц нөхцөл, түүнчлэн *“-ж+орхи → -чих, ...-аад+орхи → -аадах”, “ууу (Мо. uruγu) → руу (Мо. uruγu)*” хэмээн хураагдсан нь бие даасан үг залгавар бүтээвэр болсны жишээ юм[11]. Үүнтэй адил жишин адилтгах утгатай “битүр” хэмээх үг “*-втар*” дагавар болж, хэлний хөгжлийн явцад ***-втар**[4] **-тар**[4] **-вар**[4]* болж салаалсан байна. Тухайлбал, ногоовтор (цайвардуу ногоон өнгө) ~ ногоовор (хар ногоон өнгө). Мөн айхавтар (аймшигтай аюултай; овсгоо самбаатай) ~ айхтар (сүрхий), хөхөвтөр (бага зэрэг хөх, хөх өнгө нь багавтар) ~ хөхвөр (хөх сортой цагаан өнгө).

Айхавтар хэмээх үг нь аймшигтай аюултай; овсгоо самбаатай гэсэн эсрэг утгыг илтгэж байна. Монгол хэлнээ “дүүрэх (дуусах) ↔ дүүрэх (бялхах), үлээх

[9] Өнөрбаян, Ц., Жумдаан, Л., нар *Монгол хэл судлал үг зүй,* УБ., 2022, х.6.
[10] https://iiif.lib.harvard.edu/manifests/view/drs:45707103$8i
[11] Өнөрбаян, Ц., Соронзон, Д., 2019., *Монгол үгийн гарал судлалын үндэс,* УБ., 2019, х.76.

(асаах) ↔ үлээх (унтраах), хадах (товч хадах, дуу хадах) ↔ хадах (өвс хадах), төгсөх (дуусах) ↔ төгсөх (төгс бүрэн) гэхчлэн үгийн утга эсрэгцэн салаалах нь бий”[12]. Ийнхүү үгийн утга эсрэгцэн салаалахыг энантиосемия гэдэг. Харавтар, шаравтар, навтар гэхэд шинж тэмдгийг бууруулж байгаа бол айхтар, сайтар гэхэд шинж чанарыг эрчимжүүлсэн утгатай байна. Иймд үгийн утга эсрэгцэн салаалдгийн адилаар дагаврын утга мөн эсрэгцэн салаалдаг ажээ.

Нийлмэл (хэлц) бүтээвэр

Хоёр бүтээврээс тогтсон нийлмэл бүтээврийг *хэлц бүтээвэр*[13] гэнэ. Монгол хэлэнд тэмдэг нэр бүтээх *-мсаг (msuγ) ~ саг, (suγ)~ суу (suu), -рхаг ~ рхуу, -магаи ~ матагаи* гэсэн хэлц дагавар бий. Хэлний баримтаас утга, хэрэглээний ялгааг тодруулъя.

а). -мсаг[4] -саг[4] -суу[4] дагавар

Монгол хэлний нэрээс тэмдэг нэр бүтээх *-саг[4] “-sa+γ”* гэсэн нийлмэл дагавар болон шиг, мэт гэсэн утгатай *“-msuγ”* хоёр нь төсөөт дагавар юм. Тухайлбал, хүүхэмсэг хэмээх үг нь “хүүхэн хүний зан байдалтай, хүүхэн шиг; нэлээд шалиг зантай хүн” гэсэн утгыг илтгэж байна. Тэмдэг нэр бүтээх *-саг[4] (sa[2]+γ)* дагавар нь аливаад тэмүүлэлт шинжийг илэрхийлсэн утгатай бол *-мсаг[4] (-msuγ)* дагавар нь жишин адилтгах утгатай юм.

хүүхэмсэг (Mo. keükemsüg) ~ хүүхэмсэг (Mo. keükemseg) ~ хүүхэмсүү (Mo. keükemsügü)

элгэмсэг (Mo. eligemseg) ~ элэгсэг (Mo. eligeseg) ~ элгэмсүү (Mo. eligemsügü)

эрхэмсэг (Mo. erkimseg) ~ эрхэмсүү (Mo. erkemsügü),

эрхэмсэг (Mo. erkimsüg erkin+msüg)

b). -рхаг[4] ~ рхуу[2] дагавар

Монгол хэлний нэрээс үйл үг бүтээх *-рх* дагавар болон тэмдэг нэр бүтээх *-уу[4] (-γu)* дагавар нийлж *-рхагу (-rqaγu)* хэмээх нийлмэл дагавар болжээ. Энэхүү нийлмэл дагавраас “*γ*”- нь сугарч -рхуу, “u”- нь сугарч, *-рхаг* болон хоёр салаалж хувьссан байна. Б. Идэрбаяр “Тэмдэг нэр бүтээх ра-ка-г~р-ка-у (-р-ка-гу) хоёр нь -ка-гу гэсэн нийлмэл залгаврын “г” нь гээгдсэн эсэхээс шалтгаалан “г”-т нь тухайн юмын элбэг шинж” нь тодорхой гэсэн утгыг зааж байгаа бол “г”-гүй нь тухайн юмыг “элбэг шинж” нь тодорхой бус, таамагласан байдалтай”[14] гэсэн байна.

дээрэлхүү (Mo. degerelkeü) ~ дээрэлхэг (Mo. degerelkeg)

баярхуу (Mo. bayarqau) ~ баярхаг (Mo. bayarqaγ)

биерхүү (Mo. beyerkeü) ~ биерхэг (Mo. beyerkeg)

[12] Идэрбаяр, Б., *Монгол хэлний төсөөт үг,* УБ., 2005, х.4.
[13] Базаррагчаа, М., *Монгол хэлний бүтээвэр судлал.* УБ., 2017, х.667.
[14] Идэрбаяр, Б., *Монгол хэлний төсөөт үг,* УБ., 2005, х.15.

с). -мхий, -мтгай[4], -мгай[4] дагавар

Цэцэнцогт “-ma-qa-i”~ “-ma-γa-i” дагавар нь гарал нэг. “-ma-γa-i” дагаврын завсар “-ta” үе-утгалбар шурган орсон ажээ. Эдгээрийн завсар “ta...” үе-утгалбар шургаж орж болно[15] гэсэн байна. Иймд *-мхай[2], -мтгай[2], -мгай[2]* зэрэг дагавар нь гарлын холбоотой төсөөт дагавар юм. Тухайлбал, “аймхай байгаад хиймтгий, алжуу байгаад идэмхий”, “гуймхай мөртөө голомтгой” гэсэн хэлц үгэнд *-мхий, -мтгай[4]* хэмээх төсөөт дагавраар сүүл холбожээ.

аврамхай (Mo. aburamaqai) ~ аврамтгай (Mo. aburamataγai) ~ аврамгай (Mo. aburamaγai)

гулгамхай (Mo. γulγumaqai) ~ гулгамтгай (Mo. γulγumataγai) ~ гулгамгай (Mo. γulγumaγai)

гуймхай (Mo. γuyumaqai) ~гуймтгай (Mo. γuyumataγai) ~ гуймгай (Mo. γuyumaqai) *-мтгай[2]*

хэмээх дагавар дахь оруулбар *“-ta”* нь гээгдвэл *-мгай, -мхай* дагавар салаалсан ба “уг үйлийг богино хугацаанд чадмаг гүйцэтгэх” гэсэн утга илтгэнэ[16]. Мөн *-мтгай[2]* нь тухайн үйлийг давтан үйлдэх утга илэрхийлдэг. Жишээлбэл, мартамтгай (Mo. martamataγai) нь (аливаа үйл, хэлсэн үгээ байнга мартах), гулгамтгай (Mo. γulγumataγai) нь (гулгах нь олонтоо, байнга гулгаж явдаг) гэх мэт.

ДҮГНЭЛТ

Монгол хэлний тэмдэг нэр бүтээх төсөөт дагаврыг дан болон хэлц бүтээвэр гэж ангилна. Дан бүтээвэр нь авиа сэлгэх *(r~i),* авиа сугарах *(-γu[2] → γ, btur → tur),* авиа сулрах *(bitur → -wtur[4]),* авиа ондооших *(tar[4] → tur[4])* зэрэг хувьслын үр дүнд үүсэж байна. *r (р)* дагавраар цагийн нэр, *i (й)* дагавраар тэмдэг нэр бүтээн үгсийн аймаг ялгана. Харин *γ/g* дагавар нь товч, тодорхой утгатай бол *-γu/gü нь* барагцаалсан, ерөнхий тойм утгатай. Бие даасан үгээс үүссэн *-btur* дагавар нь шинж тэмдэг бууруулах бол эсрэгээрээ *-tur* нь шинж тэмдэг эрчимжүүлэх, *-bur* нь шинж тэмдэг сүлэлдэх, *-tar* нь жишин адилтгах утга илтгэж байна.

Хэлц бүтээвэр нь үйл үг бүтээх дагавар болон тэмдэг нэр бүтээх дагаврын нийлцээс бүтэж байна. Ингэхдээ үе нэмэгдэх (*mаγai) → (ma**ta**γai*), авиа ондооших *(maqai → maγai)*, авиа сулрах *(msuγ → suu)* зэрэг хувьслын үр дүнд бий болжээ. Дагаврын утгыг харьцуулбал *mataγai[2]* нь давтан үйлдэх утга илэрхийлдэг бол *maqai ~ maγai* дагавар нь үйлийг богино хугацаанд чадмаг гүйцэтгэх утга илтгэнэ. Мөн *-saγ* нь аливаад тэмүүлэлт шинжийг илэрхийлсэн утгатай бол *-msuγ* дагавар нь жишин адилтгах утгатай юм. Нийлмэл дагавраас *γ* нь сугарч -рхуу, u

[15] Идэрбаяр, Б., *Монгол хэлний төсөөт үгийн тухай,* УБ., 2022, х.110.
[16] Базаррагчаа, М., *Монгол хэлний бүтээвэр судлал,* УБ., 2017, х.171.

нь сугарч, *-рхаг* болон хоёр салаалж хувьссан. Тэмдэг нэр бүтээх -рхаг дагавар нь юмны элбэг шинж тодорхой гэсэн утгыг зааж байгаа бол -рхуу дагавар нь тухайн юмны элбэг шинж тодорхой бус, таамагласан утга илтгэж байна.

ABOUT IMAGINARY SUFFIXES USED TO CREATE NAMES FOR SYMBOLS IN THE MONGOLIAN LANGUAGE

In the Mongolian language, adjectives are indeclinable words that occur before nouns and verbs in their root form, expressing the qualities, colors, appearances, symbolic meanings, and states or conditions of actions associated with people, animals, objects, and phenomena. This study examines the derivational suffixes used to form adjectives in Mongolian, explaining their formation patterns, meanings, and differences in usage based on linguistic evidence. In doing so, the study considers adjective-forming derivational suffixes at both the individual suffix level and the phrasal construction level.

Keywords: *adjective, imitative word, derivational suffix, simple construction, phrasal construction, meaning*

НОМ ЗҮЙ

Базаррагчаа, М., (2017), *Монгол хэлний бүтээвэр судлал,* УБ.

Ганбаатар, Ж., (2023), *Монгол хэлний дагавар байр, үүрэг, хэрэглээ,* УБ.

Өнөрбаян, Ж., (2004), *Орчин цагийн монгол хэлний үг зүй.* УБ.

Идэрбаяр, Б., (2005), *Монгол хэлний төсөөт үг,* УБ., Төмөр замын хэвлэх үйлдвэр.

Идэрбаяр, Б., (2022), *Монгол хэлний төсөөт үгийн тухай,* УБ.

Өнөрбаян, Ц., Жумдаан, Л., Саруул-Эрдэнэ, М., Ганбаатар, Ж., (2022), *Монгол хэл судлал үг зүй,* УБ.

Өнөрбаян, Ц., (1994), *Орчин цагийн монгол хэлний үг зүй,* УБ., Есөн эрдэнэ ББХ.

Өнөрбаян, Ц., Соронзон, Д., (2019), *Монгол үгийн гарал судлалын үндэс,* УБ., Соёмбо Принтинг.

Соронзон, Д., (2021), *Монгол бичиг (үгийн бүтэц, дүрэм, дасгал, тайлбар),* УБ., Арвай бархан.

Цолоо, Ж., (1988), *БНМАУ дахь монгол хэлний нутгийн аялгууны толь бичиг,* УБ., ШУА хэвлэл.

Цахим эх сурвалж

https://iiif.lib.harvard.edu/manifests/view/drs:45707103$8i. (1764).

https://mongoltoli.mn/

2026 Fasc.3

“МОНГОЛ И ЮЙ” ТОЛЬ БИЧГИЙН НЭМЭЛТ ДЭВТРҮҮД ДЭХ ЦАГ УЛИРЛЫН АЙМГИЙН ҮГИЙН САНГ ХАРЬЦУУЛАХ НЬ

Чимиддоржийн ӨНӨРЗАЯА
МУИС-ийн Багш, монгол хэл, уран зохиолын боловсрол хөтөлбөрийн III курсийн оюутан

Удирдагч: М. Жавхлан
МУИС-ийн Монгол хэл, хэл шинжлэлийн тэнхимийн багш, доктор (Ph.D), дэд профессор

Хураангуй: *Юань, Мин гүрний үеэс олон хэлний толь бичгүүдийг[1] зохиож эхэлсэн бөгөөд эдгээр нь дундад үеийн монгол хэлний судалд чухал баримт болдог билээ. Олон хэлний толь бичгийг хэл шинжлэл, түүх зэрэг олон хүрээнд судалж байна. Хэл шинжлэлийн үүднээс хятад хэлний галиг, зарлигийн бичгийн орчуулга, үгийн хувьсал зэргийг анхааран судалсаар байна. Гэвч олон хувилбарыг харьцуулж, зүйл тус бүрийг анхааран судалсан нь цөөн байна. Тиймээс бид энэхүү өгүүлэлд Монгол и юй толь бичгийн дөрвөн хувилбарыг үгийн сангийн хүрээнд харьцуулан ижил болон ялгаатай талыг шинжлэхээр зорив. Арга зүйн хувьд харьцуулах, задлан тайлбарлах аргыг ашиглаж, эрдэм шинжилгээний галигт буулган үгийн санг ангилж, нэмэлт дэвтрүүд дэх адил болон ялгаатай тэмдэглэсэн үгсийг харьцуулан тайлбарлав. Тус судалгаагаар дундад үеийн монгол хэлний толь бичгүүдийн уламжлал хийгээд түүний харилцан нөлөөллийг тодруулж, нэмэлт дэвтрүүд дэх ялгаатай байдлыг хэлний бариматаар харуулав.*

Түлхүүр үг: *Олон хэлний толь бичиг, Монгол и юй толь бичиг, нэмэлт дэвтэр, үгийн сан, харилцан нөлөөлөл*

УДИРТГАЛ

[1] Юань, Мин гүрний үед Хятад үндэстэн газар зүй болон улс төрийн холбоо хамааралтай улс оронтой мэдээлэл солилцох, албан бичгийн орчуулга зэрэг шалтгаанаар тус бүр толь бичиг зохиож байжээ. Үүнд, Хятад-Монгол, Хятад-Солонгос, Хятад-Төвөд, Хятад-Түнгүс зэрэг олон толь бичиг байгаа бөгөөд эдгээрийг олон хэлний толь бичиг хэмээн нэрлэдэг болно. Бид энэхүү өгүүлэлд гагц Хятад-Монгол хэлний толь бичгийн хувилбаруудыг харьцуулан шинжилсэн болно.

Судалгааны ажлын үндэслэл. Дундад зууны үед улс төрийн шаардлагаар монгол хэлийг сурах судлах хэрэгцээ их байжээ. Тиймээс тухайн үед холбогдох монгол хэлний сурвалжийн баримт олон байдаг болно. Үүний нэг нь "Хуа и и юй" толь бичиг юм. Одоогоор бидэнд Юань, Мин гүрний үеэс уламжлагдсан "Монгол И Юй" болон хятад монгол орчуулга үгсийн цуглуулга (толь бичиг) арав гаруй хувилбар байна. Эдгээрийн дотроос "Монгол и юй" бичгийг анх зохиосон[2] гэж үздэг. Үүнээс хойш "Хуа и и юй" толийг 1389 онд хааны зарлигаар Хоу Иен-жи, Ма-ша и-хе гэдэг хоёр түшмэлд нанхиад-харь үгийн толь зохиохыг даалгажээ. Уг толийг зохиох ажил долоон жил үргэлжилжээ. 15 дугаар зууны хоёрдугаар хагаст мөн иймэрхүү толь бичиг хэвлэгдсэн бөгөөд тэдгээр нь 1389 оны "Хуа и и юй" тольтой адил боловч доторх үг ба үгийн тоо нь өөр өөр байна[3] хэмээжээ. Тус нэмэлт дэвтрийн тухай Х. Лувсанбалдан нар[4] "1389 оны эхэд цаг улирлын зүйлд өдөр, цаг, шөнө, хавар, зун, өвөл, намар гэх мэт ерөнхий нэр бүхий 24 үг орсон бол дараагийн нэмэлт дэвтэрт нь сар гэдэг ерөнхий нэрийг дотор нь салбарлуулан хувь сар (цагаан сар), хужир сар (II сар), өгэлжин сар (III сар), хөхөө сар (IX сар) гэх мэт нэр томьёог оруулсан байна." хэмээжээ. Үүнээс үзэхэд тус нэмэлт дэвтрүүдэд арван хоёр сарын нэрлэлтийг зарим хувилбарт тэмдэглэсэн, зарим хувилбарт тэмдэглээгүй байгаа нь ямар шалтгааны улмаас тэмдэглээгүй байна вэ?, он цагийн хувьд ямар дарааллаар зохиогдсон байна вэ?, эдгээр үгс нь өөр сурвалжуудад тохиолдож байна уу? зэрэг асуудлын хүрээнд түүхэн хэл зүйн үүднээс судлах шаардлага буй болж байна. Тиймээс бид энэхүү өгүүлэлдээ "Хуа и и юй" толь бичгийн дөрвөн нэмэлт дэвтэр ("Монгол и юй (Жи Шүний бар), "Хан хуа дэвтэр", "Нань хуа дэвтэр", "Хуа и и юй толь бичиг)-ийг судалгааны эх хэрэглэгдэхүүн болгон ашиглаж, "Цаг улирал"-ын аймгийн үгийн санг харьцуулан, ижил бол ялгаатай талыг тодруулахаар зорилоо.

Судлагдсан байдал. Олон хэлний толь бичгийг хэл шинжлэл, түүхийн хүрээнд харьцуулах, задлан тайлбарлах, үгсийг сэргээх зэрэг аргаар өнөөг хүртэл судалсаар байна. Аливаа хэлний үгийн сан нь гадаад бодлого, улс төр, худалдаа наймаа, соёл шашны олон талын нөлөөгөөр өөрчлөгдөн солигдож байдаг. Энэ үүднээс толь бичгийн судалгаанд тухайн хэлний үгийн сан өөрчлөгдөх тутам хэл шинжлэлчид толь бичгийг шинэчлэн боловсруулдаг уламжлалтай. Тиймээс энэхүү толь бичгийг нэмэн найруулан шинэчилж байсан нь нэмэлт дэвтрүүдээс ажиглагдаж байна.

---

[2] Manduqu. Ö., *"Huwa i yi bičig"* öbermongγul-un ündüsün-ü heblel-ün qoriy-a., 1995, x.47.

[3] Шагдарсүрэн, Ц., нар, *Үгийн сан, утга зүй, Монгол хэл судлал, Боть Х*, УБ., 2022, х.260.

[4] Lubsangbaldan, Qa., Boosiyang., *Huwa i yi toli-yin jarim keseg,* kele jokiyal teüke sedkigül (№41) 1959, x.17.

Монгол, хятад, солонгос, түрэг, төвөд зэрэг *олон хэлний толь бичиг* зохиогдсон тул бид энд зөвхөн "монгол-хятад" толь бичгийн судлагдсан байдлыг товч танилцуулъя.

Poppe. N, Ligeti. L, зэрэг судлаачид харьцуулсан авиа зүй, монгол үгийг хятад галигаар тэмдэглэсэн онцлог, зарлигийн бичгийн орчуулга зэргийг анхааран судалжээ.

Huo, Yuan Jie, A.B.Apatoczky, Kuribayashi. H., Rykin. P., зэрэг судлаачид тус толь бичгийн хятад эхийн галиг, умард юанийн хятад хэлний авиа зүйн тогтолцоо, хувьсал зэргийг голлон судалсан байна.

Kazue Iwasa[5] нь хэл шинжлэлийн газар зүй (geolinguistic)-ийн үүднээс И бичгийг судлан шинжилж, Хятадын баруун өмнөд хэсэг болон Вьетнам, Лаосын хойд хэсэгт амьдардаг И угсаатны хэлний авиа зүй, тархалт зэргийг судалжээ.

Уг толь бичгийг өвөр монголын судлаачид "Монголын нууц товчоон"-ы хятад галигтай харьцуулан судалсан нь нэлээд байна. Мөн Х. Лувсанбалдан, Бао Сянь, Шонхор, Мандах нар Хуа и и юй толь бичгийн нэмэлт дэвтрийн гэрэл зургуудыг хэвлүүлж, судалгааны эргэлтэд оруулснаас гадна зарим үгийг сэргээж, мөн холбогдох тайлбарыг хийсэн байна.

Мөн Н. Туяацэцэг "13-20 дугаар зуунд монгол бичгийн хэлэнд орсон хятад үг" гэх судалгааны ажилдаа хятад хэлнээс монгол хэлэнд орсон 390 үгийг бүртгэн гаргаж, зарим Хуа и и юй-д холбогдох үгийг тайлбарласан[6] бол М. Жавхлан монгол хэлний зарим үгийг галиглахдаа шинээр зохиосон хятад үсгийг тогтоож, тэдгээр нь дээрх сурвалжуудад хэрхэн тохиолдож байгааг бүртгэсэн[7] байна. Эдгээрээс үзвэл Хуа и и юй толь бичгийн нэг зүйл, аймгийг дангаар нь харьцуулсан судалгаа цөөн байна.

Судалгааны онол, арга зүй. Хүн төрөлхтний нийгмийн хөгжлийн зүй ёсны шаардлагаар толь бичгийн зүйл үлэмж олон болсноос гадна толь бичиг нь хөгжлийнхөө дүнд өөрийгөө судлах *толь бичгийн судлал* хэмээх салбар ухааныг буй болгосон. Энэ ухаан нь хэл шинжлэлийн үгийн сангийн судлалд багтах бөгөөд толь бичигт холбогдох бүхий л ажил, тухайлбал, толь зохиох арга барил хийгээд баримтлах зарчим тэргүүтнийг хэл шинжлэлийн онол, практикийн үүднээс хамран судалдаг байна[8]. Бид эх хэрэглэгдэхүүнд ашиглаж буй дөрвөн нэмэлт дэвтрийн цаг улирлын аймгийн үгсийг хөрвүүлж, эрдэм шинжилгээний галигт буулгав. Үгийн санг гурван хэсэгт ангилан нэмэлт дэвтрүүдтэй тулгахдаа

---

5 Iwasa. K., *Geolinguistic Analysis of the Yi Script written in Hua-Yi Yiyu.* In Proceedings of the fifth International Conference on Asian Geolinguistics., 2023, p.172–202.

6 Туяацэцэг. Н., *Монгол бичгийн хэлэнд орсон хятад үг XIII-XX*, УБ., 2003, х.39-63.

7 Жавхлан. М., *"Монголын нууц товчоон" ба "Хуа и и юй", "Монгол и юй" толь бичгийг галиглахад хэрэглэсэн "та" үсгийн судалгаа*, ALTAICA XII., 2015, х.77-84.

8 Шагдарсүрэн. Ц., нар, *Үгийн сан, утга зүй, Монгол хэл судлал, Боть Х*, УБ., 2022, х.260.

харьцуулах, задлан тайлбарлах аргыг ашиглав. Үгийн сангийн судалгааны арга зүйн хувьд *тусгай үгийн сан судлалын онол*-ын дагуу монгол хэлний үгийн санг түүхэн он цагийн үүднээс хэрхэн харилцан нөлөөлсөн, хувиран өөрчлөгдсөнийг ажигласан учир *түүхэн харьцууллын арга* (comparative-historical method)-ыг ашигласан болно.

СУДАЛГААНЫ ҮНДСЭН ХЭСЭГ

Судалгааны эх хэрэглэгдэхүүн:

1. Монгол и юй толь бичиг - (Жи Шүний бар) Жи Юанийн анхдугаар он (1264)-д хэвлэгдсэн толь бичиг учраас Жи юань и юй ч гэдэг. Хятад монгол орчуулгын толь бичгийн хамгийн анхны хэвлэл гэж үздэг бөгөөд хожим нь Хуа и и юй толь бичиг үүдлийг тавьжээ. Нийтдээ монгол хэлний 541 үгийг ханз үсгээр галигласан байдаг.
2. Хан хуа дэвтэр - Хань Фень Лю бичгийн гэрийн нарийн бичгийн дөтгөөр эмхэтгэл дэх Хуа и и юй толь бичиг дээд дэвтэр, өмнө нь оршил ба жишээ дүрэмтэй. Үүнийг Хан хуа дэвтэр хэмээн судалгаанд нэрлэдэг бөгөөд 1389 оны Хуа и и юй дэвтрээс эх авсан гэж үздэг. Зарим судлаачид тус дэвтрийг дөрвөлжин бичгээс эхтэй гэж үздэг.
3. Нань хуа дэвтэр - Мин гүрний орчуулгын ажилтны нэмсэн толь бөгөөд өмнө нь монгол бичгээр бичигдсэн жишээ дүрэмгүй дэвтэр юм. Үүнийг Хуа и и юй - а дэвтэр буюу хөх дэвтэр хэмээн нэрлэдэг. Тус дэвтэр БНХАУ-ын төв номын санд хадгалагдаж байгаа бөгөөд сан хөмрөгийн нэр нь Нань хуа дэвтэр юм. Тус дэвтрийг 1382 оны анхны Хуа и и юй дэвтрээс эх авсан гэж үздэг.
4. Хуа и и юй толь бичиг - Анх Хун Ү-гийн 15 дугаар он (1382)-д толийг анх зохиожээ. Хожим Хун Ү-гийн 22 дугаар он (1389) -д Хуа Юань Же нэртэй монгол хүн, Ма Ша Их Мухамад нэртэй мусалман хүн хааны зарлигаар нэмэн сайжруулсан байна. Ингээд тус тольд 17 зүйлд хуваасан 844 нэр томьёог багтаажээ. Ингэхдээ цаг улирлын 24 үгийн оруулсан байна. Хожим Хуа и и юй толь бичгийг нэмж, сайжруулан олон дахин хуулбарласан байдаг билээ.

Харьцуулан ангилсан үг

“Харь болоод харь бус аль нэгэн хэлээр бичсэн бичгийг уншин тайлах эсвэл ямар нэгэн бичигт буй утга учир нь бүгт буюу хуучин үг хэллэгийг тайлбарлах зэрэг аж төрөхийн шаардлагаар хүн төрөлхтөн толь бичгийг анх зохиож эхэлсэн

ажээ.[9] Үүний адилаар тухайн үеийн олон хэлний толь бичгүүдийг улс төрийн харилцаа холбоо, нийгэм соёлын шаардлагаар зохиосон байна. Эдгээрийн нэг нь Монгол и юй толь бичиг бөгөөд эх хэрэглэгдэхүүн болох дөрвөн хувилбарын "Цаг улирлын аймаг"-ийн үгийг дараах байдлаар ангилав.

Хүснэгт 1. Нэмэлт дэвтрийн үгийн ангилал

№	Ялгаатай байдлыг ангилсан нь	Үгийн тоо
1	Ижил утгатай, ижил бичигдсэн үг	19
2	Ижил утгатай боловч өөр үсгээр тэмдэглэгдсэн үг	5
3	Ганц хувилбарт тохиолдож буй үг	43
Дөрвөн хувилбарт буй үг (Давтагдаагүй тоогоор)		59

1. Ижил утгатай, ижил бичигдсэн үг

Бид нэмэлт дөрвөн дэвтэр дэх "Цаг улирал"-ын аймгийн үгийн сан дахь ижил утгатай, ижил бичигдсэн үгийг дараах байдлаар байдлаар ангилав.

Хүснэгт 2. Ижил утгатай бичигдсэн үг

Тохиолдож буй хувилбар	Ижил бичигдсэн үг
1. Монгол И Юй толь бичиг (Жин Шүний бар) 2. Хан хуа дэвтэр 3. Нань хуа дэвтэр 4. Хуа и и юй толь бичиг	Он- (hon)
	Зун- (jun)
	Намар- (namur)
	Өвөл- (öbül)
	Өдөр (ödür)
	Шөнө (söni)
1. Хан хуа дэвтэр 2. Нань хуа дэвтэр 3. Хуа и и юй толь бичиг	Балар эрт- (balar erde)
	Манахар эрт- (manaqar erte)
	Дулаан- (dulaqan)
	үдэш (üdesi)
	Завсар шөнө- (jabsar söni)
	Цаг (čag)
	Халуун (halaqun)
	Чилгэр (čilger)
	Өдөр шөнө (ödür sini)
	Хүрэв- (kürbe)
1. Монгол И Юй толь бичиг (Жин Шүний бар) 2. Нань хуа дэвтэр 3. Хуа и и юй толь бичиг	Хавар (qabur)
	Өдөр дөл (odür düli)
1. Нань хуа дэвтэр 2. Хуа и и юй толь бичиг	Жүхэн- (jüken)

Хоорондоо ижил утгатай бичигдсэн үгсээс үзвэл тухайн нэмэлт дэвтрүүдийг ямар нэгэн алдаа мадаггүй хуулбарласан бөгөөд авиа зүй, үгийн сангийн хувьд ямар нэгэн зөрүүгүй байна. Үүнээс үзвэл толь бичгийн уламжлах шинжийн дагуу зохиогдсон байна.

[9] Шагдарсүрэн. Ц., нар, *Үгийн сан, утга зүй, Монгол хэл судлал, Боть X*, УБ., 2022, х.260.

2. Ижил утгатай боловч өөр үсгээр тэмдэглэгдсэн үг

Хүснэгт 3. Ижил утгатай боловч өөр үсгээр тэмдэглэгдсэн тохиолдол

Тохиолдож буй хувилбар	Ижил утгатай боловч өөр үсгээр тэмдэглэгдсэн			
Хан хуа дэвтэр	Хатахар (qataqar)	Сэрүүн (serigün)	Хүйтэн (kökiten)	Бүлээн (büliyen)
Нань хуа дэвтэр	Хатахар (qataqar)	Сэрүүн (sirigün)	Хүйтэн (küyiten)	Бүлээн (büligen)
Хуа и и юй толь бичиг	Хатагар (qataγar)	Сэрүүн (sirigün)	Хүйтэн (küyiten)	Бүлээн (büligen)
Монгол И Юй толь бичиг	Өдгөө	edö		
Нань хуа дэвтэр	Эдүгээ	edüge		
Хуа и и юй толь бичиг	Эдүгээ	edüge		

Дээрх хувилбарт тохиолдож буй үгсийн утга өөрчлөгдөөгүй боловч авиа сэлгэн бичсэн тохиолдол ажиглагдаж байна. Нэмэлт дэвтрийн нийтлэг алдааг Шонхор дараах гурван зүйлд ангилан үзжээ. Үүнийг товч дурдвал, “o, u, ö, ü-г хутгасан”, “h, q хутгасан”, “l, r болон l, n-г хутгасан” гурван алдаа байна[10] хэмээжээ. Дээрх хувилбаруудад тохиолдож байгаа үгсийг ажиглавал Хан хуа дэвтэрт “Бүлээн (büliyen)” “Сэрүүн (serigün)” хэмээн Нань хуа дэвтэрт “Бүлээн (büligen)” “Сэрүүн (sirigün)” гэж “g, y”, “i, e” авиаг хольж бичсэн тохиолдол байна. Үүнээс үзвэл Мин улсын үед хуулбарласан бичээч эсвэл дуудаж өгсөн хүн нь монгол хэлтэн биш байсныг таамаглаж болно.

3. Ганц хувилбарт тохиолдож буй үг

Хүснэгт 4. Ганц хувилбарт тохиолдож байгаа үг

Тохиолдож буй хувилбар	Үгс
Монгол и юй толь бичиг	Уржнан- (ulidai hong)
	Ноднин- (nidani hon)
	Энэ жил, энэ он- (enai hon)
	Дараа жил- (nai hon)
	Цаад жил- (qoiči hon)
	Цаадын цаад жил- (jinaiji hon)
	Жил бүр- (hon büli)
	Урьд сар- (uliji sara)

[10] Šongqur. A., *Huwa i i iü bičig,* Öber mongγul-un surγan kümüjil-ün heblel-ün qoriy-a., 2017, x.62.

	Зун- (najir)
	Энэ сар- (enai sara)
	Дараа сар- (qoiči sara)
	Цагаан сар- (qubi sara)
	Хоёрдугаар сар- (qudali ükölјin sara)
	Гуравдугаар сар- (ünen ükölјin sara)
	Дөрөвдүгээр сар- (kökökö sara)
	Тавдугаар сар- (qujar sara)
	Зургаадугаар сар- (najir sara)
	Долоодугаар сар- (quči sara)
	Наймдугаар сар- (buqun sara)
	Есдүгээр сар- (quča dalbi sara)
	Аравдугаар сар- (kekimdür sara)
	Арван нэгдүгээр сар- (itilgü sara)
	Арван хоёрдугаар сар- (küküler sara)
	Уржин өдөр, урждар- (uridai üdür)
	Өчигдөр- (qoitu üdür)
	Энэ өдөр, өнөөдөр- (enai üdür)
	Маргааш өдөр- (moqai üdür)
	Хойд өдөр- (qoiči üdür)
	Цаад өдөр- (činaji üdür)
	Өдөр бүр- (üdür)
	Олон өдөр- (üni üdür)
	Гэгээрэв, гийв- (čayeba)
	Өглөө- (tunqonaiqai)
	Өдөр дунд, үд- (üdür düli)
	Жилда, орой- (yeda)
	Шөнө- (süni)
	Өчигдөр шөнө- (ciqagan süni)
	Шөнө дүл- (süni düli)
	Нэгэн хоног- (nigen qonu)
	Тэр үед- (öčör)
	Энэ агшнаа, энэ үед- (enai eqajina)
	Урьд- (yer daki)
	Хэзээ- (Keli)

Эх хэрэглэгдэхүүнд ашиглаж буй дөрвөн нэмэлт дэвтрийн нэг болох Монгол и юй толь бичгийн цаг улирлын аймагт буй 42 үг нь бусад дэвтэрт тэмдэглэгдээгүй байна. Бидний таамаглалаар Монгол и юй толь бичгийг Юань гүрний үед зохиож байсан учир монгол уламжлалт арван хоёр сарыг оноон нэрлэж, “хувь сар, өгэлжин сар” зэрэг нэрлэлтийг багтаасан бололтой. Харин Мин гүрний үед зохиосон “Хан хуа дэвтэр”, “Нань хуа дэвтэр” нэмэлт дэвтэрт арван хоёр сарын нэрлэлтийг хасан найруулж мөн авиаг ялгалгүй тэмдэглэсэн байна.

Үүнээс үгийн сангийн онцлогийг дэлгэрүүлбэл, Монгол и юй толь бичигт “өдөр дүл (odür düli)”, “шөнө дүл- (süni düli)” хэмээх үг тохиолдох бөгөөд эл үгийг Монголын нууц товчоон (=МНТ)-оос сурвалжлан үзэхэд,*“дүл-”* хэмээх

язгуур нь МНТ-д үйл болон нэр үгийн үүргээр тус бүр 20 удаа тохиолдож байна. Жишээлбэл, 145 дугаар зүйлд "…Зэлмэ шимэн шимэн, амаан цусдаж, Зэлмэ бус хүмүүн үл итгэн, сахиж сууж, шөнө дүл болтол бөглөсөн цусыг амаар дүүрэн залгиад асгаад, *шөнө дүл нөгчвөөс*, Чингис хаан дотроо сэргэж өгүүлрүүн:" хэмээн тохиолдож буй бөгөөд үүнийг "шөнө дүл нөгчвөөс - шөнө дунд өнгөрвөөс" гэсэн утгаар тохиолдож байна[11] хэмээн тайлбарлажээ. Мөн үйл үгийн үүргээр МНТ-ы 92 дугаар зүйлд "…гурван өдөр, гурван *шөнө дүлиж* хүрэв" хэмээн шөнө зогсолгүй явахыг илтгэсэн утгаар тохиолдож байна[12] хэмээжээ. Энэхүү тайлбараас үзвэл, Цаг улирлын аймагт "шөнө дунд", "өдөр дунд" гэсэн нэр үгийн утгаар тэмдэглэгдсэн байна.

Зарим авианы солигдол тохиолдож байгааг дурдвал, "qoitu üdür", "qoiči üdür" хэмээх хоёр үгийн галиг нь дундад үеийн монгол хэлний хамжин шүргэх гийгүүлэгчийн солигдлоор "č, t" хоёр авиа солигдсон байна. Энэ тухай Д.Төмөртогоо "Бидний олж ажигласнаар гийгүүлэгч авианы солигдол нь хэлний урт удаан хөгжлийн явцад илэрдэг цуваа цагийн шинжтэй хувьсал юм. Тухайлбал, дундад үеийн монгол хэлэнд тогтвортой байранд хэлэгдэж байсан гийгүүлэгч нь орчин үеийн монгол хэл аялгуунд ижилшиж, ондооших замаар солигдсон жишээ олонтоо тохиолдоно[13] хэмээн дүгнэсэнтэй тохирч байна. Мөн дундад үеийн монгол хэлний ярианы хэл нөлөөлснөөс болж хоёр эгшгийн дундах авиаг гээж бичсэн тохиолдол байна. Жишээлбэл, Монгол и юй толь бичигт "edö", Хан хуа дэвтэр болон Хуа и и юй толь бичигт "edüge" гэсэн хувилбараар тохиолдож байна.

Мөн нутгийн аялгууны үг тохиолдож байна. Чилгэр (čilger) гэх үг Монгол и юй толь бичигт тохиолдож байгаа бөгөөд монгол хэлний товч тайлбар тольд "хатуу чийрэг, цэх[14]" гэсэн санааг илтгэдэг хэмээн тайлбарлажээ. Ойрад аялгуунд "цэлмэг, саруул" гэсэн утгыг илэрхийлдэг байна. Жишээлбэл: Чийгтэй газрын мөнгөнцэцэг хэвтэй Чилгэр огторгуйн сар наран хэвтэй Ус лустын отгон хүүхэн Өлзий-Утас хатан билээ[15] хэмээсэн утга илтгэдэг байна. Үүнээс үзвэл тухайн үеийн зарим үг орчин цагийн монгол хэлний нутгийн аялгуунд анхдагч утгаа хадгалсаар байна.

Монголчууд арван хоёр сарыг оноохдоо "qubi sara, qudali üköljin sara, ünen üköljin sara, kökökö sara, qujar sara, najir sara, quči sara, buqun sara, quča dalbi sara, kekimdür sara, itilgü sara, küküler sara" гэж нэрлэж байсныг Монгол и юй-гийн

[11] Чоймаа. Ш., *Монголын нууц товчоон судлал,* УБ., 2026, х.359.
[12] Мөн тэнд. х.312.
[13] Төмөртогоо, Д., *Түүхэн хэл зүй, Монгол хэл судлал, Боть V*, УБ., 2022., х.81.
[14] Цэвэл, Я., *Монгол хэлний товч тайлбар толь*, УБ., 2021., х.1183.
[15] Катуу. Б., *Монгол урианхайн аман зохиол*, 2011,

баримтаас үзэж болно. Зарим судлаачид арван хоёр сарын оноолт нь нэмэлт дэврүүдэд тэмдэглээгүйг "Ордос нутагт энэ маягийн сарын нэрийдэл буй. Гэвч тэр нь нийт монголд хэрэглэгдэхгүй болохоор орчин цагийн нэрийдэл оруулсангүй[16] хэмээн тайлбарлажээ. Мөн 1959 онд Х. Лувсанбалдан, Бао Сянь нарын өгүүллийн нэмэлт дэвтрийн хавсралтыг нягтлан үзэхэд арван хоёр сарын оноолтыг "qubi sara, qudali üköljin sara" хэмээх уламжлалаар тэмдэглэсэн байна. Үүнээс үзвэл тухайн оноолт нь ганц нутгийн аялгуунд суурилж зохиогдсон бус Юань гүрний үед зохиогдсон толь бичгээс эх авч нэмэлт дэвтрийг хуулбарлаж байсныг мэдэж болно. Мөн Х. Лувсанбалдан, Бао Сянь нарын хэвлүүлсэн[17] тус хуулбарт "Цаг улирлын аймаг" гэх нэрийг өөрчлөн "Цаг агаарын зүйл" хэмээн нэрийдсэн байна. Энэ мэт толь бичгийн зүйл, аймгийн нэрийг өөрчлөх, үгийн санг нэмэх, шинэчлэн найруулах ажил Манж Чин гүрний үеийн таван хэлний толь бичиг болон хорин нэгт, хорин наймтын толь бичгүүдэд мөн ажиглагддаг болно. Энэ нь тухайн үеийн толь зүйч, хэл шинжлэлч нар нийгэм соёлын өөрчлөлтийг даган нэмэн найруулж, толь бичгийг боловсронгуй болгож байсныг харуулж байна.

ДҮГНЭЛТ

Бид энэхүү өгүүлэлд олон хэлний толь бичгийн нэг Монгол и юй толийн нэмэлт дэвтрүүд дэх "Цаг улирал"-ын аймгийн үгийн санг харьцуулсан болно. Үүний үр дүнд толь зүйн уламжлал, дундад үеийн монгол хэлний үгийн сангийн утга, өөрчлөлт, авианы хувьсал, нутгийн аялгууны үг хэллэг зэргийг цаг улирлын аймгийн хүрээнд тодруулав. Ийм тул доор хэдэн зүйлээр дүгнэж болохоор байна.

1. Эх хэрэглэгдэхүүнээс шүүн үзэхэд, өнөөгийн ордос болон ойрад нутгийн аялгууны зарим нэг үг хэллэг тохиолдож байгаа нь тухайн үеийн монгол хэлэнд эдгээр үгс нийт монгол аялгуунд идэвхтэй хэрэглэж байсныг гэрчилж байна. Энэ мэт хуучирсан үгийг олон хэлний толь бичгүүдээс илрүүлж, бусад нутгийн аялгуунаас тодруулах боломжтой байна.
2. Арван хоёр сарын оноолт нь хожуу зохиогдсон хувилбарт тохиолддог хэмээн үздэг судлаачдын санал, Х. Лувсанбалдан нарын хэвлүүлсэн 15 дугаар зууны эхэн хагаст хэвлэгдсэн байх магадтай Хуа и и юй бичигт тэмдэглэгдсэн арван хоёр сарын нэр нь анхдагч гэж үзсэн баримтыг бид дахин нягталж, анхны дэвтэр болох Юань улсын үед зохиогдсон Монгол

[16] Manduqu. Ö., *"Huwa i yi bičig"* Öbermongγul-un ündüsün-ü heblel-ün qoriy-a., 1995, x.139.
[17] Lubsangbaldan, Qa., Boosiyang., *Huwa i yi toli-yin jarim keseg*, Kele jokiyal teüke sedkigül (№41) 1959, x.17.

и юй толь бичигт арван хоёр сарын нэрлэлтийг ижил тэмдэглэсэн болохыг тодруулав.

Эцэст нь, дээр дурдсан арван хоёр сарын оноолт нь монголчуудын соёл, ёс заншилтай холбоотой уламжлалт нэрлэлт болох нь тодорхой байна. Тиймээс толь бичгийн судлагдахуун нь тухайн хэлний үгийн сан, утга зүй хийгээд хэл шинжлэлийн түүхийг хадгалдаг судалгааны эх хэрэглэгдэхүүн болохоос гадна тухайн үндэстний соёл сэтгэлгээний онцлогийг илэрхийлэх нэгэн хэрэглэгдэхүүн болдог байна.

Иймд цаашид нэмэлт хувилбарын үгийг харьцуулан судалж, дундад үеийн монгол хэлний үгийн сангийн утга, хувьсал хийгээд нутгийн аялгууны үг хэллэгийг тодруулан судлахад эрдэм шинжилгээний ач холбогдолтой байна.

A COMPARATIVE STUDY OF SEASONAL VOCABULARY IN THE SUPPLEMENTARY VOLUMES OF THE “MENGGU YIYU” DICTIONARY

Since the Yuan and Ming dynasties, multilingual dictionaries began to be compiled, and these works have become important sources for the study of Middle Mongolian. Multilingual dictionaries have been studied across various disciplines, including linguistics and history. From a linguistic perspective, researchers have continued to examine Chinese transliterations, translations written in the imperial script, and lexical developments. However, there have been relatively few studies that systematically compare multiple versions while examining each entry in detail. Therefore, this article aims to compare four versions of the Menggu Yiyu dictionary within a lexical framework in order to analyze their similarities and differences. Methodologically, the study employs comparative and analytical approaches, transliterates the lexical items into academic transcription, classifies the vocabulary, and explains the identical and differing annotations found in the supplementary volumes. Through this research, the study clarifies the traditions of Middle Mongolian lexicography and their mutual influences, while also demonstrating the variations found in the supplementary volumes through linguistic evidence.

Keywords: *multilingual dictionaries, Menggu Yiyu dictionary, supplementary volumes, lexicon, mutual influences*

НОМ ЗҮЙ

Эх хэрэглэгдэхүүн

Manduqu, Ö., (1995), *Mongγul i iü toli bičig,* Ündüsün-ü heblel-ün qoriy-a Mongγul i iü toli bičig (Ji šün-ü bar).

Šongqur, A., (2017), *Huwa i i iü bičig,* Öber mongγul-un surγan kümüjil-ün heblel-ün qoriy-a. (nang huwa debter).

Šongqur, A., (2017), *Huwa i i iü bičig,* Öber mongγul-un surγan kümüjil-ün heblel-ün qoriy-a. (qan huwa debter).

Šongqur, A., (2017), *Huwa i i iü bičig,* Öber mongγul-un surγan kümüjil-ün heblel-ün qoriy-a. (Hua yi yi yu bičig-ün jüyil qubiyagsan mongγul üges-ün toli).

Судалгааны бүтээл

Lubsangbaldan, Qa., Boošiyang., (1959), *Huwa i yi toli-yin jarim keseg,* Kele jokiyal teüke sedkigül (№41).

Manduqu, Ö., (1995), *Mongγul i iü toli bičig,* Ündüsün-ü heblel-ün qoriy-a.

Туяацэцэг, Н., (2003), *Монгол бичгийн хэлэнд орсон хятад үг (XIII-XX),* УБ.

Катуу, Б., (2011), *Монгол урианхайн аман зохиол* УБ.

Жавхлан., М., (2015), *“Монголын нууц товчоо”, “Хуа-И И-Юй”, “Монгол И Юй” толь бичгийг галиглахад хэрэглэсэн “та” үсгийн судалгаа,* ALTAICA XII, УБ.

Šongqur, A., (2017), *Huwa i i iü bičig,* Öber mongγul-un surγan kümüjil-ün heblel-ün qoriy-a.

Цэвэл, Я., (2021), *Монгол хэлний товч тайлбар толь,* УБ., Мөнхийн үсэг ХХК.

Шагдарсүрэн, Ц. нар, (2022), *Монгол хэлний үгийн сан, утга зүй, Монгол хэл судлал, X боть,* УБ., Монгол судлалын хүрээлэн.

Төмөртогоо, Д., (2022), *Түүхэн хэл зүй, Монгол хэл судлал, V боть,* УБ., Монгол судлалын хүрээлэн.

Чоймаа, Ш., (2026), *Монголын нууц товчоон судлал-Бүтээлийн чуулган I,* УБ., Соёмбо принтинг.

Гадаад хэлээрх бүтээл

Iwasa, K. (2023). Geolinguistic Analysis of the Yi Script written in Hua-Yi Yiyu. *In Proceedings of the fifth International Conference on Asian Geolinguistics*. Geolinguistic Society of Japan.

Товчилсон үгийн жагсаалт

МНТ Монголын нууц товчоон

2026 Fasc.4

МОНГОЛ ХЭЛНИЙ НАРМАЙН ЭГШИГ АВИАНЫ ТАРХАЦ БА ХУВЬСАЛ

Үнэнбүрэнгийн СОЛОНГО
МУБИС-ийн Монгол хэл, уран зохиолын багшийн III курсийн оюутан

Удирдагч багш: Р. Сарангэрэл
МУБИС-ийн Монгол хэлний тэнхимийн багш, доктор (Ph.D)

Хураангуй: *Нутгийн аялгууны судалгааг дотор нь байдлыг тодорхойлсон нутгийн аялгууны судалгаа, түүхэн нутгийн аялгууны судалгаа, нутгийн аялгууны газар зүйн судалгаа хэмээн ангилдаг. Нутгийн аялгууг газар зүйн аргаар судлах нь тухайн аялгууны хэлний онцлог (дуудлага, хэлбэр) хэрхэн нутаг нутгаар ялгаатай тархаж буйг илэрхийлэх чухал ач холбогдолтой судалгааны арга юм. Тиймээс энэхүү өгүүлэлд бид Монгол хэл аялгуун дахь "өмд бүс" гэх үгийн жишээн дээр монгол хэлний нармайн эгшиг авианы тархац болон хувьслыг газар зүйн байрлалд тулгуурлан судалж, үр дүнг гаргасан.*

***Түлхүүр үг**: Халх аялгуу, буриад аялгуу, ойрад аялгуу, өвөрлөгч аялгуу, өмд, бүс, нармайг эгшиг, авианы хувьсал, тархац*

УДИРТГАЛ

Судалгааны зорилго: Монгол хэл аялгуу дахь "*өмд, бүс*" гэх үгсийн жишээн дээр нармайн эгшиг авианы тархац ба хувьслыг тодорхойлох.

Судалгааны зорилт:

1. "Өмд, бүс, өглөө, үлээх" гэх үгсийг монгол хэл аялгууны толь бичгүүдээс түүвэрлэх.
2. Газрын зураг дээр үгсийн тархцыг тэмдэглэх;
3. Авианы өөрчлөлт, хувьслыг тайлбарлаж, харьцуулах;
4. Нэгтгэн дүгнэх.

Сэдвийн судлагдсан байдал:

Монгол хэл, Монголын судлал болон Монгол хэлний нутгийн аялгууг судлахад монголч эрдэмтэн Я. Шмидт, О. Ковалевский, А. Бобровников, Г. И. Рамстедт, А. Д. Руднеев, Б. Я. Владимирцов, С. А. Козин, Г. Д. Санжеев, Т. А. Бертагаев, В. М. Наделяев нар чухал хувь нэмэр оруулсан.

Халх аялгууны материалыг цуглуулж, судалгааны эргэлтэд оруулах ажил XX зууны эхэн үеэс эхэлсэн.

- 1908 онд эрдэмтэн Ц. Ж. Жамцарано, А. Д. Руднеев нар халх ардын аман зохиолыг
- 1926 онд Б. Б. Бимбаев халх ардын туулийг
- 1932 онд Н. Н. Поппе умард халхын үлгэр, дуу, ерөөл
- 1940 онд Л. А. Амстердамская дорнод халхын ардын үлгэр зэргийг авиа зүйн галигаар нийтлүүлсэн байна.

Алексей Бобровников 1849 онд "Монгол халимаг хэл зүй" гэдэг том бүтээл бичиж Монгол хэлний авиа зүй болон хэл зүйн үзэгдлийг системтэй харьцуулан авч үзжээ. Эл бүтээлд халимаг хэл аялгууны ярианы үг хэллэгийг монгол бичгийн хэлний дурсгалуудтай харьцуулан судалж монгол хэл судлалын сонгодог зохиол бичсэн юм. Монгол хэлний нутгийн аялгуу судлалын хээрийн шинжилгээний судалгаа 1950-1980-аад оноос хойш Шинжлэх Ухааны Академийн Хэл зохиолын хүрээлэнгийн нутгийн аялгууны хээрийн судалгаа эхлүүлж өнөөг хүртэл хийсээр байна.

- 1950-аад оноос халхын аман аялгууг нарийвчлан судлах ажил эрчимжсэн бөгөөд Д. Эрдэмбилэг, Н. Шарав-Иш нар нутгийн аялгууны тухай өгүүлэл бичин хэвлүүлсэн.
- Халх аялгууны авиа зүй, хэл зүйн үндсэн онцлогийн талаар Ш.Лувсанвандан, Э. Вандуй, Ж. Цолоо нарын бие даасан бүтээлүүд бий.
- Халх аялгууны авиалбарын бүрэлдэхүүн, авиалбар судлалын тогтолцооны талаар Ш. Лувсанвандан, Т. Пагва, Э. Вандуй, С. Мөөмөө, Ж. Цолоо нар тусгайлан судалсан.
- Салбар аман аялгууг судлах талаар Ц. Шархүү, Д. Төмөртогоо, Ж.Төмөрцэрэн, Ж. Цолоо, М. Шинэхүү, Ш. Барайшир нар бүтээлүүдээ хэвлүүлсэн байна.

Монгол хэл аялгууны харьцуулсан судалгааны тухайд эрдэмтэн Г. Батзаяа, Д. Уртнасан нар "Монгол хэлний нутгийн аялгууны авиа зүйн харьцуулсан судалгаа" 2023, Г. Батзаяа "Монгол хэлний нутгийн аялгуудын авианы харьцуулал" 2008 гэх мэт бүтээлийг гаргажээ.

Хэл шинжлэлийн хүрээнд арван есдүгээр зууны сүүл үеэр G. Wenker, Францын эрдэмтэн Р. Киллврон хэлний газар зүйн шинжлэл гэх шинэ судалгааны салбарыг бий болгож, үндсийг тавьсан байдаг. Монгол хэлний тухайд эрдэмтэн Б. Ринчен, Х. Лувсангэндэн нар Оросын эрдэмтэнтэй хамтран монгол улсын хязгаар дахь угсаатны зүй ба хэл шинжлэлийн талаар судалгаа хийж 1979 онд "Монгол ард улсын угсаатны судлал, хэлний шинжлэлийн атлас" хэмээх бүтээлээ туурвиж байсан.

2008 онд Өвөр Монголын Их Сургуулийн Монгол Судлалын төвийнхөн нутгийн аялгууны газар зүйн судалгааг чухалчлан үзэж, “Өвөр монголын монгол хэлний нутгийн аялгууны судалгааг газрын зурагт тулгуурлан “Монгол хэлний нутгийн аялгууны газрын зураг”-ийн байцаалтын хөтөлбөрийг батлуулан хоёр агуулгаас бүрдэх судалгааг хийсэн.

Сэдвийн үндэслэл:

Дээр дурдагдсанчлан монгол хэл аялгууны авианы сэлгэц, зүй тогтол, хэл аялгууны хоорондох авианы харьцуулсан судалгаа элбэг байгаа ч газар зүйн байрлал, хэл аялгууны харилцан нөлөөллөөс (language contact) үүдэн өөрчлөгдөж буй авианы өөрчлөлт, үгийн тархац, хувьслыг тусгайлан тодорхойлсон судалгаа ховор байна.

Мөн нөгөөтээгүүр эрдэмтэн Ц. Өнөрбаян “Аливаа хэлний дархлааг хамгаалдаг, унаган төрхийг хадгалдаг нэг хүчин зүйл нь тухайн үндэстний хэлний доторх олон ястны аялгуу, аман аялгуу, салбар аман аялгуунууд юм. Тодорхой нэг хэл дотроо олон аялгуу, аман аялгууны өнгө төрхтэй байх нь хэлний дархлааг хамгаалдаг”[1] хэмээн тодорхойлсон нь монгол хэл аялгууг судлах зайлшгүй нэгэн үндэслэл болж байгаа юм.

Судалгааны ажлын шинэлэг тал, ач холбогдол:

Нутгийн аялгууны судалгааг дотор нь байдлыг тодорхойлсон нутгийн аялгууны судалгаа, түүхэн нутгийн аялгууны судалгаа, нутгийн аялгууны газар зүйн судалгаа гэх мэтээр хувааж байдаг. Нутгийн аялгууг газар зүйн аргатай хослуулан судлах нь хэл аялгууны хоорондох зөрүүтэй байдал ба хөгжил хувьслыг тодорхойлох чухал ач холбогдолтой юм.

Судалгааны арга зүй:

Баримт түүвэрлэх арга зүйгээр эх хэрэглэгдэхүүнүүдээс өмд, бүс, өглөө, үлээх гэх үгсийг түүвэрлэнэ. Харьцуулах арга зүйгээр дээрх үгсийн нармайн эгшгийн авианы ялгаатай байдлыг тайлбарлаж, зураг зүйн арга буюу изоглоссын аргаар тархцыг тэмдэглэнэ. Эцэст нь нэгтгэн дүгнэх арга зүйгээр судалгааны аждын үр дүн, дүгнэлтийг тодорхойлно.

ЭХ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

1. Өвөрмонголын монгол хэлний нутгийн аялгууны газрын зургийн байцаалтын материалын цуврал

2008 онд Өвөр Монголын Их Сургуулийн Монгол Судлалын төвийнхэн нутгийн аялгууны газар зүйн судалгааг чухалчлан үзэж, “Өвөр монголын монгол хэлний нутгийн аялгууны судалгааг газрын зурагт тулгуурлан “Монгол хэлний

[1] Өнөрбаян, Ц., (2020). *Орчин цагийн монгол хэлний нутгийн аялгуу.* УБ., Хаан үсэг: х.9.

нутгийн аялгууны газрын зураг”-ийн байцаалтын хөтөлбөрийг батлуулан хоёр агуулгаас бүрдэх судалгааг хийсэн. Тус “материалын цуврал” нийт 13 ботиос бүрдэнэ. Тухайлбал:

1. Ерөнхий өгүүлийн боть
2. Алшан аймгийн боть
3. Баяннуур хотын боть
4. Ордос хотын боть
5. Улаанцав, Богд хотын боть
6. Шилийн гол аймгийн боть
7. Шилийн гол аймгийн Цахарын боть
8. Шилийн гол аймгийн Авга хошуу, шилийн хотын боть
9. Шилийн гол аймгийн Үзэмчний боть
10. Улаанхад хотын боть
11. Жирим аймгийн боть
12. Хинган аймгийн боть
13. Хөлөн буйр аймаг (Хөлөн буйр хот) -ын боть зэрэг болно.

Мөн

- Амаржаргал, Б. (1988) *БНМАУ дахь монгол хэлний нутгийн аялгууны толь бичиг-Ойрд аялгуу*. УБ.
- Цолоо, Ж. (1988) *БНМАУ дахь монгол хэлний нутгийн аялгууны толь бичиг-Халх аялгуу. У*Б.
- Гантогтох, Г. (2010) *БНМАУ дахь монгол хэлний нутгийн аялгууны толь бичиг-Буриад аялгуу.* УБ зэрэг толь бичгүүдийг эх хэрэглэгдэхүүнээр ашиглав.

ОНОЛЫН ХЭСЭГ

1. НАРМАЙН ЭГШИГ АВИА

Өгүүлэхүйн эрхтнээр дамжин гарах авиаг утга ялгахад оролцох талаас нь хэлний авиа (speech sound) гэнэ. Хэлний авиа нь физик шинжээрээ бодитой оршиж, хийсвэр шинжээрээ танигддаг. Хэлний авиаг өгүүлэгдэх шинжээр нь эгшиг (vowel), гийгүүлэгч (consonant) гэж хуваана. Авиа зүйн үүднээс үзвэл, эгшиг авиаг өгүүлэхэд хийн урсгал ямар ч саадгүй гардаг.[2]

Эгшгийг хэлэхэд хийн урсгал хэлний урд хэсэг тагнайн хооронд, хэлний хойд хэсэг зөөлөн тагнайн хооронд, хэлний гүн уг[3] багалзуурын хооронд нарийсдаг. Өөрөөр хэлбэл, энэ нь хэлний булчин чангарлын улмаас дууны зам агшсан тэр цэгийн байр буюу эгшиг бүтэх орон юм.

[2] Уртнасан, Д., нар. *Монгол хэл судлал, авиа зүй.* УБ., 2020. х.30.
[3] Хэлний угаас хойших хэсэг

Монгол хэлний /и, э, у, о, а/ эгшиг нь тагнайн авиа (platal sound), /ө, ү/ эгшиг нь нармайн авиа (velar sound), /а, о, у/ эгшиг нь хөөмийн авиа (phrayngeal sound) юм.[4]

Бүтэх орон, бүтэх орны зай	Тагнай	Нармай	Хөөмий
Хаалттай	и	ү	а
Дунд нээлттэй	э	ө	о
Нээлттэй			у

Монгол хэлний эгшиг авианы ангилал

III зууны үед гүн ухаантан Аристотель өөрийн багш Платоны адил хэлний нийт авиаг эгшиг, хагас эгшиг, эгшиг бус гэж ангилсан. Тэрээр эгшгийг хэлний оролцоогүй бүтэх авиа (альфа, омего), хагас эгшгийг хэлтэй хамжин хэлэгдэх авиа (сигм, ро), эгшиг бусыг хэлээр хамжин бие даасан авиа болон үл сонстох, харин бусад авиатай хамт хэлэгдэн сонстох (гамма, дельта) авиа гэж үзжээ. Түүнчлэн Аристотель авиаг ангилахдаа хэлэгдэх үед амны хэлбэр, үүсэх үед хэлэх эрхтнүүдийн байрлал, гүн ба гүехэн амьсгал урт, богино хэлэгдэх байдал зэргийг анхаарч үзэхийг сургажээ.

Харин Платон эгшгийг дуугүй яруу дуутай, дуугүй аниргүй гэж ялгаж байгаад хожим нь эгшиг, хагас эгшиг, дуугүй гэж хуваасан байна.[5]

“Порт Роялийн хэл зүй”-д эгшиг авиаг тус бүрдээ богино, урт байх ба эгшиг авиа нь амны их бага нээгдэх байдлаар өөр хоорондоо ялгаатай гэж үзжээ. Монголч эрдэмтэн А. Бобровников монгол бичгийн эгшиг үсгүүд нь дуугаараа хуваагддаг, чанга ба сул эгшиг үсгүүд гэж ангилаад “а, и, о” чанга, “э, ү” сул эгшиг гэжээ.[6]

О. Ковалевский “Монгол судрын хэлний товч хэл зүй” гэх бүтээлдээ монгол хэлний эгшиг авиаг хатуу (твёрдый) “a, o, u” зөөлөн (мягкий) “e, ö, ü” саармаг (средний) “i” гэж гурав хуваажээ.[7] А. Бобровников О. Ковалевскийн энэхүү санааг дэмжсэн байна.

Түүнчлэн эрдэмтэн А. Д. Руднев “Монгол бичгийн хэл зүйн лекц” хэмээх бүтээлдээ “a, o, u” гурвыг ***төвөнхийн*** (гортанные, твёрдые буюу эр), “e, ö, ü” ***тагнайн*** (небные, мягкие буюу эм), “i” саармаг (средний буву эрсү) гэж гурав хуваасан байна.[8]

Дон Грахам Стуарт, Мэтью М. Халтод нар “Орчин цагийн монгол утга зохиолын хэлний үгийн авиалбар зүй” бүтээлдээ эгшиг авиаг хэлний хойгуурх “a, o, u”, хэлний урдуурх “e, ö, ü”, “i” фонем нь энэ хоёр бүлгийн аль алинтай нь

---

4 Уртнасан, Д., нар. *Монгол хэл судлал, авиа зүй.* УБ., 2020. х.35.

5 Ганболд, Д., Сарангэрэл, Р., Өлзийсүрэн, М. *Монгол хэлний авиа үсгийн ангиллыг тодруулагч уг.* УБ., 2022, х.130.

6 Мөн тэнд, х.137.

7 Мөн тэнд, х.139.

8 Мөн тэнд, х.141.

хамт тохиолдож болно гэжээ.[9]

Г. И. Рамстедт халх аялгууны эгшиг авиаг хэлний хойгуурх, урдуурх гэж хоёр ангилаад, хэлний хойгуурх эгшгийг хойгуур хэлэх, хойгуурхаас урдуур хэмээн мөн ангилсан байна. Урдуур хэлэх эгшгийг бас дотор нь хойгуур хэлэх, урдуур хэлэх гэж ангилжээ. Мөн эгшгийг уруул цорвойж хэлэх, уруул ангайж хэлэх гэж ялгаад амны хөндийн байдлаар уйтан, дунд, агуу гэж гурав хуваасан байна.[10]

Мөн монголч эрдэмтэн Б. Х. Тодаева "Орчин цагийн монгол хэлний хэл зүй" бүтээлдээ эгшиг авиаг өгүүлэхийн эрхтний үүднээс ангилсан нь ерөнхийдөө Б. Я. Владимирцовын адил хэл, уруулын байдлаар дуурхаг, анирхаг гэж ангилсан байна.[11]

Монгол хэлний эгшиг авианы талаар эрдэмтэн Ш. Лувсанвандан "a, o, u", гурван эгшиг дууг хэлэхүй дор хэлний дээд этгээдийн у язгуурын хувь хойш бөгөөд дээш өргөгдөх тул эл гурван дууг хэлний язгуурын хэмээмүй. Харин "e, ö, ü, i" дөрвөн эгшиг дууг хэлэхэд хэлний дээд этгээд дундад хувь урагш бөгөөд дээш өргөгдөх тул эл дөрвөн дууг хэлний урдуурх хэмээмүй. Үүнээс гадна эгшиг дуунуудыг хэлэхүй дор уруул идэвхтэйгээр оролцох ба үл оролцохоор хоёр хуваан үзэж, мөн эгшиг дуунуудыг хэлэхэд ам уруулын явцуу уужмын байдал харилцан адилгүй гэж үзжээ.[12]

Ерөнхийлөн үзвэл монгол хэлний ялгарах шинжийг хослох эгшиг авиаг байдлаар дараах байдлаар ангилжээ.

1	Өгүүлэхийн эрхтний булчингийн чангарал, сулралын байдлаар	Эр, эм, саармаг
2	Хэлний хэвтээ байдлаар	Хэлний урдуурх, дундуурх, хойгуурх
3	Хэлний босоо байдлаар	Уужим, дунд зэрэг, уйтан
4	Уруулын оролцоогоор	Уруулын, уруулын бус
5	Өгүүлэх хугацаагар	Урт, богино
6	Бүтцээр	Ерийн, хос
7	Сонсгол зүйн талаас	Өргөлттэй, балархай
8	Хамрын оролцоогоор	Хамаршсан, эс хамаршсан

Мөн эрдэмтэн Ж. Санжаа, Ж. Надмид нар ангилан үзэхдээ

1. Өгүүлэхийн эрхтний булчингийн чангарал, сулралаар эр, эм, саармаг
2. Уруулын оролцоогоор уруулын, уруулын бус
3. Хэлний оролцоогоор хэлний хойгуур, дундуур, урдуур

[9] Ганболд, Д., Сарангэрэл, Р., Өлзийсүрэн, М. *Монгол хэлний авиа үсгийн ангиллыг тодруулагч уг.* УБ., 2022, х.142.
[10] Мөн тэнд, х.143.
[11] Мөн тэнд, х.146.
[12] Мөн тэнд, х.170.

4. Амны хөндийн зайгаар уужим, дунд, уйтан
5. Хугацаагаар богино, урт
6. Бүтцээр ерийн, хос
7. Сонсохуйн талаас өргөлтөт тод, заримдаа балархай, огцом хэт балархай
8. Орчны гийгүүлэгчийн нөлөөгөөр хамаршсан, урагшилсан, уруулшсан
9. Хүртэхүйн талаас тод байранд, сул байранд
10. Дохиожуулах талаас тод байранд, сул байранд
11. Тухайн эгшгийн хувилбар болох талаас үндсэн, үндсэн бус, бусцар

Харин Д. Уртнасан нар "Монгол хэл судлал, авиа зүй" бүтээлдээ "Эгшгийг хэлэхэд хийн урсгал хэлний урд хэсэг тагнайн хооронд, хэлний хойд хэсэг зөөлөн тагнайн хооронд, хэлний гүн уг багалзуурын хооронд нарийсдаг. Өөрөөр хэлбэл, энэ нь хэлний булчин чангарлын улмаас дууны зам агшсан тэр цэгийн байр буюу эгшиг бүтэх орон юм.

Монгол хэлний /и, э/ эгшиг нь тагнайн авиа (platal sound), /ө, ү/ эгшиг нь нармайн авиа (velar sound), /а, о, у/ эгшиг нь хөөмийн авиа (phrayngeal sound) юм." хэмээн бүтэх орны талаас ангилсан байна. Нармайн авиаг дэлгэрүүлэн тайлбарлавал "Нармайн авиа нь хэлний ар хэсэг зөөлөн тагнайтай шүргэлцэх буюу ойртон байрласнаар үүсэх авиаг хэлнэ" хэмээн тодорхойлжээ. Энэхүү өгүүлэлд бид судлаач Д. Уртнасан нарын дэвшүүлсэн зарчмын ангиллыг баримтлан нармайн эгшиг буюу "ө, ү" эгшиг авианы хувьслыг тайлбарлалаа.

2. [Ө] ЭГШИГ АВИАНЫ ТАРХАЦ

Тухайн нэг хэлээр харилцагчдын оршин суугаа газар нутаг, яг угсаа, аман ярианы хөгжлийн онцлог зэргээс шалтгаалж авианы дуудлага, хэл зүйн байгуулал, үгийн сангийн хэрэглээний ялгаа хувилбарыг аялгуу (орос: диалект, англи: dialect) гэнэ. Монгол хэл нь үндсэн дөрвөн аялгуутай бөгөөд үүнд халх, ойрад, буриад, өвөрлөгч аялгуунууд хамаарна.

Аялгуу гэдэг нь хэлнийхээ шинжээр ноцтой ялгавар байхгүй, харилцан өчүүхэн ч саадгүй нэвтрэлцэх бүлэг хүмүүсийн үг хэл болно. Монгол хэлний төв, дорнод өрнөд, умард аялгуунууд өөр хоорондоо нөгөө нутгийн аялгуунаасаа хэлний шинжээр мэдэгдэхүйц ялгарна.

Аман аялгуу гэдэг нь хэлнийхээ шинжээр ерийн хэлэлцэхэд ялгавар байхгүй, нэг нутгийн бүлэг хүмүүсийн үг хэл болно.

Салбар аман аялгуу гэдэг нь нэгэн аман аялгууны дотор багтавч хааяа авиа зүй, үгийн сангийнхаа талаар гол олонхоосоо өчүүхэн ялгарах нэг нутгийн бүлэг хүмүүсийн үг хэл юм.

Өвөрлөгч аялгууны эх хэрэглэгдэхүүн дээр суурилан тодорхойлбол тухайн аялгууг Жирим, Ордос, Улаанхад, Хөлөн буйр, Улаанцав, Цахар, Авга хошуу,

Үзэмчин, Сөнөд, Баяннуур, Алшаа, Хинганы аман аялгуудад хуваан үзжээ. Бид энэхүү судалгаанд дээр дурдсан эх хэрэглэгдэхүүнээс “өмд, бүс” гэх үгсийн тархац болон хувьслын жишээг шууд авч ашиглав.




Зураг 1. Өвөр монголын газрын зураг



Зураг 2. Хөлөнбуйр аймгийн газрын зураг

№	Үг	Галиг	Тэмдэглэгээ
1	Өмд	omod	10
2		umәd	6, 7
3		omәd	2, 4, 8
4		ømd	16, 17, 33
5		omd	9, 21, 43
6		und	41
7		umedeŋ	1



Зураг 3. Жирим аймгийн газрын зураг

№	Үг	Галиг	Тэмдэглэгээ
1	Өмд	omd	1
2		omәd	8
3		omod	13, 14
4		umd	22
5		umәd	27
6		umud	9
7		әmd	4, 6
8		әmәd	28
9		әmdә	29



№	Үг	Галиг	Тэмдэглэгээ
1	Өмд	əməd	1, 4, 7, 9
2		umd	2
3		omd	45
4		oməd	5, 8
5		uməd	14
6		əmd	13, 15

Зураг 4. Хинган аймгийн газрын зураг

Халх аялгууны эх хэрэглэгдэхүүнд дурдсанаар,

Нэг. Төв халхын аман аялгуу

1. Төв, Булган, Архангай, Баянхонгор, Сэлэнгийн халхууд, Завханы сартуул хотгойдоос бусад халх, Хөвсгөлийн дархад, хотгойд, ариг урианхайгаас бусад халх, Хөвсгөлийн дархад, хотгойдоос бусад халх, Өвөрхангайн Арвайхээрийн халхуудаас бусад, Дундговийн хойт сумдын халхуудын ярилцдаг төв халхын салбар аман аялгуу
2. Дундговийн өмнөд сумын халхууд, Дорноговь, Өмнөговь аймгийн халхуудын ярилцдаг говийн халхын салбар аман аялгуу
3. Зүүнбаян-Улаан, Бат-Өлзий, Уянга, Тарагт сум, Арвайхээрийн орчмын халхуудын ярилцдаг Өвөрхангайн Арвайхээрийн салбар аман аялгуу

Хоёр. Өрнөд халхын аман аялгуу


1. Ховд аймгийн Буянт, Дарви сум, Цэцэг, Дуут сумын хагас. Говь-Алтайн бүх сумдын халхын салбар аман аялгуу
2. Ховд аймгийн Мянгад сумын Мянгадын салбар аман аялгуу
3. Увс аймгийн Зүүнхангай, Өндөрхангай, Цагаанхайрхан сум, Баруутурууны хагас элжгэн халхын салбар аман аялгуу
4. Хөвсгөл аймгийн Ринчинлхүмбэ, Улаан-Уул, Баянзүрх сум, Алаг-Эрдэнэ сумын хагаст ярилцдаг дархадын салбар аман аялгуу
5. Хөвсгөл аймгийн Чандань-Өндөр, Цагаан-Үүр сумын цөөн ариг урианхайн салбар аман аялгуу
6. Ховд аймгийн Чандмань сум, Завхан аймгийн Ургамал, Завханмандал, Сантмаргац, Сонгино, Нөмрөг, Цэцэн-Уул зэрэг сумын сартуулын салбар аман аялгуу
7. Хөвсгөл аймгийн Цэцэрлэг, Арбулаг, Цагаан-Уул, Бүрэнтогтох, Төмөрбулаг сумдын хотгойдын салбар аман аялгуу

8. Архангай аймгийн Өлзийт, Батцэнгэл, Хотонт сумын халхажсан хойд өөлдийн салбар аман аялгуу


Гурав. Дорнод халхын аман аялгуу

1. Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгуудын зүүн халхын салбар аман аялгуу
2. Сүхбаатар аймгийн Түвшинширээ, Баяндэлгэр, Дариганга, Хонгор, Онгон, Наран, Асгат сумдын даригангын салбар аман аялгуу
3. Дорнод аймгийн Сэргэлэн, Баянтүмэн, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сум болон бусад зэргэлдээ сумдад цөөн байгаа үзэмчний салбар аман аялгуу гэх ангиллыг баримтлан газрын зураг дээр тархцыг тэмдэглэлээ.

№	*Үг*	*Галиг*	*IPA*	*Аман аялгуу*	*Тэмдэглэгээ*
1	Өмд	emusku	[eməskʰə]	Tkha., Ökha.	
		emudun	[eməskʰə]	Tkha., Ökha.	
		umudun	[umədəŋ]	Tkha., Ökha.	
		mayag	[majək]	Ōl.	
2	Хүүхдийн өмд	bādǎē	[pa:təe:]	Dun.	
		rugǎwtš	[qojəwʧʰ]	Kho., Khot.	
3	Хүүхдийн өмд, цамц	dūdū	[tu:tu:]	Ü.	




Зураг 5. Монгол улсын газрын зураг



Зураг 6. Хөвсгөл аймгийн газрын зураг



Зураг 7. Архангай аймгийн газрын зураг



Зураг 8. Ховд аймгийн газрын зураг

Ойрад аялгууны эх хэрэглэгдэхүүнд дурдсанаар, Дөрвөд ястан Увс аймгийн Давст, Сагил, Түргэн, Бөхмөрөн, Ховд, Өмнөговь, Өлгий, Наранбулаг сум болон Улаангом хот, мөн Ховд аймгийн Дөргөн суманд нутагладаг.

Баяд ястан нь Увс аймгийн Малчин, Хяргас, Тэс, Зүүнговь суманд бөөнөөрөө сууж, зүүн урд талаараа илжгэн халх, дөрвөд, баруун, баруун хойт талаараа түрэг угсааны тува нартай хиллэдэг.

Торгууд ястан нь Ховд аймгийн Булган суманд оршин суудаг.

Урианхай ястан нь Ховд аймгийн Мөнххайрхан, Дуут суманд бөөнөөрөө, Баян-Өлгий аймгийн Алтай, Буянт, Булган суманд хэсэг хэсгээрээ суудаг.

Өөлд ястан Ховд аймгийн Эрдэнэбүрэн суманд оршин суудаг.

Захчин ястан нь Ховд аймгийн Манхан, Алтай, Үенч, Зэрэг, Мөст суманд бөөнөөрөө оршин суудаг.

Хотон ястан нь Увс аймгийн Тариалан суманд нутаглана гэх ангиллыг баримтлан газрын зураг дээр тархцыг тэмдэглэлээ.

№	Үг	Галиг	IPA	Аман аялгуу	Тэмдэглэгээ
		ümdŭn	[umtəŋ]	T., Ö., U., Ba., Kho.	●
		ümdn	[umtŋ]	Dö.	▲
		ömŭd	[өmət]	Dž.	★



Зураг 9. Ховд аймгийн газрын зураг



Зураг 10. Ховд аймгийн газрын зураг

Буриад аялгууны эх хэрэглэгдэхүүнд дурдсанаар, Баяндун, Баян-Уул, Цагаан-Овоо, Эрээн хороо, Чулуунхороот суманд болон Чойбалсан хотод суугаа Агын аман аялгуутан, Хэнтий аймгийн Дадал, Биндэр, Батширээт, Норивлин сум, Өндөрхаан хотод оршин суугч Хорийн аман аялгуутан, Хэнтий аймгийн Батширээт суманд хэсэг өрх Худир буриад аман аялгуутан байдаг.

Төв аймгийн Мөнгөнморьт сумнаа суудаг хори, агын аман аялгуутныг Онон-Улзын аман аялгуунд багтааж оруулсан юм. Дорнод аймгийн Хөлөнбуйр, Гурванзагал, Төв аймгийн хуучнаар, Авдархаан суманд суудаг барга зоны хэлэлцэх баргын аман аялгуу, Сэлэнгэ аймгийн Хүдэр, Ерөө сум, Уялга нутаг, Сүхбаатар, Дархан, Улаанбаатар хотод суудаг цонгоол аман аялгуутан, аймгийн Цагааннуур Хатгал, Ханх суманд суугаа буриад зоны хэлэлцэх Түнхэний аман аялгуу гэх ангиллыг баримтлан газрын зураг дээр тархцыг тэмдэглэлээ.

№	Үг	Галиг	IPA	Аман аялгуу	Тэмдэглэгээ
1	Өмд	mede(ŋ)	[umətəŋ]	Khori., Aga., Bar., Tunk., San.	●
		md	[umətə]	Kham.	▲
		ömede	[ɵmətə]	Tson.	★



Зураг 11. Дорнод аймгийн газрын зураг



Зураг 12. Булган аймгийн газрын зураг



Зураг 13. Сүхбаатар аймгийн газрын зураг



Зураг 14. Хөвсгөл аймгийн газрын зураг

[Ө] ЭГШИГ АВИАНЫ ХУВЬСАЛ

Эгшиг авиа хувьсах үзэгдэл нь сэлгэх, ижилших, ондоошох, хамарших, гээгдэх болон түүнтэй төстэй авиа нэмэгдэх, солигдох үзэгдэл багтана. Утга зохиолын хэлнээ [ө] эгшиг авиа нь хэлний дундуур хэлэгддэг, өндрөвтөр, уруулын эгшиг авиа юм.

Авианы ижилсэл

Монгол үгийн язгуурын тольд тэмдэглэснээр "*Эртний монгол хэлэнд "өмд" хэмээх үгийг* [emüdü] *гэж бичдэг байжээ."* Монгол хэл аялгуунд тэргүүн ба тэргүүн бус үед тохиолдох уруулын эгшиг нь өмнөх ба дараах үеийнхээ эгшгийг уруулын хүчдэлээр бүрэн ба заримдаг ижилсүүлдэг ёсоор үгийн дэд үед тохиолдож буй уруулын [ü] эгшиг нь тэргүүн үед тохиолдох [е] эгшгийг уруулын хүчдэлээр ижилсүүлж уруулын [ö] авиа болгосон хувьсал ажиглагдаж байна. Энэхүү хувьслаар монгол бичгийн хэлний [ömüdü] хувилбар үүсжээ. Халх аялгуунд энэхүү энэхүү эртний монгол хэлний хэлбэрийг хадгалж [eməskʰə], [eməd̬ŋ] хэмээх хэлбэрүүд байна.

Мөн халх аялгуунд [ü] эгшиг авиатай сэлгэсэн байгаа нь *халхчууд үгийн 1р үеийн ө, ү хоёрыг сайн ялгадаг боловч бас зарим үгийн нэгдүгээр үеийн ө,ү эгшгийг хутгаж хэлэх явдал үзэгдэнэ* гэх үндэслэлтэй нийцэж байна.

Авианы сэлгэц

Нармайн эгшиг авиа нармайн эгшиг авиатайгаа сэлгэсэн нь

Өвөрлөгч аялгуунд [ө] эгшиг авиа нь уруулын, хэлний урдуурх, өндрөвтөр [ø] авиатай сэлгэж урагшилсан "ømd", мөн уруулын, хэлний дундуурх, нам [ʉ] сэлгэсэн байна. Ойрад болон буриад аялгуунд уруулын, хэлний дундуурх, өндрөвтөр [ө] авиа, уруулын, хэлний хойгуурх, өндөр [u] авиа сэлгэн хойшилсон байна.

Нармайн эгшиг авиа хөөмийн эгшиг авиатай сэлгэсэн нь

Өвөрлөгч аялгуунд үгийн тэргүүн үед тохиолдох уруулын, хэлний дундуурх, өндрөвтөр [ө] авиа нь уруулын, хэлний хойгуурх, намавтар, тагнайн [о] авиатай сэлгэж хойшилсон байна.

Монгол хэлний нармайн эгшиг авиа тагнайн эгшиг авиатай сэлгэх ёс нь голчлон аялга үгс дээр илэрдэг. Жишээ нь "*пөө-поо-паа, бөндгөр-бондгор-бандгар, пээ-паа, хөө-хаа, чүү-чаа" гэх мэт утгын нарийн ялгамж бүхий аялга үгс нь авиа сэлгэж үүссэн байдаг.*


[U] ЭГШИГ АВИАНЫ ТАРХАЦ

Өвөрлөгч аялгуунд,



№	Үг	Галиг	Тэмдэглэгээ
1	Бүс	busə	
2		bus	
3		buhə	
4		buh	
5		buhu	
6		buhu:	
7		buxu:	
8		bөhө	
9		bəsə	

Зураг 15. Хөлөнбуйр аймгийн газрын зураг



№	Үг	Галиг	Тэмдэглэгээ
1	Бүс	bos	
2		bus	
3		boslu:r	
4		dɛ:s	
5		pi:de	
6		xurɛ:təŋ	
7		xurə:təŋ	


Зураг 16. Жирим аймгийн газрын зураг



№	Үг	Галиг	Тэмдэглэгээ
1	Бүс	dɛ:s	
2		bus	
3		busəlbur	
4		buslu:r	
5		bos	
6		bəsəlgur	
7		but	

Зураг 17. Хянган аймгийн газрын зураг

№	Үг	Галиг	IPA	Аман аялгуунд	Тэмдэглэгээ
1	Бүс	büs	[pus]	Dö., Ba., Kho.	●
		bis	[pis]	Dž., T., Ö., U	▲



Зураг 18. Увс аймгийн газрын зураг



Зураг 19. Ховд аймгийн газрын зураг



Зураг 20. Баян-Өлгий аймгийн газрын зураг

Буриад аялгуунд,


№	Үг	Галиг	IPA	Аман аялгуу	Тэмдэглэгээ
1	Бүс	behe	[pexə]	Khori., Aga., Tunk.	●
		bhe	[puxə]	Khori., San.	▲
		bse	[pusə]	Kham., Tson.	★



Зураг 21. Булган аймгийн газрын зураг



Зураг 22. Дорнод аймгийн газрын зураг



Зураг 23. Хэнтий аймгийн газрын зураг



Зураг 24. Сэлэнгэ аймгийн газрын зураг

[U] ЭГШИГ АВИАНЫ ХУВЬСАЛ

Авианы сэлгэц

Өвөрлөгч аялгуунд үгийн тэргүүн үед тохиох уруулын, хэлний хойгуурх, өндөр [u] авиа нь уруулын, хэлний дундуурх, өндрөвтөр [ө] авиа, уруулын, хэлний дундуурх, өндөр [ᵾ], мөн уруулын, хэлний урдуурх, өндөр [ү] авиатай сэлгэж урагшилсан.

Мөн ойрад аялгуунд уруулын, хэлний хойгуурх, өндөр [u] авиатай, халх аялгуунд уруулын, хэлний дундуурх, өндрөвтөр [ө] авиатай тус тус сэлгэсэн байна. Үүнээс ажиглахад бүтэх орноор хамгийн ойр авиануудтай голчлон сэлгэжээ.

Ойрад аялгууд уруулын бус, хэлний урдуурх, өндөр [i] авиатай сэлгэсэн байна.

ДҮГНЭЛТ

Өмд, бүс гэх үгсийн жишээн дээр монгол хэлний нармайн эгшиг авиан хувьслыг ажиглавал,

[ө] авиа өвөрлөгч аялгуунд хэлний хойгуурх авианuудтай сэлгэсэн үзэгдэл их байна. Халх аялгуунд үгийн тэргүүн үед тохиолдох эртний монгол хэлний [е] авиаг хадгалсан байна. Харин ойрад болон буриад аялгуунд илүү хэлний урдуурх авиатай сэлгэжээ.

[u] авиа нь өвөрлөгч аялгуунд хэлний урдуурх авианuудтай сэлгэсэн байна. Ойрад болон буриад аялгуунд энэхүү уруулын авиа нь уруулын бус авиатай сэлгэж, мөн урагшилсан байна. Халх аялгуунд бүтэх орчны хувьд хамгийн ойр авианuудтай сэлгэсэн байна.

Халх аялгуунд хэлбэрийн ялгаатай тал ажиглагдаж хүүхдийн өмдийг [pa:tәe:], [qojәwʃʰ], [tu:tu:] гэх мэтээр өгүүлж буй хувилбарууд байна. *Ар, өвөр монголчуud, ойрад, буриадын хэл аялгуу, авиа зүй, хэл зүйн талаар харьцуулан үзэхэд, хэрэв ялгаатай газар арав, хориодоос хэтрэхгүй бол адил төсөөтэй, нийт дундын шинж нь маш их хувийг эзэлж байдаг.*[13] гэх үндэслэлийг суурилан ажиглавал бидний энэхүү судалгааны баримтууд арав, хорин хувилбараас хэтрэхгүй байгаа нь хэл аялгуу хоорондоо харилцан нөлөөлж, дундын шинжтэй болж буйг илтгэж байна

THE DISTRIBUTION AND EVOLUTION OF VELAR SOUND IN MONGOLIAN LANGUAGE

The study of dialects is classified into descriptive dialectology, historical dialectology, and linguistic geography (dialect geography). Studying dialects through the geographic method is a crucial research approach for demonstrating how specific linguistic features such as pronunciation and morphology are distributed across different regions. Accordingly, this article examines the distribution and evolution of the velar nasal vowel in the Mongolian language, using the word “өмд бүс” (trousers and belt/waistband) as a case study, analyzed through the lens of geographical location.

Keywords: *Khalkha dialect, Buryat dialect, Oirat dialect, Inner Mongolian dialect, Phonetic evolution, Distribution, Veral sound*

[13] Базаррагчаа, М., *Монгол хэлний авиа зүйн онол, практикийн асуудлууд.* УБ., 2002. х.48.

НОМ ЗҮЙ

Базаррагчаа, М. (1987). *Монгол хэлний авиа сэлгэх ёс*. УБ.

Базаррагчаа, М. (2002). *Монгол хэлний авиа зүйн онол, практикийн асуудлууд.* УБ.

Ганболд, Д., Сарангэрэл, Р., Өлзийсүрэн, М. (2022). *Монгол хэлний авиа үсгийн ангиллыг тодруулагч уг*. УБ.

Лувсанвандан, Ш., (1959). *Монгол хэл аялгууны учир*. Монголын судлал, 1-р боть 32-р дэвтэр. УБ.

Өнөрбаян, Ц., (2020). *Орчин цагийн монгол хэлний нутгийн аялгуу*. УБ.

Санжаа, Ж., Надмид, Ж. (2018). *Монгол хэлний авиа зүй ба авиалбар зүй.* УБ.

Уртнасан, Д., нар. (2020). *Монгол хэл судлал, авиа зүй.* УБ.

Цолоо, Ж., (1976). *Орчин үеийн монгол хэлний авиа зүй.* УБ.

Crystal, D., (2008). *A Dictionary of Linguistics and Phonetics* (6th ed.). Malden, MA & Oxford: Blackwell Publishing.

2026 Fasc.5

МОНГОЛ ХЭЛЭН ДЭХ ГАДААД ҮГИЙН ХӨӨМИЙН ЭГШГИЙН ДУУДЛАГА БА АВИАНЫ ХУВЬСАЛ

(АНГЛИ, ОРОС ХЭЛНИЙ ХҮРЭЭНД)

Зоригтбаатарын ХИШИГБАЯР

МУБИС-ийн Монгол хэл, уран зохиолын багшийн IV курсийн оюутан

Удирдагч: Р. Сарангэрэл

МУБИС-ийн Монгол хэлний тэнхимийн багш, доктор (Ph.D)

Хураангуй: *Техник технологи эрчимтэй хөгжиж буй энэ үед харилцааны чухал зэвсэг болох эх хэлний маань үгийн сан баяжсаар байна. Ингэхдээ гадаад үг нь дуудлага болон бичгийн хэлбэрээрээ орж ирсээр байна. Гадаад үгийг тухайн сурвалж хэл дэх дуудлагатай нь адил дуудах, эсвэл зөрүүтэй дуудах үзэгдэл түгээмэл ажиглагдаж байгаа тул гадаад үгийн дуудлагын онцлогийг илрүүлж, авиа зүйн үүднээс тайлбарлах нь олон талын ач холбогдолтой.*

Тус судалгааны хүрээнд мэдээний цахим хаягууд дахь 300 үгийг дуу бичлэгийн хамт түүвэрлэж үгийн сан хөмрөг бүрдүүлсэн. Тухайн түүвэрлэсэн үгсийн гарлыг тэмдэглэж, дуудлагыг нь олон улсын авиа зүйн галиг IPA-аар галиглаж, англи болон орос хэлний тогтсон IPA-тай харьцуулж эгшиг авиалбарын ондоошлыг тайлбарласан. Энэ удаагийн судалгаанд эгшиг авиалбарын ондоошлыг зөвхөн хөөмийн эгшгийн хүрээнд авч үзсэн.

Түлхүүр үг: *хөөмийн эгшиг, гадаад үг, богино эгшиг авиалбар, дуудлагын галиг (IPA), эгшгийн ондоошил*

УДИРТГАЛ

Сэдвийн үндэслэл: Хүн бүр мэдлэг чадвараа дээшлүүлэхийн тулд төрөлх хэлээсээ гадна гадаад хэлийг техник технологи, цахим орчны тусламжтайгаар суралцаж байна. Ингэхдээ өдөр тутмын харилцаандаа гадаад үгийг их хэрэглэх болжээ. Үгийн сангийн үүсвэр бүрэлдэхүүний талаас үзвэл XX зууны сүүлчээр орос хэлний үг их орж ирсэн бол орчин үед европ хэлнээс гаралтай үгс маш их орж ирж байна. Иймд эдгээр үгийн дуудлагын галигийг харьцуулж, авианы үндсэн дуудлага болон монгол хэлэнд дуудагдах авианы шинжийг судлах

шаардлагатай гэж үзсэн тул тус сэдвийг сонгов.

Сэдвийн зорилго: Цахим орчинд илэрч буй гадаад үгийг түүвэрлэж, сурвалж хэл дэх үгийн эгшиг авиалбарын дуудлагыг монгол хэлний эгшиг авиалбарын дуудлагын галигтай харьцуулж, зөрүүтэй дуудлагад дүн шинжилгээ хийж, авианы хувьслыг тайлбарлах.

Сэдвийн зорилт:

- *Мэдээний цахим хаягуудаас гадаад үгийг түүвэрлэх;*
- *Гадаад үгийн гарлыг тэмдэглэх;*
- *Монгол хэлний дуудлагын галиг буюу IPA-аар галиглах;*
- *Англи, орос хэлний дуудлагын галиг буюу IPA-аар галиглах;*
- *Эгшиг авианы хувьслыг илрүүлэн тайлбарлах;*
- *Дүгнэлт гаргах.*

Сэдвийн судлагдсан байдал

Аливаа ард түмний амьдрал, ахуйд тухайн юм, үзэгдэл, ухагдахуун байдаг тул нэг үгээр орчуулан хэрэглэж болох авч гадаад үгийг яриан дунд хавчуулах эсвэл бичвэрт эх хэлнийх нь цагаан толгойн үсгийг ашиглан бичих зэрэг нь тааралддаг. Зарим тохиолдолд зохиолчид найруулгын эсвэл тухайн яриа болж буй улс орны тухай тодруулах зорилгоор үгийг ингэж ашиглах нь бий. Мөн гадаад хэл мэддэг хүмүүс аман ба бичгийн хэлэндээ эх хэлнийхээ үгэн дунд хавчуулан хэрэглэдэг. Үгийн сангийн ийм нэгжүүдийг гадаад үг гэж нэрлэх боломжтой юм.[1]

Монгол хэлийг тогтолцоотой судалж эхэлсэн 1920-оод оноос манай судлаачид төрөлх хэлэндээ орсон бусад хэлний үгсийг гадаад үг хэмээх нэр томьёогоор тэмдэглэж байсан билээ. Харин "...1951 онд зохиож гаргасан дунд сургуулийн 5-р ангийн Монгол хэлний сурах бичиг ба 1964 онд боловсруулж гаргасан Хэл шинжлэлийн нэр томьёоны бичиг-т өөрчилж хэрэглэсэн" (Дамдинсүрэн, 1983: 8-9) ба тухайлбал гадаад үг гэсэн нэр томьёог зээлдсэн үг хэмээн өөрчилжээ. Гэвч монгол хэлний үгийн сан судлалын бүтээлүүдэд харь үг (Төмөрцэрэн, 1974), зээлбэр үг (Өлзийхутаг, 1979), харь хэлний үг (ҮССҮ, 1986), гадаад үг (Балжинням, 2008) гэх зэргээр харилцан адилгүй нэрлэж байна. Мөн Н. Нансалмаа (2005) харь хэлний үг монгол хэлэнд нутагшсан байдлыг харгалзан ормол үг, зээлсэн буюу зээлбэрлэсэн үг, гадаад үг, олон улсын чанартай үг, хэллэг хэмээн ангилсан байна.[2]

Харь үг болгон үгийн санд нэвтэрдэггүй агаад нийтэд танигдаж хэрэглээнд орсны дараа зарим нь орчуулагдаж, зарим нь оновчтой уугуул үгээр солигддог

[1] Нансалмаа, Н., *Үгсийн сан судлал*, УБ., 2015, х.118.
[2] Баттөгс, Ш., Пүрэвжав, Э., нар *Үгийн сан, утга, найруулга судлал,* Боть (III), УБ., 2022, х.16-17.

байна. 1990-ээд оноос хойш англи хэлний 700 орчим үг монгол хэлнээ орсныг хэвлэл мэдээллийн хэрэгслээс тооцоолон судалсан бөгөөд өдгөө 500 хүрэхгүй болсон зарим үгийг огт хэрэглэхээ больсон, зарим үгсийг харь үгээр нь биш монголчлон хэрэглэж байна.[3]

Гадаад хэлнээс гаралтай үгсийн монголжих ерөнхий зүй тогтол нь монгол бичгийн хэлний дуудлагын хэм хэмжээнд захирагдахад оршино. Харь гаралтай үг нь зөөлдүүлэгч эх хэлнийхээ авиа зүйн хэм хэмжээг тэр болгон амархан хаячихдаггүйгээс болж, эдгээр үгийг дуудахад бэрхшээл тохиолдоно. Энэ бол хэл бүхэн байдаг түгээмэл байдаг юм. Харь гаралтай үгийн дуудлага эх хэлнийхээ дуудлагаас цагийн уртад ямар нэг хэмжээгээр өөрчлөгдөн хувирдаг жамтай. Хэл шинжлэлийн онолд *Харь гаралтай үг нь уугуул эх хэлнийхээ авианы дуудлагыг хадгалдаг* хэмээн үздэг...[4]

Орчин цагийн монгол хэлэнд европын хэлнээс орсон “курс”, “фунт” зэрэг үгийг “күрс”, “фүнд” гэж өргөлттэй үгэгээр дууддаг нь харь гаралтай үг нь эх хэлнийхээ авианы дуудлагыг хадгалдгийг баталж байна. “Клуб” гэх үгийн эхэнд хоёр гийгүүлэгч дараалан орох нь монгол үг, түүний дуудлагад таарахгүй тул монгол хүн уг хоёр гийгүүлэгчийг эгшиг зохицох ёсны дагуу у, үгэгээр амилуулж “kulub” гэж дууддаг.[5]

Сэдвийн шинэлэг тал, ач холбогдол

Судалгааны ажлын хүрээн дэх 107 үгийг олон улсын авиа зүйн галиг буюу IPA (Internatoinal Phonetic Alphabet)-аар галигласан нь шинэлэг талуудын нэг болно. Авианы галиг нь хэл бүрийн авиаг хамгийн энгийн тэмдгээр илэрхийлдэг бөгөөд нийтээр даган хэрэглэх нь хэл бүрийн авианы тэмдэглэгээг нэг болгож аливаа хэлийг сурах хийгээд сургах, судалгаа шинжилгээнд чухал үүрэгтэй юм. Энэхүү судалгаанд орос, англи гаралтай үгсийг IPA-аар галигласнаар хэл сурч байгаа хүн дараах үгсийн дуудлагыг хооронд харьцуулан судлах боломжтой болох юм. Мөн гадаад үгийг журамлан буулгах тал дээр хэрэглээний ач холбогдолтой.

Судалгааны ажлын арга зүй

- ✓ Түүврийн арга
- ✓ Харьцуулалтын арга
- ✓ Индукцийн арга
- ✓ Тайлбарлах арга


[3] Шагдарсүрэн, Ц., Бадамдорж, Д., нар *Үгийн сан, утга зүй,* Боть (X), УБ., 2022, х.37.
[4] Пүрэвжав, Э., Ганболд, Д., нар *Бичгийн хэл*, Боть (XIII), УБ., 2022, х.194-203.
[5] Даваажав, Г., *Монгол хэлэнд орсон европын хэлний үгийн өөрчлөлт онцлог*, УБ., 2022, х.32.

Судалгааны ажлын хэрэглэдэхүүн

Судалгааны ажлын хүрээнд мэдээний цахим хаягуудад гадаад үгсийг түүвэрлэсэн. Давтамжийг тооцохгүйгээр нийт 107 үгийн сан хөмрөг бүрдүүлж, судалгааны ажлын хэрэглэдэхүүн болгосон. Тухайн түүвэрлэсэн үгийн дуудлагыг олон улсын авиа зүйн галиг IPA-аар галиглаж, англи болон орос хэлний тогтсон IPA-тай харьцуулсан.

Онолын хэсэг

Эгшгийг хэлэхэд хийн урсгал хэлний урд хэсэг тагнайн хооронд, хэлний хойд хэсэг зөөлөн тагнайн хооронд, хэлний гүн уг багалзуурын хооронд нарийсдаг. Өөрөөр хэлбэл, энэ нь хэлний булчин чангарсны улмаас дууны зам агшсан тэр цэгийн байр буюу эгшиг бүтэх орон юм.



Зураг 1. Эгшиг бүтэх орон[6]

Бүтэх орон Бүтэх орны зай	Тагнай	Нармай	Хөөмий
Хаалттай	и (у [ʏ])	ү	а
Дунд нээлттэй	э (о [œ])	ө	о
Нээлттэй	(а [æ])		у

Зураг 2. Монгол хэлний эгшиг бүтэх орны ангилал[7]

Үндсэн хэсэг

Монгол хэлний [а] эгшиг авиалбар илрэх байдал

[а] эгшиг авиалбар хэвээр илэрсэн нь:

Дараах гадаад үгсийг орос, англи хэлний дуудлагатай нь харьцуулахад [а] эгшиг авиалбар адил илрэв. Ингэхдээ үгийн нэгдүгээр үед орсон [а] эгшиг

[6] Уртнасан, Д., Батдорж, Ц., нар *Авиа зүй,* Боть (VIII), УБ., 2022, х.35.
[7] Мөн тэнд. х.35.

авиалбар нь адил илэрсэн нь түгээмэл байв. Мөн орос болон англи хэлэндээ богино хэлэгдсэн [a] эгшиг авиалбар нь монгол хэлэнд урт эгшгээр дуудагдаж байна. Дараах үгст хоёр гийгүүлэгч дараалан орсон үгийг монгол хүн хэлэхдээ эгшиг зохицох ёсны дагуу [a] эгшиг авиалбараар амилуулан дуудаж байна. Үгийн гарлыг авч үзвэл [a] эгшиг авиалбар хэвээр илэрсэн үгс нь ихэнхдээ орос хэлээр дамжин орж иржээ.

1. Автомат [Mon. **а**ɸtʰm**а**:tʰ < Rus. **ɐ**ftɐˈmat] – Д. Төмөртогоо {Rus. < Gr.}
2. Аппарат [Mon. **а**pr**а**:tʰ < Rus. ɐpɐˈr**а**t] – Д. Төмөртогоо {Rus. < Ger. < Lat.}
3. Академи [Mon. **а**kʰ**а**tje:m < Rus. **ɐ**kɐˈdʲemʲijə] – Д. Төмөртогоо {Rus. < Pol.}
4. Акт [Mon. **а**:xtʰ < Rus. **а**kt] – Д. Төмөртогоо {Rus. < Lat.}
5. Банк [Mon. p**а**ŋkʰ < Rus. b**а**nk] – Д. Төмөртогоо {Rus. < Fr.< It.}
6. Вагон [Mon. w**а**qɔ:ŋ < Rus. vɐˈgon] – Д. Төмөртогоо {Rus. < Fr. < Ger.}
7. Вакуум [Mon. w**а**:kʰo:m < Rus. ˈv**а**kʊʊm] – Д. Төмөртогоо {Rus. < Lat.}
8. Градус [Mon. kar**а**:təs < Rus. ˈgr**а**dʊs] – Д. Төмөртогоо {Rus. < Lat.}
9. Гуаш [Mon. qw**а**:ʃ < Eng. gw**ɑ**ʃ] – Н. Балжинням {Eng. < Fr.}
10. Карман [Mon. kʰ**а**rma:ŋ < Rus. kɐrˈman] – Н. Балжинням{Rus.}
11. Карт [Mon. kʰ**а**:rtʰ < Rus. ˈk**а**rtə] – Д. Төмөртогоо {Rus. < Ger.}
12. Команд [Mon. kʰ**а**m**а**:nt < Rus. kɐˈm**а**ndə] – Н. Балжинням{Rus. < Fr.}
13. Касс [Mon. kʰ**а**:s < Rus. ˈk**а**s(:)ə] – Д. Төмөртогоо {Rus. < It. < Lat.}
14. Каск [Mon. kʰ**а**:skʰ < Rus. ˈk**а**skə] – Д. Төмөртогоо {Rus. < Fr. < Sp.}
15. Квадрат [Mon. kʰ**а**wtr**а**:tʰ < Rus. kvɐˈdr**а**t] – Д. Төмөртогоо {Rus. < Lat.}
16. Кран [Mon. kʰar**а**:ŋ < Rus. kr**а**n] – Д. Төмөртогоо {Rus. < Ger.}
17. Лапша [Mon. ɬ**а**pʰʃa: < Rus. ɬɐpˈʂa] – Н. Балжинням{Rus.}
18. Маркетинг [Mon. m**а**:rkʰtʰiŋ < Eng. ˈm**ɑ**rkəˌtɪŋ] – Н. Балжинням{Eng.}
19. Маршрут [Mon. m**а**rʃro:tʰ < Rus. mɐrʂˈrut] – Д. Төмөртогоо {Rus. < Ger.}
20. Мастер [Mon. m**а**:sər < Rus.ˈm**а**sʲtʲɪr] – Н. Балжинням{Rus. < Gr.}
21. Парламент [Mon. pʰ**а**rɬa:mjentʰ < Rus. pɐrˈɬamʲint < Eng. ˈp**ɑ**rləmənt] – Д. Төмөртогоо {Rus. < Eng.}
22. Парк [Mon. pʰ**а**:rkʰ < Rus. p**а**rk < Eng. p**ɑ**rk] – Д. Төмөртогоо {Rus. < Eng.}
23. Плаза [Mon. pʰɑɬ**а**:ʦa < Eng. ˈpl**ɑ**zə] – Etymonline цахим толь {Eng.}
24. Практик [Mon. pʰar**а**:kʰtʰikʰ < Rus. ˈpr**а**ktʲɪkə] – Д. Төмөртогоо {Rus.}
25. Радио [Mon. ar**а**:tiɔ < Rus. ˈr**а**dʲɪo] – Д. Төмөртогоо {Rus. < Ger. < Lat.}
26. Тактик [Mon. tʰ**а**:kʰtʰəkʰ < Rus. ˈt**а**ktʲɪkə] – Н. Балжинням{Rus. < Gr.}
27. Хаус [Mon. χ**а**os < Eng. h**а**ʊs] – Н. Балжинням{Eng.}

[a] эгшиг авиалбар ондоошиж илэрсэн нь:

Дараах гадаад үгсийг орос, англи хэлний дуудлагатай нь харьцуулахад [a] эгшиг авиалбар ондоошиж илрэв. Ингэхдээ [æ] эгшиг авиалбар [a] эгшиг

авиалбар болон ондоошсон үзэгдэл их байв. Орос, англи хэлний нэгдүгээр үе дэх балархайшсан эгшиг авиалбар нь монгол хэлэнд [a] эгшиг авиалбар болон ондоошсон. Мөн хос эгшиг дан эгшиг болж, дан эгшиг нь урт эгшиг болж ондоошсон. Үгийн гарлыг авч үзвэл [a] эгшиг авиалбар ондоошиж илэрсэн үгс нь ихэнхдээ англи хэлээр дамжин орж иржээ.

1. Адаптер [Mon. **a**t**a**:ɸtʰər < Rus. **ɐ**ˈd**a**ptʲr < Eng. **ə**ˈd**æ**ptər] Д. Төмөртогоо {Rus. < Eng. < Lat.} – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад үгийн нэгдүгээр үе дэх балархай болон хоёрдугаар үе дэх хэлний урдуурх, нам эгшиг нь монгол хэлэнд хэлний дундуурх, нам эгшиг болж ондоошсон. Орос хэлний дуудлагын галиг адил илэрсэн.
2. Андройд [Mon. **a**ntrœ:t < Eng. ˈ**æ**ndrɔɪd] Д. Төмөртогоо {Eng. < Gr.} – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний урдуурх, намавтар эгшиг нь монгол хэлэнд хэлний дундуурх, нам эгшиг болж ондоошсон.
3. Апп [Mon. **a**pʰ < Eng. **æ**p] – Etymonline цахим толь {Eng.} – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний урдуурх, намавтар эгшиг нь монгол хэлэнд хэлний дундуурх, нам эгшиг болж ондоошсон.
4. Аудит [Mon. **ao**tiːtʰ < Eng. ˈ**ɔ**dət] Д. Төмөртогоо {Eng. < Lat.} – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний хойгуурх, уруулын, намавтар эгшиг нь монгол хэлэнд хэлний дундуурх, уруулын бус, нам эгшиг болж ондоошсон.
5. Аутизм [Mon. **ao**tʰitsm < Eng.ˈ**ɔ**ˌtɪzəm] Etymonline цахим толь {Eng. < Fr. <Gr.} – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний хойгуурх, уруулын, намавтар эгшиг нь монгол хэлэнд хэлний дундуурх, уруулын бус, нам эгшиг болж ондоошсон.
6. Баллон /газны/ [Mon. p**a**ɬɬɔːŋ < Eng. bəˈlun] Н. Балжинням {Eng. < Fr.} – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад балархай эгшиг нь монгол хэлэнд хэлний дундуурх, уруулын бус, нам эгшиг болж ондоошсон.
7. Батальон [Mon. p**a**tʰəɬjɔːŋ < Rus. bətɐˈlʲjən] Д. Төмөртогоо {Rus. < Fr.} – орос хэлний дуудлагын галигтай харьцуулахад балархай эгшиг нь монгол хэлэнд хэлний дундуурх, уруулын бус, нам эгшиг болж ондоошсон.
8. Газ [Mon. q**a**:ʦ < Eng. g**æ**s] Н. Балжинням {Eng. < Fr.} – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний урдуурх, намавтар богино эгшиг нь монгол хэлэнд хэлний дундуурх, нам урт эгшиг болж ондоошсон.
9. Кактус [Mon. kʰ**a**kʰtʰos < Eng. ˈk**æ**ktəs] Etymonline цахим толь {Eng. < Lat. < Ger.} – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний

урдуурх, намавтар богино эгшиг нь монгол хэлэнд хэлний дундуурх, нам урт эгшиг болж ондоошсон.

10. Кап [Mon. kʰ**a**:pʰ < Eng. kʌp] Etymonline {Eng. < Fr. < Lat.} – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад англи хэлэндээ сулавтар дуудагдаж буй [a] эгшиг авиалбар нь монгол хэлэнд хэлний дундуурх, нам урт эгшиг болж ондоошсон.
11. Караоке [Mon. kʰ**a**raɔkʰje < Eng. ˌkæriˈoʊki] Д. Төмөртогоо {Eng. < Jap.} – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний урдуурх, намавтар эгшиг нь монгол хэлэнд хэлний дундуурх, нам эгшиг болж ондоошсон.
12. Лаборатори [Mon. ɬ**a**pərtʰɔ:r < Rus. ɬəbərʁˈtorʲijə] Д. Төмөртогоо {Rus. < Ger. < Lat} – орос хэлний дуудлагын галигтай харьцуулахад балархай эгшиг нь монгол хэлэнд хэлний дундуурх, уруулын бус, нам эгшиг болж ондоошсон.
13. Лазер [Mon. ɬ**a**:tsər < Rus. ˈɬ**a**zʲir < Eng. ˈl**eɪ**zər] Д. Төмөртогоо {Rus. < Eng.} – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хос эгшиг нь монгол хэлэнд хэлний дундуурх, уруулын бус, нам урт эгшиг болж ондоошсон. Орос хэлний дуудлагын галигт адил илэрсэн.
14. Магнитуд [Mon. m**a**knitʰotʰ < Eng. ˈm**æ**gnəˌtud] Etymonline цахим толь {Eng.< Lat.} – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний урдуурх, намавтар эгшиг нь монгол хэлэнд хэлний дундуурх, нам эгшиг болж ондоошсон.
15. Марафон [Mon. m**a**rəpʰɔ:ŋ < Rus. mərʁˈfon] Д. Төмөртогоо {Rus. < Gr.} – орос хэлний дуудлагын галигтай харьцуулахад балархай эгшиг нь монгол хэлэнд хэлний дундуурх, уруулын бус, нам эгшиг болж ондоошсон.
16. Маск [Mon. m**a**:səkʰ < Eng. m**æ**sk] Н. Балжинням {Eng. < Fr.} – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний урдуурх, намавтар эгшиг нь монгол хэлэнд хэлний дундуурх, нам урт эгшиг болж ондоошсон.
17. Памперс [Mon. pʰ**a**:mpʰərs < Eng. ˈp**æ**mpər] Н. Балжинням {Eng.} – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний урдуурх, намавтар эгшиг нь монгол хэлэнд хэлний дундуурх, нам урт эгшиг болж ондоошсон.
18. Пара-олимп [Mon. pʰ**a**ɾ**a**liːmpʰ < Eng. ˈp**æ**rə-əˈlɪmpɪk] Etymonline цахим толь {Eng. <Gr.} – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад нэгдүгээр үе дэх хэлний урдуурх, намавтар эгшиг болон хоёрдугаар үе дэх балархай эгшиг нь монгол хэлэнд хэлний дундуурх, нам эгшиг болж ондоошсон.

19. Паспорт [Mon. pʰ**a**:spʰɔrtʰ < Eng. ˈpæspɔrt] Д. Төмөртогоо {Eng.} – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний урдуурх, намавтар эгшиг нь монгол хэлэнд хэлний дундуурх, нам урт эгшиг болж ондоошсон.
20. Платформ [Mon. pʰał**a**:tʰpʰɔrəm < Eng. ˈplætfɔrm] Etymonline цахим толь {Eng. < Fr.} – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний урдуурх, намавтар эгшиг нь монгол хэлэнд хэлний дундуурх, нам урт эгшиг болж ондоошсон.
21. Стратеги [Mon. istʰ**a**tʰjeːk < Eng. ˈstrætɟədʒi] Etymonline цахим толь {Eng. < Fr. <Gr.} – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний урдуурх, намавтар эгшиг нь монгол хэлэнд хэлний дундуурх, нам эгшиг болж ондоошсон.
22. Таблет [Mon. tʰ**a**pɬeːtʰ < Eng. ˈtæblət] Д. Төмөртогоо {Eng. < Fr.} – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний урдуурх, намавтар эгшиг нь монгол хэлэнд хэлний дундуурх, нам эгшиг болж ондоошсон.
23. Танк [Mon. tʰ**a**:ŋ < Rus. t**a**nk < Eng. tæŋk] Д. Төмөртогоо {Rus. < Eng.} – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний урдуурх, намавтар эгшиг нь монгол хэлэнд хэлний дундуурх, нам урт эгшиг болж ондоошсон. Орос хэлний дуудлагын галигтай харьцуулахад урт эгшгээр илэрсэн.
24. Трактор [Mon. tʰar**a**:xtʰər < Eng. ˈtræktər] Н. Балжинням {Eng.} – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний урдуурх, намавтар эгшиг нь монгол хэлэнд хэлний дундуурх, нам урт эгшиг болж ондоошсон.
25. Хакер [Mon. χ**a**kʰər < Eng. ˈhækər] Д. Төмөртогоо {Eng.} – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний урдуурх, намавтар эгшиг нь монгол хэлэнд хэлний дундуурх, нам эгшиг болж ондоошсон.
26. Чат [Mon. ʧʰ**a**:tʰ < Eng. tʃæt] Etymonline цахим толь {Eng.} – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний урдуурх, намавтар эгшиг нь монгол хэлэнд хэлний дундуурх, нам урт эгшиг болж ондоошсон.

Монгол хэлний [ɔ] эгшиг авиалбар илрэх байдал

[ɔ] эгшиг авиалбар хэвээр илэрсэн нь:

Дараах гадаад үгсийг орос, англи хэлний дуудлагатай нь харьцуулахад [ɔ] эгшиг авиалбар адил илрэв. Орос болон англи хэлэнд богино хэлэгдсэн [ɔ] эгшиг авиалбар нь монгол хэлэнд дуудагдахдаа зарим үгэнд уртаар дуудагдаж байна. Монгол хэлэнд хоёр гийгүүлэгч дараалан орсон үг байдаггүй учраас тухайн үгийг монгол хүн хэлэхдээ эгшиг зохицох ёсны дагуу эгшгээр амилуулан дууддаг. Доорх зарим үгсийг дуудахдаа эхний хоёр гийгүүлэгчийг [ɔ] эгшиг

авиалбараар амилуулан дуудаж байв. Үгийн гарлыг авч үзвэл [ɔ] эгшиг авиалбар хэвээр дуудагдаж буй үгс нь ихэнхдээ англи хэлээр дамжин орж иржээ.

1. Босс [Mon. pɔːs < Rus. b**o**s < Eng. b**ɔ**s] – Д. Төмөртогоо {Rus. < Eng.}
2. Брокер /борокер/ [Mon. pɔrɔːkʰər < Eng. ˈbr**oʊ**kər] – Н. Балжинням {Eng.}
3. Допинг [Mon. tɔːpʰiŋk < Eng. d**oʊ**pɪŋ] – Н. Балжинням {Eng.}
4. Дрон [Mon. tɔrɔːŋ < Eng. dr**oʊ**n] – Н. Балжинням {Eng.}
5. Квот [Mon. kʰɔwɔːtʰ < Rus. ˈkv**o**tə] – Д. Төмөртогоо {Rus. < Lat.}
6. Кокс [Mon. kʰɔːkʰs < Rus. k**o**ks] – Н. Балжинням {Rus. < Ger.}
7. Кола [Mon. kʰɔːɬaː < Rus. ˈk**oł**ə < Eng. ˈk**oʊ**lə] – Д. Төмөртогоо {Rus. < Eng.}
8. Кофе [Mon. kʰɔːpʰiː < Rus. ˈk**o**fʲe < Eng. ˈk**ɔ**fi] – Д. Төмөртогоо {Rus. < Eng.< Arab.}
9. Кросс [Mon. kʰɔrɔːs < Eng. kr**ɔ**s] – Н. Балжинням{Eng.}
10. Логик [Mon. ɬɔːkəkʰ < Rus. ˈ**ł**ogʲɪkə] – Д. Төмөртогоо {Rus. < Lat.}
11. Лого [Mon. ɬɔːkɔː < Eng. ˈl**oʊ**g**oʊ**] – Н. Балжинням{Eng.}
12. Мобайль [Mon. m**o**bjaːɬ < Eng. ˈm**oʊ**bl] – Etymonline цахим толь {Eng. < Fr.}
13. Молл [Mon. m**ɔ**ɬ < Eng. m**ɔ**l] – Д. Төмөртогоо {Eng.}
14. Моод [Mon. m**ɔ**ːt < Rus. ˈm**o**də] – Д. Төмөртогоо {Rus. < Fr.}
15. Мопед [Mon. m**ɔ**pʰjeːt < Eng. ˈm**oʊ**pɛd] – Etymonline цахим толь {Eng.< Ger.}
16. Нобель [Mon. n**ɔ**ːpjeɬ < Eng. n**oʊ**ˌbɛl] – Etymonline цахим толь {Eng.}
17. Норм [Mon. nɔːrəm < Rus. ˈn**o**rmə] – Д. Төмөртогоо {Rus. < Lat.}
18. Оффшор [Mon. **ɔ**ɸʃɔːr < Eng. **ɔ**f-ʃ**ɔ**r]– Д. Төмөртогоо {Eng.}
19. Покер [Mon. pʰ**ɔ**ːkʰjer < Eng. ˈp**oʊ**kər] – Etymonline цахим толь {Eng.}
20. Робот [Mon. ɔrɔːpətʰ < Rus. ˈr**o**bət] – Д. Төмөртогоо {Rus. < Czech.}
21. Сошиал [Mon. sɔːʃəɬ < Eng. ˈs**oʊ**ʃl] – Etymonline цахим толь {Eng. < Fr. < Lat.}
22. Тонн [Mon. tʰ**ɔ**ːn < Rus. ˈt**o**nːə] – Д. Төмөртогоо {Rus. < Ger. < Fr.}
23. Тросс [Mon. tʰɔrɔːs < Rus. tr**o**s] – Н. Балжинням {Rus. < Golland}
24. Фронт [Mon. pʰɔrɔːntʰ < Rus. fr**o**nt] – Д. Төмөртогоо {Rus. < Lat.}
25. Фокус [Mon. pʰ**ɔ**ːkʰəs < Eng. ˈf**oʊ**kəs] – Н. Балжинням{Eng. < Ger.< Lat.}
26. Форум [Mon. pʰ**ɔ**ːrom < Rus. ˈf**o**rʊm] – Д. Төмөртогоо {Rus. < Lat.}
27. Фудволка [Mon. pʰ**ɔ**twɔːɬkʰ < Rus. f**ʊ**dˈbołkə] – Н. Балжинням {Rus.}
28. Хлор [Mon. xɔ**ł**ɔːr < Rus. x**ł**or] – Н. Балжинням {Rus. < Gr.}

[ɔ] эгшиг авиалбар ондоошиж илэрсэн нь:

Дараах гадаад үгсийг орос, англи хэлний дуудлагатай нь харьцуулахад [ɔ] эгшиг авиалбар ондоошиж илрэв. Ингэхдээ [а] эгшиг авиалбар [ɔ] эгшиг авиалбар болон ондоошсон үзэгдэл их байв. Орос, англи хэлний нэгдүгээр үе дэх балархайшсан эгшиг авиалбар нь монгол хэлэнд [ɔ] эгшиг авиалбар болон ондоошсон. Үгийн гарлыг авч үзвэл [ɔ] эгшиг авиалбар ондоошиж илэрсэн үгс

нь ихэнхдээ англи хэлээр дамжин орж иржээ.

1. Блок [Mon. pɔɬɔːkʰ < Eng. blɑk] Н. Балжинням {Eng.} – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний дундуурх, уруулын бус, нам эгшиг нь монгол хэлэнд хэлний хойгуурх, уруулын, намавтар эгшиг болж ондоошсон.
2. Бонд [Mon. pɔːnt < Eng. bɑnd] Д. Төмөртогоо {Eng.} – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний дундуурх, уруулын бус, нам эгшиг нь монгол хэлэнд хэлний хойгуурх, уруулын, намавтар эгшиг болж ондоошсон.
3. Бокс [Mon. pɔːkʰəs < Rus. boks < Eng. bɑks] Д. Төмөртогоо {Rus. < Eng.} – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний дундуурх, уруулын бус, нам эгшиг нь монгол хэлэнд хэлний хойгуурх, уруулын, намавтар эгшиг болж ондоошсон. Орос хэлний дуудлагын галигт адил илэрсэн.
4. Коллекц [Mon. kʰɔɬɬjeːxtsʰ < Rus. kɐˈlʲektsʲijə] Н. Балжинням {Rus. < Lat.} – орос хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний дундуурх, уруулын бус, нам эгшиг нь монгол хэлэнд хэлний хойгуурх, уруулын, намавтар эгшиг болж ондоошсон.
5. Конвенц [Mon. kʰɔnwjeːntsʰ < Rus. kɐnˈvʲen͡tsʲijə] Д. Төмөртогоо {Rus. < Lat.} – орос хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний дундуурх, уруулын бус, нам эгшиг нь монгол хэлэнд хэлний хойгуурх, уруулын, намавтар эгшиг болж ондоошсон.
6. Контракт [Mon. kʰɔntʰraːxtʰ < Eng. ˈkɑntrækt] Н. Балжинням {Eng. < Lat.} – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний дундуурх, уруулын бус, нам эгшиг нь монгол хэлэнд хэлний хойгуурх, уруулын, намавтар эгшиг болж ондоошсон.
7. Контент [Mon. kʰɔntʰjeːntʰ < Eng. ˈkɑntɛnt] Etymonline цахим толь {Eng. < Fr.} – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний дундуурх, уруулын бус, нам эгшиг нь монгол хэлэнд хэлний хойгуурх, уруулын, намавтар эгшиг болж ондоошсон.
8. Контор [Mon. kʰɔntʰɔːr < Rus. kɐnˈtorə] Н. Балжинням {Rus. < Ger.} – орос хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний дундуурх, уруулын бус, нам эгшиг нь монгол хэлэнд хэлний хойгуурх, уруулын, намавтар эгшиг болж ондоошсон.
9. Концерт [Mon. kʰɔntsʰjeːrtʰ < Rus. kɐnˈt͡sɛrt] Д. Төмөртогоо {Rus. < Ger.< Fr.< It} – орос хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний дундуурх, уруулын бус, нам эгшиг нь монгол хэлэнд хэлний хойгуурх, уруулын, намавтар эгшиг болж ондоошсон.

10. Концепт [Mon. kʰɔntsʰjeːɸtʰ < Rus. ˈkɔn͡tsɛpt < Eng. ˈkɑnsɛpt] Д.Төмөртогоо {Rus. < Eng. < Lat.} – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний дундуурх, уруулын бус, нам эгшиг нь монгол хэлэнд хэлний хойгуурх, уруулын, намавтар эгшиг болж ондоошсон. Орос хэлний дуудлагын галигт хэвээр илэрсэн.
11. Комплекс [Mon. kʰɔmpʰɬjəkʰs < Rus. ˈkomplʲɪks < Eng. kɑmˈplɛks] Н.Балжинням {Rus. < Eng.< Lat.} – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний дундуурх, уруулын бус, нам эгшиг нь монгол хэлэнд хэлний хойгуурх, уруулын, намавтар эгшиг болж ондоошсон. Орос хэлний дуудлагын галигт хэвээр илэрсэн.
12. Компани [Mon. kʰɔmpʰaːn < Rus. kʁmˈpanʲɪjə] Д. Төмөртогоо {Rus. < Fr.} – орос хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний дундуурх, уруулын бус, нам эгшиг нь монгол хэлэнд хэлний хойгуурх, уруулын, намавтар эгшиг болж ондоошсон.
13. Компьютер [Mon. kʰɔmpʰjuːtʰər < Rus. kʁmʲˈpʲjutər < Eng. kəmˈpyuţər] Д. Төмөртогоо {Rus. < Eng.} – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад балархай эгшиг нь монгол хэлэнд хэлний хойгуурх, уруулын, намавтар эгшиг болж ондоошсон. Орос хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний дундуурх, уруулын бус, нам эгшиг нь монгол хэлэнд хэлний хойгуурх, уруулын, намавтар эгшиг болж ондоошсон.
14. Модерн [Mon. mɔtjeːrŋ < Eng. ˈmɑdərn] Н. Балжинням {Eng. < Fr.} – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний дундуурх, уруулын бус, нам эгшиг нь монгол хэлэнд хэлний хойгуурх, уруулын, намавтар эгшиг болж ондоошсон.
15. Мотор [Mon. mɔtʰɔːr < Rus. mʁˈtor] Д. Төмөртогоо {Rus. < Ger. < Lat.} – орос хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний дундуурх, уруулын бус, нам эгшиг нь монгол хэлэнд хэлний хойгуурх, уруулын, намавтар эгшиг болж ондоошсон.
16. Нотариат [Mon. nɔtʰəriatʰ < Rus. nətərʲɪˈat] Д. Төмөртогоо {Rus. < Ger. < Lat.} – орос хэлний дуудлагын галигтай харьцуулахад балархай эгшиг нь монгол хэлэнд хэлний хойгуурх, уруулын, намавтар эгшиг болж ондоошсон.
17. Объект [Mon. ɔpjeːkʰtʰ < Rus. ʁbˈjekt] Д. Төмөртогоо {Rus. < Lat.} – орос хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний дундуурх, уруулын бус, нам эгшиг нь монгол хэлэнд хэлний хойгуурх, уруулын, намавтар эгшиг болж ондоошсон.
18. Оксфорд [Mon. ɔkʰspʰɔːrt < Eng. ˈɑksfərd] Etymonline цахим толь {Eng.} – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний дундуурх,

уруулын бус, нам эгшиг нь монгол хэлэнд хэлний хойгуурх, уруулын, намавтар эгшиг болж ондоошсон.

19. Прокурор [Mon. pʰ**ɔ**rkʰrɔːr < Rus. pr**ə**kʊˈror] Д. Төмөртогоо {Rus. < Fr.< Lat.} – орос хэлэнд үгийн нэгдүгээр үед балархайшсан эгшиг авиалбар нь монгол хэлэнд эгшиг зохицох ёсны дагуу “п” болон “р” гийгүүлэгчийн завсар [ɔ] эгшиг авиалбар нэмэгдсэн.
20. Продакшн [Mon. pʰ**ɔ**rtakʰʃəŋ < Eng. pr**ə**ˈdʌkʃn] Н. Балжинням {Eng.} – англи хэлэнд үгийн нэгдүгээр үед балархайшсан эгшиг авиалбар нь монгол хэлэнд эгшиг зохицох ёсны дагуу “п” болон “р” гийгүүлэгчийн завсар [ɔ] эгшиг авиалбар нэмэгдсэн.
21. Шоколад [Mon. ʃ**ɔ**kʰɬaːt < Rus. ʂ**ə**kɐˈɬat < Eng.ˈtʃ**ɑ**klət] Д. Төмөртогоо {Rus. < Eng.} – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний дундуурх, уруулын бус, нам эгшиг нь монгол хэлэнд хэлний хойгуурх, уруулын, намавтар эгшиг болж ондоошсон. Орос хэлний дуудлагын галигтай харьцуулахад балархай эгшиг нь монгол хэлэнд хэлний хойгуурх, уруулын, намавтар эгшиг болж ондоошсон.
22. Хоккей [Mon. χ**ɔ**kʰjeː < Rus. x**ɐ**ˈkʲej < Eng. ˈh**ɑ**ki] Д. Төмөртогоо {Rus. < Eng.} – орос, англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний дундуурх, уруулын бус, нам эгшиг нь монгол хэлэнд хэлний хойгуурх, уруулын, намавтар эгшиг болж ондоошсон.
23. Хобби [Mon. x**ɔ**ːpiː < Rus. ˈx**o**bʲ(ː)ɪ < Eng. ˈh**ɑ**bi] Д. Төмөртогоо {Rus. < Eng.} – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний дундуурх, уруулын бус, нам эгшиг нь монгол хэлэнд хэлний хойгуурх, уруулын, намавтар эгшиг болж ондоошсон. Орос хэлний дуудлагын галигт хэвээр илэрсэн.

[o] эгшиг авиалбарын хувьсал

1. Купон [Mon. kʰ**o**pʰɔːŋ < Eng. ˈk**u**pɑn] Etymonline цахим толь {Eng. < Fr.} – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад хэлний хойгуурх, уруулын, өндөр эгшиг нь монгол хэлэнд хэлний өндөвтөр эгшиг болж ондоошсон.
2. Труба /турба/ [Mon. tʰ**o**rpaː < Rus. tr**ʊ**ˈba] Д. Төмөртогоо {Rus.} – орос хэлэнд үгийн нэгдүгээр үед балархайшсан эгшиг авиалбар нь монгол хэлэнд эгшиг зохицох ёсны дагуу “т” болон “р” гийгүүлэгчийн завсар [o] эгшиг авиалбар нэмэгдсэн.
3. Журнал [Mon. ʧ**o**rnaːɬ < Eng. ˈdʒ**ɜ**rnl] Н. Балжинням {Eng. < Fr.} – англи хэлний дуудлагын галигтай харьцуулахад балархай эгшиг нь монгол хэлэнд хэлний хойгуурх, уруулын, өндрөвтөр эгшиг болж ондоошсон.

ДҮГНЭЛТ

Бид энэхүү судалгаандаа мэдээний цахим хаягуудад илэрч буй гадаад үгийг түүвэрлэж, сурвалж хэл дэх үгийн богино эгшиг авиалбарын дуудлагыг монгол хэлний богино эгшиг авиалбарын дуудлагын галигтай харьцуулж, зөрүүтэй дуудлагад дүн шинжилгээ хийж, авианы хувьслыг тайлбарлахыг зорилго болгон ажилласан. Мэдээний цахим хаягуудаас үгийн датагаа бүрдүүлсэн бөгөөд үгийн гарлыг тэмдэглэж, түүвэрлэсэн үгийн дуудлагыг олон улсын авиа зүйн галиг (IPA)-аар галиглаж, англи болон орос хэлний тогтсон IPA-тай харьцуулав. Ингэхдээ зөвхөн хөөмийн эгшгийн хүрээнд хийж гүйцэтгэсэн бөгөөд дараах үр дүнг ажиглав.

- **[a]** эгшиг авиалбарын ондоошлыг авч үзвэл, хэлний босоо байрлалаар намавтар эгшиг нь нам эгшиг болж ондоошсон бол хэлний хөндлөн байрлалаар хэлний урдуурх эгшиг дундуурх эгшиг болж ондоошсон. Ихэнх үгэнд [æ] эгшиг авиалбар нь **[a]** эгшиг авиалбар болж ондоошсон үзэгдэл их байсан.
- **[ɔ]** эгшиг авиалбарын ондоошлыг авч үзвэл, хэлний босоо байрлалаар нам эгшиг нь намавтар эгшиг болж ондоошсон бол хэлний хөндлөн байрлалаар хэлний дундуурх эгшиг хойгуурх эгшиг болж ондоошсон. Ингэхдээ [a] эгшиг авиалбар [ɔ] эгшиг авиалбар болж ондоошсон үзэгдэл их байсан.
- Уруулын бус эгшиг уруулын эгшиг болж ондоошсон.
- Хос эгшиг дан эгшиг болж ондоошсон.
- Түүвэрлэсэн үгсийн гарлыг авч үзэхэд монгол хэлэнд гадаад үг нэвтрэхдээ ихэвчлэн орос хэлээр дамжин орсон байна.
- Англи хэлнээс орж ирсэн үгийг зөв дуудах нь түгээмэл байна. Энэ нь англи хэлний хэрэглээ өндөр байгаатай холбоотой байж болох юм.
- Англи, орос хэлний богино эгшиг авиалбарын дуудлагаас монгол хэлний дуудлага орос хэлний дуудлагатай илүү ойр байна.

PRONUNCIATION AND PHONETIC CHANGE OF GUTTURAL VOWELS IN FOREIGN WORDS IN MONGOLIAN

(WITH REFERENCE TO ENGLISH AND RUSSIAN)

In the present era of rapid technological advancement, new terms are continually emerging, enriching the vocabulary of our native language, which serves as an essential means of communication. Foreign words enter Mongolian in both spoken and written forms. Consequently, the pronunciation of newly adopted terms and foreign words may either correspond to, or differ from, their pronunciation in the

source language. For this reason, identifying the pronunciation patterns of foreign words and explaining them from a phonetic perspective is of considerable linguistic significance.

Within the scope of this study, 107 words were collected from online news platforms together with their corresponding audio recordings, and a word corpus was compiled. The origins of the selected words were identified, their pronunciations were transcribed using the International Phonetic Alphabet (IPA), and the differences in vowel phonemes were analyzed by comparing them with the standard IPA transcriptions of English and Russian. In this study, vowel phoneme differences were examined specifically in relation to guttural vowels.

Keywords: *guttural vowel, foreign word, short vowel phoneme, pronunciation transcription (IPA), vowel variation.*

НОМ ЗҮЙ

Балжинням, Н., (2005), *Монгол хэлний гадаад үгийн толь,* УБ., МУИС-ийн хэвлэх үйлдвэр.

Баттөгс, Ш., Пүрэвжав, Э., нар (2022), *Үгийн сан, утга, найруулга судлал,* Боть III, УБ., Соёмбо принтинг.

Даваажав, Г., (2022), *Монгол хэлэнд орсон европын хэлний үгийн өөрчлөлт онцлог*, УБ., Соёмбо принтинг.

Дуламрагчаа. Т., (2018), *Судалгааны ажлын үндэс,* УБ., Адмон принтинг.

Нансалмаа, Н., (2015), *Үгсийн сан судлал*, УБ., Адмон принтинг.

Пүрэвжав, Э., Ганболд, Д., нар (2022), *Бичгийн хэл*, Боть XIII, УБ. Соёмбо принтинг.

Самбуудорж. О., (2011). *Монгол хэлний үгийн дуудлагын толь,.* УБ., Адмон ХХК.

Төмөртогоо, Д., (2018), *Монгол хэлний үгийн гаралын тайлбар толь,* УБ., Адмон принт.

Уртнасан, Д., Батдорж, Ц., нар (2022), *Авиа зүй,* Боть VIII, УБ., Соёмбо принтинг.

Шагдарсүрэн, Ц., Бадамдорж, Д., нар (2022), *Үгийн сан, утга зүй,* Боть X, УБ., Соёмбо принтинг.

“Oxford Learner’s Dictionaries” цахим толь https://www.oxfordlearnersdictionaries.com/

“Wiktionary” цахим толь https://en.wiktionary.org/wiki/Russian

Судалгааны ажлын хэрэглэгдэхүүн түүвэрлэсэн мэдээний цахим хуудсууд

https://news.mn/
https://eguur.mn/
https://ikon.mn/
https://gogo.mn/
https://www.shuud.mn/
https://www.mnb.mn/
https://zarig.mn/
https://www.noorog.mn/
https://ubn.mn/
https://timenews.mn/

2026 Fasc.6

“ТОРГУУД АМАН АЯЛГУУНЫ [e], [e:] ЭГШИГ АВИАГ ТУРШИЛТ АВИА ЗҮЙН АРГААР СУДЛАХ НЬ”

Сүхбаатарын ЦЭЛМҮҮН
МУБИС-ийн Монгол хэл, уран зохиолын багшийн IV курсийн оюутан

Удирдагч багш: Р. Сарангэрэл
МУБИС-ийн Монгол хэлний тэнхимийн багш, доктор (Ph.D)

Хураангуй: *“ТОРГУУД-2024” төслийн хүрээнд Ховд аймгийн Булган суманд оршин суух торгууд угсаатны бүлгийн дөрвөн хүнийг авиалагчаар сонгон, судалгааны ажилд зориулан бэлдсэн 250 үгийг авиалуулж “WAV” хэлбэрийн дуу бичлэгийн хөмрөгийг бий болгосон бөгөөд үүнээс тэргүүн үеийн [e], [e:] эгшиг авиаг туршилт авиа зүйн судалгаанд өргөн хэрэглэгддэг “Praat” программаар задлан, тоон үзүүлэлтийн дунджийг тодорхойлов. Үүний үр дүнд [e] авиа нь $\bar{X}F_1$-389Hz, $\bar{X}F_2$-2423Hz байх бөгөөд туршилт судалгаагаар тус эгшиг авиаг уруулын бус, хэлний урдуурх, амны хөндийн зай дэд уйтан гэж үзсэн бол [e:] авиа нь $\bar{X}F_1$-492Hz, $\bar{X}F_2$-2316Hz-тэй илэрсэнд уруулын бус, хэлний урдуурх, амны хөндийн зай уйтан дунд эгшиг авиа гэж тодорхойлов.*

Түлхүүр үг: *авианы галиг, формант, герц, хөмрөг, харьцуулалт*

УДИРТГАЛ

Судлагдсан байдал

ОХУ-ын монгол судлаач Г. И. Рамстедт 1903-1904 онд Ижил Мөрөний халимаг, Шинжааны торгууд, өөлдийн аман аялгууг судалсан бол Б.Я.Владимирцов 1908-1909 онд Ховд аймаг дахь дөрвөд, баяд нутгийн аялгуу, аман зохиол, угсаатны зүйг судлах эрдэм шинжилгээний томилолтоор ажиллаж, тайлан тэмдэглэлээ хэвлүүлснээр түүний Монгол Улс дахь ойрад аялгууны судалгаа эхэлсэн байна. Тэр бээр ойрад хэл аялгууг дөрвөд, баяд, өөлд, захчин, торгууд, урианхай, мянгад гэх долоон аялгуунд хуваан үзэж, ардын дуу, үлгэр, домог, ерөөл, баатарлагийн туульс зэргийг тус тус аялгуугаар нь ангилан, орос үсгийн галигаар тэмдэглэсэн байдаг. Харин торгууд аман аялгууг нягтлан авч үзэхдээ Ховог сайраар нутаглах торгууд, Эзнээ гол, Хөх нуур орчим оршин

суух торгууд, Их болон Бага Юлдус голын сав газраар нутаглах Хар-шаарын торгууд, Хүр-хар уснаас баруун урагш Хулц хотын орчим нутаглах торгууд мөн Монгол Улсад оршин суух Алтайн торгууд хэмээн ангилсан байна.

Торгууд аман аялгуу нь монгол угсааны ойрадын нэг салбар аялгуу бөгөөд голчлон Монгол Улсын баруун бус нутаг болох Ховд аймаг, Хятад улсын Шинжаан уйгур мөн Ижил мөрний хэсэгт хэлэлцдэг байна. Энэхүү салбар аман аялгууг тусгайлан судалсан судлаач бол Х. Лувсанбалдан юм. Тэр бээр "Торгууд аман аялгууны онцлог" хэмээх сэдэвт бүтээлийг туурвиж Шинжлэх Ухааны Академийн Хэл зохиолын хүрээлэнгийн "Хэл зохиол судлал" цуврал сэтгүүлийн 1975 оны дугаарт хэвлүүлсэн байдаг ба эл бүтээлд торгууд аман аялгууны авиа зүй, үг зүйн онцлог, үгсийн сангийн зарим жишээг дурдсан байдаг.

БНХАУ дахь монгол хэл, аялгуу, үсэг бичиг, авиа судлалын талаар авч үзвэл Бямба *"Ховог сайрын торгууд аман аялгууны эгшиг зохицох ёс"* (1981), Бүрэнбаяр *"Хөхнуурын монголчууд ба түүний хэл"* (1982), Таяа *"Ховог сайрын торгууд аман аялгууны зарим авиалбарын онцлогийн тухай мөчид ойлголт"* (1987), Батжав *"Ойрад аялгууны өвөрмөц авиаг баримжаа авиатай харьцуулан мөчид шинжлэх нь"* (1987), Уртнасан *"Баримжаа авиа болон торгууд аман аялгууны авианы харьцуулал"* (1988), Гарди *"Шинжаанны Баянгол торгууд аман аялгууны аман аялгууны гийгүүлэгчийн тогтолцоо"* (1988), В. Сэцэн *"Баримжаа авиа хийгээд ойрад аялгууны авиалбарын харьцуулал"* (1989) зэрэг өгүүлэл нийтлэгдэж ойрад аялгуу, ялангуяа торгууд аман аялгууны авиа зүй, авиалбар зүйн судалгааг ахиулжээ.

Олон улсад торгууд аман аялгууны авиа зүйн онцлог, дуудлага, үгийн сан, торгууд аялгууны фонологийн системийн талаар судлагдсан байдлыг жишээ татан авч үзвэл Иванов А.В., (2016), "Акустические особенности ойратских диалектов: торгутский диалект" (Acoustic Features of Oirat Dialects: Torgut Dialect), Wang Fang., (2018), "土尔扈特蒙古语口语语音初探" (Preliminary Study on the Phonetics of Torgut Mongolian Spoken Language), Hasibagen., (2019) "新疆蒙古族土尔扈特方言语音系统研究" (Study on the Phonological System of the Torgut Dialect of Xinjiang Mongols), Aikebaier Tuersun (2020) "土尔扈特蒙古语语音与词汇研究" (Study on the Phonetics and Vocabulary of Torgut Mongolian) докторын диссертаци зэргийг дурдаж болох бол торгууд аман аялгууг туршилт авиа зүйн аргаар судалсан нь Li Na., (2017), "新疆土尔扈特蒙古语口语语音的实验研究" (Experimental Study on the Phonetics of Torgut Mongolian Spoken Language in Xinjiang), Elena Parina, Sechenbaatar., (2018), "Acoustic Analysis of Oirat Dialects: A Case Study of Torgut Mongolian", Zhao Li., (2019), "土尔扈特蒙古语口语的实验语音学分析" (Experimental Phonetic Analysis of Torgut

Mongolian Spoken Language) зэрэг өгүүлэл хэвлэгджээ[1].

Түүнчлэн бид "Эрдмийн хэлхээ" эрдэм шинжилгээний сэтгүүлийн XIV ботид "Торгууд аман аялгууны [а, а:, æ, æ:] эгшиг авиаг туршилт авиа зүйн аргаар судлах нь" сэдэвт өгүүллийг нийтлүүлсэн бөгөөд энэ удаагийн өгүүлэл нь тус өгүүллийн үргэлжлэл юм.

Судалгааны ажлын зорилго, зорилт

Торгууд аман аялгууны эгшиг авианы формант (F1, F2)-ыг хэмжин задалж, авианы ялгаатай шинжийг тодорхойлох, тогтоох.Үүнд тулгуурлан дараах зорилтуудыг дэвшүүлэв. Үүнд:

- Сэдэвтэй холбоотой өмнө нь судлагдсан байдлыг тоймлох;
- Авиалагчдын хурааж авсан бичлэгээс эр эгшиг авиа бүхий үгсийг түүвэрлэн кодлох;
- "Excel" программ дээр хөмрөг үүсгэх;
- "Praat" программыг ашиглан кодолсон үгсийн формантыг тодорхойлох;
- Үгсийг IPA буюу олон улсын авиа зүйн галигаар галиглах;
- Авианы ялгаатай шинжийг тогтоон харьцуулах
- Задлан шинжлэх, дүгнэлт хийх.

Судалгааны ажлын шинэлэг тал, ач холбогдол

Энэхүү судалгаа нь салбар дундын аман аялгууг харьцуулснаар хэлний онцлогийг шинжлэх ухааны үндэслэлтэй баримтжуулах ба өнөөдрийн түвшинд тус аман аялгуунууд хэр зэрэг өөрчлөгдсөн байгааг илрүүлэх ба монгол хэл шинжлэлд технологийн хандлага нэвтрүүлж, уламжлалт авиа зүйн хүрээнд тогтоосон онолыг туршилтын аргаар баримтжуулан нягтлах, мөн ялгаатай байдлыг тодруулах зэрэг практик ач холбогдолтой. Цаашлаад удаах судалгааны ажлуудын үндэс суурь болох боломжтой хэмээн үзэж байна.

Судалгааны арга ба аргачлал

Торгууд аман аялгууны эгшиг авиаг судлахдаа хэлний авианы өгүүлүүрийн шинжийг авианы физик шинжтэй холбон тайлбарладаг хэл яриа бүтэх акустик онол (Acoustic theory of speech production)-ыг баримтлан, туршилт авиа зүйн аргууд болон тоон арга, ажиглалтын арга, тодорхойлох тайлбарлах арга, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх зэрэг аргуудыг ашигласан ба туршилт авиа зүйн аргаар авианы шингээлт хийн, үр дүнг боловсруулахдаа Cool Edit pro 2.0, Praat 5.2 зэрэг программуудыг ашиглав.

Туршилт авиа зүй

Физиологийн авиа зүйд аливаа авианы эсрэгцэх шинжийг нь зөвхөн бүтэх

[1] Цэлмүүн, С., *Торгууд аман аялгууны [а, а:, æ, æ:] эгшиг авиаг туршилт авиа зүйн аргаар судлах нь,* Эрдмийн хэлхээ, боть XIV. УБ., 2025, х.11-21.

арга байдлаар нь тайлбарлахаар хязгаарлаж байсан учир энэ бэрхшээлийг давахын тулд XIX зууны сүүлчээр авиаг тэмдэглэж, задлан шинжилдэг багаж хэрэгсэл бүхий туршилт авиа зүй үүссэн түүхтэй.

Туршилт авиа зүй нь хэлний авиаг шинжлэх ухааны арга, технологи ашиглан судалдаг хэл шинжлэлийн салбар бөгөөд ярианы авианы үйлдвэрлэл, дамжуулалт, хүлээн авалтын физик, физиологийн болон сэтгэл зүйн талуудыг нарийвчлан шинжилдэг. Энэ нь хэлний авианы шинж чанарыг лабораторийн нөхцөлд хэмжилт, туршилт, анализын тусламжтайгаар судалдаг тул “туршилт” хэмээн нэрлэсэн байдаг.

Хэлний өгүүлэгч сонсогчоос бүрдсэн хамгийн энгийн харилцаагаар жишээлэн авч үзэхэд, сэтгэц физиологи, өгүүлэхүй болон акустик гэсэн харилцан нягт уялдаатай үзэгдэл юм. Өгүүлүүрийн эрхтний үйл ажиллагааны үр дүнд бий болсон хэлэхүйн дохио сонсголын эрхтэнд хүртэхэд бие биедээ харилцан нөлөө бүхий шаталсан хэд хэдэн үе шатыг дамждаг ажээ. Эдгээр үе шатаас өгүүлэх, сонсохын дунд орших акустик авиа зүй нь хэлний бодит илрэл, агаарын хэлбэлзлийн долгион буюу баялаг хувирамтгай дохиог судалдаг. Авианы физик хэмжигдэхүүнийг задлан шинжилж үүргийн хувьд ач холбогдол бүхий үзүүлэлтийг олж тогтоон, дүн шинжилгээ хийх нь туршилт буюу акустик авиа зүйн гол судлагдахуун юм[2].

Акустик авиа зүйн онол (Acoustic Theory of Speech Production)-ын хүрээнд хэлэхүйн авиаг хэрхэн физик шинж чанараар тайлбарладаг талаар Fant (1960) суурь судалгаа хийжээ. Тэр бээр дуу хоолойн дамжуулалтын функцийг математикийн аргаар боловсруулж эгшиг авианы формантын байрлалыг тодорхойлох онолын суурийг тавьсан байна.

Формант (F1, F2) гэдэг нь ярианы гарлын спектрт харагдах дуун ухааны резонансийн давтамж бөгөөд амны хөндийн хэлбэрийн өөрчлөлтөөс хамаардаг. F1 нь амны хөндийн нийт эзлэхүүнтэй, F2 нь хэлний хэлбэртэй нягт уялдаатай.

Өнөөдөр туршилт авиа зүйн болон лабораторийн авиалбар зүйн хооронд зааг ялгаа бараг байхгүй болжээ. Туршилт авиа зүйн онолын загвар нь авиалбар зүйн загварын нэг адил хүлээн зөвшөөрөгдөж, хэрэглээний хэлшинжлэл болон байгалийн салбар ухаануудын уулзварт чухал үүрэг гүйцэтгэх болжээ. Лабораторид хөмрөг бүрдүүлэх, мөн тэдгээрийг сүүлийн үеийн боловсронгуй техник технологи ашиглан дуун ухаан, өгүүлүүр зүй, харааны болон физиологийн олон хэмжигдэхүүнийг нэгэн зэрэг гарган авч задлан шинжлэх, өгүүлэх эрхтний ажиллагааны талаар илүү нарийвчлалтай мэдээлэл авч авиа

[2] Батзаяа, Г., Уртнасан, Д., *Монгол хэлний нутгийн аялгууны авиа зүйн харьцуулсан судалгаа*, УБ., 2023, х.6.

зүйн үзэгдлийг тодорхойлоход ашиглаж байна. Мөн сүүлийн үеийн авч явах боломжтой авсаархан багаж хэрэгслийн ачаар заавал лабораторид бичлэг хийх шаардлагагүй, газар дээр нь очиж баримт мэдээлэл цуглуулах, хэлний баримтын бичлэгийн чанарт ахиц гарснаар авиа зүй, тэр дундаа нутгийн аялгуу судлалд үнэтэй хувь нэмэр оруулж байна[3].

Туршилт судалгааны арга зүй

Тус судалгаанд "*Монгол хэлний нутгийн аялгууны газрын зургийн байцаалтын материалын цуврал, Ерөнхий өгүүлийн боть"* дахь 1-3 үет 250 үгийг хэрэглэгдэхүүн болгож ашигласан ба эдгээр үгсийг 1 эрэгтэй, 3 эмэгтэй авиалагчаар диктафон дээр тус тус уншуулж бичлэг хийсэн. Үүнээс үгийн тэргүүн үед орсон эгшиг авиаг задалж, формант давтамжийн 1, 2-р бүрэлдэхүүнийг тоо баримтаар гарган хөмрөгт оруулав. Энэ туршилт судалгааны үр дүнг уламжлалт авиа зүйн аргаар тодорхойлсон судлаачдын судалгаанд түшиглэн уламжлалт арга болон туршилтын аргаар судалсан байдал хоорондоо хэр зөрүүтэй байгааг нягталж харьцуулан үзэв.

Судалгааны явцад тооцоолон гаргасан хэмжигдэхүүнийг дуун ухааны үүднээс шинжлэхдээ туршилт авиа зүйн судалгаанд өргөн хэрэглэгддэг дараах ангиллыг баримталлаа. Үүнд:

Формантын 1-р бүрэлдэхүүн буюу F1-ийн хэмжигдэхүүн амны хөндийн зайнаас хамааран өөрчлөгдөнө.

200-350Гц уйтан
350-400Гц дэд уйтан
400-500Гц уйтан дунд
500-550Гц дунд
550-650Гц агуу дунд
650-800Гц дэд агуу
800+ Гц агуу

Формантын 2-р бүрэлдэхүүн буюу F2 нь хэлний урдуурх, дундуурх, хойгуурх хэлэгдэхтэй холбоотой.

1600+Гц хэлний урдуурх
1200-1600Гц хэлний дундуурх
-1200Гц хэлний хойгуурх

Судалгааны хэрэглэгдэхүүн

Тус судалгааны хэрэглэгдэхүүн нь МУБИС-ийн Монгол судлалын хүрээлэнгийн "ТОРГУУД-2024" хөмрөг болон тус хөмрөгийг байгуулахад

[3] Булгантамир, С., *Эгшиг авиаг туршилт авиа зүйн аргаар судлах нь*, Acta Mongolica *15*(411), УБ., 2014, х.130.

зориулан бэлтгэсэн торгууд аман аялгуутай авиалагчдаар дуудуулан шингээсэн “WAV” хэлбэрийн дуу бичлэг болно.

Формант ба акустик задлалтын онол

Формант нь ярианы авианы спектр дэх хүч чадлын дээд цэгүүд буюу резонансийн давтамж юм. Формант давтамж нь ярих үед үүсэх дуу чимээний (vocal tract) хэлбэрээс шалтгаалдаг.

Эгшиг авианы хувьд дор хаяж дөрвөн формант байдаг ч авиа зүйн шинжилгээнд F1 ба F2 хоёр нь хамгийн чухал байдаг. F1 нь хэлний өндрийн байрлалтай (доод-дээд) урвуу хамааралтай ба хэл доошлох тусам F1 нэмэгдэнэ. F2 нь хэлний урд-хойдын байрлалтай шууд хамааралтай бөгөөд хэл урагшлах тусам F2 нэмэгдэнэ.

Уруулын байдал нь мөн формантад нөлөөлнө. Уруулаар бөглөрсөн (rounded) эгшгийн хувьд F1 ба F2-ын аль аль нь буурах хандлагатай байдаг. Ийм учраас уруулын, хэлний урдуурх эгшиг [ө, у] нь F2 нь нэлээд өндөр байгаа ч уруулын нөлөөгөөр буурч F2 дундуурх байрлалтай болдог.

Хүснэгт 1. Формантын тайлбар

Формант	Физик тайлбар	Холбогдох хүчин зүйл
F1	1-р резонансийн давтамж	Амны хөндийн нийт эзлэхүүн (хэлний өндөр)
F2	2-р резонансийн давтамж	Хэлний урд-хойдын байрлал
F3	3-р резонансийн давтамж	Уруул, хэлний үзүүрийн байрлал
F4	4-р резонансийн давтамж	Залгиурын хоолойн байдал

Солонгон бичлэг - Спектрограмма /Spectrogramme Praat/

Туршилт авиа зүйн олон төрлийн арга, электрон аппарат, багаж дотроос солонгон бичлэг буюу спектрограммын шинжилгээ ихэд өргөн дэлгэр болж байгаа бөгөөд судалгаа шинжилгээний үр дүн, тооцоолол, нийтэд хүртээлтэй байдал зэргээрээ Praat программ нь олон давуу талтай байна.

Praat программыг Голланд улсын Амстердамын их сургуулийн судлаач Пол Боэрсма, Давид Вийник (Paul Boersma, David Weenink) үндэслэсэн ба уг программ нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн бөгөөд Macintosh, Windows, Linux болон бусад үйлдлийн системд ажиллах боломжтой. Тус программаар дамжуулан авиаг задлан шинжлэх, авианы өндөр нам, формант, хүчдэл зэргийг хэмжих, өгүүлүүрийн эрхтний оролцоог тодорхойлох, авиалбарын нэмэлт өнгийг задлан шинжлэх, сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах, хэл ярианы дохиог өөрчлөх зэрэг олон үйлдлийг хийх боломжтой.

Эл судалгаанд Praat 5.2 хувилбарыг ашигласан бөгөөд бичлэгийн засварлалтад Cool Edit Pro 2.0 программыг хавсарган хэрэглэлээ. Praat программд авиалагч тус бүрийн WAV файлыг оруулан, эгшиг авиа бүхий үгийн тэргүүн үед текстийн тэмдэглэгээ (TextGrid) тавьж, формант анализыг гүйцэтгэв.

Формант задлалтын аргачлал

Эдгээр үгээс үгийн тэргүүн үед орсон эгшиг авиаг задалж, формант давтамжийн 1, 2-р бүрэлдэхүүнийг тоо баримтаар гарган хөмрөгт оруулав. Энэ туршилт судалгааны үр дүнг уламжлалт авиа зүйн аргаар тодорхойлсон судлаачдын судалгаанд түшиглэн уламжлал арга болон туршилтын аргаар судалсан байдал хоорондоо хэр зөрүүтэй байгааг нягталж харьцуулан үзлээ.

Praat программд формант задлалтыг гүйцэтгэхдээ:

- WAV файлыг Praat-д оруулах,
- TextGrid тэмдэглэгээ үүсгэж судлах эгшиг авиа бүхий үгсийг тэмдэглэх,
- FormantPath тооцоолол гүйцэтгэх,
- Эгшиг авианы тогтвортой хэсгийн дундаас F1, F2 утгыг авах,
- Excel программд оруулж статистик боловсруулалт хийх.

Формант задлалтад ашигласан параметрүүд: F1-ийн зорилтот хүрээ 0-1000Hz, F2-ын зорилтот хүрээ 0-3000Hz, цонхны урт 0.025 сек, алхмын урт 0.005 сек. Дундаж утгыг ($\bar{X}$) тооцоолохдоо арифметикийн дундаж аргыг хэрэглэж, 4 авиалагч тус бүрийн үр дүнг нэгтгэн боловсруулав.

Торгууд аман аялгууны эгшиг авианы туршилт авиа зүйн тухайд

МУБИС-ийн Нийгэм хүмүүнлэгийн ухааны сургууль болон Монгол судлалын хүрээлэнгийн судалгааны баг 2024 онд Ховд аймгийн Булган сумын торгууд ард түмнийг зорин 7-р сарын 31-ээс 8-р сарын 10-ны хооронд «ТОРГУУД-2024» төслийн хүрээнд хэл аялгуу, угсаатан, түүх соёл, нийгэм, социологи зэрэг тал талын судалгааг хамтран зохион байгуулсан ба энэ хугацаанд Ховд аймгийн Булган сумын уугуул дөрвөн хүнийг энэхүү туршилт авиа зүйн судалгаанд авиалагч болгон хамруулав. Тэдгээр авиалагчийн яриаг DR-05X диктофонд буулган авсан.

Авиалагчдыг сонгохдоо уугуул торгууд угсаатны хүн буюу бага наснаасаа Ховд аймгийн Булган суманд аж төрсөн байх, хэл ярианы хувьд ямар нэгэн асуудалгүй бөгөөд бүрэн шүдтэй байх зэрэг шаардлагад нийцүүлэв.

Мөн торгууд аман аялгууны эгшиг авиаг халх аялгууны харгалзах эгшгийн F1, F2 хэмжигдэхүүний тоо баримттай харьцуулан үзүүлсэн ба тус хэсэгт ашигласан халх аялгууны эгшгийн формантад холбогдох тоо баримтыг 2014 онд Өвөр Монголын Их Сургуульд докторын зэрэг хамгаалсан Ц. Батдоржийн “Халх аялгууны авианы дууны ухааны задлалт” нэг сэдэвт бүтээлээс авсан болно[4].

[4] Батдорж, Ц., *Монгол хэлний халх аялгууны авианы дуун ухааны задлалт.* Докторын зэрэг горилсон бүтээл, ӨМИС, Хөх хот., 2014, х.12-52.

Авиалагчдын мэдээлэл:

Хүснэгт 2. Авиалагчдын мэдээлэл

№	Асуулт	Авиалагч 1	Авиалагч 2	Авиалагч 3	Авиалагч 4
1.	Код	trg001	trg002	trg003	trg004
2.	Нас	69	82	25	75
3.	Хүйс	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй	эмэгтэй
4.	Угсаа	торгууд	торгууд	торгууд	торгууд
5.	Төрсөн газар	Ховд, Булган	Ховд, Булган	Ховд, Булган	Ховд, Булган
6.	Ажил мэргэжлийн байдал	Эмийн санч	Багш	Багш	Малчин

Богино эгшиг

Үндсэн хэсэгт торгууд аман аялгууны эгшиг авианы туршилт авиа зүйн судалгааны үр дүнг нармайн эгшиг, хөөмийн эгшиг гэсэн хоёр бүлэгт хуваан тайлбарлахдаа богино эгшиг, урт эгшиг тус бүрийг дэлгэрэнгүй авч үзэхээс гадна халх аман аялууны эгшиг авиатай тус бүр харьцуулан өөрийн оюун дүгнэлтийг тусгав.

Урт эгшиг

Ойрад аялгуунд a, ä, o, u, e, ő, ű, i, ï гэсэн 9 богино эгшиг, ā, a̋, ō, ū, ē, ő, ű, ī, ï гэсэн 9 урт эгшиг байх ба монголын ойрад аялгуунд ā^{i}, ō^{i}, u^{i}, ű^{i} гэсэн хос эгшиг авиа, *ūă*, ōă, ōa̋, űa̋, ő̄a̋, ēa̋, ő̄ě, őű, ia̋ гэх мэт хосорхог урт эгшгийн хувилбар тохиолдоно. Ойрад аялгууны урт эгшиг нь бусад монгол хэл аялгуунд урт эгшиг үүссэн түгээмэл үзэгдлийн нэгэн адилаар бий болжээ. Монгол бичгийн хэлний ЭГЭ бүтцэд орсон түрэлтэт ɣ, g, y, b(w) гийгүүлэгч нь аль тод сонсогдох эгшгийн нөлөөгөөр уусан шингэж захын эгшгүүд ижилсэн урт эгшиг үүсжээ[5].

Торгууд аялгууны урт эгшиг нь ярианы явцад богино эгшгийг бодвол удаанаар хэлэгдэж байгаа юм. Ийм ч учраас урт богино эгшиг үгийн утга ялгах авиалбарын үүрэг гүйцэтгэж байна. Урт эгшиг эгшиг бол эртний монгол хэлнээ байсан хоёр эгшгийн завсрын ɣ, g, y, b сугаран гээгдсэний үндсэн дээр үүсжээ. Торгууд аялгууны урт эгшиг ā, a̋, ō, ō̰, ū, ṵ̄, ē, ő̄, ű̄, ī, байна[6].

[5] Цэндээ, Ю., *Орчин цагийн монгол хэлний нутгийн аялгуу,* УБ., 2020, х.64-65.

[6] Лувсанбалдан, Х., *Сурвалж бичиг нутгийн аялгуу судлал,* УБ., 2015, х.268.

СУДАЛГААНЫ ҮНДСЭН ХЭСЭГ

Торгууд аман аялгууны [e] авиа

Хүснэгт 3. [e] эгшиг авианы харьцуулал

[e]	Х. Лувсанбалдан	эс уруулшсан, хэлний урдуурх, дунд эгшиг
	Ю. Цэндээ	уруулын биш, хэлний дундуурх, амны хөндийн зай дунд зэрэг
	Туршилт судалгаа	уруулын бус, хэлний урдуурх, амны хөндийн зай дэд уйтан

[e] авианы судалгаанд хэрэглэсэн зарим үгийн F1, F2-ын жишээ:

Хүснэгт 4. trg0001 кодтой авиалагчийн [e] авианы формант задрал

Код	Бичлэгийн дугаар	Кирилл	Галиг	Авиа	F2	F1
trg001	1	бэр	per	e	2321	433.2
trg001	2	элэг	ełək	e	2375	380
trg001	3	эсгий	eska:	e	2321	273.6
trg001	4	сэрүүн	seru:ŋ	e	2233	447.7
trg001	5	тэлээ	tʰełe:	e	2566	387.1
trg001	6	тэмээ	tʰeme:n	e	2414	689.7
trg001	7	тэнгэр	tʰeŋүər	e	2475	417.4
trg001	8	цэцэг	tsʰetsʰək	e	2475	447.7
trg001	9	цэвэр	tsʰewər	e	2505	417.4
trg001	10	зэрлэг	tserłək	e	2233	417.4

Хүснэгт 5. trg0002 кодтой авиалагчийн [e] авианы формант задрал

Код	Бичлэгийн дугаар	Кирилл	Галиг	Авиа	F2	F1
trg002	1	бэр	per	e	2082	387.1
trg002	2	элэг	ełək	e	2112	387.1
trg002	3	эсгий	eski:	e	2293	356.9
trg002	4	сэрүүн	seru:ŋ	e	2263	387.1
trg002	5	тэлээ	tʰełe:	e	2475	387.1
trg002	6	тэмээ	tʰeme:	e	2203	447.7
trg002	7	тэнгэр	tʰeŋүər	e	2051	387.1
trg002	8	цэцэг	tsʰetsʰək	e	2324	356.9
trg002	9	цэвэр	tsʰewər	e	2203	387.1
trg002	10	зэрлэг	tserłək	e	2233	387.1

Хүснэгт 6. trg0003 кодтой авиалагчийн [e] авианы формант задрал

Код	Бичлэгийн дугаар	Кирилл	Галиг	Авиа	F2	F1
trg003	1	бэр	per	e	2626	326.6
trg003	2	элэг	ełək	e	2808	356.9
trg003	3	эсгий	eski:	e	2808	356.9
trg003	4	сэрүүн	seru:ŋ	e	2565	376.8
trg003	5	тэлээ	t^hełe:	e	2670	376.8
trg003	6	тэмээ	t^heme:	e	2635	412.1
trg003	7	тэнгэр	t^heŋүər	e	2812	341.5
trg003	8	цэцэг	ts^hets^hək	e	2459	341.5
trg003	9	цэвэр	ts^hewər	e	2706	341.5
trg003	10	зэрлэг	tserłək	e	2459	376.8

Хүснэгт 7. trg0004 кодтой авиалагчийн [e] авианы формант задрал

Код	Бичлэгийн дугаар	Кирилл	Галиг	Авиа	F2	F1
trg004	1	бэр	per	e	2445	387.1
trg004	2	элэг	ełək	e	2475	356.9
trg004	3	эсгий	eski:	e	2414	296.4
trg004	4	гэдэс	ketəs	e	2082	387.1
trg004	5	тэлээ	t^hełe:	e	2535	387.1
trg004	6	тэмээ	t^heme:	e	2505	356.9
trg004	7	тэнгэр	t^heŋүŋər	e	2445	417.4
trg004	8	цэцэг	ts^hets^hək^h	e	2384	417.4
trg004	9	цэвэр	ts^hewər	e	2505	356.9
trg004	10	зэрлэг	tserłək^h	e	2414	387.1


Х. Лувсанбалдан торгууд аман аялгууны [e] эгшиг авиаг эс уруулшсан, хэлний урдуурх, дунд эгшиг ба гагцхүү үгийн нэгдүгээр үед тохиолдоно гэж тодорхойлсон байдаг бол ойрад аялгууг судалсан Ю. Цэндээ [e] эгшиг авиаг хэлний дундуур, уруулын биш, амны хөндийн зай дунд зэрэг, эм сул эгшиг, эм үгийн эхэн, дунд тохиолдох ба үеийн адагт маш балархай сонсогдоно хэмээн үзсэн байна. Харин бидний судалгааны үр дүнд дөрвөн авиалагчийн авиалсан үгсийн формантын задралын дундаж нь $\bar{X}F_1$-389Hz, $\bar{X}F_2$-2423Hz байх бөгөөд [e] эгшиг авиаг уруулын бус, хэлний урдуурх, амны хөндийн зай дэд уйтан гэж тодорхойлов.

Дөрвөн авиалагчийн авиалсан нийт үгийн формантын задралаас гарсан дундаж утга нь $\bar{X}$F1=389Hz, $\bar{X}$F2=2423Hz байна. Эдгээр тоон утгыг судалгаанд

хэрэглэсэн стандарт ангиллын дагуу тайлбарлавал: F1=389Hz нь 350–400Hz-ийн «дэд уйтан» ангилалд орж байгаа бөгөөд амны хөндий харьцангуй нарийн нээгдэж байгааг илтгэнэ. F2=2423Hz нь 1600Hz-ээс дээш буюу «хэлний урдуурх» ангилалд орж байна. Ийм байдлаар [e] авиаг «уруулын бус, хэлний урдуурх, амны хөндийн зай дэд уйтан» хэмээн тодорхойлов. Энэ нь Х. Лувсанбалданы «урдуурх» гэсэн тодорхойлолтыг баталж, Ю.Цэндээгийн «дундуурх» гэсэн тодорхойлолттой зөрж байна.

Авиалагч тус бүрийн хэмжилтийн үр дүнг нарийвчлан авч үзвэл trg001 (эмэгтэй, 69 нас) авиалагчийн F2 формантын дундаж нь 2432Hz орчимд байсан бол trg002 (эрэгтэй, 82 нас) авиалагчийнх 2219Hz болж харьцангуй бага гарсан байна. Энэ зөрүү нь голдуу хүйсийн онцлогоос шалтгаалсан байх боломжтой. trg003 (эмэгтэй, 25 нас) авиалагчийн F2 хэмжээ нь нь дөрвөн авиалагчийн дотроос хамгийн өндөр буюу 2660Hz орчимд байгаа нь залуу үеийнхний [e] авиа улам урдуур хэлэгдэх боломжтой гэсэн таамаглалыг дэвшүүлж болох ч дан ганц нэг авиалагчийн өгөгдлөөр дүгнэлт тохиромжгүй юм.

F1 формантын хувьд ажиглавал trg001 авиалагчийн тэмээ гэсэн үгэнд F1=689.7Hz гарсан нь бусад үгстэй харьцуулахад мэдэгдэхүйц өндөр байна. Энэ нь тухайн үгийн [e] авиа өмнөх болон дараах гийгүүлэгчийн нөлөөгөөр амны хөндий илүү нээгдэж буйг илтгэж байгаа юм. Харин trg003 авиалагчийн тэнгэр гэсэн үгэнд F2=2812Hz буюу хэмжилтийн хамгийн өндөр F2 утга гарсан нь тухайн авиалагчийн хэлний байрлал онцгой урдуур байсныг харуулж байна.



Зураг 1. tʰeme:n/тэмээ хэмээх үгийн солонгон мяралзал бичлэг

Торгууд аман аялгууны [e:] авиа

[e:]	Х.Лувсанбалдан	уруулын бус, хэлний урдуурх, амны хөндийн зай дунд зэрэг
	Ю.Цэндээ	хэлний урдуурх, уруулын биш, амны хөндийн зай дунд зэрэг
	Туршилт судалгаа	уруулын бус, хэлний урдуурх, амны хөндийн зай уйтан дунд

[e:] авианы судалгаанд хэрэглэсэн зарим үгийн F1, F2-ын жишээ:

Хүснэгт 8. trg0001 кодтой авиалагчийн [e:] авианы формант задрал

Код	Бичлэгийн дугаар	Кирилл	Галиг	Авиа	F2	F1
trg001	1	бүлээн	puɬe:n	e:	2112	477.9
trg001	2	гээх	ke:x	e:	2475	447.7
trg001	3	хээл	kʰe:ɬ	e:	2414	447.7
trg001	4	тэлээ	tʰeɬe:	e:	2172	720
trg001	5	тэмээ	tʰeme:n	e:	2112	780.5
trg001	6	цээж	tsʰe:ʧə	e:	2505	447.7
trg001	7	зээл	tse:ɬ	e:	2505	447.7

Хүснэгт 9. 3 trg0002 кодтой авиалагчийн [e:] авианы формант задрал

Код	Бичлэгийн дугаар	Кирилл	Галиг	Авиа	F2	F1
trg002	1	бүлээн	puɬe:n	e:	2051	598.9
trg002	2	тэлээ	tʰeɬe:	e:	2263	477.9
trg002	3	тэмээ	tʰeme:	e:	2142	538.4
trg002	4	цээж	tsʰe:ʧ	e:	2233	447.7
trg002	5	үлээх	uɬe:x	e:	2172	447.7
trg002	6	үнээ	une:	e:	2142	477.9
trg002	7	зээл	tse:ɬ	e:	2233	447.7

Хүснэгт 10. trg0003 кодтой авиалагчийн [e:] авианы формант задрал

Код	Бичлэгийн дугаар	Кирилл	Галиг	Авиа	F2	F1
trg003	1	бүлээн	puɬe:n	e:	2324	417.4
trg003	2	тэлээ	tʰeɬe:	e:	2318	518
trg003	3	тэмээ	tʰeme:	e:	2388	518
trg003	4	цээж	tsʰe:ʧ	e:	2706	341.5
trg003	5	үлээх	uɬe:x	e:	2384	447.7
trg003	6	үнээ	une:	e:	2475	447.7
trg003	7	зээл	tse:ɬ	e:	2741	376.8

Хүснэгт 11. trg0004 кодтой авиалагчийн [e:] авианы формант задрал

Код	Бичлэгийн дугаар	Кирилл	Галиг	Авиа	F2	F1
trg004	1	бүлээн	puɬe:ŋ	e:	2082	629.2
trg004	2	үлээх	uɬe:x	e:	2293	508.2
trg004	3	зээл	tse:ɬ	e:	2475	356.9

Х. Лувсанбалданы үзсэнээр торгууд аман аялгууны [e:] авиа нь уруулын бус, хэлний урдуурх, амны хөндийн зай дунд зэрэг, хүчдэлгүй эгшиг байна. Харин ойрад аман аялгууг судалсан Ю. Цэндээ [e:] авиаг хэлний урдуурх, уруулын биш, амны хөндийн зай дунд зэрэг эм сул, урт эгшиг, ихэвчлэн үгийн тэргүүн үед орох ба ойрад аялгуунд хаяа үгийн дунд, адагт тохиолдоно хэмээн үзжээ. Харин тус судалгааны үр дүнд дөрвөн авиалагчийн авиалсан үгсийн формантын задралын дундаж нь $\bar{X}F_1$-492Hz, $\bar{X}F_2$-2316Hz илэрсэн бөгөөд ийнхүү [e:] авиаг уруулын бус, хэлний урдуурх, амны хөндийн зай уйтан дунд гэж тодорхойлов.

Авиалагч тус бүрийн өгөгдлийг нарийвчлан авч үзвэл trg001 авиалагчийн тэлээ болон тэмээ гэсэн үгийн F1 тус тус 720Hz, 780.5Hz гарсан нь бусад үгсийн F1 хэмжилтээс хоёр дахин өндөр байна. Эдгээр үгийн бүтцийг авч үзвэл тэлээ гэдэгт [e:] авианы өмнө [t^h], дараа нь [ɬ] орж байгаа бол тэмээ гэдэгт дараа нь [m] орж байна. Ийм орчинд урт эгшгийн дундаас хэмжилт авахад шилжилтийн хэсэг хэмжилтэд нэвтэрч, F1-ийг нэмэгдүүлсэн байж болзошгүй юм.

Уламжлалт тодорхойлолттой харьцуулахад Х. Лувсанбалдан болон Ю.Цэндээ хоёул [e:]-г «амны хөндийн зай дунд зэрэг» гэж тодорхойлсон байдаг. Гэвч бидний хэмжилтийн $\bar{X}F_1$=492Hz нь “уйтан дунд” ангилалд (400–500Hz) орж байгаа нь “дунд” (500–550Hz) ангиллаас доогуур байна. Богино [e]-ийн F1=389Hz “дэд уйтан” ангилалд байхад урт [e:]-ийн F1=492Hz “уйтан дунд” ангилалд шилжсэн нь урт хэлбэрт амны хөндий нэмэлтээр нээгддэг болохыг баталж байна.

Хүснэгт 12. Халх болон торгууд аман аялгууны [e:] эгшиг авианы харьцуулалт

Аялгуу	Галиг	F_1, F_2-ын дундаж	Тодорхойлолт
Халх	e:	$\bar{X}F_1$=362 Hz $\bar{X}F_2$=1581 Hz	Уруулын бус, хэлний дундуурх, дэд уйтан
Торгууд	e:	$\bar{X}F_1$=492 Hz $\bar{X}F_2$=2316 Hz	Уруулын бус, хэлний урдуурх, уйтан дунд

ДҮГНЭЛТ

Энэхүү судалгааны ажилд торгууд аман аялгууны богино болон урт эгшиг авиаг «ТОРГУУД-2024» төслийн хүрээнд цуглуулсан бодит хэлний материалд тулгуурлан туршилт авиа зүйн аргаар задлан шинжилж, уламжлалт авиа зүйн тодорхойлолттой болон халх аялгууны эгшиг авиатай акустик харьцуулалт хийв. Судалгааны үр дүнг дараах байдлаар нэгтгэн дүгнэв.

Ховд аймгийн Булган сумын дөрвөн авиалагчийн бичлэгийн хөмрөгт үндэслэн Praat программаар гүйцэтгэсэн формант задлалын үр дүнд [e] эгшиг авиа $\bar{X}F1$=389Hz, $\bar{X}F2$=2423Hz, [e:] эгшиг авиа $\bar{X}F_1$-492Hz, $\bar{X}F_2$-2316Hz гэсэн

үзүүлэлттэй байна. Мөн авиалагч тус бүрийн хэмжилтийн үр дүнд хүйс болон насны хүчин зүйл нөлөөлж байгаа нь ажиглагдлаа. Эрэгтэй авиалагч trg002-ын F2-ын дундаж 2219Hz байсан нь эмэгтэй авиалагчдынхаас мэдэгдэхүйц бага гарсан бөгөөд энэ нь хүйсийн ялгаатай байдлаас хамааралтай байх магадлалтай юм. Мөн хамгийн залуу авиалагч trg003-ын F2 нь дөрвөн авиалагчийн дотроос хамгийн өндөр буюу 2660Hz орчим гарсан нь залуу үеийнхний дуудлагад [e] авиа улам урдуур хэлэгдэх хандлагатай байж болохуйц байна. Гэвч энэ таамаглалыг батлахын тулд илүү олон авиалагчийг хамруулсан цаашдын судалгаа шаардлагатай.

Харин тус судалгааны хязгаарлалтын хувьд хэд хэдэн зүйлийг тэмдэглэх нь зүйтэй. Авиалагчдын тоо дөрвөн хүн байгаа нь статистик дүгнэлт хийхэд тийм ч хангалттай биш бөгөөд авиалагчдын тоог нэмэгдүүлэх нь зүйтэй. Бичлэгийн нөхцөл нь лабораторийн стандартаас ялгаатай буюу төслийн явцад буюу Ховд аймгийн Булган сумд байх хугацаанд бичлэгийг хийсэн тул энэ нь зарим хэмжилтэд нөлөөлсөн байж болзошгүй. Тиймээс цаашдын судалгааны ажлыг илүү өргөжүүлэн торгууд аман аялгууны гийгүүлэгч авиаг туршилт авиа зүйн аргаар задлан шинжилж эгшгийн тогтолцооны тухай гарсан дүгнэлтийг гийгүүлэгчийн тогтолцоотой нь хослуулан авч үзэх нь зүйтэй байх. Мөн авиалагчдын тоог нэмэгдүүлж нас болон хүйсийн хуваарилалтыг жигд болгосноор үр дүнгийн хувьд илүү чанаржих боломжтой. Х. Лувсанбалдан, Ю. Цэндээ зэрэг судлаачдын тодорхойлолтоос энэхүү судалгааны үр дүн харьцангуй зөрүүтэй байгаа нь цаг үеэс шалтгаалсан нийгэм, орчны нөлөө, техник технологийн хурдацтай хөгжил, хотжилт зэрэг маш олон талын хүчин зүйлээс шалтгаалсан байх болзошгүй юм.

AN EXPERIMENTAL PHONETIC ANALYSIS OF VOWEL [e] IN THE TORGHUT DIALECT

Within the framework of the “TORGHUT-2024” project, four speakers from the torghut ethnic community residing in Bulgan sum of Khovd aimag were selected as informants. A corpus of 250 words prepared for the study was recorded in WAV audio format. From this corpus, the vowel [e], [eː] occurring in word-initial syllables was analyzed using Praat, a software widely employed in experimental phonetic research, and the mean values of acoustic parameters were determined. The results indicate that the vowel [e] has a mean first formant of $\bar{X}$F1=389Hz and a mean second formant of $\bar{X}$F2=2423Hz. Based on these findings, the vowel [e] in the torghut dialect is characterized as non-rounded, front, and near-close. Meanwhile, the vowel [eː] yielded $\bar{X}$F1 = 492 Hz and $\bar{X}$F2 = 2316 Hz, and was accordingly defined as an unrounded, front, mid vowel.

Keywords: *phonetic transcription, formant, hertz, vowel space diagram, comparison*

НОМ ЗҮЙ

Батдорж, Ц., (2014). *Монгол хэлний халх аялгууны авианы дуун ухааны задлалт.* Докторын зэрэг горилсон бүтээл. ӨМИС. Хөх хот

Батзаяа, Г., Уртнасан, Д., (2023). *Монгол хэлний нутгийн аялгууны авиа зүйн харьцуулсан судалгаа*. УБ.

Булгантамир, С., (2014). *Эгшиг авиаг туршилт авиа зүйн аргаар судлах нь*, Acta Mongolica 15 (411), УБ.

Лувсанбалдан, Б., (2015). *Сурвалж бичиг нутгийн аялгуу судлал*. УБ., Шинжлэх Ухааны Академи Хэл Зохиолын Хүрээлэн

Цэндээ, Ю., (2020). Орчин цагийн монгол хэлний нутгийн аялгуу. УБ., Хаан үсэг ХК

Цэлмүүн, С., (2025), *Торгууд аман аялгууны [a, a:, æ, æ:] эгшиг авиаг туршилт авиа зүйн аргаар судлах нь,* Эрдмийн хэлхээ, боть XIV, УБ., Арвайбархан ХХК.

ЭХ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

Зоригт нар., (2018). "*Монгол хэлний нутгийн аялгууны газрын зургийн байцаалтын материалын цуврал, Ерөнхий өгүүлийн боть"*, Өвөр Монгол

МУБИС-ийн Монгол судлалын хүрээлэнгийн "ТОРГУУД-2024" хөмрөг

Товчилсон үгийн жагсаалт:

ОХУ - Оросын Холбооны Улс

БНХАУ - Бүгд Найрамдах Хятад Ард Улс

ШУА - Шинжлэх Ухааны Академи

МУБИС - Монгол Улсын Боловсролын Их Сургууль

НХУС - Нийгэм, Хүмүүнлэгийн Ухааны Сургууль

МСХ – Монгол Судлалын Хүрээлэн

WAV - Waveform Audio File Format (Дууны файлын формат)

IPA - International Phonetic Alphabet (Олон улсын авиа зүйн галиг)

2026 Fasc.7

ТОД ҮСЭГТ УРТ ЭГШГИЙГ ТЭМДЭГЛЭСЭН “УДААН” ТЭМДГИЙН ХЭЛ ШИНЖЛЭЛИЙН ТАЙЛБАР

Сугарын ЧУЛУУНЦЭЦЭГ

МУБИС-ийн НХУС-ийн Монгол хэл, уран зохиолын багшийн IV курсийн оюутан

Удирдагч багш: Г. Цэцэгдарь доктор (Ph.D), дэд профессор

Монгол Улсын Боловсролын Их Сургууль (МУБИС)-ийн Монгол хэлний тэнхим (1-301 тоот)-д хадгалагдан буй тод үсгийн Xutuqtu sudariyin ayimagiyin erketü xa’an keme’eqdekü yeke kölgön sudar[1] (Хутагт судрын аймгийн эрхэт хаан хэмээгдэх их хөлгөн судар) буюу Алтангэрэл судрын судалгааны ажлынхаа анхан шатны боловсруулалтын жишээнд үндэслэн тод үсгийн “удаан” тэмдгийн хэл шинжлэлийн тайлбарыг танилцуулж байна.

Хураангуй: ***“Удаан” тэмдгийн тухай***

Тод үсгийг Зая бандида Намхайжамц 1648 онд зохиосон бөгөөд тод үсэг зохиох болсон шалтгааныг нэг талаас, улс төрийн бодлого, нөгөө талаас, шарын шашныг дэлгэрүүлэх зорилготой холбон авч үздэг. Мөн түүнчлэн уйгуржин монгол бичгийн “тодорхой бус” байдлыг “тодорхой” болгох гэсэн хэл шинжлэлийн, авиа зүйн, үсэг зүйн зорилгыг ч орхигдуулалгүй дурддаг.

Тод үсэгт урт эгшгийг нэгд, эгшиг үсгийг давхарлан бичиж, хоёрт, “удаан” тэмдгээр тэмдэглэсэн байдаг. Үүнийг тод бичиг-ийн цаг үед ярианы хэлэнд урт эгшиг хэдийнээ бий болсон байсны баримт хэмээн эрдэмтэд үздэг. XVII зууны үед зохиогдсон хэвтээ дөрвөлжин, соёмбо бичгүүдэд ч урт эгшгийг тэмдэглэхдээ тухайн үсгийн бичлэгийн нуруунд доод талд хойшоо зураас татдаг байна.

***Түлхүүр үг**: Тод үсэг, урт эгшиг, удаан тэмдэг, өргөлтөт эгшиг*

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Бид энэхүү өгүүллээрээ тод үсгийн “Алтангэрэл” сударт “удаан” тэмдгийг хэрхэн хэрэглэсэн, тус тэмдгийн талаарх эрдэмтдийн санал юу болох, бидний

[1] Ганболд, Д., *"Бичиг соёлын төв"-д буй монгол, төвөд судрын гарчиг, бичвэрийн тодорхойлолт,* УБ., 2012, х.4.

дэвшүүлж буй санал өмнөх саналуудтай хэрхэн нийлж буйг хэл шинжлэлийн үүднээс тайлбарлахыг зорилоо.

1. Тод үсгийн “Алтангэрэл” сударын
2. “Удаан” тэмдгийн талаарх эрдэмтдийн санал
3. Тод үсгийн “Алтангэрэл” сударын дахь “удаан” тэмдгээр урт эгшгийг тэмдэглэсэн жишээ
4. Тод үсгийн “Алтангэрэл” сударт урт эгшгийг “удаан” тэмдэггүйгээр тэмдэглэсэн жишээ
5. Тус сударт “удаан” тэмдгийг хэрэглэсэн жишээнд үндэслэсэн хэл шинжлэлийн тайлбар

ҮНДСЭН ХЭСЭГ

1. Тод үсгийн “Алтангэрэл” сударын:

Тус судрыг МУБИС-ийн Монгол хэлний тэнхимийн багш, доктор Д.Ганболдын үйлдсэн тодорхойлолтын дагуу танилцуулбал:

Судрын нэр: *Xutuqtu sudariyin ayimagiyin erketü xa’an keme’eqdekü yeke kölgön sudar*

Хутагт судрын аймгийн эрхэт хаан хэмээгдэх их хөлгөн сударын, гүн

Шифр: МоБ.040

Бичгийн хэлбэр: гар бичмэл, хар улаан шунх

Хэл: монгол, тод бичиг

Судрын хэмжээ: 52х15.5 см

Бичвэрийн хэмжээ: 50х12 см

Хуудасны тоо: бүрэн, 93

Тус судрын бичвэрийг улаан хүрээний дотор бичсэн, хуудсын дугаарыг бичвэр бүхий хүрээний гадна хуудсыг голлуулан бичмэлээр бичсэн, нэг хуудас нь ар өвөр хоёр талдаа бичвэртэй (бид а, б гэж ялган тэмдэглэв), нэг хуудас дахь мөрийн тоо 26-34.

Тус сударын нь төвөд үгсийн өмнө төвөд үсгээр давхар хадсан[2], хар, улаан шунхаар ялган бичсэн[3] ***Алтангэрэл*** сударын болно.

Энэ далимд дурдахад, тод бичгийн *Хутагт дээд Алтан гэрэл судрын аймгийн эрхэт хаан хэмээх их хөлгөн сударын*-уудын модон барын дурсгалууд олон

2 Энэ удаа төвөд үсгийг мэдэхгүйн харгайгаар тухайн үгсийг галигласангүй, зориуд орхисон ба судалгааны ажлын дараагийн шатанд хийхээр төлөвлөж байна. Харин дөрвөлжин хаалт [ ]-аар төвөд үг байгааг тодорхой зааж мэдүүлэхээр шийдвэрлэв.

3 Улаан шунхаар бичсэн үгсийг бид энэ удаагийн хэвлэлд өнгөөр ялгасангүй, харин налуу (italic) үсгээр ялган бичив.

байдгийг др. Б. Түвшинтөгсийн саяхны шинэ бүтээлээс мэдэж болно.[4]

Энэ удаа нийт 93 хуудас, 184 тал бүхий Алтангэрэл судрын бичвэрийн эрдэм шинжилгээний галиг үсгийн болон кирилл үсгийн хөрвүүлгээс урт эгшгийг тэмдэглэсэн "удаан" тэмдэгтэй жишээнүүдийг түүвэрлэж, хэл шинжлэлийн тайлбар хийхийг хичээв.

2. "Удаан" тэмдгийн талаарх эрдэмтдийн санал:

Энэхүү "удаан" тэмдгийг тод үсэгт урт эгшиг авиаг тодорхой ялган тэмдэглэсэн тэмдэг гэж үзсээр иржээ.

Х. Лувсанбалдан, Ц. Шагдарсүрэн, Б. Ренчин нарын судлаачид "удаан" тэмдэг нь урт эгшгийг богино эгшгээс ялгах тэмдэг гэж санал нэгддэг бол Г. Жамьян тод үсгийн "удаан" нэртэй ' ├' тэмдэг бол эгшгийн уртыг заах үүрэгтэй бус, харин '*ā*', '*ē*' гэсэн хоёр дуудлагат биеэ даасан үсэг хэмээх саналыг дэвшүүлсэн. Мөн Ш. Лувсанвандан, Г. Д. Санжеев нар энэхүү саналтай нэгдсэн байр суурьтай байв. Тодруулан авч үзвэл:

Ш. Лувсанвандан	"Удаан" гэдэг нэртэй " ├" тэмдгийг урт *ā* буюу *ē* мөн болохоос биш тухайн эгшгийн уртыг тэмдэглэсэн тэмдэг бус гэж нотолсон. Жишээ нь: мо. *sayad*, то. *saād*, мо. *deger-e*, то. *deēre*[5]
Г. Жамьян	Тод бичгийн 'удаан' нэртэй ' ├' тэмдэг бол эгшгийн уртыг заах үүрэгтэй бус харин '*ā*', '*ē*' гэсэн хоёр дуудлагат биеэ даасан үсэг, өөрөөр хэлбэл, эр эгшиг үгэнд богино эгшгийн дараа урт *ā*, эм эгшиг үгэнд богино эгшгийн дараа орсон урт *ē* үсэг, бас тод үсгийн *ou, öü, uu, üü* нийлбэр нь хос хосоороо урт *ū* буюу *ǖ* тэмдэглэсэн биш зөвхөн сүүлчийн үсэг нь дангаараа эр эгшигт үгэнд урт *ū*, эм эгшигт үгэнд бол урт *ǖ* эгшгийг тэмдэглэх үсэг болно гэсэн саналыг тод бичгийн дурсгал, ойрад аялгууны баримтад тулгуурлан дэвшүүлжээ. Жишээ нь: qaγan > qaān, '*хаан*', deger-e > deēre, '*дээр*', ögede > öēdö '*өөдөө*', sirege > širеē, '*ширээ*', aγula > oūla '*уул*', öülen > öūlen '*үүл*'[6]
Г. Д. Санжеев	Г. Жамьянгийн тайлбарыг үндэсгүй зүйл гэж болохгүй. Энэ тайлбар нь тод үсгийн үсэг зүй, монгол хэл аялгууны түүхэн авиа зүйн тал алинаас нь үзсэн ч зөв болно. Гэхдээ "тод бичгийн энэ тэмдэг урт '*ā*', '*ē*' биш, харин өргөлттэй '*á*', '*é*' байх. Жишээлбэл: *ulaān* биш *ulaán* байх гэж бодож байна.[7]

[4] Түвшинтөгс, Б., *Тод бичгийн модон барын дурсгалын судалгаа,* УБ., 2024, х.256.

[5] Лувсанбалдан. Х. *Тод үсэг, түүний дурсгалууд,* УБ., 2015. х.40-41.

[6] Жамьян. Г. *Тод үсгийн зөв бичих дүрэмд урт эгшгийг хэрхэн тэмдэглэсэн тухай асуудалд.* Studia Mongolica, Tom. Facs. 20. х.257-270.

[7] Жамьян. Г., *Обозначение долгих гласных в ойратском ясном письме.* Народы Азий и Африки, №.5 х.150-152.

Х. Лувсанбалдан	Академич Ш. Лувсанвандан тод үсгийн урт эгшгийг тэмдэглэх ‘ ├’ зураасыг урт *а*, *е* гэж үзсэн нь сонин боловч бодит баримтаас зөрж байна. Хэрэв ‘ ├’ зураасыг урт *а, е* гэж үзэхэд хүрвэл мо. *boγoqu*, то. *bōxui*; мо. *qoγula*, то. *xōl*; мо. *boγul*, то. *bōl*; мо. *čögörüm*, то. *čō̄röm* гэх мэт үгнээ байгаа уртын зураасыг юугаар тайлбарлах вэ? Үүнээс гадна тод үсгийн “Саран хөхөө”-ний сударт imi [iēmi болно гэж үү], timi [tiēmi болно гэж үү) ийм байгааг юугаар тайлбарлах вэ? Эдгээр үгийн хоёрдугаар үед *а* буюу *е* байхгүй байгаа нь сонирхолтой байна. Үүгээр үзвэл ‘ ├’ зураас нь *а, е*-г тэмдэглэсэн бус, мөн л тухайн эгшгийн уртыг тэмдэглэсэн байна.[8]
Ц. Шагдарсүрэн	Тод бичигт “удаан” тэмдгийг дэвсгэр үсэгт тооцсон тухайд самгард, төвөд, дөрвөлжин, соёмбо бичиг дэх эгшгийн дараа орсон *а* буюу *е* үсэг зүйн баттай баримт байхгүйн дээр тод бичгийн тухай уламжлалт зохиол бүтээлд эгшгийн уртын тэмдгийг дэвсгэр гийгүүлэгчид багтааж ирсэн нь үүний нугалаа болж өгнө.[9]
Зая бандида Намхайжамц	“Тарни унших арга хураасан хэмээхү” хэл зүйн бүтээлд ‘ ├’ зураасыг “urtu kubitu” гэж нэрийдсэн. Зохиогч “урт хувьт” үсгээ монгол үгэнд эгшгийн урт, богиныг ялгахад хэрэглэсэн байна. Жишээ нь: (То. sana – sanā, ser – serē, kökö - kökō̄)[10]
Рокаш Аттила (Унгар)	Зая бандида урт эгшгийг тэмдэглэхдээ 3 аргыг хэрэглэж байв. Үүнд: 1. Тусгай тэмдэг буюу удаан тэмдэг хэрэглэх 2. Эгшиг давхарлан бичих 3. Нэг эгшгээр тэмдэглэх [11] Энэхүү өгүүллээрээ Зая бандида Намхайжамц тод бичигт урт эгшгийг хэрхэн тэмдэглэж байсан асуудлыг авч үзсэн.

Эрдэмтдийн дээрх саналыг нэгтгэвэл:

“Удаан” хэмээх ‘ ├’ тэмдгийг

- Бие даасан урт *ā, ē* эгшиг үсэг
- Эгшгийн уртыг илтгэх тусгай тэмдэг
- Өргөлттэй эгшиг хэмээн өөр өөрөөр үзсэн бөгөөд нэгдсэн байр суурь байхгүй байна.

[8] Лувсанбалдан. Х., *Тод үсэг, түүний дурсгалууд,* УБ., 2015. х.40-41.

[9] Шагдарсүрэн. Ц., *Монголчуудын үсэг бичгийн товчоон.* УБ., 2001. х.123-124.

[10] Лувсанбалдан. Х., *Тод үсэг, түүний дурсгалууд,* УБ., 2015. х.40-41.

[11] *Олон улсын монголч эрдэмтний XIII их хурлын илтгэлийн хураангуй.* УБ., 2026. х.247-248.

3. Тод үсгийн “Алтангэрэл” сударын дахь “удаан” тэмдгээр урт эгшгийг тэмдэглэсэн жишээ:

Эгшиг үсэг + “удаан” тэмдэг-ээр орчин цагийн монгол хэлний урт эгшигтэй үгсийг тэмдэглэсэн байдлыг харвал 2 янз байна. Үүнд:


1) VCV байран дахь *γ/g* гийгүүлэгчийн хоёр талын эгшгүүд нь ижилхэн хэлний эгшгүүд байгаад, тэдгээр эгшгүүдийн хооронд ухран ижилшил явагдаж, үеийн тоо хураагдсан үгст, Тухайлбал:

qa-γān > qa-’ān > qān ‘*хаан*’

de-gē-dü > de-’ē-dü > dēd ‘*дээд*’

tü-ge-gē-mel > tü-ge-’ē-mel > tü-gē-mel ‘*түгээмэл*’

si-re-gē > si-re-’ē > si-rē ‘*ширээ*’



2) VCV байран дахь *γ/g* гийгүүлэгчийн хоёр талын эгшгүүд ижил бус байгаад, тэдгээр эгшгүүдийн хооронд дэвшин ба ухран ижилшил дараалан явагдсан үгст, Тухайлбал:


to-γā-sun > to-’ā-sun > to-’ō-sun > tōs ‘*тоос*’

qo-γā-sun > qo-’ā-sun > qo-’ō-sun > xō-sŏŋ ‘*хоосон*’

Энэ дашрамд тэмдэглэхэд, дэвшин ижилшлийн үр дүнд хоёрдугаар үеийн хэлний урт *ā* эгшиг нь уруулын урт *ō* эгшиг болсныг уйгуржин монгол бичигт “*гэдэс*” үсгийн зурлагаар тэмдэглэсэн байна. Хэрвээ тухайн “*гэдэс*”-ийг уруулын

и эгшиг гэж үзвэл, авианы хувьслын үр дүнд тухайн үг нь “*тоос*”, “*хоосон*” бус, харин “*туус*”, “*хуусан*” болох байлаа. Үүнээс дүгнэвэл, ярианы хэлэнд гарсан авианы хувьслын өөрчлөлтийг үсэг бичигт тэмдэглэжээ гэж дүгнэх бүрэн боломж байна.

Онцлон тэмдэглэх нэг зүйл нь, дэвшин ижилшлийн үр дүнд дээрх үгсийн нэг ба хоёрдугаар үеийн эгшгүүд ижилхэн уруулын эгшгүүд (o-’ō) болж, улмаар ухран ижилшиж, үе хураагдсан тохиолдолд “удаан” тэмдгийг хэрэглэсэн бололтой гэсэн саналыг дэвшүүлж байна.




4. Тод үсгийн “Алтангэрэл” сударт урт эгшгийг “удаан” тэмдэггүйгээр тэмдэглэсэн жишээ:

Орчин цагийн монгол хэлний олонх урт эгшгийг түүхэн үүднээс үүсмэл урт эгшгээс үүссэн буюу VCV байран дахь өмнөө богино эгшигтэй, шүргэх *γ/g* гийгүүлэгчийн арын утга ялгах өргөлтөт эгшиг (= á, é, ú, ǘ, í)-ээс гаралтай үүсмэл урт эгшгээс үүссэн гэдэг.

Энэхүү үүсмэл урт эгшгийг уйгуржин монгол бичигт VCV гэсэн авианы байраар нь төвөггүй тодорхой таньж чадна. Жишээлбэл: qaγan ‘*хаан*’, degedü ‘*дээд*’, tügegemel ‘*түгээмэл*’, sirege ‘*ширээ*’, toγusun ‘*тоос*’, qoγusun ‘*хоосон*’ гм.

Харин тод үсэгт энэхүү урт эгшгийг тэмдэглэсэн байдал нь харилцан ялгаатай байгааг өмнөх хэсгээс болон энэ хэсгээс тодорхой харж болно. Өөрөөр хэлбэл, тод үсгийн “Алтангэрэл” судрын жишээнээс харвал, нэг хэсэг урт эгшгийг “удаан” тэмдэгтэйгээр, нэг хэсэг урт эгшгийг дараалсан эгшиг үсгүүдтэйгээр тэмдэглэсэн байгааг харж болно. Жишээлбэл,


ǰe-gǖ-dü > ǰe-’ǖ-dü > ǰö-’ǖ-dü > ǰü-’ǖ-dü > ǰǖd/dzǖdě ‘*зүүд*’
či-γūl-γan > či-’ūl-γan > ču-’ūl-γan > čūl-γan/ʧūl-γăŋ ‘*чуулган*’
ü-ǰe-gǖl- > ü-ǰe-’ǖl- > ü-ǰö-’ǖl- > ü-ǰü-’ǖl- > ü-ǰǖl-/ü-dzǖl- ‘*үзүүл-*’
da-γūs- > da-’ūs- > do-’ūs- > du-’ūs- > dūs- ‘*дуус-*’



Онцлон тэмдэглэх өөр нэг зүйл нь, дараалсан хоёр ухран ижилшлийн үр дүнд дээрх үгсийн нэг ба хоёрдугаар үеийн эгшгүүд o-’ū/ö-’ǖ, u-’ū/ü-’ǖ болсон тэр хувьслыг, нэг ба хоёрдугаар үе хараахан хураагдаагүй байх тэр үеийн хувьслыг “удаан” тэмдгийг хэрэглэлгүйгээр, харин дараалсан хоёр үсгийн зурлагаар тэмдэглэсэн бололтой ажиглагдана.

Мөн VCV бүтэц бүхий авианы байрлалд, үгийн дундах γ/g шүргэх гийгүүлэгчийн арын эгшиг нь тагнайн *ī* байсан тохиолдолд, Vуī хэмээн тэмдэглэсэн жишээ байна. Жишээ нь:

negīte > neyīte ‘*нийт*’



Энд нэг зүйлийг тэмдэглэхэд, VCV буюу Vγ/gV байрлал дахь хоёр эгшгийн хоорондох, богино эгшгийн дараах, үүсмэл урт эгшгийн өмнөх шүргэх *γ/g* гийгүүлэгч арынхаа урт эгшгийн нөлөөгөөр сулран сугарах явц дахь *у* гийгүүлэгчийн сулралын үе шат харьцангуй удаан хугацаанд тогтвортой байсныг илтгэнэ.

ДҮГНЭЛТ

Энэхүү судалгааны өгүүллээрээ тод үсгийн “Алтангэрэл” судрын жишээн дээр үндэслэн урт эгшгийг тэмдэглэдэг гэж үздэг “удаан” тэмдгийг хэл шинжлэлийн үүднээс тайлбарлахыг зорилоо.

Орчин цагийн монгол хэлний олонх урт эгшиг нь монгол бичгийн VCV буюу Vγ/gV бүтэцтэй тохирдог бөгөөд тус бүтэц дэх урт эгшгийг XVII зууны тод бичигт хэрхэн тэмдэглэсэн байдлыг “Алтангэрэл” судрын жишээгээр тайлбарлах зорилготой юм.

Тус сударт урт эгшгийг 2 янзаар буюу “удаан” тэмдэгтэй, тэмдэггүйгээр тэмдэглэсэн байна. Үүнд:

1) Үгийн нэг ба хоёрдугаар үеийн эгшгүүд ижилхэн a’ā/e’ē гэсэн хэлний эгшгүүд байх тохиолдолд ухран ижилшил явагдаж, үе хураагдсан нөхцөлд “удаан” тэмдэгтэй;

2) Үгийн нэг ба хоёрдугаар үеийн эгшгүүд ижил биш, a’ū/e’ū̃ гэсэн хэлний ба уруулын идэвхтэй өөр өөр эгшгүүд байх тохиолдолд ухран ижилшлийн үр дүнд o’ū/ö’ū̃ болсон нөхцөлд “удаан” тэмдэггүй;

3) Үгийн нэг ба хоёрдугаар үеийн эгшгүүд нь ижил биш, хэлний ба тагнайн эгшиг байх тохиолдолд, түүнчлэн урт эгшгийн өмнөөс *γ/g* гийгүүлэгч нь сулраад, тагнай *у* болсон авианы хувьслын үе шатны ауī/еуī байрлалд “удаан” тэмдэггүй;

НОМ ЗҮЙ

Эх хэрэглэгдэхүүн

Xutuq tu suduriyin ayimagiyin erketü xān kemēkü yeke kölgöni sudur.

Судалгааны бүтээл

Ганболд, Д., (2012), *"Бичиг соёлын төв"-д буй Монгол, Төвөд гарчиг, бичвэрийн тодорхойлолт.* УБ.

Дарханчимэг, Ч., (2010), *Алтангэрэл судар, түүний зарим ойлголт.* УБ.

Лувсанвандан, Х., (2015), *Тод үсэг түүний дурсгалууд*. УБ.

Сүман., (2025), *Алтангэрэл судрын шашин, гүн ухааны шинжилгээ.* УБ.

Түвшинтөгс, Б., (2024), *Тод бичгийн модон барын дурсгалын судалгаа*. УБ.

Шагдарсүрэн, Ц., Даваасүрэн, Б., нар*, (2022), Үсэг зүй "Монгол хэл судлал" VII боть.* УБ.*,* МУИС хэвлэх үйлдвэр.

Эрдэм шинжилгээний өгүүлэл

Чулуунцэцэг, С., (2024), *Хутагт судрын аймгийн эрхэт хаан хэмээх их хөлгөн судар*. Эрдмийн хэлхээ. УБ., Адмон принтинг.

Чулуунцэцэг, С., (2025), *Хутагт судрын аймгийн эрхэт хаан хэмээх их хөлгөн судар*. Эрдмийн хэлхээ. УБ., Адмон принтинг.

THE LINGUISTIC EXPLANATION OF ‘UDĀN’ SPECIAL MARK FOR INDICATING VOWEL LENGTH IN THE TODO ÜSÜG

The Clear Script (Todo bichig) was created by Zaya Pandita Namkhaijamts in 1648. In the Clear Script, long vowels are indicated in two ways: first, by writing the vowel twice (doubling), and second, by marking it with the "long" (udaan) sign. This indicates that long vowels had already developed in the spoken language by the time the Clear Script was devised. Drawing on examples from the Clear Script "Altangerel" sutra, the study examines which structures of the derived long vowel of the VCV type (egshig-giiguulegch-egshig, "vowel-consonant-vowel") take the udaan mark, and, conversely, clarifies in which cases the vowel is written without it.

Keywords: *Todo Script, Long Vowel, Udaan Mark*

УТГА ЗОХИОЛ

2026 Fasc.8

Ж. ОЛДРИЖИЙН “ГАЙХАМШИГТ МОНГОЛ МОРЬ” ТУУЖ ДАХЬ МОРИНЫ ДҮР

Эрхэмзаяагийн БУДСҮРЭН
МУБИС-ийн Багш монгол хэл, уран зохиолын боловсрол хөтөлбөрийн IV курсийн оюутан

Удирдагч: П. Яньдий
МУБИС-ийн Утга зохиолын тэнхимийн багш, доктор *(Ph.D)*

Хураангуй: *Уг өгүүлэлд Ж. Олдрижийн “Гайхамшигт монгол морь” тууж дахь монгол морины шинж чанарыг судлан морины дүрийг задлан шинжиллээ. Ингэхдээ морины дүрийн гадаад, дотоод шинжийг хэрхэн дүрсэлсэн онцлогийг тодруулж, монгол хүн, морь хоорондын холбоо хамаарлыг хэрхэн дүрсэлсэн болон монгол ахуй, соёл уламжлалтай хэрхэн холбогдож буйг тодорхойлов.*

Түлхүүр үг: *тахь, морины дүр, дүрслэл, тууж*

УДИРТГАЛ

Английн зохиолч Жеймс Олдрижийн “Гайхамшигт монгол морь” тууж нь монголд хоёр өөр хувилбараар орчуулагдсан. Эхний хувилбар нь 1980 онд Л.Хуушааны орчуулсан хувилбар бол дараах нь орчуулагч Д.Гонгорын 2014 онд орчуулсан хувилбар юм. Тус хувилбар нь “Гайхамшигт монгол адуу” нэрээр хэвлэгдсэн.

Иймээс энэхүү зохиол нь төрлийн хувьд орчуулгын уран зохиолын төрөлд хамаарна. Монголчууд өөрийн гэх өвөрмөц үгийн урлагийн төрөл жанруудыг бүтээхийн зэрэгцээ мөн хөрш зэргэлдээ улс орны төдийгүй алс холын ард түмнүүдтэй соёлын өргөн харилцаа тогтоож, тэдгээр орны уран зохиолоос үндэснийхээ хэл рүү орчуулах замаар үндэсний уран зохиолын санг баяжуулж ирсэн байна. Гадаадаас эх хэлнээ орчуулсан бүтээлийг орчуулгын уран зохиол гэнэ[1] хэмээн тодорхойлсон байдаг.

Мөн “Орчуулга гэж эх хэл дээр өгүүлсэн буюу бичсэнийг өөр хэлний

[1] Галбаатар, Д., *Уран зохиол: онол, түүх, шүүмжлэл,* УБ., 2012, х.269.

хэрэглүүрээр илэрхийлэхийг хэлдэг. Улс үндэстэн бүрийн хэлний тогтолцоо өөр өөр байдаг болохоор нэг хэлнээс нөгөө хэлнээ орчуулах нь ердийн механик үйлдэл бус хүний оюуны онцгой нарийн төвөгтэй, ээдрээтэй, бүтээлч үйл ажиллагаа юм”[2] хэмээн доктор Ц. Сүхбаатар нэг сэдэвт бүтээлдээ тодорхойлсон байдаг.

Бид энэхүү судалгааны ажлын хүрээнд зохиолч, орчуулагч Л. Хуушааны орчуулсан хувилбар болох “Гайхамшигт монгол морь” туужийг эх хэрэглэгдэхүүн болгон ашигласан болно.

Тус тууж нь монгол морины хүч чадал, тэсвэр хатуужил, эрэмгий зориг, үнэнч байдал болон нүүдэлчин ахуй амьдралыг уран сайхны аргаар дүрслэн харуулжээ. Мөн байгаль, хүн, амьтны шүтэлцээг тодруулан үзүүлж, монгол ахуй соёлын онцлогийг илэрхийлсэн байдаг. Туужийн сэдэв нь монгол морины гайхамшигт гайхамшигт чанар, түүний хүн ба байгальтай холбогдох гүн утга учрыг харуулсан явдал юм.

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Энэхүү туужийн эхлэл хэсэгт монголын говиос нэгэн тахийг английн дархан цаазтай газар луу аваачиж байгаа тухай гардаг. Английн эрдэмтэн өөрийн гэрт буй давжаа морьтойгоо хань болгож, Англид нутагшуулах гэж үздэг ч энэ бүх үйл ажил нь талаар болдог. Учир нь Монголоос Англид очсон тахь өөрт тохиолдсон бүхий л саад тотгорыг үл тоон зөвхөн өөрийн нутаг буюу умардыг зорих аяллаа эхлүүлдэг. Энэхүү аяллаа ганцаараа хийгээгүй бөгөөд давжаа морь Пийптэй ижилдэн дасаж, хамтдаа бэрхшээлийг даван туулдаг. Тэдний хамтдаа Франц, Итали, Унгар, ЗХУ-ын нутгийг дамжин гүйж явахад нь тохиолдсон сонирхолтой адал явдал нь зохиолын үйл явдлын гол зангилаа хэсэг юм.

Харин төгсгөл хэсэгт тэд монголд очих чадах болов уу? гэсэн сонирхолтой асуулт уншигчдад төрнө. Мэдээж тэд бүхий л саад бэрхшээлийг даван туулж монголын газар нутагт эсэн мэнд хүрнэ. Харин Пийп энэ урт аяллын хугацаанд хээл авч ирдэг. Монголд ирээд унагалсан бөгөөд маш урт хугацааны аялал, сорилтуудын дүнд тэрээр маш их ядарсныг дүрсэлжээ. Улмаар унагаа эсэн мэнд төрүүлж чадсан ч өөрөө амь эрсэддэг. Ингэж монгол тахь эх нутгаа зорин ирснээр тууж төгсдөг. Ингээд бид морины дүрслэлийг дараах байдлаар авч үзлээ. Үүнд:

---

[2] Сүхбаатар, Ц., *Орчин үеийн монгол орчуулгын уран зохиолын шүүмжлэлийн туршлага, сургамж,* УБ., 2003, х.2.

Нэгд. Морины гадаад, дотоод шинж, зан чанарыг харуулсан дүр, дүрслэл

Хүснэгт 1. Морины гадаад, дотоод шинжийн дүрслэл

Шинж чанар	Гадаад төрх байдал	Гаднах дүр төрх, харагдах байдлын талаарх дүрслэл	• Тахь төдий л өндөр биш, гэтэл тийм нүх малтаж гаргасан гэхэд үнэмшихийн аргагүй байлаа... • ...нөгөө нь морины төстэй боловч үл танигдах маш аймшигтай амьтан байсан. • “хачин адуу” гэдэг нь үс ноолуур нь гуужсан монголын зэрлэг адуу. • тахийн хурц нүд, соргог чих, үнэрч хамар... • нэг хачин зүс буруу намхан морь... • муухай зүстэй, намхавтар биетэй үрээ айхавтар доголж байсан... • Ер бусын сэгсгэр намхан бор... • ...намхавтар үзэшгүй муухай амьтан (тэр ингэж дүрслэв) • Сармагчин шиг жижигхэн адуу. • ...хачин сэгсгэр үстэй зэрлэг амьтан мэт харагджээ. • Тахийн үс ноолуур нь намрын байдлаар сэгсийж ургаснаас гадна дэл сүүл нь газар шүргэм унжжээ. • ...сахлаг зузаан үс ноос нь түүнийг аварсан бололтой. • ...бие бялдар жижигтэй луус ч, эсвэл зэрлэг илжиг байна.
	Дотоод шинж чанар	Сүргээ хамгаалж байгаа дүрслэл	• Бидний ойртож очихыг тахь ямагт тааварлан мэдэж, адуунуудаа хазах, түлхэх зэргээр холдож зайлахыг шаарддаг байлаа. • Тахь адуугаа атгын чинээ болтол нь хурааж, мал харагч нохой шиг ууртайгаар тойрон хатирна. • Зэрлэг монгол морь өөрийнхөө хань ижлийг (Давжаа ба хээр халтар хоёрыг) хамгаалан үхлээс айхгүй тулалдсан бололтой.
		Нутгаа гэх сэтгэлийг харуулсан дүрслэл	• Гэхдээ тэдний өссөн төрсөн өлгий нутаг нь энэ шүү дээ. Ер нь адуу бол өссөн төрсөн нутагтаа амьдрах дуртай. Манай монгол адуу ч тийм. Тэд өлгий нутгаасаа холдохыг хүсэхгүй. Тийм ч учраас энэ уулнаас холдож чадахгүй байгаа юм. Тэд нутгаа санахаар барахгүй, үхэж ч болно биз дээ. • Тэр морь гэр өөдөө ирж явна. Өөрийнхөө төрөлх ууланд буцаж ирэхээр эрс шийдвэрлэжээ. • Тахь хүзүүндээ өргөст төмөр торны тасархайтай хашааны шонгийн хоёр том баганыг чирэн явж байжээ. Гэрийн зүг явахад тохиолдсон ямар ч саад бэрхшээлийг үл тоон зөвхөн умардыг зорьж явсан.
		Зан чанарыг харуулсан дүрслэл	• Тахь зугтахын оронд гэнэт эргэж бидний зүг толгойгоо тухайлган хурдалж ирэв. Бусдыгаа зугтаалгахын тулд өөрөө бидэн рүү дайрсан нь энэ байжээ. Энэхүү эрэлхэг зоригоосоо болж тэр баларсан юм даа. • Энд би ингэж дэлгэрэнгүй бичдэгийн учир бол ямар зоригтой, гайхамшигтай морь танай нугад нутагших болсон ба чиний Пийп хэмээх Давжаа ямар аюултай, зэрлэг найзтай болсныг чи ойлгох нь хэрэгтэй гэж бодсон юм. • Тахь бол мах цуснаасаа зэрлэг. Хээзээ ч тэр өөр газар идээшиж чадахгүй.

Шинж чанар		Зан чанарыг харуулсан дүрслэл	• Зэрлэг адуу уснаас маш их айдаг. • Тахь, яг чиний дүрслэн бичсэнээр, толгойгоо ууртай нь аргагүй сэгсрэв. Бодоход өвөө бид хоёрын үнэрийг салхиар авсан бололтой. • Миний бодоход хашаа эвдэхийг оролдсон байх. Эвдэж л байж санаа нь амарна! • Одоо харин өвөө тахийн ааш араншин, түүний нугаршгүй зөрүүд занг дутуу үнэлсэндээ өөрийгөө зэмлэнэ. • Тахь бол их зөрүүд, эрс шийдэмгий морь. • Тахь чиний бяцхан байдсыг хэрхэвч хаяж орхихгүй. Адуу мал нэг ижилсэхээрээ бие биедээ туйлын үнэнч байдаг юм. Чиний Давжаад халдсан бүхэнтэй Тахь хайр найргүй тулалдах болно. • Хэргийн гол эзэн Тахь байлаа. Юу ч түүний аялах замыг саатуулж чадсангүй.

Дүрслэлийн тоог диаграммаар харуулбал:



График 1. Тууж дахь морины дүрслэл

Тууж дахь морины дүрслэлээс харахад зан чанарыг илтгэсэн дүрслэлүүд дийлэнх хувийг эзэлж байна. Харин гадаад шинж, дүр төрх, харагдах байдлыг илэрхийлсэн дүрслэл нь дараа нь орж байна.

Ж. Олдриж зохиолч нь монголд ирж байгаагүй, монгол тахийг нэг ч удаа харж байгаагүй. Хэдийгээр тийм боловч манай орны болоод тахийн тухай олон ном уншиж судалгааг маш сайн хийсэн[3] хэмээн өөрөө дурдсан байдаг. Үүний үндсэнд монгол морины шинж чанарыг үнэн бодитойгоор дүрсэлж чадсан байна.

Монгол морины хамгийн гол шинж болох аливаа зүйлд тэсвэр тэвчээртэй, ухаантай, зоригтой, шийдэмгий, үнэнч, сүргээ хамгаалдаг гэх зэргийг илүү

[3] Хуушаан, Л., *Гайхамшигт монгол морь*, УБ., 1980, х.9.

товойлгон дүрсэлсэн байна. Ер нь аливаа дүрийн хэр хэмжээ, хүч чадал өмнөө тавьсан тодорхой зорилго, түүнийгээ хэрхэн хэрэгжүүлэн биелүүлж буйгаар хэмжигдэнэ.[4] Зохиолын хамгийн чухал зүйл болох эх нутгаа гэсэн сэтгэл, төрсөн нутагтайгаа хүйн холбоотой байдлыг харуулахдаа зохиолын туршид зөвхөн англиас умардыг буюу монголыг зорьж буйгаар, ямар ч саад бэрхшээл тулгарсан даван гарч чадаж байгаагаар, алс хол очсон ч нутгаа мэдрэх зөн совинтой байгаагаар дүрслэн харуулсан байна.

Харин гадаад төрхийг дүрсэлсэн дүрслэлээс харахад гадаад орны хүмүүс зэрлэг морийг хараад ямар сэтгэгдэлтэй байдаг, яаж дүрсэлдэг, ямар шинжийг хамгийн түрүүнд хардаг вэ? гэхчлэн гаднын соёлт хүмүүсийн сэтгэлгээний онцлогийг харуулсан байна. Үүнээс үзэхэд их төлөв бие жижиг, зэрлэг, зөрүүд гэх шинжийг нь гаргахдаа үл танигдах аймшигтай амьтан, хачин адуу, ер бусын сэгсгэр, муухай зүстэй, үзэшгүй муухай, сармагчин шиг жижиг, сахлаг зузаан үс ноостой гэх мэт сөрөг үнэлэмжээр бичжээ. Гаднын соёлт хүмүүсийн зэрлэг адууг харах үнэлэмж нь анхны сэтгэгдлээр ийм байдгийг мэдлээ. Гэвч зохиолч гадна төрх нь зорилгыг тодорхойлоход төдийлөн чухал ач холбогдолгүй бөгөөд гадаад төрхөөс илүүтэйгээр зорилгоо хэрхэн биелүүлэх вэ? Ямар зан чанаруудтай байх вэ? гэдэг дотоод шинж чанарт голчлон анхаарчээ.

Хоёрт. Морь ба монгол хүний нөхөрлөл, харилцаа холбоог дүрсэлсэн нь

Морины нуруун дээрээс өндийн босч, балар эртний нийгмээс боловсон нийгэм зүгээ алхан орсон монголчуудад авч хэлбэл, түүний түүх бол хүн морьтойгоо хамтаар үүдсэн түүх юм. Морь монгол хүний түүхэнд үзүүлсэн үйлдэл нь зөвхөн хүн болон амьтны хоорондох харилцаа биш, харин хэн алинаасаа салж болшгүйгээр нэгдсэн нэг зүйлийн онцгой соёлын үзэгдэл болой. Иймээс монгол хүн болон морины хоорондох холбоо нь зөвхөн энгийн аж амьдралын хэрэгцээнээс шалтгаалагдсан төдий биш. Харин үзэл сэтгэлгээний гүнд үүрд тогтворжин хоногшсон оюуны амьдралынх нь чухал агуулга болж бүрэлджээ.[5]

Монголчууд эрт дээр цагаас хүлэг морио эрэгтэй хүний сайн нөхөр, үнэнч туслагч хэмээн ихэд дээдлэн шүтсээр ирсэн.[6] Энэхүү туужид монгол хүний морио мэддэг, занг нь андахгүй таньдаг, ойлгодог байдлыг харуулан дүрсэлсэн. Жишээ нь: Үйл хөдлөлөөс нь юу хийх гэж байгааг нь шууд мэддэг байдлыг "... сүүлээ шарваж, толгойгоо ууртайгаар хаялан, ямар нэг юм хайж байгаа юм шиг",

4 Лувсанвандан, С., *Орчин үеийн монголын үргэлжилсэн үгийн зохиолын сайн талын баатрын дүрийн асуудалд*, УБ., 1962, х.41.

5 Бүрэнбэх, Б., *Монгол баатарлаг туульсын шүлэг зүй,* ӨМӨЗО., 1998, х.17.

6 Одонтуяа, Л., *Зүйр цэцэн үгээр үнэлэмж илрэх нь*, УБ., 2005, х.87.

“Миний бодоход хашаа эвдэхийг оролдсон байх. Эвдэж л байж санаа нь амарна!”, “Тахь, яг чиний дүрслэн бичсэнээр, толгойгоо ууртай нь аргагүй сэгсрэв. Бодоход өвөө бид хоёрын үнэрийг салхиар авсан бололтой”, “Тэр морь гэр өөдөө ирж явна. Өөрийнхөө төрөлх ууланд буцаж ирэхээр эрс шийдвэрлэжээ” гэх мэтээр хийж буй үйлдлээс дараа нь ямар үйлдэл хийхийг шууд мэддэгийг ийн дүрсэлжээ. Тахийг барихаар явахад олон хүн явах шаардлагатай, мөн өдрөөр бэлчдэггүй шөнөөр идшилдэг учраас шөнийн цагаар нутгийн олон адуучин залуус болон профессорууд тойрон гарч болох бүх зай завсраар бүчин зогсдог. Тэд тахийг хөөгөөд шууд барьж чадахгүй гэдгээ мэдэх бөгөөд олон хүн цуглуулж явах газаргүй болгоод нойрсуулагч сумтай буугаар буудахаар шийдэж буй нь хамгийн зөв сонголт болдог. Хэрэв шууд хөөж барих гэсэн бол тахь ямар нэг зам гаргаад тэр нутгаас бүрмөсөн зугтах байсан. Мориныхоо занг мэддэггүй, анзаардаггүй монгол адуучин эр хүн гэж байхгүй биз ээ. Тийм ч учраас залуус өөрсдийн зорилгоо биелүүлж нэг үрээг амжилттай барьж авдаг.

Морины соёлын үзэгдлээр монголчуудын бүхий л аж амьдрал ба соёл сэтгэхүйд гүнзгий нэвчиж, баларлаг үеийн шүтээн байснаас баатарлаг үеийн хүслэн болж эцэстээ монголчуудын зориг санааны илрэл болж билээ.[7]

Уг туужид тахийг англиас зугтаад хаашаа явж байгааг нь зөвхөн монгол хүн л мэдсэн бөгөөд англи профессор тааварлаж чаддаггүй. Үүнээс мөн монгол, англи хүний онцлог, монгол хүний морь малтайгаа ойр байж, ойлголцож мэдэрдэг гэдгийг харж болно.

Тус тууж нь захидал хэлбэрээр бичигдсэнээрээ онцлог бөгөөд монгол, англи хүүхдийн сэтгэлгээний ялгаа, морины талаарх үзэл бодол, хоёр улсын соёл иргэншлийн ялгааг харуулж байна. Монгол хүүхэд тахийг хамгийн анх олж мэдсэн ч “Хүмүүс ирээд үргээчих вий, үргээд бүр хол газар луу яваад өгвөл яана аа” хэмээн бодсон. Тийм ч учраас ганцаараа өдөр бүр ирж үйлдэл бүрийг нь харж судалдаг байсан. Монгол хүүхэд багаасаа морь малтайгаа ойр өсдөг бөгөөд уламжлалт ахуй нь хүн болох цагаас нь эхэлж малд нүдтэй, ажигч гярхай, тэвчээртэй, хөдөлмөрч, байгаль орчноо таньж мэддэг, улирал цаг агаарын өөрчлөлтийг ажигладаг, амьдрах ухаан, бие даах арга барилыг сурсан, уламжлал, өв соёлоо багаасаа өвлөн тээж, бахархаж явдаг тийм л эрхэм чадваруудыг сургаж өгдөг. Тус зохиолд говийн хүү Билигтийн талаар дараах байдлаар бичсэн байдаг.

- Бидэрт хүрнээ унаж, биеэ даан тал хөндий, довцог толгодыг дамжин адуу маллах болсон.

[7] Баяр, Н., *Монгол аман зохиолын зарим төрөл жанр ба морины дүрийн соёл судлал,* УБ., 2005, х.100.

- Нэг удаа би алдсан хоёр морио эрж, адуу бэлчдэг байсан говийн ердийн уулнаас хэтэрч, амьд амьтан баймааргүй асга хадтай гүн хавцлын дэргэд очив.
- Би өөрийнхөө адууг бол юу андах вэ? Энэ хоёр адуу, тэр унага ямар ч байсан манайх биш гэдгийг тэр дороо мэдлээ.
- Манай гэрийн адуу малын хувьд гэвэл бид жилийн дөрвөн улиралд адуун сүрэгтэйгээ хамт бэлчээрийн аль сортой сайхныг дагаж нүүдэллэнэ. Бэлчээр бол олон зуун километр үргэлжилсэн их газрыг эзэлдэг юм. Морь бол бидэнд зөвхөн унаж зугаалах буюу америкийн ковбой маягаар эдлэхэд гол нь биш. Морь бол бидний амьдралын салшгүй чухал хэсэг нь мөн. Иймээс ч би тэр зэрлэг адуунд ямар нэг муу юм учрах вий гэхээс болгоомжлоод байсан хэрэг.
- “Тэр толгойгоо хаялан, сүүлээ шарван зогсож байгаа нь яг мөн байлаа. Сүрэгт байгаа залуу морьдын дотроос хамгийн зоригтой, хамгийн ааштай болох нь харваас андашгүй байлаа. Дааанч нас нь гүйцээгүй учир сүргийн эзэн болж хараахан чадаагүй бололтой” гэх мэтээр малд нүдтэй, ажигч гярхай байдлаар дүрсэлсэн байна.

Харин англи охины тахийг анх хараад төрсөн сэтгэгдлийг дүрсэлсэн дүрслэлээс үзэхэд монгол хүүхдээс өөр соёл иргэншилтэй болох нь шууд мэдэгддэг. Өөр өөр соёлын онцлогийг тусгасан байдаг. Жишээлбэл: Бүхээгийн ар тал нээгдэж, тахийн бие ямх ямхаар цухуйж ирэхэд, урьд өмнө үзэж хараагүй, хачин муухай зэрлэг амьтан харагдах шиг болов. Би өөрийн эрхгүй ярвайж: “Энэ чинь л ёстой хүн аймаар амьтан байна” гэв. Тийм боргил булиа, бяр чадалтай, сахлаг үстэй, толботой ч юм шиг, үс нь зарим газраа зулгарч унасан сонин адуу үзнэ гэж би огт бодсонгүй. Дэл нь хүртэл ер бусын, яг л шүдний сойзны үс шиг санагдав.

Үүнээс үзэхэд зэрлэг адууг урьд өмнө нь харж байгаагүй, байгальтайгаа ойр өсөөгүй, суурин, хотын соёлд өссөн тул зэрлэг адууг харсан сэтгэгдэл нь монгол хүүхдийнхээс өөр байна. Энэ нь хоёр орны соёлын онцлогийг харуулж байна.

ДҮГНЭЛТ

Энэхүү өгүүлэлд Жеймс Олдрижийн “Гайхамшигт монгол морь” тууж дахь морины дүрийг задлан шинжилж, монгол морины онцлог шинж, уран сайхны илэрхийллийг тодруулахыг зорилоо. Судалгааны явцад уг туужид морь нь зөвхөн үйл явдлын нэгэн элемент бус, зохиолын утга санаа, үндэсний соёлын онцлогийг илэрхийлсэн бэлгэдэлт дүр болох нь ажиглагдлаа.

Зохиолч морины дүрийг дүрслэхдээ түүний тэсвэр хатуужил, хурд хүч, ухаалаг зан чанарыг онцлон харуулсан нь монгол морины бодит шинж чанартай уялдаж байна. Ийнхүү морины дүр нь зохиолын үйл явдал, монгол, гадаад хүмүүсийн дүрийн онцлогийг тодруулахын зэрэгцээ монгол ахуй, соёлын өвөрмөц байдлыг уран сайхны аргаар илэрхийлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна.

Иймд “Гайхамшигт монгол морь” тууж дахь морины дүр нь амьтны энгийн дүрслэлээс давж, монголчуудын соёл, уламжлал, байгальтайгаа харилцах гүн холбоог илтгэсэн уран сайхны болон бэлгэдлийн ач холбогдол бүхий дүр болох нь энэхүү судалгаагаар тогтоогдлоо.

THE ROLE OF THE HORSE IN J.ALDRIDGE’S “THE MARVELLOUS MONGOLIAN”

This article examines the characteristics of the mongolian horse in J. Aldridge’s “The Marvellous Mongolian” and analyzes the role of the horse. In doing so, it clarifies the external and internal characteristics of the horse, the depiction of the relationship between the Mongolian people and horses, and its relation to Mongolian culture and traditions.

Keywords: wild horse, role of the horse, representation, narrative

НОМ ЗҮЙ

Эх хэрэглэгдэхүүн

Олдриж, Ж., (1980). Л. Хуушаан (орч), *Гайхамшигт монгол морь,* УБ., Улсын хэвлэлийн газар.

Судалгааны бүтээл

Баяр, Н., (2005). *Монгол аман зохиолын зарим төрөл жанр ба морины дүрийн соёл судлал,* УБ.

Бүрэнбэх, Б., (1998). *Монгол баатарлаг туульсын шүлэг зүй,* ӨМӨЗО., Өвөр монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо.

Галбаатар, Д., (2012). *Уран зохиол: онол, түүх, шүүмжлэл,* УБ.

Одонтуяа, Л., (2005). *Зүйр цэцэн үгээр үнэлэмж илрэх нь,* УБ., Бит пресс.

Лувсанвандан, С., (1962). *Орчин үеийн үргэлжилсэн үгийн зохиолын сайн талын баатрын дүрийн асуудалд,* УБ., Улсын хэвлэлийн газар.

Сүхбаатар, Ц., (2003) *Орчин үеийн монгол орчуулгын уран зохиолын шүүмжлэлийн туршлага, сургамж,* УБ.

ХАВСРАЛТ

МОРИНЫ ДҮРИЙН УЛАМЖЛАЛ

Монголчууд эрт дээр цагаас хүлэг морио эрэгтэй хүний сайн нөхөр, үнэнч туслагч хэмээн ихэд дээдлэн шүтсээр ирсэн. Монгол морь судлал, ялангуяа морины уг гарал, удам угшил, зүс зүсэм, явдал гүйдлийн талааар монголчуудын оюуны гайхамшигт бүтээл ардын аман зохиолын томоохон төрөл болох ардын дуу, зүйр цэцэн үг, оньсогод гол байр суурь болдог нь хүлэг морь бөгөөд тэдгээрийн гол дүрслэл нь монголчуудын адууны гадаад дотоод шинжийг гойд тодотгосон байдаг. Иймд морины дүрийн уламжлалыг төрөл тус бүрээр судлан үзэх шаардлагатай.

1. Оньсогод туссан морины дүр

- Босуул бурхан
  Бодьсадын хувилгаан
- Дээд тивийн
  Дэрс сайхан
  Дэнжин нуурын
  Шагшуурга сайхан
- Мягдар мягдар гишгэдэлтэй
  Мянган цагаан дагуултай
  Түгдэр түгдэр явдалтай
  Түмэн цагаан дагуултай
- Хүйтэнд хөрөхгүй
  Халуунд халахгүй
  Чийрэг бөх баатар

2. Зүйр цэцэн үгэнд туссан морины дүр

Л. Одонтуяа “Зүйр цэцэн үгээр үнэлэмж илрэх нь” номдоо зүйр цэцэн үгээр илрэх үнэлэмжийг зургаа хуваан авч үзсэний нэг нь *хүлэг морио дээдлэх үнэлэмж* юм. Уг номд “Монголчууд хүлэг морио магтан дээдэлсэн зүйр цэцэн үг нэлээд хувийг эзэлж байна” гээд хэд хэдэн зүйр цэцэн үгээр жишээ авсан байна. Тухайлбал:

- Сайн хүн ажил голдоггүй
  Сайн морь зам голдоггүй
  Сайн морь енавал нисэх шувуу шиг
  Муу морь унавал мөлхөх мэлхий шиг
  Сайн морь эцэхгүй
  Сайн эр гутахгүй

- Цацаг яндар гоёлтой
  Хажиг ужиг зантай
  Хүнээс илүү хүзүүтэй
  Хүзүү сээрээ тавиастай (азарга)
- Сайн эр
  Саадаггүй (адуу)
- Жир жир гүйдэлтэй
  Жингэр жингэр дуутай
  Жаран хүн дагуултай (морины явдал, янцгаах, сүүл)

3. Ардын дуунд туссан морины дүр

Морин эрдэнээ онголон дээдэлдэг монголчуудын оюуны болоод эдийн бүтээлийн нэг гол сэдэв нь морь билээ. Хурдан хүлэг морь нь хайр дурлал, эх оронч сэтгэл, баатарлаг үйлсийн салшгүй бүрэлдэхүүн болж байдаг учраас монголчууд морины тухай хамгийн олон дуу зохиосон ард түмэн юм. (Жамбалдорж, 1996)

Морины тухай ардын дуунаас харахад гол төлөв морины зүсмээр нь нэрлэж тодотгосон байна. Жишээлбэл:

- Шар хээр морь
- Улаан бор морь
- Жаахан шарга
- Нарийн хөх морь
- Ороо сайхан хээр
- Улаан бор морь
- Хашлага зандан хар
- Цомбон цуутай хүрэн гэх мэт.

4. Ерөөл, магтаалд туссан морины дүр

Морины уралдаан бол монголчуудын эртний уламжлалт тэмцээн наадмын нэг билээ. Тийм ч учраас манай ард түмэн хүлэг сайн морьдоо ерөөн магтах нь нэн элбэг. Жишээлбэл:

- “Хурдан морины ерөөл”-д
  Заан дөрвөн соёогоо яралзуулан
  Заамал зургаан хүзүүгээ гүвдэлзүүлээд
  Дунгийн угалзан хамраа сортолзуулаад...
  ...Мянган агтын түрүүнд
  Мятралгүй гүйгээд ирдэг
  Түмэн агтын түрүүнд
  Түгдрэлгүй гүйгээд ирдэг... хэмээн бүх шинжийг нь тодотгон уран

яруугаар ерөөсөн байдаг бол;

- “Хурдан морины цол”-нд

...Жиргэн нисэх шувуу шиг
Жирэлзэн үзэгдэх
Зэргэлээ шиг жирэлздэг
Хөвчин Монголын
Хүлгийн дээж
Хүн олныхоо
Сэтгэлийг татагч
Бат төрийн чимэг
Их төрийн магнай
Тодхон сайхан
Торгон жолоо
Баярын магнай
Бат идэр

Хурдан хүлэг ээ! (Х. Нямбуу, 1983) гэж мөн л бүх сайхан шинжийг нь дурдан наадамд бүхнийг цэнгүүлэн жаргаалаа хэмээгээд цааш үргэлжлүүлэн “Түрүү морины цол”, “Дэд морины цол”, “Айргийн тавд ирсэн морины цол” гэгчлэн цоллодог байна.

5. Туульд туссан морины дүр

Монгол ардын баатарлаг тууль нь монголчуудын нийгмийн аж төрөл, түүхт үнэн байдлыг олон талаас нь эрт дээр үеэс нь тусгасан нийгмийн гүнзгий өргөн агуулгатай байдгийн хувьд монгол хүний бахархал болсон аргамаг хүлэг морьдыг гайхалтай магтан дуулсан байдаг. Жишээлбэл:

- “Ойрад Жангарт”

Есөн эрдэнийн шинж бүрдсэн
Эвэртэй халтар морь хэмээсэн бол;

- “Хаан Чингэл баатар” туульд

Баруун наран шингэх зүгийг
Эзлэн төрсөн
Далан эвэртэй
Догшин хар морьтой хэмээн баатрын тодотгосон;

- “Жангар” туульд

Долоон түмэн цусан зээрд
Дайсны хөлд дасагсан
Далай их харвинтай
Наран зулын хурдан зээрд хэмээн дүрсэлсэн байдаг. (Б. Катуу, 2013)

2026 Fasc.9

“ХААН СИЙР” БААТАРЛАГ ТУУЛИЙН ХУВИЛБАРУУДЫН СОЁЛЫН ХАМ СЭДВИЙГ ХАРЬЦУУЛАН ШИНЖЛЭХ НЬ

Нямдаваагийн БЯМБАЖАРГАЛ

МУИС-ийн Багш, монгол хэл, уран зохиолын боловсрол хөтөлбөрийн III курсийн оюутан

Удирдагч: И. Даваадорж

МУИС-ийн Утга зохиол, урлаг судлалын тэнхимийн багш, докторант

Хураангуй: *Бид энэхүү өгүүлэлд Жангар туулийн үндсэн бүлэг хэмээн үздэг “Хаан Сийр” баатарлаг туулийн хувилбаруудын соёлын хам сэдэв, тэр дундаа ураг хуримын зан үйлийг харьцуулан судаллаа. Мөн нийгмийн жижиг бүлгийн хүрээнд уран сайхны хэлбэрээр ямар уламжлалыг дамжуулж буйг Дан Бэн Амосын онолд тулгуурлан авч үзэх юм. Шинжааны Буурал Жангарч, Пүрвэй тайж гэх туульчдаас өвлөн дэлгэрсэн “Хаан Сийр” туулийн хувилбаруудын хам сэдвийг харьцуулан үзэхэд, өндгөн шийд бололцох болон шийд буцах зэрэг торгууд хуримын зан үйлийг дэлгэр дүрслэн өгүүлсэн байна. Тухайн угсаатны бүлэг уран сайхны харилцаандаа эл дүрслэл, соёлын хам сэдвийг тусган хуримын зан үйл, ёсыг уламжилж буйгаараа онцлог юм.*

***Түлхүүр үг**: Хаан Сийр, Хонгор, Жангар, торгууд, өндгөн шийд, хувилбар, хам сэдэв*

УДИРТГАЛ

Бид энэхүү өгүүлэлдээ “Хаан Сийр” баатарлаг туулийн ялгаатай гурван хувилбарыг шинжлэн үзлээ. Үүнд:

Нэгдүгээр хувилбар болох “Хаан Сийрийн бүлэг” -ийг ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн аман зохиол, нутгийн аялгуу судлах шинжилгээний анги 1978 онд Ховд аймгийн Булган сумын иргэн М. Пүрэвжалаас тэмдэглэн авчээ. Улмаар 1982 онд Хэл зохиолын хүрээлэнгийн “Монгол ардын баатарлаг тууль” номд хэвлэн гаргасан байна.

Хоёрдугаар хувилбар буюу “Ханцан болсон бууралтай Хаан Суурь бодонгийн бүлэг”-ийг Т. Жамц 1983 онд Шинжааны Борталын Жин Шианы

Б. Мөнтгөрөөс тэмдэглэн авч, “Жангар”-ын эх материал-VII” (1990)-д тод үсгээр хэвлэсэн байна.

Гуравдугаар хувилбар болох “Хаан Сийр хөвгүүний бүлэг”-ийг судлаач Д.Таяа 1992 онд Шинжааны Ховогсайрын жангарч Аримпилаас тэмдэглэн авч, “Аримпилын “Жангар”-ын арван долоон бүлэг” (2013) хэмээх эмхэтгэлд хэвлэснийг эх хэрэглэгдэхүүн болгож, соёлын хам сэдвийг харьцуулан шинжилж, нэгтгэн дүгнэлээ.

Судлагдсан байдал. Ж. Эрдэнэбаяр “Хаан Сийр” туулийг “Жангар” туулийн үндсэн бүлгүүдийн нэг гэж үзсэн юм. XIX зууны эхэн үеэс “Жангар” туулийг судлах ажил эхэлж, анхлан Германы эрдэмтэн жуулчин Б.Бергманн Ижил мөрний халимагуудаас “Жангар”-ын нэг бүлэг, жангарчийн тухай домгийн хамт тэмдэглэж авчээ. Ийн 1804 онд өмнөтгөл үг бичин, Рига хотод хэвлүүлснээр уг туулийг судлах ажил эхэлсэн гэж үздэг. Энэ хугацаанд “Жангар”-ын хувилбарыг тэмдэглэн хэвлүүлэх ажил өргөн далайцтай өрнөж, олон орны эрдэмтэн “Жангар”-ын туулийг хэл, түүх, соёл, угсаатны зүй, утга зохиол, аман зохиол зэрэг олон талаас нь судлах болсноор Жангар судлал нь дэлхийн хэмжээний монгол судлалын салбар болон хөгжжээ[1].

“Хаан Сийр” туулийн М. Пүрэвжал болон Б. Мөнтгөр нарын хайлсан хувилбарын үйл явдлыг Т. Баясгалан харьцуулан шинжилж, уг тууль нь Шинжааны ойрадуудын дунд үүсэж, “Жангар”-ын туульд үр хүүхдийн бүлэг боловсрон, салбарлаж хөгжих үед үүссэн[2] гэж дүгнэсэн юм.

Мөн Ш. Буурал, Пүрэв нараас тус бүлгийг сурч, уламжлан дамжуулсан М. Пүрэвжал, Б. Мөнтгөр, П. Рампил, Т. Ням нарын жангарчдын хайлсан хувилбаруудад үйл явдлын талаар ямар өөрчлөлт гарсныг тодруулсан байна. Улмаар эдгээр нь Ховогсайрын жангарч Шишнээн Бууралын дэг сургууль, Борталын Жин шианы жангарч Пүрэв тайжийн дэг сургууль гэсэн хоёр төрөлд хуваагдаж байна гэж үзжээ. Энэ бүлэгт Хаан Сийр хөвгүүний гэрлэлтийг үзүүлсэн боловч, Хонгор баатрын алдар гавьяаны тухай бүлэг гэж болно. Тодруулбал, энэ бүлэг Хонгорын дүр Бумбын орныг төвхнүүлэгч, аврагч, хамгаалагч хэв шинжтэй болсон цаг үед буюу XVII-XVIII зуунд шинээр үүссэн[3] гэж үзжээ.

Ж. Эрдэнэбаяр “Хаан Сийрийн бүлэг” нь Шинжааны Ховогсайр, Жингийн торгууд болон Монгол Улсын торгууд угсаатны бүлэгт тархсан хэмээжээ. Мөн тэр бээр тус туулийн гурван хувилбарыг Жангарын үндсэн бүлгийн нэг гэж

---

1 Баясгалан, Т., *“Жангар” туулийн хувилбаруудын харьцуулсан судалгаа*, УБ., 2019, х.7.
2 Баясгалан, Т., *“Жангар” туулийн хэв шинжийн харьцуулсан судалгаа*, УБ., 2010, х.74.
3 Баясгалан, Т., *“Жангар” туулийн Хаан Сийр бодонгийн бүлгийн хоёр зүйлийн уламжлал,* Аман зохиол судлал-46, (36-43), УБ., 2025, х.34.

үзээд, гарал үүсэл болон хэв шинжийн хувьд онцгой бүлгүүд байгаа бололтой[4] хэмээн дүгнэсэн юм.

Ж. Цолоо, У. Загдсүрэн, Г. Кара нар М. Пүрэвжалын хайлсан "Хаан Сийр" туулийг англи хэлээр хөрвүүлэн, тууль дахь нутгийн аялгууны үгсийг тайлбарласан байна[5].

Тус туулийн дүр, хам сэдэв зэргийг харьцуулан судалсан зүйл харьцангуй цөөн тул бид энэхүү өгүүлэлдээ "Хаан Сийр" баатарлаг туулийн гурван хувилбарын соёлын хам сэдэв, тэр дундаа ураг хуримын хам сэдвийг харьцуулан судлахыг зорьсон болно.

Судалгааны онолын үндэслэл. Утга зохиолын хам сэдэв гэдэг бол дүрийг тодорхойлж буй тухайн цаг үеийн нийгэм-соёлын нөлөө, үйл явдал, үзэл бодол зэрэг хамгийн их мэдээлэлтэй хэсэг юм[6]. Тиймээс тухайн зохиолын ерөнхий утга санааг бүтээхээс гадна холбогдох утга санааг нэмэн бүтээж буй хам сэдвийг шинжлэн судлах юм.

Нөгөө талаас бид "Хаан Сийр" баатарлаг туулийг Дан Бэн Амос (Dan Ben Amos)-ын ардын билиг, аман уламжлалыг шинжлэн үзэх онолын хараажаас харж, тухайн нөхцөл байдал болон бичвэрт буусан аль ч хувилбартаа жижиг бүлгийн уран сайхны харилцааг илэрхийлж байна хэмээн үзлээ. Дан Бэн Амос (Dan Ben Amos) "Toward a Definition of Folklore in Context (Аман зохиолыг хам сэдвийн хүрээнд тайлбарлах нь, 1971)" өгүүлэлдээ аман зохиолыг бие даасан бичвэр хэлбэрээр авч үзэх уламжлалт хандлагыг шүүмжилж, тодорхой нийгэм-соёлын орчинд явагдах харилцааны үйл явц гэж тодорхойлсон байна. Тэр бээр аман зохиолыг "жижиг бүлгийн хүрээнд явагдах уран сайхны харилцаа" хэмээн тодорхойлж, тухайн бүтээлийн утга нь зөвхөн хэлбэр, агуулгаар хязгаарлагдахгүй, уламжлагч нь хэнд, ямар нөхцөлд, ямар зорилгоор дамжуулж байгаагаас шууд хамаардаг[7] болохыг онцолсон байдаг. Иймээс аман зохиолын судалгаанд хүлээн авч ойлгох, утга бүтээхэд чухал үүрэгтэй "контекст" буюу хам сэдвийг бичвэрийн гаднах нэмэлт нөхцөл бус, харин утга бүтээх үндсэн бүрэлдэхүүн хэсэг гэж үзэх шаардлагатай байна.

---

[4] Эрдэнэбаяр, Ж., *"Жангар"-ын тархац, түүний газар зүйн хэв шинжүүд*, УБ., 2010, х.105.

[5] Dzagdsüren, U., Tsolo, J., Kara, G., (1982). *Khan siir. A chapter of the Jangar epic.* Acta Orientalia Academiae Scientiarum Hungaricae, 36(1/3), p.271–314.

[6] Нандинбилиг, Г., *Эх зохиолыг задлан шинжилж, үнэлэх арга зүй,* УБ., 2017, х.17.

[7] Ben-Amos, D., *Toward a definition of folklore in context*, Journal of American Folklore, 84(331), 1971, p.10

ҮНДСЭН ХЭСЭГ

Эл тууль нь Жангараас салбарласан, биеэ даасан бүлэг тууль бөгөөд М.Пүрэвжал, П. Аримпил нарын хувилбарт ураглан хуримлах, дайснаа дарах гэсэн хоёр мөчлөг гарч байгаа тул угсарсан нийлмэл тууль буюу хоёр давалтай тууль болно. Харин Б. Мөнтгөрийн хувилбар нь Хаан Суурь бодон хатнаа буулгах найр хуримын өгүүлэмж бүхий дан мөчлөгт буюу дан давалтай тууль болох юм. В. Хайсигийн (1972) бичсэнээр монгол туульсын шинж төгөлдөр өгүүлэгдэхүүн нь туульсын баатрын харийг зорьж, хатуу хаалганы амыг таньж, заяаны зандан дагинаа олдог үйл явдал болно[8].

Бид ураг хуримын хам сэдвийг задлан шинжлэхийн урьд туулийн өгүүлэгдэхүүн дарааллыг шинжилж үзлээ. Ийн үзэхэд, нийлмэл туулийн анхны давал нь ураг хуримын зан үйлтэй холбогдож байна. Тухайлбал:

Хүснэгт 1. "Хаан Сийр" баатарлаг туулийн өгүүлэгдэхүүнийг харьцуулсан нь

	Өгүүлэг-дэхүүн дараалал	М.Пүрэвжалын хувилбар	П.Аримпилын хувилбар	Б.Мөнтгөрийн хувилбар
Тэргүүн мөчлөг	Эхлэл	Алтан Цээж баатар Хаан Сийр, Улаадай хоёртой таарна.	Хонгор мангасынхнаас алба ааваад харьж явна.	Хаан Суурийн эцэг нь эхнэр, нагац хоёрыг нь хэлээд нас эцэслэнэ. Замдаа Жирмандай Улаантай таарч зөрчилдөөд ялж, дагуулаа хийж явна.
	Зангилаа	Хаан Сийрийг унтаж байхад нь Орно Улаадай түүнийг цавчиж алаад, Мөндөлгуаг авахаар очиход Мөндөлгуа биш байна гэж хэлээд эцэгтээ шийтгүүлж цөлөгдөнө.	Цавчигдсан Сийр бодонтой таарч үен цагаан эм хийчхээд цааш явна.	Хаан Суурь бодон сэрэмж алдан цавчуулаад, Жирмандай улаан Цагаан Билигийг авахаар очиход нь Цагаан Билиг түүнийг эр нөхрөө биш гэж хэлээд эцэгтээ шийтгүүлж тамд унана.
	Өрнөл	Хонгор бөгс, цээж болсон Хаан Сийртэй таарч учрыг нь тунгаахаар цааш явна.	Хөдөө цөлөгдсөн Нарны гэрэл, Ховч цагаан хоёр үрэн (халх. охин)-тэй тараад учрыг нь олж, Нарны Гэрэлийг эдгээгээд Ном төгс хааныд очсон Улаадайг цавчиж ална.	Хонгор хоёр хэсэг болсон Суурь бодонтой таарч үен цагаан эмээр амьдруулж орхиод, хатны нутагт очин Жирмандай Улааныг барьж хүлээд Хаан Суурь дээр хүрч ирнэ.

[8] Дулам, С., Нандинбилиг, Г., *Монгол аман зохиолын онол*, Боть 1, УБ., 2016, х.211.

Тэргүүн мөчлөг	Туйл	Хонгор Мөндөлгуа, Ам цагаан хоёртой уулзаад учрыг олж эдгээж аваад нутагт нь очиж Орно Улаадайг барьж хүлнэ.	Хаан Сийр дээр эргэж ирээд Нарны Гэрэл, Ховч цагаан хоёр дээр дагуулан ирж уулзуулна.	Хаан Суурь, Хонгор хоёр Цагаан билиг, Шинжээч цагаан хоёр үрэн (халх.охин) дээр ирнэ.
	Тайлал	Мөндөлгуа, Хаан Сийр хоёр уулзалдан бие биесээ танин учраа олно.	Нарны Гэрэл, Суурь бодон хоёр биесээ танин харгалдана.	Хаан Суурь, Цагаан Билиг хоёр биесээ мэдэлцэнэ.
	Төгсгөл	Жангарынханд очоод хурим найраа хийнэ.	Найр хийж төгсөнө.	Жангарынханд очиж хурим найраа хийгээд амар сайхандаа жаргана.
	Хаан Сийр эхнэрээ дагуулаад Жангарынхантай золголдохоор ирнэ.			
Дэд	Эхлэл	Жангарынхан талагдаад одсон байна.	Жангарынхан эзгүй байна.	
	Зангилаа	Хонгорыг Жангарынхнаас гарч явах үед дайнд гарсан баатрууд нь эргэж ирээгүй болж таарна.	Хонгорыг эзгүй байхад мангасынхан жангарынхныг шавдан туугаад, хаашаа одсон нь мэдэгдэхгүй алга болсон байв.	
	Өрнөл	Араас нь нэхэж очоод мангасынхныг хядна.	Хаачихаа мэдэхгүй байтал өмнөөс нь хоёр хон хэрээ гарч ирсэнд тэр хоёроос хааш одсоныг нь асууж мэдээд замдаа гарна.	
	Туйл	Жангар Сийрийг танилгүй Хонгороос асуухад гэртээ хариад хэлнэ гэхэд нь “За” гэнэ.	Жангар Сийрийг танилгүй Хонгороос асуутал үгийн хариу өгсөнгүй гэж уурлана.	
	Тайлал	Жангар мангасаа Хонгор, Сийр хоёрт өгнө.	Хаан Сийр Жангар, Алтан Цээж хоёроос мангасыг нь гуйж аваад ална.	
	Төгсгөл	Баатрууд дайснаа дийлж, Сийр Жангарын арван ес дэх баатар болж найрлан сууж төгсөнө.	Бөх мөнгөн Шигшрэг ирж баатруудыг арзаар дайлж, Жангар Хаан Сийр зээгээ таниад Хонгорын дараах баатар болгон найрлаж төгсөнө.	

Судлаач С. Шенквич (1978) монгол баатарлаг туульсын ураг хуримын өгүүлэмжид “амьдрал-үхэл-сэхэл” гэсэн дэс дараалал байгааг илрүүлжээ. Тодруулбал, хүргэн болох баатар заяаны зандан дагинадаа очих үедээ саад бартаатай тулгарч, таван ухаан нь тасардаг билээ. Үүнийг “амьдрал-үхэл” хэмээн тайлж, дахин сэргэн босонгуутаа “урьднаасаа угтай, хэзээнээсээ хэвтэй” болж эрүүлжин залуужаад сүйт бүсгүйдээ очдог байна. Баатар нь дүрээ өөрчилж, хувирч байх үед сүйт бүсгүй нь ч гэсэн бүхнээс таслагдсан, идэвхгүй, ганцаардмал болж байгаа нь завсрын үе нөхцөл буюу “үхэл-сэхэл” болно[9] гэжээ. Бидний судалж буй туульсын ураг хуримын өгүүлэгдэхүүн ч эл зарчмын дагуу өрнөж байна. Тухайлбал, Хаан Сийр баатар урьдаас тогтож хэлэлцэн “зөвтэй болсон” хатнаа авахаар явж байхдаа Улаадай гэх дайсандаа хорлогдон үхэж байгаа нь “амьдрал-үхэл” гэсэн үед хамаарч, түүнийг Хонгор дахин амьдруулж байгаа нь “үхэл-сэхэл” гэсэн хэсэгт хамаарч байна. Мөн Хаан Сийрийг хорлогдсон байх үед түүний хатан нь дайсныг эсэргүүцсэний улмаас эрмэг цагаан хөдөө цөлөгдөх юм уу, тамын ёроолд унаж байгаа нь ч дээрх судлаачийн гаргасан дэс дараатай ижил байдлаар илэрч байна. Үүнээс үзэхэд “Хаан Сийр” баатарлаг туулийн ураг хуримын өгүүлэмж бүхий тэргүүн мөчлөгт хатнаа буулгахын тулд дайснаа дарах өгүүлэмж буй тул давлын дотор дахин давал байна гэж харж болох юм.

Бид туульд буй ураг хуримын зан үйл, үг хэллэг, хувцас зүүсгэл, идээ ундтай холбогдох соёлын хам сэдвийг задлан шинжлэх юм. Ингэснээр торгууд угсаатны бүлгийн доторх нийтлэг болоод ялгаатай соёлыг илрүүлэх боломжтой юм.

Тус туульд торгуудын хуримлах зан үйлийн өмнөх үе, хуримлах үе, дараах үе[10] гэсэн гурван үеийг туульд тодорхой тусгажээ. Туульд хуримын өмнөх үеийн ёс буюу ураг тогтох ёсны тухай ийн өгүүлсэн байна.

Хар бага цагт чинь,
Архийг чинь ууж
Өндгөн шийд болсон[11]

гэх агаад халхаар “өндгөн сүй тавих” ёсыг Ховогсайр болон Жингийн торгуудад “өндгөн шийд болох” хэмээн нэрлэдгийг харуулж байна. Монгол улс дахь торгууд туульч М. Пүрэвжалын хайлсан хувилбарт,

Наран гарах зүгээс явлаа
Наран орох зүгт
Насны минь багад

---

[9] Дулам, С., Нандинбилиг, Г., *Монгол аман зохиолын онол*, Боть 1, УБ., 2016, х.211.
[10] Бадамцэцэг, Н., *Торгууд хуримын зан үйл, аман зохиолын судалгаа,* УБ., 2025, х.26.
[11] *Жангарын эх материал VII.* Дундад улсын ардын аман зохиолын хэвлэлийн хороо., 1990, х.116.

Мөнгөн хааныд шийд болгож хэлсэн билээ[12] гэсэн хэсэгт өндгөн сүй тавих ёсыг "шийд" хэмээн нэрийджээ.

Мөн Торгуудын хуримын "зөв авах" ёс буюу бэр сонгон зөвшөөрөл авах дэг ёсыг тусгасан өгүүлэмж бий юм. Энэ ёсыг торгуудын нутаг бүрд ялгаатай нэрлэж байна. Тухайлбал, энэхүү хэсгийг хайлсан Б. Мөнтгөрийн нутаг болох Бор талын Жин шианд "Үг оруулах ёс" гэж нэрлэдэг[13]. Энэхүү ёсыг гүй-цэлдүүлэхдээ хажуудаа нэг дагуулч, нэг хөхүүрч дагуулж, бэлгийн зүйл өгөхгүйгээр нэг сав архи болон хадагтай очиж, хадмууд "үг эрэх" үйлээ гүйцэтгэдэг. Харин П. Аримпил жангарчийн нутаг болох Ховогсайрт овог төрөл дотроо худ ураг болохоос сайтар сэргийлж, ураг тогтоосны дараа таваг бэлгээ амсуулж, сацал өргөн, архи уулгаж, "зөв өгдөг" байна. Хэрэв хүүхний талынхан эдгээр бэлгэдлийн утгатай ёсны зүйлсийг хүлээн авах юм бол хэрэг явдал үндсэндээ бүтэв гэж үздэг[14]. Энэхүү ёсыг гүйцэлдүүлсний бас нэгэн баталгаа бол Жирмандай Улаан, Хаан Суурь бодон хоёр зөрчилдөхдөө:

Чиний авдаг зөвтэй хүүхэн биш,
Миний авдаг зөвтэй хүүхэн[15]

хэмээн ам мурийхад, анхлан зөв авч, урьднаас ураглахаа тогтсон Хаан Сийр дийлж буйгаас харж болох юм.

Жозеф Райсан (Joseph Rysan) "Аман зохиол бол нийгмийн бүлгийн гишүүдийн гайхах, айх, үзэн ядах, хүндэтгэх, хүсэх зэрэг үндсэн сэтгэл хөдлөлийн бодит илэрхийлэл"[16] гэж тодорхойлсон байна. Туулийн гурван хувилбарт илэрч буй нэгэн хатуу дэг ёс нь өндгөн шийд буцах юм. Ховогсайрын торгуудын дунд эрт үед хоёр хүүхдийг эхийн гэдсэнд байх үед нь ирээдүйн амьдралынх нь талаар хэлэлцэн, тохирох ёс байжээ[17]. Торгуудын хэн боловч "Удам холдвол ухаан нэмэгдэнэ", долоон үе дотор төрөл саднаа таньж, долоон үе өнгөрвөл сая харилцан худ худгуй болж, хурим гийч хийдэг[18]. Эцэг эх нь эдгээрийг чанд баримтлан, ураг удмыг нь судлан тогтож, өндгөн шийд бололцоно.

Ингэж урьдаас тогтож хэлэлцсэн өндгөн шийдээсээ буцах нь торгууд угсаатны бүлгийн дунд байж боломгүй, үл буцах явдал гэдгийг туульд өгүүлэхдээ,

---

[12] *Монгол ардын баатарлаг туульс*, УБ., 1982, х.155.
[13] Бадамцэцэг, Н., *Торгууд хуримын зан үйл, аман зохиолын судалгаа,* УБ., 2025, х.27.
[14] Мөн тэнд, х.30.
[15] *Жангарын эх материал VII.* Дундад улсын ардын аман зохиолын хэвлэлийн хороо., 1990, х.11
[16] Ben-Amos, D., *Toward a definition of folklore in context*, Journal of American Folklore, 84(331), 1971, p.7.
[17] Баасандорж, Ц., Очир, А., *Ойрад монголчуудын хуримын ёс (XIX зууны сүүлч, XX зууны эхэн),* УБ., 2019, х.149.
[18] Бадамцэцэг, Н., *Торгууд хуримын зан үйл, аман зохиолын судалгаа,* УБ., 2025, х.129.

Тангараг тасарвал тамын ёроолд
Сал тасарвал далайн ёроолд[19]

гэж тангараг хэлэлцээ буюу "зөв авсан" хүнээсээ буцвал хэрхэхийг илэрхийлсэн байна. Тэр дундаа бүсгүй хүн өндгөн шийд болсон эрээсээ буцахыг ихэд цээрлэж, буцсан тохиолдолд ихэд хатуу шийтгэдэг болохыг туульд ийн өгүүлжээ.

Хүснэгт 2. Өндгөн шийд буцах өгүүлэмж

М.Пүрэвжалын хувилбарт	П.Арипилын хувилбарт	Б.Мөнтгөрийн хувилбарт
-Аяа аавваа *Намайг авах хүн* *Энэ лав биш.* *Би танихгүй хүнтэй суухгүй!* *-Ха! Толгойгоо мэдсэн охин* *Барман чөтгөр гэдэг энэ* *Нэг гарыг нь хугалаад* *Нэг нүдийг нь сохлоод* *Ам цагаан дагуултай нь* *Нутгийн захад аваачаад цөл!*[20]	*Энэ морийг нь унаад* *Хувцсыг нь өмсөөд* *Улаадай гэдэг хүн ирээд* *Намайг авах болохлаа* *Би одох биш би гэсэнд* *Хоёр нүдийг минь цаазлаад* *Энэ ховч цагаан үрэнтэй* *Хоёулыг минь* *Эрмэн цагаан хөдөө* *Эзгүй цагаан бүүрэгт* *Цөлчихсөн билээ*[21]	*-Энэ ирсэн залуу тангараг авалцсан хань минь биш* *Түүнд мордохгүй би гэж* *Зөв учраа хэлэв гэнэ.* *Зуувжийн цагаан хаан үгийг нь сонсоод* *Уур нь их хүрч* *Биеэ мэдсэн буруу* *Зөндөө одно гэдэг энэ.* *Чи энэ залууд эс морддог болхула* *Алтан болсон биеийг чинь* *Хүрээ Цахар хоёрын хооронд ох* *Хоёр хаалгын бэлчирт авч одоод* *Хоёр нүдийг чинь сохлоод* *Хоёр гарыг чинь хугалаад* *Есөн алд гүн тамд хаяна*[22]

Улаадай гэх дайсан Хаан Сийр баатрыг хорлон, түүний дүрд хувилан хатныг авахаар гэрт нь очиход хатан нисэн очиж, шинжлэн таниад, өөрийн зөвтэй болсон эр нөхрөө биш байна гэдэг учраа эцэгтээ хэлнэ. Гэвч эцэг нь ихэд уурлан, "Толгойгоо мэдсэн охин барман чөтгөр гэдэг энэ" хэмээн ихэд уурлан, гарыг нь хугалж, нүдийг нь сохолж хээр хөдөө эсвэл тамын ёроолд (нүхэнд) цөлөх зэргээр хатуу шийтгэж байна. Энэ нь эмэгтэй хүн биеэ мэдэх нь ёс бус зүйл юм гэдгийг харуулж, хүний мэдрэхүйн эрхтэн болох нүдийг нь сохлох, аливааг хийж бүтээх гарыг нь хугалах түүгээр ч барахгүй есөн алд гүн там ухаж хийх зэргээр биеэ удирдах, өөрийгөө мэдэхийг нь хатуу хориглож байна.

---

[19] *Жангарын эх материал VII.* Дундад улсын ардын аман зохиолын хэвлэлийн хороо., 1990, х.135.
[20] *Монгол ардын баатарлаг туульс*, УБ., 1982, х.160.
[21] Таяа, Д., Аримпилын "*Жангар"-ын арван долоон бүлэг,* УБ., 2023, х.229.
[22] *Жангарын эх материал VII.* Дундад улсын ардын аман зохиолын хэвлэлийн хороо., 1990, х.134.

Энэхүү там (нүх) ухаж, түүний ёроолд цөлж шийтгэх өгүүлэмж нь “Баянжаргал хүү” гэх Ойрад хүний ярьсан үлгэрт давтагдаж байна. Тус үлгэрт хаан муу санаат албатаа шийтгэхдээ “Жаран алд жанадмал там (нүх) малтаж тамлаад, хандгай бугын арьсаар ширлээд...[23] гэсэнтэй нийцэж, хэцүү хатуу шийтгэлийн илэрхийлэл болжээ. Гэсэн ч туулийн хатны дүр нь ам тангараг өгсөн эр нөхөртөө үнэнч, ариун байх явдлыг сахиж,

Өөрөөсөө гарсан үрнээн (халх. охиныхоо)
Үгийг сонсолгүй
Алдаг болхула
Алаад байгтун!
Амьд л байвал
Би түүнд мордохуш би[24]

гэж хэлээд шийтгэл амсаж буй өгүүлэмж гурван хувилбарт давтагдаж байгаа нь эмэгтэй хүний нийгэмд эзлэх байр суурь, үнэнч зан чанарыг илтгэх хатны дүрийн төлөөлөл болжээ.

Туулийн гол баатар болох Хаан Сийрийн туслах дүр буюу Хонгор тархай хожгор хөвгүүн болж хувилан хатны гэрт ороход, Улаадай хэмээх дайсныг хүргэнээ гэж эндүүрсэн хатны эцэг түүгээр хохь/ тууль, тууж хэлүүлнэ гэсэн өгүүлэмж хоёр хувилбарт гарч байна. Энэ нь хурим найрын үед тууль, тууж эсвэл даршлагат үг хэлдэг соёлын тусгал юм. Тухайлбал:

Тархай хожгор хүн хохир болдог юм
Төлөв цоохор морь хурдан болдог юм
Миний шинэ хүргэнд
Мэддэг туужаа хэлж өгтүгэй[25]
Хожгор хүн хохитой байдаг
Хув цоохор морь хурдан байдаг юм
Миний шинэ хүргэнд
Энэ хожгор хүүгийн
Хохий нь хэлүүл![26]

гэснээс харахад хожгор хүнийг хэлэмгий, бэлэн цэцэн үгтэй гэсэн санааг агуулж байна. Харин “Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь”-д “хүний хохийг сонсох” гэвэл мууг нь сонсох, тавлах гэсэн утгатай, мөн “хохир болох” гэдэг нь ёхир муу зантай, хохиур хүнийг хэлнэ гэж тайлбарлажээ[27].

---

[23] *Монгол ардын үлгэр (Монгол ардын аман зохиолын чуулган I)*, УБ., 1982, х.181.
[24] *Жангарын эх материал VII.* Дундад улсын ардын аман зохиолын хэвлэлийн хороо., 1990, х.129.
[25] Мөн тэнд. 1990, х.136.
[26] *Монгол ардын баатарлаг туульс*, УБ., 1982, х.162.
[27] *Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь,* Ерөнхий редактор Л.Болд, А.Лувсандэндэв. УБ., 2008, х.2582.

Мөн Ховогсайр торгуудын ураг тогтох ёсны нэгэн хэсэг болох “зөв авах” ёсыг дараах байдлаар тусгасан байна. Тухайлбал, Хүргэн нь хүүхнээ авахаар очихдоо:

Таван амт төгссөн
Тансаг сайхан идээний дээжээ
Таваг дүүрэн барьж бараалхах[28] гэжээ.

Үүнд хүүхнээ авахаар ирэхэд нь охины талынхан авчирсан идээнээс нь амсаад “зөвтэй болсон хариугаа хэлэх” буюу хурим найр хийхийг охины талынхан зөвшөөрч буйгаа илэрхийлэх өгүүлэмж буй юм. Мөн Хаан Суурь, Цагаан билиг хатан хоёр уулзалдан танилдсаны дараа Хонгор тэднийг Зуувжийн Цагаан хааныд оч гэж хэлэхдээ:

Шар толгойтой иргээрээ
Дээж тавьж
Шар хөхүүртэй архиа
Цацалд оруулж
Хаан аав
Хатан ээжийн зөвшөөрлийг аваад[29]

гэж идээ, архитай очиж байгаа нь Ховогсайрын торгуудын “зөв авах ёс”-ыг харуулжээ. Мөн бусад газарт “Архи зөөх” буюу “Зөвийн архи” гэж нэрлэх нь ч бий. Ховогсайрын торгуудын ёсны онцлог бол хүүхний аав ээж ураг тогтохыг зөвшөөрснөөс хойш ойр дотнын садан төрлийнхнөө зааж өгөөд, хүүгийн талаар «Зөвийн архи» өгүүлдэг. Торгууд хуримын бусад угсаатнаас ялгарах нэгэн чухал ёс нь энэ юм. Нэг архи, чихэр дагалдуулж авч очин, хоёр хүүхдийн ураг тогтсоныг дуулгаж, зөвшөөрлийг нь аваад, дараагийн ураг батлах ёсоо эхлүүлдэг[30]. Ингэж хуримлах зөвшөөрлөө авч, өдрөө хэлэлцэж “зөвтэй” болдог ёсыг туульд харуулжээ.

Зөвтэй болсны дараа хүргэн нь хүүхнээ авахаар ирэхэд сэвгэр болон хүргэн цайлуулах ёс гүйцэтгэж байгааг М. Пүрэвжалын хувилбарт ийн өгүүлжээ:

Чи одоо хадамд очно, охин минь
Чамайг бид цайлуулна[31] гэсэн хэсэг байна.

Энэ ёсонд хүргэн болох хүн нь хүүхнээ авахаар ирж, ачаа хүлээлцэх хооронд хүүхнээ гэртээ оруулж цайлна. Охин нь бурхандаа мөргөж, аав ээж, ах эгч нартаа үнсүүлнэ. Мөн сэвгэр гарах болоход хүргэн болох залууг оруулж

---

[28] *Жангарын эх материал VII.* Дундад улсын ардын аман зохиолын хэвлэлийн хороо., 1990, х.127.
[29] Мөн тэнд х.143.
[30] Бадамцэцэг, Н., *Торгууд хуримын зан үйл, аман зохиолын судалгаа,* УБ., 2025, х.31.
[31] *Монгол ардын баатарлаг туульс*, Эмхэтгэж хэвлэлд бэлтгэсэн Ж.Цолоо, ред. Х.Сампилдэндэв, УБ., 1982, х.160.

ирэн цайлна. Хүргэнд хадам ээж нь бүс бүсэлж, дагуулд нь хадаг хавчуулна. Энэ нь хүргэнээ өөрийн болгож байгаа утгатай юм[32].

Ийнхүү хурим хийх зөвшөөрлөө авч хүүгийн талд очсоны дараа үйлдэх "Ёсны хурим" буюу их найрын үеийн зан үйлийг тусгажээ. Туульд Хаан Сийр дайснаа дарж, Цагаан Билиг хатнаа аваад Жангарынханд ирж "бэр мөргүүлэх ёс" үйлдэнэ. Ингэхдээ, Алтан Цээж Баавааа тэднийг ирж байгааг мэдээд, Авай гэрэл хатан, Жангар хоёрт хэлж бэлдүүлдэг. Үүнийг туульд өгүүлэхдээ:

Зээ бэр тань ирээд
Хаш гарвуут үүдэндээ
Мөргөөд орох болно гээд Алтан цээж Авай Гэрэл хатанд:
Алтан цөгцдөө
Цагаан идээ хийж
Бар шар цоохор хивсээ
Үүдэндээ дэвсээд
Бэлэн болох хэрэгтэй гэв гэнэ[33]

гэсэн нь бэрээ мөргүүлэх ёс хийхдээ идээ бэлдэж, хивс ширдгээ дэвсэн хүндэтгэж угтаж авахыг илэрхийлжээ.

Хаан Суурь бодон Жангарынханд

Таван өнгийн хив торгон дээрээ
Морины толгойн чинээ
Морил цагаан эрдэнэ тавиад барив гэнэ[34]

гэсэн нь монголчуудын ахмад настандаа, өвөг дээдэстээ золгож очихдоо бэлэг барьж ёсолдог ёсыг тусгасан байгаа бөгөөд Жангарынхан зээ хүү, зээ бэр хоёртоо өргөө гэрийг нь барин, хурим найрыг нь хийж өгнө.

Ийн хуримласны дараа Жангар Хаан Суурь хөвүүнээ нутагт нь буцаахдаа дараах ерөөлийн үгийг хэлж, мал хөрөнгөөр мялаан явуулж, тууль төгсөнө.

Буянтай сайн ерөөлөө тавьж
Баатар аавынхаа бууринд бууж
Баян ээжийнхээ сууринд сууж
Нар арслан хааны хөвүүн
Ханцан болсон бууралтай
Хаар Суурь бодон гэдэг
Дуудах нэрээ гаргаж
Дөргөлүүлэх цолоо бадруулж

---

[32] Баасандорж, Ц., Очир, А., *Ойрад монголчуудын хуримын ёс (XIX зууны сүүлч, XX зууны эхэн),* УБ., 2019, х.140.

[33] *Жангарын эх материал VII.* Дундад улсын ардын аман зохиолын хэвлэлийн хороо., 1990, х.146.

[34] *Мөн тэнд,* х.148.

Дайлдах цагт минь
Түшиг болж,
Дэндэх цагт минь
Дүн болж яв гэж
Шинэ бэрээ хөвүүгээ ерөөв гэнэ.
Тэгээд түүнээсээ
Алдар ноён Жангар
Зээ хөвүүн бэрдээ
Азаргаар адуу
Хотоор хонь тасалж өгөөд
Агт морь унуулаад
Атан тэмээ хөтөлгөөд
Ар их нутагт нь явуулж
Амраад жаргаад суув гэнэ[35]

Туульд торгууд хуримын өмнөх үе, хуримлах үе, дараах үеийг дээрх байдлаар тусгажээ.

Үүнийг Дан Бэн Амос (Dan Ben Amos)-ын онолын үүднээс авч үзвэл "Хаан Сийр" баатарлаг туульд өгүүлэгдэж буй ураг тогтох зан үйл буюу өндгөн шийд болох, түүнээс буцвал хэрхэх, хуримын зан үйл, дараалал зэргийг дүрсэлсэн нь зөвхөн өгүүлэмжийн нэг хэсэг төдий бус, харин тухайн нийгмийн бодит соёлын нөхцөлийг илэрхийлж, түүнийг дахин бүтээж буй харилцааны хэлбэр гэж ойлгож болно. Өөрөөр хэлбэл, туульд дүрслэгдэж буй хуримын зан үйл, үг хэллэг, дараалал нь зөвхөн өгүүлэмжийг дэлгэрүүлж буй хэрэг бус, харин тодорхой угсаатны дотоод нийгмийн харилцаа, үнэт зүйлс, ёс заншлыг баталгаажуулан дамжуулах үүрэг гүйцэтгэж байна.

Хувцас хэрэглэлийн хам сэдэвтэй холбогдох өгүүлэмж Хонгор тархай хожгор хөвүүн болон хувирч, Улаадайн хувцсыг тайлуулан шинжлэхийн тулд цамцтай холбоотой домын зүйл хэлж, санаагаа биелүүлж буйгаар илэрч байгаа юм. Тухайлбал, дээр өгүүлсэн тууж, тууль хэлүүлэхийн өмнө хэлсэн үгийг Б.Мөнтгөрийн хувилбарт, харин Улаадай түүнийг тархай хожгор гээд хөөх гэхэд нь хэлсэн үгийг П.Аримпилын хувилбарт бичив.

[35] *Жангарын эх материал VII.* Дундад улсын ардын аман зохиолын хэвлэлийн хороо., 1990, х.149.

Хүснэгт 3. Хийлгээр домнох өгүүлэмж

Б.Мөнтөрийн хувилбарт	П.Аримпилын хувилбарт
Тууль тууж хэлсэн цагтаа *Тархай хожгор толгойгоо* *Хиртэй хийлгээр үрээд хэл* *Эс тэгсэн цагт* *Толгойн чинь аваржигнаад* *Тууль туужаа* *Даршлагыг нь олоод* *Тархи нь дааруул* *Хэлж чадахуш чи гэж* *Аав ээж минь захисан билээ*[36].	*Нэг насаараа* *Эсэр оройг* *Өтөн хорхой иднэ гэдэг* *Хэцүү санж* *Охор сүүлийг бөөсөн хуурс иднэ гэдэг* *Хэцүү санж* *Аав ээж минь хэлдэг билээ.* *Хаан хүний* *Халуун хийлгээр зүлгэхлээ чинь* *Эдгэнэ гэж хэлсэн билээ*[37].

Дээр өгүүлж буй “хаан хүний хийлэг” буюу “кийлэг” гэдэг нь ойрад аялгуунд дотуур өмсдөг нимгэн цамцыг хэлдэг. Туульд хаан буюу дээд язгуурын хүний дотуур нимгэн цамцанд нь тухайн хүний эрчим, энерги шингэдэг гэх язгууртан, хан цагаан ястай хүний шүтлэгийн шинжтэй зүйл ажиглагдаж байгаа юм. Монголчуудын язгуурын шүтлэг бөө мөргөлийн ертөнцийн үзэл дэх “Хөх тэнгэр”-ийн тухай ойлголт нь дээдэс доодсын ялгаа гарснаар (өмчийн ялгаа бий болсноор) тэнгэрийг үзэх үзэлд бас ялгаа гарч Чингис хааны харсан тэнгэрийг “Мөнх тэнгэр” хэмээн нэрлэх болсонтой зэрэгцэж, тайжийг хүндэтгэн дээдлэх, тайж язгууртныг “тэнгэр язгууртан”, “тэнгэрийн хүү”, “тэнгэрийн элч” гэх мэтээр шүтэх үзэл болон хувирч, энэ нь улмаар төрийг дээдлэх түүхэн ач холбогдолтой соёл болон төлөвшсөн билээ.[38] Ийнхүү хаан хүний дотуур өмсөж буй халуун илчтэй цамцаар нь толгойгоо боох, үрэх үйлийг хийснээр тархиа хамгаалах, толгойн арваганаан, бөөс хуурснаас салгана гэсэн домын чанартай зүйл ажиглагдаж байна. Энэхүү зан үйл нь “Жангар”-ын бусад бүлгүүдэд өгүүлэгдээгүй бөгөөд Б. Мөнтөрийн хайлсан хувилбарт буй өгүүлэмжийг харвал, Торгуудуудын дунд тууль хайлахын өмнө хийдэг зан үйл ч байж болох юм.

Мөн Шинжааны хоёр хувилбарт монголчуудын “Болсноос амс, буурлаас сонс” гэх буюу унд цайг эрхэмлэх ёсыг харуулж байна. Дэлгэрүүлэн дурдвал, Шинжээч Цагаан/ Ховч цагаан буюу хатны туслах Хонгор баатрыг хажуугаар өнгөрч явахад нь эгэл биш залуу гэдгийг зөнгөөрөө мэдэрч, түүнийг дуудаж буй хэсэгт гарч байгаа юм.

---

[36] *Жангарын эх материал VII.* Дундад улсын ардын аман зохиолын хэвлэлийн хороо., 1990, х.136.
[37] Таяа, Д., *Аримпилын “Жангар”-ын арван долоон бүлэг,* УБ., 2023, х.231.
[38] Дулам, С., Нандинбилиг, Г., *Монгол аман зохиолын онол*, Боть 1, УБ., 2016, х.84.

Хүснэгт 4. Цай унд эрхэмлэх ёс туульд туссан нь

П.Аримпилын хувилбарт	Б.Мөнтгөрийн хувилбарт
-Өдрийн бор шөлнөөс *Амсаад явагтун!* *Эс амсавч* *Хуруугаа дүрээд* *Явахад! гэж тосоод өгсөнд* *Өдрийн бор шөлнөөс* *Өнгөрдөг аргагүй болохоор* *Очин хөх халзан хүлгийн* *Амыг татаж байгаад* *Асар улаан Хонгор* *Зогсож байгаад* *Дунд хуруугаа дүрээд* *Цавдаж орхиод*[39]	*Өнчин овоо манай айлд буугаад* *Улаан цайгаа уугаад явагтун гэж* *Өвдөг сөгдөн гуйж гэнэ.* *-Хаан ноён болов чиг* *Хар албатын гэрт* *Буугаад өнгөрдөг ёстой билээ,* *Хамаа хүрдэг боловчиг* *Хаалга дээр тань байсан* *Улаан цайтай учраад байж* *Уухгүй явах нь* *Муу ёр эс юу? гэж гэнэ.* *Араг Улаан Хонгор* *Энэ үгэнд шуугдаад* *Алтан жолоогоо өргүүлж* *Есөн алд тамын аманд буугаад*[40]

Дээрх хэсэгт Хонгор өдрийн бор шөлнөөс өнгөрдөг аргагүй учраас тамд цөлөгдсөн хоёр хүүхний гэр рүү орж, хамаг хэргийн учрыг тунгаадаг. Иймээс “болсноос амс” хэмээх үг нь зоримог баатрыг ч зогсоон, тамын аманд хүртэл хүргэдэг чухал ёс ажээ. Цай, хоол бол хүч тамир тэнхээ нэмэхээс гадна ураг төрлийг улам ойртуулж нягтруулах, хүмүүсийн учир зүйгээ ололцон учралдах нэгэн өвөрмөц хэрэглүүр болж байна. Мөн энэхүү өгүүлэмж нь “Баянжаргал хүү” үлгэрт давтагдаж байна. Тухайлбал, Баянжаргал хүү зуун настай эмгэнээс нэгэн сайн үгийг сонсох гэж зуун сайн морио өгье, надад ганц сайн үг хэлээч гэж гурав гуйсанд эмгэн,

Болсон бор шөлнөөс битгий өнгөр
Болзоогүй хүний үгэнд бүү ор
Уур чинь хүрвэл баруун гартаа барьсан шийдэм мэсээ зүүн гартаа сольж барь...[41] гэж хэлдэг.

Эдгээрээс харахад, аман зохиолд болсноос амсах нь баатруудын зайлшгүй үүрэг буюу хойшдын үйл хэргийн сайн ёр болж байна.

[39] Таяа, Д., *Аримпилын “Жангар”-ын арван долоон бүлэг,* УБ., 2023, х.229.
[40] *Жангарын эх материал VII.* Дундад улсын ардын аман зохиолын хэвлэлийн хороо., 1990, х.133.
[41] *Монгол ардын үлгэр (Монгол ардын аман зохиолын чуулган I)*, Д. Цэрэнсодном эмхэтгэж, удиртгал, тайлбар бичив. УБ., 1982, х.177.

ДҮГНЭЛТ

Шинжааны Буурал Жангарч, Пүрвэй тайж гэх туульчдаас уламжлан дэлгэрсэн “Хаан Сийр” тууль нь “Жангар” туулийн биеэ даасан бүлэг тууль юм. Шинжаан дахь Жангарын бүлгүүд монгол нутагт тархсаныг батлах нэг жишээ болох “Хаан Сийр” туулийн гурван хувилбарын соёлын хам сэдвийг харьцуулан судлах үед бусад “Жангар”-ын бүлгүүдэд давтагдаагүй өгүүлэмж болон торгууд угсаатны бүлгийн хуримын зан үйлийн онцлог нь туульчийн орон нутаг, өвлөн уламжлагчаас шалтгаалан ялгаатай байдлаар илрэв. Эдгээр нь эл туулийг биеэ даасан, үндсэн бүлэг болохыг баталж байна.

Монгол улс дахь торгууд туульч М. Пүрэвжал болон Шинжааны Ховогсайрын жангарч П. Аримпил нарын хайлсан хувилбар нь Буурал Жангарч гэх хүнээс өвлөн дэлгэрсэн давхар байгууламжит хувилбарууд буюу хатнаа буулгах, Жангарын дайсныг даралцах гэсэн хоёр мөчлөгтэй юм. Тус хувилбаруудад ураг хуримын өгүүлэмжээс илүүтэй дайн, тулааны өгүүлэмж, дүрслэл зонхилж байна.

Харин Б. Мөнтгөрийн хувилбар нь ураг хуримын өгүүлэмж бүхий дан мөчлөгт хувилбар бөгөөд торгууд угсаатны ураг хуримын өгүүлэмж, үг хэллэгээр баялаг байна. Б. Мөнтгөр нь Борталын Жин шианы жангарч боловч, тухайн нутгийн хуримын үг хэллэгээс илүү Ховогсайрын торгуудын хуримын үг хэллэг, зан үйлтэй ойролцоо байна. Тиймээс энэхүү туулийг Ховогсайрын торгууд жангарчаас уламжлан, Шинжааны болон Монгол улсын торгуудуудын дунд хайлагдах болжээ гэж үзэж болохоор байна.

Торгууд угсаатны бүлгийн тархан суурьшиж буй нутаг дэвсгэрийн ёс заншлаас шалтгаалан хуримын өгүүлэмж, үг хэллэг нь өөр өөрөөр илэрч байгаа нь Бэн Амосын онолтой холбогдож байна. Түүний үзэж байгаагаар ардын билиг, аман зохиол нь тогтсон бичвэр бус, харин тодорхой нийгэм-соёлын нөхцөлд явагдах харилцааны үйл явц бөгөөд түүний хэлбэр, утга нь тухайн хам орчноос шууд хамаардаг. Иймээс уг туулийн хуримын зан үйл болон түүний үг хэллэгийн нутаг нутгийн хувилбарууд нь аман уламжлалын хам сэдэвт суурилсан хувьсамтгай шинжийг илэрхийлэхийн зэрэгцээ соёлын үнэт зүйлс, тухайн угсаатны бүлгийн харилцааны хэм хэмжээг үеэс үед уламжлан дамжуулах чухал хэрэгсэл болж байна.

A COMPARATIVE ANALYSIS OF THE CULTURAL CONTEXTS IN THE VARIANTS OF THE EPIC *KHAAN SIIR*

In this article, we will compare the cultural context of the versions of the epic "Khan Siir", the main chapter of the Jangar epic, including the wedding rituals of the ethnic group. We will consider what traditions are transmitted in the artistic communication of a small group of society based on the theory of Dan Ben Amos. When comparing the cultural context of the epic versions of "Khan Siir", which were inherited from the epic singers Buural Jangarch and Pürvei Taij of Xinjiang, the epic describes Torguud matrimonial customs, including pre-birth betrothal and the dissolution of engagement agreements. This ethnic group is distinguished by preserving and transmitting wedding rituals and customs through artistic communication, in which such representations and cultural contexts are reflected.

Keywords: *Khaan Siir, Khongor, Jangar, Torguud, pre-birth betrothal, variant, cultural context*

НОМ ЗҮЙ

Эх хэрэглэгдэхүүн

Жангарын эх материал VII. (1990). Эмхэтгэсэн Б. Амардалай. Дундад улсын ардын аман зохиолын хэвлэлийн хороо.

Монгол ардын баатарлаг туульс, (1982), Эмхэтгэж хэвлэлд бэлтгэсэн Ж. Цолоо, ред. Х. Сампилдэндэв, УБ., Улсын хэвлэлийн газар.

Таяа, Д., (2023), *Аримпилын "Жангар"-ын арван долоон бүлэг,* УБ., Тод номын гэрэл төв.

Судалгааны бүтээл

Баасандорж, Ц., Очир, А., (2019), *Ойрад монголчуудын хуримын ёс (XIX зууны сүүлч, XX зууны эхэн),* УБ., Соёмбо принтинг.

Бадамцэцэг, Н., (2025), *Торгууд хуримын зан үйл, аман зохиолын судалгаа,* Докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл.

Баясгалан, Т., (2010), *"Жангар" туулийн хэв шинжийн харьцуулсан судалгаа*, УБ., Тод номын гэрэл төв.

Баясгалан, Т., (2019), *"Жангар" туулийн хувилбаруудын харьцуулсан судалгаа*, УБ., Тод номын гэрэл төв.

Баясгалан, Т., (2025), *"Жангар" туулийн Хаан Сийр бодонгийн бүлгийн хоёр зүйлийн уламжлал,* Аман зохиол судлал-46, УБ., Монгол улсын шинжлэх ухааны академи.

Дулам, С., Нандинбилиг, Г., (2016), *Монгол аман зохиолын онол*, Боть 1, УБ., МУИС пресс.

Монгол ардын үлгэр (Монгол ардын аман зохиолын чуулган I), (1982), Д. Цэрэнсодном эмхэтгэж, удиртгал, тайлбар бичив. УБ., Улсын хэвлэлийн газар.

Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь, (2008), Ерөнхий редактор Л. Болд, А. Лувсандэндэв. УБ., Хэл зохиолын хүрээлэн.

Нандинбилиг, Г., (2018), *Эх зохиолыг задлан шинжилж, үнэлэх арга зүй,* УБ., МУИС пресс

Эрдэнэбаяр, Ж., (2010), *"Жангар"-ын тархац, түүний газар зүйн хэв шинжүүд*, УБ., Тод номын гэрэл төв.

Гадаад хэлээрх бүтээл

Ben-Amos, D., (1971), *Toward a definition of folklore in context*, Journal of American Folklore, 84(331), https://www.jstor.org/stable/539729

Ben-Amos, D., (1993). *"Context" in context,* Western Folklore, 52(2–4)

Dzagdsüren, U., Tsolo, J., Kara, G., (1982). *Khan siir. A chapter of the Jangar epic.* Acta Orientalia Academiae Scientiarum Hungaricae, 36(1/3), http://www.jstor.org/stable/23657856.

Товчилсон үгийн жагсаалт

ЖЭМ	Жангарын эх материал
МАБТ	Монгол ардын баатарлаг тууль
МАҮ	Монгол ардын үлгэр
МХДТТ	Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь

2026 Fasc.10

МОНГОЛ ҮЛГЭРИЙН БААТАД БА ШИДЭТ ТУСЛАГЧИЙН ХОЛБОО ХАМААРЛЫГ СИНТАГМАТИК АНАЛИЗЫН ХҮРЭЭНД ШИНЖЛЭХ НЬ

Батсүхийн ЗОЛБОО
МУИС-ийн Утга зохиол судлал хөтөлбөрийн III курсийн оюутан

Удирдагч: И. Даваадорж
МУИС-ийн Утга зохиол, урлаг судлалын тэнхимийн багш, докторант

Хураангуй: *Уг өгүүлэлд монгол үлгэрийн нэгэн төрөл зүйл болох шидэт үлгэрийн баатад ба шидэт туслагчийн холбоо хамаарлыг шинжиллээ. Ингэхдээ "Бух хар нохой хийгээд бух хар шувуу", "Тэнгэрийн Тоодог хаан", "Есгөлдэй өвгөний есөн хүү", "Өнчин Бүш хүү" болон "Гал улаан хаан" хэмээх нийт таван үлгэрийн өгүүлэмжийг В. Проппын синтагматик анализын арыг ашиглан шинжилж, онцлогийг тодорхойлон, тайлан тайлбарлав. Мөн В. Пропп үлгэрийн баатрыг "эрэл хайгуулч" болон "хохирч үлдсэн" хэмээн ангилсан ангилалд тулгуурлан, дээрх үлгэрийн баатрыг шинжлэв. Ингэснээр "эрэл хайгуулч" эсвэл "хохирч үлдсэн" баатар байхаас шалтгаалан, шидэт туслагчтай холбогдох функц нь хэрхэн өөрчлөгдөж буйг тогтоосон болно.*

Түлхүүр үг: *Шидэт үлгэр, эрэл хайгуулч баатар, хохирч үлдсэн баатар, шидэт туслагч, функц*

УДИРТГАЛ

Хүүрнэн өгүүлэх аман зохиолын төрөл зүйл болох үлгэрийг гадаад болон дотоодын эрдэмтэн, судлаачид XIX зуунаас эхлэн бүртгэн цуглуулж, эмхэтгэн хэвлэж, судлан шинжилжээ. Бид монгол шидэт үлгэрийн баатад хийгээд шидэт туслагчийн холбоо хамаарлын судлагдсан байдлыг тогтоохдоо шидэт үлгэр хэмээх төрөл зүйл, шидэт туслагч болон синтагматик анализыг хэрхэн судалсныг тодорхойлон бичив.

Өмнөх судлаачдын эрдэм судлалын ажилд үлгэр, тэр дундаа шидэт үлгэрийн төрөл зүйлийг судалсан байдлыг авч үзвэл дараах байдалтай байна.

П. Хорлоо “Монгол ардын явган үлгэр” (1960) нэг сэдэвт бүтээлийн “Ид шидэт үлгэр” бүлэгт “Алтан гуу, Мөнгөн гуу” үлгэрийн “Сайн талын баатар нь жирийн хүмүүс байгаа боловч, тэдний үйл ажиллагаа нь ямагт шидэт туслагчийн хүчээр хийгдэж байна”[1] хэмээн шидэт туслагчийг тодотгожээ.

Д. Цэрэнсодном гадаадын болон дотоодын аман зохиол судлаачдын эмхэтгэн хэвлүүлсэн үлгэрийг дахин нягталж, удиртгал тайлбарын хамт 1982 онд хэвлүүлсэн. “Монгол ардын үлгэр” (1982)[2] эмхэтгэл нь эрдэм шинжилгээ, судалгаанд ашиглах баталгаатай эх сурвалж болсон агаад тус бүтээлд бидний судалж буй шидэт үлгэрийн төрөл зүйлд хамаарах нийт 22 үлгэр буй юм.

Ш. Гаадамба, Х. Сампилдэндэв нарын “Монгол ардын аман зохиол” (1988) бүтээлд шидэт үлгэрийн онцлог нь уран сэтгэмж, ид шидийн зүйлс хэмээн дүгнэсэн байна.[3] Мөн Г. Нандинбилиг, С.Дулам нар шидэт үлгэрийн төрөл зүйлийн онцлог, баатар хийгээд эдлэл хэрэглэл, улбарих хувирах өгүүлэмжийн онцлогийг тодорхойлжээ.[4]

Б. Дайриймаа “Монгол ардын үлгэрийн баатруудын уран дүрслэлийн онцлог” (2013) хэмээх бүтээлд монгол үлгэрийн бүтцийг судалж, “Шидэт үлгэрт өгүүлэмжийн өрнөлтөд гайхамшиг, ид шид, хэтийдсэн уран сэтгэмжийн мотивууд оршино”[5] хэмээн шидэт үлгэрийн бүтцийг тодотгосон. Мөн “Шидэт үлгэрийн агуулга, бүтэц ба түүнд илрэх өгүүлэмжийн нийлэмж” (2014) хэмээх эрдэм шинжилгээний өгүүлэлд монгол шидэт үлгэрийн агуулга, сэдэв, өгүүлэмжийг онцлогийг “...эерэг, эсрэг талын баатруудын зөрчил бөгөөд утга санаа нь үйл явдлын дарааллаар тайлагддаг...харгис хатан буюу эсрэг баатрын элдэв муу явуулга, түүний улмаас баатар ямар нэг зүйл эрж хайж өрсөлдөгчтэй тулгарах, тулалдах, хайснаа олох...”[6] хэмээжээ.

Монгол аман зохиол, аман уламжлал дахь шидэт туслагчийн дүр, өгүүлэмжийг судалсан байдлыг авч үзвэл дараах байдалтай байна. С. Дулам “Монгол бэлгэдэл зүй: Өнгийн бэлгэдэл зүй, зүг чигийн бэлгэдэл зүй” нэг сэдэвт бүтээлдээ монгол туульсын дэд, туслах баатад нь зүүн зүгийг эрхшээдэг[7] хэмээн монголчуудын зүг чигийн бэлгэдэлтэй холбон тайлбарласан байна.

Б. Дайриймаа “Монгол ардын шидэт үлгэрийн өгүүлэмж” (2017) номдоо “Өнчин Бүш хүү” үлгэрийн баатар Бүш хүү цагаан сахалт өвгөний

---

1 Хорлоо, П., *Монгол ардын явган үлгэр*, УБ., 1960, х.54.
2 *Монгол ардын үлгэр*, эмх. Д. Цэрэнсодном, УБ., 1982.
3 Гаадамба, Ш., Сампилдэндэв, Х., *Монгол ардын аман зохиол,* УБ., 1988, х.267-268.
4 Нандинбилиг, Г., Дулам, С., *Монгол аман зохиолын онол II*, УБ., 2020, х.144-145.
5 Дайриймаа, Б., *Монгол ардын үлгэрийн баатруудын уран дүрслэлийн онцлог*, УБ., 2013, х.39.
6 Дайриймаа, Б., *Шидэт үлгэрийн агуулга, бүтэц ба түүнд илрэх өгүүлэмжийн нийлэмж*. Хэл зохиол судлал VII (39), УБ., 2014, х.184.
7 Дулам, С., *Монгол бэлгэдэл зүй II-Өнгийн бэлгэдэл зүй, зүг чигийн бэлгэдэл зүй*, УБ., 2000, х.131.

тусламжтайгаар шидэт үг суран өшөөгөө авч буй өгүүлэмжийг тодотгожээ.[8]

Мөн Г. Нандинбилиг, С. Дулам "Монгол аман зохиолын онол: Хүүрнэн өгүүлэх аман зохиол, жүжиг наадмын аман зохиол" (2020) бүтээлд монгол үлгэрийн гол баатар шидэт туслагч болох Хангардийн зулзагыг аварсныхаа хариуд сайн сайхантай золгодог[9] хэмээн монгол үлгэр дэх шидэт туслагчийн дүр хийгээд түүний гүйцэтгэх үүргийг судалжээ.

Судалгааны онол, арга зүйн үндэс болох Владимир Проппын "Үлгэрийн морфологи" бүтээлийн монгол хэлээрх судлагдсан байдлыг жагсаан үзвэл дараах байдалтай байна.

Ц. Нямсүрэн "Монгол, Грек туульсыг бүтцийн анализаар харьцуулан судалсан нь" (2015) докторын зэрэг горилсон бүтээлдээ Владимир Проппын синтагматик анализыг ашиглан, "Донорын анхны үйлдэл" нь Хан Харангуй болон Жангар туульд хэрхэн илэрч буйг судалсан.[10]

Б. Орхон "Тэмдэг судлал ба эхийн тэмдгийн задлал" (2017) магистрын зэрэг горилсон эрдэм шинжилгээний бүтээлдээ Владимир Проппын тэмдгийн загвар, хүүрнэмжийн үүрэг, үйлдлийн хүрээг судалж, "Алтан мөнгөн аргай" үлгэрийн функцийг тогтоосон байна.[11]

И. Даваадорж "Монгол аман зохиол дахь шидэт зүүдний дүр, өгүүлэмж" (2022) магистрын зэрэг горилсон бүтээлдээ "Өнчин Бүш хүү Түс годил" үлгэрийн шидэт туслагч болох цагаан сахалт өвгөн гол баатрын зүүдэнд үзэгдэж буйг шидтэй зүүдний шинжтэй холбон тайлбарласан.[12] Мөн "Монгол үлгэр, тууль дахь хатдын зүүдний өгүүлэмжийг шинжлэн үзэх нь" (2023) хэмээх өгүүлэлдээ "Авдай хааны түүх" болон "Хар нүдэн хүү" үлгэрийн функцийг тогтоож, мангас махчин халдаж ирэхийг мэдэх зөнтэй зүүдний үлгэрийн өгүүлэгдэхүүнд гүйцэтгэх үүргийг судалсан байна.[13]

Түүнчлэн М.Уганбаяр "Сэдвүүд I" (2022) бүтээлд В.Проппын шидэт үлгэрийн бүтцийг судлах 31 функцийн тухай дурдаж, тэдгээрийг орчуулжээ.[14]

С. Батхишиг, С. Дашдэжид нар "Гэсэрийн туужийн хэл, уран зохиолын судалгаа" (2023) нэг сэдэвт бүтээлдээ Гэсэрийн туужийн V, XII, XIII бүлгийн

---

[8] Дайриймаа, Б., *Монгол ардын шидэт үлгэрийн өгүүлэмж*, УБ., 2017, х.30.

[9] Нандинбилиг, Г., Дулам, С., *Монгол аман зохиолын онол II*, УБ., 2020, х.144-145.

[10] Нямсүрэн, Ц., *Монгол, Грек туульсыг бүтцийн анализаар харьцуулан судалсан нь*, УБ., 2017, х.38-60.

[11] Орхон, Б., *Тэмдэг судлал ба эхийн тэмдгийн задлал.* Магистрын зэрэг горилсон бүтээл, УБ., 2017, х.19-26.

[12] Даваадорж, И., *Монгол аман зохиол дахь шидэт зүүдний дүр, өгүүлэмж.* Магистрын зэрэг горилсон бүтээл УБ., 2022, х.132.

[13] Даваадорж, И., *Монгол үлгэр, тууль дахь хатдын зүүдний өгүүлэмжийг шинжлэн үзэх нь.* Оюуны хэлхээ эрдэм шинжилгээний бичиг I (24). УБ., 2023, х.77-89.

[14] Уганбаяр, М., Сэдвүүд I, УБ., 2022.

өгүүлэмжийг синтагматик анализын дагуу судалсан байна.[15]

Монгол аман зохиол, тэр дундаа шидэт үлгэрийн шидэт туслагчийн дүрийг судалсан боловч В. Проппын таксономик загварыг ашиглан, шидэт туслагчийн өгүүлэгдэхүүнд гүйцэтгэх үүрэг, үлгэрийн баатартай холбогдох хамаарлыг шинжилсэн судалгаа ховор байна. Иймээс "Бух хар нохой хийгээд бух хар шувуу", "Тэнгэрийн Тоодог хаан", "Есгөлдэй өвгөний есөн хүү", "Өнчин Бүш хүү" болон "Гал улаан хаан" үлгэрийг синтагматик анализын аргаар шинжилж, шидэт туслагч болоод баатрын холбоо хамаарлыг тодруулах юм.

ҮНДСЭН ХЭСЭГ

Бид эл илтгэлд монгол шидэт үлгэрийн баатад болон туслагчийн холбоо хамаарлыг шинжлэхдээ аман зохиолын структуралист арга, тэр дундаа синтагматик анализыг гол арга болгон ашиглалаа. Аман зохиолын бүтээлийг судлах структуралист аргыг синтагматик болон парагдиматик хоёр төрөлд хувааж болно. "Синтагматик анализ нь парагдиматик анализаас зөвхөн бичвэр доторх текстийг судалж, нийгэм болоод соёлын хам сэдэвт төвлөрдөггүйгээрээ ялгардаг."[16] Синтагматик анализ нь "...аман зохиолын текстийн бүтэц болон формал байгуулалд хандан, цуваа цаг хугацааны дагуу функцийг дараалуулан судалдаг синтагматик анализ юм"[17].

Эл синтагматик анализын аргыг Владимир Проппын "Үлгэрийн морфологи" бүтээлдээ анхлан дэвшүүлж, шидэт үлгэрийн үйл явдлын бүтэц дарааллыг судлах 31 функц боловсруулжээ. Функц нь үлгэрийн баатрын үйл хэргээр буюу үйл үгээр илэрдэг. В. Пропп функцийг товч утга, тодорхойлолт, тэмдэглэгээ гурвыг багтаадаг гэж үзжээ.[18] (Хүснэгт 1)

Хүснэгт 1. В. Проппын функцийн тэмдэглэгээ

Тэмдэглэгээ	Тодорхойлолт	Жишээ
β	Эзгүй байх	Гэр бүлийн нэг гишүүн гэртээ байхгүй байх

Мөн В. Пропп үлгэрийн баатрыг ангилахдаа "эрэл хайгуулч" болон "хохирч үлдсэн баатар" хэмээн ангилсан. Тэр бээр "ямарваа нэг зүйлийн эрэл хайгуулд гардаг баатрыг эрэлч хайгуулч, золгүй явдлын улмаас хохирч үлдэн эцэст нь

[15] Батхишиг., С., Дашдэжид, С нар., *Гэсэрийн туужийн хэл, уран зохиолын судалгаа* УБ., 2023, х.252-294.

[16] Vladimir Propp., *Morphology of the Folktale*, University of Texas Press., 1968, p.12-13.

[17] Даваадорж, И., *Монгол аман зохиол дахь шидэт зүүдний дүр, өгүүлэмж* УБ., 2022, х.70.

[18] Sapna Dogra., *The Thirty-One Functions in Vladimir Propp's Morphology of the Folktale: An Outline and Recent Trends in the Applicability of the Proppian Taxonomic Model (*Rupkatha Journal on Interdisciplinary Studies in Humanities, 410-9*),* 2017.

сайн сайханд хүрдэг баатрыг хохирч үлдсэн баатар...” хэмээн тодорхойлжээ[19].

Бид эл судалгааны ажилд тулгуур болгон ашиглаж буй синтагматик анализ нь аман уламжлал, уран зохиолын бичвэрт хэт формалчлан системчилсэн хатуу загварыг тулган хүлээлгэдэг хэмээн шүүмжид өртдөг. Тухайлбал, Леви-Стросс “Бид зөвхөн синтагматик хэлхээгээр үйл явдлыг харгалзан үзвэл уялдаа холбоогүй, тохиолдлын шинжтэй болно”[20] хэмээн синтагматик анализын сул талыг шүүмжилсэн. Энэ нь бидний судалгааны хязгаарлагдмал тал болох юм. Гэсэн хэдий ч уг аргыг ашиглан, үлгэрийн үйл явдал, функцийн хэлхээ болон баатрын холбоо хамаарлыг тогтоох нь өгүүлэгдэхүүний дарааллыг бүтээх, мөн үүнд тулгуурлан боломжит аман хүүрнэл бүтээх судалгаанд чухал нөлөөтэй. Ийн тогтоосон функцийн хэлхээг үлгэр зохиоход ашиглаж болох бөгөөд энэ нь өгүүлэгдэхүүн дарааллыг (*plot*) шинжлэх чиглэлийн суурь болдог[21]. Иймээс аман зохиолыг судлах синтагматик анализ нь хэрэг явдлын санг бүрдүүлж, боломжит хувилбар бүтээх, тооцооллын аман зохиолын эх өгөгдлийг бэлтгэх эхний шат болох ач холбогдолтой.

Тиймээс бид синтагматик анализад тулгуурлан, монгол үлгэрийн шидэт туслагчийг судлахдаа анхлан үлгэрийн өгүүлэгдэхүүний цуваа, функцийн хэлхээг тогтооно. Тухайн үлгэрийн функцэд тулгуурлан, баатрын хэв шинжийг “эрэл хайгуулч” болон “хохирч үлдсэн” баатрын аль болохыг тогтоож, шидэт туслагчтай ямар харилцаа холбоотойг шинжлэх юм.

Бид судалгааны объект болгон шинжлэн үзэж буй таван үлгэрийн синтагматик байгууламж, функцийн цувааг тогтоовол дараах байдалтай байна. (Хүснэгт 2)

Хүснэгт 2. Үлгэрийн функцийн хэлхээ, баатрын ангилал болоод тогтмол функц

Үлгэр	Функцийн хэлхээ	Эрэл хайгуулч	Хохирч үлдсэн	Холбогдох функц	Тогтмол функц
“Бух хар нохой хийгээд бух хар шувуу”	$\left\{\begin{matrix}\alpha\ \mathrm{A}^{8}-\mathrm{A}^{16}\mathrm{A}^{8}\ B^{2}\uparrow\\ G^{2}\ \mathrm{o}\ \zeta^{2}\ A^{14}\zeta^{2}\ H^{1}I^{1}\end{matrix}\right\}$ $\left\{\begin{matrix}D^{2}E^{2}DK^{2}K^{4}\ \mathrm{N}\\ \downarrow\ \mathrm{U}\ W_{*}\end{matrix}\right\}$	+	-	$\alpha\ \mathrm{A}^{8}$	$\alpha\ A$
“Тэнгэрийн Тоодог хаан”	$\left\{\begin{matrix}\alpha\ \mathrm{A}^{9}\ \mathrm{A}^{8}\ \mathrm{B}\ \downarrow\uparrow\ \mathrm{J}\\ \mathrm{J}\ \mathrm{D}\ \mathrm{E}^{7}\ \mathrm{D}^{2}\ \mathrm{E}^{2}\ \mathrm{F}^{1}\ \mathrm{G}^{1}\ \gamma^{2}\ \mathrm{G}^{1}\ \mathrm{K}\ \mathrm{D}\ \mathrm{G}^{1}\end{matrix}\right\}$ $\left\{\begin{matrix}\mathrm{W}\ \mathrm{W}\ \downarrow\ \mathrm{a}^{1}\ \mathrm{F}^{1}\ (\eta^{2})\\ \mathrm{G}^{1}\mathrm{I}^{5}\ \mathrm{W}\end{matrix}\right\}$	+	-	$\alpha\ \mathrm{A}$	

[19] Vladimir Propp., *Morphology of the Folktale,* University of Texas Press., 1968, p.39.

[20] Levi-Strauss, Claude, *The Raw and The Cooked*. *Introduction to a Science of Mythology.* Volume I. New York: Harper&Row., 1969, p.306.

[21] Sapna Dogra, *The Thirty-One Functions in Vladimir Propp’s Morphology of the Folktale: An Outline and Recent Trends in the Applicability of the Proppian Taxonomic Model (*Rupkatha Journal on Interdisciplinary Studies in Humanities, 410-9*).,* 2017, p.411.

“Есгөлдэй өвгөний есөн хүү”	$\begin{Bmatrix} \alpha\,\mathrm{A}^1\ \mathrm{B}\ \beta^1\,\mathrm{F}^6\ \uparrow \\ \mathrm{K}^1\ \mathrm{Pr}^6\mathrm{Pr}^7\ \downarrow\ \mathrm{W} \end{Bmatrix}$	+	-	$\alpha\,\mathrm{A}^1$	$\alpha\,A$
“Өнчин Бүш хүү”	$\begin{Bmatrix} \alpha \uparrow G^2(\varepsilon^1)\mathrm{neg}\zeta^2\mathrm{a}^1\mathrm{A}^{13} \\ \mathrm{D}T^1D^{10} \downarrow\ D^{10}B^2G^2 \end{Bmatrix}$ $\begin{Bmatrix} \mathrm{o}G^2D^{10}D^{\ 10} \downarrow K^5 \\ \zeta^1\,\zeta^2\gamma^2\eta^2K^5\,\mathrm{W} \end{Bmatrix}$	-	+	$\alpha \uparrow$	$\alpha \uparrow$
“Гал улаан хаан”	$\begin{Bmatrix} \alpha\ \uparrow\ \mathrm{F}^1\,\mathrm{F}^5\ \mathrm{a}^1\ \mathrm{K}^9\ \gamma^2\ \gamma^2 \\ \mathrm{K}^6\,\mathrm{W}\,\mathrm{A}^2\ \mathrm{F}^1\,\mathrm{E}^6\ \mathrm{G}^2\ \downarrow \end{Bmatrix}$	-	+	$\alpha \uparrow$	

“Бух хар нохой хийгээд бух хар шувуу”, “Тэнгэрийн Тоодог хаан”, “Есгөлдэй өвгөний есөн хүү” зэрэг үлгэрт эрэл хайгуулч баатар, “Өнчин Бүш хүү” болон “Гал улаан хаан” үлгэрт “хохирч үлдсэн” баатрын хэв шинж илэрч байна.

Нэн түрүүнд, эрэл хайгуулч баатадтай үлгэрийг задлан шинжилбэл, “Бух хар нохой хийгээд бух хар шувуу” үлгэрийн синтагматик бүдүүвчид анхдагч нөхцөл (α)-ийн дараа хорон санаатны функц (А)-д хамаарах “Хорон санаатан хохирогчоо ятгах, уруу татах” (A^8) функц илэрчээ. Үлгэрт “Эрт урьдын цагт нэг сүрхий залуу хатантай өтөлсөн хаан байж гэнэ”[22] гэсэн нь анхдагч нөхцөл болж, хатан нь хааныхаа адуучинд дурлаж, өөртөө татахыг оролдож буй нь “Хорон санаатан хохирогчоо ятгах, уруу татах” (A^8) болон “Хүчээр гэрлэхээр айлгах” (A^{16}) функц юм. Цаашлаад, хатан адуучин өөрийнх нь заль мэхэнд өртөхгүй буйд ихэд хорсон, баруун хойно байдаг, түмэн эр дийлдэггүй Бух хар нохой хийгээд Бух хар шувууг авчирч, бух хар нохойгоор нь хашаагаа сахиулж, шувуугаар нь адуу малаа хариулуулбал сайн хэмээн хаандаа хэлэхэд, хаан эл хэцүү эрэлд адууны хүнийг явуулах зарлиг буулгадаг.[23] Эл хатан нь “монгол үлгэрт хар санаатай, хань нөхрөө хорлогч хатан... муу талын дүр”[24] болох нийтлэг баатар юм.

Ийнхүү, адуучин залуу бух хар нохой, бух хар шувууны эрэлд гарч, үлгэрийн үйл явдал өрнөх суурь нөхцөлийг бүрдүүлжээ. Үлгэрийн баатар гэрээс гарснаар ямарваа нэг саад, бэрхшээл болон сайн, сайхантай золгон учирч, үлгэрийн үйл явдлыг баяжуулах суурь болдог. Эл “баатар гэрээс гарах” (↑) функц нь нэг талаас, үлгэрийн зангилаа хэсгийг тодорхойлж, нөгөө талаас адуучин хүү бух хар нохой, бух хар шувууны эрэлд гарч буй учир “эрэл хайгуулч” баатар болохыг баталж байна. “Эрэл хайгуулч” болон “Хохирч үлдсэн” баатдын гэрээс гарах нөхцөл нь хоорондоо ялгаатай. Учир нь эрэл хайгуулч баатар ямарваа нэг зүйлийг эрж хайх, олох зорилготой бол хохирч

[22] *Монгол ардын үлгэр*, Д. Цэрэнсодном эмхэтгэж, удиртгал тайлбар бичив УБ., 1982, х.86.
[23] МАУ, х.87.
[24] Хорлоо, П., *Монгол ардын явган үлгэр,* УБ., 1960, х.53.

үлдсэн баатар эсрэгээрээ адал явдалд гардаг юм. [25]

Түүнчлэн үлгэрийн үйл явдал өрнөхөд хорон санаатны функц (A) чухал үүрэг гүйцэтгэнэ. Эзгүй байх (β), хоригийг зөрчих (γ), хорон санаатан хохирогчоо ятгах, уруу татах (A^8), хууран мэхлэх (η) зэрэг функцүүд нь хорон санаатны функц хэрэгжих боломжийг бүрдүүлдэг.[26] Дээрх үлгэрт хатан, адуучин залууг бух хар нохой, бух хар шувууг олох аянд явуулах сэдэл нь үйл явдал өрнөх нөхцөл болжээ.

"Үлгэрийн баатрын ихэнх үйлдэл нь өрнөл хэсэгт аяндаа бий болдог. Харин үүнээс ялгаатай нь үндсэн функц болох хорон санаатны үйл нэмэлт тайлбар, сэдэл шаарддаг."[27] Харин эл үлгэрийн "зөрчлийг тал бүрээр баяжуулан, улам бүр нарийн төвөгтэй нөхцөл байдалд тэмцлийг үргэлжлүүлэх өгүүлэгдэхүүний холбоос..."[28] болох өрнөл хэсэгт баатар шидэт туслагчтай учирдаг. Үлгэрт, адуучин залуу нэгэн ухаа толгойн энгэрт ирээд унтахаар зэхэж байтал хүн уйлж, дуулж, инээж байхыг сонсоод очиж үзтэл, нэгэн цагаан хас гэрт гурван охин аварга могойд идүүлэх ээлжээ хүлээн уйлж, дуулж, инээж байдаг. Ийнхүү хангарди аварга могойг дийлж бараагүй учир адуучин залуу туслахаар шийднэ. Гэнэт аварга могой гарч ирсэнд баатар ойртон очоод уургалан, тэмцэж, дийлдэг[29]. Эл хэсэгт H^1- Баатар, хорон санаатан нар задгай талбайд тулалдах, I^1 - Хорон санаатныг задгай талбайд буулгаж авах функц илэрч байна.

Эдгээр хэрэг явдал нь хоорондоо холбоо хамаарал бүхүй функцийг бүрдүүлэх юм. Учир нь, "Пропп функц хоорондын холбоог хоёр төрөл болгож хуваасны нэг нь хоорондоо үргэлж уялдаатай, бие биедээ тохирох хувилбар бүхий функц юм. Жишээлбэл, задгай талбайд тулалдах (H^1), хорон санаатныг задгай талбайд буулгаж авах (I^1) функц холбогддог"[30] учир уг үлгэрт баатар эр аварга могойг дийлэх нь зайлшгүй шинжтэйг илэрхийлжээ.

Хангарди адуучин хүүгийн ачийг хариулахаа амладаг нь баатрын үйл хэрэгт шидэт туслагчийн хүч хавсрах сэжмийг бүрдүүлж байна. Хангарди баатрын зорилго, өөрөөр хэлбэл түүний тус хэрэгтэй эсэхийг асуусан нь "Шидэт туслагч үлгэрийн баатартай учирч, асуулт тавих" (D^2) функцэд нийцнэ. Мөн баатар хангардийн асуусан асуултад учир зорилгоо хэлж хариулснаар, "Баатар шидэт туслагчийг мэндлэхэд хариу өгөх, өгөхгүй" (E^2) функцтэй таарч, хангарди хариуд нь туслахаар болдог. Энэ нь "D" буюу "Донорын анхны

[25] Vladimir Propp., *Morphology of the Folktale,* University of Texas Press., 1968, p.39
[26] Propp, p.30-31.
[27] Propp, p.71.
[28] Нандинбилиг, Г., *Эх зохиолыг задлан шинжилж үнэлэх арга зүй,* УБ., 2020, х.24.
[29] MAY, х.87-88.
[30] Gervás, P. *Propp's morphology of the folk tale as a grammar for generation*, Schloss Dagstuhl, 2013, p.3.

хариу үйлдэл” болно. Иймээс уг үлгэрт хангарди шидэт туслагч болж, “D^2E^2D” хэмээх функцийг үлгэрийн өрнөл хэсэгт илэрчээ. Эл үлгэрийн өрнөл хэсэгт баатар шидэт туслагчтай учирч, түүний туслалцааг авахаас урьд ямарваа нэгэн байдлаар шидэт туслагчид тус хүргэх нь зайлшгүй байна.

Үлгэрийн төсгөлд шидэт туслагч, баатар хоёул хамтын хүчээр хайж буй зүйлээ олж, хангарди бух хар шувууг, адуучин хүү бух хар нохойг барьдаг.[31] Нэгэн зүйлийг онцлох ёстой нь, хангарди бух хар шувууг барьж, адуучин хүү бух хар нохойг дийлж буйгаар жигүүртэн жигүүртнээ, газрын амьтан нь газрын амьтантайгаа тэмцэж буй юм. Урвуулан харвал, монгол домог зүйн гурвал ертөнцийн[32] үзэл ёсоор, дунд тивийн адуучин хүү, дээд тивийн бух хар шувуутай тэмцэн барихад бэрхшээл тулгарах учир үлгэрт шидэт туслагч хангардийн хүчээр үйл хэргээ бүтээжээ.

Эл үлгэрт тулгуурлан, эрэл хайгуулч баатар болон шидэт туслагчийн холбоо хамаарлыг авч үзвэл, эрэл хайгуулч баатар нь хорон санаатны сэдлээс үүдэн, алив зүйлийн эрэлд гардаг. Эл эрлийг үйл явдлын функцтэй нэгтгэвэл “αA^8” болох бөгөөд “хорон санаатны сэдэл - хайж буй объект - шидэт туслагч” гэх дараалалтай байна.

Дараагийн үлгэр болох “Тэнгэрийн Тоодог хаан” эхлэл хэсэгт, “Эрт урьд цагт Тэнгэрийн Тоодог хаан гэж байжээ. Тэр хааны дотоод хэргийг захирсан Сонжоодой сайн түшмэл, гадаад хэргийг захирсан Бандидай муу түшмэл...”[33] гэх хоёр түшмэлийг дурдсан нь үлгэрийн анхдагч нөхцөл (α) болох юм. Сонжоодой түшмэл нь алба үүргээ сайн гүйцэтгэдэг учир солигдож халагддаггүй. Үүнд хорссон Бандидай Сонжоодой түшмэлийг албанаас холдуулах аргыг сэддэг. Ингэхдээ “... Наян жилийн цаана Наянтай уулын тэртээх цагаан бургасны агуйд нэг их алдартай лам дуулдах юм... залж ирээд номын авшиг хүрвэл яадаг юм бэ? Сонжоодой сайн түшмэлд зарлиг тушаал өгнө үү”[34] хэмээн хаандаа хэлнэ. Энэ хэрэг явдал нь A^9 буюу хорон санаатан хэн нэгнийг хөөн зайлуулах функц юм. Дээрх анхдагч нөхцөлийн дараагаар хорон санаатны үйлдлээс улбаалан гэрээс гарах αA^9 функц нь “Бух хар нохой хийгээд бух хар шувуу” үлгэрийн адил эрэл хайгуулч баатрыг тодотгон илэрхийлж байна.

Ийн Сонжоодой сайн түшмэл замд гарч, ядарч туйлдан, шидэт туслагчтай учирдаг. Ингэхдээ нэг өндөр уулын орой өөд өгсөж, даваан дээр гартал цаад талд нь хангарди шувуу аварга могойг залгиад, ухаан алдан хэвтэж байхыг

---

[31] МАУ, х.88-89.

[32] Дулам, С., *Ертөнцийн модон-гурван тив.* МУИС-Профессорын өв цуврал: Домог зүй, бөө мөргөлийн судалгаа. Боть I. УБ., 2018, х.182-189.

[33] МАУ, х.100.

[34] МАУ, х.101.

харна. Сонжоодой сайн түшмэл өрөвдөн толгойг нь илж суутал хахсан зүйл нь гардаг. Ийн сэхэл авсан хангарди түшмэлээс, Чи хэн хааны үр вэ? Хэтийн зориг юунд вэ?[35] хэмээн лавладаг. Эл хэсэгт D^2 - шидэт туслагч баатартай учирч, асуулт тавих функц илэрчээ.

Энд нэгэн зүйлийг онцлох нь, үлгэрийн баатар хангардийн туслалцааг авахаасаа өмнө, хангардийн охидыг аварга могойноос аврах, хахаж байхад нь туслах зэргээр шидэт туслагчид тус хүргэдэг.

Ижил өгүүлэмж бүхий хоёр үлгэрийн холбогдох функцийг жагсаан үзвэл, дараах байдалтай байна.

“Бух хар нохой хийгээд бух хар шувуу” $I^1D^9E^9$

“Тэнгэрийн Тоодог хаан” $DE^7D^2E^2E^1$

Дээрх хоёр үлгэрт шидэт туслагчтай холбоотой “” функц давтагдах нь баатар хангардид тусалсны удаагаар “Хүү аль нутгийн хүн бэ? Алсын зорилго юунд вэ?”[36] зэргээр хэн болох, зорьж буй хэргийг асуудаг (D^2). Баатар өөрийгөө танилцуулж, зорьж яваа хэргээ хэлэх (E^2) нь донор буюу шидэт туслагчийн үүргээ гүйцэтгэхэд нь чиглүүлж байна. Үүнээс харвал хангарди “эрэл хайгуулч баатар”-тай учирч, түүний эрж буй зүйлийг олоход тусалдаг, гэхдээ өөрийн сэдлээр бус тодорхой ач тусын хариуд шидэт туслагч болох нь харагдана.

“Есгөлдэй өвгөний есөн хүү” үлгэрийн баатад нь бүгд өөрийн гэх заяамал шинжтэй, хүч чадалтай, “эрэл хайгуулч баатад” байна. Үлгэрийн эхлэл хэсэгт анхдагч нөхцөл (α)-ийн дараагаар хаан дунд хатнаа алдсан тул заавал олох зарлиг буулгадаг. Эл хэрэг явдал нь үлгэрийн зангилаа болж, хорон санаатны анхны функц болох “Хорон санаатан хүн хулгайлах” (A^1) -аар илэрчээ. Ийн нэгэн түшмэл Есгөлдэй өвгөний есөн хүүг эрэлд мордуулах шийдвэр гаргаж, элчээр хэл хүргэдэг. Зарлиг авсан Есгөлдэй өвгөн айн сандарч есөн хүүгээ олохоор явдаг нь “гэрээс явж буй гэр бүлийн гишүүн нь ахимаг насны хүн байж болно” (β^1) функцийг нөхцөлдүүлжээ. Өвгөн уулын бэлээс алт шиг өнгөтэй элс хормойлон, алтан нум сум хийгээд, есөн хүүгийнхээ хэн эрдэмтэйд өгөхөөр шийддэг. Өвгөн “харанхуй шөнө хар батганы мөрийг ч алдахгүй хөөж чаддаг”[37] гэхчлэн тус тусын эрдэмтэй есөн хүүгээ хааны дунд хатны эрэлд мордуулдаг (↑). Үлгэрийн төгсгөлд Есгөлдэй өвгөний есөн хүү арван таван толгойтой атгаалжин хар мангаст баригдсан дунд хатныг олж ирдэг.

Энд нэгэн зүйлийг онцлох нь, “эрэл хайгуулч баатад” болох есөн хүү тус тусын “заяамал” эрдэм, хүч чадлаа хамтатган, туслагчийн тус, үйл хэрэг шаардахгүйгээр хааны дунд хатныг олдог. Үүгээрээ тус үлгэр нь “Бух хар нохой

[35] MAY, x.102.
[36] MAY, x.88.
[37] MAY, x.99.

хийгээд бух хар шувуу", "Тэнгэрийн Тоодог хаан" үлгэрээс ялгарч байна.

Бид удаах хэсэгт "хохирч үлдсэн баатар" бүхий "Өнчин Бүш хүү", "Гал улаан хаан" үлгэрийн функцийн хэлхээг тогтоож, баатар болон шидэт туслагчийн холбоо хамаарлыг шинжлэх юм.

"Өнчин Бүш хүү" үлгэрийн баатар болох Бүш хүү нь В. Проппын ангилал ёсоор "хохирч үлдсэн баатар" юм. Хохирч үлдсэн баатар нь эрэл хайгуулч баатар шиг ямар нэг зүйлийн эрэлд гардаггүй, гол төлөв өнчирч, хөөгдсөний улмаас гэрээс гарч, адал явдалтай учирдаг.[38] Үлгэрийн эхлэл хэсэгт Өнчин Бүш хүүгийн нутаг орон, "анхдагч нөхцөл" (α)-ийг "Хэзээний эрт цагт тариач хааны нутагт... Түс гэдэг годилтой, аяганы чинээ нууртай"[39] хэмээн танилцуулдаг. Харин зангилаа хэсэгт Бүш хүү аяганы чинээ нууртаа атга чихэр зуурч орхиод, удаагаар хартал нуурт шувууд цугласан байхыг үзэж, гэрээс гардаг (↑). Тийнхүү Бүш хүү шувуудыг харваад, хаандаа өгч, отгон охинтой нь хуримлах зорилгоо хэлдэг. Уг хэрэг явдал нь баатар "Сүйт бүсгүйгээр дутагдах" (a^1) функцтэй таарч байна. Харин хаан Буш хүүгийн нэг гар, нэг нүд, нэг хөлийг нь аваад, эзгүй ээрэм цагаан хөдөөд хаях зарлиг буулгадаг[40]. Бүш хүү гачигдлаа арилгах гэж яваад зэрэмдэг болж буй "хохирч үлдсэн баатар" юм.

Дээрх үлгэрийн функцийн хэлхээг ажиглавал, D^{10} буюу "Баатар шидэт хэрэглэлээ гаргаж ирэх эсхүл турших" хэмээх функц тогтмол давтамжтай байна. Бүш хүү шидэт туслагч Цагаан өвгөний тусламжтайгаар муу үзсэн хүндээ ашиглах "наалданхаш", сайн үзсэн хүндээ хэрэглэх "бусраад" гэх шидэт үгийг сурдаг[41]. Эл үлгэрийн үйл явдлыг ажиглавал, шидэт туслагч Цагаан өвгөн гол баатрыг өөрөө шийдэж үл чадах хүнд, хэцүү нөхцөл байдалд байхад нь гарч ирж байна.

Бүш хүү цагаан өвгөний хэлсэн шидэт үгийг туршин, тугал хариулж явсан хааны үхэрчнийг үзээд, "Үхэрчин хүүхэн тугалуудтайгаа газартай наалданхаш"[42] гэсэнд хэлснээр нь биелдэг. Энэ нь Баатар солилцоонд авсан шидэт эдлэл хэрэглэлээ гаргаж ирэх" (D^{10}) функцтэй нийцэх юм. Мөн уг функц нь баатар шидэт хэрэглэлээ турших утгатай байж болно[43]. "D^{10}" функцийн араас, "Баатар гэртээ ирэх" (↓) болон "Баатар шууд яван одох"(B^2) зэрэг "харих", "явах" утгатай функц тогтмол байна. (Хүснэгт 3)

[38] Vladimir Propp., *Morphology of the Folktale,* University of Texas Press., 1968, p.36-39
[39] MAY, x.93.
[40] MAY,x. 84.
[41] MAY, x.94.
[42] MAY, x.94.
[43] Propp, x.42.

Хүснэгт 3. "Өнчин Бүш хүү" үлгэрт тогтмол тохиох функцүүд

$D^{10}\downarrow$	"Үхэрчин хүүхэн тугалуудтайгаа газартай наалданхаш гэж гэсэнд хүүхэн дороо тугалуудтайгаа газартай наалдаад хашхираад хэвтэв. Хөвүүн түүнээс нь "Өвгөний хэлсэн үнэн санж уу?" гээд бусраад гээд орхитол нь хүүхэн тугалуудтайгаа босоод гүйгээд одов Тэгээв хөвүүн итгэж мэдээд, гэртээ харьж ирээд байв" (MAY, 1982: 94).
$D^{10}B^{10}$	"Хаан хатан ортойгоо, дэртэйгээ газартайгаа наалданхаш" гэж хэлээд харьж ирэв. Маргааш өглөө нь хаан хатан хоёр шөнө орондоо наалдаад босож чадахгүй...гэнэтхэн Бүш хөвүүн: Би олох, намайг илгээгтүн. Хааныхаа төлөө явж яваад би үхэвч хэрэггүй мөн гэсэнд сайд түшмэлүүд зөвшөөрөөд яв гэв" (MAY, 1982: 94-95)
$D^{10}\downarrow$	Ер та харь хүн очоод морь үзнэ гэж явахаар энэ аглаг газарт бууж морио үзээд явах тань! гэсэнд бөө хүн "чуу" гэж буугаад мөрөө үзэж суутал нь Бүш хүү Бөөгийн бөгс газартай наалданхаш" гэв...хөвүүн бөөг дор нь орхиод орхиод бөөгийн морийг хөтлөөд хааны тал харьж ирээд...(MAY, 1982: 95)

Бүш хүү шидэт туслагч болох цагаан өвгөний зааж сургасан үгсээр бүх саад бэрхшээл, хэргээ гүйцэлдүүлсээр эцэст "Сүйт бүсгүйгээр дутагдах" (a^1) буюу хааны охиныг гэргийгээ болгох зорилгоо биелүүлдэг. Ингэхдээ хаан хатан хоёр наалдсаныг салгаж, шанд нь хааны охиныг авах аж. Үүнээс үзвэл Бүш хүү "хохирч үлдсэн баатар" учир шидэт туслагч түүнд ямар нэгэн үйлдлийн хариуд бус өөрийн сайн дураар тусалж байна.

Мөн "Гал улаан хаан" үлгэрт "хохирч үлдсэн баатар" илэрч байна. Үлгэрийн эхлэл хэсэгт, "Жил бүр найман настай хүүхдээр далай тахидаг Гал улаан хаан гэж байжээ"[44] хэмээн "Анхдагч нөхцөл"(α)-ийг дурддаг. Хаан тахилга үйлдсээр эцэст нь найман настай хүүхэд олдохоо больсон тул, түшмэдийн хүүгээр далай тахихаар болдог нь үлгэрийн зангилаа юм. Гэвч хааны хоёр яргачин хүүгээр далай тахилгүй, амь хэлтрүүлдэг. Түшмэдийн хүү шувууны есөн хэл мэддэг "заяамал" чадвартай учир алтан улиасанд хоноглохоор хэвтэж байгаад нэгэн шувуу төмөр мунын хугархай авбал сайн гэж хэлэхийг сонсдог. Уг хэрэг явдал нь "баатарт шидэт хэрэглэл олгох" (F^1) функцтэй таарч байна. Баатар төмөр мунын хугархайг олж аваад замд нь дайралдсан нэгэн том мэлхийг "Хонины шагайн чинээ бол"[45] гэж өнөө төмөр мунархайгаараа цохисонд хонины шагайн чинээ болдог. Гэнэт шуурга тавьж, хүүг хийсгэн хол газар аваачин хаяхад, хөх шартай хөгшин олж авна. Тэрхүү хөгшин хүүг хааны охинтой гэрлүүлэхээр шийддэг нь сүйт бүсгүйгээр дутагдах (эсвэл найз, хүнээр дутагдах) (a^1) функц юм. Хөх шартай хөгшин өнөөх хүүг хааны охинтой гэрлүүлэхээр шийдсэн нь хүүтэй болоод зогсохгүй хүүгийн "сүйт хүнээр дутагдах" гачаалыг нөхөх оролдлого болно. Гэсэн ч үүнийг сонссон хаан уурлаж, өвгөнийг хөнөөдөг. Харин хүү нь аавыгаа "...Амь

[44] MAY, x.107.
[45] MAY, x.107

нас нь бүт, урьдаасаа уртай, хэзээнээсээ хэвтэй хүрэн улаан хөгшин бол”[46] гэж дээгүүр нь алхаад амилуулдаг билээ. Энэ нь мөн л үлгэрийн баатрын “заяамал” шинж бүхүй шидэт чадвар агаад “монгол үлгэр туульд үхсэнийг амилуулах, шархалсныг эдгээх ид чадалтай нэгэн дохио зангаа нь шившлэг шившээд үхсэн, шархалсан хүний дээгүүр гурав алхах зан дадгал байдаг”[47]-тай холбоотой юм. Харин зарим үлгэрт үлгэрийн баатрын заяамал эзэмшил нь шидэт туслагчийн үүргийг гүйцэтгэдэг. Жишээлбэл, “Болдоггүй бор өвгөн, “Алтан мөнгөн аргай” үлгэрийн шидэт туслагч болох найман хөлтэй найр алаг морь, нисдэг бор морь зэрэг нь “...тухайн баатрын заяамал эзэмшил, эд хөрөнгө байж, монгол үлгэрийн шидэт туслагчийн шинжийг тодотгож байдаг”[48].

Харин “Гал улаан хаан” үлгэрийн баатарт өөрийн гэх “заяамал шидэт хүч чадал” бий юм. Эл үлгэрийн баатар хүү нь шувууны есөн хэл мэдэх төдийгүй үхсэн хүнийг амилуулдаг. Иймээс баатар өөрт буй эрдэм, шидэт хүч чадлаараа алив саад бэрхшээлийг туулж, сайн сайханд хүрэх боломжтой. Тиймийн учир үлгэрийн баатар нь өөрийн гэх эрдэм чадлаараа бэрхшээлийг даван туулж буй хэдий ч гол төлөв шидэт хэрэглэлийг аз тохиолоор авч байна. Иймээс хохирч үлдсэн баатрын эрэл хайгуулч баатраас ялгарах онцлог нь өөрийн заяамал чадлаар шидэт хэрэглэлийг аз тохиолоор олж авах явдал юм.

Нийт таван үлгэрийг нэгтгэн үзвээс, эрэл хайгуулч болон хохирч үлдсэн баатрын аль нь болохоос хамаарч, шидэт туслагч болон функц ялгаатай байна. (Хүснэгт 4)

Хүснэгт 4. Эрэл хайгуулч ба хохирч үлдсэн баатар бүхий үлгэрийн харьцуулалт

<table>
<tr><th>Үлгэр</th><th>Баатрын төрөл</th><th>Давтагдах функц</th><th>Баатар</th><th>Баатрын шинж</th><th>Шидэт туслагч (Донор)</th><th>Шидэт туслагч (Донор)-ийн үйлдлийн сэдэл</th><th>Донорын тусаар бүтээсэн хэрэг явдал</th></tr>
<tr><td>Бух хар нохой хийгээд бух хар шувуу</td><td rowspan="2">Эрэл хайгуулч баатар</td><td rowspan="2">αA</td><td>Хааны адуучин</td><td>Хатны аалийг үл хэрэгсэх</td><td rowspan="2">Хангарди</td><td rowspan="2">Баатар тусын хариуд туслах</td><td>Жигүүртэн бух хар шувууг баатарт өгөх</td></tr>
<tr><td>Тэнгэрийн Тоодог хаан</td><td>Сонжоодой сайн түшмэл</td><td>Хааны албыг эрхэмлэх</td><td>Наянтай уулын лам залах, хол газрыг товчлох</td></tr>
</table>

[46] *Монгол ардын үлгэр*, Д.Цэрэнсодном эмхэтгэж, удиртгал тайлбар бичив УБ., 1982, х.107.

[47] Дулам, С., *Монгол бэлгэдэл зүй. III боть: Дүрсийн бэлгэдэл зүй, дохио зангааны бэлгэдэл зүй*. Монгол соёлын чуулган Х боть, УБ., [2001] 2011, х.195.

[48] Золбоо, Б., *Монгол үлгэр дэх шидэт туслагчийн дүр, өгүүлэмж. Эрдмийн хэлхээ XIV*, УБ., 2025, х.143.

Есгөлдэй өвгөний есөн хүү	Эрэл хайгуулч баатар	αA	Есөн хүү	Заяамал чадалт	-	-	-
Өнчин Бүш хүү	Хохирч үлдсэн баатар	α↑	Өнчин Бүш хүү	Сүйт хүнээр дутагдах	Цагаан өвгөн	Тусын хариуд бус өөрийн хүслээр	Бие бүтэн болж, шидэт үг мэдэх
Гал улаан хаан			Түшмэдийн найман настай хүү	Заяамал чадалт	Шувуу Хөх шартай хөгшин		Ураглан хуримлах

Дээрх үлгэрүүдийг ажиглавал, “эрэл хайгуулч” болон “хохирч үлдсэн” баатрын ангиллын аль нэгэнд үлгэрийн баатар хамаарахаас шалтгаалж, тус тусын тохиолдох функц ялгаатай байна. Тухайлбал, “Бух хар нохой хийгээд бух хар шувуу”, “Тэнгэрийн Тоодог хаан” болон “Есгөлдэй өвгөний есөн хүү” үлгэрийн эхлэл хэсэгт “Анхдагч нөхцөл” (α) дурдагдсаны дараагаар зайлшгүй “Хорон санаатан”-тай холбоо бүхүй “А” функц тохиолдож байна. “Бух хар нохой хийгээд бух хар шувуу” болон “Тэнгэрийн Тоодог хаан” үлгэрт хорон санаатан нь үлгэрийн баатарт өс санасны улмаас ямарваа нэг олоход бэрх (бух хар нохой, бух хар шувуу, наян жилийн цаана наянтай уулын бэлд байдаг лам) зүйлийн эрэлд гаргаж сорьдог. Харин “Есгөлдэй өвгөний есөн хүү” үлгэрт хааны дунд хатныг олох эрэлд Есгөлдэй өвгөний есөн хүү нь зайлшгүй татагдан орж буйгаараа ялгаатай. Түүнчлэн эдгээр үлгэрийн “эрэл хайгуулч баатад” нь шидэт туслагчтай өөр өөр байдлаар учирч байна. Тухайлбал, “Бух хар нохой хийгээд бух хар шувуу” болон “Тэнгэрийн Тоодог хаан” үлгэрт хангарди шидэт туслагчийн үүргийг гүйцэтгэхийн урьдаар баатрыг сорьж, түүнээс туслалцаа авч байна. Иймээс эрэл хайгуулч баатар бүхий үлгэрийн эхлэл хэсэгт анхдагч нөхцөл (α)-ийн дараа зайлшгүй хорон санаатантай холбоотой “А” функц илэрчээ. Мөн эрэл хайгуулч баатар нь шидэт туслагчид тодорхой тус хүргэсний дараа бэрх сорил, хэцүү тэнслийг давах зүйлийг шидэт туслагчийн хүчээр авч буй нь түгээмэл байна. Харин “Есгөлдэй өвгөний есөн хүү” үлгэрийн есөн хүү бүгд өөрсдийн гэх заяамал шидэт хүч чадлаар алив саад бэрхшээлийг туулж, хааны дунд хатныг хамтын хүчээр олж авч буйгаараа онцлогтой юм.

“Хохирч үлдсэн баатар”-тай үлгэрийн эхлэл хэсэгт тохиох функц нь “Эрэл хайгуулч баатар”-тай үлгэрээс ялгаатай байна. Тухайлбал, “Эрэл хайгуулч баатар”-тай үлгэрийн эхлэл хэсэгт А” хэлбэрийн функц тохиосон бол “Хохирч үлдсэн баатар”-тай үлгэрт “α↑” функц тогтмол байгаа юм. Бид “Өнчин Бүш хүү” болон “Гал улаан хаан” үлгэрийн баатрыг “Хохирч үлдсэн баатар” ангилалд хамааруулан авч үзсэн. Эдгээр үлгэрийн “Анхдагч нөхцөл” (α)-ийн дараагаар Баатар гэрээс гарах” (↑) функц тохиолддог. Иймээс, “Хохирч үлдсэн

баатар”-т шидэт туслагч эсхүл шидэт хэрэглэл аз тохиолоор гарч ирдгээрээ “Эрэл хайгуулч баатар”-аас ялгаатай юм. “Эрэл хайгуулч баатад” ихэвчлэн өөрийн ид хав чадлаар эрж буй зүйлээ олох эсвэл шидэт туслагчийн сорилгыг давж гарснаар үйл хэргээ гүйцэлдүүлдэг билээ.

Үлгэрийн баатрын хэв шинжийг босоо баганад жагсаан, хэвтээ тэнхлэгт шидэт туслагчийн туслалцааг авах шинжийг байршуулан, хоорондын давхцалыг авч үзвэл дараах шинжтэй байна. (Хүснэгт 5)

Хүснэгт 5. Үлгэрийн баатрын заяамал болон заяамал бус чадал нь шидэт туслагчтай холбогдох хамаарал

	Заяамал чадалтай	Заяамал чадалгүй
Эрэл хайгуулч баатар	Шидэт туслагч (*Donor*) -тай холбогдох функц илрэхгүй	Шидэт туслагч (*Donor*) - ийн үйлдэл илэрнэ
Хохирч үлдсэн баатар	Шидэт туслагч (*Donor*) -ийн туслалцааг тохиолдлын байдлаар авна	Шидэт туслагч (*Donor*) - ийн тодорхой зорилготой, сайн дурын үйлдэл илэрнэ

Үлгэрийн баатар нь “эрэл хайгуулч” болон “хохирч үлдсэн” ангиллын алинд хамаарахаас шалтгаалж, шидэт туслагчийн туслалцааг авах нь ялгаатай байна. Үүнээс гадна тухайн баатар заяамал чадалтай болон чадалгүй байхаас үүдэн шидэт туслагчтай холбогдох хамаарал нь ялгаатай байдлаар тохиолдож байгаа юм. Тухайлбал, “Эрэл хайгуулч” баатартай “Есгөлдэй өвгөний есөн хүү” үлгэрийн баатад нь бүгд өөрийн гэх заяамал чадалтай. Эл үлгэрт, “...би харанхуй шөнө хар батганы мөрийг ч алдахгүй хөөж чаддаг... Далайг ганцхан балгадаг” гэхчлэн тус тусын чадлыг хэлж, түүгээрээ хааны дунд хатныг олж, хэргээ гүйцэлдүүлж байна. Иймээс уг үлгэрт төдийлөн шидэт туслагчтай холбогдох функц илэрдэггүй. Харин “Эрэл хайгуулч баатар” нь өөрийн гэх заяамал чадалгүй тохиолдолд шидэт туслагчийн туслалцааг зайлшгүй авах шаардлага бий болдог. Жишээлбэл, “Бух хар нохой хийгээд бух хар шувуу”, үлгэрийн шидэт туслагч болох хангарди нь баатрын тусын хариуд бух хар шувууг барихад тусалдаг билээ.

Заяамал чадалгүй баатарт шидэт туслагчийн туслалцаа зайлшгүй хэрэг болох нь монгол домог зүйн “Дээд тив-Тэнгэр, дунд тив-Хүмүүн, доод тив-Газар, газар доорх” хэмээх гурван тивийн үзэлтэй холбоотой. Учир нь уг үзлээр, дунд тивийн адуучин хүү, дээд тивийн жигүүртэн буюу бух хар шувуутай тэмцэн барихад бэрхшээл тулгарах учир хангардийн хүчээр баатар үйл хэргээ бүтээжээ.

Харин заяамал чадалтай баатар нь өөрийн гэх заяамал чадалтай учир түүгээрээ эрж буй зүйлээ олж, доод тивийн мангастай тэмцэж байна. Тухайлбал, “Есгөлдэй өвгөний есөн хүү” үлгэрт, есөн хүү хатныг олсны дараагаар

өөрсдийн чадлыг ашиглан мангасын мөшгилтөөс мултарч, сайн сайханд хүрдэг. Ийн үзвэл, заяамал чадалт баатар нь өөрийн эрдэм, шидэт хүчээр доод тивийн мангастай тэмцэж, бэрхшээлийг даван туулдгаараа заяамал чадалгүй баатраас ялгарна.

“Хохирч үлдсэн” ангилалд хамаарах баатар заяамал чадалтай эсэхээс хамааран мөн л шидэт туслагчтай холбогдох хамаарал нь ялгаатай байна. “Гал улаан хаан” үлгэрт гарч буй түшмэдийн хүү нь шувууны есөн хэл мэддэг тул санамсаргүй байдлаар нэгэн шувуу, “Энэ хүүхэд төмөр мунын хугархайг авбал их сайн юм байна” гэснийг сонсож, шидэт хэрэглэл болох төмөр мунын хугархайг олж үйл хэргээ гүйцэлдүүлдэг. Тиймийн учир, уг үлгэрийн баатар нь “шувууны есөн хэл мэддэг” заяамал чадлаар шидэт туслагчтай тохиолдлын байдлаар учирч, аз тохиолоор шидэт хэрэглэлээ олж авч байна. Харин “хохирч үлдсэн” баатар ямарваа нэгэн заяамал чадалгүй байх нь шидэт туслагч тодорхой зорилгоор, сайн дураар туслах нөхцөлийг бүрдүүлэх юм. Тухайлбал, “Өнчин Бүш хүү” үлгэрт Бүш хүүг эзгүй хээр газар эрэмдэг, зэрэмдэг болгон орхиж, хүндрэлтэй нөхцөл үүссэнээр шидэт туслагчийн туслалцаа шаардлагатай болдог. Ингэснээр цагаан өвгөн Бүш хүүгийн зүүдэнд ирж, шидэт үгийг зааж өгснөөр баатар алив бэрхшээлийг даван туулж байна. Иймээс “хохирч үлдсэн” баатар заяамал чадалтай эсэхээс шалтгаалж, шидэт туслагч тохиолдлоор эсхүл сайн дураар туслалцаа үзүүлэх юм.

Ийн үзвэл, “эрэл хайгуулч” болон “хохирч үлдсэн баатар” өөрийн гэх заяамал чадалтай эсэхээс хамаарч, шидэт туслагч хэрхэн туслах нь ялгаатай байна. “Эрэл хайгуулч” баатар нь монгол домог зүйн гурвал ертөнцийн үзлээр дунд тивийн эгэл хүмүүн байх агаад дээд тивийн жигүүртнийг барихын тулд шидэт туслагчийн туслалцааг авах зайлшгүй шаардлага урган гардаг. Харин уг төрлийн баатарт өөрийн гэх заяамал чадал байваас төдийлөн шидэт туслагчийн туслалцаа шаардахгүй байна. Харин “хохирч үлдсэн”, заяамал чадалгүй баатарт шидэт туслагч сайн дураар тусалдаг бол заяамал чадалтай баатар тохиолдлоор, өөрийн эрдэм чадлаар шидэт туслагчтай учирч, шидэт хэрэглэлийг олж байна.

ДҮГНЭЛТ

Бид монгол аман зохиолын төрөл зүйл болох үлгэрийн баатад ба шидэт туслагчийн холбоо хамаарлыг синтагматик анализын хүрээнд шинжиллээ. Ингэхдээ, үлгэрийн функцийн хэлхээг В.Проппын “Үлгэрийн морфологи” бүтээл дэх 31 функцийн дагуу тогтоож, баатрын ангиллыг хийснээр шидэт туслагчтай холбогдох холбоо хамаарлыг тайлан тайлбарласны үндсэнд удаах дүгнэлтэд хүрч байна.

Анхлан, “Бух хар нохой хийгээд бух хар шувуу”, “Тэнгэрийн Тоодог хаан”, “Есгөлдэй өвгөний есөн хүү” үлгэрийн баатад нь эрэл хайгуулч шинжтэй байна. Эдгээр үлгэрийн эхлэл хэсэгт анхдагч нөхцөл (α) функцийн дараа хорон санаатан (A) функц ялгаатай төрөл хэлбэрээр илэрч байна. Аливаа саад бэрхшээлээс өмнөх сайн сайхан, энгийн аж төрлийг үлгэрт дүрсэлсний дараагаар хорон санаатан (A)-ы функц тохиож буй нь баатрын эрэл хайгуулд гарах нөхцөлийг бүрдүүлжээ. Иймээс хорон санаатны функц нь үлгэр цааш өрнөх зайлшгүй суурь нөхцөл буюу зангилааг тээдгээрээ чухал юм. Мөн баатар ямарваа эрэл хайгуулд гарч, тухайн эрж буй зүйлээ олоход хүндрэлтэй нөхцөл байдал тулгарахад шидэт туслагчтай учирч байна. Эл үйл явдлыг нэгтгэвэл “хорон санаатны сэдэл - хайж буй объект - шидэт туслагч” гэх дараалалтай байна. Түүнчлэн “хохирч үлдсэн баатар”-тай үлгэрээс ялгаатай нь шидэт туслагч баатрыг сорих юм. Баатар шидэт туслагчийн туслалцааг авахаас урьд ямар нэгэн байдлаар шидэт туслагчид тохиосон бэрхшээлийг даван туулахад нь тусалдаг. Энэ төрлийн үлгэрт шидэт туслагчийн нэг болох хангарди түгээмэл байна.

Хоёрдугаарт, “Өнчин Бүш хүү” болон “Гал улаан хаан” үлгэрийн баатад нь хохирч үлдсэн баатрын ангилалд хамаарна. Ийм төрлийн үлгэрийн эхлэл хэсэгт ихэвчлэн тохиох функц нь анхдагч нөхцөл (α)-ийн араас баатар гэрээс гарах (↑) юм. Баатар гэрээс гарснаар ямарваа нэгэн адал явдалтай зайлшгүй учирдаг. Ингэснээр үлгэрийн зөрчил буюу зангилааг үүтгэж, шидэт туслагчийн туслалцаа шаардлагатай болдог. Мөн шидэт туслагч баатартай учрахдаа өөрийн сайн дураар илэрч, алив саад бэрхшээлээс чөлөөлдөг. Харин шидэт хэрэглэл нь баатрын гарт аз тохиолоор ирэх нь түгээмэл байна.

Гутгаарт, В. Проппын ангиллын дагуу үлгэрийн баатар эрэл хайгуулч, хохирч үлдсэн байхаас шалтгаалж, шидэт туслагчийн функц нь ялгаатай байна. Тухайлбал, эрэл хайгуулч баатадтай “Бух хар нохой хийгээд бух хар шувуу”, “Тэнгэрийн Тоодог хаан” үлгэрт, хангарди баатартай анх учраад мэнд мэдэж, нэр алдрыг нь асуудаг нь, шидэт туслагч баатартай учирч, асуулт тавих нь (D^2) функцтэй таарна. Харин хохирч үлдсэн баатадтай “Өнчин Бүш хүү”, “Гал улаан хаан” үлгэрт, донорын анхны үйлдэл (D), шидэт хэрэглэл баатрын гар дээр аз тохиолоор ирэх (F^5) зэрэг функц илэрчээ. Үүнээс үзвэл, “Эрэл хайгуулч” баатадтай үлгэрт, шидэт туслагч баатрыг сорьсны дараагаар туслалцаа үзүүлэх нь түгээмэл бол, “Хохирч үлдсэн” баатарт шидэт туслагч өөрийн сайн дураар туслах төдийгүй шидэт хэрэглэл аз тохиолоор таарч байна.

Дөтгөөрт, “эрэл хайгуулч” болон “хохирч үлдсэн” баатар нь заяамал чадалтай эсэхээс хамаарч шидэт туслагчтай холбогдох хамаарал ялгаатай байна. Тухайлбал, “Есгөлдэй өвгөний есөн хүү” үлгэрийн баатад болох есөн

хүү нь бүгд өөрийн гэх заяамал чадалтай учир түүгээрээ эрж буй хатнаа олж, араас нь мөшгих доод тивийн мангасаас мултардаг. Иймээс энэ төрлийн баатарт төдийлөн шидэт туслагчийн туслалцаа шаардагдахгүй юм. Харин "эрэл хайгуулч" баатар заяамал чадалгүй байх нь шидэт туслагчийн туслалцааг авах зайлшгүй нөхцөлийг бүрдүүлдэг. "Бух хар нохой хийгээд бух хар шувуу" үлгэрт, баатар дээд тивийн жигүүртэн болох бух хар шувууг барихын тулд хангардийн туслалцааг авч байна. Энэ нь дунд тивийн эгэл хүмүүн дээд тивийн жигүүртнийг барихад төдий л хүчрэхгүй учир шидэт туслагч хангарди туслалцааг авахад хүргэж буй онцлогтой. "Хохирч үлдсэн", заяамал чадалтай баатар тохиолдлын буюу санамсаргүй байдлаар шидэт туслагчтай учирдаг. "Гал улаан хаан" үлгэрийн баатар шувууны есөн хэл мэддэгийн учир санамсаргүйгээр нэгэн шувууны хэлэхийг сонсож, шидэт хэрэглэл олж авдаг. Иймээс, энэ төрлийн баатар тохиолдлоор шидэт туслагчтай учирч, эрдэм чадлаараа бэрхшээлийг даван туулдаг. Харин заяамал чадалгүй болбоос шидэт туслагч сайн дураар тусалж байна. Тухайлбал, "Өнчин Бүш хүү" үлгэрт цагаан өвгөн Бүш хүүгийн зүүдэнд ирж, шидэт үг заадаг нь баатрыг бэрхшээлээс гаргаж, сайн сайханд хүргэх зорилготой юм.

A SYNTAGMATIC ANALYSIS OF THE RELATIONSHIP BETWEEN THE HERO AND THE DONOR IN MONGOL FOLKTALES

This article examines the relationship between the hero and the donor in Mongol's folktales, a specific subclass of Mongol oral literature. It analyzes the narrative structures of five folktales including,"Bukh khar nokhoi khiigeed bukh khar shuwuu" "Tengeriin Toodog khaan", "Yusguldei uwgunii yusun khuu", "Unchin Bush khuu," and "Gal ulaan khaan". According to the 31 narrative functions outlined in Vladimir Propp's *Morphology of the Folktale*, we identified these five tale`s distinctive features. In addition, Propp's classification of heroes into "Seeker" and "Victim" types is applied to categorize the protagonists of these tales. Based on this classification, the study concludes that the type of hero whether a "Seeker" or a "Victim" influences both the progression of events and the nature of their interaction with donor.

Keywords: *Folktale, seeker hero, victim hero, donor, function*

НОМ ЗҮЙ

Эх хэрэглэгдэхүүн

Монгол ардын үлгэр. (1982), Монгол ардын аман зохиолын чуулган I. Д. Цэрэнсодном эмхэтгэж, удиртгал, тайлбар бичив. УБ., Улсын хэвлэлийн газар.

Судалгааны бүтээл

Гаадамба, Ш., Сампилдэндэв, Х., (1988), *Монгол ардын аман зохиол*, УБ., Ардын Боловсролын Яамны сурах бичиг, сэтгүүлийн нэгдсэн редакцын газар.

Батхишиг, С., Дашдэжид, С нар, (2023), *Гэсэрийн туужийн хэл, уран зохиолын судалгаа,* УБ., Соёмбо принтинг.

Дулам, С., (2001), *Монгол бэлгэдэл зүй. III боть: Дүрсийн бэлгэдэл зүй, дохио зангааны бэлгэдэл зүй*, Монгол соёлын чуулган X боть, УБ., Битпресс. Анхны хэвлэл.

Дулам, С., (2018), *Монгол буриад бөө нэрийн Цагаан өвгөний шүтлэг, тахилга*, МУИС-Профессорын өв цуврал: Домог зүй, бөө мөргөлийн судалгаа. Боть I.

Дулам, С., (2018), *Ертөнцийн модон-гурван тив*, МУИС-Профессорын өв цуврал: Домог зүй, бөө мөргөлийн судалгаа. Боть I.

Дайриймаа, Б., (2013), *Монгол ардын үлгэрийн баатруудын уран дүрслэлийн онцлог*, УБ., ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн.

Дайриймаа, Б., (2014), Шидэт үлгэрийн агуулга, бүтэц ба түүнд илрэх өгүүлэмжийн нийлэмж, *Хэл зохиол судлал VII (39)*. УБ., ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн.

Дайриймаа, Б., (2017), *Монгол ардын шидэт үлгэрийн өгүүлэмж*. УБ., ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн.

Даваадорж, И., (2022), *Монгол аман зохиол дахь шидэт зүүдний дүр, өгүүлэмж*, Магистрын зэрэг горилсон бүтээл. УБ., МУИС.

Даваадорж, И., (2023), Монгол үлгэр, тууль дахь хатдын зүүдний өгүүлэмжийг шинжлэн үзэх нь, *Оюуны хэлхээ эрдэм шинжилгээний бичиг.* I (24). УБ., Бэмби сан.

Золбоо, Б., (2025), Монгол үлгэр дэх шидэт туслагчийн дүр, өгүүлэмж, *Эрдмийн хэлхээ XIV боть*. УБ., Арвай бархан хэвлэлийн газар.

Нандинбилиг, Г., (2018), *Эх зохиолыг задлан шинжилж үнэлэх арга зүй*. УБ., МУИС пресс.

Нандинбилиг, Г., Дулам, С нар., (2022) *Монгол аман зохиолын онол II: Хүүрнэн өгүүлэх аман зохиол, Жүжиг наадмын аман зохиол*. Монгол соёлын чуулган V боть. УБ., Соёмбо.Анхны хэвлэл: 2020.

Нямсүрэн, Ц., (2015)., *Монгол, Грек туульсын бүтцийн анализаар харьцуулан судалсан нь,* Докторын зэрэг горилсон бүтээл. УБ., МУИС.

Орхон, Б., (2017)., *Тэмдэг судлал ба эхийн тэмдгийн задлал,* Магистрын зэрэг горилсон бүтээл. УБ., МУИС.

Хорлоо, П., (1962)., *Монгол ардын явган үлгэр*, УБ., Эрдэм шинжилгээний хэвлэх үйлдвэр.

Уганбаяр, М., (2023)., *Сэдвүүд I*, УБ., Соёмбо принтинг.

Гадаад хэлээрх бүтээл

Gervás, P., (2013)., *Propp's morphology of the folk tale as a grammar for generation*. Schloss Dagstuhl.

Lèvi-Strauss, Claude., (1969), *The Raw and the Cooked. Introduction to a Science of Mythology.* Volume I. New York: Harper&Row.

Propp, V., (1968 [1929]), *Morphology of the Folktale*. University of Texas press.

Sapna Dogra., (2017), *The Thirty-One Functions in Vladimir Propp's Morphology of the Folktale: An Outline and Recent Trends in the Applicability of the Proppian Taxonomic Model*. Rupkatha Journal on Interdisciplinary Studies in Humanities, 410-9.

Товчилсон үгийн жагсаалт

MAY Монгол Ардын Үлгэр

ХАВСРАЛТ 1. “БУХ ХАР ШУВУУ ХИЙГЭЭД БУХ ХАР НОХОЙ” ҮЛГЭРИЙН ЗАДЛАЛ

Функц	**“Бух хар нохой хийгээд бух хар шувуу” үлгэр**[49]
α Анхдагч нөхцөл	Эрт урьдын цагт нэг сүрхий залуу хатантай өтөлсөн хаан байж гэнэ.
A^8 Хорон санаатан хохирогчоо ятгах, уруу татах	Энэ хатан нь хааныхаа адууны хүнд дурлаж элдэв аргаар аргалан аль бүх сайныг хэлж, эд мөнгөөр өдөөж, өөрийн зүгтээ татахаар оролдсон ч адуучин залуу ер ойшоохгүй байжээ.
A^8 - A^{16} Хорон санаатан хохирогчоо ятгах, уруу татах Хүчээр гэрлэхээр айлгах	Ингэхэд энэ харгис хатан дотроо их л хорсож хаандаа хэлсэн нь “Сонсвол тэр баруун хойно түмэн эр дийлдэггүй Бух хар нохой хийгээд Бух хар шувуу гэж байдаг гэнэ. Хэрэв энэ хоёр амьтныг барин авчирч Бух хар нохойгоор нь хот хашаа сахиулж, бух хар шувуугаар нь адуу малаа хариулуулбал хот хашаанд минь халдах дайсангүй болж, хонгор гуу дүүртэл адуу мал үржинэ.
A^8 Хорон санаатан хохирогчоо ятгах, уруу татах	Гэвч хэн явж энэ хоёр амьтныг авчирч чадах вэ?...Одоо энэ адуучин хүүг явуулж барьж ир гэвэл тэр муу амьтан очин амиа өгөхгүй хаа явна...Би үзвэл танай тэр адууны залуу идэрхэг баатар маягтай. Түүнийг явуулбал олж ирэх магадгүй.
B^2 Баатар шууд яван одох	...Хаан даруй зарлиг буулгаж, адууны залууг дуудан авчраад тушаасан нь Чи баруун хойш явж, Бух хар нохой хийгээд Бух хар шувууг барьж ир! Үгүй бол толгойг чинь авна.
↑ Баатар гэрээс гарах G^2 Баатар газар дээр эсвэл усан дээр явах	Тэгээд адуучин хүү аргагүй энэ хатны хорт санаа байна гэж бодоод мориндоо мордож, өндөр уургаа атгаж явсаар...
o Баатар харь газар нутагт ирэх	...морио унаж, ухаа толгойг давж гараад үзсэнд нэгэн цагаан хас гэрт...
ζ^2 Урвуу хамааралтай функц. Харилцан хамааралтай хариулт.	...Тэгээд адууны хүн очиж асуусанд энэ гурван охины хэлсэн нь бид гурвуулаа Хангардийн арван гурван охины хамгийн бага гурав нь билээ. Бидний арван эгчийг аварга могой өдрийн нэгийг залгисаар...бидний энэ өдөр залгигдах нь уйлж, маргаадар залгигдах нь дуулж, нөгөөдөр залгигдах нь инээж байна
A^{14} Хорон санаатан аллага үйлдэх	Бидний арван эгчийг аварга могой өдрийн нэгийг залгисаар...
ζ^2 Урвуу хамааралтай функц. Харилцан хамааралтай хариулт	...Таны ээж чинь юунд та нарыг хамгаалахгүй вэ” гэсэнд “Ээж минь хэдэн удаа аварга могойтой тулалдаж дийлсэнгүй” гэж хэлжээ.
H^1 Баатар, хорон санаатан нар задгай талбайд тулалдах нь	...Үүнийг үзээд гэнэт морио ташуурдан давхиж, ойртон очоод урт уургаа даллаж, хүзүүнд нь хаян оруулаад, хүчний чинээгээр мушгиж...

[49] *Монгол ардын үлгэр* (Монгол ардын аман зохиолын чуулган I). (1982). Д. Цэрэнсодном эмхэтгэж, удиртгал, тайлбар бичив. УБ., Улсын хэвлэлийн газар, х.86-89.

I^1 Хорон санаатанг задгай талбайд буулгаж авах	...Хүдэр их могойг хөдөлгөхгүй боомилсонд аварга могой бачимдаж,амь тэмцэн үсэрсэнд уургын шижмийн эрч нь чангарч, урван хөрвөн дутаахын зайгүй болж, хий амьсгаа нь бөглөрч, хэцүү сүүлээрээ гуядсаар үхэв гэнэ.
D^2 Шидэт туслагч үлгэрийн баатартай учирч асуулт тавих нь.	…Тэгээд адуучин хүү нуугдан сууж байтал алс өмнөөс нэгэн хэсэг хар үүл харвасан сум шиг түргэн нисэж ирээд… Хангарди үлдсэн гурван охин нь нэг ч дутуугүй бөгөөд их л баяртай байхыг үзээд “Аварга могой ирсэнгүй юу?” гэж асуужээ. Охидын хэлсэн нь Энэ өдөр нэг адуучин залуу ирж, аварга могойг уургалж боомилж алав” гэсэнд Хангарди их л баярлаж “Тэр адуучин залуу хаа байна!” Ингээд адуучин хүүг хангарди эхтэйгээ уулзуулсанд хангардийн хэлсэн нь “Хүү минь их баатар байна. Бидний дайсан аварга могойг алж, охидын минь амийг аварсанд чинь ачийг чинь хариулна...Хүү аль нутгийн хүн бэ? Алсын зорилго юунд вэ?
E^2 Баатар шидэт туслагчийг мэндлэхэд хариу өгөх, өгөхгүй	Бух хар нохой хийгээд Бух хар шувууг барихаар явж байна.
	Энэ харин бэрхтэй явдал байна. Гэвч ээж нь чамд тусалж өгье” гэжээ.
K^2 Хайж буй объектыг хэд хэдэн хүмүүс өөрсдийн үйлдлээр тус тус хурдтайгаар солилцон олж авах	Тэгээд гурван өдөр бэлтгэл хийж, Хангарди нэг хатуу төмөр дэгээ хийж аваад хоёулаа явж...Хангардийг шуудхан ирэхэд Хангарди шуудхан хатуу төмөр дэгээгээрээ нэгэнт гохдож, Бух хар шувууг барьж авав. Бух хар нохой нь адуучин хүүг барьж идэхээр гүйн ирэхэд хүү алав хийж чихдэн мордоод цохисоор номхон болгож авчээ.
K^4 Баатар хайж буй зүйлээ өмнөх үйлдлийн үр дүнд олж авах N Баатар даалгаврыг биелүүлж дуусгах	Тэгээд адуучин хүү Хангардид гүн талархал хийж салаад Бух хар шувуугаа мөрөн дээрээ суулгаж, Бух хар нохойгоо дагуулж...
↓ Баатар гэртээ ирэх	...Нутагтаа харьж ирэхэд хаан сургийг нь сонсоод их л айж.
U хорон санаатан шийтгэгдэх	...Хатан нь хамаг сайхан заслаа гаргаж чимэглээд адуучин хүүг угтан ирэхэд Бух хар нохой хийгээд Бух хар шувуу нь хамтаар очиж хатныг хоёр тийш нь салгаж идэв гэнэ.
W_* Баатар хаан ширээнд суух	Тэгээд адуучин хүү хаан ширээнд сууж, Бух хар нохойгоороо хот хашаагаа сахиулж, Бух хар шувуугаараа адуу малаа хариулгаж амар сайхан жаргаж суув гэнэ.

ХАВСРАЛТ 2. “ӨНЧИН БҮШ ХҮҮ” ҮЛГЭРИЙН ЗАДЛАЛ

Функц	**“Өнчин Бүш хүү” үлгэр**[50]
α Анхдагч нөхцөл	Хэзээний эрт цагт тариач хааны нутагт Өнчин Бүш гэдэг хөвүүн Түс гэдэг годилтой, аяганы чинээ нууртай байдаг санжээ.
↑ Баатар гэрээс гарах	Аяганы чинээ нууртаа атга чихэр зуурч орхиод, гэр дээр гараад эрхийгээрээ доордоод харуул харж байтал нь аяганы чинээ нуурт нь алтан дэлхийн шувууд цугаар цугларсан байна.
	Түүнийг Бүш хөвүүн үзээд Түс гэдэг годилоо аваад харваад орхисон чинь гучин шувууны гуяар нь тусаад, тавин шувууны тахимаар нь тусаад, жаран шувууны жигүүрээр нь тусаад, далан шувууны далаар нь тусаад, зуун шувууны зоогоор нь тусаад тогтохдоо тогоруу галуу хоёр авав.
G^2 Баатар унаа хөлөглөх o Баатар эзэн хааны нутагт ирэх	Урт тоо нь гурван зуун арван хоёр шувууд болсныг Бүш хөвүүн, хар халзан бяруундаа эмээл тохоод тэр шувуугаа цугаарыг ачаад бие нь ч мордоод, хар халзан бяруугаа хаагаар нь цохиж, хавчгалзуулаад гуяар нь цохиж гувчгалзуулаад дал дундаар нь цохиод, татаж ядаж мэхэлзүүлээд хааны өргөөн дээр хүрээд одов.
(ε^1)neg Хорон санаатан хүүхдийн байгаа газрын байршлыг эсвэл үнэ цэнтэй эд зүйл олохыг оролдох.	Шувуугаа оруулж өргөөд, Бүш хөвүүнийг суухлаар нь хаан зарлиг болов: “Чи юун хөвүүн бэ? Энэ чинь юун олон шувуу вэ?” гэсэнд...
ζ^2 Урвуу хамааралтай функц. Харилцан хамааралтай хариулт.	...Таны зэргэлдээх нутагт байдаг албатын нэг муу өнчин хүү би. Нэр минь Бүш. Аяганы чинээ нууртай билээ би, аяганы чинээ нуурт минь алтан дэлхийн шувууд ирээд цугларсанд, Түс годилоо аваад харваад орхисон минь гурван зуун арван хоёр шувуу алагдав.
a^1 Сүйт бүсгүйгээр дутагдах (эсвэл найз, хүнээр дутагдах). Гоонь баатар сүйт бүсгүйгээ эрэх	Тэгээд үүнийг хаандаа хурим өгөөд хааны отгон хар хүүхэнд хэлсүү би гэж ирэв би.
A^{13} Алахыг тушаах	Тэр үгэнд хаан цухалдаад “Миний хүүхэнд хэлдэг элмэрийг нэг гар, нэг нүд, нэг хөлийг нь аваад эзгүй ээрэм цагаан хөдөөд авч одоод хаяж орхигтун!...
J Баатар шархтах	...гэвэл хааны зарлигаар хөтөч нар хөвүүний гурван мөчийг аваад, хээр эзгүй хөдөөд авч одоод хаяж орхив.

[50] *Монгол ардын үлгэр* (Монгол ардын аман зохиолын чуулган I). (1982). Д. Цэрэнсодном эмхэтгэж, удиртгал, тайлбар бичив. УБ., Улсын хэвлэлийн газар, х.93-96.

D донорын анхны үйлдэл	Тэгээд Бүш хөвүүн үргэлж бархирч хэвтээд ухаан нь мансуурчээ. Үхэхэд шадардаж байхад зүүдэнд нь нэг цал буурал цагаан сахалтай өвгөн цагаан мөнгөн таяг гартаа барьж ирээд “Хөвүүн амаа ангай” гэв. Хөвүүн амаа ангайсанд өвгөн аманд нь нулимж орхиод, дээжээр нь цагаан мөнгөн таягаараа хоёр гурав цохиод “За хөвүүн, хөл гар нүд чинь эдгэх. Мууд үзсэн хүнийгээ “наалданхаш” гээ, сайнд үзсэн хүнийгээ “бусраад” гээ гэж хэлээд явж одсон болж...
Баатар шидэт туслагч эсвэл шидэт үйл хэргийн тусламжтайгаар шинэ дүр төрхтэй болох T^1	...зүүдэнд нь мэдэгдсэн даруй сэрэх нь ээ хөл гар нүд нь цугаар ургаад байжээ
D^{10} Баатар солилцоонд авсан шидэт эдлэл хэрэглэлээ гаргаж ирэх (Баатар шидэт хэрэглэлээ турших байж болно)	Өмнө нь хааны үхэрчин хүүхэн тугал хариулж явсныг үзээд “Саях миний зүүдэнд үзсэн өвгөн “Мууд үзсэнээ наалданхаш сайнд үзсэнээ бусраад гэж хэл гэсэн эс бил үү? Үнэн худлыг нь үзье” гэж санаад Үхэрчин хүүхэн тугалуудтайгаа газартай наалданхаш гэж гэсэнд хүүхэн дороо тугалуудтайгаа газартай наалдаад хашхираад хэвтэв. Хөвүүн түүнээс нь “Өвгөний хэлсэн үнэн санж уу?” гээд бусраад гээд орхитол нь хүүхэн тугалуудтайгаа босоод гүйгээд одов.
↓ Баатар гэртээ ирэх	Тэгээд хөвүүн итгэж мэдээд, гэртээ харьж ирээд байв.
D^{10} Баатар солилцоонд авсан шидэт эдлэл (үг)-ээ гаргаж ирэх	Тэгж байгаад хэзээ нэг шөнө хаанаас өсөө авъя гэж санаад, шөнө дүлийн цагт хаан нойрссон хойно хана тусад нь ирээд “Хаан хатан ортойгоо, дэртэйгээ газартайгаа наалданхаш” гэж хэлээд харьж ирэв. Маргааш өглөө нь хаан хатан хоёр шөнө орондоо наалдаад босож чадахгүй гэх занги албатаар шуугиад, түшмэл сайд, нутгийн өвгөд айх зовох цугаар тэгш болоод, арга хорго бэдэрчээ. Гүрэм хэрэг зэрэг хийвч, тусгүй болсонд эмч цуглуулж үзүүлсэнд эмч домч, эмнэлэг домнолго хийвч тусгүй болсонд ямар арга хийвч эс туслаад байв.
D^{10} Баатар солилцоонд авсан шидэт эдлэл (үг)-ээ гаргаж ирэх	Тэгээд албатын түшмэл өвгөд цугларч. Одоо арга яавал сайн болох вэ? гэж хүүрнэлдээд хийж байсанд нутгийн захад байдаг нэг хүү ирж хэлэхдээ Энд Могойт хааны нутагт нэг сайн бөө хүн байна гэдэг зангитай билээ. Газар нь хол, зуур дайсан олон юм болдог» гэсэнд түшмэлүүд зөвшиж Одоо түүнд ямар хөвүүн илгээх вэ?, ямар морь явах вэ? Олноор явуулах буюу цөөхнөөр нь явуулах буюу? гэж байтал...
B^2 Баатар шууд яван одох	...гэнэтхэн Бүш хөвүүн: «Би олох, намайг илгээгтүн. Хааныхаа төлөө явж яваад би үхэвч хэрэггүй мөн» гэсэнд сайд түшмэлүүд зөвшөөрөөд «Яв» гэв.

G^2 Баатар газар дээр эсвэл усан дээр явах	Тэгээд Бүш хөвүүн хар халзан бяруугаа унаад хаагаар нь цохиж хавчгалзуулаад, гуягаар нь цохиж гувчгалзуулаад, дал дундхаар нь цохиж, татаж ядаж, мэхэлзүүлээд өдөр гэж өнжилгүй, шөнө гэж хонолгүй, яваад...
о Баатар эзэн хааны нутагт ирэх	...Могойтой хааны оронд хүрээд бөөг олж одоод хааны шалтгаалсныг хэлээд...
G^2 Баатар газар дээр эсвэл усан дээр явах	“Таныг залахаар ирэв би” гэж ирсэнд бөө хүн цагаан малгайгаа өмсөөд, цагаан дээлээ өмсөөд, цагаан морио унаад гараад явав. Тэгээд бас өдөр гэж өнжилгүй, шөнө гэж хонолгүй яваад, хаандаа шадардаж ирээд, хааны өргөөний өрх үзэгдэхийн цагт бөө хүн эхлээд урьдлав: Нээ (зээ!) мэдэж орхив би одоо. Хол биш, хотонд нь байна. Чив чиги бариад өгөх би. Чив чиг хаагаад өгөх би. Айх минь чиг үгүй, нуух минь чиг үгүй» гээд уучлаараа (завжаараа?) хөөс бүрхүүлж орхиод, бураад буцлаад явахлаар нь Бүш хөвүүний санаанд Энэ бөө хүн намайг барьж өгөх л бий. Одоо үүнд юун арга хийсүү би гээд бөө хүнд хэлэв.
D^{10} Баатар шидэт эдлэл хэрэглэлээ гаргаж ирэх эсхүл турших	Ер та харь хүн очоод морь үзнэ гэж явахаар энэ аглаг газарт бууж морио үзээд явах тань! гэсэнд бөө хүн чуу гэж буугаад мөрөө үзэж суутал нь Бүш хүү Бөөгийн бөгс газартай наалданхаш гэв.
D^{10} Баатар шидэт эдлэл хэрэглэлээ гаргаж ирэх эсхүл турших	Нааш бууж тат. Би газартай наалдаад одов гэж дуудсанд буугаад хөвүүн татавчиг хуурч эс гарсанд хөвүүн бөөг...
↓ Баатар гэртээ ирэх	...дор нь орхиод бөөгийн морийг хөтлөөд хааны тал харьж ирээд...
K^5 Баатар шидэт хэрэглэлийн тусламжтайгаар хайж буй зүйлээ олж авах.	...түшмэлүүдэд бөө хүн зуураа наалдсаныг хэлэв.
ζ^1 Хорон санаатан өөрийн асуусан асуултынхаа хариуг шуудхан авах ζ^2 Урвуу хамааралтай функц. Харилцан хамааралтай хариулт.	Тэгээд бөөгийн суусан газарт түшмэлүүд «Одоо энэ хааны арга юу болох вэ?» гэж сурсанд бөө хүн «Танай хааны арга мэдэх байтугай өөрийн биеэ яаж аргалсу гэж байна» гэсэнд түшмэлүүд харьж иржээ.
γ^2 Тушаах эсвэл зааврыг биелүүлэх	Бөөгийн наалдсаныг хааны заргад мэдүүлэн, одоо арга юунд болох вэ гэж чуулсанд хаан зарлиг болов: «Яагаад боловч арга хайгтун!» гэв. Тэгээд сайд түшмэлүүд, нутгийн өвгөнүүд зөвшиж «Энэ хаан хатан хоёрыг эдгээсэн хүнд хөвүүн хүн эдгээвэл хааны отгон харагч хүүхэн өгөөд албатын өрөөлийг мэдүүлье, хүүхэн хүн эдгээвэл хааны хатан болгоё» гэж шийдээд дуудлага дуудав.

η^1 Ид шидэт хэрэглэлийн тусламжтайгаар үйл хэргээ биелүүлэх гэж оролдох.	Тэгээд ч эдгээх хүн эс олдсонд Бүш хөвүүн түшмэлүүдэд ирж хэлэхдээ Ер би удган бөө залснаас мэдэх биш, өөрийн хувийг мэдэх биш, би эдгээх ёр надад ороод байна» гэвэл түшмэлүүд: Болов эс болов эмнэ гэв. Тэгээд Бүш хөвүүн гурван хоногт ном уншмар болж, үлээмэр болж, олон зүсийн хот идээ өгч байгаад дөрөвдөгч өдөр нь Бүш хөвүүн «бусраад» гэх үгийн өрөөлийг нь хэлсэнд хаан хатан хоёрын наалдсан өрөөл нь хуураад өрөөл нь эс хуурсанд Бүш хөвүүн бас үлээмэр тарнидмар болоод ядаад байсанд түшмэлүүд хөвүүнд хэлэв. «Энэ өрөөл нь хуурсан юм. Өрөөл нь юун гээд эс хуурна. Үүнд юү түйтгэр болов?» гэж сурсанд. Бүш хөвүүн хэлэв: «Ер би мэдэх биш, олон амьтны хувь (заяагаар) нэг болох. Нэрийдсэн барьцаа бариагүй болоод тороод байна уу, яана уу гэж санана би» гэсэнд түшмэлүүд «Тийм чиг лав болох» гэж мэдээд тэр үгийг нь хаан хатанд мэдүүлсэнд хаан хатны зарлиг: «Тэгвэл барьцыг үтэрхэн өгч маныг зовлонгоос тонилгогтун» гэж захисанд...
K^5 Баатар Шидэт хэрэглэлийн тусламжтайгаар хайж буй зүйлээ олж авах.	түшмэлүүд хааны хүүхнийг Бүш хөвүүнд өгөв албатын өрөөлийг хувааж өгөв.
W Баатар гэрлэж, хаан ширээнд суух	Тэгээд Бүш хөвгүүн хааны хүүхэн аваад, маргаадар нь ирж хаан хатан хоёрыг босгов. Тэгээд хаан хатан хамаг албат түшмэлүүд, сайд бүгдээрээ ихэд баясаж, баярын хурим хийж амран жаргав. Бүш хөвгүүн ч хааны хүүхэн аваад, албатын өрөөлийг нь мэдээд аль санаснаараа жарган суув. Тариач хааны нутгийн өнчин Бүш хөвгүүн Түс годилтын үлгэр төгсөв.

ХАВСРАЛТ 3. “ТЭНГЭРИЙН ТООДОГ ХААН” ҮЛГЭРИЙН ЗАДЛАЛ

Функц	**“Тэнгэрийн Тоодог хаан” үлгэр**[51]
α Анхдагч нөхцөл	Эрт урьд цагт Тэнгэрийн Тоодог хаан гэж байжээ. Тэр хааны дотоод хэргийг захирсан Сонжоодой сайн түшмэл, гадаад хэргийг захирсан Бандидай муу түшмэл гэж байжээ. Дотоод хэргийг захирсан Сонжоодой сайн түшмэл гэдэг нь олон жил хаан төрийн алба хаахдаа алдаа дутагдал ер гаргаагүй учраас солигдож халагддаггүй байжээ.
A^9 Хорон санаатан хэн нэгнийг хөөн зайлуулах	Тэгтэл гадаад хэргийг захирсан Бандидай муу түшмэл гэгч нь дотоод хэргийг захирсан Сонжоодой сайн түшмэлийн алба хэргийг хийж түүн шиг сайн түшмэл болох сон гэж олон жил боддог байв. Тэгээд Сонжоодой сайн түшмэлийг яаж ажил албанаас нь холдуулах вэ? гэдэг арга бодож суудаг гэнэ.
A^9 Хорон санаатан хэн нэгнийг хөөн зайлуулах	Ингээд наян жилийн цаад талд Наянтай уулын тэртээх нарийн цагаан бургасанд нэг лам агуйлан суудаг гэж Бандидай муу түшмэл сонсоод нэг өдөр хаанд бараалхаж, “Манай Сонжоодой сайн түшмэл эрдэм билиг төгс ийм сайн түшмэл юм уу? Үүнийг яагаад халж сольдоггүй юм бэ? гэж асуухад Тэнгэрийн Тоодог хаан, Энэ бол эрдэм билиг сайн түшмэл байгаа юм. Хэрэв үүнийг халж солих юм бол ийм эрдэм билиг төгс хүн олдохгүй учраас халж сольдоггүй юм гэжээ. Ингэхээр нь Бандидай муу түшмэл, Наян жилийн наана Наянтай уулын тэртээх нарийн цагаан бургасны агуйд лам гэж нэг их алдартай сайн лам дуулдах юм. Үүнд Сонжоодой сайн түшмэлийг явуулж, залж ирээд энэ орон нутагтаа бурхан шашин дэлгэрүүлж номын авшиг жинан (ном хүртэх эрх олох) хүртвэл яадаг юм бэ? Та үүнийг соёрхвол Сонжоодой сайн түшмэлд зарлиг тушаал өгнө үү! гэж Бандидай муу түшмэлийг гуйхад нь, Алба хэргийг би хэнд өгөх вэ дээ? гэж Тэнгэрийн тоодог хаан хэлжээ. Тэгэхээр Бандидай муу түшмэл түүнийг иртэл би алба ажлыг хааж байя. Та даруй явуулж өгөөч гэж дахин гуйхад нь...
В Золгүй явдал тохиосныг баатарт мэдэгдэнэ. Тушаалаар баатар явахаар болно. Эрэл хайгуулч баатрын анхны функц	Тэнгэрийн Тоодог хаан Сонжоодой сайн түшмэлийг дуудан ирүүлээд, Чи миний төрийн албанд хамгийн олон жил алба хаасан итгэлт сайн түшмэл билээ. Иймд наян жилийн цаад талд Наянтай уулын энгэр дээр байдаг нарийн цагаан бургасны агуйт ламыг залж энэ орон нутагтаа бурхан шашин дэлгэрүүлж номын авшиг жинан хүртье! Гэж тушаагаад унаа хөсөг ч өгөлгүй явуулах болжээ.

[51] *Монгол ардын үлгэр* (Монгол ардын аман зохиолын чуулган I). (1982). Д. Цэрэнсодном эмхэтгэж, удиртгал, тайлбар бичив. УБ., Улсын хэвлэлийн газар, х.100-107.

↓ Баатар гэртээ ирэх	Дараа нь Бандидай муу түшмэл орж ирээд, за та түүнд тушаал зарлиг өгөв үү? гэж асуухад нь Тэнгэрийн Тоодог хаан, Би хэллээ, Сонжоодой сайн түшмэл явж агуйт ламыг залж ирнэ, чамд алба хэргийг нь хүлээлгэн өгнө гэхэд Бандидай муу түшмэл баярлан гарч гэртээ их л баяр хөөртэй ирж гэнэ. Дараахан нь Тэнгэрийн Тоодог хаан хоёр түшмэлийг дуудан ирүүлж алба ажлыг нь тушаалгаад Сонжоодой сайн түшмэлийг гэрт нь явуулжээ.
↑ Баатар гэрээс гарах	Тэр буцаж ирээд, би наян жил явж, Наянтай уулын тэртээд гараад, амьд ирнэ гэхэд бэрх байна. Намайг эргэж ирэхгүй, бараг тэр чигээрээ явчихсан гэж бодож байгаарай гэж хэлээд хавчиг үүрэг хийж үүрээд, наян жилийн тэртээ байдаг Наянтай уулын энгэрт гарахаар явжээ.
J Баатар шархтах	Сонжоодой сайн түшмэл хэд хоног явж байгаад олон жил суурин газар суусан болохоор ул таваг нь хавдаж, явж чадахгүй болжээ. Хэд хоногийн дараа Сонжоодой сайн түшмэл нэг өндөр уулын орой өөд өгсөж явахдаа өчнөөн төчнөөн хоног зовж, зүдэрч ингэж үхэхээр энэ уулын модноос боож үхвэл дээр гэж гэнэт бодоод, бүсээ тайлж, хүзүүгээрээ оосорлоод нөгөө үзүүрийг нь нэг модны оройгоор гогодож авснаа энэ уулын орой дээр гарвал аандаа намайг идэх хортон дайсан ч дайралдах юуны магад хэмээн бодож бүсээ тайлж бүсэлчхээд...
D донорын анхны үйлдэл	...хавчиг үүргээ аваад даваан дээр гартал цаад талд нь нэг том хар юм нэвсийн хэвтэж байхыг хараад, энэ чинь л намайг идэх магадгүй гэж бодоод, яаруу сандруу бууж, нөгөө амьтан дээр гүйн очвол нэг Хангарди аварга могой залгиад ухаа алдан хэвтэж байна гэнэ.
E[7] Баатар өөрөө туслалцаа үзүүлэх	Сонжоодой сайн түшмэл энэ агуу том амьтан хоолноос болж, алтан амиа алдах гэж ийнхүү хэвтэх нь яасан өрөвдөлтэй юм бэ? гэж бодоод Хангардийн толгойг нь илж суутал түүний хахаа гарч, аварга могойгоо залгичхаад Сонжоодой сайн түшмэлийг харангуут...
D[2] Шидэт туслагч баатартай учирч, асуулт тавих нь	...Чи хэн хааны үр вэ? Хэтийн зориг юунд вэ? Аль хааны үр вэ? Алсын зориг хэнд вэ? гэж асуухад нь Сонжоодой сайн түшмэл...
E[2] Баатар шидэт туслагчийг мэндлэхэд хариу өгөх	...Би Тэнгэрийг Тоодог хааны албат Сонжоодой сайн түшмэл гэдэг байна. Наян жилийн цаана, Наянтай уулын энгэрт байдаг нарийн бургасны агуйт ламыг залахаар явна гэжээ.
E[1] Баатарт шидэт хэрэглэл олгох	Аа тэгвэл алтан амийг минь аварсан ач тустай нөхрийн ажил хэрэгт тусална. Та над дээр суугаад яв гэж Хангарди хэлжээ.
G[1] Баатар агаар дээр нисэх	Тэгээд Сонжоодой сайн түшмэл хангарди дээр суугаад...

	...явж байтал тэртээ дор нэг их цагаан халзан өргөөтэй баян айлынхан харагдаж байна гэнэ. Тэгэхээр нь Сонжоодой сайн түшмэл, - Энэ ямар айл байдаг юм бэ? гэж хангардиас асуухад - Энд Цагаан лус хааных байгаа юм. Та очиж унд хоол зооглож ир! Хүлээж байя гээд буужээ.
γ^2 Хүссэн, санал болгосон хүсэлт	Сонжоодой сайн түшмэл Цагаан лус хааныд очиж хоол цай идэж уугаад явж байгаа учраа ярихад нь та буцах замдаа тэр агуйт ламыгаа манайхаар дайруулж цай зооглуулаад яваарай. Бид номын авшиг жинан хүртье. Шанд нь танд юу авах гэсний чинь өгнө гэж Цагаан лус хааных хэлжээ.
G^1 Баатар агаар дээр нисэх	Тэгээд хангарди дээрээ суугаад цаашаа явж байтал бас нэг их ногоон халзан өргөөтэй баян айл харагдаж байна гэнэ. Энэ ямар айл байдаг юм бэ? гэвэл энэ бол Ногоон лус хааных байгаа юм. Та очиж хоол унд зооглоод ир гэж хангарди хэлжээ.
	Тэгэхээр нь Сонжоодой сайн түшмэл буугаад очтол, танай нутаг хаана вэ? Хаа хүрч явна гэж Ногоон лус хааныг асуухад нь, Би Тэнгэрийн Тоодог хааны албат Сонжоодой сайн түшмэл гэдэг байна. Наян жилийн цаана Наянтай уулын энгэрт байдаг нарийн цагаан бургасны агуйт дамыг залахаар явж байна гэхэд, Та буцах замдаа тэр ламыгаа манайхаар дайруулж, цай зооглуулаад яваарай. Бид ламын авшиг жинан хүртье гэж Ногоон лус хааных хэлж гэнэ.
	Тэгээд цаашаа явж байтал нэг их улаан халзан өргөө бүхий баян айл бас дайралджээ. Энэ ямар айл вэ? гэж асуувал, Энэ Улаан лус хааных байгаа юм. Та очиж унд хоол зооглоод ир гэж хэлжээ. Сонжоодой сайн түшмэл буугаад Улаан лусын хааныд очиж агуйт ламыг залж ирэхээр явж байгаагаа ярихад нь бас Улаан лус хааных та буцах замдаа тэр ламыгаа манайхаар дайруулж цай зооглуулаад яваарай. Бид номын авшиг жинан хүртье гэж гуйжээ. Тэгээд Сонжоодой сайн түшмэл Хангарди дээрээ суугаад цаашаа явж наян жилийн цаана байгаа Наянтай уулын тэртээ гараад нарийн цагаан бургасанд буух гэтэл Хангарди багтсангүй гэнэ. Тэгэхээр нь хөдөө дэнж дээр буугаад нарийн цагаан бургасанд эргэж иртэл, хэдэн цагаан гэр байж гэнэ.
К Баатар золгүй явдал эсвэл өөрт дутагдсан зүйлийг шийдвэрлэнэ	Хамгийн том гэрт ортол агуйт лам гэртээ морилж байв гэнэ. Амрыг нь эрэхэд хариу мэндлээд…
	Аль хааны албат вэ? Алс юманд явна уу? Гэж асуухад нь Тэнгэрийн Тоодог хааны албат, Сонжоодой сайн түшмэл гэдэг би байна. Таныг орон нутагтаа залж, бурхан шашин дэлгэрүүлэн номын авшиг жинан хүртэх гэж явна гэжээ. Тэгэхээр нь би танай нутагт нэг очих түүхтэй юм даг. Харин чи ямар унаа хөсөгтэй гэж Сонжоодой сайн түшмэлээс асуухад нь унаа хөсөг сайтай гэсэнгүй, муутай ч гэсэнгүй түгдрэхдээ гараад явжээ. Тэгээд Хангарди дээр ирэхэд…

	Өнөө лам чинь байна уу? Та уулзав уу? гэж асуужээ.Гэртээ байна. Тэгэхдээ мянган тэмээ ачаатай явна гэнэ. Чи хөсөг хөтөл сайтай ирсэн үү? гэж асуухад нь би юу ч хэлж чадсангүй. Түүнийг яах билээ гэж бодоод чам дээрээ ирж байгаа нь энэ дээ гэв.
D Донорын анхны үйлдэл	Мянган тэмээ ачаа байтугай хлёр мянган тэмээ ачаатай явсан ч болно. Миний хөлөглөж ирсэн унаа танай энэ нарийн цагаан бургасанд багтахгүй болохоор би унаагаа нэлээд алсхан орхисон билээ. Харин та энэ хавийнхаа хүн амьтныг цуглуулж хүргүүлнэ үү гэж хэлээд ир гэжээ.
G[1] Баатар агаар дээр нисэх	Миний унаа нарийн цагаан бургасанд багтахгүй тул хөдөө зайдуу орхиод ирсэн билээ. Иймд та энэ хавийнхаа хүмүүсийг цуглуулаад ачаа бараагаа тэнд хүргүүлнэ үү гэсэнд Агуйт лам “Энэ ийм том хөлөгтэй хүн лав их сүрхий байж таарна. Явалгүй болохгүй” гэж бодоод гурван өдөр хавт ойрынхоо хүмүүсийг цуглуулаад авдар савтай юм өчнөөн төчнөөнийг Хангардийн нуруунд ачжээ. Тэнд гурав хоноод Агуйт лам хоёр шаана авч, Сонжоодой сайн түшмэлтэй дөрвүүлээ Хангардийн далавчин дээр суугаад...
W Баатар гэрлэх	...буцаж явтал Улаан лус хааных замд дайралдахад Сонжоодой сайн түшмэл, Энэ Улаан лус хааных буцахдаа таныг буулгаж цай зооглуулаад яваарай гэсэн юм. Та буух уу гэхэд за тэгье гэж Агуйт лам хэлжээ. Тэгээд дөрвүүлээ яваад Улаан лус хааныд хүрч ирэхэд номын авшиг жинан хүртэж янз бүрийн хүндэтгэл юм болж байгаад, За бидний хүсэл мөрөөдөл ханалаа. Сонжоодой сайн түшмэл танд хүүхнээ өгье гээд их найр хурим хийж байгаад л өгч гэнэ.
	Ингээд явах болтол хүүхэн жаахан хоргодоод юм бодоод байжээ. За юу болов. Яачихаав гэж түшмэл асуужээ. Манайд нэг зандан үхэг бий түүний дотор зандан тэвш бий. Түүний дотор зандангийн үртэс бий: Түүнийг авбал хэрэг болох болов уу гэж бодож байна гэжээ. Ингээд түүнийгээ аваад цөмөөр цааш...
W Баатар гэрлэх	Ингээд аваад бас л цааш явж байтал Цагаан лус хааных дайралджээ. Цагаан лус хааны дээгүүр гарч явахдаа таныг Цагаан лус хааных дайруулж цай зооглуулаад яваарай гэсэн юм гэж Агуйт ламд хэлжээ. цай За тэгье гээд хэдүүлээ буугаад Цагаан лус хааныд очиж хоол зооглож номын авшиг жинан хүртээлээ. Тэгээд явахад нь Цагаан лус хааных бидний хүсэл мөрөөдөл ханалаа. Ачтай тустай хүн өгчээ. Явахын үед танд охиноо өгье гээд бас л хурим найр хийж охин нь бас л гуньж гутраад юм бодоод хоргодоод байжээ. За яав? Юу бодов гэж түшмэлийг асуухад, - Манайд хөхөө шувууны өдөн үхэг бий. Түүний дотор хөхөө шувууны өдний өөдөс бий. Түүнийг аваад явбал хэт нь хэрэг болох болов уу? гэж бодоод байна гэжээ. Түүнийг нь авчээ.
↓ Баатар гэртээ харих	Ингээд гурван эхнэртэй болоод Тэнгэрийн тоодог хааныд хүрээд иржээ.

Сүйт бүсгүйгээр дутагдах (эсвэл найз, хүнээр дутагдах). Гоонь баатар сүйт бүсгүйгээ эрэх а[1]	Сонжоодой сайн түшмэл Наян жил явах байтугай найм есхөн хоногийн дотор наян жилийн цаана байдаг Наянтай уулын энгэр дэх бургасны Агуйт ламыг залж ирж, маргааш өглөө нь Тэнгэрийн тоодог хаанд бараалхахад тэр маш их гайхан энэ ямар учиртай хүн бэ? Яагаад ингэж хурдан амждаг билээ гэж бодоод, бүх албат иргэдээ цуглуулж, Манай Сонжоодой сайн түшмэл наян жилийн цаана байдаг Наянтай уулын тэртээх нарийн цагаан бургасны Агуйт ламыг залж ирсэн байна. Энэ бол үнэхээр эрдэм билээ. Эр чадал төгс хүн юм гэхэд Бандидай муу түшмэл үгүй ээ! Наян жилийн газрыг найм есхөн хоноод ирдэг яасан далд ордоггүй амьтан бэ? Бас сайхан хүү-хэн хүртэл авчирч энэ хүүхний нь авъя гэж бодоод бас нэгэн арга олжээ.
F^1 Баатарт шидэт хэрэглэл олгох Ид шидэт хэрэглэлийн тусламжтайгаар үйл хэргээ биелүүлэх гэж оролдох. (η^2) урвуу	За хаантан минь манай Сонжоодой сайн түшмэл үнэхээрийн эрдэм билэг төгс ид шидтэй хүн юм. Ийм учраас Агуйт ламыг хоёр шавьтай нь залж бас өчнөөн төчнөөн тэмээ ачаатай ирсэн байна. Харин тэр юмыг нэг талд нь задгай сайхан дэлгэж, нөгөө талд нь бид бүгдээрээ сууж номын авшиг жинан хүртэх «Эргэн тойрон дөрвөн хаалгатай ган хэрэм бариулж дотор хамгаа залж номын авшиг жинан хүртье» гэж хаанд айлтгахад тэгье гэж зөвшөөрөөд Сонжоодой сайн түшмэлийг дууджээ. За хөө чи эрдэм билэг төгс ид шидтэй хүн байна. Эргэн тойрон дөрвөн хаалгатай ган хэрмийг түргэн барь! Эс чадвал толгойг чинь авна гэж тушаажээ. Түшмэл бүр гайхаад гэртээ иртэл хэдэн хүүхнүүд нэгэн гэртээ цуглачихсан найр хурим болоод сууж байна гэнэ. Түшмэл их л гунихуун иржээ. Түшмэл гуай та яагаа вэ? Юунд гуньхраав? гэж тэд асуужээ. Намайг ган хэрэм бариул! гэж байна. Би ган хэрэм яаж барьж чадах вэ дээ! гэж гэнэ. - Аа зовох юу байсан юм бэ? Эргэн тойрон ган хэрэм болтугай гээд нөгөө гангийн үртэснээс унтахдаа цацчих гэж Ногоон лусын хааны охин хэлж гэнэ. Ингээд цацчихаад өглөө боссон чинь нээрээ дөрвөн талдаа хаалгатай ган хэрэм болчихсон байна гэнэ.
-	Хаан түүнийг үзээд, За болжээ! Одоо албат иргэдээ цуглуулж Агуйт ламаас авшиг жинан хүртээд сайн сайхан байцгааж гэнэ. Тэгтэл өнөө Бандиадай муу түшмэл: Энэ хэрмэн дээрээ зандан мод ургуулбал бүр ч сайхан болно доо гэжээ. Хаан зөвшөөрч, - Энэ хэрмэн дээр зандан мод ургуул! Эс чадвал хааны зарлиг нугалсан гэж толгойг чинь авна гэж гэнэ. Нөгөө түшмэл гайхан гуньхраад болохгүй юм бүхэн л над дээр ирэх юм. Би чадахгүй үхэх л хүн юм байгаа даа гэж бодсоор гэртээ иржээ. Түшмэл гуай та юу бодоов гэж нөгөө хатад асуужээ. Энэ хэрмэн дээр зандан мод ургуул! гэнэ. Би яаж ургуулах вэ дээ! Зовох юу байдаг юм бэ? Нөгөө зандангийн үртэс яалаа. Түүнийг ган хэрмэн дээр зандан ургах болтугай гээд цацчихаад унт гэж Улаан лусын охин хэлж гэнэ. Ингээд унтахдаа цацчихаад өглөө боссон чинь нээрээ зандан ургачихсан байжээ.

-	За одоо болжээ. Албат иргэдээ цуглуулж Агуйт ламаас авшиг жинан хүртээд сайн сайхан байцгаана гэтэл Бандиадай муу түшмэл бас нэг арга бодож олоод, Энэ зандан дотроо өглөөний нарнаар хөхөө шувуу донгодуул- бал бүр ч сайхан болно доо гэв. Тэнгэрийн тоодог хаан Сонжоодой сайн түшмэлээ дуудаж: Маргааш өглөөний нарнаар энэ зандан дотроо хөхөө шувуу донгодуул! Эс чадвал толгойг чинь авна гэж тушаажээ. Сонжоодой сайн түшмэл, Өглөөний нарнаар энэ зандан дотор хөхөө шувуу донгодуул гэж байна! Би яаж чадах вэ дээ? гэж гуньсаар очжээ. Гэтэл зовох юм юу байх вэ, нөгөө хөхөө шувууны өдөө унтахдаа болж донгодох болтугай гээд цац гэжээ. Өглөө боссон чинь үнэхээр хөхөө шувуу донгодож байдаг байна.
-	Тэнгэрийн тоодог хаан Бандиадай муу түшмэлтэйгээ хоёулаа ирж үзээд, - За болжээ гэж гэнэ. Ингээд албат иргэдээ цуглуулж зандан модон дээр хөхөө шувуу донгодсон ган хэрмэн дотроо Агуйт ламаас шан хүртээд сайн сайхан байцгааж гэнэ. Тэгтэл өнөө Бандидай муу түшмэл, Сонжоодой сайн түшмэлд алба хэргий нь хүлээл-гэн өгөх болохоороо бас нэг арга зохиож Тэнгэрийн тоодог хааныд очоод, Манай Сонжоодой сайн түшмэл үнэхээр эрдэм билэг төгс, ид шид бүрдсэн хүн юм байна. Иймд таны нас барсан ээж, аав хоёрыг миний нас барсан ээж, аав хоёртой дөрвүүлэнгий нь олж ирээд даруй бидэнтэй уулзуул! гэж та түүнд тушаал өгнө үү! гэжээ. Хаан үүнийг зөвшөөрч Бандиадай муу түшмэлийг гармагц Сонжоодой сайн түшмэлийг дуудаж ирүүлээд, - Миний нас барсан ээж аав хоёрыг Бандиадай муу түшмэлийн нас барсан ээж аав хоёртой дөрвүүлэнг нь олж ирээд даруй бидэнтэй уулзуул гэж тушаахад нь Сонжоодой сайн түшмэл, За гэж хэлээд гарчээ. Ингээд Хангарди шувуундаа ирж Тэн- гэрийн тоодог хаан өөрийн нас барсан ээж аав хоёрыг Бандиадай муу түшмэлийн нас барсан ээж аав хоёртой дөрвүүлэнгий нь олж ир гэж надад тушаав. Би одоо яах билээ гэжээ. Хангарди нь, за тэнгэрийн Тоодог хааныд очоод би танай аав ээж хоёртой уулзчихаад ирлээ. Дөрвөн ээж аав чинь хорон далайн тэртээ сайн сайхан амьдарч байна. Бид нар очиж уулзахгүй. Харин та нар бид- ний үр хүүхэд юм бол ирж уулзах ёстой. Манай хаан төрийн ёсонд ч эцэг эх нь үр хүүхдээ очиж уулздаг учиргүй гэж хэлээд ирэхгүй юмаа гээд оч гэжээ. Хэрэв чи юугаар яваад ирэв гэвэл Агуйт ламын хүлэглэж ирсэн Хангарьдаар очоод ирлээ. Хэрэв та хоёрыг явна гэвэл түүн дээр суугаад гурвуул явъя гэж хэлээрэй! гэжээ. Сонжоодой сайн түшмэл Тэнгэрийн тоодог хааныд бараалхаад, Таны ээж аав хоёр ч сайн байна. Бандиадай муу түшмэлийн ээж аав ч бас сайн байна. Харин тэд эцэг эх нь үр хүүхдээ очиж золгодог ёс хаан төрийн хуульд ч, аав ээжийн ёсонд ч байхгүй гэж хэлээд ирсэнгүй. .

	Харин та нарыг үнэхээр хүсэж байгаа юм бол бидэнтэй ирж уулзана биз гэж хэлсэн гэхэд Тэнгэрийн тоодог хаан Бандиадай муу түшмэлийг дуудаж Сонжоодой сайн түшмэл яваад бидний эцэг эхтэй уулзаад ирсэн байна. Тэд цөм сайн гэнэ. Тэгэхдээ өөрсдөө ирэхгүй чи бид хоёрыг ирж уулз гэсэн байна. Иймд юм хумаа даруй базаагаад Агуйт ламын хүлэглэж ирсэн Хангардаар явъя гэжээ
G[1] Баатар агаар дээр нисэх	Тэгээд хаан түшмэл хоёр эцэг эхдээ айлчлах юмаа хоёр гурван хоногийн дотор бэлтгээд Хангардийн нэг далавчин дээр Тэнгэрийн тоодог хаан…
I[5] Хорон санаатан тулалдаан, өрсөлдөөнгүйгээр ялагдах	Бандиадай муу түшмэл хоёр нөгөө далавчин дээр нь Сонжоодой сайн түшмэл суугаад хорон далай дээгүүр нисч явтал, түүн дотор нөгөө зах руу нь явж байхыг Тэнгэрийн тоодог хаан Бандиадай муу түшмэл хоёр хараад Сонжоодой сайн түшмэл, чи Хангарьдын хэлийг мэдэх тул энэ алтан ган хайрцаг зуусан загасыг шүүрч аль! гэж түүнд тушаа гэжээ. Сонжоодой сайн түшмэл хааны тушаалыг Хангардид хэлбэл, хорон далай дотроос тэр загасыг шүүрэх гээд тэр хоёрын суусан далавчаа сэгсрэнгүүт Тэнгэрийн тоодог хаан, Бандиадай муу түшмэлтэйгээ хорон далайд унажээ.
W Баатар гэрлэж, хаан ширээнд суух	Тэгээд Хангарди Сонжоодой сайн түшмэлийг орон нутагт нь хүргэж ирээд, За би таны тусыг өчүүхэн төдий боловч хариуллаа. Одоо та орон нутагтаа аятай сайхан жарган суугаарай! Би ч орон нутагтаа буцъя гээд хоёулаа баяртай сайхан салжээ. Тэгээд Сонжоодой сайн түшмэл Тэнгэрийн тоодог хааны оронд хаан ширээнд сууж хотол гүрнээ захиран амар сайхан жарган суужээ.

ХАВСРАЛТ 4. “ГАЛ УЛААН ХААН” ҮЛГЭРИЙН ЗАДЛАЛ

Функц	**“Гал улаан хаан” үлгэр**[52]
∝ Анхдагч нөхцөл	Жил бүгд найман настай хүүхдээр далай тахидаг Гал улаан хаан гэж байжээ. Далай тахисаар байгаад найман настай хүүхэд олдохоо болиход хаан өөрийн түшмэдийн хүүгээр далай тахихаар болжээ.
↑ Баатар гэрээс гарах	Түшмэдийн хүү шувууны есөн хэл мэддэг юм байжээ. Хүүг гэртээ байж байхад авчраад хаан үүгээр далай тахиад ир гэж хоёр яргачиндаа өгчээ. Тэр хоёр яргачин хүүг авч яваад “Чамаар яаж далай тахих вэ? Чи нар гарах зүгийг чиглэж яваад таван алтан улиас дайралдахаар тэнд хоноглогтун!” гэж хэлээд явуулчихжээ.
F^1 Баатарт шидэт хэрэглэл олгох	Хүү явсаар таван алтан улиасанд хүрч тэнд хоноглохоор хэвтэж байжээ. Гэтэл таван алтан улиасны дээрх үүрэн дээр нэгэн шувуу ирээд, “Энэ хүүхэд төмөр мунын хугархайг авбал их сайн юм байна” гэж нөгөө шувуутайгаа ярьж байна гэнэ.
F^5 Шидэт хэрэглэл баатрын гар дээр аз тохиолоор ирэх	Хүү төмөр мунын хугархайг олж аваад явж байтал нэг том мэлхий дайралдаж гэнэ. Хүү, “Хонины шагайн чинээ бол” гээд төмөр мунийнхаа хугархайгаар цохисонд хонины шагайн чинээ болчихжээ.
a^1 Сүйт бүсгүйгээр дутагдах (эсвэл найз, хүнээр дутагдах). Гоонь баатар сүйт бүсгүйгээ эрэх	Тэгэхээр нь авч залгичхаад хонотол нэг их шуурга болж өнөө хүүг хийсгээд маш хол газар аваачаад хаячихжээ. Гэтэл түүнийг нэг хөх шартай хөгшин олж аваад ихэд баярлаж тэнгэр, газарт их дуу хадуулсаар гэртээ гүйж ирлээ. Нэг хүү олж авлаа. Хүүгээ нэг өнцгийн баян хааны охинтой гэрлүүлнэ гэж хөх шараа унаж аваад хааныд ураг элгэн болъё, хурим найр хийе гэж очжээ.
A^{14} Хорон санаатан аллага үйлдэх	Юү гээгчийн эргүү хөгшин бэ? гэж хаан уурлаад өнөө өвгөнийг алаад хөх шард нь ачаад буцаачихжээ.
K^9 Үхсэн хүн амилах	Замд нь хүү таарч хөх шарыг гэр рүүгээ тууж орхиод аавыгаа “Амь нас нь бүт, урьдаасаа угтай, хэзээнээсээ хэвтэй хүрэн улаан хөгшин бол” гэж дээгүүр нь алхжээ. Юу гээчийн их унтав гэсээр аав нь урьдаасаа угтай, хэзээнээсээ хэвтэй хөгшин болж босож ирэв.
γ^2 Хүссэн, санал болгосон хүсэлт	Аав аа, аав аа, хааныд архи их уугаад унтсаныг нь би сэрээж авлаа гэртээ дагуулаад харьжээ. Өвгөн маргааш нь дахиад л худ сүй болъё, хурим найр хийе гэж очсонд арга нь барагдсан хаан их дунгаар их түмнээ цуглуулж бага дунгаар бага түмнээ цуглуулж одоо энэ хөгшинийг яах вэ? гэж зөвлөөд өвгөнд ийн хэлжээ. Чи надад зуун цагаан морь сүй хүргэж ир! Бас алтан дээвэр манай гэрийн үүдтэй сүм байгуул! Өөрийн гэрийн үүднээс аваад хүртэл алтан мөнгөн зам тавь! тэгвэл би охиноо өгч ураг садан болно гэв.
γ^2 Хүссэн, санал болгосон хүсэлт	Хөгшин тэнгэр газарт их дуу хадуулсаар гэртээ ирж хүүдээ хэлжээ. - Би чамайг гэрлүүлэх гэсэн чинь зуун цагаан мориор сүй хүргэ! Бас алтан дээвэртэй сүм байгуул! Манай гэрээс өөрийн гэрийн үүд хүртэл алтан мөнгөн зам тавь гэж байна. Би одоо яах вэ? гэжээ.

[52] *Монгол ардын үлгэр* (Монгол ардын аман зохиолын чуулган I). (1982). Д. Цэрэнсодном эмхэтгэж, удиртгал, тайлбар бичив. УБ., Улсын хэвлэлийн газар, х.107-108.

K^6 Шидэт хэрэглэлийн тусламжтайгаар гачигдлыг даван туулах	Хүү төмөр мунийнхаа хугархайг барьж «Зуун цагаан морь бол! Алтан дээвэртэй сүм бол! Манай үүднээс хааны гэрийн үүд хүртэл алтан мөнгөн зам бий бол!» гэж дохиж бөөлжив гэнэ. Тэгээд хөх үхэрт хөгшин, зуун цагаан морь аваад алган мөнгөн замаараа явж хаанд бараалхжээ.
W Гэрлэлт	Дараа нь хааныхан хамаг нийтээрээ, өлгийтэй хүүхэд, өлөгчин нохой үлдэлгүй цөм өвгөнийд гийчлэн ирсэн боловч хөгшний бэлдсэн амттай их идээний гурав хуваасны нэгийг ч барсангүй гэнэ. Хааныхан охиндоо албат хошуу, алт, мал хуваан өгч хүүгийн гэргий болгон явуулахдаа охиндоо ганцаарчлан ингэж захижээ. - Хөх шартай хөгшин яагаад баяжив гэж залуу хүүгээс асуу! Хэлэхгүй бол «үнэн үгээ хэлэхгүй бол нөхөр хань болж яаж сууна даа» гэж хэлээрэй! Тэгвэл чинь хэлэх байх гэв.
A^2 Хорон санаатан шидэт хэрэглэлийг булааж авах	Хүүхэн нөхрөөсөө асуужээ. Би ер хүнд хэлэхгүй гээд байж. Хүүхэн өдөр бүр шалаад л байж. Нэг өдөр хүү хэлжээ. Би ер хүнд хэлэхгүй гэсэн юм. Гэвч чамд хэлэхээс биш яах вэ. Би мэлхий залгиснаас хойш санаснаараа бөөлждөг болсон билээ гэв. Хүүхэн үүнийг сонсоод хаан аавдаа очиж хэлжээ. Хаан нэг өдөр хүргэнээ ирүүлж цай уу! гэж уулгаад арван хөхүүр арз өгч бөөлжүүлсээр байтал зүрх нь амаараа цухуйсанд зүрхэнд нь нэг мэлхий байжээ. Түүнийг нь аваад үд хүрдэггүй үнэгэн цагаан эм, хоног хүргэдэггүй хонин цагаан эм түрхэж зүрхийг нь цааш хийж орхижээ. Хүү унтаж байгаад сэрсэн чинь хөгшний гадаа байсан мал нь цөм хааны гадаа оччихсон байв гэнэ. Хүү чимээгүй оргож гараад таван улиасныхаа угт ирээд сууж байтал улиасны дээрх үүрэнд хоёр шувуу ингэж ярилцжээ.
F^1 Баатарт шидэт хэрэглэл олгох	Энэ хүү маргааш эрт босож гүйвэл долоон чөтгөр нэг дүгрэг гэрийг уралдуулж хэн түрүүлсэн чинь үүнийг ав! Би барьж байя гэж хар юм булаацалдаж байгаатай дайралдана. Тэгээд тэр долоон чөтгөр мэхлээд өөрөө тэр хар юмыг өмсчихвөл чөтгөр үзэж чадахгүй бол энэ хүүгийн хэрэг бүтэх юм байна гэж хэлэлцжээ.
E^6 Баатар зохих ёсны тэнцүү хуваарилалтыг хийх	Маргааш нь хүү маш эрт босоод явж байтал эзгүй цөл газар иржээ. Нэгэн хүн юм уу? Нэг цагаан юм тал дээр уралдаад байжээ. Юу боловч харгалдъя гэж бодоод очтол долоон хүмүүн байж байв. Та нар юу вэ? Бид хүмүүн. Та нар юу хийж ингэж гүйлдээд байгаа юм бэ? гэв. Тэгсэн бид бурхан багшийн овоодой (малгайг) олсон. Энийг яаж хуваах вэ? гэж сурав. Та нарын заргыг би хийж өгье! гэж хүү хэлэв. За бид ах дүү барилдъя. Та нар юунаас айдаг вэ? гэжээ. Тэгэхлээр тэд, өргөстэй харганаас айна, гөлгөр мөснөөс айна, үхрийн Бид өргөстэй бааснаас айна гэжээ. - Чи юунаас айдаг вэ? гэж тэд асууж гэнэ. Би тавагтай гурилаас айна, домботой цайнаас айна, хонины чанасан гуянаас айна. За одоо би та нарын заргыг хийнэ. Би үүний чинь авч байя. Та нар уралдаад ир! Хэн шөвгөлсөнд чинь өгнө гэжээ. Тэд уралдаанд явав. Тэр хооронд хүү өргөстэй харганад оров.

	Тэгээд энэ чинь юунаас айдаг билээ гээд домбо домбо цай, таваг таваг гурил, хонины чанасан гуя өгөөд байжээ. Хүү түүний нь идэж уугаад л суугаад байжээ. Тэгээд чөтгөрүүд аргаа бараад цагаан сарын өмнөх гучны орой чамаас хариугаа авъя гээд яваад өгчээ. Ингээд хүү овоодой хар малгайг нь өмсөөд явж байтал бас нэг долоон чөтгөр бурхны орхимж булаацалдаж байжээ.
T^3 Баатар шинэ хувцастай болох	Хүү бас л та нар уралдаад ир, хэн шөвгөлсөнд чинь өгнө гэж хуурч явуулаад тэр хооронд бурхан багшийн овоодойг өмсөөд орхимжийг нь ороож аваад цааш явж хааныд очиж бурхны нь хайрцаг дээр суужээ.
G^2 Баатар газар дээр эсвэл усан дээр явах	Хааныхан бурхандаа ууцаар тахил тавьсанд хүү ууцны хоёр хажуугийн махыг идчихжээ. Тэгсэн хааныхан манай бурхан амилж байна гээд бүтэн хониор дээж тавьдаг болж гэнэ.
↓ Баатар гэртээ ирэх	Түүнээс нь цадтал идчихээд шидэт мунаараа бурхны хайрцгийг хамх цохиж алтан мэлхийгээ авч залгичихаад гэртээ гүйж хариад амар сайхан жарган суужээ.

ХАВСРАЛТ 5. “ЕСГӨЛДЭЙ ӨВГӨНИЙ ЕСӨН ХҮҮ” ҮЛГЭРИЙН ЗАДЛАЛ

Функц	**“Есгөлдэй өвгөний есөн хүү” үлгэр**[53]
α Анхдагч нөхцөл	Эрт урьд цагт есөн хүүтэй Есгөлдэй өвгөн гэж байжээ.
A^1 Хорон санаатан хүн хулгайлах нь	Нэг хааных дунд хатнаа гэнэт нэгэн шөнө алдчихаад хааны хошуу нутгаар нэгжин эрээд ер олсонгүй учир, хаан шадар олон ноёд түшмэдээ цуглуулан дунд хатныг заавал олох тухай зарлиг буулгасанд нэгэн түшмэлээс хэлсэн нь..
	...Ер нь Есгөлдэй өвгөнийхөөр ороогүй байна шүү. Тэднийд есөн хүүхэд бий шүү. Тэд авсан байж магадгүй. Есгөлдэй өвгөний есөн хүүгээр олуулъя гэжээ.
B Золгүй явдал тохиосныг баатарт мэдэгдэнэ. Тушаалаар баатар явахаар болно.	Есгөлдэй өвгөнийг дунд хатныг олж авчир! Хэрэв олохгүй бол есөн хүүгийн чинь толгойг авна гэж элчийг мордуулан явуулжээ.
β^1 Гэрээсээ яван одож буй гэр бүлийн гишүүн нь ахимаг насны хүн байж болно.	Есгөлдэй өвгөн их айн сандарч, есөн хүү минь өглөө нарнаар гараад үдшийн харанхуйд ирдэг. Одоо чухам хаа явааг би мэдэхгүй. Би олж ирье гэж өвгөн нэгэн уулын толгой дээр гүйн гарч есөн хүүгээ харсан чинь ер сураг бараагүй болохоор...
F^6 Шидэт хэрэглэл гэнэт гарч ирэх	...уулын бэл рүү бууж явтал алт шиг өнгөтэй элс байхад түүнийг хормойлон авчраад зууран алтан нум сумыг хийж тавиад сууж байтал есөн хүү нь цуглан иржээ.
	Хамгийн бага хүү нь аав аа! Энэ сайхан алтан нум сумыг хэн өгөв. Үүнийг надад аль гэсэнд, та нарын хэн эрдэмтэйд нь өгөхөөр хийсэн юм. Та нар ямар эрдэмтэйгээ нэг нэгээрээ хэл гэсэнд, 1. Бага хүү нь би харанхуй шөнө хар батганы мөрийг ч алдахгүй хөөж чаддаг гэв. 2. Дараах хүү нь далайг ганцхан балгадаг гэв. 3. Гурав дахь хүү нь гурван дабааг нэвт хардаг гэжээ. 4. Дөрөв дэх нь хивж байгаа зээрийн хивэг, хэлэлцэж байгаа хүний хэт хутга мэдэгдэлгүй хулгайлж чадна гэв. 5. Тав дахь нь усгүй газраас унд, уулгүй газраас гал гаргах чадалтай гэв. 6. Дараах хүү нь хоолгүй газраас хонины мах, үүцгүй газраас үхрийн мах гаргаж чадна гэв. 7. Дараах нь далдын юмыг нэвт чагнах чадалтай гэв. 8. Найм дахь нь нааш хараад цааш харахын хооронд гурван давхар ширмэн байшинг барина гэв. 9. Хамгийн их хүү нь сууснаараа ороод санаснаараа гарна гэв.

[53] *Монгол ардын үлгэр* (Монгол ардын аман зохиолын чуулган I). (1982). Д. Цэрэнсодном эмхэтгэж, удиртгал, тайлбар бичив. УБ., Улсын хэвлэлийн газар, х.99-100.

	За яах вэ, та нарын эрдмийг сонслоо. Та нарын хэнд нь ч өгөхгүй. Харин энэ өдөр хааны элч ирсэн, хаан дунд хатнаа алдаад олохгүй байна гэнэ. Та нарыг олж ир гэсэн. Олохгүй бол та есийн толгойг авна гэж зарлиг буулгасан байна. Одоо та нар минь тэр хатныг олохыг хичээ гэжээ.
↑ Баатар гэрээс гарах	Есөн хүү хатныг олж чадна гэж амлаад гарчээ.
K^1 Баатар хайж буй зүйлээ хүч чадлаар эсвэл мэргэн ухаанаар олж авах	Бүгдээрээ ярилцаж байгаад их хүү нь хэлжээ. За бага дүү чи аавын алтан нум сумыг авна гэж харанхуй шөнө хар батганы мөрийг алдахгүй хөөдөг гэсэн. Одоо мөрд гэжээ. Бага хүү тэгье гээд мөрийг хөөн явж явж нэг их далайд орсон байна гэлээ. За яах вэ гэхэд их ах нь далайг ганц балгадаг чи одоо балга гэв. Ингээд балгасан чинь арван таван толгойтой атгаалжин хар мангасын гэрт дунд хатан сууж байжээ.
Pr^6 Мөшгөгч баатрыг хөнөөх гэж оролдох Pr^7 Мөшгөгч баатрын хоргодож буй модыг хазах гэж оролдох	Одоо хивж байгаа зээрийн хивлэг хулгайлдаг нь хатныг хулгайлаад хааны руу явжээ. Явж явж гурван даваг нэвт хардаг нь харсан чинь мангасынхан ганцхан даваany ард ирж явжээ. За яах вэ гэхэд наашаа хараад цаашаа харахын хооронд гурван давхар ширмэг байшин барьдаг нь байшин барилаа. Ингээд дотор нь суугаад ундгүй газраас унд гаргаж хоолгүй газраас хоол гаргадаг хоёр нь цай хоол бэлтгэн идэж уугаад амарч байгаад чагнадаг нь чагнасан чинь хоёр давхар ширмэн байшинг хайлуулаад гурав дахь байшинг хайлуулжээ. Хамгийн бага хүү нь их ах чи анх аавын хийсэн алтан нум сумыг авахаар суусан газрааараа ороод санасан газрааараа гардаг гэсэн шүү. Одоо тэр чинь хэрэг боллоо гэхэд суусан газрааараа бүгд ороод хааны босгоор гарчээ.
↓ Баатар гэртээ ирэх	Тэгээд хааныд хатныг олж ирсэн тухай айлтгахад хаан баярлаж Есгөлдэй өвгөнийг дууджээ.
W Баатар гэрлэх	Лав миний есөн хүүхдийг алах гэж намайг дуудлаа гэж их айн очсон чинь танай есөн хүү хатныг олж ирсэн. Одоо аль хүүд чинь дунд хатныг өгөх вэ? гэхэд өвгөн учиргүй их баярлаж хамгийн бага хүүд өгөгтүн. Би ч бас нум сумаа өгнө гэв. Ингээд хааныхаас өмч хөрөнгө таслан өгч дунд хатантайгаа суулгаад Есгөлдэй өвгөн есөн хүүгийн хамт наян хоногийн найр хийж жаран хоногийн жаргал хийж амар сайхан жаргаж гэнэ.

2026 Fasc.11

С. ЧОЙСҮРЭНГИЙН ТУУЛЬСЫН БААТРУУДЫН НЭР, НЭРШЛИЙН ӨВӨРМӨЦ ЧИМЭГ ҮГИЙН СУДАЛГАА

(“Галзуу хар хөхөл”, “Эзэн улаан бодон”, “Бужин даваа хаан” туулийн жишээн дээр)

Баяндалайн ЛХАГВАЧИМЭГ

МУИС-ийн Багш, монгол хэл, уран зохиолын боловсрол хөтөлбөрийн III курсийн оюутан

Удирдагч: И. Даваадорж

МУИС-ийн Утга зохиол, урлаг судлалын тэнхимийн багш, докторант

Хураангуй: *Эл илтгэл нь Алтайн уриангайн нэрт туульч Сүхийн Чойсүрэнгийн туулийн хэл найруулгын өвөрмөц онцлогийг тодорхойлоход чиглэсэн. Уг илтгэлд “Галзуу хар хөхөл”, “Эзэн улаан бодон”, “Бужин даваа хаан” гурван туулийг сонгон, баатрын нэр, нэршлийн давтамжийг тооцож, өвөрмөц чимэг үг бүхий хэвшмэл хэллэгийн хэрэглээний зүй тогтлыг тодорхойллоо. Судалгааны арга зүй нь Милман Парри, Альберт Лорд нарын “Аман хэвшил тогтолцооны онол”-д үндэслэн, хэвшмэл хэллэгийн хэрэглээг тоон болон чанарын аргыг ашиглан судаллаа. Үүний үр дүнд гол баатрын нэрийн давтамж, өвөрмөц чимэг үгийн хэлбэр, бүтэц, хэрэглээний онцлогийг харьцуулан, тууль хайлахад хэвшмэл хэллэгийн гүйцэтгэх үүргийг задлан шинжилж, тайлан тайлбарлалаа. Судалгааны ач холбогдол нь хувь туульчийн тууль хайлах онцлогийг судлах, хайлсан туульсын бүтцийг нарийвчлан шинжлэх, туульчийн онцлог бүхий “нэгэн амны үг”-ийг тодорхойлоход орших юм.*

***Түлхүүр үг**: Аман хэвшлийн онол, С. Чойсүрэн, туульсын баатар, өвөрмөц чимэг үг*

УДИРТГАЛ

Судлагдсан байдал

С. Чойсүрэнгийн туульсын судалгааны эхлэлийг Г. Ринченсамбуу[1] тавьж, 1960 онд түүний хайлсан хоёр туулийг тэмдэглэн авч, эрдэм шинжилгээний

[1] *Монгол ардын баатарлаг туульс*, Эмхэтгэн боловсруулж, удиртгал тайлбар үйлдсэн Г. Ринчинсамбуу, УБ., 1960, Улсын хэвлэлийн газар.

тайлбарын хамт хэвлүүлсэн байна. Үүний дараа Ж. Цолоо, У. Загдсүрэн[2] нар 1966 онд мөн түүний хайлсан дөрвөн туулийг эрдэм шинжилгээний галиг үсгээр тэмдэглэн, нутгийн аялгууны чанартай зарим үгэнд тайлбар хийж хэвлүүлжээ.

Судлаач Р. Нарантуяа[3] 1985 онд "Аргил цагаан өвгөн" туулийн эхийг шинээр эмхэтгэн хэвлүүлж, 1987 онд "Урианхай туульс"[4] өгүүлэлдээ С. Чойсүрэнгийн хайлсан 13 туулийн өгүүлэмжийг харьцуулан, үйл явдлыг товчлон хүргэжээ. С. Чойсүрэнгийн хайлсан туульсыг Оросын судлаач Т. Г. Борджанова[5] өгүүлэл бичиж, туульчийн намтар, хайлдаг туульсын сэдэв, өгүүлэмж болон дүрийн бүтцийг шинжилсэн байна. Харин Л. Туяабаатар[6] бүтээлдээ алтайн урианхай туульсыг халх болон баруун монголын бусад туульстай харьцуулан, өгүүлэмж, дүрийн өвөрмөц шинжийг тодорхойлсон юм.

П. Хишигбаяр[7] туульч С. Чойсүрэнгийн хайлсан туульсын үйл явдлыг бүртгэсэн бол П. Хорлоо[8] намтар, туульсын судалгааг тоймлон өгүүлжээ. Б.Катуу "Монгол тууль судлалын зарим асуудал"[9], "Алтайн урианхай тууль"[10], "Нэрт туульч С.Чойсүрэнгийн туульс"[11] бүтээлдээ түүний намтар, уран бүтээл ба хайлсан 11 туулийг ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Аман зохиол, нутгийн аялгуу судлалын лабораторийн бичмэл хөмрөгөөс боловсруулан оруулж, удиртгалд эл туульсын үйл явдлыг товчлон, хэлбэр, бүтэц, тууль дахь домог зүйн ойлголтын тухай тайлбарласан нь өдгөө судалгааны чухал хэрэглэгдэхүүн болж байна.

Алтайн урианхайн нэрт туульч С. Чойсүрэнгийн хайлсан туульсыг 1960-аад оноос судалж эхэлсэн ч эрдэм судлалын ажил тэдгээрийн үйл явдлыг товчлох, туульсын өгүүлэмж, баатрыг ерөнхийлөн дүгнэхээс хэтрээгүй байна. Тиймээс эл өгүүлэлд С. Чойсүрэнгийн хайлсан гурван туулийн гол баатрын нэр, нэршлийн давтамжийг тооцоолж, хэвшмэл хэллэгийн хэрэглээний зүй

---

[2] *Баруун монголын баатарлаг туульс*, (Аман зохиол судлал, IV боть, 2-р дэвтэр), Эмхэтгэн боловсруулж, хэвлэлд бэлтгэсэн Ж. Цолоо, У. Загдсүрэн, УБ., 1966, Шинжлэх ухааны академийн хэвлэх.

[3] *Аргил цагаан өвгөн*, Эмхэтгэн боловсруулсан Р. Нарантуяа, Х. Сампилдэндэв, УБ., 1985, Сурах бичиг хүүхдийн номын хэвлэлийн газар.

[4] Нарантуяа, Р., *Урианхай туульс*, (Аман зохиол судлал, XVII боть, 7-р дэвтэр), УБ., 1987, Шинжлэх ухааны академийн хэвлэх газар.

[5] Борджанова, Т. Г., *Творчество западномонгольского сказителя С. Чойсурена,* (Аман зохиол судлал, XVII боть, 3-р дэвтэр), УБ., 1987, Шинжлэх ухааны академийн хэвлэх газар.

[6] Туяабаатар, Л., *Алтайн урианхайн баатарлагийн туульс, түүний эх сурвалж, өвөрмөц шинж*, Өлгий., 1995.

[7] Хишигбаяр, П., *Чойсүрэнгийн хайлсан туулийн онцлог*, (Магистрын зэрэг горилсон ажил), МУИС-ийн Ховд салбар сургууль., 1997.

[8] Самдилдэндэв, Х., *Монгол аман зохиолын товчоон*. УБ., 2002, "Бэмби сан" хэвлэлийн газар.

[9] Катуу, Б., *Монгол тууль судлалын зарим асуудал*, Ховд., 1999.

[10] Катуу, Б., *Алтайн урианхайн тууль*, УБ., 2001.

[11] *Нэрт туульч С. Чойсүрэнгийн туульс*, эмхэт, Б. Катуу, УБ., 2010, "Shiny Printing" ХХК.

тогтлыг гарган, үүнд үндэслэн С. Чойсүрэнгийн тууль хайлах онцлогийг тодорхойлох юм.

Судалгааны арга зүй

Энэхүү судалгаанд Америкийн эрдэмтэн Милман Парри [Milman Parry], Альберт Лорд [Albert Lord] нарын "Аман хэвшил тогтолцоо"[12] (Парри-Лордын онол [The Parry-Lord Theory] ч гэж нэрлэдэг)-ыг гол үндэс болгож, "Жангар"-ын нэгэн бүлэгт хэвшмэл өгүүлбэр зүйн судалгаа хийсэн судлаач Б. Цогжин[13] -ий "Аман туулийн шүлэг зүй" бүтээлд тулгуурлан, туульч С. Чойсүрэнгийн хайлсан гурван туулийг задлан шинжилж, тайлан тайлбарлалаа.

Бид С. Чойсүрэнгийн хайлсан туульсыг задлан шинжлэхдээ дээрх бүтээлийн хэл хэллэгийн хэвшил, тэр дундаа баатрын нэршлийн өвөрмөц хэл, хэллэгийн судлах арга зүйг ашиглах юм. Үүний тулд:

I. **Задлан шинжлэх** туульсыг сонгон, туульд гарч буй гол болон дагалдах баатрын нэрийн давтамжийг тоолон, тэдгээрийн өгүүлэмжийн эзлэх хувийг нягтацын аргаар тодорхойлох;

II. Өргөтгөсөн чимэг үгсийн хэрэглээний давтамжийг тогтоож, ямар тохиолдолд илэрч байгааг тодорхойлох;

III. Судалж буй туульст ижил зүй тогтол буй эсэхийг шинжилж, ерөнхийлөн дүгнэснээр, тухайн тууль дахь баатрын хэвшмэл хэллэгийн үүргийг тодорхойлох юм.

Судалгааны эх хэрэглэгдэхүүний хувьд, С. Чойсүрэнгийн хайлсан "Галзуу хар хөхөл" (1938 мөр), "Эзэн улаан бодон" (2246 мөр), "Бужин даваа хаан" (4725 мөр) туулийг сонгон судалсан юм. Үндэслэл нь нэгт, мөрийн тоогоор ялгаатай туулиудад өвөрмөц хэвшмэл хэллэг ижил хэлбэрээр давтагдаж байгаа эсэхийг тогтоох, хоёрт, эдгээр тууль нь эцэг-хүү буюу хоёр үеийн үйл явдлыг өгүүлдгээрээ онцлог, гэхдээ "Бужин даваа хаан" тууль нь "Бужин даваа хаан", хааны дүү "Бахтай улаан түшмэд", тэдний хөвгүүдийн үйл хэргийг хамарч буйгаараа ялгаатай, гуравт, мөрийн тоогоор ялгаатай ч өгүүлэмжийн хувьд төстэй эдгээр туульд нийтлэг зүй тогтол илрэх эсэхийг судлахад оршино.

---

[12] Судалгааны уламжлал (Б. Цогжин, О. Отгонбаатар нарын судалгаа)-д "Oral formulaic theory"-г "аман хэвшил тогтолцоо", харин "formula"-г "хэвшмэл" эсвэл "хэвшилт" хэллэг, дүрслэл хэмээн орчуулж, хэрэглэж ирснийг харгалзан үзэж дээрх байдлаар нэрлэлээ.

[13] БНХАУ-ын Нийгмийн шинжлэх ухааны академийн Үндэстний утга зохиол судлах хүрээлэнгийн захирал, академич, монгол аман зохиол, аман уламжлал, тууль судлалын чиглэлээр ажилладаг эрдэмтэн, Судлаач нь тоо баримтад тулгуурлаж, аман хэвшил тогтолцооны онолын аргыг ашиглан, хэвшмэл хэллэг, хэм хэмнэлийн хэв шинж, өгүүлбэр зүйн бүтэц загварын холбоо харилцааг бүртгэн задлан шинжилсэн юм.

ҮНДСЭН ХЭСЭГ

Бид өгүүллийн үндсэн хэсгийг дараах гурван дэд хэсэгт хуваан судалж, тайлан тайлбарлалаа. Тухайлбал, нэгт, туульсын гол баатрын нэр, нэршлийн давтамжийг тооцож, өгүүлэмжид эзлэх хувийг тогтооно; хоёрт, өргөтгөсөн чимэг үгсийн хэрэглээг тодорхойлох буюу хэвшмэл хэллэгийг өвөрмөц болон өргөтгөсөн чимэг үгээр тодотгосон тохиолдлыг шинжилж, зүй тогтол буй эсэхийг тодорхойлно; гуравт, гурван туулиас бүртгэсэн өвөрмөц болон өргөтгөсөн чимэг үгийн жишээг адил төстэй шинж чанараар нь ангилан, давтамжийг тооцоолно.

Нэг. Туульсын гол баатрын нэр, нэршлийн давтамж

С. Чойсүрэнгийн туульсын гол баатрын нэр, нэршлийн давтамжийг тооцон, тэдгээрийн өгүүлэмжид эзлэх хувийг тодорхойлох юм. Энд өгүүлэх хэвшмэл хэллэг [*formula*] гэх нэр томьёо нь давтагдах шинж бүхий хэвшин тогтсон холбоо үгийг илтгэдэг. Иймд баатрын нэр болон нэршлийг хэвшмэл хэллэг гэе. Хэвшмэл хэллэгийн давтамжийн нягт [*formulaic density*] нь тодорхой нэгэн нэгжид хэвшмэл хэллэгийн дахин илрэх давтамжийг хэлнэ. Хэвшмэл хэллэгийн давтамж хийгээд зохиол бүтээлийн аман онцлог хоорондоо маш их холбоотой[14] гэж үздэг.

Бид туульд хамгийн олон давтагдаж буй баатрыг сонгож, түүнийгээ туулийн гол баатар гэж үзээд, "давтамжийн нягт"[15]-ыг тооцлоо. Нягтыг тооцохдоо тухайн баатрыг нэрлэн дүрсэлж буй мөрийг тоолж, туулийн нийт мөрийн тоонд хувааж, ногдворыг 100-аар үржүүлэх юм. Үүнийг томьёолбол:

$$\textit{Давтамжийн нягт} = \frac{\textit{Баатрыг дүрсэлсэн нийт мөрийн тоо}}{\textit{Туулийн нийт мөрийн тоо}} * 100\%$$

"Галзуу хар хөхөл" хэвшмэл хэллэгийн давтамжийн нягтыг жишээ болгон тооцвол, эл туульд "Галзуу хар хөхөл" нь ямар нэгэн чимэг үгүйгээр 67 удаа давтагддаг. Үүнээс гадна, өвөрмөц болон өргөтгөсөн чимэг үг авсан зургаан тохиолдол байгаагаас хамгийн дэлгэрэнгүй өгүүлснийг жишээлбэл:

Алтайн гурван таримал хар уул нутагтай
Долдоо догшин хар хээр морьтой
Галзуу хар хөхөл[16] [1815-1817 мөр]

Эл зургаан тохиолдол 12 мөрөөс бүрдсэн. Иймд "Галзуу хар хөхөл"-ийг дурдахад нийт 79 мөр хэрэглэсэн гэх тооцоо гарч байна. Тоон утгуудаа (баатрыг

[14] Цогжин, Б., *Аман туулийн шүлэг зүй*, УБ., 2020, х.44.
[15] Мөн тэнд, х.44.
[16] *Нэрт туульч С. Чойсүрэнгийн туульс*, эмхэт, Б. Катуу, УБ., 2010, х.362.

дүрсэлсэн нийт мөрийн тоо – 79, туулийн нийт мөрийн тоо - 1938) дээрх томьёонд орлуулан давтамжийг тооцоход 4 хувь гэж гарч байна. Энэ нь туулийн нийт өгүүлэмжийн 4 хувьд нь "Галзуу хар хөхөл" хэвшмэл хэллэгийг дүрсэлдэг гэсэн үг юм. Уг аргаар бусад баатрын хэвшмэл хэллэгийн давтамжийг тооцов.

Хүснэгт 1. Туульс дахь баатрын хэвшмэл хэллэгийн давтамжийн нягтын үр дүн

Баатрын нэр, нэршил	**Нэр, нэршлийн давтамж**	**Баатартай холбоотой нийт мөр**	**Чимэг үгтэй хэсэг**	**Нийт мөр**	**Нягт**
Гол баатар					
Галзуу хар хөхөл (ГХХ)	72	79	6	1938	4%
Эзэн улаан бодон (*ЭУБ*)	59	77	15	2246	3,4%
Бужин даваа хаан (БДХ)	62	81	8	4725	1,7%
Гол баатрын хөвгүүн					
Баатар бор магнай (ГХХ)	14	16	2	1938	0,8%
Хэцүү бэрх (*ЭУБ*)	45	48	5	2246	2,1%
Бурхан хар баатар (БДХ)	53	73	15	4725	1,5%
Дагина					
Ноёлхуу зандан дагина (ГХХ)	11	14	3	1938	0,7%
Алтан ганжуур (*ЭУБ*)	14	17	2	2246	0,8%
Алтан Солонго дагина (БДХ)	9	15	4	4725	0,3%
Хаан (дагинын эцэг)					
Өлзий цагаан хаан (ГХХ)	9	9	0	1938	0,5%
Алаач хаан (*ЭУБ*)	20	23	1	2246	1%
Арал хаан (БДХ)	19	29	6	4725	0,6%
Дайсан					
Өн шар хаан (ГХХ)	29	37	3	1938	1,9%
Матар хар соёо (*ЭУБ*)	33	41	2	2246	1,8%
Гунан хар мангас (БДХ)	22	40	10	4725	0,8%

Гурван туулийн баатрын хэвшмэл хэллэгийн давтамжийн нягтыг баатрын төрлөөр нь харьцуулахад, гол баатрынх 1,7-4,0%, баатрын хөвүүнийх 0,8-1,5%, дагиных 0,3-0,8%, хадам эцгийнх 0,5-1,0%, дайсных 0,8-1,8%-ийн хооронд тус тус хэлбэлзсэн байна. Өөрөөр хэлбэл, давтамжийн нягтацын утга "баатар-хүү-мангас-дагина-хадам эцэг" гэх зэргээр туульд гүйцэтгэх үүргээсээ хамаарч нэр дурдагдах хувь буурах шинжтэй байна. Мөн баатрын хэвшмэл хэллэгийн тоо их боловч ямар нэгэн чимэг үгээр тодотгосон нь цөөн байна. Жишээлбэл, нийт 72 удаа "Галзуу хар хөхөл" гэж илэрснээс ердөө 6 удаа (8 хувь)-д нь ямарваа нэгэн чимэг үгээр тодотгосон байна.

Хоёр. Өргөтгөсөн чимэг үгсийн хэрэглээг тодорхойлох нь

Эл хэсэгт хэвшмэл хэллэгийг өвөрмөц болон өргөтгөсөн чимэг үгээр тодотгосон тохиолдлыг шинжилж, тодорхой зүй тогтол буй эсэхийг тогтоох юм.

Энд дурдаж буй өвөрмөц чимэг үг [*epithet*] нь хүн, юмс, үзэгдлийн онцлогийг илтгэх тэмдэг нэр, түүний шинж бүхий холбоо үг ба ямагт нэрийдлийн нэг хэсэг болдог[17] онцлогтой. Цаашлаад хэд хэдэн мөр нэмж олон мөрт шүлэг бүтээн, тухайн баатрыг тодотгож байвал "өргөтгөсөн чимэг үг"-ийн хэвшмэл хэллэг хэмээн ойлгож болно. Судлаач Б. Цогжин *өргөтгөсөн хэлбэрийг үл тооцвол өвөрмөц чимэг бүхий шүлгийн өгүүлбэр нь "***үндсэн холбоо үг + чимэг үг + өгүүлбэрийн гишүүн**" гэ*х бүтцийн аргаар бүрэлддэг*[18] *хэмээн өвөрмөц чимэг үгийн бүтцийг тодорхойлсон байна.*

Уг санаанд тулгуурлан С.Чойсүрэнгийн хайлсан туульд тохирох бүтцийг боловсруулж, зөвхөн гол баатрын өвөрмөц болон өргөтгөсөн чимэг үгийг нарийвчлан судалж, зүй тогтлыг тодорхойллоо. Гурван туулийн гол баатрын хэвшмэл хэллэг нь "**нутаг + албат + морь + [чимэг үг] баатар**" гэх бүтцийн дагуу өргөтгөсөн чимэг үгийг бүтээж байна. Жишээ нь:

Будтай өндөр хар уул нутагтай
Бум л олон муж албаттайхан байдаг
Буурал халзан морьтой
Бужин даваа хаан[19] [182-185]

гэх мэтчилэн баатрын нутаг, албат, морийг дүрсэлсэн байх ба зарим тохиолдолд баатрын хэвшмэл хэллэгийн өмнө түүний шинж байдлыг нь тодотгосон чимэг үгийг нэмсэн байдаг. Жишээлбэл, "Эзэн улаан бодон" гэх хэвшмэл хэллэгийн өмнө "Жаргал ихтэй" гэх чимэг үгийг нэмж, "Жаргал ихтэй Эзэн улаан бодон" гэж шинжээр нь тодотгосон байна.

Зарим тохиолдолд морийг нь дүрслэхэд, шинж чанар заасан чимэг үг морины хэвшмэл хэллэгийн өмнө илэрч байна. Тухайлбал:

Буурал халзан морьтой
Бужин даваа хаан[20] [1716-1717]
Уулын дүнтэй буурал халзан морьтой
Бужин даваа хаан[21] [1859-1860]

Эхний жишээнд, морины хэвшмэл хэллэг дангаар тохиолдож байхад, удаах жишээнд, өмнө нь "Уулын дүнтэй" гэх чимэг үгийг нэмсэн байна. Энэ тохиолдолд дээрх хоёр жишээ нь хоёул баатар болон түүний морийг дүрсэлсэн тул "морь+баатар" гэсэн ерөнхий нэг бүтцийн ангилалд авч үзэх нь зүйтэй юм.

---

[17] Цогжин, Б., *Аман туулийн шүлэг зүй*, УБ., 2020, х.44.
[18] Мөн тэнд, х.167.
[19] *Нэрт туульч С. Чойсүрэнгийн туульс*. эмхэт. Б. Катуу, УБ., 2010, х.176.
[20] Мөн тэнд, х.203.
[21] Мөн тэнд, х.205.

Хүснэгт 2. "Галзуу хар хөхөл" баатрын хэвшмэл хэллэгийн тодотгол, жишээ

Төрөл	Бүтэц	Тохиолдол	Жишээ
Зөвхөн баатрыг чимэг үгээр тодотгосон	чимэг үг + баатар	Дайсны өөдөөс тосон явах үед	*Баруун ам эргүүлээд* *Баруун өмнө зүг тэнцүүлээд...* *Хариутай төрсөн* *Галзуу хар хөхөл* *Хүрэн улаан уулыг* *Хүү ев язлаад явахад*[22] [457-469]
		Дайсны нутаг, нэр, хэрэг зоригийг асуухын өмнө	*Эрийн сайн төрсөн* *Галзуу хар хөхөл* *Хашхирч дуудаад хэлэв...* *Эргүү тэнэг элмэр* *Алтай өргөн нутаг чинь хаана вэ*[23] *[569-575]*
		Дайсны аман гурван үгийг асуухын өмнө	*Хариутай төрсөн* *Галзуу хар хөхөл* *Өн шар хаан чиний...* *Алдаг хүний* *Аман гурван үгийг асуудаг*[24] [1119-1125]
Нэг зүйлээр тодотгосон	морь + баатар	Туульд анхлан баатрыг танилцуулахад	*Долдоо догшин хар хээр морьтой* *Галзуу хар хөхөл гэж* *Алдар их нэр нь* *Арван тивдээ цуурайтаад*[25] [193-196]
	нутаг + баатар	Дайсан гол баатрыг танилцуулахад	*Ган хар баатар гэдэг хүн билээ би* *Алтайн гурван таримал* *Хар уул нутагтай* *Галзуу хар хөхөл гэдэг* *Эргүү тэнэг элмэр байна гэнэ*[26] [594-598]
Хоёр зүйлээр тодотгосон	нутаг + морь + баатар	Хүү нь хадамдаа эцгийгээ танилцуулах үед	*Алтайн гурван таримал* *Хар уул нутагтай* *Долдой догшин хар хээр морьтой* *Галзуу хар хөхөл гэдэг хүн* *Хаан сайхан аавын минь нэр болдог*[27] [1815-1818]

Дээрх хүснэгтэд "Галзуу хар хөхөл" гэх хэвшмэл хэллэгийг чимэг үгээр тодотгосон тохиолдлуудыг бүртгэн, ангилсан үр дүнг харууллаа. Эл тохиолдлуудыг ажиглахад, "туульд анхлан баатрыг танилцуулахад" эсвэл "өөр нэгэн баатар түүнийг танилцуулах" -д баатрын хэвшмэл хэллэгийг 1-2 зүйл (*нутаг, морь)*-ээр тодотгож, өргөтгөсөн чимэг үг бүтээжээ (Хүснэгт 2-т улаан өнгөөр тэмдэглэв).

[22] *Нэрт туульч С. Чойсүрэнгийн туульс*. эмхэт. Б. Катуу, УБ., 2010, х.339.
[23] Мөн тэнд, х.341.
[24] Мөн тэнд, х.350.
[25] Мөн тэнд, х.334.
[26] Мөн тэнд, х.341.
[27] Мөн тэнд, х.362.

Хүснэгт 3. “Эзэн улаан бодон” баатрын хэвшмэл хэллэгийн тодотгол, жишээ

Төрөл	Бүтэц	Тохиолдол
Зөвхөн баатрыг чимэг үгээр тодотгосон	чимэг үг + баатар	Баатрыг хатан, морьтойгоо гурвуул байдаг хэмээн бататгахдаа
		Дайсны өөдөөс тосон явах үед
		Баатар дайсны нэр, хэрэг зориг, нутгийг асуухад
		Хатан нь хар зөндөө бухимдахад
		Аянд явахын өмнө мориныхоо дэргэд зогсоход
		Өөрийн тухай эргэцүүлэхэд (хөгширсөн зэрэг)
		Дайсантай дайтахын өмнө өөрийгөө зоригжуулахад
Нэг зүйлээр тодотгосон	морь + баатар	Туульд анхлан баатрыг танилцуулахад
		Туульд анхлан хатныг нь танилцуулахад баатрыг тодотгон дурдах
		Дайсан гол баатрыг анх танилцуулахад
		Хөвүүн нь дайсныг дарах үед (хүүгийн алдар гавьяаг магтахдаа анхлан аавыг дурдах)
		Дайсан гол баатрыг анхлан танилцуулахад (хөвүүний хэвшмэл хэллэгийн өмнө тодотгол хэлбэрээр илэрч байна)
Гурван зүйлээр тодотгосон	нутаг + албат + морь + баатар	Найр эхлээд баатрыг дахин дурдахад
		Дайсан гол баатрыг анх танилцуулахад
		Хөвүүн нь эцгээ танилцуулахад (хадамдаа)

Дээрх хүснэгтээс баатрын хэвшмэл хэллэгийг 1-3 зүйл (нутаг, албат, морь)*-ээр тодотгон, өргөтгөсөн чимэг үг бүтээсэн байна. Тэдгээр нь нэгт, туульд анхлан баатрыг танилцуулах; хоёрт, өөр нэгэн баатар түүнийг танилцуулах; гуравт, ялгаатай баатрыг танилцуулахад гол баатрыг дурдан, тодотгох үүргээр орсон байна. Эдгээр хэвшмэл хэллэг нь “баатрыг танилцуулах” гэсэн нийтлэг нэг зорилготой юм. Харин баатрын хэвшмэл хэллэгийг зөвхөн түүний шинж байдлыг заасан чимэг үг (“чимэг үг + баатар” гэсэн бүтэцтэй) ашиглан тодотгосон тохиолдлуудыг ажиглахад, ямар нэгэн онцгой үйл явдал гэхээс илүүтэй энгийн буюу “өөрийн тухай эргэцүүлэхэд (хөгширсөн зэрэг)”, “аянд мордохын өмнө мориныхоо дэргэд зогсох” гэх зэрэг үед ашиглажээ.*

Хүснэгт 4. “Бужин даваа хаан” баатрын хэвшмэл хэллэгийн тодотгол, жишээ

Төрөл	Бүтэц	Тохиолдол
Нэг зүйлээр тодотгосон	морь + баатар	Дайсан баатрын нэрийг дахин дуудахад
		Дайсныг тосон өөдөөс нь явах үед (хүү нь дайсныг тосохоор явах үед нэрийнх нь өмнө тодотгол хэлбэрээр илэрч байна)
Хоёр зүйлээр тодотгосон	нутаг + албат + баатар	Дайсан анх танилцуулахад (дайсан хүүгийн нэрийг анх дурдахдаа эцгийг анхлан дурдах)
Гурван зүйлээр тодотгосон	нутаг + албат + морь + баатар	Туульд анхлан баатрыг танилцуулахад
		Найр эхлээд баатрыг дахин дурдахад
		Зээ дүү нь хадамдаа гол баатрыг танилцуулахад
		Дайсан гол баатрыг анх танилцуулахад
		Дайсан гол баатрыг анх танилцуулахад

Дээрх хүснэгтэд “Бужин даваа хаан” гэх хэвшмэл хэллэгийг чимэг үгээр тодотгосон тохиолдлыг бүртгэн, ангилсан үр дүнг харууллаа. Эл тохиолдлуудыг ажиглахад, баатрын хэвшмэл хэллэгийг 1-3 зүйл (нутаг, албат, морь)-ээр тодотгон, өргөтгөсөн чимэг үг ашиглажээ. Өргөтгөсөн чимэг үг нь өмнөх туулийн адил нь нэгт, туульд анхлан баатрыг танилцуулах; хоёрт, өөр нэгэн баатар түүнийг танилцуулах; гуравт, ялгаатай баатрыг танилцуулах үед гол баатрыг дурдан тодотгох үүрэгтэй байна. Түүнчлэн “Бужин даваа хаан” туульд “чимэг үг + баатар” гэх бүтцээр гол баатрыг тодотгосон тохиолдол илрээгүй ба тогтмол 1-3 зүйлээр баатрын хэвшмэл хэллэгийг тодотгосон нь туулийн мөрийн тоо их байгаатай холбоотой байх магадлалтай.

Гурав. Өвөрмөц хийгээд өргөтгөсөн чимэг үгийн хэрэглээ, зүй тогтол

Эл хэсэгт гурван туулиас бүртгэсэн өвөрмөц болон өргөтгөсөн чимэг үгийн жишээг адил төстэй шинж чанараар нь ангилан, давтамжийг тооцооллоо. Ингэхдээ “туульд анхлан баатрыг танилцуулах”, “өөр нэгэн баатар түүнийг танилцуулах”, “ялгаатай баатрыг танилцуулах үед, гол баатрыг тодотгох” үүргээр орсныг “баатрыг танилцуулах” хэмээн багцлав. Мөн зөвхөн ганц удаагийн хэрэг явдалд илэрсэн жишээг “бусад тохиолдол” гэх ангилалд багтаасан.




График 2. Өргөтгөсөн чимэг үгийн ангилал, давтамж

Графикаас ажиглахад, *баатрыг танилцуулах* болон *бусад тохиолдол гэх ангилал* дийлэнх хувийг бүрдүүлж байна. *Баатрыг танилцуулах ангилалд* багтсан 14 тохиолдол бүгд баатрыг 1-3 зүйлээр тодотгон, өргөтгөсөн чимэг үгээр дүрсэлсэн бол, *бусад Баатрыг танилцуулах ангилалд багтсан 14 тохиолдол бүгд баатрыг 1-3 зүйлээр тодотгон, өргөтгөсөн чимэг үгийг бүтээн дүрсэлсэн бол, бусад тохиолдолд багтсан нийт найман тохиолдлоос зургаа нь баатрыг зөвхөн чимэг үгээр тодотгон, өвөрмөц чимэг үгийг бүтээжээ. Харин үлдсэн хоёр тохиолдлын нэг нь “Эзэн улаан бодон” туульд хөвүүнийхээ дайсныг дарсан алдар гавьяаг нь магтахдаа өмнө тодотгол хэлбэрээр хэрэглэсэн бол нөгөө нь, дайсныг дараад аман гурван үг асуухад илэрчээ.*

“Галзуу хар хөхөл” туульд “Баатар бор магнай” баатрыг 12 удаа дурдсанаас дараах хоёр жишээнд “Жигүүрт бор халзан морьтой, Баатар бор магнай” гэж дүрсэлжээ. Үүнд:

1. Баатрын алдар нэрийг нь дуудахад буюу туульд анхлан танилцуулахад;
2. Заяаны зандан дагинаа залахаар очоод, хадамдаа өөрийгөө танилцуулахад

дээрх байдлаар өргөтгөсөн чимэг үгийг ашиглажээ. Мөн туульд “Ноёлхуу зандан хатан” гэж нийт 11 удаа дурдсанаас дараах гурван тохиолдолд “*Ногоон дархийн хувилгаантай, Ноёлхуу зандан хатан*” гэж дүрсэлдэг. Тухайлбал:

1. Туульд анхлан хатныг танилцуулахад;
2. Олзлогдон явсных нь дараа нууж үлдээсэн номтой шар бичгийг уншихад;
3. Бал улаан хүүгийн алдар нэрийг дуудаж, алтан хонгорцгийг үргээх үед

дээрх байдлаар дурдаж буй юм.

“Бужин даваа хаан” туульд түүний хөвүүн “Бурхан хар баатар”-ын нэр нийт 53 удаа давтдагаас 15 удаад өргөтгөсөн чимэг үгээр дүрсэлжээ. Үүнээс “[чимэг үг] морь + эцэг + баатар” гэсэн бүтэцтэй дараах хэсэг хоёр удаа дурдагддаг.

Уулын дүнтэй хурдан
Хар халзан морьтой
Бужин даваа хааны хөвүүн
Бурхан хар баатар[28] [1231-1233], [4199-4202]

Дээрх дүрслэл баатрын алтан хонгорцгийг нь хайчилж, алдар нэрийг нь хайрлахад, удаагаар, түүний дүү болох “Баатар бор магнай” заяаны зандан дагинаа залахаар хадамдаа очин ахыгаа танилцуулахад тус тус ийн шүлэглэн өгүүлж байна.

Энэ мэтчилэн өргөтгөсөн чимэг үг нь баатар, хатдаас гадна дайсны хэвшмэл хэллэгт мөн адил илэрч байгаа юм. Тухайлбал, “Эзэн улаан бодон” туульд “Матар хар соёо” гэж нийт 33 удаа дурддагаас хоёр тохиолдолд “*Дөрвөлжин хар уул нутагтай, Дөлөөн олон муж албаттай, Дөрмөн цоохор морьтой, Дөмөг матар хар соёо*”[29] [1015-1020], [1506-1510] хэмээн өгүүлдэг. Энэ нь мөн, анхлан өөрийгөө танилцуулах; уг мангасыг ялсан баатрын алдар нэрийг нь дуудахад тухайн баатрыг тодотгох үүргээр илэрч байна.

Дээр дурдсан бүх жишээнээс үзэхэд, тухайн бодон баатар, хатад дагинасын хэвшмэл хэллэгийг өргөтгөсөн эсвэл өвөрмөц чимэг үгээр тодотгох тохиолдол ураг хурим хийх, сэвлэг үс үргээн, алтан хонгорцог авах насны гурван хурим,

[28] *Нэрт туульч С. Чойсүрэнгийн туульс*. эмхэт. Б. Катуу, УБ., 2010, х.194.
[29] Мөн тэнд, х.753.

төрийн чухал үйл хэрэгт илрэхийн зэрэгцээ мангас махчинтай тэмцэлдэх амь өрссөн үед өгүүлж буйгаараа онцлогтой байна. Өөрөөр хэлбэл, дээрх чимэг үгс нь тодорхой нөхцөлд илрэхээс бус тухайн баатрыг дурдах болгонд тохиолдохгүй байна. Энэ нь цаашлаад баатрын хэвшмэл хэллэгийн давтамжийн нягт бага байгаатай холбоотой гэж дүгнэж болохоор байна.

ДҮГНЭЛТ

Энэхүү илтгэлд С.Чойсүрэнгийн хайлсан “Галзуу хар хөхөл”, “Эзэн улаан бодон”, “Бужин даваа хаан” туулийн баатрын хэвшмэл хэллэгийн давтамжийн нягтыг тооцож, өвөрмөц болон өргөтгөсөн чимэг үгийг хэрэглээг задлан шинжиллээ.

Гурван туулийн сонгож авсан баатрын хэвшмэл хэллэгийн давтамжийн нягт нь 0,3-4,0%-ийн хооронд хэлбэлзэж байна. Иймд, бидний сонгож авсан баатарлаг туульсын мөрийн тоо ялгаатай боловч баатрын хэвшмэл хэллэгийн давтамжийн нягт ойролцоо байгаа нь туулийн урт, богиноос үл хамааран, баатрыг тоочин дурдах, нэрлэх тоо хэмжээ нь тогтмол байж болох таамаглалыг баталж байна.

Гол баатрын хэвшмэл хэллэгийг өргөтгөсөн болон өвөрмөц чимэг үгээр тодотгосон тохиолдлыг түүвэрлэн, тодорхой зүй тогтол байгаа эсэхийг “нутаг + албат + морь + [чимэг үг] + баатар” гэх бүтцийн хүрээнд задлан шинжиллээ. Гурван туульд баатрыг танилцуулахдаа ямагт өргөтгөсөн чимэг үгийг хэрэглэж буй нь зүй тогтол юм. Үүнээс, мөрийн тоо цөөн “Галзуу хар хөхөл”, “Эзэн улаан бодон” туульд баатрыг танилцуулахад, “морь + баатар” эсвэл “нутаг + баатар” гэх нэг зүйлээр нь баатрыг тодотгожээ. Харин мөрийн тоогоор их “Бужин даваа хаан” туульд баатрыг нэг зүйлээр бус ямагт 2-3 зүйлээр нь тодотгон, танилцуулжээ. Иймд баатрыг тодотгох өвөрмөц хэл хэллэгийн чимэг үгийн бүтэц нь туулийн мөрийн тоотой холбоотой байна хэмээн таамаглаж болохоор байна.

Түүвэрлэсэн өвөрмөц болон өргөтгөсөн чимэг үгийг адил төстэй шинж чанараар нь нарийвчлан ангилж, давтамжийг нэгтгэхэд, баатрыг танилцуулах болон бусад тохиолдол гэх ангилал дийлэнх хувийг бүрдүүлжээ. Эндээс баатрыг танилцуулахад “өргөтгөсөн чимэг үг”-ээр, зөвхөн ганц удаагийн буюу ерийн явдлын үед дүрслэхэд “өвөрмөц чимэг үг”-ээр тодотгодог гэх зүй тогтол илэрч байна. Түүнчлэн уг зүй тогтол бусад баатарт адил тохиолдож буй эсэхийг шинжлэхэд өргөтгөсөн эсвэл өвөрмөц чимэг үгээр тодотгох тохиолдол зөвхөн баатрыг таниулахаас гадна насны гурван хурим, төрийн чухал үйл хэрэг гэх мэт тодорхой нөхцөлд илрэхээс биш тухайн баатрыг дурдах болгонд үл ашиглаж байна.

A STUDY OF THE DISTINCTIVE ORNAMENTAL EPITHETS USED IN THE NAMES AND APPELLATIONS OF THE HEROES IN THE EPICS OF SÜKHIIN CHOISÜREN

(Based on the Epics Galzuu Khar Khökhöl, Ezen Ulaan Bodon, and Bujin Davaa Khaan)

This paper aims to identify the distinctive linguistic and stylistic features of the epic performance tradition of the renowned Altai Uriankhai epic singer Sükhiin Choisüren. The study examines three epics, Galzuu Khar Khökhöl, Ezen Ulaan Bodon, and Bujin Davaa Khaan, by analyzing the frequency of heroic names and appellations and identifying patterns in the use of formulaic expressions containing distinctive ornamental epithets. The methodology is based on the Oral Formulaic Theory developed by Milman Parry and Albert Lord and employs both quantitative and qualitative approaches to investigate the use of formulaic diction. The study compares the frequency of the principal hero's name, the forms and structures of ornamental epithets, and their patterns of usage, while also examining and interpreting the functions of formulaic expressions in epic performance. The significance of this research lies in its contribution to the study of individual epic singers' performance styles, the detailed structural analysis of performed epics, and the identification of the performer specific idiolect embedded within oral epic narration.

Keywords: *Oral-Formulaic Theory, Sükhiin Choisüren, epic hero, distinctive ornamental epithet.*

НОМ ЗҮЙ

Эх хэрэглэгдэхүүн

Нэрт туульч С. Чойсүрэнгийн туульс, (2010), Эмхэтгэн боловсруулж, эрдэм шинжилгээний удиртгал, тайлбар бичсэн Б. Катуу, УБ., "Shiny Printing" ХХК.

Судалгааны бүтээл

Аргил цагаан өвгөн, (1985), Эмхэтгэн боловсруулсан Р. Нарантуяа, Х. Сампилдэндэв, УБ., Сурах бичиг, хүүхдийн номын хэвлэлийн газар.

Баруун монголын баатарлаг туульс, (1966), (Аман зохиол судлал, IV боть, 2-р дэвтэр), Эмхэтгэн боловсруулж, хэвлэлд бэлтгэсэн Ж. Цолоо, У. Загдсүрэн, УБ., Шинжлэх ухааны академийн хэвлэх.

Борджанова, Т. Г., *Творчество западномонгольского сказителя С. Чойсурена*, (1987), (Аман зохиол судлал, XVII боть, 3-р дэвтэр), УБ., Шинжлэх ухааны академийн хэвлэх.

Монгол ардын баатарлаг туульс, (1960), Эмхэтгэн боловсруулж, удиртгал тайлбар үйлдсэн Г. Ринчинсамбуу, УБ., Улсын хэвлэлийн газар.

Нарантуяа, Р., *Урианхай туульс*, (1987), (Аман зохиол судлал, XVII боть, 7-р дэвтэр), УБ., Шинжлэх ухааны академийн хэвлэх.

Сампилдэндэв, Х., (2002), *Монгол аман зохиолын товчоон*, УБ., “Бэмби сан” хэвлэлийн газар.

Туяабаатар, Л., (1995), *Алтайн урианхайн баатарлаг туульс, түүний эх сурвалж, өвөрмөц шинж*, Өлгий.

Хишигбаяр, П., (1997), *Чойсүрэнгийн хайлсан туулийн онцлог*, (Магистрын зэрэг горилсон ажил). МУИС-ийн Ховд салбар сургууль.

Цогжин, Б., (2010), *Аман туулийн шүлэг зүй,* УБ., “Бэмби сан” хэвлэх үйлдвэр.

ТОВЧИЛСОН НЭР

БДХ – Бужин даваа хаан

ГХХ – Галзуу хар хөхөл

ЭУБ – Эзэн улаан бодон

2026 Fasc.12

МОНГОЛ АМАН ЗОХИОЛ ДАХЬ УРГАМЛЫГ ОНЬСОГОЛОХ ТОГТМОЛЫГ ШИНЖЛЭХ НЬ

Бямба-Эрдэнийн НОМИН
МУИС-ийн Утга зохиол судлал хөтөлбөрийн IV курсийн *оюутан*

Удирдагч: И. Даваадорж
МУИС-ийн Утга зохиол, урлаг судлалын тэнхимийн багш, докторант

Хураангуй: *Оньсого нь юм, үзэгдлийн голлох шинжийг илэрхийлэх тогтмолд тулгуурлаж, нэрийг нууцлан асуудаг аялгуут бус аман яруу найргийн зүйл юм. Ургамлыг оньсоголох тогтмолыг ангилан, шинжилж үзэхэд гадна хэлбэр байдал, бүтцийг тогтмол болгон оньсоголох нь түгээмэл, харин мэдрэхүйд өртөх байдал болон хэрэглээ, ач холбогдлыг тогтмол болгосон нь цөөн байна. Энэ нь ургамал болон оньсогын төрөл зүйлийн онцлог, гадаад хэлбэрт тулгуурлан байгалийг танин мэдэх арга замтай холбоотой. Түүнчлэн ургамлыг оньсоголох тогтмолыг угсаатны ургамал судлалын Брэнт Бэрлиний ангиллын долоон зарчмаар шинжлэн үзэхэд таарч буй нь ургамал амьтныг ангилах хүний сэтгэлгээний бүтэц нь хэл, соёлоос үл хамааран үндсэндээ ижил байдаг гэсэн дүгнэлтийг батлах юм.*

Түлхүүр үг: *Ургамлын оньсого, оньсоголох тогтмол, угсаатны ургамал судлал, угсаатны биологийн ангилал*

УДИРТГАЛ

Эртний хүний ертөнцийг танин мэдэх гэсэн оролдлого, туршлагын ул мөр аман зохиолын зүйлсэд хадгалагдан үлдсэн байдаг. Монгол аман зохиолын аялгуут бус аман яруу найргийн төрөл зүйл болох оньсого нь "...нэгэн юм үзэгдлийн олон зүйл шинж тэмдэг, овор байдал, уг язгуурыг уудлан гаргахыг оролддог"[1] онцлогтой тул сав, шим ертөнцийн олон зүйлс, түүний дотроос ургамлын онцлог, шинж чанарыг танин мэдэж, оньсоголох тогтмол болгон, уран дүрслэлийн аль нэгэн арга хэлбэрээр илэрхийлсэн онцлогтой юм.

[1] Нандинбилиг, Г., Дулам, С., *Монгол аман зохиолын онол II*, УБ., 2020, х.135.

Монгол оньсогыг сурвалжлан цуглуулсан байдлыг авч үзвэл ОХУ-ын эрдэмтэн В. Л. Котвич *Кальмыцкие загадки и пословтцы* (1905), Ц. Жамцарано, А. Руднеев нар *Обрацзы монгольской народной литературы* (1908), Бельгийн эрдэмтэн А. Мостаэрт *Textes oraux Ordos* (1937), ОХУ-ын эрдэмтэн И. Н. Мадасон *Оньһон үгэнүүд, таабаринууд* (1956), Н. О. Шаракшинова *Загадки* (1981), Ц. А. Дугарнимаев *Түмэн таабари* (1981), Ц. Б. Будаев *Оньһон үгэ оношто*й (1988) зэрэг эрдэмтэн анхлан цуглуулж хэвлүүлсэн байна. БНХАУ-ын эрдэмтэн Г. Журамт, Д. Өргөн нар *Оньсогууд* (1958), Ням, Цэцэнгуа нар *Монгол оньсогын түүвэр* (1986), Дээнжав *Оньсогын чуулган* (1989) зэрэг түүвэр хэвлүүлжээ. Монгол улсын эрдэмтэн П. Хорлоо *Монгол ардын зүйр цэцэн үгүүд ба оньсогууд* (1966), Ц. Өлзийхутаг *Түмэн оньсого I-II* (1966, 1989), Ш. Гаадамба, Г. Ловор *Монгол ардын оньсого таавар* (1990) зэрэг бүтээлдээ сурвалжлан цуглуулж, өмнөх үг, тайлбар зүүлт болон газар орны мэдээ, индекстэй хэвлэсэн байна.

Ангилан судалсан байдлыг үзвэл академич П. Хорлоо (1966), Н.О.Шаракшинова (1981), Ш. Гаадамба, Х. Сампилдэндэв (1988), С. Дулам, Г.Нандинбилиг (2005, 2007), Г. Ловор (2005), Ганцэцэг (2013) нарын эрдэмтэд монгол оньсогын төрөл зүйлийн онцлогийг тодорхойлж, тухайн онцлогийг харгалзан ангилах санал дэвшүүлсэн байна.

Ургамлыг аман болон бичгийн зохиол, утга бэлгэдлийн үүднээс судалсан байдлыг харвал профессор С. Дулам *Монгол бэлгэдэл зүй: Дүрсийн бэлгэдэл зүй, дохио зангааны бэлгэдэл зүй* (2001) ба *Монгол бэлгэдэл зүй: Зүүд зөн совингийн бэлгэдэл зүй, цагийн бэлгэдэл зүй* (2002), *Монгол угсаатны утга соёл дахь ургамлын бэлгэдэл* (2018) өгүүлэл, Д. Нямдорж *Монгол аман зохиол дахь зохиомол үгсийн тухай: Хэл зүгшрүүлэх үг, даалууны гуншин, оньсого, домог, үлгэр, туульь* (2012) магистрын судалгааны ажил болон *Монгол аман зохиол дахь зохиомол үгс* (2021) бүтээл, М. Энхбаатар *Монголчуудын ертөнц дэх "Мод"* (2025) бүтээл хэвлүүлжээ. Б. Батцэцэг *Монголчуудын ургамлын тухай мэдлэг, хэрэглээний уламжлалаас (этноботаникийн чиглэлээр)* (2006) сэдэвт магистрын судалгааны ажилдаа ургамлаар цаг агаарыг урьдчилан шинжих, ургамалтай холбоотой бэлгэдэл, зан үйл, ахуйн хэрэглээ хийгээд цайны ургамал, холбогдох зан үйлийг шинжлэн судалсан байна.

Оньсого болон ургамалтай холбоотой уламжлал, ардын билиг, бэлгэдэл, зан үйлийг судалсан судалгаа олон бий боловч ургамлын оньсогыг судалсан эрдэм шинжилгээний бүтээл цөөн байна. Тус судалгаа нь байгалийн шинжлэх ухааны парадигмаас өмнө монголчууд хэрхэн хүрээлэн буй орчныг танин мэдэж, онцлог шинжийг ялган нэрлэснийг тодруулах, мөн орчин үеийн ургамал судлалын шинжлэх ухаантай хэрхэн холбогдохыг авч үзэж буйгаараа ач холбогдолтой.

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Ургамлыг оньсоголох тогтмолыг шинжлэх нь

Аливаа юм, үзэгдлийг оньсоголохдоо бусдаас ялгарах хамгийн гол, онцлог шинж, салган ойлгож үл болох чанар буюу оньсоголох тогтмолд тулгуурлан зохиодог. Оньсоголох тогтмол тухайн эд зүйл, юм үзэгдлийн голлох шинж чанарыг заасан агуулгыг илтгэнэ.

Түмэн оньсого I, II (1966, 1989) болон *Монгол ардын оньсого таавар* (1990) эмхэтгэлээс ургамлын тухай 728 оньсого цуглуулснаас давхардсан болон ургамлын тухай биш гэж үзсэн (сүлжмэл сагс, зоорьтой будаа, гурилын аяга гэх зэрэг) заримыг хасаж, үлдсэн 652 оньсогыг задлан шинжилж, харьцуулсны үндсэн дээр тэдгээрийн тогтмолыг дараах байдлаар ангилав. Ургамлын оньсогыг ангилахдаа хуваалтын суурийг бүтэц, харагдах байдал, экологи, амьдралын хэлбэр, мэдрэхүйд өртөх байдал, хэрэглээ, ач холбогдол гэх таван ерөнхий хэсэгт хуваж, нарийвчилсан дэд хэсгүүдэд хуваалаа (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Ургамлыг оньсоголох тогтмолыг ангилсан нь (давхардсан тоогоор)

Ерөнхий		Нарийвчилсан				Тоо
1.	Харагдах байдал	1.1			Хэлбэр, дүрс	476
		1.2			Өнгө	251
		1.3			Хэмжээ	19
2.	Бүтэц	2.0			Доод ургамлын бүтэц	14
		2.1			Үндэс	54
		2.2	Иш, мөчир	2.2.1	Иш, мөчир	165
				2.2.2	Хувирсан иш	132
		2.3	Навч	2.3.1	Навч	209
				2.3.2	Хувирсан навч	54
		2.4			Цэцэг	81
		2.5			Үр жимс	197
3.	Экологи, амьдралын хэлбэр	3.1			Орчин, нөхцөл	161
		3.2			Улирал даган өөрчлөгдөх/эс өөрчлөгдөх шинж	67
		3.3			Төрөл зүйлийн онцлог (үр тараах хэлбэр, гарал үүсэл гэх мэт)	141
4.	Мэдрэхүйд өртөх байдал	4.1			Амтлах	11
		4.2			Үнэрлэх	5
		4.3			Хүрэх	6
		4.4			Сонсох	14
5.	Хэрэглээ, ач холбогдол	5.1			Хоол хүнс	88
		5.2			Ахуй амьдрал	18
		5.3			Биологийн идэвхт чанар	2
		5.4			Бусад	5




График 1. Ургамлыг оньсоголох тогтмолын ангиллын дүрслэл




График 2. Ургамлыг оньсоголох тогтмолд ангилал тус бүрийн эзлэх хувь (давхардсан тоогоор)

Дээрх хүснэгт, графикаас үзвэл ургамлын харагдах байдал, бүтцэд тулгуурлан оньсоголсон нь хамгийн их байгаа бол экологийн шинж, амьдралын хэлбэрийг тогтмол болгосон нь дундаж, мэдрэхүйд өртөх болон хэрэглээ, ач холбогдлыг чухалчилсан нь хамгийн бага байна.

I. Харагдах байдал

Ургамлын тухай 652 оньсогын 496 оньсогод хэлбэр дүрс, 251 оньсогод өнгө, 19 оньсогод хэмжээг голчлон үзэж, оньсоголох тогтмол болгосон байна. Үүнээс харвал харагдах байдал, гадаад хэлбэр төрхөөр ялгаж, салгах нь аливаа зүйлийг танин мэдэх эхний алхам болдог байна.

Нийт ургамлын оньсогын 73 хувьд хэлбэр дүрс нь оньсоголох тогтмол болжээ. Жишээлбэл байцайн бөндгөр бөөрөнхий хэлбэр дүрсийг бусад ургамал, хүнсний ногоотой харьцуулан *зантгар* хэмээж, олон давхар навчийг дээлээр

адилтган оньсоголсон байна. Түүнчлэн дотроо үргүй онцлогийг дээл гэсэн адилтгалтай холбон товчгүй хэмээн тодотгожээ.

Зантгар хүү
Далан давхар дээлтэй
Дээл бүгд нь
Нэг ч товчгүй (Байцай)[2]

Мөн өнгийг тогтмол болгох нь харьцангуй түгээмэл тохиолдоно (38.49%). Тухайлбал доорх оньсогод тарвасын гадна, дотор бүтцийн хэсгийг хэрэглээтэй нь холбож, харгалзах өнгөөр төлөөлүүлэн оньсоголсон байна.

Харахад ногоон
Хэрэглэхэд улаан
Хаяхад хар (Тарвас)[3]

Тарвасын тухай дээрх оньсогод мөн нэгэн сонирхолтой шинж илэрч буй нь анхлан тухайн объектыг харах харагдах өнгө, хазаж идэхэд үзэгдэх өнгө, идэж дууссаны араас үлдэх үрийн өнгөөр төлөөлүүлэн, үйл явдал бүтээж байгаа онцлогтой юм.

Овор хэмжээ, урт богино, хүнд хөнгөний харагдах байдлыг ямар нэгэн зүйлтэй зүйрлэх эсвэл шууд заан нэрлэж оньсоголсон нь цөөн тоотой байна (2.91%).

Тас гэх ясгүй
Таван фунт махгүй (Нэрс)[4]

Жишээ нь дээрх оньсогыг таах хүнд нэрсний оньсогод ясгүй гэж дохиолоод, ясгүй олон жимс, ургамлын дотроос таван фунт махгүй хэмээн хэмжээг заан байж болох сонголтыг нарийсгажээ.

II. Бүтэц

Ургамлын тухай 14 оньсогод доод ургамлын бүтцийг, 54 оньсогод үндсийг, 165 оньсогод иш мөчрийг, 132 оньсогод болох хувирсан иш мөчрийг, 209 оньсогод навчийг, 54 оньсогод хувирсан навчийг, 81 оньсогод цэцгийг, 197 оньсогод үр жимсийг оньсоголох тогтмол болгожээ. Зарим оньсогод ургамлын бүтцийн нэг хэсгийг, заримд нь хэд хэдэн хэсгийг хамтад нь утга далдлан өгүүлснийг тооцон бүртгэж, ангилав.

Өнөө үед ч “ургамлын аймгийг ангилах асуудал дуусаагүй бөгөөд ялангуяа ангилал зүйн төрөл, овог гэсэн таксономийн үүсэл, хоорондын уялдаа холбоо тун бага судлагджээ. Гэхдээ түүхэн хөгжлийн ерөнхий зарчим ургамлын

[2] Өлзийхутаг, Ц., эмх., *Түмэн оньсого I,* УБ., 1966, х.60.
[3] Мөн тэнд, х.55.
[4] Мөн тэнд, х.56.

ертөнцийн хөгжлийн тухай үзлийн гол чиглэл нь адил юм. Бид ургамлын аймгийг долоон салбар аймаг болгон хүрээ, баг, гол овог төрлүүдийг нь төлөөлөн судлах зарчмыг (В. Г. Хржановский, 1982) баримталъя"[5] хэмээсний дагуу мөөгний оньсогыг ургамлын оньсогод багтаан судаллаа.

Ургамлыг оньсоголох тогтмолыг бүтцийн дагуу ангилсан ангиллын 2.0 дэд хэсэгт доод ургамлын бүтцийн хэсгийг тогтмол болгосон оньсогыг хамрууллаа. Тус дэд хэсэгт зөвхөн мөөгний тухай оньсого багтаж байна. Учир нь доод ургамалд вирус, бактери, мөөг, салстан болон олон төрлийн замаг хамаардаг боловч шинжлэх ухааны хөгжил, аж ахуй, газар зүйн онцлог, нийгэм цаг үеийн нөхцөл зэрэг хүчин зүйлээс шалтгаалан мөөгнөөс бусад доод ургамлын тухай оньсого олдоогүй байж болох юм. Мөөгний тухай оньсогыг авч үзвэл:

Хөл мөнгөн аавтай
Хөгшин буурал ээжтэй
Хөвч өндөр ойтой
Хөл маахай гуталтай
Ерэн долоон үрчлээтэй
Ембүү цагаан хүү (Мөөг)[6]

Дээрх жишээнд мөөгний мицелл буюу ургал биеийн газарт тархсан байдлыг *хөл маахай гуталтай*, шилбэний утаслаг бүтцийг *ерэн долоон үрчлээтэй* адилтган, хүншүүлэх арга ашиглан оньсоголсон байна.

Оньсогод ургамлын үндсийг "үрийн сайнаар ургаж, үндэсний муугаар ховхорлоо (хамхуул)" гэх мэт шууд нэрлэн өгүүлэхээс гадна хэлбэр байдлаар нь төстэй зүйлстэй адилтган дүрслэх нь элбэг. Тухайлбал сонгинын газар доорх хувирсан иштэй холбоотой саглагар үндсийг үстэй адилтган оньсоголсон нь бий.

Улаан дээлтэй чавганц
Уландаа үстэй (Сонгино)[7]

Оньсогод иш мөчрийг ихэвчлэн харагдах байдал төстэй зүйлээр адилтган дүрсэлнэ. Түүнчлэн таалгаж буй юм нь өөрөө иш мөчир байж болдог. Жишээлбэл доорх оньсогод хулсны үелсэн ишийг давхарласан авдар, залгаасаар илэрхийлэн дүрсэлжээ.

Авдар дээр авдар
Залгаа дээр залгаа (Хулсны үе)[8]

Ургамлын оньсогод навчийн олноор ургах болон улирал солигдоход унадаг шинжийг тогтмол болгох нь элбэг боловч цөөн хэдэн оньсогод хэлбэр дүрсээр

---

[5] Оюунчимэг, Д., *Ургамлын ангилал зүй,* УБ., 2002, х.13.
[6] Өлзийхутаг, Ц., эмх., *Түмэн оньсого I,* УБ., 1966, х.47.
[7] Мөн тэнд, х.52.
[8] Мөн тэнд, х.51.

адилтгасан нь байдаг. Жишээ нь модны мөчир хөдлөхөд унжсан навч тасран унахыг ээмэгтэй адилтган оньсоголжээ.

Гэмпэлхайн охид
Гэлэр гэлэр хатирав
Гэлэр сайхан ээмгээ
Тасартал тасартал хатирав (Модны навч унах)[9]

“Ургамал өөрийнхөө амьдрах орчин нөхцөлөөс хамааран навчны дүрс хувирал байгаль нэлээд түгээмэл тохиолдоно. Зарим ургамлын навч танигдахаа болтлоо дүрсээ хувирган үндсэн үүргээсээ өөр үүрэг гүйцэтгэх болсон байдаг”[10]. Эл шинжтэй ургамлын навчийг хувирсан навч хэмээдэг. Хувирсан навч болох цагаан төмс, сонгино саримс зэргийн хальсыг дээл хувцас болгон адилтгаж дүрслэх нь бий. Жишээлбэл сонгиныг хүү хэмээн хүншүүлж, олон давхар хальсыг далан давхар хувцастай адилтгаснаас хувирсан навчийг ургамлын оньсоголох нэгэн чухал шинж хэмээн үзэж байсныг харж болно.

Далтай хааны үрлэн хүү
Далан давхар хувцастай (Сонгино)[11]

Цэцгийг оньсогод малгай, гэзэг, залаа, жинс зэрэгтэй адилтгах нь түгээмэл тохиолдоно. Энэ нь ургамлын бүтцийг хүний биеийн бүтэцтэй харгуулж байгаа хэрэг юм. Тус оньсогод сараана цэцгийг нийтэд нь малгайгаар, дэлбээг нь араагаар дүрслэн илэрхийлсэн байна.

Идэр голын охин би
Өдөн шар малгайтай
Өдөн шар малгай минь
Олон тийшээ араатай (Сараана цэцэг)[12]

Өмнө дурдсанчлан үр, жимсийг тухайн ургамлын бусад хэсгийн хүүхэд болгон дүрсэлдэг.

Өндөр тивд нутагтай
Өвгөн сагсгар эцэгтэй
Ясан хавчуур ээжтэй
Ёвуу цагаан хүүхэд нь
Шар торгон цамцтай (Хушинд ургасан самар)[13]

Энэ нь ургамал үр жимсээрээ дамжин өсөж үрждэгийг ажиглан мэдэж, хүнтэй харьцуулсан үр дүн юм. Жишээ нь модны мөчрийг аав, боргоцойг ээж,

[9] Өлзийхутаг, Ц., эмх., *Түмэн оньсого II,* УБ., 1989, х.39.
[10] Ургамал, М., Магсар, Д., Сангидорж, Б., *Ургамал судлал*, УБ., 2003, х.70.
[11] Өлзийхутаг, Ц., эмх., *Түмэн оньсого II,* УБ., 1989, х.36.
[12] Мөн тэнд, х.38.
[13] Мөн тэнд, х.41.

самрыг хүүхэдтэй адилтган, хальсыг шар торгон цамц хэмээн бүтцийн хэсгийг задлан оньсоголжээ.

III. Экологи, амьдралын хэлбэр

Ургамлын экологийн шинж, амьдралын хэлбэрийг тогтмол болгон оньсоголсныг задлан үзвэл 161 оньсогод ургах орчин нөхцөл, 67 оньсогод улирал даган өөрчлөгдөх/ эс өөрчлөгдөх шинж, 141 оньсогод тухайн зүйл ургамлын онцлогийг оньсоголох тогтмол болгожээ.

Байгалийг төрөл зүйлээр ялган ангилахаас илүү тэдгээрийн тогтолцоот харилцан хамаарлыг ойлгосноор байгаль хамгааллын хариуцлагатай хандлага төлөвшиж эхэлдэг[14]. Аман зохиолд ч ургамлыг хүрээлэн буй орчинтой хамтатган үзэж, ургах нөхцөлөөр оньсоголсон нь нийт оньсогын 24,69% болно. Ургамал фотосинтез явуулахад нарны гэрэл, ус, агаар, хөрс болон тохиромжтой температур шаардлагатай. Доорх оньсогод нарны гэрэл, ус, агаар, хөрс гэх дөрвөн нөхцөлийг оньсоголох тогтмол болгон шүлэглэжээ.

Алтан наранд ивээгдэж
Агаарын хийгээр тэтгэгдэж
Хөх усыг хөлөөрөө ууж
Хөрст дэлхийг бүрхэнэ (Ургамал)[15]

Мөн улирлын өөрчлөлт ургамалд хэрхэн нөлөөлөхийг таньсан байна. Түүнчлэн зарим мод, ургамал улирал даган өөрчлөгддөггүйг ажиглажээ. Тухайлбал бургасны навч ургах, унахыг баяжих, үгүйрэх хэмээн хүншүүлэн дүрсэлсэн байхад шилмүүст моддын орчиндоо дасан зохицож, навч нь хувьссаныг эдийн засгийн утгаар илэрхийлсэн байна.

Өндөр хар хүн
Хаварт баяжиж
Өвөлд үгүйрнэ (Бургас навчлах навч нь унах)[16]
Өвөл зунгүй саглаахай
Өвгөн залуугүй сэглээхэй (Нарс, хуш, гацуур, жодоо)[17]

Ургамлыг гадаад хэлбэр байдлаар ялган таньсаны дараа төрөл зүйл тус бүрийн хувь онцлогийг тусган оньсоголсон нь 21,62%-ийг эзэлнэ.

Алтан сайхан малгайг
Толгойдоо өмсөж

---

[14] Stephen, R., Kellert, "The Biological Basis for Human Values of Nature," in *The Biophilia Hypothesis*, (Washington, DC: Island Press, 1993), p.45.
[15] Ловор, Г., Өлзийхутаг, Ц., эмх., *Монгол ардын оньсого таавар,* УБ., 1990, х.64.
[16] Өлзийхутаг, Ц., эмх., *Түмэн оньсого I,* УБ., 1966, х.57.
[17] Мөн тэнд, х.57.

Амтат жимсээр хацраа чимж
Асхан сайхан бие нь
Огторгуй тулан зогсож
Агаарын нарны эргэлтийг
Алдалгүй ширтэнэ (Наран цэцэг)[18]

Наран цэцгийн тухай дээрх оньсогод түүний цэцгийг малгайтай адилтгаж, ишийнх нь өндрийг огторгуй тулах хэмээн дүрслээд, нахиалах үедээ нарны хөдөлгөөн даган эргэдэг онцлогийг алдалгүй ширтэх гэж хүншүүлэн илэрхийлсэн байна.

IV. Мэдрэхүйд өртөх байдал

Ургамлыг оньсоголох тогтмолыг хүний мэдрэхүйд өртөх байдлаар дэд хэсэг хуваан үзвэл, 11 оньсогод нь амтлах, таван оньсогод нь үнэрлэх, зургаан оньсогод хүрэлцэх, 14 оньсогод сонсох мэдрэхүйд өртөх байдлыг тогтмол болгожээ. Эдгээр оньсогын зарим нь тэрхүү ургамлын хэрэглээтэй, хүний үйлдэлтэй хамааралтай бол, заримдаа төрөл зүйлийн онцлогтой холбогдож байна.

Ургамлыг оньсоголохдоо амтлах мэдрэхүйд өртөх байдлыг тогтмол болгосон нь ихэвчлэн хүнсэнд хэрэглэдэг ногоо, жимсний зүйлсэд хамаарч байна. Жишээлэн мэхээрийг оньсоголохдоо:

Газар доор
Гаатай чихэр (Мэхээр)[19] хэмээжээ.

Дээрх оньсогод мэхээрийг тос хийх, цагаан идээнд холих зэрэг олон янзаар ашиглах байдал, цагаан тостой хольж хэрэглэх идээ ундааны соёл, амт чанарыг оньсоголох тогтмол болгожээ.

Ургамлын үнэрийг оньсоголох тогтмол болгосон нь цөөн (0,76%) байна. Сонгино, агь, цэцэг гэсэн гурван төрөл зүйлийн ургамлын үнэрийг сонгон оньсоголжээ. Доорх оньсогод агийн хэлбэр дүрсийг хурганы арьстай адилтган утга далдалж, анхилам сайхан үнэртэй болохыг тодотгосон байна.

Арын хурганы арьс
Аржгар буржгар байтлаа
Анхилам сайхан үнэртэй (Агь)[20]

Хүрэх мэдрэмжээр ургамлыг оньсоголсон нь ч цөөн (0,92%) байна. Үүнд өвс, өргөс, шивээ, халгай, тарвас багтаж байна. Нийтлэг байдлаар ажвал, тухайн ургамлын гадаргууд хүрэхэд ямар нэгэн гэмтэл, таагүй мэдрэмж өгөх байдлыг онцолжээ.

---

[18] Өлзийхутаг, Ц., эмх., *Түмэн оньсого I,* УБ., 1966, х.55.
[19] Ловор,Г., Өлзийхутаг, Ц., эмх., *Монгол ардын оньсого таавар,* УБ., 1990, х.70.
[20] Өлзийхутаг, Ц., эмх., *Түмэн оньсого I,* УБ., 1966, х.48.

Гар хэрвээ түүнд хүрвэл
Гал дөлгүй ч түлж орхидог (Халгай)[21]

Тус оньсогод халгайн гадаргуу дээрх бичил өргөс болон түүнд агуулагдах бодисоос үүдэлтэй улайх, хорсох мэдрэмжийг тогтмол болгон оньсоголсон байна. Дэлгэрүүлэн тайлбарлавал, халгайн бичил өргөсөнд байх шингэн бодис нь хүний арьсанд хүрэхэд галаар түлэхтэй ижил хариу урвал үзүүлдэг болохыг онцолжээ.

Сонсох мэдрэхүйд өртөх байдлаар оньсоголсон нь ургамлын оньсогын 2,14%-ийг бүрдүүлнэ. Эдгээр оньсого нь ихэвчлэн өвс хадах, тариа боловсруулах зэрэг хүний үйлдэл, болон зарим ургамлын онцлогоос хамаарч байна.

Өвч бие нь нов ногоон
Өвчүүний ус нь хор хор
Төрсөн хүүхэд нь түм бум
Тэр бүгдээрээ хав хар (Тарвас)[22]

Дээрх оньсогод тарвасын өнгө, үрийг хүншүүлээд, усархаг зөөлөн эдийг нь авиа дуурайх *хор* язгуураар илэрхийлж, сонсох мэдрэхүйд тулгуурлан оньсоголжээ.

V. Хэрэглээ, ач холбогдол

Ургамлын тухай зарим оньсогод хэлбэр дүрсийг онцлохоос илүүтэй хүний хэрэгцээг хангах шинжийг тогтмол болгох нь бий. Өөрөөр хэлбэл, тухайн ургамлын биологийн шинж чанарыг нийгэм, соёлын утга агуулгаар баяжуулан оньсоголдог. Ургамлын 88 оньсогод хоол хүнс, 18 оньсогод ахуй амьдрал, хоёр оньсогод биологийн идэвхт чанар, таван оньсогод бусад хэрэглээг оньсоголох тогтмол болгосон байна.

Алив төрөл зүйлийн ургамлыг хүн, мал амьтны идэш тэжээл болох үүднээс оньсоголсон нь ургамлын оньсогын 13,49%-ийг эзэлнэ. Жишээ нь:

Дээрээс унасан юм шиг
Дэрсний ёроолоос ургасан юм шиг
Малгай өмссөн юм шиг
Махны оронд төрсөн юм шиг
Ааг ихтэй, амт сайтай
Аль газрын хэн гээч вэ? (Мөөг)[23]

Дээрх оньсогод мөөгний хэлбэр дүрсээс гадна махны оронд идэж болох хоол хүнсний хэрэглээг оньсоголох тогтмол болгож хүншүүлэн илэрхийлжээ.

---

[21] Ловор, Г., Өлзийхутаг, Ц., эмх., *Монгол ардын оньсого таавар,* УБ., 1990, х.66.
[22] Өлзийхутаг, Ц., эмх., *Түмэн оньсого II,* УБ., 1989, х.39.
[23] Өлзийхутаг, Ц., эмх., *Түмэн оньсого I,* УБ., 1966, х.47.

Ургамлын ахуй амьдралд хэрэглэх хэрэглээг онцолсон нь нийт оньсогын 2,67%-ийг бүрдүүлж байна. Үүнд ихэвчлэн түлээ түлш, илч дулааны хэрэглээ байгаа нь манай орны эрс тэс уур амьсгалтай холбоотой.

Ахуй сүр жавхлан бие нь
Тэнгэрт ил бөгөөд
Амин сүнсээ газарт хадгална
Аяс дүрэм бус бол
Улаан сахиусанд
Зоог болгож өгнө (Мод)[24]

Эл оньсогод модны ургах орчин нөхцөлийг үндэс нь газарт байвч, эх бие нь тэнгэр өөд ургах шинжийг онцолж, утга дараалан тайлбарлах дараагийн мөрөнд хэлбэр, хэмжээ үл зохиолдон ургавал галд түлш түлээ болгох хэрэглээний ач холбогдлыг онцолсон байна.

Биологийн идэвхт чанар буюу тухайн ургамлын эд эс, эрхтэн тогтолцоотой харилцан үйлчлэлд орж, тодорхой биологийн өөрчлөлт үзүүлэх чадварыг тогтмол болгосон байж болох хоёр оньсого байна.

Ганган нэртэй
Газарт биетэй (Чихэр өвс)[25]

Чихэр өвс нь буурцагтан овгийн цэцэгт ургамал боловч түүнийг оньсоголохдоо *газарт биетэй* хэмээн үндсийг нь голчилсон байна. “Чихэр өвсний үндсийг ардын анагаах ухаанд дээр үеэс эхлэн одоог хүртэл хэрэглэж иржээ”.[26] Монгол ургамлын оньсогод ургамлын үндэс, эх биеийг цогц хамруулан оньсоголдог боловч чихэр өвсийг оньсоголохдоо анагаах ухаанд ашиглах, биологийн идэвхт бодисыг ихээр агуулдаг хэсэг болох үндсийг тухайлан дурджээ.

Тэнгэрээс түйтэй
Тэр модноос уяатай
Газраас гайтай
Ганц модноос уяатай (Чөдөр өвс)[27]

Харин чөдөр өвсийг *тэнгэрээс түйтэй, газраас гайтай* гэхчлэн илт сөрөг үнэлэмж утгаар оньсоголсон нь онцлог. Чөдөр өвс нь “хортой ургамал учир дур мэдэн эмчилгээнд хэрэглэвэл хордох аюултай”[28] байдгийг эл оньсогоор онцолсон хэрэг юм.

---

[24] Өлзийхутаг, Ц., эмх., *Түмэн оньсого I,* УБ., 1966, х.56.
[25] Мөн тэнд, х.48.
[26] Санчир, Ч., *Ургамлын нэвтэрхий толь*, УБ., 2021, х.489.
[27] Өлзийхутаг, Ц., эмх., *Түмэн оньсого I,* УБ., 1966, х.48.
[28] Санчир, Ч., *Ургамлын нэвтэрхий толь*, УБ., 2021, х.493.

Зарим оньсогод тухайн ургамлын соёл, зан үйлийн үүрэг, ач холбогдлыг тогтмол болгосон байдаг (0,76%).

Арын харцгай арзгар
Арзгар бурзгар боловч
Бурханд хэрэгтэй (Арц)[29]

Тухайлбал дээрх оньсогод арцны хэлбэр дүрсийг тодорхойлон хэлээд, *бурханд хэрэгтэй* буюу шашин, зан үйлийн хэрэглээ, ариулга санд ашиглах байдлаар тогтмол болгосон байна.

Ургамлын оньсого угсаатны ургамал судлалтай холбогдох нь

Биологийн шинжлэх ухаан нь амьд биеийн төрлөөр ургамал судлал (ботаник), амьтан судлал (зоологи), бичил биетэн судлал (микробиологи) гэж салбарладаг. Угсаатны ургамал судлал (этноботаник) нь "...эртний үеийн хүмүүс болон хүрээлэн буй ургамлын орчны харилцан хамаарлыг судалдаг"[30] ургамал судлалын шинжлэх ухааны нэгэн салбар юм. Энэхүү мэдлэг нь хэрэглээний шинжтэйгээс гадна тухайн улс үндэстний сэтгэлгээ, хэл соёлд гүнзгий тусаж, хадгалагдсан байдаг. Үүний нэгэн илрэл нь аман зохиолын богино төрөл зүйл болох оньсого билээ.

Гэри Мартин *Угсаатны ургамал судлал: Арга зүйн гарын авлага* номдоо энэ салбарын гол арга зүй хээрийн судалгаа, ажиглалт, ярилцлага хэдий ч "... домог, түүх домог, ардын дуу, дом шившлэг, зүйр цэцэн үгсээс өвөрмөц өнцөг олж харах боломжтой"[31] хэмээжээ. Өөрөөр хэлбэл угсаатны ургамал судлалын нэгэн арга зүй нь аман зохиолд өгүүлэх ургамлын дүрслэл, өгүүлэмжийг судлан тайлбарлах явдал юм.

Ургамлын оньсогын тогтмол болон ургамлын ангилал зүй хооронд ижил төстэй шинж багагүй илэрч байлаа. Энэ талаар анхлан Ральф Булмэр "Хүмүүс байгалийг танин ангилахдаа зөвхөн ахуйн хэрэгцээнд тулгуурладаггүй, харин төрөлх танин мэдэхүйн ижил арга замаар ханддаг"[32] гэх санааг дэвшүүлжээ. Тийнхүү 1973 онд Брэнт Бэрлинтэй хамтран *Ардын биологийн ангилал ба нэршлийн ерөнхий зарчмууд* хэмээх бүтээл гаргасан байна. Улмаар Брэнт Бэрлин түүний санааг улам гүнзгийрүүлэн "ургамал амьтныг ангилах хүний сэтгэлгээний бүтэц нь хэл, соёлоос үл хамааран үндсэндээ ижил байдаг"[33]

---

[29] Өлзийхутаг, Ц., эмх., *Түмэн оньсого I,* УБ., 1966, х.48.

[30] Richard Schultes, *The Role of the Ethnobotanist in the Search for New Medicinal Plants,* Lloydia 25, no. 4 (1962), p.257.

[31] Gary Martin, *Ethnobotany: A methods manual* (London: Chapman & Hall, 1995), p.112.

[32] Ralph Bulmer, *Why Is the Cassowary Not a Bird? A Problem of Zoological Taxonomy among the Karam of the New Guinea Highlands*, Man 2, no. 1 (1967), p.11.

[33] Brent Berlin, *Ethnobiological classification: Principles of categorization of plants and animals in traditional societies* (New Jersey: Princeton University Press, 1992), p.13.

гэж үзээд угсаатны биологийн ангиллын долоо, нэршлийн таван зарчим боловсруулсан. Үүнээс ангиллын долоон зарчмыг баримтлан ургамлын оньсогыг шинжлэн үзье.

Бүх ургамал оньсого болдоггүй. Ерөнхийлөн оньсоголсноос бусад ургамлын оньсогыг харвал нэг хүрээ, багт багтах бусад ургамлаас ямар нэг шинжээрээ онцлог ургамлыг сонгосон байна. Жишээ нь лууль цэцэгтний баг буюу шарилжийн төрлийн олон ургамлаас оньсого болсон нь цулхир болон хамхуул аж. Цулхирыг хүнс хоол, цайнд хийж хэрэглэдэг бол хамхуул нь салхинд туугдан хийсдэг онцлогтой ургамал юм. Энэ нь "...хүмүүс тухайн орчинд буй зүйлсээс хамгийн тод ялгарах хэсгийг л түүвэрлэн ангилдаг"[34] гэх нэгдүгээр зарчимтай нийцэж байна.

Хүн аливаа зүйлийн хэлбэрийг агуулгаас түрүүнд ажиглан мэддэг. Ургамлын оньсогоос үзвэл өмнө өгүүлсэнчлэн харагдах байдал (графикт саарлаар тэмдэглэв) болоод бүтэц (графикт ягаанаар тэмдэглэв)-ийг тогтмол болгосон нь хэрэглээ, ач холбогдол (графикт шараар тэмдэглэв)-ыг тогтмол болгосноос даруй 14 дахин их буй юм. Энэ нь "...ангилал нь соёлын ач холбогдлоос илүү биологийн бүтэц, бодит харагдацад суурилдаг"[35] гэсэн хоёрдугаар зарчимтай таарч байна.




График 4. Ургамлыг оньсоголох тогтмол тус бүрийн тоо (давхардсан тоогоор)

Гуравдугаар зарчим нь "Танин мэдсэн ургамал, амьтны нэгж өргөн хүрээний бүлэгт нэгдэх замаар цөөн тооны ангилал зүйн зэрэг бүхий шаталсан бүтэц үүсгэдэг"[36] гэжээ. Тухайлбал нарс, хус, улиас, жодоо, гацуур зэрэг төрөл нийлэн мод болох ба мод нь бусад өвс, цэцэг зэрэгтэй нийлэн ургамлын аймаг болдог. Энэ нь монголчууд ургамлын аймгийг тодорхой тогтолцоогоор ангилж ирснийг харуулж байна.

[34] Brent Berlin, *Ethnobiological classification: Principles of categorization of plants and animals in traditional societies* (New Jersey: Princeton University Press, 1992), p.21.
[35] Мөн тэнд, p.21.
[36] Мөн тэнд, p.22.

Бэрлин бүх ард түмэн амьтан, ургамлыг "...аймаг (*kingdom*), амьдралын хэлбэр (*life-form*), завсрын анги (*intermediate*), төрөл (*generic*), зүйл (*specific*), хувилбар (*varietal*) гэсэн түгээмэл зургаан зэрэг (*rank*)-т хуваана"[37] гэж үзжээ. Ургамлын оньсогыг орчин үеийн биологийн ангилал зүйгээр хуваахад зарим хэсэгт ногдох оньсого байдаггүй нь дээрхтэй адил цөөн зэрэгт хуваагдахыг батална.

Тавдугаар зарчим ёсоор ардын ангилал зүй нь тооны хязгаартай ба бүх оронд төрөл (*generic*)-ийн тоо 500-аас хэтэрдэггүй"[38] байна. Ургамлын тухай 652 оньсого нийтдээ 70 ургамалд хамаарч байна. Энэ нь аман зохиол дахь ургамлын оньсогын тоо болохоос монголын нийт ардын ангиллыг төлөөлөхгүйг анхаарах хэрэгтэй.

Ангиллын бүх ургамал эрх тэгш биш, "...зарим нь тухайн бүлгээ төлөөлөх үндсэн загвар (*prototype*) болдог"[39]. Монгол оньсогод хамхуул, сонгино, сараана зэрэг ургамлын тухай оньсого олон байх тул үндсэн загвар болдог гэж үзэж болох юм. Тодруулбал хамхуул нь лууль цэцэгтний багийг төлөөлөн, нийт 47 оньсого, цагаан төмс зэрэг сараана цэцэгтний багийг сараана цэцгээр төлөөлөн, нийт 53 оньсого, сонгино нь тарна цэцэгтний багийг төлөөлөн, нийт 54 оньсого буйгаас тухайн бүлгээ төлөөлж буй үндсэн загвар болох ургамал гэдгийг харж болно.

"Ардын ангилал зүйн нэгжийн дийлэнх нь ургамал судлал, амьтан судлалын ангилалтай яв цав нийцдэг"[40] зарчим ургамлын оньсогод мөн үйлчилж байна. Ургамлын оньсогыг орчин үеийн ангиллын системээр бүрэн биш ч ангилж болдог. Мөн оньсогод дүрслэгдэх бүтэц, экологийн шинж, амьдралын хэлбэр зэрэг нь ургамал судлалын онолын тодорхойлолттой таардаг

ДҮГНЭЛТ

Оньсого нь юм, үзэгдлийн голлох шинжийг илэрхийлэх тогтмолд тулгуурлан, нэрийг нууцалж, шүлэглэсэн хэлбэр бүхий асуулт тавих аялгуут бус аман яруу найргийн зүйл юм. Эл судалгааны ажилд ургамлыг оньсоголох тогтмолыг ангилан, задлан шинжилж, угсаатны ургамал судлалтай холбон тайлбарлалаа.

Аливаа зүйлийг оньсоголохдоо бусдаас ялгарах хамгийн гол, онцлог шинж, салган ойлгож үл болох чанар буюу оньсоголох тогтмолд тулгуурлан

[37] Brent Berlin, *Ethnobiological classification: Principles of categorization of plants and animals in traditional societies* (New Jersey: Princeton University Press, 1992), p.22
[38] Мөн тэнд, p.24.
[39] Мөн тэнд, p.25.
[40] Мөн тэнд, p.26.

зохиодог. Ургамлыг оньсоголох тогтмолыг хуваалтын таван суурь, 22 хэсэгт хуваан ангилж, тус бүрийг задлан шинжилж, тайлан тайлбарласан. Ургамлын гадна хэлбэр байдал, бүтцийг тогтмол болгон оньсоголох нь түгээмэл, харин мэдрэхүйд өртөх байдал болон хэрэглээ, ач холбогдлыг тогтмол болгосон нь цөөн. Энэ нь ургамал болон оньсогын төрөл зүйлийн онцлог, гадаад хэлбэрт тулгуурлан байгалийг танин мэдэх арга замтай холбоотой.

Ургамлыг оньсоголох тогтмолыг угсаатны ургамал судлалын Брэнт Бэрлиний долоон зарчмаар шинжлэн үзэхэд тохирч байна. Үүнээс хамгийн чухал нь ургамлын оньсогыг орчин үеийн ангиллын системээр бүрэн биш ч ангилж болох бөгөөд оньсогод дүрслэгдэх бүтэц, экологийн шинж, амьдралын хэлбэр зэрэг нь ургамал судлалын онолын тодорхойлолтыг дэмжиж байна.

AN ANALYSIS OF PLANT RIDDLES IN MONGOL ORAL LITERATURE

A riddle is a subgenre of non-musical oral poetry that conceals the name of an object or phenomenon while describing its defining characteristics through invariants. When the invariants of plant riddles are classified and analyzed, it becomes evident that invariants based on external appearance and structure are the most common, whereas those based on sensory perception, usage, and significance are relatively rare. This is related both to the characteristics of plants and riddles as genres and to the ways in which nature is understood through observable external forms. Furthermore, when the invariants of plant riddles are examined according to the seven principles of ethnobotanical classification proposed by Brent Berlin, they correspond closely with his framework, supporting the conclusion that the cognitive structures humans use to classify plants and animals are fundamentally similar regardless of language or culture.

Keywords: *plant riddle, riddle invariant, ethnobotany, ethnobiological categorization*

НОМ ЗҮЙ

Эх хэрэглэгдэхүүн

Ловор, Г., Өлзийхутаг, Ц., (1990), эмх. *Монгол ардын оньсого таавар*. УБ., Улсын хэвлэлийн газар.

Өлзийхутаг, Ц., (1966), эмх. *Түмэн оньсого I*. УБ., ШУА-ийн хэвлэх үйлдвэр.

Өлзийхутаг, Ц., (1989), эмх. *Түмэн оньсого II*. УБ., Армийн СХ-ийн хэвлэх үйлдвэр.

Судалгааны бүтээл

Дулам, С., Нандинбилиг, Г., (2016) *Монгол аман зохиолын онол I*. УБ., МУИС Пресс, (Анхны хэвлэл: 2007).

Санчир, Ч., (2021), *Ургамлын нэвтэрхий толь*. УБ., Монсудар.

Ургамал, М., Магсар, Д., Сангидорж, Б., (2003), *Ургамал судлал*. УБ., Жинст Харгана хэвлэлийн газар.

Brent Berlin. *Ethnobiological classification: Principles of categorization of plants and animals in traditional societies*. New Jersey: Princeton University Press, 1992.

Gary Martin. (1995), *Ethnobotany: A methods manual*. London: Chapman & Hall.

Эрдэм шинжилгээний өгүүлэл

Bulmer, Ralph, (1967), *Why Is the Cassowary Not a Bird? A Problem of Zoological Taxonomy among the Karam of the New Guinea Highlands.* Man 2, no.1

Kellert, Stephen R. (1993), *The Biological Basis for Human Values of Nature. In The Biophilia Hypothesis,* edited by Stephen R. Kellert and Edward O. Wilson, Washington, DC: Island Press,.

Schultes, Richard Evans. (1962), *The Role of the Ethnobotanist in the Search for New Medicinal Plants. Lloydia* 25, no.4

ТҮҮХ, АРХЕОЛОГИ, АНТРОПОЛОГИ

2026 Fasc.13

ХҮРЛИЙН ҮЕИЙН СОЁЛУУД ДАХЬ ОРШУУЛГЫН ЗҮГ ЧИГИЙГ БӨӨ МӨРГӨЛТЭЙ ХОЛБОН ТАЙЛБАРЛАХ НЬ

Ёндонжамцын АДЬЯАЛХАМ
МУИС-ийн Археологи хөтөлбөрийн III курсийн оюутан

Удирдагч багш: Ч. Амартүвшин
МУИС-ийн Археологи, антропологи, хүн ам зүйн тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D), дэд профессор

***Хураангуй**:Энэхүү судалгаанд НТӨ 2600-600 он буюу одоогоос 5000 жилийн өмнөх, хүрэл зэвсгийн үеийн оршуулгатай булшнуудын, талийгчийг хандуулсан зүг чигийн байрлалыг шинжилж, түүгээр дамжуулан тэдний сүсэг бишрэлийн ойлголтыг тайлбарлах, мөн тэдгээрийн ертөнцийг үзэх үзэл, хүрэл зэвсгийн үеэс ямар замаар, өнөөгийн дүр төрхөө олсон зэрэг асуудлыг археологийн малтлага хэрэглэгдэхүүн, оршуулгын дурсгалуудын харьцуулсан шинжилгээг ашиглан тайлбарлав.*

Тухайлбал талийгчийг тодорхой зүгт хандуулан оршуулсан нь санамсаргүй бус, харин нар, сар, баруун, зүүн тэнгэр, болоод тухайн оршин буй байгаль, газар зүйн мөчлөгтэй холбогдох үзэл санааны илэрхийлэл ба үр дүнд нь зүүн ба баруун чиглэлийн давамгайлал нь амьдрал, үхэл, дахин төрөлтийн бэлгэдэлтэй уялдаж, тэрхүү үзэл санаа тухайн газар оронд нутаглаж байсан үе үеийн хүмүүсийн сонголтоос бус, гагцхүү тэрхүү орон зайд удаан хугацааны туршид тогтвортой бэхэжсэн үзэл санаанаас, сүсэг бишрэл болон тогтож буйг харуулж байна.

***Түлхүүр үг**: бөө мөргөл, оршуулга, зүг чиг, ертөнцийг үзэх үзэл, сүсэг бишрэл*

УДИРТГАЛ

Бид энэхүү судалгаандаа Монголын тэгш өндөрлөгт орших хүрлийн үеийн оршин суугчид оршуулгын зүг чигээс үүдэлтэй оюун санааны нэгдмэл байдал байсан эсэхийг малтан судалсан тухайн үед холбогдох булшны эх хэрэглэгдэхүүнд тулгуурлан нягталж, өөрийн саналыг нэмэрлэхийг хичээв.

Монгол оронд одоогоор мэдэгдээд буй хамгийн анхны оршуулга неолитын

үед хамаардаг. Анх 1949 онд А. П. Окладниковоор удирдуулсан шинжилгээний анги Дорнод аймгийн нутгаас нэгэн суурин илрүүлэн олсон бөгөөд үүнийг Тамсагбулагийн суурин хэмээн нэрлэх бөгөөд хожим 1967 онд тэндхийн нэгэн сууцны шалан доороос давчуу нүхэнд суугаа байдлаар нь баруун зүг хандуулан оршуулсан оршуулга илэрсэн юм.[1] Энэхүү сууцны он цагийг НТӨ IV-III мянган буюу НТӨ 5668 (54.0%) 5607 онд хамаарна хэмээн судлаачид тогтоожээ.[2]

Үүний дараа энеолит, Түрүү Хүрлийн үед холбогдох Баруун болон Төв Монголын нутагт орших Афанасьевын (НТӨ 3200-2600) соёлд хамаарах оршуулга орох бөгөөд тэд талийгаачийг толгойг зүүн тийш хандуулан, нуруугаар нь хэвтүүлж, хөлийг атийлган оршуулдаг байжээ.[3]

Ойролцоогоор НТӨ 2600-600 оныг хамарч буй хүрлийн үеийн археологийн соёлуудыг тойрсон судалгаа, таамаглал өндөр түвшинд хүрч, судлаачдын шинэ арга зүй, техник, технологи зэргийн хөгжлөөс үүдэлтэйгээр таамаглал, үр дүнгүүд гарах болжээ.

Тухайн үеийн оршуулгын зүг чиг, түүний утга зүй, агуулга зэрэгт анхаарч буй нь өнөөдрийн хурдацтай хөгжиж буй археологийн судалгаанд бага ч болов нэмэр болно хэмээн найдаж байна. Гэхдээ мэдээж оршуулгын зан зүйл, дагалдах эд өлөг, бүтэц зохион байгуулалт чухал хэдий ч бидний “хэлж заншсан” хойт насны болоод хойт төрлийн ойлголт нь байгаль орны газар зүйн байрлалаас хамааралтай юу аль эсхүл ертөнцийг үзэх-үзэл суртлын шинжтэй юу гэдгийг тодруулах нь тун сонирхолтой юм.

Төрт улс байгуулагдснаас хойших зан үйл, аливаа шашны холбогдолтой үйл хэргийг судлахад бичгийн эх сурвалжид үндэслэн тоймтой гаргалгааг гаргаж болдог бол хүрлийн үеийн соёлуудын сүсэг бишрэл, зан үйл зэргийг судлахад оршуулгын ёс заншлаас гадна тэнгэр шүтлэг, бөө мөргөлтэй холбож үзэхээс өөр аргагүйд хүрдэг. Үнэндээ өөр гаргалгаа гаргахад нэн хүндрэлтэйн дээр, одоогоос 5000 жилийн өмнөх зүйлийг ярьж байгаа тул шашин шүтлэгээс гадна хадны зураг нэмэлт эх сурвалж болж болох боловч он цагийг ялган ангилахад бэрхшээлтэй байдаг.

Илтгэл нь хүрэл зэвсгийн үед бөө мөргөлийг шашны хэмжээнд авч үзэх саналын талаар дурдаагүй ба гагцхүү Монголын анхны төрт улс байгуулагдахаас ч өмнө өнөөгийн Монгол нутагт сүсэг бишрэлийн цогц давлагаанууд он цаг улиран өөрийн дүр төрхөө олтлоо тогтвортой оршиж

---

1 Дорж, Д., *Неолит Восточной Монголии,* УБ., 1971, х.хадгалалтаас болж тодорхойгүй

2 Гүнчинсүрэн, Б., *Тамсагбулагийн шинэ чулуун зэвсгийн сууринги*йн *он цагийн асуудлыг дахин авч үзэхэд,* // Studia Archaeologica. Tom.XX, Fasc.2, УБ., 2000, х.12-13.

3 Волков, В.В., *Курганы афанасьевского типа в Монголии.* Studia Archaeologica. Tom.IX, Fasc.2. УБ., 1980, х.98.

байсан ба энэ үйл явц шинэ соёлууд бүрэлдэн тогтох болоод, түрэгдэн гарсан ч суурь ойлголтоо гээгдүүлэхгүйгээр бөө мөргөлийн үзэл суртлын дэлгэрэлтэд тодорхой хэмжээгээр нөлөөлсөн болохыг тайлбарласан.

Судлагдсан байдал, онолын үндэслэл

Хүрлийн үеийн оршуулгын дурсгалын талаар сүүлийн үед тоймтой судалгаанууд ихээхэн нийтлэгдсэн бөгөөд энэ удаагийн судалгаандаа доорх бүтээлүүдийг голчлон ашигласан болно. Үүнд, 2016 онд хэвлэгдсэн "Монголын эртний булш оршуулга" бүтээл багтана. Энэхүү бүтээлд өвөг түүхийн үеэс Монголын үе хүртэлх булш оршуулгын дурсгалуудыг нэгтгэн, товч байдлаар авч үзсэн байдаг.

Хөгжингүй хүрлийн үеийн томоохон төлөөлөл болсон түрүүлгэ нь харуулсан булшны хэлбэр ба тархац, оршуулгын зан үйл, угсаа соёлын асуудлыг нэгтгэн доктор Д.Хатанбаатар 2019 онд эрдэм зэрэг горилсон бүтээлээ нийтлүүлсэн байна.

2020 онд А.Очир нарын судлаачид "Археологийн судалгаа: Монголчуудын гарал, угсаа-соёлын хөгжил" бүтээлд хөгжингүй хүрлийн үе буюу НТӨ 1800-1200 онд хамаарах соёлууд болон хожуу хүрлийн үеийн НТӨ 1200-600 хүртэлх соёлуудыг нэгтгэн, тархац, ангилал, бүтэц зохион байгуулалт, оршуулгын зан үйл, эд өлөг, залгамж холбоо, генетик зэргийг тайлбарласан. Дээрх бүтээлүүдээс өмнөх үеийн сонгодог томоохон бүтээлүүдээс миний бие боломжийн хирээр ашигласан гэдгийг энд дурдах нь зүйтэй.

Археологийн судалгааны бүтээлүүдээс гадна угсаатны зүй, бэлгэдэл зүй, шүтлэгийн зан үйлийн талаарх үндсэн дэвшүүлж буй бичил санааны, онолын хэрэглэгдэхүүн нь С. Дулам (2020) "Монгол бэлгэдэл зүй II: Өнгийн бэлгэдэл зүй, зүг чигийн бэлгэдэл зүй", Ч.Далай (2009) "Монголын бөө мөргөлийн түүх", О.Пүрэв (2006) "Монгол бөөгийн шашин" зэрэг бүтээлийг ашиглав. Мөн нөгөөтээгүүр, өөрийн хэмжээндээ тааруулан, зарим бүрэн нотолж чадаагүй санаа зэргээ, цухас дурдаад өнгөрсөн болно.

Дээрх сурвалжит бүтээл, өгүүллүүд дэх мэдээллээс дүгнэлт гаргах, мэдээллийг нэгтгэх арга зүйг барин өөрийн хэмжээнд хэд хэдэн асуулт тавьсан бөгөөд үүнд,

Нэгдүгээрт, өөр, өөр цаг үед хамаарах хүрлийн үеийн соёлууд атал нэг бүс нутагт оршуулга үйлдэж буй хүмүүсийн ертөнцийг үзэлд залгамж холбоо байх боломжтой эсэх;

Хоёрдугаарт, хүрлийн үеийн зэрэгцээ оршин буй соёлууд өөр өөр зүгийг эрхэмлэх боломжтой эсэх, хэрэв тийм бол яагаад;

Гуравдугаарт, хэрэв нэг цаг үе дэх соёлыг бүрэлдүүлэгчид нэг нэгнийгээ улс төр, нийгэм, соёл, газарзүй зэрэг шалтгаанаар шахсан бол, энэ нь зүг чигийн ялгаатай байдлаар харагдаж болох эсэх гэсэн хэдэн асуулт багтана.

"...Хэрвээ бид юмсын бэлгэдэлт чанарыг харж, үүнийгээ бэлгэдлийн ойлголтоор тайлбарлаж чадахгүй л бол өөрсдийгөө санаатайгаар сохолж байна гэсэн үг"[4] хэмээх ишлэл уг судалгааг бичихэд ихээхэн нөлөөлсөн билээ.

Судалгааны шинэ санаа ба таамаглал:

***1. Түрүү хүрлийн үеийн соёлуудын зүг чигийн учир шалтгааны таамаглал*:**

Монголын бөөгийн шашны анхны хэлбэр сүсэг бишрэл, дом шившлэг эхийн эрхт байгууллын үед буюу хуучин чулуун зэвсгийн дунд үеэс дээд үед үүсчээ гэсэн Б. Ринчен, С. Бадамхатан, Х. Буянбат, Сүрбадрах, Ёнсог нарын дүгнэлт байдаг.[5] Нөгөөтээгүүр Хэмцэгийн соёлын хадны зургийн өвөрмөц дүрслэлүүдийг дурдах нь зүйтэй. Шинжааны Дунд Булаг, Монголын Цагаан Салаа/Бага Ойгор зэрэг хадны зургийн дурсгалаас илрүүлжээ (*Зураг 2-ыг үзнэ үү).* В. Д. Кубаревын үзэж байгаагаар энэхүү нөмрөгтэй хүн дүрст зургууд "Эвэртэй бодгал-Түрүү удган" нь эм үүтгэлтэй удган нарыг дүрсэлсэн байна. Магадгүй бүр хүрлийн үед Төв Азид бөөгийн шүтлэг бий болсон байсны гэрч баримт бололтой гэсэн таамаглалыг тэрээр дэвшүүлжээ [Кубарев 2005: 76] Цагаан Салаа ба Бага Ойгорын хадны зурагт ийм "Нөмрөг ба эвэртэй хүн төрхт дүр" 11 удаа тохиолддог ажээ[6].


Хадны зургийн хувьд бүжиг, эсвэл тойрон гал тахиж буй мэт дүрслэл харагддаг. Зайрин, удганы бөөлөх хэлбэр бол монголын эртний бүжгийн хөдөлгөөнтэй нягт холбоотой. Тэгэхээр бөө мөргөл, аль эсхүл тэнгэр шүтлэгтэй байх тал харагдаж байна. Мөн Хэмцэгийн соёлын анхны судалгааг хийсэн монгол эрдэмтэдийн нэг болох доктор Д. Эрдэнэбаатарын 2010 онд Хөх үзүүрийн дугуйд малтсан булшны олдвор хэрэглэгдэхүүнээс чулуун бөмбөлөг илэрсэн ба тэрээр үүнийг хүүхдийн тоглоом хэмээн өөрийн таамаглалыг дэвшүүлжээ. Тэрхүү чулуун бөмбөлгийн диамер 1,3-1,6 см (?), ба олдсон тооны хувьд 30-аас доошгүй хэмээн тэмдэглэжээ (*Зураг 3-ыг үзнэ үү).* Мөн Хэвийн ам 1-ээс 1 см гаруй диаметртэй гурван цагаан чулуун бөмбөлөг олдсон, Хэвийн ам 3-аас 1-1.5 см диаметртэй найман жижиг цагаан чулуун бөмбөлөг мөн олдсон байна.



Зураг 2. Хэмцэгийн соёлд хамаарах хадны зураг

Эх сурвалж: Төрбат, Ц., *Хэмцэгийн соёлын хадны зураг*, Tomus XXXVIII., 2018, х.10.

[4] Карл Юнг., *Зурагт хөтөч.,* УБ., 2022, х.129.
[5] Пүрэв, О., *Монгол бөөгийн шашин*, УБ., 2006, х.30.
[6] Төрбат, Ц., *Хэмцэгийн соёлын хадны зураг*, Tomus XXXVIII., 2018, х.10.



Зураг 3. Хэмцэгийн булшнаас илэрсэн чулуун бөмбөлөг.

Эх сурвалж: Ковалев А.А - Древнейшие европейцы в сердце Азии: чемурчекский культурный феномен.

Үнэн хэрэгтээ дээрх жижиг чулуугаар хүүхэд тоглох нь бодит байдал дээр эрсдэлтэйн дээр, уг оршуулгууд хүүхдийн оршуулга биш билээ. Үүн дээр миний бие 2024 онд харьяа тэнхимийн оюутны эрдэм шинжилгээний хуралд өөрийн санаагаа илэрхийлж байв. Энэхүү чулуун бөмбөлгүүд нь мэргэ төлгөний нэг хэлбэр байж болох талтай гэж үзээд бөө мөргөл дэх чулууны мэргэтэй холбогдох сэжим байх. Чулууны мэргэ гол төлөв Монголын баруун хязгаараас түрэн, зөөвөрлөгдөж нийт Монголчуудад түгээмэл харагдах болсон. Зан үйлийн шинж чанар нь харьцангуй бага, энгийн хүмүүс дотор ч элбэг тохионо. Чулууны мэргийн анхны хэв шинж нь алдагдсан малын эрэл хайгуул гэх мэтээр түгж эхэлсэн (зүүн Монголд ихэвчлэн уг зориулалтаар дэлгэрснийг аман судалгаагаар хийж байв).

Төв Азийн бөө мөргөлийн талаарх судалгааг Макс Планкийн Нийгмийн антропологийн хүрээлэн, Сибирь судлалын төвийн туслах судлаач Анетт К. Оэлшлагел нэлээдгүй судалсан ба тэрээр 1990-ээд оны дунд үеэс өмнөд Сибирь, Төв Ази, ялангуяа ОХУ-ын Бүгд Найрамдах Тува, Киргиз улсад судалгаа хийж байна. Түүний үзэж буйгаар, *"Хилийн чанад дахь мэргэ төлөг нь ихэвчлэн онцгой буюу тэнгэртэй харьцдаг гэх хүмүүс үйлддэг бол Монгол дахь мэргэ төлөг нь уламжлагдан, заншил маягаар дэлгэрсэн. Ирээдүйн бөө нар хэнгэрэгтэй ажиллахаасаа өмнө мэргэ төлөгчийн урлагийг эзэмшсэн байх ёстой. Мэргэлэх нь бөө мөргөлийн үндэс гэж ойлгох хэрэгтэй. Үндсэндээ энэ нь сүнснүүдтэй харилцах гэсэн утгатай бөгөөд энэ нь аливаа төрлийн эдгээх ажлын үндэс суурь бөгөөд итгэлгүй байдал, тэнцвэргүй байдал, найдваргүй мэт санагдах нөхцөл байдал, цөхрөл эсвэл хүч чадалгүй, арчаагүй байдлын мэдрэмжийг даван туулах шийдлийг санаачилдаг".*[7]

Бөө мөргөлд, зүүн тэнгэрт сургууль хийсэн бөөг хар буюу хараалын бөө, баруун тэнгэрт сургууль хийсэн бөөг цагаан бөө буюу сайн бүхний төлөө үйлчлэгч бөө гэж үздэг[8]. Хэмцэгийн соёлын оршуулга үйлдэж буй газар болоод тэдний тархалт Алтайд бий учир, тэнгэр, хангай, уул усыг аргадах, Алтайн эрс тэс уур амьсгалд дасан зохицох хэрэгцээ шаардлага үүссэн байх нь тодорхой.

[7] https://eth-mpg.academia.edu/AnettCOelschlaegel

[8] Далай, Ч., *Монголын бөө мөргөлийн түүх*, УБ., 2009, х.31

Тэд магадгүй бөө мөргөл, тэнгэр шүтлэгтэй тул, баруун зүг буюу цагаан зүг рүү талийгчийг харуулдаг төдийгүй, мэргийн чулуунаас оршуулгад хийн, өөрсдийн шүтлэгийг талийгчийн дараа төрөлд ч дамжуулж буйн хэлбэр байж болох юм.

1.1 Мөнххайрханы соёл нь түрүү хүрлээс хөгжингүй хүрлийн үе рүү дамнан оршиж буй соёл гэдгийг дээр дурдсан. Хэсэг хугацаанд Хэмцэгийн соёлынхонтой Алтайд амьдарч байсан ба хоёр томоохон соёлын хооронд ертөнцийг үзэх, үзэл-санааны хувьд өөр байсан гэдэг нь нийтэд илт байна.

Археологич Т. Идэрхангай, “Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Харуулын гозгорт малтсан Мөнххайрханы соёлын нэгэн булш” өгүүлэлдээ, он цаг, тэр дундаа эд өлөг дээр төвлөрсөн судалгаа нийтлүүлсэн бөгөөд хамгийн эрт он цагтай Мөнххайрханыг Хангайд буюу Хөвсгөл, Булган хэмээсэн байгаа нь уг соёл нь эхэн үедээ, Хэмцэгийн соёлтой хөршилж оршин байсныг илтгэнэ.

Дээрээс нь Мөнххайрханчуудийн Алтайд үйлдсэн оршуулгын гадаад байгууламж жигд өнгийн дараас чулуугаар үйлдсэн байдаг бол Хангайд үйлдсэн оршуулга хоёр өнгийн чулуугаар хийгдсэн байдаг. Энэ нь тэд эхэн үедээ Хэмцэгийнхтэй хөршилж оршин байх хугацаандаа тэдний байгалийн шүтлэгийн талаар бага ч болов зүйлийг (баруун, зүүн, сайн, муу зүгийн тухай) мэдэхийнхээ хувьд булшныхаа байгууламжийг ийнхүү өнгийн чулуугаар үйлдсэн байж болох талтай.

Харин цаг хугацааны хувьд түрүү хүрлийн төгсгөл шатанд тэд Алтай руу очсоны дараа гадаад байгууламжийн хувьд дараас чулууг өнгөөр ялгах зүйлгүйгээр “даруухан” үйлдэж эхэлсэн нь нүүдэллэж очсон бүс нутгийнхаа төрхөд нийцүүлсэн эсхүл, нэгдэн нийлж буйн хэлбэр ба газрын хөрсөн дээр үл мэдэгдэх оршуулга үйлдэж эхэлсэн.

Мөн сонирхолтой нэг зүйл бий нь Мөнххайрханы булшнаас халбага гардаг нь Хэмцэгийн соёлын аягатай ямар нэгэн үзлээр холбогдож байхыг үгүйсгэхгүй. Нөгөөтээгүүр зэр зэвсгийн бус аж ахуйн хэрэглэл дагалдуулдаг нь, эд хоорондоо дайн тулаан хийдэггүй, хийх шалтгаан ч үгүй, өөрсдийгөө нэг тэнгэрийн доорх хүмүүс гэж үздэг байсан ба Алтайн уулархаг, сэрүүн бүсэд нэгдэн нийлж амьдрах хэрэгцээ ямагт байсан нь гарцаагүй. Ямартай ч, хоорондоо сөргөлдсөн ул мөрийг хүний ясны судалгаагаар тодруулах хэрэгцээ байгаа талаар дурдаад энэ хүрээд дуусгая.

2. Хөгжингүй хүрлийн үеийн соёлуудын зүг чигийн учир шалтгааны таамаглал:

2.1 Сагсай булшны оршуулгын зүг баруун, одоогоор говийн бүсэд бүртгэгдээгүй байгаа ба уулын энгэр, бэл, ам, голын хөндий, тэгш тал зэрэг газруудад оршуулгыг наран шингэх баруун зүг рүү хандуулан үйлддэг,

тэдний хувьд баруун зүгийг ертөнцийн төгсгөл гэж үздэг байсантай холбоотой. Баруун зүг бол тэнгэр шүтлэгийн ёсоор бол сайн үйлийн тавин таван цагаан тэнгэрийн орших зүг болно.[9]

Оршуулгадаа дахин төрхийг бэлгэдэн улаан зос цацдаг нь тэнгэрийг шүтэгчдийн үзэл дэх улаан утсаар амин судлыг бэлгэдэн амилуулах үзэлтэй агаар нэгэн ба нөгөөтээгүүр үхсэн хүн дахин төрөхийг хүрлийн үед мэддэг байсан уу гэвэл бас эргэлзээлтэй.

Харин энэ нь тэнгэр шүтлэгийн өөр нэгэн үзэл болох "савдаг" хэмээх зүйлтэй холбоотой байж болох юм. Тэднийхээр савдаг нь бүх хуурай газар (их бага, уулс, дов толгод)-д оршдог, эдгээр уул толгод нь савдгуудын орон гэр нь бөгөөд савдгийн эзэд газар дээр явж байгаад газрын хөрс уул толгодын хажуу руу шингэчихдэг[10] гэх ойлголтын эртний хэлбэр болох талтай юм. Үүнийгээ улаан зосоор илэрхийлж, нэгэнт савдгийн хүн боллоо гэсэн утга. Үнэндээ тэд палеопаталогийн хэмжилт судалгаагаар байгалийн хатуу ширүүн нөхцөлд амьдарч, хүнд хүчир хөдөлмөр эрхэлж байсан нь тодорхой болсон ба үхэгсдээ амилуулах гэхээс илүү байгалийн эздийн үйлчлэгч, боол болж байгалийг, нэгэнт талийгч болсон нэгнийгээ тэднийг аргадахаар өөрсдийн төлөөллийг явуулж буй мэтээр үздэг байх боломжтой билээ.

Чулуун дараасны дөрвөн талдаа хөшөө чулуутай уг булш нь нэг оршуулгын газарт ганц нэгээс авхуулаад дунджаар 20-30-аараа зэрэгцэн орших ба зарим тохиолдолд нэг эгнээнд хэдэн арваараа цуварч байрлах нь бий[11,12]. Нэг газар олноороо байгаа нь үхэгсдээ хэдий энэ хорвоо дээр үгүй болсон ч тухайн газартай хүйн холбоотой гэж үзсэн. Учир юу хэмээвээс аливаа хүн төрсөн, уугуул нутгийнхаа лус, савдагтай үргэлжийн хүйн холбоотой байдаг ба эхээс хүй тасарч унасан газрынхаа шороо чулууг дээдлэн шүтэж явахыг тэнгэрийг шүтэгчид болох бөө нар сургадаг.[13]

Мөн дээр дурьдаснаар судлаач Дулам абуйган цагаан зүгийн бөө нь судлаач Пүрэв абугайн бүтээл дэх хүмүүсийн аж амьдралыг ерөнхийд нь чиглүүлж,

---

[9] Дулам, С., *Монгол бэлгэдэл зүй II: Өнгийн бэлгэдэл зүй, зүг чигийн бэлгэдэл зүй*., УБ., 2020, х.144

[10] Пүрэв, О., *Монгол бөөгийн шашин,* УБ., 2006, х.84.

[11] Гантулга, Ж., *Сагсай хэлбэрийн булш, Археологийн судалгаа: Монголчуудын гарал, угсаа-соёлын хөгжил,* УБ., 2020, х.10.

[12] Тэдний антропологийн төрхийн хувьд төв Монгол дахь булшнууд монголжуу байдаг бол Баруун хэсгийн булшнууд европжуу байдаг аж. Палеопаталогийн хэмжилт судалгаагаар тэд байгалийн хатуу ширүүн нөхцөлд амьдарч, хүнд хүчир хөдөлмөр эрхэлж байсныг тодорхой харуулж байгаа бөгөөд эдгээр өвчлөлүүд нь нуруу, хөлийн ясны хөнгөн ба хүнд хэлбэртэй байжээ.

[13] Пүрэв, О., *Монгол бөөгийн шашин,* УБ., 2006, х.84. 1993 оны намар Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын харъяат хар дархад ясны бөө Балжир удган Монгол, Солонгосын эрдэм шинжилгээний хамтарсан хээрийн ангийнханд *(Жү Чаэ Хиог, О. Пүрэв, С. Цолмон, Ж. Гэрэлбадрах нарт)* энэ сургаалиа айлдаж байсан.

нийгмийн доторх хэв хуулийг сахиулах, дээд тэнгэр, газар усны эзэдтэй хэрхэн харьцахыг хүмүүст заах, сургах үүрэгтэй цагаан зүгийн бөө гэсэнтэй утга дүйх ажээ.

2.2 Түрүүлгэ харуулсан булшны тухайд, дотор нь хоёр хуваан авч үзэх санал байдаг ба Шоргоолжин булш болон, Олон төрөлт дараас чулуу гэсэн ангилал байдаг. Үүний гол шалтгаан нь зөвхөн гадаад байгууламжаар нь ялган, Шоргоолж хэлбэрт булшны тархалт их тул тусдаа бие даасан байх боломжтой хэмээн үзэж байгаа аж [14].

Гэвч энэ нь эсрэгээрээ буюу тухайн оршуулгыг үйлдэж байсан нэгэн бүлгийн хүн ам, газар нутаг тэлэхийн хэрээр үндсэн оршуулгын тавилтын хэв алдагдаагүй ч бүлэг хоорондын оршуулга байгуулах гадаад хэлбэр нь өөр өөр болсон ба тэдний гаднаас харагдах байдал өөр ч үзэл санааны хувьд цул болсны шинж байж болно.

Мөн түрүүлгэ харуулсан булшны тайлбарын тухай дээр дурдсанчлан бусад ангиллуудыг энэ удаад судалгаандаа оролцуулахгүй ба зөвхөн зүг чигийг л хамруулна гэдгээ илэрхийлсэн билээ.

Түрүүлгэ харуулсан байдлын учир байдлын талаарх судлаачдын нэлээдгүй баримт байдаг ба нийтдээ бүгд *харанхуй орон, буцаж ирэхээргүй явсан, дээд-дунд-доод* тивүүдтэй холбосон талаар бичжээ. Талийгчийн булшин дахь оршоосон зүг нь зүүн зүг. Уг зүгийг туульст бол *сүнсний халих зам* [15] хэмээн нэрлэдэг бол, дийлэнх тохиолдолд наран ургах зүүн зүгийг дахин төрхтэй холбон тайлбарладаг. Үүнээс үзэхэд талийгчийг түрүүлгэ харуулан харанхуй орон руу дахин ирэхээргүй явуулсан учир сүнсний халих зам гэсэнтэй утга ойролцоо буюу сүнсийг эргэж хоргодолгүй, нөгөө ертөнцөд саадгүй очих замыг заан тусалж буй.

Харин зарим тохиолдолд толгойг баруун тийш хандуулсан байдлын талаар судлаач А. Очир, Алтай, Соён, Говь-Алтай, Хангайн нуруу орчмоор тархацтай хүрлийн үеийн дөрвөн хөшөөт болон хиргисүүртэй төстэй дурсгалуудтай хөршлөх тул тэдний уламжлалыг зээлдсэн байж болох талтай, нэг үгээр хэлбэл хөрш соёлын уламжлал, нөлөөг хүлээн авсан, харилцаанд орсон болохыг харуулж байж болно гэж тэмдэглэжээ. Үнэхээр ч тийм байх талтай, Алтайд байсан түрүү хүрлийн Хэмцэг болон хөгжингүй хүрлийн Сагсай нартай холбоотой байж болно. Гэхдээ тэдэнтэй харилцаа холбоо ч юм уу улируулан авсан гэхээс илүүтэйгээр *Монгол Алтайн баруун зүгийн бэлгэдлийн үзэгдэл*, түрүүлгэ харуулсан булшинд илэрсэн хэлбэр байх. Харин

---

[14] Амартүвшин, Ч., *Түрүүлгэ нь харуулсан оршуулгат булш, Археологийн судалгаа: Монголчуудын гарал, угсаа-соёлын хөгжил,* УБ., 2020, х.25

[15] Дулам, С., *Монгол бэлгэдэл зүй II: Өнгийн бэлгэдэл зүй, зүг чигийн бэлгэдэл зүй*., УБ., 2020, х.140.

түрүүлгэ харуулж буй байдал бол тэдний оршуулгын ондоошил гэдэг нь ойлгомжтой.

Түрүүлгэ харуулж буй булшны толгой талын буюу зүүн талын ханыг хийхдээ ямагт хавтгай чулууг босгож зоох аргаар хийдэг ба бусдаасаа өндөр байдаг аж [16].

Учир юунд толгой талын ханыг өндөр хийв. Магадгүй энэ нь өнөөгийн булшны **чулуун самбар**-ын эрт үеийн хэлбэр байж болно. Зарим түрүүлгэ харуулсан булшны уг чулуунд хирс, янгир, болон нэгэн амьтны дүрс (?) сийлсэн байдаг нь таамгийг баталгаажуулж байна. Булшны чулуу гэж хэлж болохуйц зүйл хожуу хүрлийн дөрвөлжин булшинд мөн тохиолдсон ба, буган хөшөөг дөрвөлжин булшны хашлага, хаалт, таг болгон хэрэглэсэн нь байна.[17] Самбар чулуу нь неолитын үед холбогдох Тамсагбулагийн сууринаас ч мөн илэрсэн байдаг ба үүрэг зориулалтын хувьд, үр тариа бутлах зориулалттай, харин дээрх хүрлийн үеийн булшнуудад тохиолдож буй нь самбар чулуу гэж нэрлэхэд зохимжгүй ба булшны чулуу хэмээвэл зохино.

Дараагийн нэг сонирхолтой зүйл бол түрүүлгэ харуулсан булшинд хөшөө чулуу босгосон байдаг ба үйлдэхдээ булшны баруун талын хананаас баруун урагшаа 10-80м орчим талбайд хоёр янзаар үйлдсэн байна. Булшнаас баруун урагш зэл чулууг нэг эгнээгээр цуврууллан босгосон, мөн булшнаас баруун урагш зэл чулууг хоёр эгнээгээр цуврууллан, нэг эгнээнд 2-4 чулууг дөрвөлжилж эсвэл чандмань хэлбэртэй нийлүүлж хооронд нь 1-2 м зайтай цуврууллан үйлдсэн зэрэг болно. Ийнхүү зэл чулууд зүг чигийн хувьд адил боловч газарт шигтгэн үйлдсэн нь хоёр төрөлтэй [18].

Хорь буриад бөөгийн эр хүний сүлд болсон Хошоонгол есөн тэнгэр баруун зүг байрлалтай бөгөөд чанарын ёслолын үеэр бөөгийн амьтай оргой сахиусыг тахилын гэрээс баруун урд зүгт залдаг. Дархад шарнууд бөөгийн ёсонд цагаан

---

[16] Хатанбаатар, Д., *Монгол нутаг дахь хүрлийн үеийн түрүүлгэ нь харуулсан оршуулгат булшны судалгааны зарим асуудалд, Докторын зэрэг горилсон бүтээл*, УБ., 2019, х.45-54

[17] Шивэртийн амны дурсгал нь Архангай аймгийн Батцэнгэл сумаас баруун тийш 45 км-т Цэцэрлэг хотоос хойш 45 км-т зайд хуучин Баянуул сум (одоогийн баг)-аас хойш зургаан км-т оршино. Энд олон тооны булш хөшөөтэй болох тухай Батцэнгэл сумын иргэн Галсандагва судлаачдад анх мэдээлжээ.
"...13-22-р буган хөшөөдийг хоёр дахь дөрвөлжин булшны доорх чулуун авсны хана, таг шал хийхэд ашигласан ажээ. Харин 18-р хөшөө өөр чулуун авсны баруун хэсгийг таглаж тавьсан ба гурван тал нь зураггүй зөвхөн нүүрэн талын өргөн хавтгайн голоор хоёр зэрэгцээ нарийн зураас (зам) гарган түүний дээгүүр морь хөтөлсөн гурван хүн, 18 адуу, нэг нохойн зургийг хонхойлгон цохиж урласан нь Монгол болон Төв Азийн нутагт нэлээд элбэг тохиолдох хадны зосон зурагтай төстэй бөгөөд эрдэм шинжилгээний хувьд энэхүү самбар чулуу чухал ач холбогдолтой болохыг цохон тэмдэглэх хэрэгтэй. Самбар чулуу 1.25 м өндөр, 0.55 м өргөн, 0.15 м зузаан хэмжээтэй".

[18] Идэрхангай, Т., *Зэл чулуут дурсгалын тухайд*, Studia Archaeologica. Tom.(IX) XXIX. Fasc.11, УБ., 2010, х.190.

тэнгэрт өргөсөн сүү, цагаан чулуу зэрэг өргөлийг баруун урагш нь гаргаж өргөдөг зэрэг нь энэ зүгийн тэнгэр онгодыг тахиж буй хэрэг бөгөөд дээрх хорь буриадын зан үйлтэй төстэй байна.[19]

Монгол туульсын өгүүлэмжийг нарийвчлан ажиглаж үзэхэд алс холоос ирсэн баатар эр зорьж ирсэн айлынхаа далай цагаан өргөөний баруун хойт биед нь ирж буудаг бөгөөд орохын өмнө агсаж ирсэн зэр зэвсгээ мөн өргөөний баруун эгэм дээр нь тавиад ордог, ирсэн хойноо гэрийн баруун хоймор биеийг эзлэн суудаг, зөв сайн санаатай ирсэн бол бүх үйл үйлдлээ баруун зүг, баруун тал этгээдээр төгсгөдөг ажээ. Мөн туульсын эерэг баатар, анд сайн нөхдийнх нь орших орон тив, амьтны бие эрхтэн дээр бол бүхэл бие цогцсыг эн тэргүүнээ төлөөлж чадах сайн бэлгэдэлт тал.[20]

Мөн л бөө мөргөлийн нэгэн зүйлтэй холбогдож буй нь энэ. Дээрхээс үзвэл, булшны баруун талд байх уг зэл чулууд нь талийгчийн ойрын хүмүүс, нарийн хэлбэл оршуулгад оролцсон хүмүүсийн төлөөлөл болно.

3. Хожуу хүрлийн үеийн соёлуудын зүг чигийн учир шалтгааны таамаглал:

3.1. Хиргисүүр: МЭӨ II мянган жилийн эхний хагасын эцсээс Евразийн тал нутаг хөдөлгөөнд орж археологийн дурсгалуудын байршилт өөрчлөгдөж, нэг соёл нөгөөгөөр солигдох, шинээр үүсэн бий болох явц эхэлжээ. Энэхүү угсаатан хоорондын харилцаа ба ижилсэх үйл явц тогтворжсоны үр дүнд археологийн соёлын нийтлэг хэлбэршин тогтсон байна [21].

Хожуу хүрлийн үед оршин буй соёлууд өргөн газар нутгийн хамран, оршуулгын дэг ерөнхийдөө тогтож, утга агуулга талаасаа төгөлдөржиж эхэлсэн нь сүсэг бишрэл лав тогтсонтой холбоотой. Хиргисүүрийн тархалт дан ганц Монгол орноор хязгаарлагдахгүй, гэхдээ гол төв нь өнөөгийн Монгол орон.

Хиргисүүрийн өвөг нь хөгжингүй хүрлийн Сагсай, тиймдээ ч тэдний оршуулгын чиг баруун.

Дээр Сагсайн соёлд дурдсан улаан зос цацах үзэгдэл нь Хиргисүүрийг үйлдэгсдэд байхгүй болсон ч тэд талийгчийг үүрд санан дурсахтай холбоотойгоор, хөшөө чулуу босгож, сүсэг бишрэл, хойт төрлийн үзэл санаанд шинэ төрх үүссэнтэй холбоотой. Тэдний оршуулгын зүг чигийн тухай үзэл нь Сагсайтай ижил буюу баруун зүгийг ертөнцийн төгсгөл хэмээн үзэж буй. Харин буган чулуу хөшөө босгож буй нь баатар эрийн төлөөлөл гэдэг нь тодорхой болсон. Тухайлбал энэ нь оршуулгын гадна илэрхийнхээ хувьд баруун тивийг эзлэн төрсөн баатар эр.

---

[19] Дулам, С., *Монгол бэлгэдэл зүй II: Өнгийн бэлгэдэл зүй, зүг чигийн бэлгэдэл зүй*., УБ., 2020, х.155

[20] Мөн тэнд. х.147.

[21] Батсайхан, З., *Хүннү.,* 2002, х.124

Харин буган хөшөөний нүүрийг зүүн зүгт чиглүүлэн босгосон байдаг нь зос цацан амилуулах зан үйлийн дараачийн хэлбэр бөгөөд баатар эрийг дахин төрөхийг бэлгэдсэн санаа.

3.2. Дөрвөлжин булш: Монголчуудын угсаа гарвалийг нэхэн тодруулахад хамгийн их үүрэг гүйцэтгэсэн соёл бол Дөрвөлжин булшныхан. Археологич З.Батсайханы үзэж буйгаар өмнө зүгээс гарсан нүүдэлчдийн хэсэг Монголд ирж уг соёл бүрэлдэн тогтох үйл явцад нөлөөлсөн[22].

Тэд ямар ч байсан өнөөгийн өвөг Монголчууд гэдэг нь тодорхой. Харин зүг чигийн хувьд түрүүлгэ харуулсан булштай ижил, мөн сагсайн зос цацахтай ижил зан үйл ч мөн байдаг, гэхдээ дээрх соёлуудын салаа салбар гэхээсээ илүүтэйгээр шилжин ирэгсэд уугуул соёлын оршуулгын зан үйлээс хүлээн авсан хэлбэр байх.

Нөгөөтээгүүр бидний харж буйгаар түрүүлгэ харуулсан булшны хөшөө чулуу босгодог үзэлтэй холбогдож болохуйц хоёр зүйл ажиглагдаж байна *(Хүснэгт 2-ыг харна уу).*

Хүснэгт 2: Түрүүлгэ харуулсан булш болон Дөрвөлжин булш дахь ижилсэх боломжтой талуудыг ажигласан байдал

№	Түрүүлгэ харуулсан булш	Дөрвөлжин булш
1	Булшинд хөшөө чулуу босгосон байдаг ба үйлдэхдээ булшны баруун талын хананаас баруун урагшаа 10-80м орчим талбайд хоёр янзаар үйлдсэн байна[23].	Булшны зүүн талын булан, өнцөгт ханын бусад чулуунаас өндөр чулуу зоох, эсхүл булшнаас нэлээд зайтай боловч мөн л зүүн талд нь шон, хөшөө босгох ёс заншил зэрэг нь зүг эрхэмлэхтэй холбогдон гарчээ[24].
2	Талийгчийн толгой талын буюу зүүн талын ханыг хийхдээ ямагт хавтгай чулууг босгож зоох аргаар хийдэг ба бусдаасаа өндөр байдаг[25].	Талийгчийн толгой доор чулуун дэр хийсэн байдаг[26].

Наран ургах зүгийг бэлгэдсэн байдал нь хүрлийн хожуу шатанд бүрэлдэн хэвшиж буй сүүлийн үзэгдэл болохынхоо хувьд энэ үед Монгол оронд соёлын нийтлэгүүд хэр хэмжээнд, ямар байдалтайгаар төрхөө олсныг илтгэж буй.

Дөрвөлжин булш нь олдвор хэрэглэгдэхүүний хувьд нэн ариун, олон төрөлт байдаг уу эдгээрээс сүсэг бишрэлд холбогдох сэжим бий бөгөөд энэ талаар цаашдын судалгаандаа лавшруулах болно.

---

[22] Батсайхан, З., *Хүннү.,* 2002, х.137.

[23] Идэрхангай, Т., *Зэл чулуут дурсгалын тухайд.,* 2010, х.190.

[24] Наваан, Д., *Дорнод Монголын хүрлийн үе.,* 1975, х.131.

[25] *Монгол нутаг дахь хүрлийн үеийн түрүүлгэ нь харуулсан оршуулгат булшны судалгааны зарим асуудалд,* Докторын зэрэг горилсон бүтээл, УБ., 2019, МУИС. х.58.

[26] Очир, А., нар., *Археологийн судалгаа: Монголчуудын гарал, угсаа-соёлын хөгжил,* 2020,х.105

ДҮГНЭЛТ

Хүрэл зэвсгийн соёлуудын ертөнцийг үзэх, сүсэг бишрэлийг өөрийн цуглуулсан хэрэглэгдэхүүнээс ерөнхийд нь харахад дараах үр дүнгүүд гарч болохоор байна.

Өөр, өөр цаг үед хамаарах хүрлийн үеийн соёлуудад атал, эрс тэс байгалийн хил хязгаарт захирагдан тухайн бүс нутгийн шинжтэй, оршуулгын зүг чигийн үзэгдлийг улируулан өөрсдийн зан үйлд тааруулж буй зэргээс харахад дийлэнх тохиолдолд оршуулгын дэг оршин буй бүс нутаг, газар, байр зүйнээс хамаарч байна, мөн нөгөөтээгүүр энэ байдал нь газар нутгаа өөрийн эзэмшилд удаан байлгах санаархалтай давхар холбогдоно. Ялангуяа хөгжингүй хүрлээс эхлэн энэ үзэгдэл харагдаж эхэлж байна. Энэ нь сүсэг бишрэлийн хувьд тогтвортой болж, зан үйлийн зүйлс нэмэгдсэн буюу товчоор хэлбэл хөршлөн удаан оршихын гол утга санаа, өөрчлөлт нь ертөнцийг үзэх үзэлд шинэ дэг бий болгож, зарим тохиолдолд оршуулгын зүг чигийн тогтсон хэвийг өөрчилж, өөрсдийн соёлд уусан нэвчүүлж байгаа хэдий ч хүрлийн үеийн соёлуудад сүсэг бишрэлийн нийтлэг тал ихээхэн байсантайгаар огцом өөрчлөлт ажиглагдахгүй байна

Бөө мөргөлтэй холбогдохынхоо хувьд, өнөөгийн Монгол орон дахь бөөгийн шашны анхны дүр төрх хүрлийн үеэс эхлэлтэй ба бөө мөргөлийн суурь сүсэг бишрэлүүд энэ үед тавигджээ. Мөн Монгол туульсын зүг чигийн учир холбогдол нь тэнгэр шүтлэгтэй нягт холбоотой сурвалж болно.

Хожуу хүрлийн үе бол анхны төрт улс Хүннүгийн сүсэг бишрэлд том дэвшлийг олгосон. Тиймдээ ч Хүннүгийн бөө мөргөл нь өөрийн имижээ олох шаардлагатай тулгараагүй ба, үүнд хожуу хүрлийн үед өрнөсөн соёлын нийтлэгүүдийн янз бүрийн зан үйлийн нэгдэл нөлөөлсөн.

Бид цаашдын судалгаанд хилийн чанад дахь хүрлийн үеийн соёлуудын зүг чигийн учир байдлыг тодруулахад анхаарах ба судалгааны өгөгдлөө улам бүр нэмэгдүүлэн, нэмэлтээр эд өлгийн зүйлсийг харьцуулах тал дээр төвлөрч ажиллах болно.

INTERPRETATION OF BURIAL ORIENTATIONS IN BRONZE AGE CULTURES IN RELATION TO SHAMANISM

This study analyzes the orientation of the deceased in Bronze Age burial sites dating from 2600 to 600 BCE-approximately 5,000 years ago. Through this analysis, the research interprets their religious beliefs and examines how their worldview evolved from the Bronze Age to take its modern form. These issues are explained using archaeological excavation materials and comparative analysis of burial monuments. Specifically, burying the deceased facing a particular direction was

not accidental; rather, it expressed ideological concepts linked to the sun, moon, western and eastern skies, and the surrounding natural and geographical cycles. Consequently, the dominance of eastern and western orientations correlates with the symbolism of life, death, and rebirth. This demonstrates that such a worldview did not stem from the arbitrary choices of successive populations inhabiting the region, but rather manifested as a structured belief system deeply and stably embedded within that specific space over a long period.

Keywords: *Shamanism, burial, orientation, worldview, beliefs*

НОМ ЗҮЙ

Судалгааны бүтээл

Амартүвшин, Ч., Жаргалан, Б., (2008), *Бага газрын чулуунд хийсэн хүрэл зэвсгийн түрүү үеийн булшны судалгаа*. Studia Archaeologica. Tom. (VI) XXVI. Fasc.5, УБ.

Амартүвшин, Ч., (2018), *Эртний нүүдэлчдийн өвөрмөц нэгэн оршуулгын тухай (түрүүлгэ нь харуулсан оршуулгат булш). Монголчуудын хойлгын зан үйл,* УБ.

Батболд, Н., Түвшинжаргал, Т., Баярсайхан, Ж., & Содномжамц, Д., (2025), *Мөнххайрханы соёлын судалгааны тойм ба сүүлийн үеийн үр дүн*, Studia Archaeologica, 46(4). УБ.

Батсайхан, З., (2002), *Хүннү,* УБ., МУИС.

Гүнчинсүрэн, Б., (2000), *Тамсагбулагийн шинэ чулуун зэвсгийн суурингийн он цагийн асуудлыг дахин авч үзэхэд.* Studia Archaeologica. Tom.XX, Fasc.2, УБ.

Далай, Ч., (2009), *Монголын бөөгийн мөргөлийн түүх,* УБ., Шидэт Өнгө принтинг.

Дулам, С., (2020), *Монгол бэлгэдэл зүй. II боть: Өнгийн бэлгэдэл зүй, зүг чигийн бэлгэдэл зүй*, УБ., Битпресс.

Идэрхангай, Т., (2010), *Зэл чулуут дурсгалын тухайд.* Studia Archaeologica. Tom.(IX) XXIX. Fasc.11, УБ.

Идэрхангай, Т., Хүслэн, Л. (2025), *Харуулын гозгорт малтсан Мөнххайрханы соёлын нэгэн булшны тухайд.* Mongolian Journal of Anthropology, Archaeology and Ethnology, Vol. 14 (1), УБ.

Карл Густав Юнг., (2022), *Зураг хөтөч: Сэтгэл засал*, Орчуулсан, Төрбурам, Л., УБ., Сайколожи Паблишинг.

Наваан, Д., (1975), *Дорнод Монголын хүрлийн үе,* УБ., ШУА-ийн Хэвлэх үйлдвэр.

Очир, А., Төрбат, Ц., Амартүвшин, Ч., Эрэгзэн, Г., Гантулга, Ж., Түмэн, Д., Баярсайхан, Ж., Эрдэнэболд, Л., Өлзийбаяр, С., & Эрдэнэбат, У. (2020), *Археологийн судалгаа: Монголчуудын гарал, угсаа-соёлын хөгжил*, УБ., Мөнхийн үсэг.

Пүрэв, О., (2006), *Монголын бөөгийн шашин*, УБ., Адмон принтинг.

Төрбат, Ц., Амартүвшин. Ч., Эрдэнэбат, У. (2003), *Эгийн голын сав нутаг дахь археологийн судалгаа,* УБ., Соёмбо принтинг.

Хатанбаатар, Д., (2019), *Монгол нутаг дахь хүрлийн үеийн түрүүлгэ нь харуулсан оршуулгат булшны судалгааны зарим асуудалд,* Докторын зэрэг горилсон бүтээл, УБ., МУИС.

Эрдэнэбаатар, Д., (2002), *Монгол нутгийн дөрвөлжин булш, хиригсүүрийн соёл*, УБ.

Гадаад хэл дээрх бүтээл


Дорж, Д., (1971), *Неолит Восточной Монголии*. УБ.

Волков, В.В., (1980), *Курганы афанасьевского типа в Монголии.* Studia Archaeologica. Tom.IX, Fasc.2. УБ.

Ковалев, А.А., (2014), - *Древнейшие европейцы в сердце Азии: чемурчекский культурный феномен. Часть I.* Результаты исследований в Восточном Казахстане, на севере и юге Монгольского Алтая.

ХАВСРАЛТ





Зураг 1: Бүс нутгаар хуваахдаа ерөнхий харагдцаар хуваав.
Газрын дэвсгэр зургийн эх сурвалж: mapcreators

Хүснэгт 1: Монгол нутагт одоогоор малтан судалсан хүрлийн үеийн булшнуудын тархцын мэдээллийг аймгаар нь Алтай, Хангай, Хэнтийн нуруу, Говь, тал хээрийн 3 бүсэд хуваан байршуулав.

№	Хүрэл зэвсгийн оршуулгат соёлууд	Алтайн нуруу	Саян, Хангай, Хэнтийн нуруу	Говь, тал хээрийн бүс	Талийгчийг оршоосон зүг	Эх сурвалж
Түрүү хүрэл зэвсгийн үе	Хэмцэг	Ховд, Булган сумын Ягшийн хөдөө, Хөх Үзүүрийн дугуй, Авын хөх уул, Хэвийн ам, Баян-Өндөр, Ховд сумын Бэлэн Усны дэнж, Эрдэнэбүрэн сумын Баянзүрхийн Энгэр, Баян-Өлгий, Цэнгэл сумын Шарговь, Сагсай сум Годон гол (Хар чулуутын гол), Цагаан Асгын гол			Баруун	Эрдэнэбаатар нар 2010; Эрдэнэбаатар нар 2011; Төрбат нар 2012; Төрбат нар 2019
	Мөнххайрхан	Баян-Өлгий 1, Ховд 4,	Увс 5 (малтсан 2, малтаагүй 3), Завхан 6 (малтсан 5, малтаагүй 1), Хөвсгөл 11 (малтсан 9, малтаагүй 2), Булган 1, Архангай 1, Өвөрхангай 1		Зүүн	Монголын археологи 2024, 2025; Амартүвшин нар 2017; Эрдэнэбаатар нар 2010; Идэрхангай нар 2025...

Хөгжингүй хүрээ зэвсгийн үе	Сагсай	Баян-Өлгий, Цагаан аса 22, Тахилгат үзүүр 8, Ховд, Хөх толгой 2, Говь-Алтай, Хяр хараач 2, Баянхонгор, Орог нуурт 3, Эмээл толгой 2	Увс, Саваа хар толгойд 3, Архангай, Хойд Тамирын голын хөндийд 11, Өвөрхангай, Хужирт, Майхан толгойд 4, Хөвсгөл аймагт 5,		Баруун	Төрбат нар 2012а; Төрбат нар 2012б; Гантулга 2020.
	Түрүүлгэнь харуулсан оршуулгат булшнууд	Ховд, Хөшөөтийн гол	Увс, Дорнод, Архангай, Төв, Хэнтий, Баянхонгор, Өвөрхангай, Хужирт, Майхан толгой,	Сүхбаатар, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Баянхонгор, Баянлиг, Богд, Өвөрхангай, Тэвш уул	Зүүн	Монголын археологи 2016; Хатанбаатар 2019; Амартүвшин 2020;
Хожуу хүрээ зэвсгийн үе	Хиргисүүр	Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Өвөрхангай, Баянхонгор	Увс, Архангай, Өвөрхангай, Завхан, Баянхонгор, Булган, Орхон, Хөвсгөл, Сэлэнгэ, Төв, Улаанбаатар	Дундговь, Бага газрын чулуу-2	Баруун	Эрдэнэбаатар 2002; Амартүвшин, Цэлхагарав 2018; Төрбат 2020; Гантулга 2020;
	Дөрвөлжин булш	Нийт нуттийг хамарсан	Нийт нуттийг хамарсан	нийт нуттийг хамарсан	Зүүн	Эрдэнэбаатар 2002; Төрбат 2020;

2026 Fasc.14

ХОР ДАГАЛДУУЛАХ ЗАН ҮЙЛИЙГ ТОДРУУЛАХ НЬ

Эрдэнэбатын БААТАР
МУБИС-ийн Түүх нийгмийн ухааны багш хөтөлбөрийн IV курсийн оюутан

Удирдагч багш: Г. Цэнгүүн
ШУА-ийн Түүх, Угсаатны зүйн хүрээлэнгийн ЭША, докторант

Хураангуй: *Энэхүү өгүүлэлд дундад эртний монголчуудын оршуулгын зан үйлд хор дагалдуулах ёсны утга учир, бэлгэдлийг судлав. "Qor" хэмээх үгийн утгыг толь бичиг болон судлаачдын судалгаанаас үзэхэд сум агуулах савны нэр болох нь тодорхой байна. Бид нас барсан хүнд хор дагалдуулдаг зан үйлийн шалтгааныг археологийн судалгаа, сурвалж бичгийн мэдээ, миниатюр зураг зэрэг бариmтаас тодруулахыг зорилоо. Судалгааны дүнгээс харахад нас барсан хүнд хор дагалдуулах зан үйл нь дараах утгуудыг илэрхийлдэг байна.*

1. *Эр хүний дайчин чанар, нэр төрийн бэлгэдэл бөгөөд үхэхэд нь хорыг дагалдуулах нь тухайн хүнийг дайн тулаанд ялагдаж зэвсгээ алдаагүйг илэрхийлдэг.*
2. *Хорыг ихэвчлэн биеийн зүүн талд байрлуулдаг нь монголчуудын зүүн зүгийг үхэл, мөхлийн зүг гэж бэлгэддэгтэй холбоотой. Нас барсан хүнд хорыг дагалдуулахдаа амьд ахуйдаа зүүж байсны эсрэг талд нь тавьдаг.*
3. *Монголчууд нөгөө ертөнцийг энэ ертөнцийн эсрэг тусгал гэж үздэгтэй холбоотой, үхлийг амьдралын үргэлжлэл хэмээн ойлгодог байсан тул нас барсан хүнд хэрэглэж байсан эд зүйлсийг дагалдуулдаг байжээ. Ингэхдээ энэ ертөнцөөс өөр байлгах үүднээс зориуд хагалж гэмтээж хийдэг байна зэрэг үр дүн гарлаа.*

Түлхүүр үг: *оршуулга, хор, монголын нууц товчоон, миниатюр зураг, нөгөө ертөнц*

УДИРТГАЛ

Монголчуудын оршуулгын зан үйл нь нүүдэлчдийн ахуй амьдрал, нийгмийн зохион байгуулалт, ертөнцийг үзэх үзэл, соёлын онцлогийг илэрхийлэх өвөрмөц

судлагдахуун болдог онцлогтой. Дундад зууны үеийн монголчууд нас барсан хүнд зориулж оршуулга үйлдэхдээ тухайн хүний амьд ахуйдаа эдэлж хэрэглэж байсан зүйлсийг нь дагалдуулан тавьдаг билээ. Монгол орны нутаг дэвсгэрт байх монгол булшны малтлага судалгааны үр дүнгээс үзэхэд нас барсан эр хүнд хор дагалдуулах явдал нэлээд түгээмэл байна. Сүүлийн жилүүдэд монгол булшны малтлага судалгааны үр дүн, олдвор хэрэглэгдэхүүнээр "Талын язгууртны өв соёл IV"[1], "Хадны оршуулга"[2], "X-XVII зууны монгол булш оршуулгын судалгаа"[3], зэрэг судалгааны бүтээлүүд гараад байна. Эдгээр бүтээлд судлаачид нас барсан хүнд дагалдуулсан хорны байршил, хэлбэр хийц, хээ чимэглэл зэргийг нь анхааран судалсан ч түүнийг дагалдуулах болсон шалтгаан, утга бэлгэдлийг тодруулаагүй байна. Иймээс нас барсан хүнд хор дагалдуулах болсон шалтгаан, зан үйл, утга бэлгэдлийг тодруулах шаардлагатай юм.

"Qor" хэмээх үгийн утгыг хорин нэгтийн тайлбар толинд "арьсаар хийсэн саадгийн дотор этгээдэд хавсран хадаж годил, гилбэр дүрэх тасаг"[4] хэмээжээ.

Монголын нууц товчоонд гарах "dabčitu qor" хэмээх үгийн утгыг судлаачид дараах байдлаар тайлбарлажээ. П. Пеллиот «бүрхүүлтэй саадаг салгалахад»[5], Э. Хэниш "ороолттой, бүрхүүлтэй саадаг"[6], А. Мостаэрт "бүрээстэй саадаг савлан хөдлөхөд"[7] гэсэн утгатай үг хэмээн тайлбарлажээ. Эдгээрээс үзэхэд "Qor" хэмээх үг нь сум агуулах сав гэсэн утгатай болох нь тодорхой байна.

Монголын нууц товчоонд "*ibulun bükü dayisun dotora irgetei ger minu horcin hirmes ülü kin itqaju bayiqsat itegelten kebte'ül minu* ***uyilsun qor*** *ubis kikü-tür udal ügei bayidaltan uriyarqun kebte'ül minu* ***qutan qor*** *qubis kikü-tür qojit ese bayiqsat qurdun yabudaltan kebte'ül minu*"[8]

(Ивлэн бүхий дайсан дотор
Иргэтэй гэр минь орчин
Ирмэс үл хийн

---

1 Эрдэнэболд, Л, Эрдэнэ, Ж., нар, *Талын язгууртны өв соёл IV: Оорцог уулын түүх соёлын дурсгал,* УБ., 2024, х.217-218.

2 Хүрэлсүх, С., *Хадны оршуулга: Монголын эртний оршуулгын өвөрмөц хэлбэр,* УБ., 2024, х. 134-142.

3 Батдалай, Б., *X-XVII зууны монгол булш, оршуулгын судалгаа (монгол улсад малтсан хэрэглэгдэхүүнээр),* Түүхийн ухааны доктор (Ph.D)-ын зэрэг горилсон бүтээл, УБ., 2022. х.153-157.

4 *Qorin nigetü tayilburi toli,* Öbür Mongγol-un arad-un keblel-ün qoriy-a, 1979, х.387.

5 Pelliot, P., *Histoire secrete des Mongols: restitution du texte mongol et traduction franais I VI*, Paris., 1949, p.147.

6 Haenisch, E., *Die Geheime Geschichte der Mongolen*, Leipzig., 1948, p.30.

7 Mostaert, A., *Sur quelques passages de l'Histoire secrète des Mongols.* Harvard Journal of Asiatic Studies, 1950, p.351.

8 Rachewiltz, I. D., *Index To The Secret History of the Mongols,* Bloomington., 1972, p.133.

Ятган байгсад
Итгэлтэн хэвтүүл минь
Уйлсун (=үйсэн) хор
Увс хийхэд
Удалгүй байдалтан
Уриархан хэвтүүл минь
Худан (=дан) хор
Хувьс хийхэд
Хожид эс байгсад

Хурдан явдалтан хэвтүүл минь) хэмээн хорыг хийсэн бүтээсэн эдээр нь үйсэн хор, удан хор гэж ялган тэмдэглэсэн байна.

Харин нас барсан хүнд хор дагалдуулах тухай Монголын нууц товчооны 190-р зүйлд: "*töreksen ere-de ükü'esü taki **qor** numun-lü'e-ben yasun-lu'a niken-e kebte'esü ülü-'ü sayin bui"*[9] (Төрсөн эрд үхвээс тахь хор нум лугаа яс лугаа нэгнээ хэвтвээс үл хүү сайн буй) хэмээн тэмдэглэжээ. Үүнээс үзэхэд дундад эртний монголчууд баатар эрийг үхэхэд нь хорыг эзэнтэй нь хамт оршуулдаг зан үйл байсан ажээ. Эл мэдээ нь Монгол орны нутаг дэвсгэрт хийгдсэн дундад эртний булш, оршуулгын дурсгалуудад хийсэн археологийн малтлага судалгааны үр дүнгээр батлагддаг.

Нас барсан хүнд хор дагуулан оршуулах болсон шалтгааныг монголын нууц товчооны дээрх мэдээнд тулгуурлан тодруулж болохуйц байна. Тухайлбал, монголын нууц товчоонд хороо автах, хорыг нь хураах гэх мэтээр ялсан тал нь ялагдсан дайсны хорыг хураадаг тухай мэдээ олонтоо гардаг. Хороо автах, хорыг хураах зэрэг мэдээзг монголын нууц товчооны 190-р зүйлийн мэдээтэй харьцуулан үзэхэд дундад эртний монголчуудын дунд дайн тулаанд ялагдаж хороо хураалгах нь маш их гутамшигт үйл явдал байжээ. Иймд нас барсан хүнд хор дагалдуулж оршуулж байгаа явдал нь тухайн хүний нэр төр, дайн тулааны амжилтыг харуулдаг байна.

Монгол улсын нутаг дэвсгэрт монголын үеийн булш оршуулгын дурсгал өргөн тархалттай байдаг билээ. Сүхбаатар аймгийн Онгон сумын Таван толгой, Түвшинширээ сумын Адгийн булаг, Бага хүнгүй, Бөмбөгөрийн асга, Их хүнгүй, Тэмээн чулууны хөтөл, Дорноговь аймгийн Айраг сумын Баруун цагаан дэл, Дэлгэрэх сумын Чандмань хар уул, Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Оюут овоо, Баянжаргалан сумын Эрээн, Хөөт, Дэлгэрцогт сумын Алаг толгой, Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Зангат уул, Улаан худаг, Ханбогд сумын Бага ухаа, Будаагийн улаан, Зэлтийн гол, Маанийн задгай, Сондуулын задгай,


[9] Rachewiltz, I. D., *Index To The Secret History of the Mongols,* Bloomington., 1972, p.98.

Талын хар, Тоонотын ар, Түймэрт, Улаан эргийн элс, Ханангийн тойром, Хар дэлийн толгод, Хар толгой, Хөх хад, Хүйс толгой, Хүрэн дэл, Хүрэн толгойн хоёр мод, Цахиурт овоо, Ясан хашаат, Ханхонгор сумын Баруун наран, Цогтцэций сумын Улаан худаг, Майхан толгой, Усны хоолой, Ухаа худаг, Баруун наран, Эрдэнэс таван толгой, Хармагтай, Төв аймгийн Баяндэлгэр сумын Маанийн энгэр, Баян сумын Ясангийн хар толгой зэрэг дурсгалт газарт нийт 220 чулуун дараастай монгол булш малтан судалжээ[10]. Эдгээрийн 31 булшинд хор дагалдуулсан байснаас 23 булшинд нас барагчийн биеийн зүүн талд, 3 булшинд нас барсан хүний биеийн баруун талд, 6 булш тоногдож сүйтгэгдсэний улмаас анхны байрлал нь мэдэгдэхгүй байна. Үүнээс үзэхэд оршуулгын зан үйлд хорыг ихэвчлэн нас барсан хүний биеийн зүүн талд тавьдаг болох нь харагдаж байна. Харин хорыг амьд ахуйдаа биеийнхээ аль талд зүүдэг байсныг доор тодруулан авч үзье.

Дундад эртний монголчуудын түүхэнд холбогдох хөрөг зураг, миниатюр зураг, номын чимэглэл зургууд олон байдаг билээ. Тэдгээр зургийн дүрслэлээс монгол цэрэг эр хороо биеийнхээ аль талд зүүдэг байсан болохыг тодруулж болох юм.




Зураг 1. Дайсныг мөрдөн хөөж буй монгол цэргүүд (Судрын чуулганы чимэглэл зураг)




Зураг 2. Хаан хатны хамт сууж буй нь (Судрын чуулганы чимэглэл зураг)

[10] Батдалай, Б., *X-XVII зууны монгол булш, оршуулгын судалгаа (монгол улсад малтсан хэрэглэгдэхүүнээр)* Түүхийн ухааны доктор (Ph.D)-ын зэрэг горилсон бүтээл, УБ., 2022, х.22-31.



Зураг 3. Байлдаж буй монгол цэргүүд (Судрын чуулганы чимэглэл зураг)



Зураг 4. Монгол морьтнууд олзны хүмүүсийн хамт (Судрын чуулганы чимэглэл зураг)

Судрын чуулганы дээрх чимэглэл зургуудад Монгол цэрэг эрсийг дүрслэхдээ хорыг нь баруун ташаандаа зүүсэн байдлаар дүрсэлжээ. Үүнээс үзэхэд монгол цэргүүд хороо биеийнхээ баруун талд зүүдэг байжээ. Мөн манж хэлээр зүүн гар талыг ᠵᠡᠭᠦᠨ (дасхүван) баруун гар талыг ᠪᠠᠭᠤᠨ (жэбэлэ) гэдэг нь хоромсого, саадаг гэсэн үг. Зүүн талдаа хоромсого агсаж, баруун талдаа саадгаа зүүдэг тул ингэж нэрлэх болжээ[11].

Дээрх баримтаас үзэхэд монголчууд хороо биеийн баруун талд зүүдэг болох нь тодорхой байна. Гэтэл хорыг нас барсан хүнд дагалдуулан тавихдаа нас барсан хүний зүүн талд тавьж байгаа явдал нь тохиолдлын зүйл биш бололтой.

Монгол уламжлалт газар зүйн ухаан, түүний дүрэмт саваар үйлдэх хорин дөрвөн хуваарийн ёсоор бол цэх зүүн зүг нь «долоо» буюу «туулай» зүг, түүний хоёр этгээдийн завсрын дараа найман өнгөөс «зургаа» буюу «хөх», «найм» буюу «хөхөгчин» гэсэн хоёр өнгө байрлаж буй (өнгө, зүг, чигийн бэлгэдлийн чуулбараас үзмүй!) нь дээрх домог зүйн, тэнгэр шүтлэгийн болон бэлгэдэл зүйн утгатайгаа яв цав нийлэлцэж байна. Нөгөөтээгүүр «долоо» бол үхэл мөхлийг дохиологч өлзий бус тооны бэлгэдэл болдог байна[12]. Иймээс нас барагчид хор дагалдуулахдаа биеийн зүүн талд тавьж буй явдлыг монголчуудын нөгөө ертөнцийн тухай үзэлтэй холбон тайлбарлаж болмоор байна.

Дундад эртний монголчуудын нөгөө ертөнцийг хэрхэн үздэг талаар тухайн үед монгол нутгаар аялсан аялагчид, элч төлөөлөгчид тэмдэглэн үлдээжээ. Тухайлбал, Плано Карпини бичихдээ: “Тэд мөнхийн амьдрал, үүрдийн

[11] *Манж үгийн толь бичиг*, Тэргүүн дэвтэр, УБ., 1960, х.192.

[12] Дулам, С., *Монголын бэлгэдэл зүй дэд дэвтэр өнгийн бэлгэдэл зүй, зүг чигийн бэлгэдэл зүй,* УБ., 2020, х.136.

гэсгээлийн талаар юу ч мэддэггүй, харин үхсэн хойноо өөр ертөнцөд очоод мал сүргээ адгуулан өсгөж, идэж ууж энэ ертөнцийн хүмүүсийн үйлддэг бусад бүх зүйлийг хийнэ гэдэгт итгэх ажгуу”[13] гэж тэмдэглэжээ. Монголчууд үхсэнийхээ дараа өөр ертөнцөд энэ ертөнцтэй адил амьдарна хэмээн үздэг болох нь тодорхой байна.

Марко Пологийн номд өгүүлснээр, Монголын их хааны шарилыг онголохоор дөчин хоногийн турш залж явах замын гудаст тохиолдсон аливаа бүх хүнийг мэслэн хороогоод “Манай эзэн хааныг дагалдан нөгөө ертөнцөд одож хүчээ өгөгтүн” хэмээн хэлээд шарилыг дагуулан хойлго хийсэн гэнэ. “Тэд тэр хороогдсон хүмүүсийг нөгөө ертөнцөд одож эзэндээ үйлчилдэг хэмээн нутад итгэдэг авай. Хаан эзэн халин одсон цагт эрдэнэт сайн хүлэг морьдыг нь хороож, мөн л дагалдуулан нөгөө ертөнцөд илгээнэ” гэжээ[14]. Үүнээс үзэхэд нас барагчид хүн болон сайн хүлэг морийг нь хороож хойлог болгон дагалдуулдаг байжээ.

Рубрукийн тэмдэглэл дэх тэр үеийн монголчуудын гэрлэлт, хуримлах ёсны тодорхойлолтод тодорхой гарч ирдэг: “Бэлэвсэн эхнэр дахин хадамд гарна гэж үгүй. Учир нь энэ ертөнцөд ямар нэгэн эрд гарсан эхнэр нөгөө ертөнцөд мөн тэр хүнтэйгээ суух учир ийнхүү цээрлэдэг ажгуу. Түүнчлэн хүү нь өөрийн төрсөн эхээс бусад эцгийнхээ үлдээсэн эхнэрүүдтэй суух муухай заншил бий. Учир нь эцгийн өв хөрөнгийг отгон хүү нь залгамжлах учир эхнэрүүдийг бас асарч тэжээх үүрэгтэй болдог байна. Тэгэхдээ тэдгээр эхнэрүүд үхэхдээ эцэгт нь эргэж очих учир тэдэнтэй суухад ичих харшлах зүйлгүй” гэжээ[15]. Монголчуудад үхэх нь төгсгөл бус харин нөгөө ертөнцөд очоод одоогийн амьдралаа үргэлжлүүлэн амьдардаг хэмээн үздэг байжээ.

Монголчуудын нөгөө ертөнцийг үзэх үзлийг судлаачид дээр дурдсан сурвалжийн мэдээ болон угсаатан зүйн мэдээ зэрэгт тулгуурлан дараах байдлаар өөрсдийн саналыг дэвшүүлжээ.

Эртний монголчууд нөгөө ертөнц үхэгсдийн оронд очсон хүн бүр амьд ахуйдаа хийж байсан ажил үйлээ үргэлжлүүлэн хийдэг гэж үздэг тухай Уно Харвагийн мэдээлснээр, “буриад дархчууд ч бас ур чадвараа мартдаггүй: бичээч хүн үзгээ оёдолчин хүн нөгчигсдийн оронд очоод зүүгээ ашигладаг шиг чадварлагаар ашигладаг. Мөн газар доорх ертөнцийн ханхүүд тэдний тусламж хэрэгтэй байдаг тул сайн хүмүүс бусдаас эрт үхдэг гэж ярьцгаадаг”[16] гэжээ.

---

[13] Плано Карпини, Ж. Д., *Монголчуудын түүх.* Орчуулсан С. Туяа, С. Цолмон. УБ., 1988, х.18.

[14] Марко Поло. *Орчлонгийн элдэв сонин (Аяны тэмдэглэл),* Орчуулсан А. Очир, Б. Дорж, С.Идшинноров. УБ., 1987, х.69.

[15] Рубрук, Г., *Дорно этгээдэд зорчсон минь.* Орчуулсан Ү. Нямдорж, УБ., 1988, х.115.

[16] Harva, U., *Die religiösen Vorstellungen der Altaischen Völker,* Helsinki., 1938, p.344.

Археологич У. Эрдэнэбат Дундад эртний монголчуудын итгэл үнэмшлийн дагуу нас барагсдын сүнс нь өөр ертөнцөд очиж, амьдралын хэв маягаа үргэлжлүүлэн, гэр бүл, мал сүрэгтэйгээ хамт оршдог гэж үздэг байжээ. Энэ ертөнц нь амьдралын үргэлжлэл мэт төсөөлөгдөж, нас барагсад идэж ууж, өмсөж хэрэглэж байсан зүйлсээ дахин ашиглах боломжтой гэж итгэдэг байсан нь оршуулгын зан үйлд тусгагдсан байна. Хайртай хүмүүсийнх нь өргөсөн хоол хүнс, хувцас болон бусад хэрэгцээтэй зүйлс нь тэдний сайн сайхан байдлыг хангах чухал нөхцөл гэж үздэг байв. Мөн нөгөө ертөнцөд нас барагсад хэрхэн амьдрах (явган явах уу, морьтой эсвэл сүйх тэргээр аялах уу) нь амьдралын үеийн хөрөнгө чинээний байдлаас хамаарна гэсэн ойлголт байсан. Энэ нь нийгмийн давхарга, эдийн засгийн байдал, шашны төсөөлөлд хэрхэн шингэсэн болохыг харуулж байна. Иймээс оршуулгын зан үйл нь зөвхөн нас барсан хүнийг үдэх төдийгүй түүний дараах амьдралын нөхцөлийг хангах зорилготой байсан нь эртний монголчуудын шашны болон соёлын үзэл санааны онцгой шинж юм[17] хэмээжээ.

Францын эрдэмтэн Жан-Поль Ру бээр, сүнс болон нөгөө ертөнцийн амьдралын тухай эртний монгол итгэл үнэмшлийн өөр нэг талыг "Энэ ертөнцөд боол үгүй, унах морьгүй байсан бол тэнд боол, морь байхгүй. Гэсэн хэдий ч хэрэв зарим амьтдыг нөгөө ертөнцөд хамт аваачсан бол тэднийг өсгөж үржүүлж болно. Тэнд бас тулаанууд болдог учир нас барсан хүн хоёр дахь удаагаа үхэж ч болно"[18] гэж үзжээ.

Б. Ринчен гуай 1965 онд Францын сэтгүүлчидтэй ярилцахдаа: "Хэрэв хэн нэгэн надаас "Амьгүй юм хүртэл сүнстэй гэх гэж байна уу?" хэмээн асуувал бөөгийн шашинтай монгол хүн "Тийм ээ, бүх зүйл сүнстэй" гэж хариулна. Монголчууд нас барагсдаа оршуулахдаа өөрийн нь хэрэглэж байсан эд юмтай нь хамт оршуулдаг. Тэгэхдээ түүнийг эвдэж хэмхлээд эвдэрхий буюу амьд хүн хэрэглэхгүй болсон зүйлийг хамт оршуулдаг. Үүнийг санамсаргүй тохиолдлын юм хэмээн үзэж болохгүй. Тэр хүн үхэхдээ хүүрээс нь сүнс нь салдаг бол эд юмсыг нь хагалж эвдэж бас сүнсийг нь салгаж байгаа хэрэг болно. Үхсэнээс хойш тэр хүн аяга хэрэглэх бус аяганыхаа сүнсийг хэрэглэдэг. Тийм учраас хагалж хамт оршуулдаг юм. Гэрийн эзэгтэй авгай хүн үхвэл оршуулахдаа хугархай хайч, зүү, өрөөсөн ээмэг зэргийг, цэрэг хүн үхвэл булшинд нь хугархай сэлэм, жад байх буюу өөрөөр хэлбэл, үхсэн хүн авсан дотроо амьд ахуйдаа эдэлж хэрэглэж явсан эд хэрэгслээ дахин олж хэрэглэх ёстой гэсэн

[17] Эрдэнэбат, У., *Сүнс ба нөгөө ертөнцийн тухай дундад эртний монголчуудын ойлголт төсөөлөл,* Mongolian Journal of Anthropology, Archaeology and Ethnology, УБ., 2025, х.137-149.

[18] Roux, J.P., *La mort chez les peuples altaïques anciens et médiévaux d'aprés les documents écrits,* Paris., 1963, p.107.

ойлголттой байсан. Их хаан үхсэний дараа өөрийн морь, нохойг хэрэглэж, сайн зарцаа зарцалж байх ёстой гэдэг. Тиймээс булшинд морь, нохой, хүн хүртэл алж хийдэг ёс ч байжээ"[19] гэж хэлсэн байдаг.

Энэ үзэгдэл нь шашин судлалын шинжлэх ухаанд "дүрс сүнс" гэгддэг итгэл үнэмшил буюу нас барсан хүний сүнс, түүний эд зүйлсийн "сүүдэр" нөгөө ертөнцөд хамт явах ёстой гэсэн ойлголттой холбоотой. 1880-аад онд Буриадуудын дунд явуулсан судалгаанд тэмдэглэснээр: Нас барсан хүний булшинд эд зүйлсийг тавихдаа заавал эвддэг байсан нь эд зүйлсийн "бодит дүрс" бус, харин түүний "сүүдэр" эсвэл "дүрс" нөгөө ертөнцөд очих ёстой гэсэн итгэлтэй холбоотой. Амьтдыг нядалж булшинд тавих нь мөн адил: амьтны бие бус, харин түүний "сүүдэр" эзэндээ үйлчлэх ёстой хэмээн үздэг байжээ[20].

Сибирийн янз бүрийн түрэг ард түмний дунд байсан булшны эд зүйлсийг эвдэх заншлын талаар Н. А. Алексеев өгүүлэхдээ: "Ерөнхийдөө хүйс, нас, мэргэжил зэргээр ялгаатай байсан гэж болно. Эмэгтэй хүнд гэр ахуйн эд зүйлс, хүүхдүүдэд хус модоор хийсэн тоглоом, анчинд жад, дархан хүнд алх, шөвөг, алт мөнгөний дархан хүнд зэс, мөнгө хайлуулах халбага маягийн зүйл мэтийг хамт дагуулан оршуулдаг. Бүх эд зүйлсийг талийгаачид өргөхөөс өмнө эвддэг байсан хэдий ч ирээдүйд ашиглах боломжтой хэмжээнд л сэвтээдэг. Жишээлбэл, аяга савны амсрыг бага зэрэг зүсэж, жижиг ховил гаргаж, эмтэлж орхих гэх мэт. Мэдэгдэж буйгаар энэ нь дурдсан эд зүйлсийг нөгөө ертөнцөд хүрэх боломж олгодог зайлшгүй арга хэмжээ бөгөөд зөвхөн хувцас, үнэт эдлэлд л үл хамаарах зүйл байсан бололтой"[21] гэжээ.

Мөн монголын үеийн булшинд нас барсан хүнд хүрэл толь дагалдуулах тохиолдол түгээмэл байдаг. Үүнийг судлаачид "толь нь хүний ертөнцийн бүхий л зүйлсийг урвуу болгон харуулж буй нь нууцлаг бөгөөд хөлгүй нуурын тусгал зэрэгтэй харгуулан үзэхэд хязгааргүй ертөнц мэт далд шидлэг мэдрэмжийг төрүүлдэг"[22] гэж тайлбарлажээ.

Дээр өгүүлсэн сурвалжийн мэдээ, судлаачдын судалгаанаас үзэхэд дундад эртний монголчуудын нөгөө ертөнцийн тухай үзэл нь хүн үхэх нь төгсгөл бус, харин амьдралын үргэлжлэл гэж ойлгодог онцлогтой байжээ. Тэд нас барсны дараа хүн өөр ертөнцөд очиж, энэ ертөнцөд хийж байсан бүх үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн хийдэг гэж үздэг учир нас барагчид хүн, хүлэг морь, хэрэглэж байсан эд зүйлс зэргийг нь дагалдуулан тавьдаг ажээ. Ингэхдээ тухайн эд

---

[19] Noirot, P., Lentin, A.P., *Sur la première èpopèe mongole entretien avec le professeur B.Rintchen. In: Dèmocratie nouvelle: La seconde èpopèe numèro spècial,* octobre, 1965, p.10-15.

[20] Harva, U., *Die religiösen Vorstellungen der Altaischen Völker,* Helsinki., 1938, p.256.

[21] Алексеев, Н.А., *Ранние формы религии тюркоязычных народов Сибири,* Новосибирск., 1980, стр.182.

[22] Содномжамц, Д., Эрэгзэн, Г., нар *Монгол нутгаас олдсон хүрэл толины судалгаа*, УБ., 2025, х.18.

зүйлсийг амьгүй болгох буюу энэ ертөнцөөс өөр болгохын тулд ямар нэгэн байдлаар эвдэж гэмтээдэг байна. Харин хорыг амьд сэрүүн цагтаа биеийнхээ баруун хэсэгт зүүдэг атлаа нас барагчид дагалдуулахдаа биеийн зүүн талд тавьж байгаа явдал нь монголчуудын нөгөө ертөнцийг энэ ертөнцтэй урвуу хамааралтай гэж үзэх үзэлтэй холбоотойгоор энэ ертөнцөөс өөр байлгах үүднээс зориуд биеийн зүүн хэсэгт тавьдаг ажээ.

Монголын угсаатны дунд нас барсан эрэгтэй эмэгтэй хүнийг амьдадаа гэртээ байсан байрлалыг сольдог. Энэ нь гэрийн баруун талд эм, гэрийн зүүн талд эр хүнийг байрлуулдаг байна[23]. Энэхүү зан үйл нь монгол булшинд нас барагчид хор дагалдуулахдаа зориуд амьд сэрүүн цагтаа зүүж байсан талынх нь эсрэг талд нь байрлуулсан болохыг нотолж байна. Магадгүй энэ зан үйл нь хор дагалдуулах зан үйлийн уламжлал ч байж болох юм.

ДҮГНЭЛТ

Дундад эртний монголчуудын оршуулгын зан үйлд хор дагалдуулах ёс нь тухайн үеийн цэрэг дайны соёл, нийгмийн үнэлэмж, нөгөө ертөнцийн тухай үзэлтэй салшгүй холбоотой байжээ. Монголын нууц товчооны мэдээ болон археологийн судалгааны баримтаас харахад хор нь эр хүний дайчин чанар, нэр төрийн чухал бэлгэдэл байсан бөгөөд үхсэний дараа дагалдуулах нь тухайн хүнийг амьд ахуйдаа ялагдаж зэвсгээ алдаагүй, нэр төрөө хадгалсан болохыг илэрхийлдэг байна.

Археологийн малтлага судалгааны үр дүнгээр хорыг ихэвчлэн нас барагчийн биеийн зүүн талд байрлуулсан нь санамсаргүй бус, тодорхой утга агуулгатай үйлдэл юм. Судрын чуулганы номын чимэглэл зургийн дүрслэл, толь бичгийн зарим мэдээ зэргээс үзэхэд монгол цэрэг эр хороо биеийнхээ баруун талдаа зүүдэг байсан нь тодорхой мэдэгдэж байна. Гэвч нас барсан хүнд хор дагалдуулахдаа биеийн зүүн талд тавьсан явдал нь монголчуудын бэлгэдэл зүйн ёсоор зүүн зүгийг үхэл мөхлийн зүг гэж үздэгтэй нийцэж байна. Мөн монголчууд нөгөө ертөнцийг энэ ертөнцийн эсрэг тусгал гэж үздэгтэй холбоотойгоор хорыг зориуд нас барагчийн биеийн зүүн хэсэгт тавьдаг байжээ.

[23] Тангад, Д., *Монголын угсаатны зүйн судалгаа,* Боть IV, УБ., 2014, х.247.

ON THE ISSUE OF INCLUDING QUIVERS IN FUNERARY RITUAL PRACTICES

This paper examines the meaning and symbolism of including quivers in the funerary practices of medieval Mongols. Drawing upon archaeological excavations, written historical sources, and miniature paintings, the research aims to clarify the reasons for and characteristics of the practice of depositing quivers with the deceased. The findings suggest that the quiver functioned as a symbol of masculine martial identity and honor. Its inclusion in burial contexts signified that the deceased had not been defeated nor deprived of his weapons in life. Furthermore, the consistent placement of the quiver on the left side of the body appears to be associated with the belief that the other world represents an inverse reflection of the living world. The study also demonstrates that the Mongols perceived death as a continuation of life; consequently, objects used during one's lifetime were interred alongside the deceased. In this regard, the inclusion of quivers in funerary rites was not incidental, but rather constituted a practice embedded with deep symbolic meaning within Mongolian worldview and mortuary ideology.

Keywords: *Funerary ritual, Quiver, The Secret History of Mongols, Miniature Painting, Afterlife*

НОМ ЗҮЙ

Батдалай, Б., (2022), *X–XVII зууны монгол булш, оршуулгын судалгаа (Монгол Улсад малтсан хэрэглэгдэхүүнээр).* Түүхийн ухааны доктор (Ph.D)-ын зэрэг горилсон диссертаци, УБ.

Дулам, С., (2020), *Монголын бэлгэдэл зүй.* Дэд дэвтэр: Өнгийн бэлгэдэл зүй, зүг чигийн бэлгэдэл зүй, УБ.

Манж үгийн толь бичиг, Тэргүүн дэвтэр, (1960), УБ.

Марко Поло, (1987), *Орчлонгийн элдэв сонин (Аяны тэмдэглэл)*, А. Очир, Б. Дорж, С.Идшинноров нар орчуулсан, УБ.

Плано Карпини Жиованни дель, (1988), *Монголчуудын түүх,* С. Туяа, С. Цолмон нар орчуулсан, УБ.

Рубрук Гильом де, (1988), *Дорно этгээдэд зорчсон минь,* Ү. Нямдорж орчуулсан, УБ.

Содномжамц, Д., Эрэгзэн, Г., Батболд, Г., Баярсайхан, Ж., Баяндэлгэр, Ч., Нандин-Эрдэнэ, Н., (2025), *Монгол нутгаас олдсон хүрэл толины судалгаа,* УБ.

Тангад, Д., (2014), *Монголын угсаатны зүйн судалгаа,* IV боть, УБ.

Хүрэлсүх, С, (2024), *Хадны оршуулга: Монголын эртний оршуулгын өвөрмөц хэлбэр,* УБ.

Эрдэнэбат, У., (2025), *Сүнс ба нөгөө ертөнцийн тухай дундад эртний монголчуудын ойлголт, төсөөлөл,* Mongolian Journal of Anthropology, Archaeology and Ethnology, УБ.

Эрдэнэболд, Л., Эрдэнэ, Ж., Солонго, Ж., Алтан-Очир, Я., Сугар-Эрдэнэ, М., Болормаа, М., Ариунболд, Г., Гантогтох, Г., Жамъян, Г., (2024), *Талын язгуртны өв соёл IV: Оорцог уулын түүх соёлын дурсгал,* УБ.

Qorin nigetü tayilburi toli, (1979), Öbür Mongγol-un arad-un keblel-ün qoriy-a.

Гадаад хэлээрх

Алексеев, Н.А., (1980), *Ранние формы религии тюркоязычных народов Сибири*, Новосибирск.

Haenisch, E., (1948), *Die Geheime Geschichte der Mongolen,* Leipzig.

Mostaert, A., (1950), *Sur quelques passages de l'Histoire secrète des Mongols*, Harvard Journal of Asiatic Studies.

Harva, U., (1938), *Die religiösen Vorstellungen der Altaischen Völker,* Helsinki.

Noirot, P., Lentin, A.P., (1965), *Sur la première épopée mongole: entretien avec le professeur B. Rintchen,* Democratie nouvelle: La seconde épopée, numéro spécial, octobre.

Pelliot, P., (1949), *Histoire secrète des Mongols: restitution du texte mongol et traduction française,* I–VI, Paris.

Rachewiltz, I. de, (1972), *Index to the Secret History of the Mongols,* Bloomington.

Roux, J. P., (1963), *La mort chez les peuples altaïques anciens et médiévaux d'après les documents écrits,* Paris.

2026 Fasc.15

МОНГОЛ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН АНХНЫ САРЫН ТЭМДЭГ ИРЭХ НАС БОЛОН БИЕ БЯЛДРЫН ХӨГЖЛИЙН ХАНДЛАГА

Болорчулууны МӨНХЖИН
МУИС-ийн Антропологи хөтөлбөрийн IV курсийн оюутан

Удирдагч: М. Эрдэнэ
МУИС-ийн профессор (Ph.D)

Хураангуй: *Энэхүү судалгаагаар Монгол эмэгтэйчүүдийн бие бялдрын хөгжлийн акцелераци болон насанд хүрсэн үеийн антропометрийн үзүүлэлтүүд нь сарын тэмдэг анх ирэх насанд хэрхэн нөлөөлж буйг судалсан болно. Судалгаанд өсвөр насны охид (N=79) болон залуу эмэгтэйчүүдийн (N=79) хоёр бүлгийг хамруулж, 1980 оноос хойших түүхэн өгөгдөлтэй харьцуулав. Судалгааны үр дүнд Монгол эмэгтэйчүүдийн биеийн өндөр 1980 онд дунджаар 154.77 см байсан бол 2026 онд 160.89 болж өссөн нь бие бялдрын өсөлтийг харуулж байна. Мөн сарын тэмдэг ирэх дундаж нас 1958 онд Vlcek (1958) судалгаагаар дундаж нас 15 нас 10 сар байсан бол өмнөх үеийнхнээс жил ирэх тусам залуужссаар 2026 оны байдлаар 2001-2008 оны хооронд төрсөн охидын сарын тэмдэг анх ирэх дундаж нас 13.45, 2009-2015 оны хооронд төрсөн охидынх 12.29 нас болсон байна. Сарын тэмдэг анх ирэх нас нь аарцаг ясны хөгжил (bi-iliac width)-тэй сул урвуу хамааралтай байгаа нь биологийн нас бие гүйцэх хугацаа нь ясны бүтцэд тодорхой хамааралтай байна.*

***Түлхүүр үг**: бие бялдрын хөгжил, антропометр, анхны сарын тэмдэг ирэх нас, өсөлт хөгжил*

УДИРТГАЛ

Хүн судлалын шинжлэх ухаанд охидын сарын тэмдэг анх ирэх нас нь хоол тэжээлийн хангамж болон хүрээлэн буй орчны эрүүл мэндийн чухал үзүүлэлт болдог. Сүүлийн жилүүдэд дэлхий даяар амьдралын чанар дээшилсэнтэй холбоотойгоор охидын бэлгийн боловсролт эрт явагдах, биеийн хэмжээ томрох

«секуляр тренд» ажиглагдаж байна. Монгол улсын хувьд хотжилт болон хооллолтын хэв маягийн өөрчлөлт нь эдгээр биологийн үйл явцыг хурдасгаж байна. Энэхүү судалгааны зорилго нь эдгээр өөрчлөлтийг тоон үзүүлэлтээр тодорхойлж, сарын тэмдэг ирэх нас ба аарцаг болон мөрний хэмжээний хоорондын хамаарлыг харахад оршино.

Шинжлэх ухааны ойлголтоор *menarche* гэдэг нэр томьёо нь сарын тэмдэг (биеийн юм) анх ирэхийг илэрхийлдэг бөгөөд хүн биологийн зүйл амьтны хувьд нас бие гүйцэж үржилд орох нөхцөл бүрдсэнийг илтгэнэ. Сарын тэмдэг анх харилцан адилгүй насанд эхэлдгийг эрдэмтэд тухайн нийгэм эдийн засгийн хөгжлийн төлөв байдал, байгаль, газарзүйн байршил, тухайн үндэстний ёс заншил, удамшил, сэтгэл зүйн байдал, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдал, хоол хүнс гэх мэт олон хүчин зүйлээс шалтгаалдаг болохыг тогтоосон бөгөөд хамгийн тэргүүлэх хүчин зүйл бол нийгэм-эдийн засгийн нөхцөл байдал (тухайн эмэгтэйн амьдарч буй амьдралын түвшин, гэр бүлийн боловсролын түвшин, зарим тохиолдолд тухайн гэр бүлийн хүүхдийн тоо, хот ба хөдөө амьдардаг гэх мэт) байгаль, газар зүйн байршил нөлөөлдөг байна[1]. Сарын тэмдэг анх ирэх нас удамших нөлөөг судалгаа байгаа хэдий ч эрдэмтдийн дунд маргаантай сэдэв хэвээр байна. Тухайлбал, И. Ковальскагийн 1963 онд ахлан хийсэн сарын тэмдэг анх ирэх нас хоорондоо тодорхой холбоогүйг нотолсон бол, Ковалвска 1966 онд өөрийн бие даасан судалгаагаар холбоотой хэмээн дүгнэжээ.

Сүүлийн жилүүдэд охидын биений юм ирэх насны хувьсал нь дэлхий даяар ажиглагдаж байна. Энэхүү хувьсал нь биологийн, байгаль орчны, нийгэм-эдийн засгийн олон хүчин зүйлсийн нөлөөгөөр тодорхойлогддог. Жишээлбэл, илүүдэл жин, таргалалттай охидын биений юм эрт мэдэрдэг болохыг олон судалгаагаар тогтоожээ. Мөн хоол тэжээл, амьдралын хэв маяг, стресс зэрэг хүчин зүйлс ч биений юм ирэх насанд насанд нөлөөлдөг[2]. Монгол охидын хувьд менархийн насны тухай судалгааг 1958 оноос хийж эхэлсэн байдаг ба хамгийн сүүлийн нэгдсэн датасан бүхий судалгааг 2009 онд хийсэн байна. Тус судалгаанд оролцогчид 1990 оноос өмнө төрж өссөн хүмүүс байсан ба монголын чөлөөт эдийн засгийн шилжилтийн үеийн болон түүний дараа төрж өссөн охидын менархийн насны судалгаа хомс байна.

---

[1] Cyrus Cooper et al., *Childhood Growth and Age at Menarche,* BJOG an International Journal of Obstetrics & Gynaecology 103, no. 8 (August 1, 1996), p.814-817, https://doi.org/10.1111/j.1471-0528.1996.tb09879.

[2] Shakib Ghassemieh, *Miniaturized Power Processing Unit Study: A Cubesat Electric Propulsion Technology Enabler Project,* NASA Technical Reports Server (NASA) 25, no. 1–2 (May 1, 2014). p.57–62, https://doi.org/10.1515/jpem-2011-0277.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Судалгааны ажлыг хоёр бүлэг эмэгтэйчүүдээс асуумж, антропометрийн хэмжилт хийх замаар тоон өгөгдлүүдийг цуглуулсан. Тус цуглуулсан бүлэг эмэгтэйчүүдийн өгөгдлүүдийг түүхэн цаг хугацааны динамик өөрчлөлттэй харьцуулан дүгнэхийн тулд Ж. Намсарайнайдан (1990), Л. Нямдорж (1994), Ш. Гүндэгмаа (2009) нарын өмнөх судалгааны үр дүнгүүдийг харьцуулсан хэрэглэгдэхүүн болгон ашиглаж хүн амын бие бялдрын хөгжлийн хандлагыг тодорхойлов.

- **А бүлэг (Өсвөр насныхан):** N=79 охид (2009–2015 оны хооронд төрсөн охид). Одоогийн жин болон сарын тэмдэг ирсэн насны мэдээлэл.
- **Б бүлэг (Насанд хүрэгчид):** N=79 эмэгтэйчүүд (1980–2008 оны хооронд төрсөн охид). Аарцагны өргөн (bi-iliac), ташааны өргөн (bi-spinal), мөрний өргөн болон цээжний бүслүүрийн нарийвчилсан хэмжилтүүд.
- **Харьцуулсан өгөгдөл:** Ж. Намсарайнайдан (1990), Л. Нямдорж (1994), Ш. Гүндэгмаа (2009) нарын судалгааны үр дүнг түүхэн хандлагыг харахад ашигласан.

Антропометрийн биеийн хэмжилтийн судалгааг Martin-ний арга зүйгээр Швецарийн GPM багажаар хийж гүйцэтгэсэн ба нийт антропометрийн 7 хэмжилтийг хийж гүйцэтгэв.

Монгол эмэгтэйчүүдийн бие бялдарын өсөлт хөгжил, антропометрийн хэмжилтүүд

Хүснэгт 1. Насанд хүрсэн эмэгтэйчүүдийн бие бялдарын үзүүлэлтүүд

Эмэгтэйчүүдийн хэмжээ						
Хэмжилтийн нэр	N	X	SD	SE	Min	Max
Өндөр	79	160.8	5.4	0.6	150.8	177.6
Жин	79	58.86	8.96	1.01	45	96.9
Цээжний бүслүүр	79	87.99	7.9	0.7	73.9	111.3
Мөрний өргөн	79	33.9	2.6	0.2	24.6	39.6
Цээжний хөндлөн голч	79	24	2.5	0.2	18.4	32.4
Цээжний тууш голч	79	16.27	2.1	2.4	12.5	21.8
Аарцгийн өргөн (Bi-illiac)	79	26.46	2.9	0.2	20.2	30.5

Судалгаанд нийт N=79 эмэгтэй хамрагдсан байна. Дундаж өндөр 160.8 см ± 5.4 ба хамгийн намхан нь 150.8 см, хамгийн өндөр нь 177.6 см байна. Стандарт хазайлт бага байгаа нь эмэгтэйчүүдийн өндөр хоорондоо их ялгаагүй, нэгэн төрлийн бүтэцтэй байгааг харуулж байна. Дундаж жин 58.86 кг ± 8.96 ба хамгийн бага жин 45 кг, хамгийн их нь 96.9 кг байгаа нь жингийн хэлбэлзэл өндөртэй харьцуулахад их байна. Цээжний тойргийн хувьд дундаж нь 87.99 см

± 7.9 байна. Цээжний хөндлөн голч 24 см ± 2.5 болон тууш голч 16.27 см ± 2.1 байна. Эмэгтэйчүүдийн цээжний хөндий эрэгтэйчүүдийнхээс жижиг боловч хэлбэрийн хувьд ижил зууван бүтэцтэй байна. Мөрний өргөний дундаж нь 33.9 см ± 2.6 байгаа нь биеийн ерөнхий бүтцийн хувьд эмэгтэй хүний бие бялдрын онцлогийг (нарийн мөр) тодорхойлж байна. Эмэгтэйчүүдийн аарцгийн дундаж өргөн 26.46 см ± 2.9 байна. Эмэгтэйчүүдийн түүвэр бүлэг нь биеийн өндөр болон мөрний өргөнөөрөө жигд тархалттай байна ба жин болон цээжний бүслүүрийн хэмжээнд хувь хүний ялгаатай байдал илүү ажиглагдаж байна. Аарцгийн өргөний үзүүлэлт нь эмэгтэйчүүдийн биеийн бусад хэмжээтэй харьцуулахад хамгийн өргөн (пропорциональ утгаар) бүтэцтэй ажиглагдаж байна.

Эрин зууны хандлага болон биеийн өсөлт хөгжлийн харьцуулалт

Тус эмэгтэйчүүдийн бүлгийн өгөгдлүүдийг жин, өндөр, цээжний бүслүүрүүдийн хэмжилтүүдийг Ж. Намсарайнайдан (1990)[3], Л. Нямдорж (1994)[4], Ш. Гүндэгмаа (2009)[5] нарын өмнөх судалгааны үр дүнгүүдийг харьцуулав. Энэхүү судалгаанд Монголын эмэгтэйчүүдийн биеийн өндөр, жин, цээжний тойргийн хэмжилтийн дүнг дөрвөн өөр цаг үеийн мэдээллийн эх сурвалжтай харьцуулан шинжилсэн. Нийт дөрвөн багц өгөгдөл ашиглагдсан бөгөөд тэдгээрт Ж. Намсрайнайдан (1990, n=2046), Л. Нямдорж (1994, n=359), Ш. Гүндэгмаа (2009, n=924), мөн 2026 оны одоогийн судалгаа (n=79) багтаж байна. Нийт хэмжээ N=3408 боллоо.

Хүснэгт 2. Эмэгтэйчүүдийн атропометрийн үндсэн хэмжилтүүд

Хэмжилтийн нэр	Өгөгдлийн сан	Түүвэр (N)	Дундаж (Mean)	Хазайлт (SD)	Алдаа (SE)
Өндөр (cm)	Ж. Намсрайнайдан (1990)	2046	154.77	5.57	0.13
	Л. Нямдорж (1994)	459	152.76	4.82	0.25
	Ш. Гүндэгмаа (2009)	924	158.09	5.2	0.17
	Одоогийн (2026)	79	160.89	5.45	0.61
Жин (kg)	Ж. Намсрайнайдан (1990)	2046	56.09	8.49	0.2
	Л. Нямдорж (1994)	459	56.51	8.89	0.41
	Ш. Гүндэгмаа (2009)	924	56.4	7.4	0.24
	Одоогийн (2026)	79	58.86	8.96	1.01

[3] Намсрайнайдан, Л., *Хөдөөгийн насанд хүрэгчдийн антропометрийн судалгаа*, Биологийн хүрээлэн, Антропологийн сектор, эрдэм шинжилгээний ажлын тайлан, УБ., 1990, х.138.

[4] Нямдорж, Я., *Морфофизиологическая характеристика коренного населения*, Академия наук Монголии, Институт общей и экспериментальной биологии, Национальный центр антропологии, УБ., 1994, х.29.

[5] Гүндэгмаа, Л., *Морфофункцинальнэные особенности студенческой молодежи монголий в зависимости от генетичких и средовых фарторов.* Российский Государственный университет физической культуры, Спорта и Туризма, 2009, х.Таблица1.

Цээжний бүслүүр	Ж. Намсрайнайдан (1990)	2046	87.78	7.48	0.18
	Л. Нямдорж (1994)	459	85.88	6.9	0.36
	Ш. Гүндэгмаа (2009)	924	84.2	5.1	0.17
	Одоогийн (2026)	79	88	7.09	0.8
Мөрний өргөн (cm)	Ж. Намсрайнайдан (1990)	459	34.51	1.62	0.08
	Л. Нямдорж (1994)	924	35.8	1.7	0.06
	Ш. Гүндэгмаа (2009)	79	33.91	2.6	0.29
Аарцгийн өргөн	Л. Нямдорж (1994)	459	27.85	1.58	0.07
	Ш. Гүндэгмаа (2009)	924	26	2.5	0.08
	Одоогийн (2026)	79	26.47	2.09	0.24
Цээжний хөндлөн	Л. Нямдорж (1994)	459	24.16	1.72	0.08
	Ш. Гүндэгмаа (2009)	924	25.1	1.7	0.06
	Одоогийн (2026)	79	24.04	2.52	0.28
Цээжний тууш	Л. Нямдорж (1994)	459	17.24	1.6	0.07
	Ш. Гүндэгмаа (2009)	924	17.8	1.5	0.05
	Одоогийн (2026)	79	16.28	2.14	0.24

Хүснэгт. 3 Эмэгтэйчүүдийн үндсэн хэмжилтүүдийг оноор харьцуулсан хүснэгт

Хэмжүүр	F утга	df (хооронд/дотор)	p утга	Дүгнэлт
Биеийн өндөр (см)	143.76	3 / 3404	< 0.001	***
Биеийн жин (кг)	5.01	3 / 3404	0.002	**
Цээжний тойрог (см)	33.67	3 / 3404	< 0.001	***

Зураг.1 Эмэгтэйчүүдийн антропометрийн үзүүлэлтүүдийн цаг хугацааны өөрчлөлт



Гурван хэмжүүр бүгдэд нэг хүчин зүйлийн ANOVA-ийн үр дүн статистикийн хувьд мэдэгдэхүйц ялгааг харуулсан ($p < 0.05$). Энэ нь дор хаяж нэг багц өгөгдлийн дундаж нь бусдаасаа ялгаатай болохыг нотолж байна.

Биеийн өндөр: 2026 оны дундаж өндөр 160.89 см бөгөөд бүх өмнөх үеийн мэдээллээс статистикийн хувьд мэдэгдэхүйц өндөр байна. Хамгийн их зөрүү нь Нямдорж (1994)-ийн мэдээлэлтэй харьцуулахад +8.13 см байв. Биеийн өндөр 1990–2026 оны хооронд тогтмол өсөж, 30 орчим жилд нийт ~8 см нэмэгдсэн нь харагдаж байна.

Биеийн жин (кг): 2026 оны дундаж жин 58.86 кг байгаа нь өмнөх гурван мэдээллийн эх сурвалжаас (56.09–56.51 кг) мэдэгдэхүйц их байна. Гэхдээ биеийн жингийн ANOVA-ийн F утга (5.01) харьцангуй бага байсан нь 1990–2009 оны дундаж жингүүд маш ойр байсантай (зөрүү ≤0.42 кг) холбоотой. Мөн үүнд 2009 оны судлаач Гүндэгмаагын хэмжилтийн өгөгдөл нь спортоор хичээллэдэг, тамирчдаас цуглуулсан тул ийнхүү нөлөөлсөн байж болох юм.

Цээжний бүслүүр: Цээжний тойргийн хувьд шугаман бус хандлага ажиглагдав: 1990 (87.78 см) → 1994 (85.88 см) → 2009 (84.20 см) буурсны дараа 2026 онд 88.00 см болж дахин өссөн. 2026 оны үзүүлэлт 1990 оны дундажтай бараг тэнцүү байгаа ч 2009 оноосоо мэдэгдэхүйц өндөр ($p < 0.001$) байна.


Биеийн жин болон цээжний тойргийн хувьд 2026 оны дээжийн стандарт хазайлт өмнөх үеийн мэдээллүүдээс мэдэгдэхүйц их байгаа нь F-тестээр батлагдав ($p < 0.05$). Биеийн өндрийн дисперс харьцангуй тогтвортой хэвээр байна (SD ≈ 4.82–5.57 см). Монголын эмэгтэйчүүдийн биеийн хэмжилтийн гурван үзүүлэлт бүгдэд 1990–2026 оны хооронд статистикийн хувьд мэдэгдэхүйц өөрчлөлт гарсан байна (ANOVA: $p < 0.05$). Биеийн өндөр хамгийн тогтмол, хамгийн их өсөлт үзүүлсэн бол биеийн жин нь 2026 онд илүү тод ялгараад байна.

Энэхүү шинжилгээнд Монгол эмэгтэйчүүдийн биеийн дөрвөн хэмжээсийг мөрний өргөн, бүсэлхийн өргөн (bi-iliac), цээжний өргөн, цээжний гүн гэсэн гурван өгөгдлийн санд харьцуулан судалсан болно: Нямдорж (1994, n=459), Гүндэгмаа (2009, n=924), Одоогийн судалгаа (2026, n=79). Нийт түүвэр: N=1,462.

Хүснэгт 4. Эмэгтэйчүүдийн бусад хэмжилтүүдийг оноор харьцуулсан хүснэгт

Хэмжилт	1994 дундаж	2009 дундаж	2026 дундаж	F утга	p утга	Дүгнэлт
Мөрний өргөн	34.51	35.8	33.91	72.08	$p < 0.001$	***
Аарцгийн зай	27.85	26	26.47	94.31	$p < 0.001$	***
Цээжний хөдлөн голч	24.16	25.1	24.04	27.96	$p < 0.001$	***
Цээжний тууш голч	17.24	17.8	16.28	37.44	$p < 0.001$	***

Зураг 2. Эмэгтэйчүүдийн антропометрийн бусад үзүүлэлтүүдийн цаг хугацааны өөрчлөлт



Аарцгийн хоорондох зай (bi-iliac): 2026 оны эмэгтэйчүүдийн аарцгийн хоорондох зай 1994 оны мэдээлэлтэй харьцуулахад дунджаар 1.38 см нарийссан байна. Хамгийн өндөр F-утга (94.31) бүхий энэ хэмжээст Гүндэгмаа (2009) болон Нямдорж (1994) судалгааны хооронд хамгийн тод ялгаа (−1.85 см) ажиглагдлаа. Энэ нь биеийн бүтцийн хувьд мэдэгдэхүйц өөрчлөлт бөгөөд суугаа амьдралын хэв маяг зонхилж, хоол тэжээлийн өөрчлөлт зэрэг хүчин зүйлтэй холбоотой байж болзошгүй.

Цээжний тууш голч: 2026 оны эмэгтэйчүүдийн цээжний хэмжээ 1994 оноос дунджаар 0.96 см багассан байна ($t=3.84$, $p<0.001$). Цээжний тууш голчийн хэмжээ буурсан нь биеийн ерөнхий хэлбэр нарийссантай нийцэж байгаа бөгөөд аарцгийн өргөн буурсантай мөн адил биеийн хэлбэр нарийссаныг илтгэж байна.

Мөрний өргөн: 1994–2009 онд дундаж утга 34.51 см-ээс 35.80 см болж нэмэгдсэн боловч 2026 оны судалгаанд 33.91 см болж буурсан байна.

Цээжний хэмжээсүүд: Цээжний өргөн болон гүн хоёулаа 2026 оны дундаж нь хоёр өмнөх судалгааныхаас бага утгатай байна; ялангуяа цээжний гүн 16.28 см болж хамгийн бага дундажтай гарчээ.

Дээрх шинжилгээний үр дүнгээс харахад, аарцгийн өргөн, цээжний тууш голч, мөрний өргөн нь 1994–2026 оны хооронд статистикийн хувьд мэдэгдэхүйц буурсан байна. Хамгийн их, ач холбогдолтой өөрчлөлт аарцгийн өргөн хоорондох зайд (−1.38 см, $p<0.001$) илэрсэн нь биеийн ерөнхий бүтэц нарийсах


хандлагатай болж байгааг харж болохоор байна. Эдгээр хэмжилтүүдээс тогтвортой хэвээр үлдсэн хэмжүүр нь цээжний хөндлөн голч байна.

Эмэгтэйчүүдийн биеийн хэмжилтийн харьцааны статистик дүгнэлт

Хүснэгт 5. Эмэгтэйчүүдийн биеийн харьцаанууд оноор

Харьцаа	1994	2009	2026	Чиглэл
Мөр / өндөр	22.6	—	21.08	↓ Буурсан
Аарцаг / өндөр	18.18	—	16.46	↓ Буурсан
Цээжний итгэвэр	14.33	14.18	14.87	↑ Өссөн
Жин / өндөр (кг/м)		22.6	23.63	≈ Тогтвортой
Мөр / аарцаг	80.77	—	128.7	↑ Өссөн

Зураг 3. Эмэгтэйчүүдийн биеийн харьцааны өөрчлөлт





Мөр/Аарцгийн харьцаа: Энэ нь хамгийн их өөрчлөлттэй үзүүлэлт бөгөөд 1994 онд 80.77 байсан бол 2026 онд 128.7 болж өсжээ. Энэ нь орчин үеийн бүлгийн хувьд аарцгийн өргөнтэй харьцуулахад мөрний өргөн илүү давамгайлах болсныг харуулж байна.

Жин/Өндөр: 2009 онд (22.6) 2026 онд (23.63) болж бага зэрэг өссөн хэдий ч, эмэгтэйчүүдийн БЖИ нь эрүүл хэмжээнд хадгалагдаж байна.

Хамгийн их өөрчлөлт мөр/аарцгийн харьцаан дээр ажиглагдаж байна. Энэ нь хүн амын биеийн хэлбэр төрхөд тодорхой хувьсал (аарцаг нарийсаж, мөр өргөсөх хандлага) явагдаж байгааг харуулж байж болох юм. Харин биеийн жингийн ерөнхий үзүүлэлт 1990-ээд оны түвшиндээ хадгалагдан үлджээ.

Цээжний итгэвэр: 2026 онд энэхүү үзүүлэлт бага зэрэг өссөн (14.87) нь цээжний хэлбэр өмнөх үеийнхээс ялимгүй томорсон болохыг илтгэж байна.

1994, 2009 болон 2026 онуудын хэмжилтийг харьцуулахад монгол эмэгтэйчүүдийн биеийн пропорц цаг хугацааны өөрчлөгдсөн байна. Гэсэн хэдий ч, дээрх 5 үзүүлэлтээр хийсэн ANOVA шинжилгээгээр онуудын хоорондох ялгаа статистик ач холбогдолгүй ($p > 0.05$) гарсан ба 1994 оноос биеийн харьцаанд өөрчлөлт явагдаж байгаа хэдий ч энэ өөрчлөлт нь статистик ач холбогдолгүй болно.

Анхны биеийн юм ирэх насны өөрлөлт болон бие бялдарын хөгжил


Монгол охидод болон дэлхийн зарим улс орны хүн амд эмэгтэйчүүдийн биеийн юм анх ирэх үеийн насыг өмнө нь Монголын болон гадаадын эрдэмтэд судалж байсан. Vlcek-ийн 1958 онд монгол охидын дунд явуулсан судалгаагаар охидын сарын тэмдэг анх ирэх дундаж насыг 15 нас 10 сар (Цит. Г. Грим. 1967) гэж тодорхойлжээ. Х. Лхагважавын (1972) Улаанбаатар хотод амьдардаг охидын дунд явуулсан судалгаагаар охидын сарын тэмдэг анх ирэх нас дунджаар 14 нас 1 сартайд ирдэг гэсэн үр дүн гарчээ. 1958-1961 онд явуулсан Ч. Чүлтэмдорж (1962, 1967) явуулсан судалгаагаар 14 насанд биеийн юм ирсэн охид нийт судалгаанд оролцсон охидын 45.3% эзэлж байсан бол 1981 онд Д.Батчулуун (1981) судалгаагаар 14 насанд сарын тэмдэг ирсэн охид 96% болж өссөнийг судлаач тэмдэглээд сүүлийн 50 жилд охидын сарын тэмдэг ирэх нас бараг 2 жилээр урагшилсан гэж дүгнэжээ.

П. Цэндсүрэнгийн (1977) Улаанбаатар хотын охидын дунд хийсэн судалгаагаар анхны сарын тэмдэг охидод дунджаар 13.48±1.02 насанд, Монголын говийн бүсийн нутагт амьдардаг охидод дунджаар 13.52±1.09, хангайн уулархаг нутагт амьдардаг охидод 13.64±1.04 насанд тус тус ирдэг гэж тодорхойлжээ. Улаанбаатар хот болон 6 аймгийн төвд амьдардаг 2804 өсвөр насны охидыг (нийгмийн байдлаар өөр өөр) хамруулан судалсан Ж.Дэмбэрэлсүрэн нарын судалгаагаар анхны сарын тэмдэг ирэх үеийн дундаж насыг 12.8 гэж тодорхойлжээ. Ш. Уранчимэг (1990) судалгаагаар охидын анхны сарын тэмдэг хот, хөдөөгийн охидод харилцан адилгүй насанд үзэгддэг гээд анхны сарын тэмдэг хотод амьдардаг охидод 13.2 насанд, аймгийн төвийн охидод 13.3 насанд, суманд амьдардаг охидод 14.0-14.6 насанд ирж байна гэж дүгнэжээ[6] 2025 онд 11–45 насны 112 эмэгтэйг хамруулсан судалгаагаар анхны сарын тэмдэг ирэх нас 12.4 болж залуужсан байна[7].


[6] Ганболд, С., *Монголын хүн ам дахь генетик процессийн онцлог*, Монгол улсын гэгээрлийн яам анагаах ухааны их сургууль хүн судлалын үндэсний төв, Биологийн ухааны боловсролын докторын зэрэг горилсон диссертаци., УБ., 1999, х.15.

[7] Мөнхжин, Б., *Монгол охидын сарын тэмдэг анх ирэх нас менархи ба түүнд нөлөөлөх хүчин зүйл*, Антоон Мостаэрт Монгол судлалын төв, Эрдмийн хэлхээ ЭШБ, Боть XIV, УБ., 2025, х.209.

Зураг 4. Анх сарын тэмдэг ирэх дундаж насны өөрчлөлт



Зураг 5. Монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүний өөрчлөлт[8]



Энэхүү график нь сүүлийн 46 жилийн хугацаанд Монгол эмэгтэйчүүдийн дундаж өндөр хэрхэн нэмэгдэж ирснийг харуулж байна. 1980 онд дундаж өндөр


[8] "Төрийн нэгдсэн өгөгдлийн сан," Төрийн нэгдсэн өгөгдлийн сан, УБ., 2026, https://data.nso.mn/.

154.77 см байсан бол 2026 он гэхэд 160.89 см болж, нийт 6.12 см-ээр өссөн нь илэрхий харагдаж байна.Биеийн өндөр 40 жилийн дотор 154 см-ээс 160 см болж өссөн нь Монголын нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, хоол тэжээлийн хүртээмж сайжирсны илрэл байж болох юм. Сарын тэмдэг ирэх нас залуужиж байгаа нь хүн амын биологийн хэмнэл хурдасч буйг харуулж байна.

Биеийн өндөр нэмэгдэж байгаа боловч биеийн хөндлөн хэмжээсүүд болох мөрний өргөн болон аарцагны (bi-iliac) өргөн ялимгүй нарийсах хандлага ажиглагдлаа. Тухайлбал, 1994 оны Нямдоржийн судалгаагаар аарцагны өргөн хамгийн өндөр буюу 27.85 см орчим байсан бол 2026 онд энэ үзүүлэлт буурч 26.47 см орчим болсон байна. Мөрний өргөн мөн 2009 оны Гүндэгмаагийн судалгаанаас бага зэрэг буурсан үзүүлэлттэй байгаа нь орчин үеийн монгол эмэгтэйчүүдийн биеийн харьцаа илүү «нарийхан, туранхай» төрх рүү дөхөж буйг харуулж байна.

Насанд хүрсэн эмэгтэйчүүдийн (N=59) өгөгдөл дээр хийсэн корреляцийн шинжилгээ:

Зураг 6. Насанд хүрсэн эмэгтэйчүүдийн аарцгийн өргөн болон сарын тэмдэг анх ирсэн нас хоорондын хамаарал



Сарын тэмдэг ирэх нас болон аарцагны өргөн хооронд урвуу хамаарал (r = -0.22) ажиглагдлаа. Энэ нь насанд хүрсэн үеийн аарцагны ясны хэмжээ их байх тусам сарын тэмдэг эрт ирэх хандлагатайг харуулж байна.

Хэмжилт	Дундаж (мм)	Сарын тэмдэг ирэх настай хамаарах коэффициент (r)
Биеийн өндөр	1608.9	+0.12
Аарцагны өргөн (Bi-Iliac)	264.7	-0.22
Мөрний өргөн	345.6	-0.18

ДҮГНЭЛТ

Энэхүү судалгаагаар Монгол эмэгтэйчүүдийн бие бялдрын хөгжлийн түүхэн өөрчлөлт (секуляр тренд) болон биологийн нас бие гүйцэх үйл явцын харилцан хамаарлыг антропометрийн тоон өгөгдөл болон урт хугацааны харьцуулсан шинжилгээнд тулгуурлан амжилттай тодорхойллоо. Судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэвэл, Монгол эмэгтэйчүүдийн бие бялдрын хөгжилд сүүлийн 30 гаруй жилийн хугацаанд статистик ач холбогдлын өндөр түвшинд ($p < 0.05$) өсөлтийн хурд буюу акцелерацийн үзэгдэл тогтвортой явагдаж, дундаж өндөр 160.89 см-т хүрсэн байна. Гэвч биеийн тууш өсөлтийг дагаж хөндлөн хэмжээсүүд тэлээгүй бөгөөд аарцагны өргөн (27.85-аас 26.47 см) болон мөрний өргөн эрс буурч, Мөр/Аарцгийн харьцаа (80.77-аас 128.7) огцом өссөн нь Монгол эмэгтэйчүүдийн биеийн ерөнхий харьцаа уламжлалт чийрэг, өргөн хэв шинжээс илүү өндөр, нарийхан хэв шинжтэй ажиглагдаж байна. Үүний зэрэгцээ өсвөр насны охидын анхны сарын тэмдэг ирэх дундаж нас (менархи) түүхэн хугацаанд тасралтгүй залуужсаар 12.29 нас болж эрс буурсан нь хотжилт, суурин амьдралын хэв маяг болон хоол тэжээлийн бүтэц өөрчлөгдсөнтэй холбоотойгоор охидын дааврын идэвхжил болон бэлгийн шилжилтийн үе эрт урагшилсны илрэл юм. Пирсоны корреляцийн шинжилгээгээр сарын тэмдэг анх ирэх нас нь насанд хүрсэн үеийн аарцагны ясны өргөнтэй сул урвуу хамааралтай ($r = -0.22$) гарлаа. Цаашид охидын менархийн нас ийнхүү залуужиж, аарцагны яс нарийсах хандлагатай болсон нь ирээдүйд нөхөн үржихүйн эрүүл мэнд, эх барихын практикт (төрөх замын хүндрэл) хэрхэн нөлөөлөхийг илүү өргөн түүврээр гүнзгийрүүлэн судлах бодлогын болон онолын бодит шаардлага тулгарч байна.

SECULAR TRENDS IN AGE AT MENARCHE AND PHYSICAL DEVELOPMENT AMONG MONGOLIAN WOMEN

This study investigated how acceleration in physical development and adult anthropometric characteristics among Mongolian women are associated with the age at menarche. The research included two groups: adolescent girls (N=79) and young women (N=79), and compared the findings with historical data collected since 1980. The results showed a clear secular increase in body height among Mongolian women, with the average height rising from 154.77 cm in 1980 to 160.89 cm in 2026, indicating significant physical growth acceleration. In addition, the average age at menarche has progressively decreased over time. According to the study by Vlcek, the mean age at menarche in 1958 was 15 years and 10 months, whereas by 2026 the average age at menarche had declined to 13.45 years among girls born between 2001–2008 and to 12.29 years among those born between 2009–2015. The findings

also demonstrated a weak inverse correlation between age at menarche and pelvic development (bi-iliac width), suggesting that the timing of biological maturation is related to skeletal structure development.

***Keywords**: Physical development, anthropometry, age at menarche, growth and development*

НОМ ЗҮЙ

Монгол хэлээрх материалууд:

Ганболд, С., *Монголын хүн ам дахь генетик процессийн онцлог,* Монгол улсын гэгээрлийн яам анагаах ухааны их сургууль хүн судлалын үндэсний төв, Биологийн ухааны боловсролын докторын зэрэг горилсон диссертаци., УБ., 1999.

Мөнхжин. Б., *Монгол охидын сарын тэмдэг анх ирэх нас менархи ба түүнд нөлөөлөх хүчин зүйл,* Антоон Мостаэрт Монгол судлалын төв, УБ., 2025.

Гадаад хэлээрх материалууд:

Гүндэгмаа, Л., *Морфофункциональнэные особенности студенческой молодежи монголий в зависимости от генетичких и средовых факторов.* Российский Государственный университет физической культуры, Спорта и Туризма, 2009.

Намсрайнайдан, Л., *Хөдөөгийн насанд хүрэгчдийн антропометрийн судалгаа,* Биологийн хүрээлэн, Антропологийн сектор, эрдэм шинжилгээний ажлын тайлан, УБ., 1990.

Нямдорж, Я., *Морфофизиологическая характеристика коренного населения,* Улаанбаатар: Академия наук Монголии, Институт общей и экспериментальной биологии, Национальный центр антропологии, 1994.

Cyrus Cooper et al., *Childhood Growth and Age at Menarche,* BJOG an International Journal of Obstetrics & Gynaecology 103, no. 8 (August 1, 1996): https://doi.org/10.1111/j.1471-0528.1996.tb09879.

Shakib Ghassemieh, *Miniaturized Power Processing Unit Study: A Cubesat Electric Propulsion Technology Enabler Project,* NASA Technical Reports Server (NASA) 25, no. 1–2 (May 1, 2014): https://doi.org/10.1515/jpem-2011-0277.

2026 Fasc.16

МОНГОЛЫН ЭРТНИЙ НҮҮДЭЛЧДИЙН ЯСАН ДЭЭРХ ГЭМТЭЛ БЭРТЛИЙН СУДАЛГАА (АХУЙН ГЭМТЛИЙН ЖИШЭЭГЭЭР)

Эрдэнэ-Очирын **ӨСӨХБАЯР**
МУИС-ийн Археологи хөтөлбөрийн IV курсийн оюутан

Удирдагч М. Эрдэнэ
МУИС-ийн профессор (Ph.D)

Хураангуй: *Энэхүү судалгаагаар нүүдлийн соёлтой, мал аж ахуй эрхэлдэг хүн амын дунд аль хэсгийн ясны хугарал түлхүү тохиолдож байгааг тодруулсан ба үр дүнд дээд мөчдийн яснуудын хугарал хамгийн өндөр хувийг эзэлж байсан нь тэдний адуу уналга, түүний хэрэглээний явцад үүссэн байх боломжтойг судаллаа. Бид тус судалгаагаар өнөөгийн Монгол улсын газар нутгаас илэрсэн 80 хүний олдвор дээр палео-антропологийн арга зүйн дагуу судалгаа гүйцэтгэсэн бөгөөд гарсан гэмтлийн түгээмэл шинжийг орчин үеийн хүн амд адуутай холбоотой үүссэн гэмтлүүдтэй харьцуулахад нийцэж байв. Эрэгтэйчүүдэд гэмтэл илрэх хувь илүү байсан нь хөдөлмөрийн үүрэг, нийгмийн зохион байгуулалтын ялгааг харуулж байгаа төдийгүй олдворын гэмтэл бэртлийн шинж нь түүхэн сурвалж, археологийн олдвор хэрэглэгдэхүүнүүдээр мөн батлагдаж байна. Нүүдэлчдийн нийгэмд адуу төвтэй аж ахуй давамгай байсныг хүний ясны олдвор дээр ч мөн судлах боломжтойг харууллаа. Цаашид илүү өргөн хүрээнд, олон хэрэглэгдэхүүн дээр тулгуурласан судалгаа хийх шаардлагатайг онцлов.*

***Түлхүүр үг**: Ахуйн гэмтэл, адуу ба түүний уналга, хугарал, хүний яс, био-археологи, палеопаталоги*

УДИРТГАЛ

Эрт үеийн түүхийн дурсгалт эд өлгийн зүйлсийг археологи гэх шинжлэх ухаан судалдаг бөгөөд археологийн судалгаагаар дамжуулан хүн төрөлхтний өнгөрсөн үеийн аж байдал, нийгмийн хөгжил, соёл боловсролын түвшин, ертөнцийг үзэх үзэл төсөөллийг хүртэл сэргээн тодруулах боломжтой[1]. Археологийн малтлага судалгааны ажлын үеэр олон төрлийн олдвор

хэрэглэгдэхүүн илэрдэг ба тэдгээрийн нэг нь яахын аргагүй эртний хүний ясны олдвор билээ. Эртний хүний ясны олдвор нь өөртөө маш олон төрлийн мэдээллийг агуулдаг бөгөөд тухайн хүний амьд байх үеийн талаарх тодорхой ойлголтыг авч болдог[1]. Эдгээрт: амьд байх үеийн өндөр, нас, хүйс, өвчлөл, шим тэжээлийн дутагдалд нэрвэгдэж байсан эсэх, хэдэн настайдаа эхийн сүүнээс гарч байсан[2] гэх зэргээр зогсохгүй гэмтэл бэртлийн ангиллын арга зүйгээр аж ахуй, нийгмийн байдал зэргийг тодруулах боломжтой[3].

Тус судалгаанд эртний хүн судлалын нэг болох траума (гэмтэл бэртлийн) ангиллын арга зүйн дагуу ахуйн гэмтлүүдийг ажиглалтын аргаар судлан тодорхойлох ба ингэснээр тодорхой нэгэн хүн амд түгээмэл тохиолдож байгаа ясны гэмтэл, бэртлээр тэдний эрхэлж байсан аж ахуйг нь тодорхойлох боломжтой гэж үзлээ. Олон улсад хийгдсэн судалгаагаар газар тариалан, ан агнуурын аж ахуй эрхэлдэг суурьшмал соёлтой хүн амд гар хөлийн яс болон урт мөчдийн яснууд түлхүү гэмтэж байгааг тодорхойлсон байдаг. Харин адуу амьдралынх нь нэг хэсэг болсон нүүдэлчин соёлтой Монголын эртний хүн амын дунд ямар яс түгээмэл гэмтэж байгааг тодруулан тухайн ахуйн гэмтлүүд нь адуу болон түүний уналгын үр дүнд үүссэн гэмтэл байх боломжтой эсэх талаар судлахыг зорилоо.

Matthew R. Fuka нар (2018) Монголын эртний нүүдэлчдийн ясны олдворын судалгаанд тулгуурлан нүүдэлчин аж ахуйн онцлог, түүний ялгааг тодруулах оролдлого хийсэн ба судалгаандаа булчингийн маркерын шинжийг ашиглажээ. Булчингийн маркерийг ашиглан эртний хүн амын аж ахуйг тодруулах аргыг эртний хүн судлалын зарим эрдэмтэд эрс үгүйсгэдэг бөгөөд “Хүн амын бүлгүүдийн энтезийн ялгаа нь зөвхөн хөдөлмөрийн үйл ажиллагаанаас шалтгаалахгүй бөгөөд биологийн онцлог, хүрээлэн буй орчны нөхцөл зэрэг олон хүчин зүйлс илүү давамгайлан нөлөөлдөг. Иймээс энтезийн өөрчлөлтийг шууд биеийн хүчний ачааллын үр дүн гэж тайлбарлах нь шинжлэх ухааны хувьд хангалтгүй, алдаатай хандлага”[4] хэмээжээ. Үүнээс үзэхэд булчингийн маркераар аж ахуй тодруулах нь өөрөө хэт таамаглалд тулгуурласан шинж учир гэмтэл бэртлийн шинжийг ашиглах нь илүү найдвартай[5] гэж үздэг аж. Монголын нутгаас илэрсэн хүний ясан дээрх гэмтэл бэртлийн шинжийг

---

1 Эрдэнэбат, У., *Археологийн үндэс-Судалгааны арга зүй*, УБ, 2012, х.8.

2 Larsen, C. S., *Bioarcheology: Interpreting behavior from the human skeleton*, 1997, х.8.

3 Trinkaus, Erik. 1995. “*Neandertals, early modern humans, and rodeo riders: Detecting occupational stress in skeletal remains.”*. pp.658.

4 Milella, Marco. 2012. “*The influence of age, sex, and body size on entheseal changes in a contemporary sample from Switzerland.”*. pp.233.

5 Jurmain, Robert. 1999. “*Stories from the Skeleton: Behavioral Reconstruction in Human Osteology.” In Stories from the Skeleton, edited by Jane E. Buikstra and Lane A. Beck*, pp.42

Мамонова (1997), Наран (2003) нар судалсан байдаг. Гэвч эдгээр судалгаанд ахуйн гэмтэл бэртлүүдийн талаар дурдаагүй ба аж ахуй тодорхойлох оролдлого хийгээгүй юм. Иймд энэхүү судалгаа нь гэмтэл бэртлийн шинжийг ашиглан нүүдэлчдийн ахуйг тодруулах анхны оролдлого болж байна.

1. Судалгааны арга зүй, үндэслэл

Тус судалгаанд эртний хүний ясан дээрх гэмтэл, бэртлийн тохиолдлуудыг траума анализ буюу гэмтэл, бэртлийн ангиллын арга зүйн дагуу тодорхойлох ба зөвхөн ахуйн, антемортем эдгэрэлттэй гэмтлүүдийг сонгон авна. Учирлавал ахуйн гэмтэл нь тухайн хүний өдөр тутмын амьдралын хэв маяг зан үйлийг бүрэн харуулж чадах ба антемортем буюу аль хэдийн эдгэсэн хэв шинжтэй байдаг[6]. Ахуйн гэмтэл нь хүчирхийллийн болон дайны гэмтлүүдээс эдгэрэлтийн түвшин болоод биеийн ясанд илрэх байрлалаараа өөр байх бөгөөд траума ангиллын арга зүйд ахуйн гэмтлийг тодорхойлохдоо хүний амин тус газраас хол аль хэдийн эдгэсэн шинжтэй байна гэжээ.


Нүүдэлчид адууг гаргууд сайн эзэмшдэг мөн амьдралынхаа нэг хэсэг болгон хэрэглэж байсан нь сурвалж бичиг болон, археологийн олдвор хэрэглэгдэхүүнээр батлагддаг. Тухайлбал Булган аймгийн Эгийн гол дахь 2003 оны археологийн малтлага судалгааны ажлын үеэр Бурхан толгойн булш оршуулгуудаас төмөр амгай, ясан зуузай (13 булш), хазаарын төмөр цагариг (17 булшнаас 24 ш), хазаарын хүрэл товруу (1 булшнаас 7 ш), хазаарын хүрэл хонх (1 булш) зэрэг адууны тоног хэрэгсэл илрүүлжээ[7]. Мөн сүүлийн үед хийгдсэн биоархеологийн судалгаагаар НТӨ 1200-аад оны үед хамаарах хүрэл зэвсгийн үеийн зарим булшнаас илэрсэн хүний шүдэн дээр хийгдсэн судалгаагаар тэднийг адуутай ойр аж ахуй эрхэлдэг байсныг баталсан төдийгүй гүүний сүүнд агуулагддаг β-lactoglobulin уураг илрүүлжээ[8]. Эдгээрээс харахад эртний нүүдэлчдийн гол онцлог нь нүүдлийн соёлд суурилсан мал аж ахуй гэдэг нь тодорхой байна. Тиймээс бид энэхүү судалгаагаар нүүдэлчдийн ясан дээр бусад бүс нутгийн өөр соёлтой хүн амаас онцгойрох шинж ажиглагдаж буй эсэхийг судлана.

---

6 Trinkaus, Erik. 1995. "*Neandertals, early modern humans, and rodeo riders: Detecting occupational stress in skeletal remains.*". pp.658.

7 Төрбат, Ц., нар, *Эгийн голын сав нутаг дахь Археологийн дурсгалууд (Хүрэлийн үеэс Монголын үе),* УБ, 2003, х.101.

8 Wilkin, Shannon, et al. 2020. "*Dairy pastoralism sustained eastern Eurasian steppe populations for 5,000 years.*". pp.585.




Зураг 1. Гэмтэл бэртлийн түгээмэл илрэх хэсэг. А. Ан агнуур (Trinkaus, 1984). Б. Газар тариалан (Jurmain, 1999). В. Мал аж ахуй

2. Судалгааны хэрэглэгдэхүүн

Тус судалгаанд МУИС-ийн Био-археологийн лабораторид хадгалагдаж буй эртний хүний ясны олдворуудыг хамруулсан ба ингэхдээ их биеийн бүтэн ястай олдворуудыг санамсаргүй байдлаар түүвэрлэн авсан. Судалгаанд хүрлийн үе дөрвөлжин булш, буган хөшөө-хиргисүүрийн дурсгалууд, төмрийн түрүү үе болох Чандманийн соёл, Хүннүгийн үе зэрэг байгаа бол хамгийн хожуу нь Монголын эзэнт гүрний үеийн нийт 80 хүний ясны олдворыг хамруулсан (Зураг 2) ба энэ дунд Хүннүгийн үеийн олдворууд тооны хувьд хамгийн их байна Мөн өндөр давтамжтай гэмтсэн ясны хэсгүүдийг адуу ба түүний уналгын үед үүссэн эсэхийг тодруулахын тулд Эрүүл Мэндийн Хөгжлийн Төвөөс орчин үеийн хүний ясны хугарлын мэдээллийг ашиглав.



Бүдүүвч 1. Олдворуудын түүхэн үеийн тооны харьцаа



Зураг 2. Судалгаанд ашигласан олдворуудын дурсгалт газрын байршил

3. Нүүдэлчдийн ясан дээрх гэмтлийн судалгаа

Судалгаанд хамрагдсан нийт 80 хүний хүйсийг тодорхойлон авч үзэхэд 51 (63.7%) эрэгтэй бол 29 (36.3%) эмэгтэй байна. Насыг тодорхойлохдоо зөвхөн бэртэл гэмтэлтэй 30 хүний ясан дээр сонгон гүйцэтгэсэн бөгөөд олон улсад шинээр нэвтрээд буй Transition Analysis-3 арга зүйг баримталсан. Тухайн арга зүй нь хүний ясны олдворын бүх ясан дээрх өөрчлөлтүүдийг хамруулан үздэгээрээ давуу талтай.

Амьд ахуйдаа гэмтэл бэртэл авсан 30 хүний насыг нь тодорхойлсон ба нийт олдворуудын насны дундаж 42.7 байна. Хүйсээр ялган авч үзвэл эрэгтэй олдворуудын дундаж нас 44.1, эмэгтэй олдворуудынх 33.2 байна. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. Монголын хүрлийн сүүл, төмрийн түрүү, Хүннү, Монголын эзэнт гүрний үеийн түүвэр олдворуудад ажиглагдсан гэмтлийн тохиолдлууд

Д/д	Олдворын дугаар	Түүхэн үе	Хүйс	Нас	Гэмтэл илэрсэн яс	Гэмтэл илэрч буй хэсэг
1	AT 1054	Хүрэл	эр	37.3	зүүн тахилзуур	Доод мөчдийн яс
2	AT 1053	Хүрэл	эр	58.2	1-р хавирга, хатан хүзүү, эгэм	Дээд хэсгийн яс
3	AT 1044	Хүннү	эм	21.8	Шаант, 1ш хавирга,	Доод мөчдийн яс, дээд хэсгийн яс
4	AT 146	Хүннү	эр	16.5	Эгэм зүүн, баруун хавирга	Дээд хэсгийн яс
5	AT 179	Хүннү	эм	42.2	Бүсэлхийн 4, 5	Багана нуруу
6	AT 154	Хүннү	эр	15.5	Тахилзуур	Доод мөчдийн яс
7	AT 1045	Хүннү	эр	60	5ш хавирга, баруун эгэм	Дээд хэсгийн яс
8	AT 569	Хүннү	эр	53.9	Хавирга, богтос	Багана нуруу, Дээд хэсгийн яс
9	AT 530	Хүннү	эр	67.2	Баруун эгэм зүүн талын 3 хавирга	Дээд хэсгийн яс

10	АТ-1085	Хүннү	эр	21.2	Бүсэлхийн нугалам, богтос,	Багана нуруу, Дээд хэсгийн яс, Дээд мөчдийн яс
11	АТ-1091	Хүннү	эр	36.4	Хавирга, эгэм	Дээд хэсгийн яс
12	АТ-1094	Хүннү	эм	54.1	Бүсэлхийн нугалам, хавирга	Багана нуруу, Дээд хэсгийн яс
13	АТ-1093	Хүннү	эр	33.8	Бүсэлхийн нугалам, дал, богтос, эгэм	Багана нуруу, дээд хэсгийн яс
14	АТ-1092	Хүннү	эр	50.7	Зүүн сүүж, дунд чөмөг	Доод мөчдийн яс
15	АТ-1086	Хүннү	эр	58.4	Хатан хүзүү, хүзүүний 3-р нугалам	Хүзүүний нугалам
16	АТ-1090	Хүннү	эр	67.3	Зүүн хавирга	Дээд хэсгийн яс, хүзүүний нугалам
17	АТ-1084	Хүннү	эр	45.7	Хавирга	Дээд хэсгийн яс
18	АТ-536	Хүннү	эр	21.9	Хавирга	Дээд хэсгийн яс
19	АТ-569	Хүннү	эр	53.9	Хавирга	Дээд хэсгийн яс
20	АТ 130	Чандмань	эм	40.1	Зүүн богтос	дээд мөчдийн яс
21	АТ-126	Чандмань	эр	35.6	баруун зүүн шуу	дээд мөчдийн яс
22	АТ-140	Чандмань	эр	47.5	Хос богтос, хавирга, баруун эгэм	дээд мөчдийн яс, дээд хэсгийн яс
23	АТ-72	Чандмань	эр	39	Зүүн шаант, зүүн 1, баруун 2 хавирга, зүүн бугалга	Дээд мөчдийн яс, дээд хэсгийн яс
24	АТ 1031	Монгол	эм	48	Зүүн талын хавирга	Дээд хэсгийн яс
25	АТ 1036	Монгол	эр	56.3	4 хавирга зүүн тал,	Дээд хэсгийн яс
26	АТ-963	Хүрэл	эм	28.7	Хавирга	Дээд хэсгийн яс
27	АТ-960	Хүрэл	эр	48.2	Тахилзуур	Доод мөчдийн яс
28	АТ-539	Хүннү	эм	31.2	Баруун хавирга	Дээд хэсгийн яс
29	АТ 544	Хүннү	эр	38.3	Хавирга	Дээд хэсгийн яс, багана нуруу
30	АТ 466	Хүрэл	эр	52.5	Хавирга	Дээд хэсгийн яс

Хүснэгт 2. Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн гэмтэл бэртлийн статистик үнэлгээ

Chi-Square Tests

	Value	df	Asymptotic Significance (2-sided)	Exact Sig. (2-sided)	Exact Sig. (1-sided)
Pearson Chi-Square	3.465[a]	1	.063		
Continuity Correction[b]	2.629	1	.105		
Likelihood Ratio	3.586	1	.058		
Fisher's Exact Test				.092	.051
Linear-by-Linear Association	3.422	1	.064		
N of Valid Cases	80				

a. 0 cells (0.0%) have expected count less than 5. The minimum expected count is 10.88.

b. Computed only for a 2x2 table

Олдворуудын дунд ажиглагдсан нийт гэмтэл бэртлийн 63.75% нь эрэгтэй хүйсэд, 36.25% нь эмэгтэйд тохиолдож байгаагаас харахад эрэгтэй хүмүүс амьд ахуйдаа адуутай ойр хөдөлмөр эрхэлдэг байсан байх өндөр магадлалтай. Гэвч

энэхүү үзүүлэлтэд хоёр хүйсийн олдворуудын тооны харьцаа нөлөөлж байгаа бөгөөд хүйс дунд задлан авч үзвэл нийт эрэгтэй олдворуудын 45.1% нь амьд ахуйдаа гэмтэл авч байсан бол энэ нь эмэгтэй хүйсэд ердөө 21.1% байна. Хүйс болон ясан дээрх гэмтлийн хоорондын хамаарлыг Pearson-ийн χ^2 шинжилгээгээр үнэлэхэд статистикийн ач холбогдолтой ялгаа илрээгүй, $\chi^2(1, N = 80) = 3.47$, $p = .063$. Иймээс эрэгтэйчүүдэд гэмтлийн хувь өндөр хандлагатай байсан боловч энэ ялгаа статистикийн ач холбогдолд хүрсэнгүй (Зураг 3).

Археологийн малтлага судалгаагаар илэрсэн эд өлгийн зүйл нь хүйсийн ялгааг мөн харуулдаг бөгөөд судлаач Төрбат оршуулгын эд өлгийн зүйлс нь бодит хэрэглээний бүрэн дүр зургийг өгөхгүй боловч тухайн нийгмийн аж ахуйн бүтэц, соёлын хэв шинжийг сэргээн тодорхойлоход чухал ач холбогдолтой гэжээ. Оршуулгын эд өлгийн зүйлсийг нас хүйсийн бүлэгт хуваан харуулсан хүснэгтэд тэмдэглэснээр нийт амгай зуузайн олдворын 73% нь эрэгтэй хүнд, 27%-ийг нь эмэгтэй хүнд дагалдуулан оршуулсан байжээ[9].

Хавирга ясны гэмтэл: Тус төрлийн гэмтэл нь нүүдэлчдийн ясанд хамгийн түгээмэл давтагдаж байгаа бөгөөд нийт 18 хүн буюу нийт гэмтэл авсан хүмүүсийн 43.9% нь (AT-1053, AT-146, AT-1045, AT-569, AT-1091, AT-1094, AT-1090, AT-1084, AT-536, AT-569, AT-140, AT-72, AT-1031, AT-1036, AT-963, AT-544, AT-466) хавирга ясандаа антемортем (амьд ахуй үедээ) гэмтэл аван эдгэрчээ (Бүдүүвч 3). Эдгээрээс AT-1045, AT-140, AT-72, AT-1036 нарын бодгалиуд 3-аас дээш хавирга гэмтэлтэй, лавлан судлахад дараалсан нэг талын хавирга яснууд байв. (Зураг 3)



Зураг 3. AT-1045 дугаартай Хүннүгийн үеийн 60 настай, эрэгтэй хүний хавирга ясны гэмтэл.

[9] Төрбат, Ц., нар. *Тамирын улаан хошууны Хүннүгийн археологийн соёл (2017 оны малтлага судалгааны үр дүн)*, УБ, 2021, х.99

Дээд мөчдийн ясны хугарал: АТ-140, АТ-569, АТ-130 дугаартай олдворууд богтос ясандаа хугаралтай, АТ-126 дугаартай олдвор шууны ясандаа хугаралтай, АТ-72 дугаартай олдвор бугалга ясандаа тус тус гэмтэлтэй байв. Магадгүй тус шинжүүд нь зарим талаараа адуунаас унах үед биеэ хамгаалах зорилгоор газар тулах үед үүссэн байх боломжтой.



Зураг 4. АТ-1085 дугаартай Хүннүгийн үеийн 21 настай, эрэгтэй хүний богтос ясны гэмтэл

Гэвч траума ангиллын арга зүйд дээд мөчдийн ясанд тохиолдох гэмтэл нь хүчирхийллийн шинжтэй байж болно. Учирлавал тухайн хүн толгой хэсэг рүү нь чиглэсэн дайралтад өртөхдөө тухайн дайралтыг гараараа хаах үед үүсэх боломжтой хэмээжээ[10].

Эгэм ясны гэмтэл: Эгэм ясны хугарлын гол шалтгаан нь өндрөөс хүчтэй унах үед үүсдэг байна. Судалгаанд ашигласан Монголын эртний хүний олдворууд дунд 7 хүн эгэмний гэмтэл ажиглагдсан. АТ-1053, АТ-146, АТ-1045, АТ-530, АТ-1091, АТ-1093, АТ-140 нарын бодгалиуд эгэм ясандаа гэмтэлтэй байсан бөгөөд АТ-1093 нь далны маяа хэсэгтээ давхар хугаралтай байв.



Зураг 5. АТ-1045 дугаартай Хүннүгийн үеийн 60 настай, эрэгтэй хүний эгэм ясны гэмтэл

[10] Weiss, Elizabeth. 2014. *"Back Pains." In Paleopathology in Perspective: Bone Health and Disease through Time,* pp. 71

Багана нуруу: AT-1053, AT-179, AT-1085, AT-1094, AT-1095 нар бүсэлхийн нугалам болон хүзүүний нугаламдаа гэмтэлтэй байх бөгөөд ихэвчлэн арын сэртэнгийн хугарал ажиглагдлаа. Ийм шинжтэй хүн хүнд юм өргөх, нуруугаа эргүүлэхэд маш их зовуурьтай байдаг ба магадгүй мориноос ахар сүүлээрээ хүчтэй унасан байх боломжтой. Рандалл нарын (2025) судалснаар адуу түүний уналгын явцад үүссэн нуруу нугалмын хугарлыг 54,830 бодгалиуд дээр судалсан ба нийт гэмтсэн нугалмуудын 49.1% нь бүсэлхийн нугалмуудад тохиолдсон байсан ба тус мэдээлэл нь нүүдэлчдийн бүсэлхийн нугалмын хугарлын учир шалтгаан байж болох юм. Зарим талаараа хувь хүн хоорондын зөрчилдөөнөөс үүдэн багана нуруунд гэмтэл илрэх боломжтой байдаг[11].

Доод мөчдийн ясны гэмтэл: AT-1054, AT-154 дугаартай олдворууд шаант ясандаа, AT-1044, AT-960, AT-72 дугаартай олдворууд тахилзуур, AT-1092 дугаартай олдвор дунд чөмгөний толгой хэсэгтээ тус тус гэмтэлтэй байгаа юм. Тухайн гэмтлүүдийг зэвсгийн нөлөөтэй гэж үзэх боломжтой тухайлбал явган цэрэг морьт дайчныг онилохдоо тэдгээрийн өндрийн түвшинд хамаарч хөл рүү нь онилдог талаар таамаг бий. Үүн дээрх хүйсийн харьцаа тухайн таамгийг улам бататгаж байгаа бөгөөд нийт доод мөчдийн ясандаа гэмтэлтэй 5 хүний 4 нь эрэгтэй хүйсэд хамаарах олдвор байгаа юм. Гэвч тухайн гэмтлүүд нь мушгиран, ташуу хугарч эдгэсэн байгаагаас үзэхэд магадгүй энэ хөл дөрөөнд гацах болон хурдтай явж буй адуун дээрээс хажуу талаараа унах үед ч үүссэн байх боломжтой. Гэвч Монгол нутгаас илэрсэн хамгийн эрт үед холбогдох төмөр дөрөө нь Жужаны үед хамаарагдах ба түүнээс өмнөх үед одоогоор хараахан илрээгүй байна. Гэвч зарим судлаачид Хүннүгийн үед суран эсвэл модон дөрөө хэрэглэдэг байсан байж магадгүй хэмээн үздэг ба эдгээрээс харахад тухайн гэмтлүүдийг шууд адууны тоног хэрэгсэлтэй холбон тайлбарлах нь хангалтгүй юм.




Зураг 6. AT-1044 дугаартай Хүннүгийн үеийн, 21 настай эмэгтэй хүний шаант ясны гэмтэл

[11] Weiss, Elizabeth. 2014. *"Back Pains." In Paleopathology in Perspective: Bone Health and Disease through Time,* pp. 69

Хавирга яс хамгийн өндөр давтамжтай буюу 18 хүнд ажиглагдсан. Үүн дотор нэг хүнд 5 хавирга яс хугарсан тохиолдол ч мөн багтаж байна. Тухайн ясны гэмтэл нийт гэмтлийн 43.9%-ийг дангаараа бүрдүүлж байгаа бөгөөд үүн дээр эгэм болон дал яснуудын тохиолдлыг нэмбэл нүүдэлчдийн ясан дээрх гэмтэл бэртлийн 63.4%-ийг биеийн дээд хэсгийн ясны гэмтэл бүрдүүлж байна. Энэхүү үр дүн нь суурьшмал соёлтой хүн амаас ялгаатай байгаа бөгөөд нүүдэлчдийн ахуй амьдралын онцлог ясны гэмтэл бэртлийн тоо, тархалтад мөн илэрч байна гэж ойлгож болно (Бүдүүвч 3).

Бүдүүвч 3. Эртний нүүдэлчдийн биеийн янз бүрийн хэсэгт илрэх гэмтэл бэртлийн хувь



5. ДҮГНЭЛТ

Монголын газар нутгаас илэрсэн Хүрэл, Хиргисүүр-буган хөшөө, Хүннү, Чандмань, Монголын эзэнт гүрний үед хамаарах дурсгалуудаас илэрсэн нийт 80 хүний ясны олдворуудыг палеопаталогийн траума ангиллын арга зүйн дагуу судлав. Судалгаагаар нүүдэлчдийн амьдралын хэв маяг, хөдөлмөрийн ялгаатай байдал, аж ахуйн онцлогтой холбоотой бие махбодын гэмтэл бэртлийн хэв шинж тодорхой илэрлээ. Нийт судалгаанд хамрагдсан 80 хүнээс 30 хүнд бэртэл, гэмтлийн шинж илэрч байгаагаас гэмтлийн дийлэнх хувь нь дээд мөчдийн ясанд (63.4%) буюу эгэм, дал, хавирга зэрэг ясан дээр тохиолдсон нь орчин үеийн хүмүүст адуу уналгын үед үүсдэг гэмтэл бэртлийн түгээмэл шинжтэй тохирч байна. Бусад хэсгийн ясны гэмтэл харьцангуй бага, газар тариалан, ан агнуур давамгай нийгмүүдийн ясны гэмтлийн тархалттай харьцуулахад ялгаатай байгаа нь нүүдэлчин мал аж ахуйн онцлогийг илтгэж байна гэж үзэж байна.

Хүйсийн ялгааг авч үзвэл эрэгтэйчүүдийн дунд ахуйн гаралтай антемортем гэмтлийн хувь 63.75%, эмэгтэйчүүдэд 37.25% байв. Нүүдэлчдийн нийгэмд хөдөлмөрийн хуваарийн хүйсийн тодорхой ялгаа байсан ба эрэгтэйчүүдэд адуу уналга болон биеийн ачаалал шаардсан үйл ажиллагаа давамгайлж байсныг булшны эд өлгийн зүйлсээс гадна гэмтэл бэртлийн өндөр хувь харуулж байна. Оршуулгын эд өлгийн зүйлсийн бүтэцтэй энэ үзүүлэлт дүйж, эртний хүн амын нийгмийн бүтэц, амьдралын хэв маягийн тухай археологийн дүгнэлт палеопатологийн судалгаагаар батлагдаж байна гэж үзэж болно.

Энэхүү судалгаа нь харилцан адилгүй бүс нутгийн болон он цагийн хүн амууд, тэр дундаа нүүдэлчдийн ясанд илэрсэн хугарал, гэмтлийн шинж тэмдгийг ашиглан аж ахуй, амьдралын хэв маягийг тодорхойлоход анхны алхам болсон гэж үзэж болно. Цаашид гэмтэл бэртлийн шинжүүдийг илүү олон хүний ясны олдворыг хамруулж, бусад бүс нутгийн болон өөр он цагийн хүн амтай харьцуулан судалснаар эртний хүмүүсийн амьдралын хэв маяг, хөдөлмөрийн хуваарь, нийгмийн байр суурь, улмаар эрхлэх аж ахуй, нийгмийн бүтэц зохион байгуулалт зэргийг нэхэн тодруулах боломжтой юм.

ACCIDENTAL TRAUMA IN HUMAN SKELETAL REMAINS OF ANCIENT NOMADIC POPULATIONS FROM MONGOLIA

This study aimed to identify which skeletal regions were most frequently affected by fractures among nomadic, pastoral populations. The results indicate that fractures of the upper limbs constitute the highest proportion, suggesting a strong association with horseback riding and related activities. The analysis was conducted on osteological remains of 80 individuals recovered from the territory of present-day Mongolia, employing standard paleoanthropological methods. The observed patterns of trauma were found to be consistent with injuries associated with horse-related activities in modern populations. A higher prevalence of trauma was recorded among males, reflecting differences in labor roles and social organization. Moreover, the nature of the injuries identified in the skeletal remains is corroborated by historical records as well as archaeological artifacts. These findings demonstrate that the horse-centered subsistence system of nomadic societies can be effectively examined through the study of human skeletal remains. The study further emphasizes the need for broader, multi-proxy research based on a wider range of materials in future investigations.

Keywords: *Accidental trauma, horse back riding, bone fracture, human skeleton, bioarcheology, paleopathology.*

НОМ ЗҮЙ

Монгол хэл дээрх

Батбаяр, Т., Батсүх, Д., Баярхүү, Н., Гантогтох, Г., Дюшен, С., Жерард, П., Крюбезы, Э., Николаева, Д., Пак Жансик, Төрбат, Ц., Трикслэ, С., Энхбаяр, Г., Эрдэнэ, Б., Эрдэнэцэцэг, Р., (2021), *Тамирын улаан хошууны хүннүгийн археологийн соёл (2017 оны малтлага судалгааны үр дүн)*, УБ., Адмон принтинг.

Төрбат, Ц., Амартүвшин, Ч., Эрдэнэбат, У., *Эгийн голын сав нутаг дахь археологийн дурсгалууд*, УБ., Соёмбо принтинг.

Эрдэнэбат, У., (2012). *Археологийн үндэс-Судалгааны арга зүй.*

Гадаад хэл дээрх

Aufderheide, A. C. (2003). *The scientific study of mummies.* Cambridge University Press.

Brooks, S., & Suchey, J. M. (1990). *Skeletal age determination based on the os pubis: A comparison of the Acsadi–Nemeskeri and Suchey–Brooks methods.* Human Evolution

Buikstra, J. E. (Ed.). (1977). *Bioarchaeology: The contextual analysis of human remains.* Southern Illinois University Press.

Fuka, M. R. (2018). *Activity markers and horse riding in Mongolia: Entheseal changes among Bronze and Iron Age human skeletal remains (Master's thesis).* University of Central Florida.

Hoffmann, M. F., Bernstorff, M., Kreitz, N., Roetman, B., Schildhauer, T. A., & Wenning, K. E. (2023). *Horse-related injury patterns: A single center report.* Journal of Orthopaedic Surgery and Research.

Larsen, C. S. (1997). *Bioarchaeology: Interpreting behavior from the human skeleton.* Cambridge University Press.

Loder, R. T., Walker, A. L., & Blakemore, L. C. (2025). *Spinal injuries from equestrian activity: A US nationwide study.* Journal of Clinical Medicine, 14(1).

Milella, M. (2012). *The influence of age, sex, and body size on entheseal changes in a contemporary sample from Switzerland.* American Journal of Physical Anthropology, 149(3).

NIJ Research Team. (2019). *Transition analysis 3 (TA3) trait manual: Public distribution draft ver. 1.0.* Department of Anthropology, The Pennsylvania State University; ADBOU, University of Southern Denmark.

Weiss, E. (2014). *Back pains.* In A. L. Grauer (Ed.), Paleopathology in perspective: Bone health and disease through time. Rowman & Littlefield.

White, T. D., Black, M. T., & Folkens, P. A. (2012). *Human osteology* (3rd ed.). Elsevier Academic Press.

Wilkin, S., Ventresca Miller, A., Taylor, W. T. T., Miller, B. K., Hagan, R. W., Bleasdale, M., Scott, A., Gankhuyg, S., Ramsoe, A., Trachsel, C., Nanni, P., Grossmann, J., Orlando, L., Horton, M., Stockhammer, P., Myagmar, E., Boivin, N., Warinner, C., & Hendy, J. (2020). *Dairy pastoralism sustained eastern Eurasian steppe populations for 5,000 years.* Nature Ecology & Evolution, 4(3)

2026 Fasc.17

МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООНЫ 275-Р ЗҮЙЛИЙГ НЯГТЛАН ҮЗЭХ НЬ

Шижирбатын Ундрах-Эрдэнэ
МУИС-ийн Археологи хөтөлбөрийн *II курсийн оюутан*

Удирдагч: Г. Батболд
ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн ЭША, доктор (Ph.D)

Хураангуй: *Энэхүү судалгаанд "Монголын нууц товчоо"-ны 275-р зүйлд гардаг Бат, Гүюг хоёрын маргааныг бусад сурвалжийн мэдээтэй харьцуулан нягталж үзэв. Уг зүйлд Мэгэд хотыг эзэлсний дараа болсон найрын үеэр Бат ахмад хөвүүний хувиар түрүүлэн сархад хүртсэнээс үүдэн Гүюг, Бүри нар түүнийг доромжлон уг найрыг орхин одсон тухай өгүүлдэг. Судалгаанд энэ мэдээг Перс, Хятад, Орос сурвалжтай тулган шинжилж, үйл явдлын он цаг, өрнөл, түүхэн бодит байдлыг тодруулахыг зорьсон. Шинжилгээний дүнд Нууц товчооны 275–277-р зүйлд буй зарим мэдээ, ялангуяа Гүюгийг Монголд буцаан дуудан авчирч дахин дайны талбар луу илгээсэн гэх өгүүлэмж нь он цагийн хувьд бусад эх сурвалжтай нийцэхгүй байгаа бөгөөд нэг үгээр хэлбэл Гүюг Монгол яваад, буцан дайны талбарт ирэх цаг байгаагүй нь тогтоогдов. Гэхдээ Бат, Гүюг хоёрын зөрчил бодит үндэстэй бөгөөд энэ нь зөвхөн хувийн маргаан гэхээсээ илүү Батын цэргийн удирдагчийн хувьд гаргасан алдаа дутагдалтай холбоотой санал зөрөлдөөн, цаашлаад Монголын эзэнт гүрний дотоод улс төрийн тэмцэлтэй холбоотой чухал үйл явдал байсан гэж үзэж байна.*

***Түлхүүр үг**: Өрнө зүгийн байлдан дагуулал, Монголын нууц товчоо, Бат-Гүюгийн зөрчил, Мэгэд хот*

УДИРТГАЛ

Монголын эзэнт гүрний өрнө зүгт хийсэн байлдан дагуулал нь XIII зууны дэлхийн түүхэнд асар их нөлөө үзүүлсэн томоохон үйл явдал билээ. Өгөдэй хааны зарлигаар зохион байгуулагдсан ахмад хөвгүүдийн аян дайн нь газар нутгаа тэлэхээс гадна Чингис хааны угсааны хан хөвгүүдийн хоорондын харилцаа, эрх мэдлийн тэнцвэр, удирдлагын асуудлыг ил тод гаргаж ирсэн

онцгой үе байсан юм. Энэхүү аян дайны явцад Батын удирдлага дор Зүчи, Өгөдэй, Цагаадай, Тулуйн удмын хан хөвгүүд хамтран оролцсон боловч тэдний хоорондын зөрчил, нэр хүндийн өрсөлдөөн, харилцан үл итгэх байдал тодорхой хэмжээнд оршиж байжээ.

Энэ зөрчлийн хамгийн тод тусгалын нэг нь Монголын нууц товчооны 275-р зүйлд өгүүлэгдэх Бат, Гүюг, Бүри нарын хооронд болсон маргаан юм. Уг мэдээнд Мэгэд хотыг эзлэн авсны дараах найрын үеэр Бат ахмад хөвүүний хувиар түрүүлэн сархад хүртсэнээс үүдэн Гүюг, Бүри нар түүнийг доромжилж, улмаар Бат энэ тухай Өгөдэй хаанд нууцаар мэдүүлсэн тухай өгүүлдэг. Гэвч энэхүү үйл явдлын он цаг, өрнөл, үр дагаврыг бусад сурвалжтай тулган үзэхэд зарим мэдээ нь эргэлзээтэй, бүр зарим хэсэг нь хожим нэмэгдсэн байж болзошгүй асуудал гарч ирдэг.

Иймээс энэхүү судалгааны зорилго нь Монголын нууц товчооны 275-р зүйлд өгүүлсэн мэдээг Перс, Хятад, Орос сурвалжийн мэдээтэй харьцуулан шинжилж, уг үйл явдлын бодит үндэс, он цагийн тохироо, түүхэн үнэнийг нягтлан үзэхэд оршино. Ялангуяа Гүюг Монголд буцаж очоод, хаан эцэгтээ зэмлүүлээд, дахин дайны талбарт ирсэн гэх мэдээ түүхэн бодит байдалтай нийцэх эсэх, мөн Бат, Гүюг хоёрын зөрчил нь зөвхөн хувийн маргаан байсан уу, эсвэл аян дайны удирдлага, цэргийн ажиллагааны алдаа дутагдалтай холбогдох асуудал байсан уу гэдгийг тодруулахыг зорив.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

275-р зүйл дэх үйл явдлын он цагийн асуудал

Зүрчидийн Алтан улсыг нэг мөр эзлэн авсны дараа 1235 оны хавар Өгөдэй хаан Даландаваа хэмээх газар их хуралдайг хуралдуулан, өрнө зүгийн улс орнууд болох Кипчак, Алан, Булгар, Оросуудыг байлдан дагуулах томоохон аян дайн хийхээр шийдвэрлэв. Энэ армийг Чингис хааны дөрвөн хүүгийн эзэмшил нутгаас татсан цэргүүд бүрдүүлж байсан бөгөөд айл бүрийг том хөвгүүд нь төлөөлж байв. Иймээс энэ аян дайнд "*Зүчийн удмаас Бат, Орда, Шибан, Танхут, Өгөдэйн удмаас Гүюг, Хадаан, Цагаадайн удмаас Бүри, Байдар, Хааны дүү Хөлгөн, Тулуйн удмаас Мөнх, Бөчөг тэргүүтэй хан хөвүүд оролцсон юм.*"[1] "Ахмад хөвгүүдийн аян дайн" гэж хожим нэрлэгдсэн энэ аугаа аян дайныг Бат ерөнхийлөн удирдаж, цэргийн ерөнхий командлагчаар өмнө нь Орос, кипчакуудтай байлдаж туршлагажсан, тухайн бүс нутгийг маш сайн мэдэх Сүбээдэй баатар байв.

[1] Рашид-ад-Дин Фазлуллах, *Шасдирын чуулган хэмээх монголчуудын түүх оршвой* (Судрын чуулган), орч. Г. Аким, УБ., 2021, х.467.

Бүтцийн хувьд энэ арми анхнаасаа үндсэн хоёр жигүүрт хуваагдаж байлаа. Нэг нь зүүн жигүүр бөгөөд Өгөдэйн болон Тулуйн удмын, өөрөөр хэлбэл Их Монгол улсын "төвөөс" татагдсан цэргүүдээс бүрдэж, Гүюг захирч байв. Нөгөө нь баруун жигүүр бөгөөд Зүчийн болон Цагаадайн удмын цэргүүдээс бүрдэж, Батын удирдлагад байсан. Эдгээр хоёр жигүүр ерөнхийдөө тус тусдаа байлдааны ажиллагаа явуулдаг байсан бөгөөд зөвхөн зарим тохиолдолд л хамтран байлдаж байв.

275-р зүйлд дараах байдлаар бичсэн байдаг:

"Бат, хипчак нутгаас Өгэдэй хаанд нууцаар өчиж илгээсэн нь: "Мөнх тэнгэрийн хүчинд, хаан ахын сууд Мэгэд хотыг эвдэж, Орос улсыг эзэлж, зүг зүгт арван нэгэн харь улсыг оруулж, алтан жолоогоо татаж салалцах болоход их асар босгож хуримыг хуримлав. Энэ хурим дээр би бүх хан хөвүүдийн ахмад тул нэг хоёр аяга сархад тэргүүлэн уув. Гэтэл, Бүри Гүюг хоёр надад муудаж хуримаас гарч одов."[2] Энэ хэсгээс харахад "Мэгэд"-ийг буулган авч, Оросуудыг эзлэн авсны дараа болсон найрын үеэр энэ маргаан гарсан гэдэг нь тодорхой харагдана. Иймээс нэн тэргүүнд Мэгэд хотыг буулган авсан он цагийг авч үзье. Мэгэд буюу Магас нь Кубань голын орчимд байрлаж байсан Алануудын нийслэл хот байв.[3] Юань улсын сударт бичсэнээр "*1239 оны өвлийн арван нэгэн сард [Мөнх] Манлайсу цэрэг авч Мэгис/* Мэгэд хотыг хааж гурван сар үзээд авчээ."[4] Рашид ад-Дин ч мөн адил "*1239 онтой таацах гахай жил Гүюг, Мөнх, Бүри болон Хадаан нар Магас/Мэгэд хотыг дайлав. Арван таван хоног бүслэн байлдаад, хаврын эхэн сард эзэлсэн*[5]*"* гэж бичсэн байдаг. Иймээс энэ хот 1240 оны эхээр эзлэгдсэн нь дээрх хоёр сурвалжаас тодорхой харагдах бөгөөд Нууц товчоонд гардаг хагацлын найр энэ үйл явдлаас хойш болсон байх учиртай юм.

Нууц товчоонд цааш өгүүлэхдээ "*Батын энэ үгэнд Өгөдэй хаан маш хилэгнэж Гүюгийг үл уулзуулан өгүүлрүүн: Энэ түрэмгий хэний үгэсд долгисч, ах хүмүүнийг ам дүүрэн өгүүльюү*[6]*..."*хэмээн зэмлэсэн байдаг. Улмаар тэднийг бараалхахыг зөвшөөрөөгүй боловч Мөнгэй болон бусад ноёдын ятгалгаар тэднийг дуудан ирүүлж хатуу зэмлээд "*Гүюг, Аргасун хоёрыг Бат мэдтүгэй... Бүрийг Цагадай ах мэдтүгэй*[7]*"* хэмээн тушаагаад буцаан явуулжээ. Хэрэв энэ

---

[2] Чоймаа, Ш., *Монголын нууц товчоо: Эртний үг хэллэгийн түгээмэл тайлбартай шинэ хөрвүүлэг,* УБ., 2022, х.243.

[3] Paul Pelliot, *Notes sur l'histoire de la Horde d'Or*, Paris., 1949, х.124.

[4] *Юань улсын судар, I боть: Хураангүй дээд, доод дэвтэр, 1–15 дугаар дэвтэр*, эрх. На. Сүхбаатар, ред. Б. Түшигтөгс, УБ., 2021, х.81.

[5] Рашид-ад-Дин Фазлуллах, *Шасдирын чуулган хэмээх монголчуудын түүх оршвой* (Судрын чуулган), орч. Г. Аким, УБ., 2021, х.470.

[6] Чоймаа, Ш., *Монголын нууц товчоо: Эртний үг хэллэгийн түгээмэл тайлбартай шинэ хөрвүүлэг,* УБ., 2022, х.244.

[7] *Мөн тэнд*, х.245.

мэдээг шууд үнэн гэж үзвэл Гүюг Монголд очсон явдал зөвхөн Мэгэд хот эзлэгдсэний дараа буюу 1240 оны 1-р сараас хойш болсон байх учиртай. Рашид ад-Дин ч энэ таамгийг батлах мэт бичсэн байдаг. "*Магас хотыг эзэлсний дараа Тэд хаваржин аялан байлдах цэргийг засаж, Бухадайд өгөөд, Төмөр хаалга болон тэр хавийг дайлаар илгээвэй. Гүюг, Мөнх нар хулгана жилийн [1240] намар зарлигаар буцав. 1241 онтой таацах үхэр жилийн намар тэд Ордостоо дөрөө мултталсан ажгуу"*[8] гэж бичжээ. Юань улсын сударт мөн л "*[1240 он] өвлийн арван хоёр сард зарлигт: Гүюгийн цэрэг эгжээ*[9]*"* хэмээн дурдсан байна.

Гэвч төрийн түүхэнд бичсэн дээрх мэдээг шууд үнэн зөв гэж үзэхэд хэцүү. Учир нь Гүюг өрнө зүгийн дайны талбар дээр байсаар байсныг нотлох өөр сурвалжийн мэдээ бий. Тухайлбал Оросын нэгэн сурвалжид Киев хотыг эзлэн авах байлдаанд Гүюг оролцсон гэж тодорхой бичсэн байдаг. "*Киевчүүд Товрул гэдэг нэгэн татарыг олзлон авч, түүнээс Бат болон бусад ноёд ирснийг мэдсэн байна. Тухайлбал Орда, Байдар, Бэрхчэр, Хадаан, Бөчөг, Мөнх, Гүюг, Сүбээдэй баатар, Бурундай, Байдар нар байсан"* гэжээ.[10] Тэр олзлогдогч бүр Гүюгийг Батын армийн "тэргүүн ноён" гэж тодорхойлсон байдаг. Хэрэв энэ мэдээг үндэслэвэл Гүюг Киев хот эзлэгдэхээс өмнө Монгол руу буцсан гэх боломж багасаж, харин Киев хот эзлэгдсэний дараа буюу 1240 оны 12 дугаар сарын 6-наас хойш л эгсэн байж болох талтай юм.

Гүюг яг хэдий үед Монгол руу буцсаныг нарийн тогтоох боломж хомс боловч 1241 он гарснаас хойш хөдөлсөн магадлалтай. Учир нь Рашид-ад-Дин бичихдээ "*Хаан үхдэг жилээ Гүюгийг элчээр дуудуулж, Гүюг ч дуудсаныг нь хүлцэнгүй даган эгсэн"*[11] гэжээ. Өгөдэй хаан 1241 оны 12-р сарын 11-нд нас барсан[12] нь мэдэгдэж байна. Гүюг 1242 оны эхээр эцэг хааныхаа нас барсан тухай мэдээг Имилд өөрөөр хэлбэл одоогийн Казахстаны нутагт явж байхдаа сонссон байна.[13] Хэрэв тэр 1241 оны эхээр Монгол руу явсан бол илүү дорно зүгт хүрсэн байх ёстой. Ийм нөхцөлд Гүюг 1241 оны сүүлчээр буюу Өгөдэй хааны амьд ахуй цагийн хамгийн сүүл үед түүний зарлигийг даган хөдөлсөн байх боломж илүү өндөр байна.

Иймээс Гүюгийг аян дайны дунд үеэр Монголд очоод буцаад дайны талбарт

---

8 Рашид-ад-Дин Фазлуллах, *Шасдирын чуулган хэмээх монголчуудын түүх оршвой* (Судрын чуулган), орч. Г. Аким, УБ., 2021, х.470.

9 *Юань улсын судар,* I боть, х.82

10 Dmitriev L. A. and Likhachev D. S., *Памятники литературы Древней Руси. XIII век*, Moscow., 1981, х.172.

11 Рашид-ад-Дин Фазлуллах, *Шасдирын чуулган хэмээх монголчуудын түүх оршвой* (Судрын чуулган), орч. Г. Аким, УБ., 2021, х.576.

12 Christopher P. Atwood, *Encyclopedia of Mongolia and the Mongol Empire,* New York., 2004, х.418.

13 'Ala-ad-Din 'Ata-Malik Juvaini, *The History of the World-Conqueror*, trans. John Andrew Boyle, vol. 1, Manchester., 1958, p.248.

буцан ирэх завдал гараагүй байна. Энэ нь 275–277-р зүйл дэх зарим өгүүлэмжид хожуу үеийн найруулга эсвэл засвар орсон магадлалтай хэмээн үзэхэд хүргэж байна. Гэвч үүнээс үндэслэн уг гурван зүйлийн агуулгыг бүхэлд нь зохиомол хэмээн үзэх нь учир дутагдалтай юм.

Бат, Гүюг хоёрын зөрчлийн бодит шалтгааныг тодруулах нь

Нууц Товчоонд өгүүлж буй Гүюг, Бүри, хоёр Батыг доромжилсон нь түүний эцэг Зүчийг Чингис хааны төрсөн хүү гэдэгт эргэлздэг байсан явдалтай холбоотой байж болох юм. Гэвч Гүюгийн уг үйлдэл өөр нэг шалтгаантай байсан байж болох талаар нэгэн санал дэвшүүлье. Юань улсын сударт Кипчак, Орос болон Унгарын эсрэг явуулсан дайныг маш дэлгэрэнгүй тайлбарлахдаа Бат энэ дайны явцад хэд хэдэн ноцтой алдаа гаргасан тухай дурдсан байна.

Жишээлбэл Бат Торск цайзыг эзлэхийг оролдсон боловч бүтэлгүйтсэн. Харин Сүбээдэй ирээд илүү бага цэрэгтэйгээр гуравхан хоногийн дотор, ганц тулалдаанаар уг цайзыг эзэлжээ.[14] Бат Унгарчуудтай тулалдах үед ч бас нэгэн ноцтой алдаа гаргасан байна. 1241 оны дөрөвдүгээр сард Монголын цэргийн тэргүүн анги Легницийн алдарт тулалдаанд оролцож байсан. Үүнтэй зэрэгцэн үндсэн арми Карпатын нурууг давж, Бат, Сүбээдэй нар удирдан таван замд хуваагдан Шайо голыг гатлахаар болсон.[15] Юань улсын сударт бичсэнээр Бат болон бусад ноёд “дайсны хүч хэт их” гэж үзэн гол гатлахад дургүй байсан. Тэгэхэд Сүбээдэй армийг таван хэсэгт хувааж, өөр өөр газраар гол гатлах ухаалаг арга санал болгосон. Дөрвөн хэсэг нь голын дунд болон дээд урсгалаар гүүр эсвэл явганаар гарч, Сүбээдэй өөрийн удирдсан сүүлчийн хэсгийг доод урсгалаар гаргах ёстой байв. Сүбээдэйн төлөвлөгөө бол сал ашиглан гол гаталж дайсны ар талд гэнэт цохилт өгөх явдал байсан. Гэтэл Бат түүнийг хүлээлгүй түрүүлж гол гатлан тулалдаанд орсноор цэргүүдийнх нь гучин хүн тутмын нэг нь живж Шибаны хүү Бахату хэмээх ноён нь алагджээ.[16] Монголын бүх цэрэг голын нөгөө талд цугларсны дараа ч Бат “дайсны тоо хэтэрхий олон байна” гэж үзэн ухрахыг хүссэн байна. Тэгэхэд Сүбээдэй *“Хэрэв та буцахыг хүсвэл ганцаараа буц. Би Дунай мөрий эрэг дээрх Пешт хот хүрэх хүртэл ухрахгүй”* гэж хэлээд давшсан. Бусад ноёд ч мөн тэр хот руу хөдөлж, хамтран дайрч эзлээд буцсан гэж Юань улсын сударт бичжээ. Энэ нь тухайн тулалдааны үеэр Монголын удирдагчдын дунд санал зөрөлдөөн, үл ойлголцол байсныг илтгэх нэгэн мэдээ юм.

Рашид ад-Дины бичсэнээр Унгарчуудыг ялсны дараа Монгол жанжид тэр

---

[14] Храпачевского, Р. П.,*Золотая Орда в источниках. Том III: Китайские и монгольские источники*, Москва., 2009, с.230-231.

[15] *Золотая Орда в источниках*, с.232.

[16] *Золотая Орда в источниках*, с.232.

зун Тисса болон Дунай мөрний орчимд амарч байжээ. Юань улсын сударт ч мөн адил тэр жил Монголын арми Шайо голыг гаталсны дараа “дараа нь тэд их цуглаан хийж, айраг болон дарс уусан” гэж бичсэн байдаг.

Эдгээр эх сурвалжууд 1241 оны зун Унгарыг ялсны дараа Шайо, Тисса, Дунай орчимд томоохон цуглаан болсон гэдгийг харуулж байна. Тэр цуглаан дээр Бат Шайо голын тулалдааны үеэр болсон явдлын талаар гомдоллож, Сүбээдэйг оройтож ирснээс олон цэрэг үрэгдсэн гэж буруутгасан байна. Харин Сүбээдэй энэ нь Батыг хэтэрхий эрт довтолсонтой холбоотой гэж тайлбарлажээ. Тэгэхэд Бат өөрөө буруугаа хүлээн зөвшөөрсөн байна.[17]

Юань улсын сударт бичигдсэн энэ цуглаан Нууц Товчооны 275-р зүйлд гардаг найрын дүр зурагтай төстэй харагдаж байна. Тэнд Гүюг ба Бүри хоёр Батыг архи түрүүлэн уусанд уурлаж, тэднийг “сахалт эмгэд” “нум барьсан эмгэд”[18] гэж доромжилсон байдаг. Энд олон тооны хэлбэр хэрэглэсэн нь зөвхөн Батыг биш, түүний удирдсан бүх цэргийг доромжилсон гэдэг нь харагдаж байна. Энэ найр Нууц товчоонд бичигдсэнтэй адил мөн эсэхийг батлах шууд баримт байхгүй боловч зарим нөхцөл байдал ижил байна. Тухайлбал Гүюг зун орчим явсан, энэ нь хагацлын найр байсан, мөн Бат шүүмжлэлийн гол бай болсон зэрэг нь энэ хоёр явдал нэг байж болохыг харуулж байна.

Ямар ч байсан дээрх хэлэлцүүлгээс хоёр зүйл тодорхой байна. Нэгдүгээрт Нууц товчооны 275–277-р зүйлд гардаг Гүюг Монголд очоод буцсан тухай мэдээ он цагийн хувьд боломжгүй тул хожим нэмэгдсэн эсвэл найруулгын алдаа байх магадлал өндөр байна. Хоёрдугаарт Гүюг, Бат хоёрын маргаан нь аян дайны үеэр Батын гаргасан олон алдаанаас үүдэлтэй байж болох юм. Хэрвээ энэ таамаг үнэн бол Гүюг 1241 оны сүүлийн хагаст Шайо, Тисса, Дунай орчим болсон их найрын дараа Монгол нутагруу хөдөлсөн байх үндэс гарч байгаа юм.

ДҮГНЭЛТ

Энэхүү судалгаанаас үзэхэд "Монголын нууц товчоо"-ны 275-р зүйлд өгүүлсэн Бат, Гүюг хоёрын зөрчил нь тодорхой бодит үндэстэй түүхэн үйл явдал байсан бололтой. Гэвч уг зүйлийн доторх бүх мэдээ, ялангуяа Мэгэд хотыг эзэлсний дараа болсон найр, түүнээс хойш Гүюгийг Монголд буцаан дуудан авчирч дахин дайны талбар руу илгээсэн гэх өгүүлэмж нь бусад сурвалжийн мэдээтэй он цагийн тулгалт хийж үзэхэд Гүюг Монгол яваад буцан дайны талбарт ирэх цаг байгаагүй байна. Перс, Хятад, Орос сурвалжуудыг харьцуулан

[17] *Золотая Орда в источниках*, с.232.

[18] Чоймаа, Ш., *Монголын нууц товчоо: Эртний үг хэллэгийн түгээмэл тайлбартай шинэ хөрвүүлэг,* УБ., 2022, х.243.

үзэхэд, Гүюг 1240 оны сүүл хүртэл өрнө зүгийн дайны талбарт байлдааны ажиллагаанд оролцож байсан нь тодорхой бөгөөд 275–277-р зүйл дэх зарим өгүүлэмж бусад сурвалжийн он цагийн мэдээтэй зөрж байгаа тул тухайн хэсгийн найруулга, бүрэлдэхүүнд хожуу үеийн засвар орсон эсэхийг цаашид нягтлах шаардлагатай. Энэ нь эх сурвалж судлалын хувьд төдийгүй Монголын эзэнт гүрний улс төр, цэргийн түүхийг илүү бодитой сэргээн ойлгоход чухал ач холбогдолтой юм.

Нөгөө талаас Бат, Гүюг хоёрын зөрчлийг зөвхөн хувийн атаа жөтөө, язгуур угсааны өрсөлдөөнөөр тайлбарлах нь хангалтгүй юм. Судалгаанд дурдсан баримтуудаас харахад Батын цэрэг армиа удирдах үедээ гаргасан зарим алдаа, тухайлбал Торск болон Шайо голын тулалдаантай холбоотой асуудлууд нь бусад хан хөвгүүд, жанждын дургүйцлийг төрүүлсэн байх боломжтой. Иймээс Гүюгийн зүгээс Батыг шүүмжилсэн явдал нь зөвхөн ёс хүндийн маргаан биш, харин цэргийн удирдлагын бодит шалтгаантай холбоотой байсан гэж үзэх үндэстэй байна.

Мөн энэхүү зөрчил нь дараагийн улс төрийн үйл явцад маш том нөлөө үзүүлжээ. Гүюг хааныг нас барсны дараа Батын зүгээс Өгөдэйн удмыг дэмжихээс татгалзаж, улмаар Толуйн хүү Мөнхийг хаан ширээнд суухад дэмжлэг үзүүлсэн нь энэ эртний зөрчилтэй салшгүй холбоотой байж болохыг энэхүү судалгаа харуулж байна. Өөрөөр хэлбэл Бат, Гүюг хоёрын маргаан нь ганцхан найрын үеийн үл ойлголцол биш, харин Монголын эзэнт гүрний дотоод эрх мэдлийн тэмцлийн зангилаа асуудал ил гарч эхэлж байгаа нь энэ байжээ.

A CRITICAL EXAMINATION OF PARAGRAPH 275 OF THE SECRET HISTORY OF THE MONGOLS

This article examines the conflict between Batu and Güyük described in section 275 of the The Secret History of the Mongols through a comparative analysis with other historical sources. According to this passage, after the capture of the city of Meged, Batu, as the senior prince among the descendants, was the first to drink at a ceremonial feast. This led Güyük and Büri to insult him and leave the banquet in anger. The study compares this account with Persian, Chinese, and Russian sources in order to clarify the chronology, development, and historical reliability of the event.

The analysis demonstrates that certain accounts found in sections 275–277 of The Secret History of the Mongols, particularly the narrative claiming that Güyük was recalled to Mongolia and later sent back to the western campaign, do not correspond chronologically with information preserved in other sources. In other words, there was insufficient time for Güyük to return to Mongolia and then rejoin the military

campaign in the west.

Nevertheless, the conflict between Batu and Güyük appears to have had a real historical basis. It was not merely a personal dispute, but rather a disagreement connected to Batu's military leadership and, more broadly, an important event related to the internal political struggles of the Mongol Empire.

Keywords: *The Secret History of the Mongols, Batu–Güyük conflict, city of Meged, Western campaign of the Mongols*

НОМ ЗҮЙ

Atwood, Christopher P. *Encyclopedia of Mongolia and the Mongol Empire*. (2004). New York: Facts On File.

Juvaini, 'Ala al-Din 'Ata-Malik. *The History of the World-Conqueror*. (1958). Translated by John Andrew Boyle. Vol. 1. Manchester: Manchester University Press.

Pelliot, Paul. *Notes sur l'histoire de la Horde d'Or*. (1949). Paris: Librairie d'Amérique et d'Orient, Adrien-Maisonneuve.

Рашид-ад-Дин Фазлуллах. *Шашдирын чуулган хэмээх монголчуудын түүх оршвой (Судрын чуулган)*. (2021) Орчуулсан Г. Аким. УБ., Жиком Пресс.

Храпачевский, Р. П. *Золотая Орда в источниках. Том III: Китайские и монгольские источники*. (2009). Москва.

Монголын нууц товчоон: Эртний үг хэллэгийн түгээмэл тайлбартай шинэ хөрвүүлгэ. (2022). Хөрвүүлж, тайлбарласан Ш. Чоймаа. УБ., Болор судар.

Памятники литературы Древней Руси: XIII век. (1981). Compiled by Л. А. Дмитриев and Д. С. Лихачев. Moscow: Khudozhestvennaia literatura.

Юань улсын судар. I боть: *Хураангуй дээд, доод дэвтэр, 1–15 дугаар дэвтэр*. (2021). Эрхэлсэн На. Сүхбаатар. Редактор Б. Түшигтөгс. УБ., Соёмбо принтинг.

2026 Fasc.18

ОРЧИН ҮЕИЙН МОНГОЛЧУУДЫН ЯЛГАРАА БА НУТГАРХАХ ҮЗЭЛ

Батбаярын ШҮРЭНЦЭЦЭГ
МУИС-ийн Археологи хөтөлбөрийн III курсийн оюутан

С. Бямбадорж
МУИС-ийн Археологи, антропологи, хүн ам зүйн тэнхимийн ахлах багш

Хураангуй: *Энэхүү өгүүлэл нь орчин үеийн Монголын нийгэмд өрнөж буй нэгэн сонирхолтой үзэгдэл болох нутгархал буюу аймаг, сумаараа бүлэглэн ялгарах, ижилсэх үйл явцад нөлөөлж буй түүх, улс төрийн болон нийгэм-соёлын хүчин зүйлсийг тодорхойлохыг зорьсон болно.*

Нутгархах үзлийг «нэг нутаг усныхаа хүмүүсийг илүүд үзэх, бусдыг нутаг орноор нь ялган хандах үзэл» хэмээн тодорхойлж болно. Монголчуудын нутгархалын хэлбэр, илрэн байгаа хэлбэр байдлын талаарх судалгаа шинжилгээ МУИС-ийн хэмжээнд цөөн хийгдсэн ба дагнасан судалгаа нэг сэдэвт бүтээлийн төвшинд одоогоор байхгүй байна.

Харин цахим орчинд "нутгархах үзэл" сэдвээр сэтгүүлч, нийтлэгчид нэлээд бичиж байгаа хэдий ч хувийн дүгнэлт, сэтгэгдэл төдийгөөр гол төлөв илэрч байгаа нь уг сэдвийг цаашид гүнзгийрүүлэн судлахын чухлыг илтгэж байгаа хэрэг юм. Ер нь угсаатан үндэстний төвшинд ижилсэл хийгээд ялгарал, түүнийг өдөөгч хүчин зүйлсийн талаар дорвитой антропологийн бүтээлүүд гарч эхэлж байна. Жишээлбэл, судлаач Урадын Булаг "Үндэсний үзэл ба эрлийзжил" хэмээх номдоо "Үндсэрхэг үзлийн зэрэгцээ локализм буюу нутгархах үзэл гэж байв. Монголчуудын үзэл суртлаар үндсэрхэг үзэл, нутгархах үзэл хоёр заримдаа өөр хоорондоо давхцдаг" хэмээн тэмдэглэсэн байна.

***Түлхүүр үг**: нутгархах үзэл, түүхэн ой санамж, угсаатны бүлгийн ялгарал, конструктив, инструменталист*

1. НУТГАРХАХ ҮЗЛИЙН ТҮҮХЭН ҮНДЭС

Орчин үеийн Монголын нийгэм - соёлын орчинд ил тодорхой харагдаж байгаа нэг сонирхолтой үзэгдэл бол “нутгархах” буюу “төрсөн, өссөн нутаг орноороо бүлгэрхэх” үзэгдэл юм. Уг үзэгдлийн мөн чанарыг тайлахын тулд “Нутаг” гэсэн ойлголтыг авч үзье.

“Нутаг” гэдэг үг монголчуудын ертөнцийг үзэх үзэл, ухамсар, хэл яриа, ахуй амьдрал дотор гүн гүнзгий шингэж, оршихуйн үндэс болсон нэг гол ойлголт юм.

Монголын нууц товчоо болон бусад эх бичгүүдэд «nuntu» хэмээн тэмдэглэгдэж байсан энэ үг XVII зуунд «nutu» хэлбэрт шилжсэн. Энэ ойлголтыг судлаач Мораками (1970) «нүүдэл малжилын хүрээ хэмжээ», Озава (1984) «нүүдэлчин монголчуудын амьдарлын тойрог», Ёшида «малжих хүрээ хэмжээ» хэмээн харилцан адилгүй тодорхойлсон байна[1].

Орчин цагийн монгол хэлэнд нутаг буюу «ну/н/туг» нь «төрсөн газар, оршин суугаа газар орон»[2] гэсэн утга агуулдаг. Товчлон хэлбэл, Нүүдлийн соёлын хүрээнд нутаг нь таван хошуу малаа бэлчээн оршин суух тодорхой хүрээ заагаар хязгаарлагдах газар орон байсан бол орчин үед энэ ойлголт засаг захиргааны нэгжтэй давхцдаг болжээ.

Энэхүү соёлын суурь ойлголт нь нутгархах үзлийн хамгийн гүн давхаргыг бүрдүүлж, түүхэн болон улс төрийн хүчин зүйлсийн нөлөөгөөр улам бэхжиж ирсэн.

2. ОНОЛЫН ХҮРЭЭ

Угсаатны ялгарал, нутгархах үзэл, Хүний бүлгэмдлийн талаар **примордиалист,** конструктивист болон инструменталист онолууд чухал байр суурь эзэлдэг**.**

2.1 Примордиал хандлага

Примордиал онолын дагуу угсаатны харьяалал нь “эртнээс тогтож ирсэн, төрөлхийн” шинж чанартай. Энэ онол ёсоор угсаатан үндэстний бүлэг нь «нийтлэг нэр, нэгэн үүсгэгч өвөг дээдсээс гаралтай гэдэг үзэл, эв нэгдэл, тодорхой нэгэн нутагтай холбоотой байх” үзэлд суурилдаг. Примордиал хандлагын төлөөлөгч болох Клиффорд Гирц (Clifford Geertz) “анхдагч холбоо” (primordial attachment) гэсэн ойлголтыг дэвшүүлсэн. Гирцийн үзлээр “угсаатны харьяаллын мэдрэмж нь шашны итгэл үнэмшил, нийтлэг хэл, нутаг орон, овог аймаг зэрэг байгалийн гэж тооцогддог холбоосоос үүсдэг бөгөөд эдгээр

[1] Алтангараг, А., *Нон Хорчины арван хошууны «Нутаг» хэмээх нийгмийн зохион байгуулалтын тухай,* УБ., 2015, х.70.

[2] Бямбарагчаа, Г., *Малгай тавибал манайх: нүүдэл хийгээд "нутгархах" үзэл,* УБ., 2010, х.38.

холбоос нь хүний сэтгэл зүйд тайлбарлахын аргагүй хүчтэй, гүн гүнзгий шингэсэн байдаг"[3]. Энэхүү дүгнэлт нутгархах үзлийн хувьд ч хамаарах бөгөөд "нэг нутгийнхан, нэг газар усныхан, нэг голынхон" гэх итгэл үнэмшил нь нийгэмшлийн явцад бүрдсэн сэтгэл зүйн нэгдлийн илрэл юм.

2.2 Конструктив хандлага

Конструктив онолын үндэс нь угсаатны харьяаллыг байгалиас өгөгдсөн, тогтмол шинж чанар биш, харин нийгмийн харилцаа, түүхэн нөхцөл, улс төрийн үйл явцын үр дүнд «бүтээгддэг» динамик үзэгдэл гэж үзэх үзэлд тулгуурлах бөгөөд угсаатны ижилсэл бол тодорхой нийгмийн болон түүхэн нөхцөл байдалд шинээр бүтээгддэг гэж үздгээрээ примордиал хандлагаас ялгарч байгаа юм. Харин аль ч утгаараа аливаа бүлгийн гишүүд итгэл үнэмшил, үнэт зүйлс, дадал, ёс суртахуун зэргээрээ нэгдмэл, эсвэл нэгдмэл хэмээх төсөөллөөрөө ижил байдаг гэсэн үг юм. Бүлэг бүр өөрсдийгөө бусдаас өөр онцгой гэж тооцдог тул угсаатны, тодорхой бүлгийн хил хязгаар нь ч тогтмол бус, харин нөхцөл байдлаас шалтгаалан дахин дахин тодорхойлогдож байдаг ажээ.

2.3 Инструменталист хандлага

Угсаатныг үзэх инструменталист хандлага нь угсаатны болон бүлгийн ялгааг улс төр, эдийн засгийн ашиг сонирхлын үүднээс тайлбарладаг. Энэ онолын дагуу «манай нутгийнхан» гэх ойлголт нь бодит ялгаанаас илүүтэй улс төрийн дайчилгаанд ашиглагддаг нийгмийн бүтээл болж хувирдаг.

3. НУТГАРХАХ ҮЗЛИЙГ ӨДӨӨЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛС

3.1 Түүх-соёлын хүчин зүйл: Угсаатны ялгарлын суурь

Монгол угсаатан бүрэлдэх явц нь монголын нэгдсэн төр улс тогтсон XIII зууны үед холбогдоно. "Тэр үеийг хүртэл монгол угсааны аймгууд хэдийгээр гарал үүслийн холбоотой гэсэн итгэл үнэмшилтэй ч нутаг нутагтаа нүүдлийн мал аж ахуй эрхлэн, бие биеэс салангид оршин, дор дороо нэг тэргүүлэгчийн мэдэлд байжээ"[4]. ... Монгол нутагт байсан олон аймгийг нэгтгэж, Монголын нэгдсэн тулгуур төрийг байгуулах нэгэн монгол угсаатан бүрэлдэх үйл явцыг түргэтгэх үйлийг язгуурын монгол аймаг <Хамаг монгол улс> манлайлан гүйцэтгэсэн юм[5]. Янз бүрийн нэртэй байсан аймгууд (Мэргэд, Тайчууд, Найман, Ойрад, Баргуд, Урианхайд, Түмэд ...) XIII зууны эхээр "Их Монгол улс"-ын тугийн дор "Монгол" хэмээх нэгэн нэршлээр[3] нэгдэж төвлөрсөн нэгэн төр улсыг

[3] Clifford, G., *The integrative revolution: primordial sentiments and politics in the new states,* London, 1963, p.107

[4] Далай, Ч., *Ойрад Монголын түүх*, УБ., 2006, х.50.

[5] Мөн тэнд. х.51.

байгуулсан юм. Чингэснээр олон аймгийн хоорондын дажин хямрал намжиж, тархай бутархай байдал нь устаад ... монгол орон, монгол улс, монгол хэл, монголын зан заншил, аж байдал хэмээн ялгарах угсаатны нийтлэг төлөвшин бий болсон байна[6]. Өөрөөр хэлбэл, Ийнхүү XIII зууны төгсгөлд монголын олон аймгууд тус тусдаа биеэ даасан засаг захиргаатай байхаа болин нэгэн соёлын холбоогоор нэгдснээр "монгол угсаатан баттай бүрэлдэн тогтсон байна"[7].

Түүхийн явцад Монголын нэгдсэн улс төр, эдийн засгийн нэгдэл задарснаар угсаатны бүлгүүд ялгаран гарах үзэгдэл Юань гүрний задралын дараа буюу «10 Түмэн Монголын»-ын үеэс эхэлсэн гэж үзэж болно. Тухайн үеийн хамгийн том ялгарал нь Ойрад ба Халх буюу Зүүн Монгол хоёрын хооронд өрнөжээ. Ойрад нь угтаа 1227 онд Чингис хаан Зүчийг илгээж Түмэдийн уравлагыг дарсны дараа Ойрадыг баруун хойш Түмэдийн нутагт нүүлгэж, Енисейн мөрний дээд урсгал Найман голоор нутаглуулсан байна. Чухам энэ үед Чингис хаан Ойрадыг дөрвөн мянгат болгон хуваагаад Их Монгол улсын баруун жигүүрийн түмэнд багтаан харьяалуулсан агаад тийнхүү дөрвөн мянган болсноос хойш ямар ч үед өөрсдийгөө Дөрвөн Ойрад хэмээн нэрлэж ирсэн ажгуу[8]. Их хааны түмтийн зохион байгуулалт Монгол угсаатан, Монгол хүн гэх нэгдмэл статусыг бүтээжээ. Гэвч Мөнх хаан нас барсны дараагаас Ойрадууд бие даасан байдалтай болж Юан гүрний хаадын захиргаанаас ангид хараат биш байдлаар орших эрмэлзэлтэй болжээ[9].

Хубилайн үеэс нэгдсэн Их Монгол улс задарч, Монголчуудын хоорондоо "Монгол, Ойрад" буюу "Зүүн, Баруун" гэж илэрхий хуваагдан тэмцэлдэх эхлэл үндсэндээ тавигджээ[10]. Юань гүрэн унасны дараа XVI зууны эхний хагасд Ойрад гаралтай ноёд болох Тогоон, Эсэн нар төрийн эрхэнд товойн гарч ирсэн нь алтан ургийнхны эрх мэдэл, болон Чингисийн Монголчуудын зөвхөн алтан ургийн хүн эзэн хаан байх гэсэн сэтгэлгээнд харшилж байлаа. Эсэн тайшийн алтан ургийн хүн бус хэмээх дотоод шалтгаан, "Эсэн тайш Монгол улсын хаан болсон тухайгаа Мин улсын хаанд бичгээр мэдэгдэхэд Мин улс Эсэнг бүх Монголын хаан биш зөвхөн Ойрадын хаан гэдгээр зөвшөөрсөн"[11] нь Монголчуудын баруун, зүүнээрээ хуваагдсан байдлыг улам дэвэргэн хооронд хагаралдуулан хүчийг нь тарамдуулах гэсэн гадаад хүчин зүйлээс шалтгаалан монголын дотоод эв нэгдэл тогтворгүй болжээ. Улмаар "Эсэн тайш нас барснаар Баруун Монголын ноёдууд "газар нутгаа тэлэн Монголын их хааны мэдлээс ангижирч

[6] Далай, Ч., Ойрад Монголын түүх, УБ., 2006, х.53.
[7] Мөн тэнд. х.54.
[8] Мөн тэнд. х.27
[9] Мөн тэнд. х.29
[10] Мөн тэнд. х.32
[11] Мөн тэнд. х.54.

толгой даан амьдрахыг эрмэлзэн XIV зууны сүүлчээр Байгал, Соёноос баруун тийш нүүж Алтай, Эрчис, Ил, Тарвагтайн газар очиж нутаглсан”[12] нь Баруун, Зүүн Монголын хуваагдлыг газар нутгийн хувьд эцэслэн шийдвэрлжээ.

Баруун монголын угсаатны бүлгүүд өөрийн гарал үүслийг домог, түүхэн дурсамжаар дамжуулан ялгарал бүхий ухамсрыг хадгалж ирсэн. Жишээлбэл, Дөрвөд угсаатны бүлгийн тухайд авч үзвэл:

Тэдний гарал үүслийн талаар анх Монголы нууц точоонд дурьдсан “Дува сохор ах нь дөрвөн хөвүүнтэй бүлгээ. Дува сохрыг үхсэний хойно түүний дөрвөн хөвүүн, Добу мэргэнийг авга гэж үзэхгүй доромжилж салж нүүгээд дөрвэд овогтон болов”[13] хэмээн өгүүлсэн байдаг. Дөрвөд бол эртний монгол угсаатны бүлэг, ойн иргэдийн нэгэн. Зүүнгарын Хаант улсын гол аймаг, Богд хаант монгол улсын үеийн Ховд хязгаарын зонхилогч угсаатны бүлэг юм. “Дөрвөд гэдэг нэр нь эртний монголын дээд өвөг, Дува Сохорын дөрвөн хүүхдийн удмаас буюу дөрөвлөн жагсдаг цэргийн жагсаалын нэр болох <дөрвөд> гэсэн үгнээс гарсан домогтой”[14] гэх мөн “Дөрвөн гэдэг овогтон Чингэсээс хэдэн үеийн өмнө Дува сохорын дөрвөн хүүгээс үүссэн Дөрвөн гэдэг овгоос XIII зууны үед дөрөв гэдэг тооны дээр “д” гэдэг олон тооны нөхцөл залгагдан Дөрвөд овогтон үүссэн бололтой”[15] хэмээн тэдний гарал үүслийн талаар ном зохиолд бичигдсэн байна.

1753 онд Зүүнгарын хаант улсын дотоод тэмцлийн улмаас Дөрвөдийн ноён Цэрэн, Цэрэн уваш, Цэрэнмөнх нар албат иргэдээ дагуулан Манжид дагаар орон 1754 онд Дөрвөд Далай хан даргатай 2 аймаг болон, 1757 онд өнөөгийн Увс аймгийн газар ирж нутаглажээ.[16] Ийнхүү Дөрвөд хэмээх угсаатны бүлгийн нэр засаг захиргааны нэгжийн нэр болон өргөжин Дува сохорын дөрвөн хүүгийн удам хэмээх түүхэн ой санамжтай хүч хавсарсан нь угсаатны бүлгийн онцлогийг бэхжүүлэх соёлын механизм болж өгсөн байна.

Мөн Дарма Гүүшийн Алтан Хүрдэн Мянган Хигээст хэмээх сурвалжид XV зууны сүүлч үед Мандухай хатан Ойрадуудыг дайлсан тухай домоглохдоо “Төрийг тэрсэлсэн дөрвөн Ойрадад сайн Мандухай хатан их цэрэг мордож, Тэс Бурт дээр дайлж аваад Гэрээ орд гэж бүү хэл, өргөө гэж хэл. Залаагаа хоёр хуруунаас илүү бүү хий. Завилж бүү суу, сөгдөж суу. Махыг хутгаар бүү ид, амаар хазаж ид. Айргийг цэгээ гэж хэл хэмээн цаазлавай. Ойрад, махыг

[12] Нямбуу, Х., *Монголын угсаатан зүйн удиртгал*, УБ., 1992, х.103.
[13] Дамдинсүрэн, Ц., *Монголын нууц товчоо,* УБ., 2011, х.6.
[14] Нямбуу, Х., *Монголын угсаатан зүйн удиртгал*, УБ., 1992, х.112.
[15] Цэрэл, Б., *Дөрвөн Ойрад ба Ойрадын холбоонд багтах үндэстэн ястнуудын угсаа түүхийн зарим асуудал,* УБ., 1965-1997, х.57.
[16] Нямбуу, Х., *Монголын угсаатан зүйн удиртгал,* УБ., 1992, х.106

хутгаар идэхийг гуйвай”[17]. Ингэж барууныг зүүнээс тусгаарлан цааз гаргасан нь монголчуудын дунд ямар нэгэн байдлаар угсаатны бүлгийн ялгараа үүсчихсэн байх боломжтойг илтгэж байна.

Монгол Улсад халх угсаатны бүлэг хүн амын олонхийг бүрдүүлдэг онцлогоос шалтгаалан баруун монгол гаралтай угсаатны бүлгүүд өөрсдийгөө «өөр» хэмээн тодорхойлох, түүндээ түүхэн болон соёлын баримтуудыг ашиглах явдал ажиглагдаж байгаа нь аливаа ард түмэн, хүний нийтлэгийн дунд элбэг ажиглагддаг «бид-тэд» гэсэн хосломол эсрэгцэл үүссэн түүхэн онцлогийг харуулж байна.

3.1 Улс төр-институцийн хүчин зүйл: Зөвлөлтийн бодлогын өв

Нутгархах үзлийн өдөөгч хамгийн хүчтэй хүчин зүйлийн нэг нь Зөвлөлт - Коминтерны “бага ястны тухай бодлого” буюу 1920-иод оноос хэрэгжүүлсэн угсаатны ялгааг тодорхойлох, хуваах бодлого юм. Судлаач Л. Мөнх-Эрдэнэ өөрийн өгүүлэлдээ энэ бодлого нь “Зөвлөлтөд үндэстний асуудлыг шийдэхийн тулд Большевикуудын явуулж байсан үндэстний бодлогын хуулбар байлаа гэжээ. 1928 онд Борис Владимирцов тэргүүт Оросын монгол судлаачид Зүгээр л Монголчууд гэж байхгүй, харин Халхчууд, Харчинууд, Буриадууд, Чахарууд гэх мэт л бий”[18] гэсэн нь Монголчуудын дунд угсаатны бүлгийн ялгаврыг улам тодорхой болгон бэхжүүлэхэд хүргэсэн нэг нөхцөл шалтгаан болсон байна.

1925 онд Чандмань уулын аймаг, 1931 онд Увс аймаг байгуулсан зэрэг засаг захиргааны нэгжийн хил хязгаар шинээр тогтоосон явдал, “Бага ястны зөвлөл” байгуулсан зэрэг улс төрийн үйл явдлууд нь монгол угсаатны бүлгүүдийн ялгааг улам хүчтэй болгож албан ёсоор баталгаажуулсан хэрэг болсон байна. Мөн Паспортжуулах бодлого нь угсаатны ялгааг улам бэхжүүлсэн нэмэлт хүчин зүйл болсон юм. Энэ нь угсаатны ялгааг хуулийн баримт бичигт тогтоосон бөгөөд хүн бүрийг “халх”, “дөрвөд”, “казах” гэх мэтээр ялгаж, аймгийн нэршилтэй уялдуулан бүртгэх ажил нь нутгархах үзлийг албаны болгосон. Мөн “Монгол Улсад 1969, 1989 онуудад явуулсан хүн амын тооллогуудад аймаг, угсаатны бүлгээр ялган тухайлбал, 1969 онд Улаанбаатар хотод 5456 дөрвөд хүн, 2499 баяд хүн, 217239 халх хүн, 1989 онд 481663 халх хүн, 8208 дөрвөд хүн, 5177 баяд хүн”[19] бүртгэн мэдээлэл цуглуулдаг байсан нь ялгааг системтэйгээр баримтжуулах хэрэгсэл болжээ. Ийнхүү Зөвлөлтийн бодлого

[17] Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал, Боть 15, *Алтан хүрдэн мянган хигээст*, УБ., 2006, х.82.

[18] Мөнх-Эрдэнэ, Л., *Монголын тусгаар тогтнолын ёгт үр дагавар: Монголчуудыг Монголжуу,* Монгол улсыг олон ястны болгосон нь, УБ., 2011, х.26.

[19] Булаг, Э., *Монгол дахь үндэсний үзэл ба эрлийзжил*, УБ., 2016, х.66-68.

нь аль эртнээс бага багаар үүсээд байсан угсаатны бүлгээрээ, аймаг аймгаараа ялгарах үзэгдлийг улам эрчимжүүлсэн буюу асаж эхэлж байсан галыг улам өрдсөн хэрэг болжээ.

“Засаг захиргааны нэгжийг угсаатны нэршилтэй уялдуулж тогтоосон” оор Зөвлөлтийн үед угсаатны бүлгийн ялгааг институцлаж, нутгархах үзлийг бэхжүүлсэн. Тухайлбал, “1930–аад оны зэвсэгт бослого Баруун монголд төвлөрч байсан нь санамсаргүйгээр нэлээд угсаатны шинжтэй болж хувирав. Жишээлбэл, Улаангомын лам нар эсэргүүцлээ бүх дөрвөдийн үүрэг гэж үзэж байжээ”[20] буюу Монголын ард түмэн бус Дөрвөд хүмүүс ЗХУ – Зүүнтнүүдийн алдаатай бодлогын эсрэг тэмцэж байсан болж таарч байна.

Мөн “1986 онд Монголын удирдагч болсон Батмөнх МАХН-ын Төв хорооны бүгд хурал дээр социалист амьдарлын хэв маягт харш үзэгдлүүд, түүний дотор нутгархах үзлийн эсрэг газар сайгүй, хайр найргүй тэмцэл өрнүүлэх хэрэгтэй гэжээ”[21] үүнийг тунгаавал Монголын төрийн тэргүүн намын төв хорооны бүгд хурал дээр ийнхүү заралсан нь нутгархах үзэл хэрхэн гаарч байсныг мэдэж болох биз ээ.

3.2 Улс төрийн элитүүдийн нийгмийн ашиг

Нутгархах үзлийг нийгмийн элит хэсгийнхэн зориудаар дэвэргэх хандлагатай. “1940-1990 оны хооронд Улс Төрийн Товчоо (УТТ)-ны гишүүдийн аймгийн бүрэлдэхүүнийг шинжилбэл Увс аймгийнхан 12.7 хувь, Дорноговийнхан 12.7 хувь буюу бусад аймгаас 2-6 дахин давуу байгаа нь нутгархах үзлийн улс төрийн хэрэглэгдэхүүнийг тодорхой харуулж байна”[22].

Энэ тухай нийтлэгч Баабарын тэмдэглэснээр “Ю. Цэдэнбал УТТ-г тэн хагасыг нь өөрийн нутаг Увсынхнаар дүүргэв. Нөгөө тал нь дорноговийн гэгдэх аж”[22]. Нэг нутгийнхан гэх нийгмийн итгэлийг ашиглан эрх мэдлийн сүлжээг бэхжүүлэх, нутгийнхаа хүнийг дэвшүүлэх практик нь социализмын үеэс улбаалан өнөөг хүртэл үргэлжилж байна. Нутгархах үзлийг энэхүү талаас нь харах юм бол инструменталист онолын тайлбартай нийцэж байна. Орчин үед ч мөн адил энэ эл хэв маяг хүн бүрт ажиглагдахуйц түгээмэл болжээ. Жишээлбэл, “Засгийн газар улсынх уу, Увсынх уу” гарчигтай нийтлэлд МАН-ын Удирдах зөвлөл өчигдөр хуралдаж, Засгийн газрын найман сайдыг чөлөөлж, УИХ-ын найман гишүүнийг сайдаар томиллоо. Гэтэл сая томилогдсон УИХ-ын гишүүн найман сайдын гурав нь Увсын сайд болж байна. Бүр сүүлдээ нутгархаж,

---

[20] Булаг, Э., *Монгол дахь үндэсний үзэл ба эрлийзжил,* УБ., 2016, х.40.

[21] Мөн тэнд. х.44.

[22] Тамир, Ч., *Улс төрийн товчооны гишүүдийн хэв маяг, социал төрх (1940-1990 он)*, УБ., 2009, х.172.

зиндаархдаг үйлдлүүд гаарч, тэр дундаас Улсын Засгийн газар биш, “Увсын” Засгийн газар болгох нь”[23] гэх утга бүхий бөгөөд энэ мэтчилэн Увсын фракц, Хэнтийн фракц зэрэг төрийн албыг төрлийн алба болгосон үзэгдэл хүчийг аваад ихэд уджээ.

2000-аад оны үеэс эхлэн Монгол улсын засгийн газрын бүрэлдэхүүн, төрийн байгууллагын дарга удирдлагуудын аймгийн харьяалал тогтмол хэлэлцэгддэг нийгмийн сэдэв болжээ.

“1990-ээд оноос хойш энэ үзэл тодорхой хэлбэрийн нийгмийн зохион байгуулалтанд орж {Нутгийн зөвлөл} хэлбэрээр үйл ажиллагаа, зохион байгуулалтын өндөр төвшинд хүрчээ. Нутгийн Зөвлөлүүдийн гол үүрэг бол улс төр, бизнес, эрдэм шинжилгээ, спорт болон соёлын элитүүдийг улс төрийн, орон нутгийн удирдлагад оруулах замаар төрөлх нутагтаа туслалцаа үзүүлэх явдал юм. Тэдгээрт албан тушаал ахиулах, бизнесийн харилцаа үүсгэх, тамирчин, поп дуучин, эсвэл зүтгэлтэй залуу оюутан зэрэг орон нутгийн авъяастнуудыг дэмжих болон настан буурлууд, эрүүл мэндийн асуудалтай байгаа иргэдэд халамж үзүүлэх зэрэг үйл ажиллагаанууд багтдаг”[24]. “Хэнтийн аймгийн нутгийн зөвлөлийг тэргүүлж УИХ-ын гишүүн Б. Бат-Эрдэнэ, Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газар (ЗГХЭГ)-ын дарга Л. Оюун-Эрдэнэ нар наадмын түрүү бөх Э. Оюунболдод шагналыг нь гардуулсан байна. Төрийнхөө наадамд үзүүрлэсэн Увс аймгийн Ховд сумын харьяа улсын аварга Н. Батсуурьд нутгийн зөвлөлөөс нь хүндэтгэл үзүүлж, хоёр өрөө байр бэлэглэжээ. Шагналыг УИХ-ын гишүүн Н. Цэрэнбат гардуулан өгчээ”[25] энэ нь 2019 оны Itoim.mn–ын нийтлэл бөгөөд Монголын баяр наадмын үеэрх наадмын түрүү бөхөд тэр нутгийн зөвлөлөөс тэчнээн төгрөгийн мөнгөн шагнал, байр, машин бэлэглэжээ гэсэн гарчиг бүхий нийтлэл наадмын түрүү бөхөөс илүүтэйгээр олны анхаарлыг татах ажээ.

Улс төрийн элитүүд нутгархах үзлийг ашиг сонирхолын хэрэгсэл болгон ашигласаар ирсэн бөгөөд УТТ-ны гишүүдийн аймгийн бүтцийн тэгш бус байдал үүнийг нотолж байна. Зөвхөн улс төрийн салбар төдийгүй соёл урлагийн хүрээнд ч нутгархах үзэл ижил хэлбэрээр илэрдэг. Монголын алдартай дуучид, жүжигчид, тамирчид нутаг орноороо бахархах нийгмийн хэв маяг тогтсон бөгөөд тэдний амжилт нутгийнхны нийтлэг бахархал болж хувирдаг. Энэ нь нутгийнхны дунд “манай нутгийн хүн” гэх онцлог мэдрэмжийг бэхжүүлж, нутгаар нь ялган харах үзлийг нийгмийн зөвшөөрөгдсөн хэлбэрт оруулдаг.

---

[23] Азсайхан, А., *Засгийн газар улсынх уу, Увсынх уу,* Ergelt.mn, 2022.08.30, https://ergelt.mn/news/44/single/24581

[24] Туяа, Ш., *Нутгийн зөвлөл ба Албан бус Улс төрийн Хүч*, Blogs.ucl.ac.uk, 2015.12.18, https://blogs.ucl.ac.uk/mongolian-economy/

[25] Батжаргал, Г., *Нутгийн зөвлөл: Түрүүлсэн бөхөд тав, үзүүрлэсэн бөхөд хоёр өрөө байр бэлэглэжээ,* Itoim.mn, 2019.07.13, https://itoim.mn/article/zgdgo/17651

“Манжуудын эзэлсэн улсаа тогтоон барих энэ хорон бодлого (засаг захиргааны нэгжийг бутлан жижигрүүлэх) монголчуудын дунд “нутгархал” хэмээх “амттай” өвчнийг түгээн дэлгэрүүлсэн. Энэ өвчин орчин үед спортод ихэд хурцаар илрэх болжээ. Зарим аймаг зөвхөн өөрийн нутгийн бөхийг наадамдаа барилдуулах шийдвэр ч гаргаж байв. Улстөрч, бизнесмен, тэдний тойрон хүрээлэгчдийг голцуу эгнээндээ нэгтгэсэн нутгийн зөвлөл гээч байгууллагын хийдэг хамгийн чухал ажил нь нутгаасаа төрсөн бөхөд хүндэтгэл үзүүлэх”[26]. 2022 оны улсын баяр наадмын барилдаанд Ховд аймгаас гаралтай хүн 10 даван аврага цолыг хүртэхэд аврагыг Ховд аймгийн зүгээс нэлээдгүй сүр дуулиантай цагдаа хүчний оролцоотойгоор угтаж байсныг санахад л хамгийн ойрын тод жишээ болох юм.

Бөхчүүд, улс төрчдийн нутгархах үзэл үүгээр дуусахгүй бөгөөд “Р.Гончигдорж тэргүүтэй улстөрчид бүр А. Сүхбат, Г. Өсөхбаяр хэмээх хоёр бөхөд зориулж хууль батлуулж, монгол төрийн түүхэн дэх хамгийн шившигтэй популизмыг хийж байлаа”[27]. Уг хуулиар бөхийн цолноос далай аврага цолыг бөхчүүдийг даян болон дархан аврага цол авах замыг нь хаана гэж үзсэн тул тийнхүү баяр наадмын “ХУУЛЬ”–д өөрчлөлт оруулах төслийг санаачлан батлуулсан байдаг.

3.3 Шилжилт хөдөлгөөн, нийгэм – эдийн засгийн хүчин зүйлс

Хот руу чиглэсэн дотоод шилжилт хөдөлгөөн нь нутгархах үзлийг өдөөх дараагийн чухал хүчин зүйл болж байна. Нийслэл Улаанбаатарт хөдөөнөөс шилжин ирсэн иргэд нутгийн хүрээлэлдээ тулгуурлан нийгмийн сүлжээ байгуулах нь нийтлэг үзэгдэл болдог. Ажлын байр, боловсролын боломжид хүрэхэд, мөн байр орон олоход нутгийн танил талаар дамжуулан шийдвэрлэх нь нутгархах үзлийг өдөөдөг бодит нийгмийн механизм юм. Миний бие өөрөө оюутан учир нийгмийн сүлжээнд тавигдсан оюутны тэтгэлэгт хөтөлбөрүүдийг байнга шалгаж байдаг. “Саяхан 100 оюутан, 100,000,000 төгрөг” гэх гарчигтай хөтөлбөрийг ихэд олзуурхан бүртгүүлэх гэсэн боловч “Тэр” аймгаас гаралтай биш гэх шалтгаан минь намайг тэтгэлэгт хөтөлбөрт бүртгүүлж амжаагүй байхад хасагдах шалтгаан болсон.

---

[26] Баяраа, Я., *Монгол бөхөд шүглэсэн таван гэм*, Eagle.mn, 2020, https://eagle.mn/r/46912

[27] Shumilov, M, M., *The Influence of Pan-Turkism on the Political Identity Formation of the Turkic States of Central Asia in the XXI Century (Part 1)*, 2022, https://api.semanticscholar.org/CorpusID:251513094

3.4 Мэдээллийн орчин ба гадаад нөлөө: Угсаатан хоорондын ялгараа

Орчин үеийн нутгархах үзлийн шинэ хэлбэр нь гадаад үзэл санааны нөлөөтэй уялдаж байна. Монгол улсын Баян-Өлгий аймагт төвлөрч суурьшиж буй казах иргэдийн ялгарал нь сүүлийн жилүүдэд улам хүчтэй болж байна. Үүнд гаднаас нөлөөтэй пантүркизм, пан туранизм хэмээх үзэл нэлээд хувь нэмэр оруулж байгаа бололтой. Пан-Туранизмийг маш энгийнээр хэлбэл түрэг хэлт ард түмнийг нэгтгэхийг зорьдог үндсэрхэг үзэл, улс төрийн хөдөлгөөн юм. Жишээ дурдвал The Influence of Pan-Turkism on the Political Identity Formation of the Turkic States of Central Asia in the XXI Century (Part 1) өгүүллийн дүгнэлтэд пантүркизм болон Төв Азийн бүс нутагт Зөвлөлтийн дараах орон зайд Туркийн бодлогын талаарх сөрөг мэдэгдлүүд Оросын хэвлэл мэдээллийн хэрэгслээр давамгайлж байна. Үнэндээ пантуркизм нь тус бүс нутгийн шинээр тусгаар тогтносон улсуудын төр улс болоход хүч нэмэр болдог”[27] хэмээн тусгагдсан байна. Пантүркизм үзэл, Казакстаны засгийн газрын дэмжлэг зэрэг нь Казах иргэдийн угсаатны ухамсрыг бэхжүүлж өгч байгаа бөгөөд тэд хэл бичиг, хувцас, урлаг гэх мэт зүйлсээрээ монголчуудаас улам их ялгарахыг хүсэх болжээ. **Баян-Өлгий аймагт Дорнод Казакстаны улсын их сургуулийн салбарыг байгуулсан нь** үүний нэг жишээ юм.

Инструменталист үүднээс бол уг үзэл нь тодорхой улс төр, соёлын зорилгод үйлчилж, угсаатны ялгааг идэвхжүүлэх хэрэгсэл болж байна. Казахуудын жишээ нь нутгархах үзэл нь зөвхөн нэг улсын дотоод үзэгдэл бус, олон улсын мэдээллийн орчинтой уялдсан дэлхийн үзэгдэл болж байгааг харуулдаг.

Дээрх дөрвөн хүчин зүйл нь тусдаа биш, харин харилцан хүчитгэж, системийн нөлөөг бий болгодог. Түүхэн соёлын суурь нь Зөвлөлтийн бодлогоор хэлбэрээ олж, улс төрийн элитүүдээр стратегийн зорилгоор ашиглагдаж, хот суурин газрын нийгмийн бүтцэд бэхжиж, гадаад мэдээллийн нөлөөгөөр шинэ хэлбэртэй болж байна.

Нутгархах үзэл нь нийгмийн бүтээгдэхүүн болж байгааг тайлбарлах конструктив онол, нутгархах үзэгдлийг элит хэсгийнхний улс төр, эдийн засгийн ашиг сонирхолд үйлчилдэг хэрэгсэл болох тухай инструменталист онолын аль аль нь монголын өнөөгийн нөхцөлд бодитойгоор оршин байгааг харж болохоос гадна эл хоёр онол нь бие биеийг нөхцөлдүүлэгч шинжтэй байгааг нэмж хэлж болно.

ДҮГНЭЛТ

Монголчуудын нутгархах үзэл нь угсаатны бүлгүүдийн түүхэн ой санамж, “өөрсдийгөө бусдаас ялгаатай”, “айл хүний амь нэг, саахалт хүний санаа нэг” хэмээн үзэх үзэлд суурилсан боловч орчин үеийн нийгэм, улс төрийн нөхцөлд

дахин бүтээгдэж, зарим тохиолдолд зориуд ашиглагдаж буй цогц үзэгдэл бөгөөд бид дараах дүгнэлтэд хүрлээ.

Монгол угсаатны бүлгүүдийн оршин амьдарч буй газар орон болон нэг соёлын орон нутгийн онцлог зэрэг нь нутгархах үзлийн үндэс болно. Нэг талаараа нутгархах үзэл нь монгол соёлын онцлог хэв шинжүүдийг хадгалах ач холбогдолтой юм. Гэхдээ уг үзэл нь нийгэм цаг үе өөрчлөгдөхийн хэрээр хувьсан шинэчлэгдэж, мөн зориудаар дахин бүтээгдэж, түүнийг нь бүлгийн элитүүд болон улс төрчид нийгмийн субьектив ашиг сонирхлын үүднээс хэтрүүлэн дэвэргэх хандлагатай байна.

Иймд нутгархах үзлийг зөвхөн соёлын ялгаа гэх бус, харин улс төрийн болон нийгмийн харилцааны үйл явцтай салшгүй холбоотой үзэгдэл хэмээн ойлгох нь зүйтэй.

DIFFERENTIATION AND LOCALISM AMONG CONTEMPORARY MONGOLIANS

This article aims to identify and analyze the historical, political, and socio-cultural factors influencing a noteworthy phenomenon in contemporary Mongolian society: localism, or the process by which people align themselves with and distinguish themselves through groupings based on their province (aimag) or soum (sum). Localism may be defined as “the tendency to favor people from one’s own locality and to treat others differently based on their place of origin.” Research on the forms and manifestations of localism among Mongolians has been limited within the scope of the National University of Mongolia, and to date there has been no comprehensive monographic study devoted exclusively to this subject. Although journalists and commentators have written extensively on the topic of “localism” in online media, such discussions have generally been confined to personal opinions and impressions. This, in itself, underscores the importance of conducting more in-depth research on the subject. In recent years, significant anthropological works have begun to emerge on the issues of identity formation and differentiation at the ethnic and national levels, as well as on the factors that stimulate these processes. For example, in his book Nationalism and Hybridity, Uradyn Bulag notes that “Alongside nationalism, there existed localism. Within Mongolian ideology, nationalism and localism sometimes overlap with one another.”

Keywords: *localism, historical memory, ethnic group differentiation, constructivist, instrumentalist.*

НОМ ЗҮЙ

Монгол хэл дээрх эх сурвалж

Алтангараг, А., (2015), *Нон Хорчины арван хошууны «Нутаг» хэмээх нийгмийн зохион байгуулалтын тухай,* УБ., Historia mongalrum.

Бямбарагчаа, Г., (2010) *Малгай тавибал манайх: нүүдэл хийгээд «нутгархах» үзэл,* УБ., https://e-library.num.edu.mn/cgibin/koha.

Булаг, Э., (2016), *Монгол дахь үндэсний үзэл ба эрлийзжил,* УБ., Соёмбо принтинг.

Далай, Ч., (2006), *Ойрад Монголын түүх,* УБ., Соёмбо принтинг.

Дамдинсүрэн, Ц., (2011), *Монголын нууц товчоо,* УБ.,

Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал Б.15: *Алтан хүрдэн мянган хигээст,* (2006) УБ., Соёмбо.

Мөнх-Эрдэнэ, Л., (2011) *Монголын тусгаар тогтнолын ёгт үр дагавар: Монголчуудыг Монголжуу, Монгол улсыг олон ястны болгосон нь,* УБ.

Нямбуу, Х., (1992) *Монголын үгсаатан зүйн удиртгал,* УБ., Сурах бичиг хүүхдийн номын хэвлэлийн газар.

Тамир, Ч., (2009) *Улс төрийн товчооны гишүүдийн хэв маяг, социал төрх (1940-1990 он),* УБ., Политологи.

Цэрэл, Б., (1965-1997), *Дөрвөн Ойрад ба Ойрадын холбоонд багтах үндэстэн ястнуудын үгсаа түүхийн зарим асуудал,* УБ., ШУ хэвлэлийн "Эрдэм" компани.

Гадаад хэл дээрх эх сурвалж

Clifford, G., (1963) *The integrative revolution: primordial sentiments and politics in the new states,* London, https://www.academia.edu/29114815.

Shumilov, M, M., (2022) *The Influence of Pan-Turkism on the Political Identity Formation of the Turkic States of Central Asia in the XXI Century (Part 1),* https://api.semanticscholar.org/CorpusID:251513094.

Цахим эх сурвалж

Азсайхан, А., (2022) *Засгийн газар улсынх уу, Увсынх уу,* Ergelt.mn, https://ergelt.mn/news/44/single/24581.

Батжаргал, Г., (2019) *Нутгийн зөвлөл: Түрүүлсэн бөхөд тав, үзүүрлэсэн бөхөд хоёр өрөө байр бэлэглэжээ*, Itoim.mn, https://itoim.mn/article/zgdgo/17651.

Баяраа, Я., (2020) *Монгол бөхөд шүглэсэн таван гэм,* Eagle.mn, https://eagle.mn/r/46912.

Туяа, Ш., (2015) *Нутгийн зөвлөл ба Албан бус Улс төрийн Хүч,* Blogs.ucl.ac.uk, https://blogs.ucl.ac.uk/mongolian-economy/.

ЗОХИОГЧИД

МУИС-ийн ШУС-ийн НУС-ийн Археологи, антропологи, хүн ам зүйн хөтөлбөрийн III түвшний оюутан Ёндонжамцын АДЪЯАЛХАМ
И-мэйл хаяг: adyalkham.num@gmail.com

МУБИС-ийн НХУС-ийн Түүх нийгмийн ухааны багш хөтөлбөрийн IV курсийн оюутан Эрдэнэбатын БААТАР
И-мэйл хаяг: baadaibaatar585@gmail.com

МУБИС-ийн НХУС-ийн Багш монгол хэл, уран зохиолын боловсрол хөтөлбөрийн IV курсийн оюутан Эрхэмзаяагийн БУДСҮРЭН
И-мэйл хаяг: budsuren313@gmail.com

МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын Багш, монгол хэл, уран зохиолын боловсрол хөтөлбөрийн III курсийн оюутан Нямдаваагийн БЯМБАЖАРГАЛ
И-мэйл хаяг: bymbajargalnnn@gmail.com

МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын Багш, монгол хэл, уран зохиолын боловсрол хөтөлбөрийн IV курсийн оюутан Гансүхийн ГАНСУВД
И-мэйл хаяг: suvdaasue07@gmail.com

МУБИС-ийн НХУС-ийн Монгол хэл, уран зохиолын багшийн I курсийн оюутан Ганбаатарын ЛХАГВАНАРАН
И-мэйл хаяг: gnbtrlxagvanaran@gmail.com

МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын Багш, монгол хэл, уран зохиолын боловсрол хөтөлбөрийн III түвшний оюутан Баяндалайн ЛХАГВАЧИМЭГ
И-мэйл хаяг: lkhagvachimegbayndalai@gmail.com

МУИС-ийн ШУС-ийн НУС-ын Антропологи хөтөлбөрийн IV курсийн оюутан Болорчулууны МӨНХЖИН
И-мэйл хаяг: munkhjinb2104@gmail.com

МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын Утга зохиол судлал хөтөлбөрийн III курсийн оюутан Батсүхийн ЗОЛБОО
И-мэйл хаяг: zolboo05150220@gmail.com

МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын Утга зохиол судлал хөтөлбөрийн IV курсийн оюутан Бямба-Эрдэнийн НОМИН
И-мэйл хаяг: nomin.b.kh@gmail.com

МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын Багш, монгол хэл, уран зохиолын боловсрол хөтөлбөрийн III курсийн оюутан Чимиддоржийн ӨНӨРЗАЯА
И-мэйл хаяг: 23b1num0934@stud.num.edu.mn

МУИС-ийн ШУС-ийн НУС-ын Археологи хөтөлбөрийн IV түвшний оюутан Эрдэнэ-Очирын ӨСӨХБАЯР
И-мэйл хаяг: usukhbayar816@icloud.com

МУБИС-ийн НХУС-ийн Монгол хэл, уран зохиолын багшийн III курсийн оюутан Үнэнбүрэнгийн СОЛОНГО
И-мэйл хаяг: solongosoko0316@gmail.com

МУИС-ийн ШУС-ийн НУС-ын Археологи хөтөлбөрийн II курсийн оюутан Шижирбатын УНДРАХ-ЭРДЭНЭ
И-мэйл хаяг: undraherdene18@gmail.com

МУБИС-ийн Монгол хэл, уран зохиолын багшийн IV курсийн оюутан Зоригтбаатарын ХИШИГБАЯР
И-мэйл хаяг: khishgeezorigtbaatar@gmail.com

МУБИС-ийн Монгол хэл, уран зохиолын багшийн IV курсийн оюутан Сүхбаатарын ЦЭЛМҮҮН
И-мэйл хаяг: tselmun949@gmail.com

МУБИС-ийн Монгол хэл, уран зохиолын багшийн IV курсийн оюутан Сугарын ЧУЛУУНЦЭЦЭГ
И-мэйл хаяг: Sugarchuka948@gmail.com

МУИС-ийн ШУС-ийн НУС-ын Археологи хөтөлбөрийн III түвшний оюутан Батбаярын ШҮРЭНЦЭЦЭГ
И-мэйл хаяг: Shvreeb612@gmail.com

ХАВСРАЛТ

“ОЮУТАН СУДЛААЧ” ХӨТӨЛБӨРИЙН ТАНИЛЦУУЛГА

“Оюутан судлаач” тэтгэлэгт хөтөлбөрийн тухай: Жил бүрийн IX сард монгол судлалын чиглэлээр суралцдаг их, дээд сургуулийн оюутнуудыг сонгон, шалгаруулдаг бөгөөд 25-30 оюутны бүрэлдэхүүнтэй сургалт, судалгааны лекц, тайлан хамгаалалтыг зохион байгуулдаг. Мөн оюутнууд суралцах чадвараа идэвхжүүлэхийн тулд тэмдэглэлт баяр, танилцах аялал, спорт өдөрлөгт хамрагддаг. Хичээлийн жилийн төгсгөлд оюутнуудын дунд Эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж, тэргүүлсэн оюутан, тэдний багш нарыг урамшуулдаг.

Хамтран зохион байгуулагч: МУИС-ийн Археологи, антропологи, хүн ам зүйн тэнхим, Монгол хэл, хэл шинжлэлийн тэнхим, Утга зохиол, урлаг судлалын тэнхим, МУБИС-ийн Монгол хэлний тэнхим, Утга зохиолын тэнхим, түүхийн тэнхим болон бусад тэнхим.

Тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдсанаар:

- ✓ Бие даан сурах, төлөвших, хамтран ажиллах, түүх, хэл, соёлоороо бахархах чадварыг эзэмшинэ;
- ✓ Нийгэм, хүмүүнлэгийн шинжлэх ухааны нэр хүндтэй ахмад, залуу судлаачдын лекц, ярилцлагад хамрагдаж, тэднээс судалгааны туршлага хуримтлуулна;
- ✓ Сонгосон сэдвийн дагуу судалгааны ажлаа гүйцэтгэж, судалгааны ажлын арга зүйд суралцаж, өгүүллээ *Эрдмийн хэлхээ* сэтгүүлд хэвлүүлнэ;
- ✓ Антоон Мостаэрт Монгол Судлалын төвөөс оюутан судлаачдад сар бүр тэтгэлэг өгч, цаашдын судалгааг нь дэмжин ажиллана.

Тэтгэлэгт хөтөлбөрийн шалгуур: Судалгааны ажил хийх хүсэл сонирхолтой их, дээд сургуулийн бакалаврын I-III ангийн суралцагчид хамрагдах боломжтой.

Хамрагдах хугацаа: Жил бүрийн X сарын 1- V сарын 31

“ОЮУТАН СУДЛААЧ” ХӨТӨЛБӨРИЙН САР ТУТМЫН ХУВААРЬТ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2025. 10. 23 Сонгон шалгаруулалтын ярилцлага
2025. 10. 30 Судалгааны ажлын танилцуулга
2025. 11. 05 Судалгааны ажлын танилцуулга
2025. 11. 12 Судалгааны ажлын танилцуулга
2025. 11. 19 Лекц ярилцлага: Монгол улсын ардын багш, шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор, МУБИС-ийн Монгол судлалын хүрээлэнгийн зөвлөх профессор Ц. Өнөрбаян “Эрдэм шинжилгээний өгүүлэл бичих аргачлал”
2025. 12. 03 Лекц ярилцлага: ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн Эртний түүхийн салбарын эрхлэгч, доктор (Ph.D) Г. Алтансүх “XII зууны монголчуудын нийгмийн байгууллын судалгааны арга зүйн асуудал”
2025. 12. 10 Шинэ жил
2026. 02. 25 Сар шинийн золголт
2026. 03. 04 Лекц ярилцлага: Соёл судлалын ухааны доктор (Ph.D), дэд профессор, зураач Д. Тангад “Монгол соёлын судалгааны уламжлал ба шинэ чиг хандлага”
Эрдэм шинжилгээний өгүүлэлд шүүмж бичих аргачлал: Т. Батбямба
2026. 03. 11 Лекц ярилцлага: СУИС-ийн Соёл урлаг судлалын хүрээлэнгийн ЭШТА, Түүхийн ухааны доктор (Ph.D), дэд профессор Б. Баатархүү “Монгол хүний эрхэмлэх үнэт зүйл”
2026. 03. 18 Лекц ярилцлага: Унгарын Сегедийн их сургуулийн хэл шинжлэлийн докторант, МУИС-ийн зочин судлаач Sara Tiszai “Халимаг хэлээрх анхны монгол библи”
2026. 03. 25 Лекц ярилцлага: ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн захирал, доктор (Ph.D), дэд профессор О. Шинэбаяр «Хэлний нэгжүүдийн утгын судалгаа»
2026. 04. 01 Эрдэм шинжилгээний өгүүлэлд шүүмж бичих
2026. 04. 11 Спорт өдөрлөг
2026. 04. 08 Эрдэм шинжилгээний өгүүлэлд шүүмж бичих
2026. 04. 15 Тайлан хамгаалалт
2026. 04. 22 Тайлан хамгаалалт
2026. 04. 29 “ОЮУТАН СУДЛААЧ - 2026” Эрдэм шинжилгээний хурал
2026. 05. 02 Орон нутаг судлал/Аялал: “Тэрэлж - Аръяабалын хийд - Цонжин болдог”
2026. 05. 06 Төгсөлтийн баяр

“ОЮУТАН СУДЛААЧ - 2026”
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН ХӨТӨЛБӨР

2026 оны 4 сарын 29 Лхагва гараг
15.00- 20.00 цаг

ТҮҮХ, АРХЕОЛОГИ, АНТРОПОЛОГИ

1. МУИС-ийн Археологи, антропологи, хүн ам зүйн тэнхимийн Археологи хөтөлбөрийн II курсийн оюутан Ш. Ундрах-Эрдэнэ

МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООНЫ 275-Р ЗҮЙЛИЙГ НЯГТЛАН ҮЗЭХ НЬ

2. МУИС-ийн Археологи, антропологи, хүн ам зүйн тэнхимийн Археологи хөтөлбөрийн III курсийн оюутан Ё. Адъяалхам

ХҮРЛИЙН ҮЕИЙН СОЁЛУУД ДАХЬ ТАЛИЙГЧИЙН ЗҮГ ЧИГИЙН АСУУДЛЫГ НЯГТЛАХ НЬ

3. МУИС-ийн Археологи, антропологи, хүн ам зүйн тэнхимийн Археологи хөтөлбөрийн IV курсийн оюутан Э. Өсөхбаяр

“МОНГОЛЫН ЭРТНИЙ НҮҮДЭЛЧДИЙН ЯСАН ДЭЭРХ ГЭМТЭЛ БЭРТЛИЙН СУДАЛГАА (АХУЙН ГЭМТЛИЙН ЖИШЭЭН ДЭЭР)”

4. МУИС-ийн Археологи, антропологи, хүн ам зүйн тэнхимийн Антропологи хөтөлбөрийн IV курсийн оюутан Б. Мөнхжин

“МОНГОЛ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН АНХНЫ САРЫН ТЭМДЭГ ИРЭХ НАС БОЛОН БИЕ БЯЛДРЫН ХӨГЖЛИЙН ХАНДЛАГА”

5. МУБИС-ийн НХУС-ийн Түүх, нийгмийн ухааны багшийн IV курсийн оюутан Э. Баатар

“ХОР ДАГАЛДУУЛАХ ЗАН ҮЙЛИЙГ ТОДРУУЛАХ НЬ”

Асуулт, хариулт
Шүүгчдийн санал, зөвлөгөө

ХЭЛ ШИНЖЛЭЛ

1. МУБИС-ийн НХУС-ийн Монгол хэл, уран зохиолын багшийн I курсийн оюутан Г. Лхагванаран

“МОНГОЛ ХЭЛНИЙ ТЭМДЭГ НЭР БҮТЭЭХ ТӨСӨӨТ ДАГАВРЫН ТУХАЙ”

2. МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын Багш, монгол хэл, уран зохиол хөтөлбөрийн III курсийн оюутан Ч. Өнөрзаяа

“МОНГОЛ И ЮЙ” ТОЛЬ БИЧГИЙН НЭМЭЛТ ДЭВТРҮҮД ДЭХ ЦАГ УЛИРЛЫН АЙМГИЙН ҮГИЙН САНГ ХАРЬЦУУЛАХ НЬ

3. МУБИС-ийн НХУС-ийн Монгол хэл, уран зохиолын багшийн III курсийн оюутан Г. Энхжин

“ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ХЭЛНИЙ ХЭРЭГЛЭЭНИЙ АВИА ХУВЬСАХ ҮЗЭГДЛИЙГ СУДЛАХ НЬ”

4. МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын Багш, монгол хэл, уран зохиол хөтөлбөрийн IV курсийн оюутан Г. Гансувд

“МӨ-“ ЯЗГУУРТ БҮЛЭГ ҮГИЙН ТУХАЙД

5. МУБИС-ийн НХУС-ийн Монгол хэл, уран зохиолын багшийн IV курсийн оюутан З. Хишигбаяр

“МОНГОЛ ХЭЛЭН ДЭХ ГАДААД ҮГИЙН ХӨӨМИЙН ЭГШГИЙН ДУУДЛАГА, АВИАНЫ ХУВЬСАЛ (АНГЛИ ОРОС ХЭЛНИЙ ЖИШЭЭГЭЭР)”

6. МУБИС-ийн НХУС-ийн Монгол хэл, уран зохиолын багшийн IV курсийн оюутан С. Чулуунцэцэг

“ТОД ҮСГИЙН “УДААН” ТЭМДГИЙН ХЭЛ ШИНЖЛЭЛИЙН ТАЙЛБАР”

Асуулт, хариулт
Шүүгчдийн санал, зөвлөгөө

УТГА ЗОХИОЛ

1. МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын Багш, монгол хэл, уран зохиол хөтөлбөрийн III курсийн оюутан Н. БЯМБАЖАРГАЛ

“ХААН СИЙР” БААТАРЛАГ ТУУЛИЙН ГУРВАН ХУВИЛБАРЫН СОЁЛЫН ХАМ СЭДВИЙГ ХАРЬЦУУЛАН ШИНЖЛЭХ НЬ”

2. МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын Багш, монгол хэл, уран зохиол хөтөлбөрийн III курсийн оюутан Б. ЛХАГВАЧИМЭГ

С.ЧОЙСҮРЭНГИЙН ТУУЛЬСЫН БААТРУУДЫН НЭР, НЭРШЛИЙН ӨВӨРМӨЦ ЧИМЭГ ҮГИЙН СУДАЛГАА (“ГАЛЗУУ ХАР ХӨХӨЛ”, “ЭЗЭН УЛААН БОДОН”, “БУЖИН ДАВАА ХААН” ТУУЛИЙН ЖИШЭЭН ДЭЭР)”

3. МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын Утга зохиол судлал хөтөлбөрийн III курсийн оюутан Б. ЗОЛБОО

“МОНГОЛ ҮЛГЭРИЙН БААТАД БА ШИДЭТ ТУСЛАГЧИЙН ХОЛБОО ХАМААРЛЫГ СИНТАГМАТИК АНАЛИЗЫН ХҮРЭЭНД ШИНЖЛЭХ НЬ”

4. МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын Утга зохиол судлал хөтөлбөрийн III курсийн оюутан Ө. ХУЛАН

“МОНГОЛ ШИДЭТ ҮЛГЭРИЙГ ЖОЗЕФ КАМПБЕЛЛ (JOSEPH CAMPBELL)-ИЙН БААТРЫН АЯЛЛЫН ЗАГВАРААР ШИНЖЛЭХ НЬ”

5. МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын Утга зохиол судлал хөтөлбөрийн IV курсийн оюутан Б. НОМИН

“МОНГОЛ УРГАМЛЫН ОНЬСОГЫН ТОГТМОЛЫГ УГСААТНЫ УРГАМАЛ СУДЛАЛЫН ҮҮДНЭЭС ШИНЖЛЭХ НЬ”

Асуулт, хариулт
Шүүгчдийн санал, зөвлөгөө

“ОЮУТАН СУДЛААЧ” ХӨТӨЛБӨРТ ХОЛБОГДОХ ЗУРГУУД


Эрхэм хүндэт Та бүхнийг
Антоон Мостаэрт Монгол Судлалын Төвийн
"ОЮУТАН СУДЛААЧ" тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд
уламжлал болгон зохион байгуулдаг лекц-ярилцлагад
хүрэлцэн ирэхийг урьж байна.
Ц. ӨНӨРБАЯН
Монгол улсын ардын багш, шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор,
МУБИС-ийн Монгол судлалын хүрээлэнгийн эвлэлэх профессор
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛ
БИЧИХ АРГАЧЛАЛ
2025 оны 11 дүгээр сарын 19-ний лхагва гаргийн 18:00-20:00 цаг
Антоон Мостаэрт Монгол Судлалын Төвд


НОМЫН САН


Эрхэм хүндэт Та бүхнийг
Антоон Мостаэрт Монгол Судлалын Төвийн
"ОЮУТАН СУДЛААЧ" тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд
уламжлал болгон эохион байгуулдаг лекц-ярилцлагад
хүрэлцэн ирэхийг урьж байна.
Г. АЛТАНСҮХ
ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн
Эртний түүхийн ёслолын эрхлэгч, доктор (Ph.D)
"XII ЗУУНЫ МОНГОЛЧУУДЫН
НИЙГМИЙН БАЙГУУЛЛЫН
СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙН АСУУДАЛ"
2025 оны 12 дугаар сарын 3-ны лхагва гаргийн 18:00-20:00 цаг
Антоон Мостаэрт Монгол Судлалын Төвд




Эрхэм хүндэт Та бүхнийг
Антоон Мостаэрт Монгол Судлалын Төвийн
"ОЮУТАН СУДЛААЧ" тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд
уламжлал болгон зохион байгуулдаг лекц-ярилцлагад
хүрэлцэн ирэхийг урьж байна.
Д. ТАНГАД
Соёл судлалын ухааны доктор (Ph.D), дэд профессор, Зураач
МОНГОЛ СОЁЛЫН
СУДАЛГААНЫ УЛАМЖЛАЛ БА
ШИНЭ ЧИГ ХАНДЛАГА
2026 оны 3 дугаар сарын 4-ний лхагва гаргийн 18:00-20:00 цаг
Антоон Мостаэрт Монгол Судлалын Төвд


НОМЫН САН


Эрхэм хүндэт Та бүхнийг
Антоон Мостаэрт Монгол Судлалын Төвийн
“ОЮУТАН СУДЛААЧ” тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд
уламжлал болгон зохион байгуулдаг лекц-ярилцлагад
хүрэлцэн ирэхийг урьж байна.
Б. БААТАРХҮҮ
Түүхийн ухааны доктор (Ph.D), дэд профессор
СУИС-ийн Соёл урлаг судлалын хүрээлэнгийн
Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан
МОНГОЛ ХҮНИЙ ЭРХЭМЛЭН ДЭЭДЛЭХ
ҮНЭТ ЗҮЙЛ
2026 оны 3 дугаар сарын 11-ний лхагва гаргийн 18:00-20:00 цаг
Антоон Мостаэрт Монгол Судлалын Төвд




Эрхэм хүндэт Та бүхнийг
Антоон Мостаэрт Монгол Судлалын Төвийн
"ОЮУТАН СУДЛААЧ" тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд
уламжлал болгон зохион байгуулдаг лекц-ярилцлагад
хүрэлцэн ирэхийг урьж байна.
Sàra Tiszai
Унгарын Сегедийн их сургуулийн доктор оюутан,
МУИС-ийн зочин судлаач
ХАЛИМАГ ХЭЛЭЭРХ
АНХНЫ МОНГОЛ БИБЛИ
2026 оны 3 дугаар сарын 18-ны лхагва гаргийн 18:00-20:00 цаг
Антоон Мостаэрт Монгол Судлалын Төвд




Эрхэм хүндэт Та бүхнийг
Антоон Мостаэрт Монгол Судлалын Төвийн
"ОЮУТАН СУДЛААЧ" тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд
уламжлал болгон зохион байгуулдаг лекц-ярилцлагад
хүрэлцэн ирэхийг урьж байна.
О. ШИНЭБАЯР
ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн захирал,
доктор (Ph.D), дэд профессор
ХЭЛНИЙ НЭГЖҮҮДИЙН
УТГЫН СУДАЛГАА
2026 оны 3 дугаар сарын 25-ны лхагва гаргийн 18:00-20:00 цаг
Антоон Мостаэрт Монгол Судлалын Төвд



АНТООН МОСТАЭРТ МОНГОЛ СУДЛАЛЫН ТӨВ
“ОЮУТАН СУДЛААЧ” ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР

Эрхэм хүндэт Удирдагч багш таныг

Антоон Мостаэрт Монгол Судлалын Төвийн
2025-2026 оны хичээлийн жилийн
“ОЮУТАН СУДЛААЧ” тэтгэлэгт хөтөлбөрийн
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛД
хүрэлцэн ирэхийг урьж байна.

Хэзээ: 2024. 04. 29-ний өдрийн 15:00-20:00 цагт
Хаана: Антоон Мостаэрт Монгол Судлалын Төвд




MONGOLIA
13
MIAT






asics


MONGOLIA
13
MIAT




АНТООН МОСТАЭРТ МОНГОЛ СУДЛАЛЫН ТӨВ
“ОЮУТАН СУДЛААЧ”
ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР
орон нутаг судлах аялал
2026.05.02 БЯМБА ГАРАГ 08:30-20:00














ӨНДӨР ЦАЛИНТАЙ
АЖИЛД УРЖ БАЙНА








МУИС-ийн ШУС-ийн НУС-ын Археологи, антропологи, хүн ам зүйн хөтөлбөрийн III түвшний оюутан Ёндонжамцын АДЪЯАЛХАМ



МУБИС-ийн НХУС-ийн Түүх нийгмийн ухааны багш хөтөлбөрийн IV курсийн оюутан Эрдэнэбатын БААТАР



МУБИС-ийн НХУС-ийн Багш монгол хэл, уран зохиолын боловсрол хөтөлбөрийн IV курсийн оюутан Эрхэмзаяагийн БУДСҮРЭН



МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын Багш, монгол хэл, уран зохиолын боловсрол хөтөлбөрийн III курсийн оюутан Нямдаваагийн БЯМБАЖАРГАЛ



МУИС-ийн Багш, монгол хэл, уран зохиолын боловсрол хөтөлбөрийн IV курсийн оюутан Гансүхийн ГАНСУВД



МУБИС-ийн НХУС-ийн Монгол хэл, уран зохиолын багшийн I курсийн оюутан Ганбаатарын ЛХАГВАНАРАН



МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын Багш, монгол хэл, уран зохиолын боловсрол хөтөлбөрийн III түвшний оюутан Баяндалайн ЛХАГВАЧИМЭГ



МУИС-ийн ШУС-ийн НУС-ын Антропологи хөтөлбөрийн IV курсийн оюутан Болорчулууны МӨНХЖИН




МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын Утга зохиол судлал хөтөлбөрийн III курсийн оюутан Батсүхийн ЗОЛБОО



МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын Утга зохиол судлал хөтөлбөрийн
IV курсийн оюутан Бямба-Эрдэнийн НОМИН



МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын Багш, монгол хэл, уран зохиолын боловсрол
хөтөлбөрийн III курсийн оюутан Чимиддоржийн ӨНӨРЗАЯА



МУИС-ийн ШУС-ийн НУС-ын Археологи хөтөлбөрийн
IV түвшний оюутан Эрдэнэ-Очирын ӨСӨХБАЯР



МУБИС-ийн НХУС-ийн Монгол хэл, уран зохиолын багшийн
III курсийн оюутан Үнэнбүрэнгийн СОЛОНГО



МУИС-ийн ШУС-ийн НУС-ын Археологи хөтөлбөрийн II курсийн оюутан
Шижирбатын УНДРАХ-ЭРДЭНЭ



МУБИС-ийн Монгол хэл, уран зохиолын багшийн IV курсийн оюутан
Зоригтбаатарын ХИШИГБАЯР



МУБИС-ийн Монгол хэл, уран зохиолын багшийн IV курсийн оюутан
Сүхбаатарын ЦЭЛМҮҮН



МУБИС-ийн Монгол хэл, уран зохиолын багшийн IV курсийн оюутан
Сугарын ЧУЛУУНЦЭЦЭГ



МУИС-ийн ШУС-ийн НУС-ын Археологи хөтөлбөрийн II курсийн оюутан
Батбаярын ШҮРЭНЦЭЦЭГ

ЭРДМИЙН ХЭЛХЭЭ
Эрдэм шинжилгээний бичиг
2026 (15)

Цаасны хэмжээ: B5
Хэвлэлийн хуудас:25.5
Хэвлэсэн тоо: 100

АРВАЙБАРХАН ХХК-д эхийг
бэлтгэж хэвлэв.